



Ирээд Намайг дага

Ням гаргийн анги 2017

Өсвөр үеийнхэнд зориулсан суралцах материал

ХӨРВӨЛТИЙН төлөө ЗААХ ба СУРАЛЦАХ

Ням гаргийн анги 2017

© 2016 он Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хамгаалагдсан

Англи эхийн зөвшөөрөл: 5/16

Орчуулгын эрх: 5/16

Come, Follow Me: Learning Resources for Youth, Sunday School 2017-ын орчуулга

Mongolian

13570 363

Энэ гарын авлагын тухай

Энэ гарын авлага дахь хичээлүүд нь Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний сургаалын үндсэн зарчмуудыг тайлбарласан бүлгүүдээс бүрддэг. Хичээл бүр нь өсвөр үеийнхний асуултууд дээр болон тэдэнд хариултаа олоход нь туслах сургаалын зарчмууд дээр төвлөрсөн юм. Хичээлүүд нь сургаалаас та өөрөө суралцсанаар сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлдээд улмаар өсвөр үеийнхэнд идэвхтэй сурах нөхцөлийг бүрдүүлж өгөх арга замуудыг төлөвлөхөд тань туслахаар зохион байгуулагдсан болно.

Сурах тоймууд

Жагсаасан гарчгууд дахь сургаалын сэдэв бүрд нэг сарын дотор зааж багтахааргүй олон сурах тоймууд бий. Та Сүнсний удирдамжийг болон өсвөр үеийнхний сонирхол ба асуултуудыг харгалзан, аль тоймоос хэр хугацаанд заахаа шийдээрэй.

Эдгээр тойм нь ангид таны хэлэх үгс болон үйлдлийг нэг бүрчлэн заахгүй. Эдгээр хөтөлбөр нь сургаалыг эхлээд өөрөө сурахад мөн зааж байгаа өсвөр үеийнхнийхээ хэрэгцээ шаардлагад нийцүүлэн заахаар бэлтгэхэд тань туслахаар зориулагдсан юм.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Өсвөр үеийнхэнд эдгээр тоймын зарчмуудыг ойлгоход нь туслахын тулд та өөрөө эдгээр зарчмыг ойлгож мөн үүний дагуу амьдардаг байх ёстой. Судруудыг болон бусад тарааж өгөх материалуудыг судалж, өсвөр үеийнхэнд сүнслэгээр нөлөөлөх хэлсэн үгс, түүх болон жишээнүүдийг хайж олоорой. Та өсвөр үеийнхнийг эдгээр зарчмуудыг өөрсдөө олж нээх, тэдгээрийн тухай гэрчлэлтэй болох, сайн мэдээнээс сурч мөн заахдаа эдгээрийг хэрэгжүүлдэг болоход нь туслах арга замуудыг төлөвлөөрэй.

Хамтдаа зөвлөлд

Ангийнхаа өсвөр үеийнхний талаар тэдний удирдагч, багш нартай зөвлөлд. Тэд бусад газруудад—гэртээ, семинар болон сүмийн бусад ангиудад юу сурч байна вэ? Бусдад заахын тулд тэдэнд ямар боломжууд байна вэ?(Хэрэв ярилцлагын үеэр эмзэг сэдэв хөндөгдсөн бол нууцыг хадгална уу.)

Дэлгэрэнгүй мэдээллийг онлайнгаар үзэж болно

Та эдгээр хичээлүүдтэй холбогдох нэмэлт материалуудыг болон заах санаануудыг [lds.org/youth/learn](https://www.lds.org/youth/learn) интернэт хаягаар орж, үзэж болно. Интернэт дэх хичээлүүд нь дараах зүйлсийг агуулдаг:

- Амьд бошиглогч, төлөөлөгчдийн болон сүмийн бусад удирдагчдын хамгийн сүүлд заасан зүйлүүдийг тавьсан интернэт хаягууд. Эдгээр интернэт хаягууд нь үргэлж шинэчлэгдэж байдаг тул та байнга орж, үзэж байгаарай.
- Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлдэх болон өсвөр үеийнхэнд заахад хэрэглэж болох видео бичлэг, зураг болон мэдээллийн бусад хэвлэмэл зүйлсийг олж үзэж болох интернэт хаягууд.
- Өсвөр үеийнхэнд хөрвөгдөхөд нь туслах ур чадварыг тань дээшлүүлэхэд зориулагдсан үр нөлөөтэй сургаалын загварыг харуулсан видео бичлэгүүд.

Гарчиг

1 Нэгдүгээр сар: Бурхан Тэргүүтэн

- 3 Суралцахад минь Ариун Сүнс надад хэрхэн тусалдаг вэ?
- 6 Судраас судлах нь надад Тэнгэрлэг Эцэгийнхээ тухай мэдэхэд хэрхэн тусалж чадах вэ?
- 10 Тэнгэрлэг Эцэгийн тухай мэдэж авахад нь би бусдад хэрхэн тусалж чадах вэ?
- 13 Би Тэнгэрлэг Эцэгийн нөлөө бүхий л зүйл дээр байдгийг хэрхэн олж харж сурах вэ?
- 17 Сайн мэдээг заахад Ариун Сүнс надад хэрхэн тусалдаг вэ?

21 Хоёрдугаар сар: Авралын төлөвлөгөө

- 23 Суралцах нь яагаад Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний чухал хэсэг болдог вэ?
- 27 Сайн мэдээг заах нь авралын төлөвлөгөөнд яагаад чухал вэ?
- 30 Сайн мэдээнээс суралцахад сонгох эрх ямар үүрэгтэй вэ?
- 34 Би бусад хүмүүсийг суралцахад нь хэрхэн тусалж чадах вэ?
- 38 Би авралын төлөвлөгөөний талаар суралцахдаа сүмийн дуу хөгжмийг хэрхэн ашиглаж болох вэ?
- 43 Христийн сургаалыг ойлгоход нь бусад хүмүүст би хэрхэн тусалж чадах вэ?

45 Гуравдугаар сар: Есүс Христийн Цагаатгал

- 47 Би Есүс Христийн Цагаатгалд итгэх итгэлээ бэхжүүлэхийн тулд амьд бошиглогч, төлөөлөгчдийн үгсийг хэрхэн ашиглаж болох вэ?
- 51 Судрууд надад Есүс Христийн Цагаатгалын тухай юу заадаг вэ?
- 55 Есүс Христийн Цагаатгалын тухай итгэх итгэлээ бэхжүүлэхэд Мормоны Ном надад хэрхэн тусалж чадах вэ?
- 59 Аврагчийн ач ивээлд найдах нь намайг илүү сайн багш болоход хэрхэн туслах вэ?
- 63 Би Цагаатгалын тухай бусдад заахдаа зүйрлэлүүдийг хэрхэн ашиглаж болох вэ?

67 Дөрөвдүгээр сар: Урвалт ба сэргээлт

- 69 Христийн амилсны баяр: Би Есүс Христийн амилалтын талаарх гэрчлэлээ хэрхэн хуваалцаж болох вэ?
- 72 Иосеф Смитийн жишээ сайн мэдээнээс суралцах талаар надад юу заадаг вэ?
- 77 Би хэрхэн үнэн, худал хоёрын ялгааг таньж мэдэх вэ?
- 81 Цэвэр сургаалыг заах нь яагаад чухал вэ?
- 84 Урвалт ба сэргээлтийн үйл явдлуудыг би өөрийнхөө амьдралтай хэрхэн адилтгаж болох вэ?
- 88 Урвалт ба сэргээлтийн тухай би бусдад хэрхэн тайлбарлах вэ?

93 Тавдугаар сар: Бошиглогчид ба илчлэлт

- 95 Би амьд бошиглогч, төлөөлөгчдөөс юу сурч болох вэ?
- 99 Би судраас хэрхэн илүү үр дүнтэй суралцаж болох вэ?
- 103 Бишрэл хүндэтгэлтэй байх нь намайг илчлэлт хүлээн авахад хэрхэн туслах вэ?
- 106 Гэрчлэл хуваалцана гэдэг нь юу гэсэн үг вэ?
- 110 Сүнсний мэдрэмжийг дагах талаар ерөнхийлөгч Монсоноос би юу сурч болох вэ?

115 Зургаадугаар сар: Санваар ба санваарын түлхүүрүүд

- 117 Би сүм дэх зөвлөлүүдэд хэрхэн үр дүнтэй оролцож болох вэ?
- 121 Бурханы хаант улсыг байгуулахын төлөө эмэгтэйчүүд ба санваартнууд хэрхэн хамтран ажилладаг вэ?
- 125 Санваарын удирдагчдын зөвлөгөөг дагах нь яагаад чухал вэ?
- 127 Судар судлах ур чадваруудыг ашиглах нь санваарын тухай илүү ихийг мэдэхэд надад хэрхэн туслах вэ?
- 131 Би санваарын тухай бусдад заахдаа түүхүүдийг хэрхэн ашиглаж болох вэ?

135 Долоодугаар сар: Ёслолууд ба гэрээнүүд

- 137 Би сайн мэдээний ёслолуудаас ямар сүнслэг үнэнүүдийг сурч болох вэ?
- 141 Би гэрээнүүдийн тухай ойлголтоо хэрхэн гүнзгийрүүлэх вэ?
- 145 Би хэрхэн ариун ёслолыг өөрийнхөө хувьд илүү утга учиртай болгох вэ?

- 150 Би Аврагчийг үргэлж дурсан санах гэрээгээ хэрхэн сахих вэ?
154 Би хэрхэн ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахад өөрийгөө бэлдэх вэ?

159 Наймдугаар сар: Гэрлэлт ба гэр бүл

- 161 Өдрийн тэмдэглэл хөтлөх нь намайг болон гэр бүлийг маань хэрхэн адислах вэ?
165 Гэр бүлийнхээ түүхийг судлах нь яагаад чухал вэ?
169 Би гэр бүлийнхээ түүхийн ажлыг хэрхэн хийхийг бусдад хэрхэн заах вэ?
173 Гэрлэлт ба гэр бүлийн ач холбогдлын талаар би бусдад хэрхэн тайлбарлаж болох вэ?
177 Гэр орондоо суралцах болон заах ямар боломжууд байдаг вэ?

181 Есдүгээр сар: Зарлигууд

- 183 Тэнгэрлэг Эцэгтэй илүү адил болохыг сурахад маань зарлигууд надад хэрхэн тусалдаг вэ?
188 Жишгүүдийг маань ойлгоход нь би бусдад хэрхэн туслах вэ?
193 Зарлигуудыг сахих нь сайн мэдээг сурах чадварт маань хэрхэн нөлөөлдөг вэ?
197 Би зарлигуудыг дагахад нь бусдыг хэрхэн дэмжиж чадах вэ?
202 Хэрвээ би зарлигуудыг дагавал Тэнгэрлэг Эцэг ямар адислалуудыг өгнө хэмээн амладаг вэ?

207 Аравдугаар сар: Христтэй илүү адил болох нь

- 209 Би хэрхэн бусдыг Аврагчтай илүү адил болоход урих вэ?
214 Би заах хүмүүстээ хайраа хэрхэн үзүүлэх вэ?
218 Аврагч сайн мэдээний үнэнүүдийг мэддэг зүйл болон туршлагуудтай хэрхэн харьцуулсан бэ?
223 Христтэй илүү адил болоход нь бусад хүмүүст туслахдаа би судруудыг хэрхэн ашиглах вэ?
228 Би заахдаа асуултуудыг хэрхэн үр дүнтэйгээр хэрэглэх вэ?
232 Би сайн мэдээнээс суралцах талаар Аврагчийн жишээнээс юу сурч болох вэ?

237 Арваннэгдүгээр сар: Сүнслэг ба материаллаг байдлын хувьд бие даах нь

- 239 Би сүнслэг байдлын хувьд хэрхэн бие даах чадвартай болох вэ?
243 Би сайн мэдээний талаарх асуултуудынхаа хариултыг хэрхэн олох вэ?
248 Би хэрхэн эргэлзээгээ итгэлээр ялан дийлж чадах вэ?

- 252 Би хэрхэн өөрөө шийдвэр гаргаж сурах вэ?
- 256 Зорилго тавих нь бие даах чадвартай болоход минь хэрхэн туслах вэ?
- 259 Би санхүүгийн хувьд бие даасан байхад хэрхэн бэлтгэх вэ?
- 264 Би хэрхэн Бурханы гэрчлэгч болж зогсох вэ?

267 Арванхоёрдугаар сар: Хожмын өдрүүдэд Бурханы хаант улсыг байгуулах нь

- 269 Христийн мэндэлсний баяр: Есүс Христ бол Бурханы Хүү хэмээх гэрчлэлээ би хэрхэн хуваалцаж чадах вэ?
- 272 Би сүмд хэрхэн илүү үр дүнтэй үйлчилж сурах вэ?
- 276 Би хэрхэн илүү сайн удирдагч болж чадах вэ?
- 280 Би хэрхэн илүү сайн багш болж чадах вэ?
- 284 Бусадтай сайн мэдээ хуваалцах ямар үр дүнтэй арга замууд байдаг вэ?
- 288 Би Хоёр дахь Ирэлтийн талаар заахад ашиглагддаг шинж тэмдгүүдийг хэрхэн ойлгож болох вэ?
- 291 Би Хоёр дахь Ирэлтэд бэлтгэхэд туслах ямар зүйлүүдийг судраас сурч чадах вэ?

295 ХАВСРАЛТ

Нэгдүгээр сар: Бурхан Тэргүүтэн

*“Бурхан, Мөнхийн Эцэг мөн Түүний Хүү Есүс Христ мөн Ариун Сүнсэнд бид итгэдэг”
(Итгэлийн Тунхаг 1:1).*

Энэхүү бүлгийн тоймууд нь өсвөр үеийнхэнд судраас суралцан, бусадтай гэрчлэлээ хуваалцах явцдаа Бурхан Тэргүүтэний гишүүдэд итгэх итгэлээ хүчирхэгжүүлж сурахад нь тусална. Тэд сайн мэдээнээс суралцаж мөн үүнийг заахдаа Ариун Сүнсний удирдамжийг дагаснаар туршлага суух болно. Тэднийг судалж байгаа зүйлсийнхээ тухай асууж лавлан, илүү ихийг сурахыг эрэлхийлж, сурч мэдсэн зүйлээ бусадтай хуваалцахад нь дэмжээрэй.

Энэ сард сонгох тоймууд:

Суралцахад минь Ариун Сүнс надад хэрхэн тусалдаг вэ?

Судраас судлах нь надад Тэнгэрлэг Эцэгийнхээ тухай мэдэхэд хэрхэн тусалж чадах вэ?

Тэнгэрлэг Эцэгийн тухай мэдэж авахад нь би бусдад хэрхэн тусалж чадах вэ?

Тэнгэрлэг Эцэгийн нөлөө бүхий л зүйл дээр байдгийг би хэрхэн олж харж сурах вэ?

Сайн мэдээг заахад Ариун Сүнс надад хэрхэн тусалдаг вэ?

Багшид зориулсан зөвлөмж

Энэхүү бүлгийн хичээлийн туршид та Бурханы нэрс нь ариун нандин гэдгийг өсвөр үеийнхэнд сануулж болно (С ба Г 63:61-ийг үзнэ үү). Тэднийг эдгээр нэрсийг хүндэтгэл, бишрэлтэй хэрэглэхэд нь дэмжээрэй.



НЭГДҮГЭЭР САР: БУРХАН ТЭРГҮҮТЭН

Суралцахад минь Ариун Сүнс надад хэрхэн тусалдаг вэ?

Ариун Сүнс бидэнд бүх зүйлийг заах бөгөөд бүх зүйлийг сануулах болно хэмээн Аврагч амласан (Иохан 14:26-г үзнэ үү). Сайн мэдээг ангидаа, хувиараа мөн өөр бусад үед суралцахад биднийг өдөөж болохын тулд Ариун Сүнсний нөхөрлөлийг эрэлхийлэх нь сайн мэдээнээс суралцагч бидний үүрэг юм. Түүний нөлөөний төлөө залбирч мөн ойлголтыг маань гэгээрүүлэх тэр өдөөлтүүдийг сонсох нь Сүнсээр суралцахад хүргэдэг (Алма 32:28-г үзнэ үү).

Сайн мэдээг сурахад Ариун Сүнс танд яаж тусалсан бэ? Ямар туршлагыг та өсвөр үеийнхэнтэй хуваалцаж болох вэ?

Өсвөр үеийнхэн маань сүнслэг байдлын хувьд бэлтгэлтэйгээр хичээлдээ ирдэг үү? Тэд Сүнсийг эрэлхийлснээр тэдний сурч мэдэх зүйл хэрхэн нэмэгдэх вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судрууд болон материалуудыг залбиралтайгаар уншаарай. Сүнсээр сурахыг эрэлхийлэхэд нь өсвөр үеийнхнийг юу урамшуулан удирдана гэж та бодож байна вэ?

Иохан 16:13 (Ариун Сүнс биднийг үнэн рүү удирдана)

1 Коринт 2:9–14 (Бурханы зүйлсийг Ариун Сүнсээр л ойлгодог)

1 Нифай 10:19 (Бид хичээнгүйлэн эрэлхийлэх аваас, Бурханы нууцуудыг Ариун Сүнс илчлэх болно)

Алма 5:45–46; Моронай 10:3–5 (Ариун Сүнсээр дамжуулан бид үнэний гэрчлэлийг олж авч чадна)

С ба Г 11:12–14 (Сүнс оюуныг гэгээрүүлдэг)

Доналд Л.Холлстром “Түүний Сүмээр дамжуулан Түүний Сайн мэдээнд хөрвүүлэгдэх нь,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2012 оны 5-р сар, 13–15

А.Рожэр Мэррилл “Сүнсээр хүлээн авах нь” *Ensign* эсвэл *Лиахона*, 2006 оны 11-р сар, 92–94

“Ариун Сүнсээр сурах нь” *Миний сайн мэдээг номло* (2004), 20

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутанд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, Сүмийн бусад хичээлүүд, эсвэл найз нартайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний хамаарлыг олж харахад нь та нар өсвөр үеийнхэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Бурханы талаар заалгасан зүйлсээ гэр бүлийнхэнтэйгээ хуваалцахыг суралцагчдаас хүс.

- “Танд ариун ёслолын уйтгартай цуглаанд оролцож байгаа мэт санагдвал та яах вэ?” гэсэн асуултанд хариулсан ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбаллын хариултыг уншихыг өсвөр үеийнхнээс хүс. (Доналд Л.Холлстромийн хэлсэн “Түүний сүмээр дамжуулан Түүний

Сайн мэдээнд хөрвүүлэгдэх нь” хэлсэн үгэнд). Яагаад ерөнхийлөгч Кимбалл хэзээ ч ариун ёслолын уйтгартай цуглаанд сууж үзээгүй гэж хэлсэн бэ? Ариун ёслолын цуглаан эсвэл сүмийн өөр бусад хичээлийн үеэр Сүнсийг мэдэрсэн туршлагаасаа хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс. Цуглаан болон хичээл дээр Сүнсийг мэдрэхийн тулд тэд хэрхэн бэлдсэн бэ? Тэднийг хариултаа самбар дээр жагсаан бичихэд урь.

Хамтдаа суралц

Сүнсээр сурна гэдэг нь юу гэсэн үг болохыг өсвөр үеийнхэн ойлгоход дараах үйл ажиллагаанууд туслах болно. Ариун Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Энэ тоймд санал болгосон судраас уншихыг мөн сайн мэдээг сурахад бидэнд Ариун Сүнс яаж тусалдаг талаар олж уншихыг ангийн гишүүн бүрээс хүс. Сайн мэдээг Сүнсний нөлөөгүйгээр сурахаар хичээхэд гарч болох үр дагаврууд нь юу вэ? Сайн мэдээг суралцах явцдаа Ариун Сүнсний нөлөөг мэдэрсэн талаар хувийн туршлагаасаа хуваалц. Тэднээс бас тиймэрхүү туршлага байвал хуваалцахыг хүс.

- А.Рожэр Мэрриллийн хэлснээр Сүнсээр хүлээж авахын тулд бидний хийх ёстой гурван зүйлийн жагсаалтыг уншихыг залуу үеийнхнээс хүс (“Сүнсээр хүлээн авах нь” түүний хэлсэн үгсээс). Ангийн гишүүн бүрийг энэхүү гурваас аль нэгийг нь сонгон, түүнтэй холбоотой судар эсвэл туршлагаасаа хуваалцахыг хүс. Хувиараа судраас суралцах үед, Ням гарагийн хичээлд эсвэл сайн мэдээнээс суралцах бусад үед тэд

Мэррилл ахын зөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж болох талаар саналаа хуваалцахыг тэднээс хүс.

- *Миний сайн мэдээг номло* номноос (20-р хуудас) тэд “Ариун Сүнсээр сурах нь” гэсэн хэсгийг уншихыг мөн Сүнсээр суралцсанаар ирэх адислалуудыг олж мэдэхэд өсвөр үеийнхнийг урь. Бишопын зөвшөөрөлтэйгээр бүрэн цагийн номлогч нарыг (эсвэл саяхан буцаж ирсэн номлогчийг) урин, Сүнсээр сурахыг эрэлхийлснээр эдгээр адислалууд хэрхэн биелэгдсэнийг харсан тухайгаан ангийнхантай хуваалцахад урь. Сүнсээр суралцах нь тэдний амьдралыг хэрхэн адисалж болох тухай хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс. Сайн мэдээг сурах явцдаа Сүнсийг урихын тулд тэд юуг хийх хэрэгтэй вэ?

Заахад туслах арга

“Заах тэдний зүрх сэтгэлд нь сайн мэдээг хүргэхийн тулд Сүнс байх хэрэгтэй (2 Нифай 33:1; С ба Г 42:14-ийг үзнэ үү). Тиймийн тулд, Сүнсийг урин мөн хичээлд зөв уур амьсгалыг бий болгох арга барилыг та нар ашиглах хэрэгтэй” (*Teaching, No Greater Call* [1999], 91).

Өнөөдөр сурч мэдсэн зүйлийнхээ тухай хуваалцахыг тэднээс хүс. Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Сүнсээр сурна гэдэг нь юу гэсэн үг болохыг тэд ойлгож байна уу? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан зүйлийнхээ улмаас тэд юуг хийх урмыг авч байгаа талаар тэднээс асуу. Уг мэдрэмжүүдийнхээ дагуу үйлдэхэд тэднийг уриал. Дагаж болох арга замуудын талаар залбиралтайгаар бодохдоо Сүнсийг эрэлхийлээрэй.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нартаа итгэн, тэдэнд заах, адислах мөн бусдад үйлчлэх үүргийг оноосон. Сурч байгаа зүйлээ бусадтай хуваалцах ямар боломжуудыг та өсвөр үеийнхэнд өгч чадах вэ?



НЭГДҮГЭЭР САР: БУРХАН ТЭРГҮҮТЭН

Судраас судлах нь надад Тэнгэрлэг Эцэгийнхээ тухай мэдэхэд хэрхэн тусалж чадах вэ?

Түүхийн туршид бошиглогчид Бурханы тухай үнэнийг илчилсээр ирсэн. Бид судрууд дахь тэдний гэрчлэлийг тууштай судалснаар Тэнгэрлэг Эцэгийн мөн чанарын тухай суралцаж, итгэл ба гэрчлэлээ өсгөж чадна. Тэнгэрлэг Эцэгийн тухай илүү сайн ойлгох тусам бид Түүний сүнсэн хүүхдүүд болох өөрсдийнхөө тэнгэрлэг хүчин чадлыг илүү сайн ойлгодог.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Та судрууд болон эдгээр бусад материалуудыг залбиралтайгаар судлах явцдаа өсвөр үеийнхэнд Тэнгэрлэг Эцэгийн тухай сурахад туслах хэсгүүдийг олж уншаарай.

Омнаи 1:17; Мозая 1:3–7; Алма 37:8–9 (Бурханы тухай ойлгоход судрууд тусалдаг)

С ба Г 1:37–39; 18:34–36 (Судруудаас бид Бурханы дуу хоолойг сонсож чадна)

Библийн лавлах “Бурхан”

Д.Тодд Кристоффэрсон “Судруудын адислал,” *Ensign* ба *Лиахона*, 2010 оны 5-р сар, 32–35; мөн “Судруудын адислал” видео бичлэгийг үзнэ үү.

Судраас бие даан судлах нь Тэнгэрлэг Эцэгт итгэх итгэл ба Түүний тухай гэрчлэлээ хүчирхэгжүүлэхэд тань хэрхэн тусалсан бэ? Өсвөр үеийнхэнд тусгай байж болох судраас судлах ямар арга барилуудыг та ашигласан бэ?

Яагаад Тэнгэрлэг Эцэгийн тухай ойлгож, мэдэх нь өсвөр үеийнхэнд чухал байдаг вэ? Ямар судрууд тэдэнд хамгийн тусгай гэж та бодож байна вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутын туршид өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, Сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь та нар тэдэнд яаж тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

• Ангийн нэг хөвгүүнийг Аароны Санваарын Чуулгын цуглаанаас саяхан Бурхан Тэргүүтэний тухай сурсан ямар нэг зүйлийн тухай залуу

эмэгтэйчүүдтэй хуваалцахад урь. Дараа нь нэг охиныг Залуу Эмэгтэйчүүдийн ангид сурсан зүйлээ залуу эрэгтэйчүүдтэй хуваалцахад урь.

- Өсвөр үеийнхнээс “Судрууд байхгүй эсвэл судруудаа уншдаггүй хүмүүст юу тохиолдох вэ?” гэж асуу. Асуултанд хариулахын тулд тэднийг энэхүү тоймд санал болгосон нэг судрыг эсвэл “Судрууд

бидний оюун ухааныг тэлдэг” хэмээх хэсгээс ахлагч Д.Тодд Кристоффэрсоны Судруудын адислал гэсэн хэлсэн үгээс уншихыг урь. Ойлгосон зүйлийнхээ тухай хуваалцахыг тэднээс хүс.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаанууд нь суралцагчдад Бурхан Тэргүүтэний тухай ойлголтоо гүнзгийрүүлэхийн тулд судрыг хэрхэн ашиглах тухай ойлгоход нь тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг эсвэл түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

- Нэг суралцагчаас самбар дээр Бурханы тухай өөрсдийн мэддэг зарим үнэнийг жагсаан бичихийг хүс. Тэднээс тэд яаж эдгээр үнэнийг мэддэг болсон бэ? хэмээн асуу. Өөрсдийн жагсаасан Бурханы тухай үнэнүүдийг судруудаас олохын тулд Сэдэвчилсэн Удирдамж хэрхэн ашиглаж болохыг тэдэнд үзүүл (жишээ нь тэд “Бурханы хайр” эсвэл “Бурханы мэргэн ухаан” гэж хайж болно). Тэднийг самбар дээр олсон эшлэлүүдээ бичихэд урь. Эдгээр судрыг уншаад Тэнгэрлэг Эцэгийн тухай олж мэдсэн нэмэлт зүйлсээ хуваалцахыг тэднээс хүс. Бурханыг ойлгоход судрууд яагаад чухал байдаг вэ?

- Судраас нэг бүлэг эсвэл судрын нэг хэсгийг сонгож аваад, суралцагчдад энэ бүлгээс тэд Тэнгэрлэг Эцэгийн тухай юу сурч болохыг үзүүл. Жишээлбэл, та тэдэнд 1 Нифай 1 нь Түүний алдар суу (8–9-р шүлгийг үзнэ үү) мөн Түүний нигүүлслийн тухай (14, 20-р шүлгийг үзнэ үү) заадгийг үзүүлж болох юм. Хичээл дээр тэдэнд

судрын нэг бүлэг эсвэл судрын нэг хэсгийг уншин, Тэнгэрлэг Эцэгийн тухай уншсан зүйлээ тэмдэглэн бичих цаг гаргаж өг. Та тэдэнд дараах судрын хэсгүүдийг санал болгож болно: Исаиа 55; 2 Нифай 26:23–33; Мозая 2:19–25; Сургаал ба Гэрээ 1:17–39. Тэд үүнийг ганцаараа, бүлгээрээ эсвэл бүгдээрээ хамтран хийж болно. Тэднийг сурсан зүйлээ нэг нэгэнтэйгээ хуваалцахад урь.

- Тэднээс Библийн лавлахаас “Бурхан” гэсэн хэсгийг дор бүрнээ уншаад, Бурхан Эцэгийн тухай сурч авсан нэг зүйлээ бичихийг хүс. Уг хэсэгт эш татсан холбогдох судруудыг уншихад нь тэднийг дэмж. Бүгд бичиж дууссаны дараа тэднээс өөрөөс нь өөр зүйлийг бичсэн нэг суралцагчийг олохыг хүс. Тэгээд өөрсдийн сурсан зүйлээ нэг нэгэнтэйгээ хуваалцахыг хүс (олсон судруудаа мөн). Та судруудыг уншсанаар Тэнгэрлэг Эцэгээ илүү сайн мэддэг болсон тухайгаа хуваалц. Мөн цөөн хэдэн суралцагчийг туршлагаасаа хуваалцахад урь.

Заахад туслах арга

Ихэнх тохиолдолд таны заах зүйлс хичээлийн цагт багтахааргүй их байдаг. Ийм тохиолдолд та таны заах хүмүүст хамгийн тустай материалуудыг сонгох хэрэгтэй болдог (*Teaching, No Greater Call* [1999], 98–99).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Эцэгийнхээ төлөвлөгөөн дэх Өөрийн үүрэг хариуцлагын тухай зааж, гэрчлэхдээ судруудыг ашигласан юм. Та өсвөр үеийнхнийг Тэнгэр дэх Эцэгийнхээ тухай илүү сайн мэдэхийн тулд судруудыг ашиглаж сурахад нь хэрхэн тусалж чадах вэ?

Өнөөдөр сурсан зүйлээ хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс. Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Судраас суралцах нь Тэнгэрлэг Эцэгийнхээ тухай илүү сайн мэдэхэд хэрхэн тусалдаг болохыг тэд ойлгосон уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан зүйлээ судраас хувиараа судлахдаа ашиглахад нь тэднийг дэмж. Дараагийн хичээл дээр тэднийг судраас судлахдаа Тэнгэрлэг Эцэгийн тухай олж мэдсэн зүйлийнхээ талаар хуваалцахад урь.

Сонгосон материалууд

*Д.Тодд Кристоффэрсон, “Судруудын адислал”,
Ensign эсвэл Лиахона 2010 оны 5 сар, 32–35*

Судрууд нь Их Эзэнээ болон Түүнтэй мөн Эцэгтэйгээ ямар харилцаа холбоотойгоо үргэлж санахад бидэнд тусалснаар бидний ой ухааныг тэлдэг юм. Тэдгээр нь мөнх бус байдлын өмнөх амьдралдаа бидний мэдэж байсан бүхнийг сануулдаг. Тэдгээр нь мөн бидний үзэж хараагүй өөр эрин зууны, хүмүүсийн болон үйл явдлуудын тухай зааснаараа бидний ой ухааныг тэлдэг юм. Бидний хэн нь ч Улаан Тэнгисийг хоёр тал руу нь хуваагдаж байхад Мосегийн хамт усан ханан дундуур нөгөө тал руу нь гарч яваагүй билээ. Бид уулан дээрх Есүсийн номлолыг сонсохоор, мөн үхлээс амилсан Лазарьг харахаар, Аврагчаа Гетсеманид болон загалмай дээр хэрхэн зовсныг нь харахаар тэр үед байгаагүй юм. Мөн бид хоосон агуйд хоёр тэнгэр элч Мариад Есүсийг амилсан гэж гэрчлэхэд байгаагүй юм. Та нар болон би Өгөөмөр нутагт цугласан олны дунд байж амилсан Аврагчийн хүссэнээр түүний хадаасны оромны сорвийг тэмтэрч Түүний хөлийг нулимсаараа булхаагүй билээ. Бид Ариун Ойн Цоорхойд Иосеф Смитийн хажууд өвдөглөн сууж Эцэг, Хүү хоёрыг гайхширан ширтээгүй билээ. Гэсэн хэдий ч бидний мэдэхгүй зүйлсийг бидэнд зааж ой ухааныг маань тэлэх судрууд бидэнд байдаг учраас бид энэ бүхний тухай болон үүнээс ч илүү их зүйлсийг мэддэг билээ. Ингээд эдгээр зүйлс нь бидний оюун ухаан болон зүрх сэтгэлд нэвтрэх үед Бурхан

болон Түүний Хайрт Хүүд итгэх бидний итгэл үндэслэж эхэлдэг билээ.

Судрууд нь эртний үеийнхэн болон бидэнд сурснаа мартахагүй байхад маань тусалснаар бидний ой ухааныг мөн тэлдэг билээ. Бурханы цэдэглэгдсэн үгс өөрсдөд нь байхгүй эсвэл үүнийг үл ойшоодог тэдгээр хүмүүс аажмаар Түүнд итгэхээ больж өөрсдийн оршихуйн зорилгыг мартдаг билээ. Лихайн хүмүүс Иерусалимыг орхин явахдаа гуулин ялтсуудыг авч явсан нь хичнээн чухал байсныг та нар санах болно. Эдгээр судрууд нь тэдэнд Бурханы тухай болон хожим ирэх Христийн гэтэлгэлийн тухай мэдэхэд нь зайлшгүй хэрэгтэй байсан юм. Лихайн дараахан Иерусалимаас гарч ирсэн өөр нэг бүлэг хүмүүст судар байгаагүй бөгөөд ойролцоогоор гурав юмуу дөрвөн зуун жилийн дараа Лихайн удмынхан тэдэнтэй тааралдахад “тэдний хэл гуйвуулагджээ; мөн тэд өөрсдийг нь Бүтээгч байдгийг үгүйсгэсэн бөлгөө;” (Омнай 1:17) хэмээн цэдэглэгдсэн байдаг.

Тиндэйлийн үед хүмүүс Библийг олох боломжгүй, ялангуяа өөрсдийнх нь ойлгох хэл дээр байгаагүйн улмаас судрыг үл ойлгох байдал тархсан байсан. Харин өнөө үед Библи болон бусад судруудыг олж авахад үлэмж хялбар болсон ч судрыг үл ойлгох хүмүүсийн тоо нэмэгдсээр байна. Учир нь хүмүүс номыг нээж үзэхгүй байгаа юм. Үүний улмаас тэд өөрсдийн өвөө, эмээгийн мэдэж байсан зүйлсийг мартаж болжээ.



НЭГДҮГЭЭР САР: БУРХАН ТЭРГҮҮТЭН

Тэнгэрлэг Эцэгийн тухай мэдэж авахад нь би бусдад хэрхэн тусалж чадах вэ?

Өнөө үед олон хүн Бурханы тухай ямар ч ойлголтгүй эсвэл Түүний тухай маш буруу ойлголттой байдаг. Бидэнд бүрэн дүүрэн сайн мэдээ байдаг учраас бид Тэнгэрлэг Эцэгийн тухай хийгээд тэд Түүнтэй ямар холбоотой болохыг ойлгоход нь бусдад тусалж чадна.

Бурхан Эцэгийн тухай бусдад заасан эсвэл заалгасан ямар туршлагауд танд байдаг вэ? Зааж байгаа хүмүүсийнхээ итгэл бишрэлийг ойлгох нь яагаад тустай вэ?

Бурхан Эцэгт итгэдэг итгэлийнхээ талаар бусадтай хуваалцах ямар боломжууд өсвөр үеийнхэнд байдаг вэ? Эдгээр боломжуудад бэлтгэхэд нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалуудыг залбиралтайгаар судла. Бусдад заахад тэдэнд юу хамгийн тустай гэж та бодож байна вэ?

Алма 18:24–40; 22:4–23 (Аммон Аарон хоёр леменчүүдийн хаанд Бурханы тухай заадаг)

Алма 30:12–15, 37–53 (Корихор Алматый Бурхан оршдог тухай маргадаг)

“Бурхан бол бидний хайртай Тэнгэрлэг Эцэг,” *Миний сайн мэдээг номло* (2004), 33–34

“Зааж буй хүмүүсээ ойлгох нь,” *Teaching, No Greater Call* (1999), 33–34

“Бурхан Эцэг,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 59–61

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутын туршид өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, Сүмийн бусад хичээлүүд, эсвэл найз нартайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь та нар тэдэнд яаж тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Бурхан Тэргүүтэний тухай сүүлийн үед сурч мэдсэн зүйлийнхээ тухай хуваалцахыг тэднээс хүс. Тэдэнд ямар асуултууд байна вэ? Тэд нэг нэгэндээ асуултуудынхаа хариуг олоход нь хэрхэн тусалж чадах вэ?

- Тэнгэрлэг Эцэгийн тухай юу гэж боддог тухайгаа нэг минутанд бичхийг тэднээс хүс (шаардлагатай бол тэдэнд “Бурхан бол бидний хайртай Тэнгэрлэг Эцэг” *Миний сайн мэдээг номло* 33–34; эсвэл “Бурхан Эцэг,” *Итгэлдээ үнэнч байх нь* 59–61-г уншихыг санал болго). Цөөн хэдэн

суралцагчийг бичсэн зүйлсээ хуваалцахад урь. Өөр итгэл бишрэлтэй хэн нэгэнтэй Бурханы тухай ярилцсан туршлагаасаа хуваалцахыг тэднээс

хүс (эсвэл та өөрийнхөө туршлагаас хуваалцаж болно). Энэ ярилцлагаас тэд юу сурсан бэ?

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаанууд нь Бурханы талаарх итгэлээ бусдад тайлбарлаж сурахад нь өсвөр үеийнхэнд тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Ангиараа эсвэл жижиг бүлгүүд болж Алма 30:12–15, 37–53-г дүгнэ. Зарим суралцагчаас Корихор Бурханд итгэдэггүй байсан шалтгаануудыг харин бусад суралцагчаас Алма Бурханд итгэдэггүй байсан шалтгаануудыг олохыг хүс. Тэднээс Корихортой ижил бодолтой хүмүүсийг таньдаг уу? гэж асуу. Бурхан оршдог эсэхэд эргэлздэг найздаа туслахад тэднийг дэмж. Найздаа туслах төлөвлөгөөг гаргахад нь тэдэнд туслахын тулд цаг гарга. Тэд ямар туршлагаас хуваалцаж болох вэ? Тэд хэрхэн зохистойгоор гэрчлэлээ хуваалцаж болох вэ?

- Ангийн хагас суралцагчаар Алма 18:24–40-г харин үлдсэн суралцагчдаар Алма 22:4–23-г уншуул. Аммон болон Аароны жишээнүүдээс тэд заах талаар юу сурдаг вэ? Лемонай болон түүний эцэгт Бурханы тухай

Өнөөдөр сурсан зүйлээ хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс. Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Бусдад Тэнгэрлэг Эцэгийн тухай сурахад нь хэрхэн тусалж болохыг тэд ойлгосон уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан зүйлийнхээ улмаас тэд юуг хийхээр өдөөгдсөн тухай асуу. Уг мэдрэмжүүдийнхээ дагуу үйлдэхэд тэднийг уриал. Дагаж болох арга замуудын талаар залбиралтайгаар бодохдоо Сүнсийг эрэлхийлээрэй.

Заахад туслах арга

“Буруу хариултуудад хүндэтгэлтэйгээр мөн эелдэгээр хариул. Уг хүн хичээлд үргэлжлүүлэн оролцохдоо санаа зовохгүй байхад анхаар. Та хариуцлагыг өөртөө авахын тулд “Би асуултаа тодорхой тавиагүй юм шиг байна. Намайг уучлаарай. Би дахиад асуудаа” гэх мэтээр хэлж болно” (*Teaching, No Greater Call* [1999], 69).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч зааж буй хүмүүсээ мэддэг бас ойлгодог байсан. Тэрээр тэдэнд сурч мөн өсч хөгжихөд нь туслах онцгой арга барилтай байсан. Та өөрийн суралцагчдынхаа тухай сайн мэддэг үү? Та яаж илүү сайн мэдэж чадах вэ? Энэ нь таны заах арга барилд хэрхэн нөлөөлөх вэ?

Сонгосон материалууд

“Бурхан Эцэг” Итгэлдээ үнэнч байх нь (2004), 74–76

Бурхан Эцэг бол бидний итгэж, бишрэн шүтдэг Агуу Биет юм. Тэр бол эцсийн Бүтээгч, Удирдагч, бүх зүйлийн Хамгаалагч юм. Тэрээр төгс төгөлдөр, Түүнд бүх хүч байдаг ба бүх зүйлийг мэддэг. Тэр “хүмүүнийхтэй адил мэдрэгдэх мах хийгээд ясан биетэй болой;” (С ба Г 130:22).

Бидний Тэнгэрлэг Эцэг бол шүүлт, хүч чадал, мэдлэг болон хүчний Бурхан боловч Тэр мөн төгс нигүүлсэл, зөөлөн сэтгэл, энэрлийн Бурхан юм. Хэдийгээр бид “бүх зүйлүүдийн утгыг мэдэх нь үгүй” ч бид Тэр биднийг хайрладаг хэмээх лавтай мэдлэгээр амар амгаланг олж чадна. (1 Нифай 11:17-г үз).

Бидний Сүнсний Эцэг

Амьдралын талаарх агуу их асуултуудын нэг бол “Би хэн бэ?” гэсэн асуулт юм. Хүүхдийн хэсгийн хайр хүрэм дуу бяцхан хүүхдүүдэд ч мөн энэ асуултад хариулахад тусалдаг. Бид “Би Бурханы хүүхэд, Тэрээр намайг энд илгээсэн билээ” хэмээн дуулдаг. Бид бол Бурханы хүүхдүүд гэдгийг мэдэх нь хүч чадал, тайвшрал болон итгэл найдварыг өгдөг.

Та бол зуурдын байдлын өмнөх амьдралд сүнсээр төрсөн Бурханы хүүхэд мөн. Түүний хүүхэд ёсоор танд тэнгэрлэг, мөнхийн боломж байгаа гэдэгт итгэлтэй бай. Мөн Тэр энэхүү боломжид хүрэх чин сэтгэлийн хичээл зүтгэлд тань туслах болно.

Агуу Бүтээгч

Тэнгэрлэг Эцэг бол Эрхэм дээд Бүтээгч юм. Есүс Христээр дамжуулан Тэр тэнгэр, газар дэлхий хийгээд түүн дээр байх бүх зүйлсийг бүтээжээ (Моисе 2:1-ийг үз). “мөн бүх зүйл Бурхан байдгийг үзүүлдэг; тийм ээ, бүр газар дэлхий, мөн үүний гадаргуу дээрх бүх зүйл, тийм ээ, мөн үүний хөдөлгөөн, тийм ээ, мөн түүнчлэн өөрсдийн байнгын замаар хөдлөх тэр бүх гарагууд Эрхэм дээд Бүтээгч байдгийг гэрчилдэг юм” хэмээн Алма хэлжээ (Алма 30:44).

Цагаас цагт бүтээлийн гоо сайхныг тунгаан бод: модол, цэцэгс, амьтад, уул нурууд, далайн давалгаа, сая төрсөн хүүхэд. “Бурхан өөрийн алдар суу мөн хүч чадлаараа хөдөлж” байгаагийн баталгаа болсон тоо томшгүй олон одыг харан тэнгэр өөд ширтэх цаг гарга (С ба Г 88:41–47-г үз).

Авралын Төлөвлөгөөний Зохиогч

Тэнгэр дэх Эцэг маань биднийг Өөртэйгээ мөнхөд хамт амьдраасай хэмээн хүсдэг. Түүний ажил, алдар суу бол “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь миний ажил мөн миний алдар суу бөлгөө” (Моисе 1:39). Үүнийг боломжтой болгохын тулд Тэр авралын төлөвлөгөөг бэлтгэсэн юм. Тэрээр Өөрийн хайрт Хүү, Есүс Христийг үхлийн хүлээсийг тайлуулахаар, дэлхийн нүглийг цагаатгахаар илгээжээ: “Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм” (Иохан 3:16). Энэхүү золиослол нь Эцэг биднийг хайрлагчийн агуу илрэл юм.



Би Тэнгэрлэг Эцэгийн нөлөө бүхий л зүйл дээр байдгийг хэрхэн олж харж сурах вэ?

Бошиглогч Алма “Бүх зүйл Бурхан байдгийг үзүүлдэг” хэмээн заадаг (Алма 30:44-ийг үзнэ үү). Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай бөгөөд биднийг өдөр бүр адисалдаг. Бид анхааралтай ажиглах юм бол Түүний хүч чадлын нотолгоог өөрсдийн амьдралд болон эргэн тойрондоо харж чадна. Бид Түүнийг бодитоор нь харж чадахгүй байж болох ч Түүний нөлөөг бүх зүйл дээр харснаар Түүнийг амьд хэмээх гэрчлэлээ өсгөж чадна.

Та Тэнгэрлэг Эцэгийн нөлөөг хэзээ анзаарч байсан бэ? Та Түүний нигүүлслийг таньж мэдэхийн тулд юу хийдэг вэ?

Та өсвөр үеийнхний амьдрал дахь Тэнгэрлэг Эцэгийн нөлөөг ямар арга замуудаар харж байсан бэ? Тэнгэрлэг Эцэгийн нөлөөг таньж мэдэхгүй өнгөрөхөөс өсвөр үеийнхнийг юу сэргийлж чадах вэ? Түүний нөлөөг таньж мэдэж сурах нь тэдний амьдралыг одоо мөн ирээдүйд хэрхэн адислах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар, материалыг залбирч судал. Бурханы нөлөөг таньж мэдэхэд нь өсвөр үеийнхэнд юу туслах вэ?

Дуулал 145:9; 1 Нифай 1:20 (Их Эзэний нигүүлсэл Түүний бүхий л бүтээлд оршдог)

Алма 30:44; Мосе 6:63 (Бүх зүйл Бурхан байдгийг гэрчилдэг)

С ба Г 59:21 (Бүх зүйл дээр Бурханы гарыг хүлээн зөвшөөрдөггүй хүнд Бурхан гомддог)

Ким Б.Кларк, “Харах нүд, сонсох чих,” *Ensign* эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 120.

Хэнри Б.Айринг, “Өө санацгаа, санацгаа” *Ensign* ба *Liahona*, 2007 оны 11-р сар, 66–69; мөн “Өө санацгаа, санацгаа” видео бичлэгийг үзэж болно (хуулбарлах боломжгүй)

Дэвид А.Бэднар, “Их Эзэний нигүүлсэл,” *Ensign* ба *Liahona*, 2005 оны 5-р сар, 99–102; мөн “Их Эзэний нигүүлсэл” видео бичлэгийг үзэж болно

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутын туршид өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, Сүмийн бусад хичээл эсвэл найзуудтайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад та нар тэдэнд яаж тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Сайн мэдээний талаарх гэрчлэлийг нь өсгөсөн өнгөрсөн долоо хоногийнхоо туршлагаас хуваалцахыг тэднээс хүс.

- Бурхан таны амьдралыг удирдан чиглүүлж, таныг хамгаалж эсвэл адисалж байгааг ойлгосон тухай өөрийн туршлагаас хуваалц. Тэнгэрлэг Эцэгийн тухай гэрчлэлээ хуваалц.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаанууд нь өсвөр үеийнхнийг өөрсдийн амьдралд Бурханы нөлөөг олж харахад нь туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

Заахад туслах арга

Нэг суралцагч судраас чангаар уншин бусад нь түүнийг даган судраа харж гүйлгэн унших ёстой. Тэднээс сонсож мөн онцлох зарчим буюу санааг олохыг хүс. Уншихаас нь өмнө судраасаа уг судрын эшлэлийг олох цагийг тэдэнд олго (*Teaching, No Greater Call* [1999], 56).

- Өсвөр үеийнхэнд Их Эзэний мутрыг өөрсдийн амьдралд харж сурахад нь туслахын тулд тэднийг ахлагч Ким Б.Кларкийн “Харах нүд, сонсох чих” хэлсэн үгийг уншихад урь. Тэд Тэнгэрлэг Эцэгийн мутрыг хэрхэн харж мөн Түүний дуу хоолойг хэрхэн сонсох талаар энэ хэлсэн үгээс юу сурсан бэ? Та энэ ярилцлагын нэг хэсэг болгон хараатай, сонсголтой байхын ашиг тусыг мөн харж, сонсож чадахгүй байхын бэрхшээлийн талаар ярилцаж болно. Та сүнслэгээр харж, сонсдог байхын ач холбогдлыг хэрхэн дүрслэн харуулах вэ? Та болон өсвөр үеийнхэн сүнслэгээр сонсож, харах талаар ямар ямар жишээ хуваалцаж чадах вэ?

- Энэхүү тоймд санал болгосон видео бичлэгүүдийн нэгийг үзүүл. Уг видео бичлэгт гарч байгаа хүмүүс Бурханд яагаад итгэсэн шалтгаануудыг өсвөр үеийнхнээс асуу. Энэ хүмүүс Түүний нөлөөлсөн ямар нотолгоог эргэн тойрноосоо харсан бэ? Өсвөр үеийнхэн өөр ямар нотолгоог хардаг бэ? Тэнгэрлэг Эцэг тэдний амьдралд хэрхэн нөлөөлдөг тухай гэрчлэлээ хуваалцахыг тэднээс хүс.

- Ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн “Өө санацгаа, санацгаа” хэлсэн үгийг уншихыг эсвэл холбогдох видео бичлэгийг үзэхийг урь. Ерөнхийлөгч Айринг өөрийн амьдралдахь Бурханы нөлөөг эрж хайснаар ямар адислал хүлээн авсан бэ? Туулж буй туршлагауудынхаа тухай тунгаан бодож, ерөнхийлөгч Айрингийн санал болгосон “Бурхан зөвхөн надад зориулж захиас илгээсэн үү?” гэдэг асуултыг өөрсдөдөө тавьж, хариулахыг тэднээс хүс. Би Түүнийг амьдралд маань нөлөөлөхийг харж байсан уу? Өөрсдийн хариултыг суралцагчидтай хуваалцахад тэднийг дэмж. “Бурханы сайхан сэтгэлийг таньж мэдэх мөн үүнийг санаж явах арга замуудыг олох зүйлийг хийхэд нь өсвөр үеийнхнийг дэмж.

- Тэднийг “How Great Thou Art” дууллыг дуулах юм уу сонсох эсвэл уншихад урь. Энэхүү дуулалд Бурхан агуу болохыг дүрсэлсэн зүйлсийг самбар дээр зурах юм уу жагсаан бичихийг тэднээс хүс (тэд мөн энэ дууллын хойно эш татсан судрыг уншиж болно). Тэд энэ жагсаалтад Бурханы хүч чадал ба хайрын тухай өөр юу нэмж бичиж

болох вэ? Тэднээс Тэнгэрлэг Эцэгийн тухай гэрчлэлээ илэрхийлэх үр дүнтэй аргуудыг бодож олохыг хүс. Жишээлбэл, тэд энэ жагсаалтыг ашиглан богинохон дуулал өөрсдөө бичиж эсвэл гэрэл зураг авч зургийн цомог бэлтгэж болно. Дараагийн хичээл дээр өөрсдийн хийсэн зүйлийг хуваалцахад тэднийг дэмж.

- Дараах бүрэн бус өгүүлбэрүүдийг самбар дээр бич: “Би нигүүлслийг _____ гэж тодорхойлно. Нигүүлслийн нэг жишээ бол _____ юм. Хэрэв _____ бол би нигүүлслийг анзаарахгүй

Өнөөдөр сурсан зүйлээ хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс. Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Амьдралдаа Тэнгэрлэг Эцэгийн нөлөөг хэрхэн таньж мэдэх тухай тэд ойлгосон уу? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Ирэх долоо хоногт өөрийн амьдрал дахь Бурханы нөлөөг таньж мэдэхэд нь суралцагчдыг дэмж. Дараагийн долоо хоногийн хичээлийн эхэнд тэднийг туршлагаа хуваалцахад урь.

өнгөрөөж магадгүй.” Өсвөр үеийнхнийг эдгээр өгүүлбэрийг гүйцээн бичихдээ ахлагч Дэвид А.Бэднарын “Их Эзэний нигүүлсэл” хэлсэн үгнээс “Их Эзэний нигүүлсэл гэж юу вэ” гэдэг хэсгийг уншихад урь (эсвэл ийм нэртэй видео бичлэгийг үзэхэд). Тэднийг бодол санаагаа хуваалцахад урь. Нигүүлслийн ямар жишээг тэд өөрсдийн амьдралд харж байсан бэ? Эдгээр туршлага Тэнгэрлэг Эцэгийн тухай гэрчлэлийг нь хэрхэн хүчирхэгжүүлсэн бэ? Өөрсдийн туршлагаас хуваалцан итгэлээ өсгөхөд туслах хэн нэгнийг бодож олохыг тэднээс хүс.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч энгийн түүх ба амьдралын жишээнүүдээс хуваалцдаг байсан. Тэрээр дагалдагч нараа сайн мэдээний хичээлүүдийг өдөр тутмын амьдралдаа болон эргэн тойрноосоо олж нээхэд нь тусалдаг байсан. Бурхан оршдог болохыг бүх зүйл гэрчилдэг гэдгийг суралцагчдад гэрчлэх туршлага таны амьдралд тохиолдсон уу? Өсвөр үеийнхэнд тийм туршлага байгаа юу?

Сонгосон материалууд

Дэвид А.Бэднар, “Их Эзэний нигүүлсэл”. Ensign эсвэл Лиахона 2005 оны 5-р сар, 99–102

Саяхан болсон гадасны нэгэн чуулганаар 2003 оны 12-р сард Иракт нөхөр нь амь эрсэдсэн, дөрвөн хүүхдийн эх болох нэгэн залуу эхнэрийн сэтгэл хөдөлгөм гэрчлэл хуваалцах үед Их Эзэний эрхэм их нигүүлсэл илэрхий байсан билээ. Нөхөр нь амь эрсэдсэн талаар өөрт нь мэдэгдсэний дараа нөхрийнхөө өмнө нь явуулсан Христийн мэндэлсний баярын захиа, ил захидлыг хүлээн авсан талаараа энэ шантаршгүй эгч ийн өгүүлсэн юм. Амьдрал нь эмгэнэлтэйгээр өөрчлөгдөх гэнэтийн явдал тохиосон үед үнэхээр гэр бүлүүд мөнхөд хамтдаа байж чадна гэдгийг сануулах нигүүлсэм санамж цагаа олон энэ сайн эгчид иржээ. Түүний зөвшөөрөлтэйгээр би уг Христийн мэндэлсний баярын ил захидлаас эш татъя:

“Дэлхий дээрх хамгийн агуу гэр бүлд! Хамтдаа цагийг сайхан өнгөрөөн Христийн мэндэлсний баярын үнэн утга учрыг санаарай! Их Эзэн биднийг мөнхөд хамтдаа байх боломжтой болгосон. Тийм болохоор бид тусдаа байгаа ч гэр бүлээрээ хамтдаа байх болно.

“Бурхан ивээж та нарыг аюулгүй байлган мөн энэхүү Христийн мэндэлсний баярыг тэнгэр дэх Түүнд бидний хайрын бэлэг болгон өгөх болтугай!!!

“Та нартаа маш их хайртай шүү. Аав нь, хайрт нөхөр чинь!”

Христийн мэндэлсний баярын ил захидалдаа тусдаа байгаа гэж нөхөр нь бичсэн нь цэргийн

томилолтынхоо улмаас тусдаа байгаагаа бичиж байсан нь тодорхой. Гэхдээ энэ эгчийн хувьд талийгаач болсон мөнхийн хамтрагч, хүүхдүүдийнх нь аав нь, газар дороос дуу хоолой болж түүнд хамгийн хэрэгтэй байсан сүнслэг баталгаа, гэрч болон иржээ. Миний өмнө нь дурдсанаар Их Эзэний эрхэм их нигүүлсэл тохиолдлоор, эсвэл гэнэт санамсаргүй тохиодоггүй. Итгэлтэй байдал, дуулгавартай болон даруу байдал нь эрхэм их нигүүлслийг амьдралд маань урьж авчирдаг ба эдгээр чухал адислалуудыг таньж мэдэн мөн эрхэмлэх боломжийг Их Эзэний цаг хугацаа өгдөг.

Их Эзэний эрхэм их нигүүлслийн хүч чадлыг бид үл тоомсорлож дорд үзэх ёсгүй. Их Эзэний эрхэм их нигүүлслийн энгийн, энхрий байдал хийгээд тогтмол байдал нь бидний одоо амьдарч байгаа, мөн хойшид ирэх бэрхшээлт цаг үед биднийг хамгаалан бэхжүүлэхэд ихээр туслах болно. Өөрсдөд маань хэрэгтэй байгаа тайтгарлыг өгөх эсвэл мэдэрч буй баяр хөөрийг илэрхийлэх үгс олдохгүй үед, тайлбарлагдашгүй зүйлийг тайлбарлахыг хичээгээд бүтэхгүй үед, амьдралын шударга бус, эрх тэгш бус байдлын талаарх хангалттай ойлголтыг логик шалтгаан бий болгож чадахгүй байгаа үед, хүссэн үр дүнгээ гарган авахад зуурдын хүний туршилт, дүгнэлт хангалтгүй байх үед бидэнд ганцаараа байгаа мэт санагдах үед бид Их Эзэний эрхэм их нигүүлслээр үнэхээр адислагддаг ба мөн тэднийг аюулаас ангижрах чадалтай болтол нь хүчирхэг болгодог (1 Нифай 1:20-г үз).



НЭГДҮГЭЭР САР: БУРХАН ТЭРГҮҮТЭН

Сайн мэдээг заахад Ариун Сүнс надад хэрхэн тусалдаг вэ?

Бид сайн мэдээг заах үедээ Ариун Сүнс бол жинхэнэ багш гэдгийг даруунаар хүлээн зөвшөөрдөг байх ёстой. Ариун Сүнс биднээр дамжуулан зааж, гэрчилж, тайвшруулж мөн бусдад сүнслэгээр нөлөөлөх Ариун Сүнсний зэмсэг болон үйлчлэх нь бидэнд нэр төрийн хэрэг юм. Бид Сүнсийг хүлээн авахуйц зохистой амьдарч, бусдад заахаар бэлтгэхдээ Түүний удирдамжийг эрэлхийлэн залбирч мөн тэд Түүний нөлөөг мэдрэхэд нь туслах уур амьсгалыг бий болгох ёстой.

Сүнсээр зааж байгаага та хэрхэн мэдэх вэ? Өсвөр үеийнхэнтэй хуваалцаж болох сүнслэгээр заасан туршлага танд байгаа юу?

Сайн мэдээний тухай бусдад заах ямар боломжууд өсвөр үеийнхэнд байдаг вэ? Сүнсээр сурна гэдэг нь юу гэсэн үг болохыг тэд ойлгож байна уу? Зааж байхдаа Сүнсний дагах нь чухал гэдгийг ойлгоход нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалуудыг залбиралтайгаар уншаарай. Өсвөр үеийнхэнтэй юу хуваалцах хэрэгтэй гэж та сүнслэгээр өдөөгдсөн бэ?

Иохан 15:26; С ба Г 50:13–22; 52:9 (Гайтгаруулагч үнэнийг заахаар илгээгдсэн юм)

2 Нифай 33:1–2 (Ариун Сүнс бидний үгсийг хүмүүний үрсийн зүрх сэтгэлд хүргэдэг)

Алма 17:3 (Мозаягийн хөвгүүд хүч ба эрх мэдэлтэйгээр заахаар бэлтгэсэн)

С ба Г 11:21; 84:85 (Бид Бурханы үгийг олж авахаар эрэлхийлэх аваас Сүнс бидэнд юу хэлэхийг зааж өгнө)

С ба Г 42:11–17 (Бидэнд Сүнс байхгүй бол бид заах нь үгүй)

Даллин Х.Өүкс “Сүнсээр зааж судлах нь,” *Ensign*, 1997 оны 3-р сар, 6–14

Матвей О.Ричардсон “Сүнсний арга замаар заах нь,” *Ensign* ба *Лианахона* 2011 оны 11-р сар, 94–96

“Хөрвүүлэлт дэх Сүнсний хүч,” *Миний сайн мэдээг номло* (2004), 102–104

“Teach by the Spirit,” *Teaching, No Greater Call* (1999), 40–48

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутын туршид өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, Сүмийн бусад хичээлүүд, эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь та нар тэдэнд яаж тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Сүмийн хичээлүүд, семинар эсвэл гэр бүлийн үдэш дээр Сүнснийг мэдэрсэн тухайгаа эргэн санахыг тэднээс хүс. Сүнснийг урихын тулд зааж буй багш нь юу хийсэн бэ?
- Бусдад сайн мэдээг заах боломжуудыг жагсаан бичихийг суралцагчдаас хүс. Жагсаалтандаа тэд сайн мэдээг албан ёсны бус, төлөвлөгөөгүй цаг мөчид бас албан ёсоор

заах талаар оруулахад нь та сүнслэгээр нөлөөл. Самбар дээр “Сүнсээр заана гэдэг нь юу гэсэн үг вэ?” гэж бич. Суралцагчдыг хичээлийн туршид энэ асуултыг өөрсдийн жагсаан бичсэн заах боломжуудтай холбон үзэж хэрхэн үүнд хариулах вэ? гэж бодохыг хүс. Хичээлийн төгсгөлд тэднийг өөрсдийн бодлоо хуваалцахад урь.

Хамтдаа суралц

Сүнсээр сурна гэдэг нь юу гэсэн үг болохыг өсвөр үеийнхэн ойлгоход дараах үйл ажиллагаанууд туслах болно. Ариун Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Өсвөр үеийнхнээр дараах асуултаудын нэгийг сонгуул: Сүнсээр заах нь яагаад чухал вэ? Багш нар биднийг Сүнс хэрхэн адисалдаг вэ? Бидний заадаг хүмүүсийг Сүнс хэрхэн адисалдаг вэ? Зааж байхдаа Сүнснийг урихын тулд би юу хийх ёстой вэ? Суралцагч бүрийг Сүнсээр заах тухай судрын хэсгийг уншиж (энэхүү тоймд санал болгосон судрын хэсгүүдийг), сонгосон асуултынхаа хариултыг судраас олохыг хүс. Уншсан судрын хэсэг болон олсон хариултынхаа тухай хуваалцах боломжийг тэдэнд олго.
- Өсвөр үеийнхэнд Сүнсээр заах гэдэг нь юу гэсэн үг болохыг ойлгоход нь туслахын тулд ахлагч Даллин Х.Өүксийн “Сүнсээр зааж судлах нь” хэлсэн үгнээс эсвэл *Teaching, No Greater Call*, -ын 40–48-р хуудаснаас залбиралтайгаар сонгон заана уу. Суралцагчдыг хэдэн жижиг бүлэг болгоод бүлэг бүрээс эдгээрийн нэг хэсгийг хамтдаа уншин, Сүнсээр заалгахын тулд юу хийх ёстойг жагсаан бичихийг хүс. Бүлгүүдийг

сурсан зүйлсээ бусадтайгаа хуваалцан мөн бусад бүлгүүдийн ярих зүйлээс жагсаалтан дээрээ нэмж бичихэд урь. Ирээдүйд бусдад заах шаардлага гарвал өнөөдрийн сурсан зүйлсээ хэрхэн хэрэгжүүлэх тухай тунгаан бодохыг тэднээс хүс.

- Тэднийг Матвэй О.Ричардсоны “Сүнсний нөлөөний дагуу заах нь” хэлсэн үгийг уншаад “Сүнс хэрхэн заадаг вэ?” мөн “Бид заахдаа Түүний жишээг хэрхэн дагах вэ?” гэдэг асуултанд хариулт олохыг хүс. Уншсан зүйлийнхээ тухай бусадтайгаа хуваалцахад урь. “Сүнсний нөлөөний дагуу” заасан багштай адил ямар туршлага тэдэнд байдаг вэ? Тэд дараагийн удаа заахдаа уг багшийн жишээг хэрхэн дагаж болох вэ?
- *Teaching, No Greater Call* -ын 41 ба 42-р хуудсанд байгаа *ахлагч Ричард Ж.Скоттын түүхийг унших үед нь тэднээс* хоёр туршлагыг харьцуулахыг хүс. Яагаад эхний хичээлийн үеэр Ариун Сүнс байсан бэ? Хоёр

Заахад туслах арга

“Ангид чимээгүй болоход бүү сандар. Асуултанд хариулахын тулд хүмүүс бодох хэрэгтэй байдаг. Та асуулт асууж мөн сүнслэг туршлага хуваалцсаны дараа эсвэл уг хүнд өөрийгөө илэрхийлэх нь хэцүү байгаа үед түр хүлээх хэрэгтэй” (*Teaching, No Greater Call* [1999], 67).

дахь хичээл юугаараа ялгаатай байсан бэ? Дараагийн удаа бусдад заах үедээ эдгээр туршлагаас сурсан зүйлээ хэрхэн хэрэгжүүлэх тухай төлөвлөгөөгөө хуваалцахыг тэднээс хүс.

- “ Миний сайн мэдээг номло ” номын *Хөрвүүлэлт дэх Сүнсний хүч* (102–104-р хуудас) хэсгийг хувилж суралцагч бүрд өг. Энэ сэдвийг дор бүрнээ уншаад “Сүнсээр заах гэдэг” нь юу гэсэн үг болохыг ойлгохыг хүс. Ойлгосон зүйлийнхээ тухай

Өнөөдөр сурсан зүйлээ хуваалцахыг тэднээс хүс. Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Сүнсээр хэрхэн заахыг тэд ойлгосон уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан зүйлийнхээ улмаас тэд юуг хийх урмыг авч байгаа талаар өсвөр үеийнхнээс асуу. Тэр мэдрэмжүүдийнхээ дагуу үйлдэхэд тэднийг уриал. Дагаж болох арга замуудын талаар залбиралтайгаар бодохдоо Сүнсийг эрэлхийлээрэй.

хуваалцахыг урь. Үүнийг бүрэн цагийн номлолд үйлчлэхээс өмнө одоо сурах нь яагаад чухал вэ? гэдгийг асуу. “Бие даан судлах” ба “Судраас судлах” үйл ажиллагаануудыг бие даан өөрсдөө хийхэд нь тэднийг дэмж (боломжтой бол хичээл дээр судлах цаг гаргаж өгч болно). Эдгээр судрыг унших явцад нь тэдэнд төрсөн сүнслэг өдөөлтүүдийг тэмдэглэн авч, дараагийн хичээл дээр бусадтайгаа хуваалцахад урь.

Аврагчийн арга барилаар заах нь

Заасан хүмүүстээ тунгаан бодож, гүнзгий мэдрэх асуултуудыг Аврагч асуусан байдаг. Тэр тэднээс асуулт асууж, бодол санаагаа илэрхийлэх боломжийг олгодог байв. Тэр тэдэнд хайртай байсан учраас тэд хувийн бодол санаагаа нээлттэй хуваалцдаг байв. Өсвөр үеийнхнийг хувийн мэдрэмж ба бодол санаагаа хуваалцахад нь та хэрхэн тусалж чадах вэ?

Сонгосон материалууд

“Хөрвүүлэлт дэх сүнсний хүч”, Миний сайн мэдээг номло (2004), 92–93

Ариун Сүнсний хүч нь хөрвөлтийн гол цөм юм. Хөрвөлтийн сургаал болон хөрвөлтийн туршлагыг ойлгохыг хичээ. Сүнсний гол үүргийг Ерөнхийлөгч Бонд К.Пакэр тайлбарлахдаа:

“Хөрвөлт нь Ариун Сүнсний хүчээр дамжин бий болдог. Номлогчийн ажил амжилттай байхад эдгээр гурван зүйлс зайлшгүй тохиох ёстой:

“Хөрвөлтийг хүлээн авахын тулд сонирхогч юу мэдрэх ёстойг бид мэдэх хэрэгтэй.

Бид “Ариун Сүнсний хөрвүүлэгч хүчээр заахын тулд номлогч ямар сэтгэгдэлтэй байх ёстойг ойлгох хэрэгтэй.

“Тэгээд дараа нь хөрвүүлгийн туршлагад оролцоход амжилт гаргахын тулд гишүүн ямар сэтгэгдэлтэй байх ёстойг бид ойлгох ёстой” гэжээ (номлолын ерөнхийлөгчдийн чуулган, 1985 оны 4-р сарын 3).

Та сонирхогчид, номлогчид болон гишүүдийг Сүнсний гэрчлэл хүлээн авах үедээ ямар сэтгэгдэлтэй байгааг илүү сайн ойлгохын хэрээр өөрсдийн үүргийг илүү сайн ойлгох болно, энэ нь:

- Судруудыг судалж, сургаалыг заах үедээ сүнслэг байдлаараа хүчирхэг бай, оюун ухаанаа гэгээрүүл.
- Заах үед тань Ариун Сүнс гэрчилж байх тийм уур амьсгалыг бүрдүүл. Та үүнийг сэргээлтийн захиасыг зааж гэрчилснээр хийдэг.

Сүнсээр удирдуулж заа, зааж байгаа зүйл тань үнэн гэдгийг Ариун Сүнсний хүчээр мэддэгээ гэрчил.

- Захиасыг хүн бүрийн хэрэгцээнд тохируулахдаа Сүнсний удирдамжийг дага.
- Хүмүүсийг ямар нэгэн зүйл хийхийг урь. Тэд наманчилж, зарлигуудыг дуулгавартай даган гэрээнүүдийг хийж тэдгээрийг сахихын хэрээр тэдний итгэл өсөх болно.

Сүнсний хүчний тухай Ахлагч Рассэлл М.Баллард ярихдаа: “Үнэн хөрвүүлэг нь Сүнсний хүчээр дамжин ирдэг. Сүнс зүрх сэтгэлд хүрэхэд зүрх сэтгэл өөрчлөгддөг. Хувь хүмүүс. . . Сүнсийг өөрсөдтэй нь хамт ажиллаж байгааг мэдрээд эсвэл Их Эзэний хайр болон нигүүлслийн нотолгоог тэд амьдралдаа үзсэнээрээ тэд гэгээрч сүнслэг байдлын хувьд хүчирхэгжиж, Түүнд итгэх итгэл нь өсдөг. Эдгээр тохиолдлууд нь хүн үгсийг турших хүсэлтэй байхад аяндаа Сүнстэйгээр дагалддаг байна. Энэ бол бидний сайн мэдээг үнэн гэдгийг мэдэрдэг байдал юм. (“Now Is the Time,” *Ensign*, 2000 оны 11-р сар, 75).

Ариун Сүнс эдгээр өөрчлөлтүүдийг авчрахаар хүмүүсийн зүрх сэтгэлд ажилладаг. Хүмүүс амлалтуудыг биелүүлэхийг сонгосноороо Ариун Сүнсний хүчийг илүү хүчтэйгээр мэдэрч Христийг дуулгавартай дагахын тулд итгэлээ хөгжүүлэх болно. Тийнхүү та өөрийнхөө хамт ажилладаг хүмүүсийг наманчлахад болон амлалтуудыг хийж биелүүлэхэд урьснаар итгэлээрээ өсөхөд нь туслах ёстой.

Хоёрдугаар сар: Авралын төлөвлөгөө

Энэ бүлгийн тоймууд нь өсвөр үеийнхнийг авралын төлөвлөгөөний талаар суралцахад болон заахын ач холбогдлыг ойлгоход нь тусална. Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А. Бэднар “итгэлээр болон туршлагаас суралцах нь Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөний үндсэн аргуудын хоёр нь юм” хэмээн заасан (“Итгэлээр суралцахыг эрэлхийл,” *Ensign*, 2007 оны 9-р сар, 63). Танд авралын төлөвлөгөөний тухай хүчтэй гэрчлэлтэй болж, үүнийгээ бусдад заах чадвартаа илүү итгэлтэй болоход нь өсвөр үеийнхэнд туслах боломж байна. Тэднийг сурч байгаа зүйлийнхээ тухай асууж лавлан, илүү ихийг сурахыг эрэлхийлж, сурч мэдсэн зүйлээ бусдад заахад нь дэмжээрэй.

Энэ сард сонгох тоймууд:

Суралцах нь яагаад Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний чухал хэсэг болдог вэ?

Сайн мэдээг заах нь авралын төлөвлөгөөнд яагаад чухал вэ?

Сайн мэдээнээс суралцахад сонгох эрх ямар үүрэгтэй вэ?

Би бусад хүмүүсийг суралцахад нь хэрхэн тусалж чадах вэ?

Би авралын төлөвлөгөөний талаар суралцахдаа сүмийн дуу хөгжмийг хэрхэн ашиглаж болох вэ?

Христийн сургаалыг ойлгоход нь бусад хүмүүст би хэрхэн тусалж чадах вэ?



Суралцах нь яагаад Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний чухал хэсэг болдог вэ?

Тэнгэрлэг Эцэгийн биднийг дэлхий рүү илгээсэн гол шалтгаануудын нэг нь Түүнээс сурч мөн Түүнтэй илүү адил болоход туслах туршлагауудыг бидэнд өгөх явдал юм. Хэрэв бид дуулгавартай, шаргуу суралцвал Тэрээр бидний мэдвэл зохих зүйлсийг амьдралын маань туршид шат шатаар нэмж өгөх болно. Тэнгэрлэг Эцэг биднээс өөрсдийн олж авсан мэдлэгээ бусдыг адислах хийгээд Түүний хаант улсыг байгуулахад ашиглахыг хүсдэг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар, эх сурвалжийг залбирч судал. Амьдралынхаа турш суралцагч байхад юу таныг урамшуулдаг вэ?

2 Нифай 28:27–30; С ба Г 98:11–12 (Бид сурч мөн сурсан зүйлсийнхээ дагуу амьдрах юм бол Их Эзэн бидэнд “шат шатаар, дүрэм дүрмээр” заана гэж амласан)

Алма 12:9–11; С ба Г 50:40 (Хэрэв бид дуулгавартай мөн хүлээж авахад бэлэн байвал бид амьдралынхаа турш үргэлжлүүлэн суралцах болно)

С ба Г 88:77–80 (Дуудлагуудаа эрхэмлэн биелүүлэхэд бэлтгэгдэхийн тулд Их Эзэн биднээс суралцахыг хүсдэг)

Дийтр Ф.Угдорф, “Би биш биз дээ, Эзэн минь?” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 11-р сар, 56-59

Даллин Х.Өүкс болон Кристин М.Өүкс, “Суралцах нь мөн хожмын үеийн гэгээнтнүүд,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2009 оны 4 сар, 22–27

Залуучуудын бат бөх байдлын төлөө номын “Боловсрол,” (2011), 9–10

Итгэлдээ үнэнч байх нь номны “Авралын төлөвлөгөө,” (2004), 115–117

Танд үргэлжлүүлэн суралцах ямар боломжууд байна вэ? Үүнийг хийх нь хэрхэн таны амьдралыг адисалсан бэ?

Та хэрхэн амьдралынхаа турш үргэлжлүүлэн суралцаар байхын ач холбогдлыг ойлгоход нь өсвөр үеийнхэнд тусалж чадах вэ? Та боловсрол эзэмших ба сайн мэдээнээс суралцахын үнэ цэнийг олж харахад нь тэдэнд туслахын тулд юу хийж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутын туршид, өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээл эсвэл найз нартайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь та нар хэрхэн тэдэнд тусалж чадах вэ? Эдгээр санаа тусалж болох юм:

- Өсвөр үеийнхэн авралын төлөвлөгөөний тухай юу сурсан бэ (гэрээнүүд, дуулгавартай байдал, Цагаатгал, эсвэл үхлийн дараах амьдрал гэх мэт)? Тэд бие биетэйгээ юу хуваалцаж чадсан бэ?

- Самбар дээр “Сурах нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд яагаад чухал вэ?” гэж бич. Өсвөр үеийнхэнд хичээлийн турш энэ асуултыг эргэцүүлэн бодож хариултуудыг бичих цаг өг. Хичээлийн төгсгөлд тэднийг бичсэн зүйлээсээ хуваалцахад урь.

Хамтдаа суралц

Заахад туслах арга

“Хэн нэг нь асуулт асуухад та өөрөө хариулахын оронд бусдад хариулах боломж олгоорой. Жишээлбэл, 'Энэ маш сонирхолтой асуулт байна. Бусад нь юу гэж бодож байна вэ?' эсвэл 'Энэ асуулганд хариулах хүн байна уу?' гэж та асууж болох юм.”
(*Teaching, No Greater Call* (1999), 64).

Доорх үйл ажиллагаа бүр өсвөр үеийнхнийг амьдралынхаа туршид суралцагчид байхад нь урамшуулан дэмжихэд тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

- Самбар дээр *Суралцах нь яагаад Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний чухал хэсэг болдог вэ?* гэж бич. Өсвөр үеийнхнээс ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын “Би биш биз дээ, Эзэн минь?” хэлсэн үгийн “Амьдралаа дүгнэж цэгнэх нь” хэсгийг уншиж байхдаа энэхүү асуултыг бодож үзэхийг хүс. Тэдэнд бодлоо хуваалцах цаг гаргаж өг. Судруудаас суралцсанаар эсвэл амьд бошиглогчдын сургаалуудын дагуу амьдарснаар өөрсдийн амьдралд хийсэн өөрчлөлтүүдийн талаар хуваалцахад тэднийг урь.

дээрх “Боловсрол” хэсгийг судрын эшлэлүүдийн хамт уншихад урь. Ангийн хагасаас Тэнгэрлэг Эцэг биднээр хийлгэхийг хүсэж байгаа зүйлсийг олохыг хүсээд, нөгөө хагасаас Түүний амласан адислалуудыг олохыг хүс. Тэднийг олсон зүйлсээ бусадтай хуваалцан, сайжруулах хэрэгтэй гэж мэдэрч байгаа зарим зүйлийг сонгоход уриал. Эдгээр зүйлийг сайжруулах арга замуудыг ангиараа ярилцаад, Их Эзэний зөвлөгөөг дагах хувийн зорилгууд тавихад нь өсвөр үеийнхнийг урамшуулан дэмж.

- Бүх өсвөр үеийнхнийг энэ тойм дээрх судруудаас нэгийг уншаад, сурах зарчмуудыг олохыг хүс. Тус бүрийг нь уншсан судрын хэсэг дээрх зарчмыг илэрхийлсэн зураг ба схем зураг зурахад урь. Өсвөр үеийнхнийг уншсан зүйлсийнхээ талаар бие биедээ заахдаа зургуудаа ашиглахыг хүс. Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөн дэх суралцах ач холбогдлын талаар эдгээр судар юу зааж байна вэ?

- “Чи хангалттай ихийг мэднэ” видео бичлэгийг үзүүлээд, бид хэрхэн мэдлэгтэй болох талаар ахлагч Нийл Л.Андэрсэнээс сурсан зүйлээ хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс. Сайн мэдээний тухай бүх зүйлийг ойлгохгүй байгаагаасаа болоод зүдэрч байгаа найздаа тэд юу хэлж болох вэ? Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөн дэх сурах үүргийн тухай ойлгоход нь тэд хэрхэн найздаа тусалж чадах вэ?

- Өсвөр үеийнхнийг Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимол

- Өсвөр үеийнхнийг Итгэлдээ үнэнч байх нь номон дахь “Авралын

төлөвлөгөө” (115–117-р хуудас)
хэсгийг судрын хэсгүүдийн хамт
уншаад, өөрсдийн мэддэггүй байсан
ямар нэгэн зүйлийг олохыг хүс.

Тэднийг сурсан зүйлээсээ хуваал-
цахыг хүсэж мөн Тэнгэрлэг Эцэг
яагаад биднийг үргэлжлүүлэн
сураасай гэж хүсдэг талаар ярилц.

*Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлсээ хуваалцахыг хүс. Тэнгэрлэг Эцэгийн
төлөвлөгөөнд сурах нь яагаад чухал болохыг тэд ойлгож байна уу? Тэд ямар
мэдрэмж эсвэл сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ
сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?*

Үйлдэхэд урь

- Тэднийг найз болон гэр бүлийн-
хээ гишүүнд заахыг хүсч байгаа
авралын төлөвлөгөөний аль нэг
хэсгийн тухай бодоход урь. Тэр
сэдвийн тухай сурахын тулд тэд юу
хийж чадах вэ?

- Амьдралынхаа туршид сурал-
цахыг эрэлхийлснээр олж авсан
адислалуудынхаа тухай гэрчлэлээ
хуваалц.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн заасан
бүх зүйлийн төгс жишээ
байсан. Тэрээр тэдэнтэй
хамт залбирснаар залби-
рахыг заасан. Тэднийг
хайрлаж, үйлчилсэн
шигээ бусдыг хайрлаж,
үйлчлэхийг Тэр заасан.
Та хэрхэн зааж буй өсвөр
үеийнхэндээ суралцах
сонирхолтой байхын
жишээг үзүүлж чадах вэ?

Сонгосон материалууд

“Боловсрол,” Залуучуудын бат бөх байдлын төлөө (2011), 9–10

Түүнтэй илүү адил болоход тусалдаг Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд боловсрол чухал байр суурийг эзэлдэг. Тэрээр та нарыг оюун ухаанаа боловсруулан авьяас чадвараа хөгжүүлж үүрэг хариуцлагаа сайн биелүүлэх хүчтэй байж амьдралыг дээдлэн хүндэлж байгаасай гэж хүсдэг. Та нарын боловсрол нь энэ амьдрал болон ирэх амьдралд үнэ цэнэтэй юм.

Боловсрол та нарыг энэ дэлхийд болон Сүмдээ үйлчлэхэд бэлтгэх болно. Энэ нь өөрийгөө, гэр бүлээ болон гачигдалтай хүмүүсийг тэтгэн халамжлахад тусалдаг. Энэ нь мөн та нарыг ирээдүйн ханьдаа ухаалаг зөвлөгч, сайн хамтрагч, ирээдүйн хүүхдүүддээ сургамжтай, мөн үр дүнтэй багш байхад тань туслах болно.

Боловсрол нь та нарын өмнө хаалттай байж болох хаалгуудыг нээж агуу боломжуудыг авчирдаг том

хөрөнгө оруулалт юм. Одооноос боловсрол олж авах талаар төлөвлө. Шаргуу ажиллаж шаардлагатай бол золиослол гаргахад бэлэн бай. Боловсролтой болох зорилгуудынхаа талаар гэр бүлийнхэн, найз нөхөд, удирдагчидтайгаа ярилц. Тэгвэл тэд та нарыг дэмжин зоригжуулах болно.

Амьдралынхаа туршид суралцах хүсэл эрмэлзэлтэй бай. Үргэлжлүүлэн суралцах, сонирхлын хүрээгээ тэлэх урам зоригтой бай. Суралцах боломжтой үед идэвхтэй оролцохыг сонго.

Сүнслэгээр суралцах нь та нарын боловсролын салшгүй хэсэг мөн. Судруудаас мөн хожмын үеийн бошиглогчдын үгсээс суралц. Институт, семинарт хамрагд. Амьдралынхаа туршид Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний тухай үргэлж суралц. Энэ сүнслэг сургалт та нарын амьдралд тохиолдог саад бэрхшээлүүдэд хариулт олоход тань тусалж Ариун Сүнсний нөхөрлөлийг урих болно.

Алма 37:35; Сургаал ба Гэрээ 88:77–80



Сайн мэдээг заах нь авралын ТӨЛӨВЛӨГӨӨНД ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Аз жаргалын төлөвлөгөөний зорилгуудаа биелүүлэхийн тулд Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд сайн мэдээний тухай суралцах хэрэгтэй. Ийм учраас хүн бүр гэр бүлдээ, сүмийн бусад гишүүдэд мөн сайн мэдээг хараахан хүлээн аваагүй байгаа бусад хүмүүст сайн мэдээг зааж Бурханы ажилд туслах хэрэгтэй.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалуудыг залбирч судлаарай. Өсвөр үеийнхэнтэй юуг хуваалцах санаа танд төрсөн бэ?

Лук 2:46–52 (Аврагч бага байхдаа бусдад сайн мэдээний үнэнүүдийг заадаг байв);

С ба Г 43:8; 88:77–80 (Их Эзэн биднийг бие биедээ заа хэмээн тушаасан)

2 Нифай 2:8 (Эдгээр зүйлийг бусдад мэдүүлэхийн ач холбогдол нь агуу юм)

Teaching, No Greater Call (1999), 3–4

Таны сайн мэдээний багш танд хэрхэн нөлөөлсөн бэ? Та өөрийн зааж байгаа хүүхдүүддээ ямар нөлөө үзүүлж байна вэ?

Ангийн чинь өсвөр үеийнхэнд өөр хэн заадаг вэ? Эдгээр багш өсвөр үеийнхний амьдралд хэрхэн нөлөөлж байна вэ?

Өсвөр үеийнхэн хэзээ заах боломжтой байдаг вэ? Тэд бусдад хэрхэн тусалсан бэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутын туршид, өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний хамаарлыг олж харахад нь та нар тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Эдгээр санаанууд тусалж магад:

- Өсвөр үеийнхэн өнгөрсөн долоо хоногийн Ням гаргийн хичээл дээрээ юу сурсныг нь эргэн шалга. Долоо хоногийн турш тэд хэрхэн суралцаж байсан бэ?
- Өсвөр үеийнхнээс хэн нэгэн тэдэнд ямар нэгэн зүйлийг утга учир бүхий арга замаар заасан туршлагынх нь тухай ярихыг хүс.

Та бас өөрийн туршлагыг хуваалцаж болно.

- Өсвөр үеийнхнийг сайн мэдээг зааж байсан цаг үеийнхээ тухай ярихыг урь (жишээлбэл гэртээ, найзтайгаа, сүм дээр). Бурханы хүүхдүүддээ зориулсан төлөвлөгөөнд заах нь яагаад чухал вэ?

Заахад туслах арга

“Таны санаа тавих гол зүйл бол сэтгэл хөдөлгөм танилцуулга хийх биш харин бусдад сайн мэдээг сурахад туслах юм. Үүнд суралцагчдын бие биедээ заах боломжууд багтдаг” (*Teaching, No Greater Call* [1999], 64).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч сайн мэдээг бусдад заахын тулд Өөрийгөө бэлтгэсэн. Тэр ганцаараа залбирч, мацаг барин, Тэнгэрлэг Эцэгийн удирдамжийг эрэлхийлсэн. Өсвөр үеийнхэнд заахын тулд та сүнслэг байдлын хувьд өөрийгөө хэрхэн бэлтгэж чадах вэ?

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр өсвөр үеийнхнийг Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд сайн мэдээг заах нь хэчнээн чухал болохыг ойлгоход тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Аврагч сүмд зааж байгаа зургийг үзүүлж (*Сайн мэдээний уран зургийн цуглуулга*, 34), өсвөр үеийнхнийг Лук 2:46–52-ыг уншихад урь. Аврагч бага байхдаа заахын чухлыг хэрхэн мэдэрч байсан бэ? Энэ түүх Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд сайн мэдээг заахын чухлын тухай өөр юу зааж байна вэ? Өсвөр үеийнхнээс тэдэнд байгаа бүх заах боломжийнхоо тухай бодоод, жагсаан бичихийг хүс (тэдэнд найзтайгаа ярих гэх мэт энгийн нөхцөл байдлуудыг оруулан бичихэд урамшуул). Өсвөр үеийнхнийг жагсаалтаас аль нэгийг сонгоод, “Би заах боломжуудыг ашигласнаар Тэнгэрлэг Эцэгийнхээ төлөвлөгөөг биелүүлэхэд хэрхэн тусалж чадах вэ?” гэсэн асуултыг эргэцүүлэн бодоход урь. Тэднийг бодлуудаасаа хуваалцахыг хүс.
- “Заах нь хүмүүсийг аврахад тусалдаг” видео бичлэгийг үзүүлээд, өсвөр үеийнхнээс тэдэнд байсан эцэг эх болон гэр бүлийн

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд авралын төлөвлөгөөн дэх сайн мэдээг заах үүргийг ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

- Бусдад заах тухай юу ойлгосныг нь өсвөр үеийнхнээс асуу. Энэ ойлголтынхоо дагуу үйлдэхийн тулд тэд юу хийж чадах вэ?

бусад гишүүд зэрэг сайн мэдээний үр нөлөөтэй багш нарынхаа тухай бодохыг хүс. Тэднийг хос хосоор нь хуваагаад, бие биедээ өөрсдийн санаж буй багш нарын тухай ярихад урь. Юу эдгээр багшийг үр нөлөөтэй заахад нөлөөлсөн бэ? Эдгээр багш Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг биелүүлэхэд хэрхэн тусалсан бэ? Өсвөр үеийнхэн тэдний жишээг дагахын тулд юу хийж чадах вэ?

- Өсвөр үеийнхнийг *Teaching, No Greater Call* дээрх 3 ба 4 хуудас -ыг уншаад, “Авралын төлөвлөгөөнд сайн мэдээг заах нь яагаад чухал вэ?” гэдэг асуултад хариулахыг хүс. Тэднийг хариултуудаа жижиг цаасан дээр бичихийг хүсээд, цааснуудыг нь хураан ав. Тэдгээрээс нэгийг нь уншаад, уг хариултыг бичсэн суралцагчийг самбарын өмнө гарч ирээд, яагаад энэ хариултыг сонгосноо тайлбарлахад урь. Тэднийг хариултуудынхаа талаарх туршлага хуваалцахад урамшуул.

Сонгосон материалууд

Teaching, No Greater Call (1999), 3–4

Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг бусдад заах үүрэг

Зөв шударга байдалд өөрсдийн сонгох эрхийг бүрэн дүүрнээр эдлэх боломжтой байхын тулд бид Аврагч болон Түүний сайн мэдээний сургаалуудаас суралцах ёстой. Тийм учраас сайн мэдээг заах нь Тэнгэрлэг Эцэгийн Хүүхдүүддээ зориулсан төлөвлөгөөнд чухал байр суурь эзэлсээр ирсэн билээ.

Өмнөх амьдралын сүнслэг дэлхийд бид “[анхныхаа] . . . хичээлүүдийг хүлээн авч, мөн Их Эзэний тогтоосон цагт хүмүүний бодгалиудын авралын төлөө түүний талбайд хөдөлмөрлөхийн тулд урагш гарч ирэхээр бэлтгэгдсэн байжээ” (С ба Г 138:56). Их Эзэн Адам Ева хоёрыг Едений цэцэрлэгээс хөөгдсний дараа тэдэнд гэтэлгэлийн төлөвлөгөөг заалгахаар тэнгэр элчүүдийг тэрээр илгээжээ (Алма 12:27–32-г үз). Хожим нь Тэр Адам Ева хоёрт өөрсдийн хүүхдүүддээ “эдгээр зүйлийг чөлөөтэйгээр заахыг” тушаасан байна. (Мосе 6:57–59-г үз).

Сайн мэдээний эрин үе бүрд Их Эзэн гэтэлгэлийн төлөвлөгөөг заахыг удирдаж байсан. Тэр тэнгэр элчүүдийг илгээж (Мозая 3:1–4; Моронай 7:29–32; Иосеф Смит—Түүх 1:30–47), бошиглогчдыг дуудаж (Амос 3:7-г үз), судруудыг бэлдэж өгч (С ба Г 33:16-г үз), мөн Ариун Сүнсний хүчээр үнэнийг мэдэхэд тусалж байсан (1 Нифай 10:19; Моронай 10:5-г үз). Тэр Өөрийн дагалдагч нарт гэр бүлийнхэндээ (Дэд Хууль 6:5–7; Мозая 4:14–15; С ба Г 68:25–28-г үз), Сүмийн бусад гишүүдэд (С ба Г 88:77–78, 122-г үз), мөн бүрэн дүүрэн сайн мэдээг хараахан хүлээн аваагүй байгаа тэдэнд сайн мэдээг заахыг тушаасан (Матай 28:19–20; С ба Г 88:81-г үз). . . .

Гишүүн бүр багш

Амилсан Аврагч Нифайчуудад зааж байх үедээ, Тэрээр “Дэлхийд туяарч болохын тулд гэрлээ өргөгтүн. Болгоогтун би бол та нарын өргөх тэрхүү гэрэл билээ-та нарын харсан тэдгээр нь миний үйлдсэн зүйлүүд болой” (3 Нифай 18:24) хэмээн хэлжээ. Энэ заавартаа Их Эзэн Өөрийнх нь дуу хоолойг сонсох тэдний дунд зааг ялгаа гаргагүй юм. Бусдад заахыг хүн бүхэнд зарлиглажээ.

Өнөөдөр ч мөн энэ нь хэвээр байна. Сайн мэдээг заах үүрэг зөвхөн багшийн дуудлагатай хүмүүсээр хязгаарлагддаггүй. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүний хувьд та нар сайн мэдээг заах үүрэг хүлээдэг. Та нарт эцэг, эх, хүү, охин, нөхөр, эхнэр, ах, эгч, Сүмийн удирдагч, ангийн багш, гэрийн багш, айлчлагч багш, хамтран ажиллагч, хөрш эсвэл найзын хувьд бусдад заах боломжууд гарч ирдэг. Та нар заримдаа ярьж буй зүйлсээрээ, мөн хуваалцаж буй гэрчлэлээрээ шууд илэн далангүй заадаг. Та нар мөн үлгэр жишээгээрээ үргэлж зааж байдаг.

Их Эзэн, “Учрыг болгоогтун, үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь миний ажил мөн миний алдар суу бөлгөө” гэж хэлсэн (Мосе 1:39). Бурханы хүүхдүүдийг аврал мөн өргөмжлөлд хүргэх явцад сайн мэдээг бусдад заахын үүргийн талаар бодоход түүнээс илүү ариун хийгээд эрхэм үүргийг та нар төсөөлж байна уу? Их Эзэний зарлиг болгосон арга замаар заасан үед Тэрээр таныг өсгөн хөгжүүлэх болно гэдгийг мэдсэний үндсэн дээр ойлголт, заах ур чадвараа дээшлүүлэхээр шаргуу хичээж зүтгэл гарган ажиллахыг танаас шаарддаг. Энэ нь хайраас үүдсэн хөдөлмөр бусдад сонгох эрхээ шударгаар ашиглан Христэд ирж мөнхийн амьдралын адислалуудыг хүлээн авахад нь туслах боломж юм.



Сайн мэдээнээс суралцахад сонгох эрх ямар үүрэгтэй вэ?

Тэнгэрлэг Эцэг биднийг өөрсөд дээрээ үйлдүүлэх бус харин өөрсдийн төлөө үйлддэг болгон бүтээсэн (2 Нифай 2:26-г үзнэ үү). Энэ зарчим сайн мэдээг сурах бидний чармайлт болон мөнх бус амьдралын маань бүх талуудад хамааралтай юм. Бидний төлөө хэн ч сайн мэдээг сурч чадахгүй тул бид үүнийг өөрсдийнхөө төлөө сурах ёстой. Сайн мэдээг сурна гэдэг нь бусдаар үйлдүүлэх бус харин өөрөө үйлдэх үйл явц юм. Бид сонгох эрхээ ашиглан үнэнийг хичээнгүйлэн эрэлхийлэхэд Их Эзэн биднийг илүү их гэрэл болон мэдлэгээр адисалдаг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Доорх материалуудыг судал. Сурахад идэвхтэйгээр оролцох гэдэг нь юу гэсэн үг болохыг ойлгоход нь өсвөр үеийнхэнд туслахын тулд та ямар судрын хэсэг, жишээнүүдийг ашиглаж чадах вэ?

Иохан 7:17 (Бид Тэнгэрлэг Эцэгийн сургаалыг мэдэхийн тулд Түүний хүслийн дагуу хийх ёстой)

С ба Г 50:24 (Бид үнэнийг хүлээн аваад түүн дээрээ үйлдвэл илүү их үнэнийг хүлээн авна)

Иаков 1:22 (Үгийг зөвхөн сонсогч бус мөн үйлдэгч бай)

С ба Г 88:118 (Бид судлахаар болон итгэлээр сурахыг эрэлхийлдэг)

1 Нифай 10:19 (Хэрэв бид үнэнийг хичээнгүйлэн эрвэл олох болно)

Дэвид А.Бэднар “Итгэлээр суралцахыг эрэлхийл,” *Ensign* 2007 оны 9 сар, 61–68

2 Нифай 2:26 (Бид үйлдүүлэх гэж бус харин үйлдэхийн төлөө байгаа)

Та саяхан сурсан нэг зүйлийнхээ тухай бод. Үүнийг сурахын тулд та юу хийсэн бэ? Танд ямар санагдсан бэ?

Өсвөр үеийнхнийг сайн мэдээг сурахад туслах өөр ямар арга замууд байдаг вэ?

Танай ангиас хэн нь идэвхтэй сурч байна вэ? Хэн нь идэвхгүй байна вэ? Та өсвөр үеийнхнийг ангидаа болон бие дааж сурахад нь идэвхтэйгээр оролцохыг урамшуулан дэмжихийн тулд бусад багш нартай хэрхэн хамтран ажиллаж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутын туршид, өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний хамаарлыг олж харахад нь та нар тэдэнд яаж тусалж чадах вэ? Эдгээр санаа тусалж болох юм:

• Өсвөр үеийнхнийг семинар, ариун ёслолын цуглаан, хувиараа

судлах цаг эсвэл бусад орчинд сурсан зүйлүүдээ жагсаан бичихийг

урь. Ангиараа эдгээр бүх зүйлс хэрхэн авралын төлөвлөгөөтэй хамааралтай байгааг ярилц.

- Өсвөр үеийнхнийг идэвхтэйгээр оролцсон дуртай хичээлийнхээ тухай хэлэхийг урь (жишээлбэл, гэр бүлийн цуглаан, гэрийн багшийн айлчлал, Ням гаргийн хичээл эсвэл

Хүүхдийн Хэсэг дээр). Оролцохын тулд тэд юу хийсэн бэ? Тэдний идэвхтэй оролцоо илүү сайн сурахад нь хэрхэн тусалсан бэ? Сурахад идэвхтэй оролцох өөр ямар арга замууд байна вэ? (Та анги дээр санал оруулж тайлбар хэлэх нь оролцох цорын ганц арга биш гэдгийг сануулж болно)

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр өсвөр үеийнхнийг сайн мэдээг сурахад идэвхтэйгээр оролцдог болгон урамшуулахад тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Сайн мэдээг сурахыг идэвхтэйгээр эрэлхийлсэн судар дээрх хүмүүсийн зарим жишээнүүдийг хуваалцахад өсвөр үеийнхнийг урамшуул (жишээлбэл, 1 Нифай 2:14–16 [Нифай], Сургаал ба Гэрээ 138:1–11 [Жозеф Ф.Смит], болон Иосеф Смит—Түүх 1:10–18 [Иосеф Смит]-ийг үзнэ үү). Өсвөр үеийнхэн эдгээр жишээнүүдийн тухай уншсанаар сайн мэдээг сурах ямар зарчмуудыг олж мэдэж чадах вэ? (Жишээлбэл, Нифай эцэгийнхээ заасан зүйлийн тухай сонсоод, өөрөө мэдэх хүсэлтэй болж, тэгээд тэдгээр хүслүүд дээрээ тулгуурлан үйлдсэн.) Өсвөр үеийнхэн авралын төлөвлөгөөний тухай юу сурахыг хүсэж байна вэ? Тэд эдгээр зарчмуудыг өөрсдийн сурах удирдамж болгон хэрхэн ашиглаж чадах вэ?
- Өсвөр үеийнхнийг ахлагч Дэвид А.Бэднарын “Итгэлээр суралцахыг эрэлхийл” өгүүлэгийн хоёр дахь гарчиг болох “Итгэлээр сурах: Үйлд, харин өөр дээрээ бүү үйлдүүл” хэсгийг уншихад урь. Сайн мэдээг сурах үүрэг хариуцлагыг

нь илүү сайжруулахад нь тэдэнд туслах ахлагч Бэднарын санал болгосон зүйлсийг олохыг хүс. Авралын төлөвлөгөөний тухай бие даан сурахад нь зориулсан түүний зөвлөгөөг амьдралд хэрэгжүүлэхийн тулд тэд юу хийж болох вэ?

- Энэ тойм дахь судрын эшлэлүүдийг самбар дээр бич. Ангийн гишүүн бүрээр нэгийг уншихаар сонгуулж, дараах асуултын хариултаудыг олоход урь: Сурахдаа идэвхчармайлт гаргаснаар ямар адислалууд ирэх вэ? Тэднийг юу олсноо хуваалцахыг хүс. Тэднийг дараах өгүүлбэрийг тус бүрдээ дуусгахыг хүс: “Би ... хийснээр сайн мэдээг илүү идэвхтэй суралцахаар төлөвлөж байна.” Цөөн зарим суралцагчаас төлөвлөгөөгөө ангийнхантайгаа хуваалцахыг хүс.

- Тэднийг Сургаал ба Гэрээ 58:26–28-ыг уншиж, сайн мэдээг суралцагчийн хувьд Их Эзэний зөвлөгөөг амьдралдаа хэрэгжүүлэх арга замуудыг хайн олоход урь. Тэднийг суралцагчийн хувьд хийх ёстой зарим сонголтуудаа жагсаахыг хүс

Заахад туслах арга

“Суралцагчдыг судрууд болон хожмын үеийн бошиглогчдын сургаалаас хариултаудыг нь олохыг шаардсан асуултуудыг асуу” (*Teaching, No Greater Call* [1999], 62).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч зааж байхдаа энгийн түүх, сургаалт үлгэрүүд болон амьдралд тохиолдсон жишээнүүдээс ашиглаж байлаа. Тэр бусдад сайн мэдээний хичээлүүдийг өөрсдийн туршлагаараа нээж олоход нь тусалсан. Та зааж байгаа зүйлсээ, тэдний өөрсдийнх нь амьдралд байгаа жишээнүүдээсээ олж харахад нь өсвөр үеийнхэнд хэрхэн тусалж чадах вэ?

(хичээл дээр санал бодлоо хуваалцах бэлтгэх зэрэг болно). Эдгээр сонголтын зарим үр дагаврууд нь юу вэ?

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд сайн мэдээг сурахад сонгох эрхийн үүргийг ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цагийг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

- Сүмийн бусад ангиудад авралын төлөвлөгөөг сурч байхдаа сурсан зүйлсээ амьдралд хэрэгжүүлэхийн тулд өсвөр үеийнхэн юу хийж чадах вэ? Идэвхтэй суралцагч байх хичээл зүтгэлд нь та тэднийг хэрхэн дэмжиж чадах вэ?
- Сурахыг хичээнгүйлэн эрэлхийлснээс ирсэн адислалуудынхаа тухай гэрчлэлээ хуваалц.

Сонгосон материалууд

Дэвид А.Бэднар, “Итгэлээр суралцахыг эрэлхийл”
Ensign, Sept. 2007, 61–68

Ухамсартай хүмүүний үйл хөдлөлийн зарчим болох итгэл нь сайн мэдээг сурахтай ямар холбоотой вэ? Итгэлээр суралцахыг эрэлхийлэх гэдэг нь ямар утгатай вэ?

Бурханы бүтээлийн зохион байгуулалтаар үйлдэх зүйлс ч бий, мөн үйлдүүлэх зүйлс ч бий (2 Нифай 2:13–14-г үз). Тэнгэрлэг Эцэгийн охид хөвгүүдийн хувьд бид сонгох эрхийн бие даан үйлдэх чадвар болон үйлдэх хүчний бэлгээр адислагдсан. Сонгох эрх өгөгдсөн болохоор бид сонгогчид мөн ялангуяа сүнслэг мэдлэгийг олж авч мөн хэрэгжүүлэхийг эрэлхийлэх үедээ бид үйлдүүлэх төдийгүй, мөн үйлдэх ёстой юм.

Итгэлээр болон мөн туршлагаасаа сурах гэдэг нь Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөний үндсэн хэсгүүдийн хоёр нь юм. Аврагч Цагаатгалаар дамжуулан ёс суртахууны сонгох эрхийг олгосон бөгөөд биднийг өөрсдөө үйлдэж мөн итгэлээр сурах боломжтой болгосон. Уг төлөвлөгөөг эсэргүүцэн Люсифер хүмүүний сонгох эрхийг устгахыг эрэлхийлсэн ба тэрээр биднийг суралцагчдын хувьд зөвхөн үйлдүүлдэг байхаар хүссэн.

Зөв зарчмуудын дагуу үйлдэн сонгох эрхээ ашиглаж байгаа суралцагч нь өөрийн зүрх сэтгэлийг Ариун Сүнсэнд нээж мөн Түүний заавар, гэрчлэх хүч болон батлах гэрчийг урьдаг. Итгэлээр сурах нь сүнсний, оюун ухааны болон бие махбодын хичээл зүтгэлийг шаарддаг бөгөөд ердөө л хүлээн аваад суухыг хэлдэггүй. Итгэл дээр үндэслэсэн, чин сэтгэлийн мөн байнгын үйлдлээрээ

дамжуулан бид Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хүү, Есүс Христэд Ариун Сүнснээс сурч мөн зааврыг хүлээн авахад бэлэн байгаагаа харуулдаг. Итгэлээр сурснаар, найдаж байгаа зүйлийнхээ талаарх баталгааг хүлээн авч сонгох эрх чөлөөгөө ашигладаг ба мөн цорын ганц үнэний багш болох Их Эзэний Сүнснээс үзэж хараагүй зүйлсийнхээ нотолгоог урьдаг юм.

Номлогчид сонирхогчдод итгэлээр сурахад нь яаж тусалдгийг бодоод үз дээ. Мормоны Номоос сурч мөн үүний талаар залбиран Сүмийн цуглаануудад оролцож зарлиг тушаалуудыг сахих нь сонирхогчоос итгэлээ хөгжүүлж мөн үйлдэхийг шаарддаг. Номлогчийн үндсэн үүргүүдийн нэг нь амлалт авч, биелүүлэхэд нь болон итгэлээр сурч мөн үйлдэхэд нь сонирхогчид туслах явдал байдаг. Зааж, ухуулж, тайлбарлах нь хичнээн чухал байлаа ч сэргээгдсэн сайн мэдээний үнэн байдлыг сонирхогчид гэрчилж өгч чаддаггүй. Зөвхөн сонирхогч л итгэлээсээ үүдэн үйлдэж зүрх сэтгэлээ нээх зам дээр гарах үед Ариун Сүнс батлах сүнснийг илгээж чаддаг. Номлогч нар Сүнсний хүчээр заахад суралцах ёстой нь мэдээж хэрэг. Мөн түүний адил нэг чухал зүйл нь юу вэ гэвэл номлогчид сонирхогчдод итгэлээр сурахад нь туслах явдал юм. . . .

Эцсийн эцэст, итгэлээр сурч мөн сүнслэг үнэнийг хэрэгжүүлэх үүрэг нь бидний хувь хүн бүрд хамааралтай. Бидний одоо амьдарч байгаа мөн хойшид амьдрах дэлхийд энэ нь маш чухал, өндөр хариуцлага болоод байна. Бидний юуг, хэрхэн, хэзээ сурч байгаа нь багш хэрхэн зааж байгаа, эсвэл ямар сэдэв, хичээл зааж байгаагаар хэмжигддэг ч үүнээс бүрэн дүүрэн хамаардаггүй.



ХОЁРДУГААР САР: АВРАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Би бусад хүмүүсийг суралцахад нь хэрхэн тусалж чадах вэ?

Бид бүгд өөрсдийн хичээнгүй чармайлтаараа сайн мэдээний сургаалуудыг сурах үүрэгтэй. Сайн мэдээний багш нарын хувьд бид зааж байгаа хүүхдүүдээ бие даан сурах үүрэг хариуцлагыг өөрсдөдөө авахад нь тусалж чадна. Бид бусдын сурах, ойлгох мөн сайн мэдээгээр амьдрах хүслийг өдөөж чадна. Бид багшийн хувьд зааж байгаа хүүхдүүд маань сайн мэдээний зарчмуудыг өөрсдөө нээж, Бурханаас хүч авахад нь туслах үедээ хамгийн амжилттай байна.

Ангийн гишүүний хувьд хичээлд идэвхтэй, үр дүнтэйгээр оролцсон ямар туршлагаууд танд байна вэ? Энэхүү туршлага нь таны оролцоогүй байсан үеийнхээс хэрхэн ялгаатай байна вэ?

Ямар нэгэн санал оруулж тайлбар хэлэхээс гадна сурахад утга учиртайгаар оролцож чадах ямар аргууд байна вэ? Идэвхтэй оролцоог урамшуулахын тулд та юу хийх вэ?

Өсвөр үеийнхэнд заах ямар туршлагаууд байна вэ? Тэд заасан хүмүүсээ сурах үйл ажиллагаанд хэрхэн урьж оролцуулсан бэ? Та тэдний туршлагауудыг ашиглан тэднийг хэрхэн илүү сайн заадаг болгох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судрууд болон материалуудыг залбиралтайгаар судал. Таны зааж байгаа өсвөр үеийнхэнд юу хамгийн хэрэгтэй гэж та бодож байна вэ?

Матай 16:13–16 (Аврагч Петрийг гэрчлэхийг урьсан)

Матай 28:18–19; Лук 10:1–9 (Аврагч шавь нартаа бусдад заах мөн үйлчлэх үүрэг өгсөн)

Марк 10:17–21 (Аврагч Өөрийн заадаг хүмүүстээ итгэлээр үйлдэхийг урьсан)

Лук 7:36–43 (Аврагч зааж байгаа хүмүүсээс Өөрийнх нь захиасыг эргэцүүлэн бодохыг урьсан асуултуудыг асуусан)

Иохан 3:1–13 (Аврагч зааж буй хүмүүсийнхээ асуултуудад хариулдаг байсан)

3 Нифай 11:13–15 (Аврагч зааж буй хүмүүстээ, Өөрийг нь мэдрэх боломжийг өгсөн)

3 Нифай 17:1–3 (Аврагч заадаг хүмүүстээ илүү ихийг сурахад өөрсдийгөө бэлтгэхийг урьсан)

С ба Г 88:122 (Суралцагчид санаа, бодлоо хуваалцаж, бие биенээ сонсоноор сэнхэрдэг)

Дэвид А.Бэднар “Цөхрөлтгүй сэргэг бай” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2010 оны 5 сар, 40–43

“Хичээнгүйлэн суралцахад урь” *Teaching, No Greater Call* (1999), 60–74, 208–12

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутын туршид, өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, Сүмийн бусад

хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний хамаарлыг олж харахад нь та нар тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Эдгээр санаанууд тусалж болох юм:

- Өсвөр үеийнхнээс ангиас гадуур тэдэнд саяхан тохиолдсон сурах буюу заах туршлагаудаасаа хуваалцахыг хүс. Өмнөх долоо хоногуудад заагдсан зарчмууд тэдэнд хэрхэн тусалсан бэ?
- Багш нь үргэлж ярьж, ангийн гишүүд оролцох боломжгүй байдаг

хичээлийн сөрөг талуудыг ярилцахад урь. Тэдэнд суралцагчид хичээлд идэвхтэй оролцож болох олон арга замуудыг жагсаан бичихэд нь тусал (ангид болон ангиас гадуур). Багш иймэрхүү оролцоог хэрхэн урамшуулж чадах вэ?

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр өсвөр үеийнхнийг зааж байгаа хүмүүстээ сурахад нь хэрхэн тусалж чадахаа ойлгоход нь тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Өсвөр үеийнхнийг Аврагчийн арга барилаар сайн мэдээг заах нь зааврын 4–5-р хуудсыг судлаад, Аврагчийн заасан хүмүүсээ бие даан суралцахад урьсан арга барилуудыг самбар дээр жагсаан бичихэд урь. Өсвөр үеийнхнийг жагсаалтаас нэг зүйлийг сонгоод, хос хосоороо Аврагчийн энэ аргаар зааж байсан судар дахь жишээнүүдийг олохыг хүс (энэ агуулга дээр санал болгосон тэдгээр шиг). Та тэднийг бас багш нь үүнтэй ижил аргаар ямар нэгэн зүйлийг заасан өөрсдийн туршлагаудаасаа бодоход урь. Хос бүрийг юу олсноо ангийнхантайгаа хуваалцахыг хүс. Өсвөр үеийнхэн зааж байхдаа Аврагчийн аргуудыг хэрхэн дуурайж болохыг ярилц. Эдгээр аргуудад зааж байгаа тэдгээр хүмүүсээ оролцуулах нь яагаад чухал вэ?
- Хичээл эхлэхээс өмнө ангийн хэдэн гишүүдэд Teaching, No Greater

Call дээрх хуудас 63–74-р хуудсаас нэг зарчмыг судлахыг даалга. Тэднийг ангийнхаа бусад суралцагчдад уг зарчмынхаа тухай заахаар бэлтгэж ирэхийг хүс. Тэднийг танилцуулгынхаа нэг хэсэг болгон уг сонгосон зарчим нь сурахад бие даан идэвхтэйгээр оролцоход нь суралцагчдыг хэрхэн урамшуулж байгааг тайлбарлахыг хүс. Тэднийг бас зааж байхдаа энэ зарчмаа хэрэгжүүлэхэд нь урамшуул.

- LDS.org вэб хуудас дахь “Хичээнгүйлэн суралцахад урь” хэсгийн гурван видео бичлэгийг үзүүлээд, өсвөр үеийнхнийг ахлагч Дэвид А.Бэднарын “Цөхрөлтгүй сэргэг бай” хэлсэн үгийн “Хүүхдүүдийг үйлдэхэд урих” гэсэн гарчигтай хэсгийг уншихыг хүс. Сайн мэдээний багш нар нь яагаад заадаг хүмүүстээ сурах үйл явцад бие даан идэвхтэй оролцохыг урамшуулах ёстой байдаг шалтгаануудыг эрж олон

Заахад туслах арга

“Сонсох нь хайрын илэрхийлэл юм. Энэ нь ихэнхдээ золиослолыг шаарддаг. Бид бусдыг чин сэтгэлээсээ сонсохдоо, тэдэнд өөрсдийгөө илэрхийлэх боломж олгохын тулд хэлэхийг хүсэж байсан зүйлсээсээ олонтоо буцдаг” (Teaching, No Greater Call [1999], 66).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч бусдад юу зааж байгаагаа ойлгуулахын тулд энгийн түүх, сургаалт үлгэр болон амьдралд тохиолдсон жишээнүүдийг ашиглаж байлаа. Тэр тэдэнд туршлагаууд дээрээ үндэслэн сайн мэдээг нээж илрүүлэхэд нь тусалдаг байсан. Өсвөр үеийнхэн, бусдыг сайн мэдээг идэвхтэйгээр сурахад нь хэрхэн тусалж чадах вэ?

мөн хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс. Өсвөр үеийнхнийг ахлагч Дэвид А.Бэднарын дүрсэлсэн арга замуудаар тэдэнд зааж байсан багш

нарын тэр үеийн жишээнүүдийг ярилцахад урь. Ийм төрлийн заах арга нь тэдний суралцахад нь ямар нөлөө үзүүлсэн бэ?

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд бусдыг сурахад нь хэрхэн туслаж болохоо ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхнийг бусдад авралын төлөвлөгөөний тухай заах боломжуудын талаар бодоход урь. Тэднийг зааж байгаа хүмүүсээ идэвхтэй оролцоход нь туслах арга замуудыг төлөвлөхөд нь дэмж. Дараачийн хичээлүүд дээр тэднийг юу хийсэн тухайгаа хуваалцахыг урь.

Сонгосон материалууд

Дэвид А.Бэднар, “Цөхрөлтгүй сэргэг бай”, Ensign эсвэл Лиахона 2010 оны 5-р сар, 40–43

Сайн мэдээнээс суралцагчдын хувьд бид “зүгээр нэг сонсогчид биш, үгийг хэрэгжүүлэгчид” байх ёстой (Иаков 1:22). Бид сонгох эрхээ зөв зохистойгоор ашиглаж мөн зөв зарчмуудын дагуу үйлдэх аваас Ариун Сүнсний нөлөөнд бидний зүрх сэтгэл нээгдэн мөн ингэснээр бид Түүний заах мөн гэрчлэх хүч чадлыг урьдаг. Эцэг эхчүүд хүүхдүүдээ үйлдэхэд нь мөн итгэлээр сурахыг эрэлхийлэхэд нь туслах нандин үүргийг хүлээдэг. Ийм маягаар суралцахад хүүхэд хэзээ ч залуудахгүй.

Хүнд загас өгвөл тэрээр нэг удаа л хооллоно. Хүнд загас хэрхэн барихыг зааж өгвөл тэр нь түүнийг насан туршид нь хооллоно. Эцэг эхчүүд болон сайн мэдээг заах хүмүүсийн хувьд бид загас тарааж өгөх ёстой хүмүүс биш; харин оронд нь бидний хийх ажил бол хүүхдүүдээ “загас барьж” сурахад нь мөн сүнслэг байдлын хувьд тууштай болоход нь туслах явдал юм. Бид хүүхдүүдээ зөв зарчмуудын дагуу үйлдэхийг урамшуулснаар бид тэдэнд үйлдлээсээ сурахад тусалснаар энэхүү амин чухал зорилго нь хамгийн сайнаар гүйцэлддэг. “Хэрэв хэн нэгэн нь Түүний хүслийг үйлдэхийг хүсч байвал тэр нь энэ сургаал Бурханаас ирсэн үү гэдгийг мэдэх болно” (Иохан 7:17-г үз). Ингэж суралцах нь хүлцэнгүй хүлээн авахыг биш, харин сүнслэг байдлын, оюуны болон бие махбодын чармайлтыг шаарддаг.

Хүүхдүүдээ сайн мэдээнээс суралцагчдын хувьд үйлдэж, харин үйлдүүлэхгүй байхад урамшуулах нь Мормоны Номыг уншин түүний талаар

ярилцаж гэр орондоо албадуулалгүйгээр, аяндаа гэрчлэлээ хуваалцахаас эхэлнэ. Мормоны Номоос уншиж мөн сурч байгаа зүйлийнхээ талаар — эсвэл сайн мэдээний талаарх ярилцлага юм уу гэр оронд нь тохиосон гэрчлэлд гарч ирсэн сэдвийн талаар хүүхдүүд нь асуухаар урамшуулагддаг гэр бүлийн үдшийг төсөөлөөд үз дээ. Эцэг эх нь бүрэн дүүрэн хариултыг өгч чадахааргүй асуултыг хүүхдүүд нь асууж байгаагаар цааш төсөөлдөө. Зарим эцэг эх гэр бүлийн үдшийн иймэрхүү зохион байгуулалтгүй явдалд санаа зовдог байж магадгүй. Гэхдээ хамгийн сайн гэр бүлийн үдэш гэдэг нь урьдчилан бэлтгэсэн, худалдан авсан бүтээгдхүүн, эсвэл интернетээс буулган авсан заавар, зурагтай байдаг юм биш шүү. Гэр бүлийн гишүүд хамтдаа судраас эрэлхийлж мөн Ариун Сүнсээр заагдах нь ямар агуу боломж билээ. “Учир нь номлогч нь сонсогчоосоо өчүүхэн ч илүү бус ажгуу, бас багш нь сурагчаасаа илүү бус бөлгөө; . . . мөн тэд бүгд, хүн бүр өөрт буй хүчнийхээ дагуу хөдөлмөрлөж байв” (Алма 1:26).

Та бид үйлдэж мөн судалснаар мөн итгэлээр эрэлхийлдэг сонгогчид байхад нь хүүхдүүдээ тусалж байна уу, эсвэл бид хүүхдүүдээ өөрсдөд нь заахыг хүлээж мөн үйлдүүлэхийг зааж өгч байна уу? Эцэг эхчүүдийн хувьд бид хүүхдүүдээ ихэвчлэн идэхэд бэлэн загасны адил сүнслэг зүйлийг өгч байна уу, эсвэл бид тэдэнд үйлдэж, өөрсдөө сурахад нь мөн тууштай болон хөдөлшгүй зогсоход нь тогтмол тусалж чадаж байна уу? Гуйж, эрэлхийлж, мөн тогшихдоо санаа сэтгэлээ бүрэн зориулж байхад нь бид хүүхдүүдээ тусалж байна уу? (3 Нифай 14:7-г үз).



Би авралын төлөвлөгөөний талаар суралцахдаа сүмийн дуу хөгжмийг хэрхэн ашиглаж болох вэ?

Тэргүүн Зөвлөлийн зааснаар: “Хамгийн агуу зарим нэгэн номлолууд нь дуулуудыг дуулснаар тунхаглагдсан. Сүмийн дуулал нь биднийг наманчлал ба сайн үйлс рүү хөтөлж, гэрчлэл болон итгэлийг хөгжүүлж, сул дорой болон гашуудаж буй хүмүүсийг тайвшруулж, биднийг эцсээ хүртэл тэвчихэд урамшуулдаг” юм (*Сүмийн дуулал*, ix) гэжээ. Ихэнх сайн мэдээний зарчмууд, тэр тусмаа авралын төлөвлөгөөтэй холбоотой тэдгээр зүйлсийг дуулууд болон Сүмийн дуу хөгжмөөр дамжуулан маш үр дүнтэй зааж болдог.

Дуулал болон сүмийн бусад хөгжмөөс та сайн мэдээний ямар үнэнүүдийг сурсан бэ? Дуу хөгжим таны гэрчлэл болон итгэлд хэрхэн нөлөөлсөн бэ? Ямар туршлага танд дуу хөгжмийн хүчийг заасан бэ?

Таны зааж байгаа өсвөр үеийнхний амьдралд дуу хөгжим хэрхэн нөлөөлж байна вэ? Дуу хөгжмийн гайхамшгийн тухай заахад суралцагчдаас хэн нь танд тусалж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалуудыг залбиралтайгаар судал. Өсвөр үеийнхэнтэй хуваалцахаар өдөөгдсөн юуг та мэдэрсэн бэ?

Колосайчууд 3:16 (Бие биедээ дуулал болон хөгжмөөр дамжуулан заа)

“Хөгжим ба бүжиг” *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 22–23

С ба Г 25:12 (Зөв шударга хүмүүсийн дуу Их Эзэнд хандсан залбирал байдаг)

“Тэргүүн Зөвлөлийн өмнөх үг,” *Дуулал*, ix–x

Даллин Х.Өүкс, “Хөгжмөөр дамжуулан бишрэх нь,” *Ensign* 1994 оны 11 сар, 10–12

“Хичээлүүдээ хөгжмөөр баяжуулах нь,” *Teaching, No Greater Call* (1999), 172–73

Сүмийн дуу хөгжмийн вэб хуудас

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутын туршид, өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь та нар тэдэнд яаж тусалж чадах вэ? Эдгээр санаа тусалж болох юм:

- Өсвөр үеийнхнээс авралын төлөвлөгөөний тухай найздаа хэлэхийг хүссэн ямар нэгэн зүйлээ хуваалцахыг асуу. Найздаа сурахад нь тэд яаж тусалж чадах вэ?
- Ангиараа дууллын номон дээрх “Тэргүүн Зөвлөлийн өмнөх үг”-ийг унш (хуудас ix-x). Өсвөр үеийнхнийг самбар дээр Тэргүүн Зөвлөлийн биднээс хийхийг хүссэн зүйлс болон тэдний амласан адислалуудыг жагсааж бичихэд урь.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь өсвөр үеийнхнийг авралын төлөвлөгөөний тухай сурахдаа Сүмийн дуу хөгжмийг ашиглахад тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Өсвөр үеийнхэнд, дуулал буюу хүүхдийн дууны номон дээрх сэдэвчилсэн жагсаалтаас авралын төлөвлөгөөтэй холбоотой дуу хөгжмийг олоход хэрхэн ашиглахыг үзүүл. Өсвөр үеийнхнийг нэг дуулал буюу дууг сонгоод, үгсийг нь болон холбогдох судруудыг нь судлахад урь. Тэд дууллын үгсээс авралын төлөвлөгөөний тухай юу ойлгодог вэ?
- Өсвөр үеийнхнээс Сүмийн дуулалтай холбоотой сүнслэг туршлагаасаа хуваалцахыг хүс. Энэ туршлага нь яагаад тийм ач холбогдолтой байсан бэ? Бусдад сайн мэдээний үнэнийг заахад дуу хөгжим танд хэрхэн тусалж чадах вэ? Өсвөр үеийнхнийг дуу хөгжим ашиглан заах таван аргыг санал болгосон Teaching, No Greater Call дахь “Хичээлүүдийг дуу хөгжмөөр баяжуулах нь” (172-73-р хуудас) хэмээх гарчигтай хэсгийг олохыг хүс. Өсвөр үеийнхнийг сонирхлыг нь татсан нэг зөвлөгөөг сонгоод, үүнийгээ бие даан эсвэл жижиг бүлгүүд болон судлахад урь. Тэднийг дуусахад нь юу сурснаа ангид хуваалцахыг мөн уу санаануудаа ашиглан авралын

төлөвлөгөөг бусдад хэрхэн заах талаараа ангийнхандаа тайлбарлахыг тэднээс хүс. Ямар дуулууд болон дуунуудыг тэд ашиглаж болох вэ?

- Дараах гарчгуудыг самбар дээр бич: “Мөнх бус байдлын өмнөх амьдрал,” Мөнх бус амьдрал,” болон “Үхлийн дараах амьдрал.” Өсвөр үеийнхнийг “Эцэг минь ээ” дууллыг дуулах буюу сонсохыг хүс (Сүмийн дуулал, дугаар 42). Тэднээс авралын төлөвлөгөөний дээрх гурван хэллэгийн талаар энэ дуулал юу зааж байгааг олж тогтоохыг хүсээд, тэдний хэлсэн зүйлсийг тохирох гарчгийн доор самбар дээр бич. Тэнгэрлэг Эцэгийн бидэнд зориулсан төлөвлөгөөний тухай энэ дууллаас тэд юу сурч болох вэ? Тэд авралын төлөвлөгөөний тухай заадаг өөр ямар дуулууд эсвэл хүүхдийн дуунуудыг мэддэг вэ? Сүнс бидэнд дуу хөгжмөөр дамжуулан зааж чаддаг тухай өөрсдийн бодол, сэтгэгдлээ хуваалцахад тэднийг урамшуул.

Заахад туслах арга

“Суралцагчдыг асуултуудад хариулахдаа бэлтгэхэд туслахын тулд та тэдэнд ямар нэгэн зүйлийг унших юмуу үзүүлэхээсээ өмнө тэдний хариултуудыг сонсоно гэдгээ хэлж болно. Жишээ нь, та ‘Намайг энэ хэсгийг уншиж байхад үүний юу нь та нарын сонирхлыг татсан тухай хуваалцахын тулд анхааралтай сонсоорой’ гэх юмуу ‘Энэ судрыг уншиж байхад Их Эзэн итгэлийн тухай бидэнд юу хэлж байгааг ойлгож чадах эсэхээ шалгаарай’ гэж хэлж болно” (Teaching, No Greater Call [1999], 69).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч заасан тэдгээр хүмүүстээ итгэж байсан. Тэр тэдэнд итгэж, тэднийг бэлтгэж, тэдэнд заах, адислах мөн бусдад үйлчлэх чухал үүрэг хариуцлагуудыг өгсөн. Өсвөр үеийнхэнд заах дуудлага тань хэрхэн Аврагч танд итгэж байгаагийн баталгаа болж байна вэ? Та өсвөр үеийнхэнд тэдний заах чадварт итгэж байгаагаа хэрхэн үзүүлж чадах вэ?

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд авралын төлөвлөгөөний тухай зааж, сурахад сүмийн дуу хөгжмийг хэрхэн ашиглаж болохыг ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цагийг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхнээс өнөөдрийн дуу хөгжимтэйгөөр заах болон суралцах тухай юу сурснаа эргэцүүлэн бодохыг хүс. Сурсан зүйлийнхээ дагуу юуг хийхээр тэд өдөөгдсөн бэ? Энэ нь тэдний сайн мэдээг суралцахад хэрхэн нөлөөлөх вэ? Дуу хөгжим тэдний бодолд хэрхэн нөлөөлөх вэ? Ирээдүйд бусдад заахад нь хэрхэн нөлөөлөх вэ?

Сонгосон материалууд

"Хичээлүүдийг дуу хөгжмөөр баяжуулах нь" Teaching, No Greater Call, (1999), 172–173

Сайн мэдээний зарчмуудыг заах ба давтах нь

Ихэнх дуулууд сайн мэдээний зарчмуудыг заах эсвэл өмнө ярилцсан зарчмуудын тань талаар давтахад тусалж чадна.

Ямар нэг зарчмыг заахаар дууг ашиглах үедээ ярилцлагаа өрнүүлэхийн тулд эсвэл дууны утгын талаар бодоход тэдэнд туслах асуултуудыг суралцагчдаасаа асуухыг та нар хүсч болно. Жишээлбэл: Та нар "Зарлигуудыг дага" дууг суралцагчдаар дуулуулахаасаа өмнө (*Дуулал*, д. 303; *Children's Songbook*, 146–147) "Бид зарлигуудыг дагах үедээ яагаад аюулгүй байдал болон амар амгаланг мэдэрдэг вэ?" гэсэн асуултыг асууж болох юм. Мөн "I Lived in Heaven" гэдэг дууг (*Children's Songbook*, 4) хүүхдүүдэд авралын төлөвлөгөөний талаар заахдаа ашиглаж болно. "How Firm a Foundation" дууг (*Сүмийн Дуулал* д. 85) зааж байгаа хүмүүстээ Аврагч бидэнд саад тотгорыг туулахад тусалдаг гэдгийг ойлгоход нь ашиглаж болно. Хайртай нэгэн нь нас барахад бидний хүлээн авч чадах тайвшралын талаар заахын тулд та нар "Where Can I Turn for Peace?" дууг мөн ашиглаж болно (*Дуулал*, д. 129).

Сайн мэдээний зарчмыг заасны дараа суралцаж байгаа хүмүүсээсээ "Ямар дуулал энэ зарчмыг санахад бидэнд туслах вэ?" гэж асууж болно. Тэгээд тэдний санал болгосон дуунуудын нэгийг нь дуул. Хүүхдүүдэд зааж байгаа бол дуу дуулаад тухайн дуу нь хичээлд ямар хамааралтай болохыг асууж болно. Тэгээд уг дууг та өөртэйгээ хамт дуулахыг тэднээс хүсч болно.

Судрын талаарх ойлголтыг өгөх

Сүмийн дууллын номонд байгаа дуулал бүрийг судрын лавлах дагалдсан байдаг бөгөөд тэдгээрийг индексжүүлсэн байдаг. (*Дуулал*, хуудас 410–414). Хүүхдийн дууны номны ихэнх дуунуудыг судрын лавлах түүнчлэн дагалдсан байдаг. Тодорхой нэг хичээлд таарах дууг олохын тулд эдгээр лавлахуудыг та нар лавлан үзэж болох юм. Жишээлбэл, та нар Иохан 13:34–35 судраас зааж байгаа бол сурагчдаар "Love One Another" (*Дуулал*, д. 308; *Children's Songbook*, 136) дууг дуулуулж болно.

Суралцагчдад гэрчлэлтэй болж хуваалцахад нь туслах

Суралцагчид Сүмийн дуунууд болон дуулуудыг дуулах үед заагдаж байгаа зарчмуудын үнэнийг Сүнс тэдэнд гэрчлэх болно. Зарим дуунуудын үгс нь гэрчлэлийг илэрхийлдэг бөгөөд дуулахдаа хүмүүс хамтдаа гэрчлэлээ хуваалцдаг. Энэ дуунд "Би Гэтэлгэгч Амьдэг Мэднэ" дуу орно. (*Дуулал*, д. 136); "Би Бурханы Хүүхэд" (*Дуулал*, д. 301; *Children's Songbook*, 2–3); "Бурхан минь бошиглогч илгээсэн танд талархъя" (*Дуулал*, д. 19); and "Did Jesus Really Live Again?" дуунууд багтдаг. (*Children's Songbook*, 64). . . .

Хичээлээ дуусгах ба суралцагчдад сайн мэдээний зарчмыг хэрэгжүүлэхийг уриалах

Хичээлээ дуусгах үед сүмийн дуу эсвэл дуулал нь заасан зарчмыг дүгнэж мөн урамшуулах захиацыг дамжуулж өгдөг. Жишээлбэл: зарлигуудыг сахих талаар заасан хичээлийнхээ төгсгөлд та нар суралцагчдаар "Choose the Right" дуулыг дуулуулж болно. (*Сүмийн дуулал*, д. 239); "Keep the

Сонгосон материалууд

Commandments” (Сүмийн дуулал, д. 303; *Children’s Songbook*, 146–47); “Dare to Do Right” (*Children’s Songbook*, 158); эсвэл “Nephi’s Courage” дууг дуулж болно. (*Children’s Songbook*, 120–21).

Хүндэтгэл бишрэлтэй байх мэдрэмжийг төрүүлэх

Та болон таны гэр бүл, гэр бүлээрээ сайн мэдээнээс суралцахдаа хүндэтгэл бишрэлийг нэмэгдүүлэхийн

тулд гэр бүлийн зөвлөл, гэр бүлийн үдэш, мөн өөр бусад цугларалтаараа сүмийн дуулал эсвэл бусад дуунуудыг дуулж болно. Ангид суралцагчид орж ирэх үеэр та нар хөгжмийн бичлэг тоглуулах эсвэл хэн нэгнээр төгөлдөр хуур тоглуулж болно. Энэ нь хүндэтгэл бишрэлтэй уур амьсгалыг бий болгож мөн суралцагчдыг хичээлд бэлтгэдэг.



ХОЁРДУГААР САР: АВРАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Христийн сургаалыг ойлгоход нь бусад хүмүүст би хэрхэн тусалж чадах вэ?

Хаа газрын бүхий л хүмүүс Есүс Христэд итгэж, гэм нүглүүдээ наманчилж, баптисм хүртэж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авч, эцсээ хүртэл тууштайгаар тэвчих нь “Христийн сургаал” юм. Христийн сургаал бол Бурханы хаант улсад аврагдаж болох цорын ганц арга зам юм. Энэ нь сүмийн үндэс суурь бөгөөд сүмийн номлогчдын үндсэн захиас байдаг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Бэлтгэж байхдаа эдгээр судар болон материалуудыг залбирч, судлаарай. Та өсвөр үеийнхэнтэй юу хуваалцахаар өдөөгдсөн бэ?

2 Нифай 25:26 (Бид Христийн талаар заадаг)

Итгэлийн Тунхаг 1:4 (Сайн мэдээний анхны зарчим ба ёслолууд)

2 Нифай 31 (Нифай Христийн сургаалыг дүрсэлдэг)

“Есүс Христийн сайн мэдээ,” *Миний сайн мэдээг номло* (2004), 66–73

3 Нифай 11:32–41; 27:13–21 (Христ Өөрийн сургаалыг тунхагладаг)

Д.Тодд Кристоффэрсон “Христийн сургаал” *Ensign* эсвэл *Лиакхона* 2012 оны 5-р сар, 86–89

2 Нифай 31 болон судрууд дээр өөр хаа нэгтэй Христийн сургаалыг судалж байх үед танд ямар бодол болон сэтгэгдэл төрдөг вэ? Түүний сургаал таны амьдралыг хэрхэн удирдаж мөн адисалсан бэ?

Өсвөр үеийнхэн яагаад Христийн сургаалаас суралцах хэрэгтэй вэ? Энэхүү ойлголт нь Сэргээлтийн талаарх энэхүү чухал захиасыг бусадтай хуваалцахад тэднийг хэрхэн илүү сайн бэлтгэх вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний хэдэн минутад өөр өөр нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найзуудад нь тохиолдсон явдлууд гэх мэт) зүйлүүдийн уялдаа холбоог гаргахад өсвөр үеийнхэнд тусал. Та нар тэдэнд өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь хэрхэн тусалж чадах вэ? Эдгээр санаа тусалж болох юм:

- Өсвөр үеийнхнийг сүмийн ангиудад саяхан сурсан нэг зүйлийг нь сануулан, түүнийх нь талаар туршлагаа хуваалцахад тэднийг урь.
- Самбар дээр “Христийн сургаал гэж юу вэ?” гэж бич. Ангийн

гишүүн бүрд энэ хичээлийн эхэнд байгаа догол мөрийг хувиалан өгч, самбар дээрх асуултын хариултыг хайн, үүнийг уншихыг хүс. Бусадтайгаа хариултуудаа хуваалцахад тэднийг урь. Ангийн нэг хэсгийг 3 Нифай 11:39–41 -ийг уншихад,

нөгөө хэсгийг *Миний сайн мэдээг номло* удирдамжийн 1-р хуудасны “Таны зорилго” хэсгийг уншихад урь. Эдгээр суралцах

материалуудын дагуу өсвөр үеийнхэн Христийн сургаалыг ойлгох нь яагаад чухал вэ?

Заахад туслах арга

“Хэрвээ бид эцсийн дүндээ суралцагчдад нөлөөлөхийг хүсэж байвал тэдэнд хэрхэн бусдыг хайрлахыг заах төдийгүй өөрсдийн заадаг хүн нэг бүрийг хайрлах хэрэгтэй” (*Teaching, No Greater Call* [1999], 31).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн номлолыг зааж, гэрчлэхдээ судруудыг ашигладаг байсан бөгөөд Тэрээр хүмүүст судруудын талаар бодож, асуултынхаа хариултыг судруудаас олохыг заасан юм. Христийн сургаалыг ойлгоход нь өсвөр үеийнхэнд туслахын тулд та судруудыг хэрхэн ашиглаж болох вэ?

Хамтдаа суралц

Өсвөр үеийнхнийг Христийн сургаалыг бусадтай хуваалцахад нь илүү сайн бэлтгэж болохын тулд доорх үйл ажиллагаа бүр Христийн сургаалын талаар суралцахад тэдэнд тусалж чадна. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Ангийн гишүүн бүрийг *Миний сайн мэдээг номло* удирдамжийн 3-р бүлэг дээрх “Есүс Христэд итгэх итгэл,” “Наманчлал,” “Баптисм, бидний анхны гэрээ,” “Ариун Сүнсний бэлэг,” “Эцсээ хүртэл тууштайгаар тэвчих” гэсэн хэсгүүдээс аль нэгийг нь уншихыг даалга. Тэднийг судар болон жишээнүүд эсвэл өөртөө тохиолдсон явдлуудыг ашиглан, ангийн үлдсэн гишүүддээ сурсан зүйлээ хуваалцахад урь.

- Ангийн гишүүн бүрийг 2 Нифай 31 - ийг уншиж, Христийн сургаалын талаар Нифай юу гэж заасныг олж мэдэхийг тэднээс хүс (итгэл, наманчлал, Ариун Сүнсний бэлэг хүлээн авах, эцсээ хүртэл тууштай

тэвчих). Ангийг хоёр эсвэл гурван хүүхэдтэй “хамтрал” болгон хуваарилж, Христийн сургаалыг өмнө сонсож байгаагүй хэн нэгэнд үүнийг зааж болох арга замуудыг төлөвлөх цаг тэдэнд өг. Өөр хамтралуудад зааж дадлага хийхэд бүх хамтралыг урь.

- Өсвөр үеийнхнийг 2 Нифай 31-ийг уншиж, хэн нэгэнд Христийн сургаалын талаар заахдаа ашиглаж болох зураг эсвэл схем зурахад тэднийг урь. Тэднийг зурсан зургуудаа ашиглан, бие биедээ заахад урь. Бүгд Христийн сургаалыг зааж дууссаны дараа өөрсдийн туршлагаудаа хуваалцахад тэднийг урь.

Өсвөр үеийнхнийг өнөөдөр сурсан зүйлээ хуваалцахыг хүс. Христийн сургаалыг ойлгоход нь бусдад хэрхэн туслахаа тэд мэдэх үү? Энэ сургаалыг бусадтай хуваалцах үүргийнхээ талаар тэд ямар мэдрэмж болон сүнслэг өдөөлтүүдийг авсан бэ? Тэдэнд өөр ямар нэгэн асуултууд байна уу?

Үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан зүйлээсээ юу хийх хэрэгтэй гэж мэдэрснийг өсвөр үеийнхнээс асуу. Эдгээр мэдрэмжийнхээ дагуу үйлдэхэд тэднийг урамшуулан дэмж. Суралцагчид мэдрэмжийнхээ дагуу үйлдэж байгаа эсэхийг мэдэх аргуудыг бодож ол.

БҮЛГИЙН ТОВЧ ТОЙМ

Гуравдугаар сар: Есүс Христийн Цагаатгал

*“Болгоогтун та нар Христийн цагаатгалын ... хүчинд найдахыг би та нарт хэлье:”
(Моронай 7:41).*

Энэ бүлгийн тоймууд нь Есүс Христ болон Түүний Цагаатгалд итгэх итгэлээ бэхжүүлэхийн тулд судруудыг болон амьд бошиглогчдын үгсийг хэрхэн судалж сурахад нь өсвөр үеийнхэнд туслах болно. Цагаатгалын тухай хүчтэй гэрчлэлтэй болж, үүнийгээ бусдад итгэлтэйгээр заах чадвартай болоход нь өсвөр үеийнхэнд туслах боломжийг эдгээр хичээл танд олгох болно. Судалж байгаа зүйлийнхээ талаар асууж лавлан, илүү ихийг мэдэхийг хичээж, сурч мэдсэн зүйлээ бусадтай хуваалцахад тэднийг дэмжээрэй.

Энэ сард сонгох тоймууд:

Би Есүс Христийн Цагаатгалд итгэх итгэлээ бэхжүүлэхийн тулд амьд бошиглогч, төлөөлөгчдийн үгсийг хэрхэн ашиглаж болох вэ?

Судрууд надад Есүс Христийн Цагаатгалын тухай юу заадаг вэ?

Есүс Христийн Цагаатгалд итгэх итгэлээ бэхжүүлэхэд Мормоны Ном надад хэрхэн туслах вэ?

Аврагчийн ач ивээлд найдах нь намайг илүү сайн багш болоход хэрхэн туслах вэ?

Би Цагаатгалын тухай бусдад заахдаа зүйрлэлүүдийг хэрхэн ашиглаж болох вэ?



Би Есүс Христийн Цагаатгалд итгэх итгэлээ бэхжүүлэхийн тулд амьд бошиглогч, төлөөлөгчдийн үгсийг хэрхэн ашиглаж болох вэ?

Өнөө үеийн бошиглогч, төлөөлөгчид эрт үеийн бошиглогчдын нэгэн адил Есүс Христийн тухай гэрчилж, Түүний Цагаатгалаас хүртэхэд бүх хүмүүнийг урьдаг. Тэднийг Есүс Христийн “тусгай гэрчүүд” гэдэг. Амьд бошиглогч, төлөөлөгчид Есүс Христийн тухай гэрчлэхэд Ариун Сүнс үүнийг нь баталдаг бөгөөд бид тэдний сургаалын дагуу амьдарснаар адислагддаг.

Амьд бошиглогч, төлөөлөгчдийн үгс Есүс Христэд итгэх итгэлийг тань хэрхэн бэхжүүлсэн бэ? Бошиглогч, төлөөлөгчдийн хэлсэн ямар үг, ном эсвэл өгүүлүүд Түүнийг илүү сайн мэдэхэд танд тусалсан бэ?

Сүүлчийн чуулган дээр хэлсэн ямар үгс Есүс Христэд итгэх өсвөр үеийнхний итгэлийг бэхжүүлэхэд тэдэнд тусалсан бэ? Та амьд бошиглогчдын үгсийг судалж, амьдралдаа хэрэгжүүлэхэд өсвөр үеийнхнийг хэрхэн дэмжиж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Та бошиглогч, төлөөлөгчдийн үгсийг залбирч судалснаар заадаг өсвөр үеийнхнийхээ итгэлийг хүчирхэгжүүлэх юуг мэдэрсэн бэ?

Иаков 7:11–12; Мозая 13:33–35; 15:11–12 (Бүх бошиглогч Есүс Христийн тухай гэрчилдэг)

С ба Г 27:12; 107:23 (Төлөөлөгчид бол Есүс Христийн тусгай гэрчүүд юм)

С ба Г 76:22–24 (Есүс Христийн тухай Иосеф Смитийн гэрчлэл)

Библийн лавлах, “Төлөөлөгч”

Дэвид А.Бэднар, “Миний нэрийг гэрчлэхээр сонгогдсон,” *Ensign* эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 126–130

Жэффри Р.Холланд, “Шударга ёс, хайр, нигүүлсэл хамтдаа,” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 92–94

Квинтин Л.Күк, “Бид Есүс Христийг дагадаг,” *Ensign* эсвэл 2010 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 91–95

“Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл,” *Ensign* эсвэл *Лиакона*, 2000 оны 4-р сар, 2–3

Видео бичлэг: “Ачааг хөнгөлөх нь”

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхэнд хэдэн минутын туршид, янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судар судлах, семинар, Сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа харилцдаг туршилага гэх мэт) өсвөр үеийнхэнд сурч байгаа зүйлсийнхээ

хоорондын уялдаа холбоог ойлгоход тусал. Өдөр тутмын амьдрал маань сайн мэдээтэй хамааралтай болохыг олж харахад нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Доорх санаанууд танд тусалж болох юм:

- Сүүлийн үед ангиас гадуур олж авсан суралцах болон заах туршлагаасаа хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс.
- Библийн лавлагаас “Төлөөлөгч” гэсэн гарчигтай тайлбарыг уншиж, Төлөөлөгчийн үүргийг дүрсэлсэн

өгүүлбэрүүдийг олоход тэднийг урь. Бошиглогч, төлөөлөгчид бол Есүс Христийн тусгай төлөөлөгчид болохыг харуулсан судруудыг (энэ тоймд санал болгосон судруудыг оролцуулаад) олж, ангиараа унш. Эдгээр судраас юу тэдэнд гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн бэ?

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь амьд бошиглогч, төлөөлөгчдийн үгс нь Есүс Христэд итгэх тэдний итгэлийг хэрхэн бэхжүүлдгийг ойлгоход өсвөр үеийнхэнд тусалж чадна. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Ахлагч Дэвид А.Беднарын “Миний нэрийг гэрчлэхээр сонгогдсон” хэлсэн үгийн “Өөр нэгэн сургамж” гарчигтай хэсгийн хуулбарыг ангийн гишүүн бүрд тарааж өг. Өнөө үеийн бошиглогч эсвэл төлөөлөгчийн үгсээс Аврагчийн Цагаатгалыг ойлгоход тусалдаг нэг эшлэл сонгон, хуваалцахад тэднийг урь. Тэднийг олсон эшлэлүүдээ хуваалцаж байх хооронд таньдаг нэгэнтэйгээ санал бодлоо захидал, мессежээр хуваалцах эсвэл нийтийн сүлжээнд тавих зэрэг арга замыг төлөвлөхөд урамшуул.

- Ангиараа хамгийн сүүлийн ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг хураангуйлан дүгнэж, Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын Чуулгын гишүүд Есүс Христ болон Түүний Цагаатгалын тухай заасан буюу гэрчилсэн хэсгүүдийг ол (та *Ensign* эсвэл *Лиакхона*-гийн ерөнхий чуулганы дугаарын сэдвийн индексийг ашиглаж болно). Бошиглогчид,

төлөөлөгчдийн гэрчлэлүүдээс юу нь тэдэнд гүнзгий сэтгэгдэл төрүүлдэг вэ? Тэдний гэрчлэлүүд Аврагчид итгэх итгэлийг тань хэрхэн бэхжүүлснийг хуваалцаж болно.

- “Есүс Христийн Цагаатгал” гэж самбарт бич. Ангийн гишүүн бүрд ахлагч Жэффри Р.Холландын “Шударга ёс, хайр, нигүүлсэл хамтдаа” эсвэл ахлагч Квинтин Л.Күкийн “Бид Есүс Христийг дагадаг” хэлсэн үгийн хуулбарыг өг. Эдгээр хэлсэн үгээс Аврагчийн Цагаатгалын талаар суралцсан зүйлүүдээ жагсаахыг өсвөр үеийнхнээс хүс. Олж мэдсэн зүйлээ самбар дээр нэг өгүүлбэрт багтаан хураангуйлж бичихэд өсвөр үеийнхнийг уриад, яагаад энэ сургаал чухал санагдсаныг хүн бүрээс асуу.

- Энэ тоймд санал болгосон видео бичлэгүүдээс нэг буюу түүнээс олныг үзүүл эсвэл “Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл”-ийг ангийн

Заахад туслах арга

“Та заадаг хүмүүсийнхээ асуулт, санал бодолд уриалгахан хариулах юм бол тэд хичээл, ярилцлаганд илүү итгэлтэй, идэвхтэй оролцох болно. Жишээ нь та ‘Хариулсанд баярлалаа. Энэ бол чухал санаа байна’ ... гэх буюу ‘Энэ бол маш сайн жишээ,’ ‘Өнөөдөр та нарын хэлсэн бүх зүйлд би баярлан талархаж байна’ гэхчилэнгээр хэлж болно” (*Teaching, No Greater Call* [1999], 64).

гишүүдээр ээлжээр уншуул. Есүс Христэд итгэх тэдний итгэлийг бэхжүүлэх үгсийг сонсох буюу эрж олоход өсвөр үеийнхнийг урь. Эдгээр захиасууд тэдний найз нөхөд, гэрийнхний итгэлийг хэрхэн бэхжүүлж болох тухай хуваалцахад тэднийг урамшуул.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Амьд бошиглогчдын үгс Цагаатгалд итгэх тэдний итгэлийг хэрхэн бэхжүүлж болохыг тэд ойлгосон уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэвт илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

- Хичээлийн үеэр төрсөн сэтгэгдлээ хуваалцахад өсвөр үеийнхнийг урь. Амьд бошиглогч, төлөөлөгчдийн үгсийг судлах нь Есүс Христэд итгэх тэдний итгэлийг хэрхэн бэхжүүлсэн бэ? Сурч мэдсэн зүйлээ үйлдэхэд

- “Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл”-ээс хамгийн чухал гэж үзсэн нэг өгүүлбэрийг цээжлэхэд тэднийг урь. Хэрэв амьд бошиглогчид, төлөөлөгчдийн сургаалууд тэдэнд байгаагүй бол Есүс Христэд итгэх итгэл нь хэрхэн өөр байх байсан тухай бичихийг өсвөр үеийнхнээс хүс. Бичсэн зүйлээ хуваалцах цагийг тэдэнд гаргаж өг.

нь та тэднийг хэрхэн урамшуулан дэмжиж болох вэ?

- Амьд бошиглогч, төлөөлөгчид бол Христийн тусгай гэрчүүд болох тухай өөрийн гэрчлэлийг хуваалц.

Аврагчийн арга барилаар заах нь

Есүс заадаг хүмүүсээ сайн мэддэг байсан бөгөөд тэд ямар хүмүүс болж чадахыг ч мэддэг байлаа. Тэр тэдэнд сурч, өсөж хөгжихөд нь туслах арга замуудыг олдог байв. Та амьд бошиглогч, төлөөлөгчдийн үгсийг эрхэмлэн, санахад нь сүнслэгээр нөлөөлөх ямар туршлагаар өсвөр үеийнхэнд тусалж чадах вэ?

АМЬД ХРИСТ

Төлөөлөгчдийн гэрчлэл

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм

Есүс Христ хоёр мянган жилийн өмнө мэндэлснийг бид дурсан тэмдэглэхдээ Түүний зүйрлэшгүй амьдрал, агуу цагаатгагч золиослолын хэмжээлшгүй хүч нь үнэн бодитойг гэрчилдэг. Дэлхий дээр амьдарч байсан болон хойшид амьдрах бүх хүнд ийм хүчтэй нөлөөг өөр хэн ч үзүүлэхгүй юм.

Тэр бол Хуучин Гэрээний Агуу Иехова, Шинэ Гэрээний Мессиа билээ. Тэр бол Эцэгийнхээ удирдлаган дор дэлхийг бүтээсэн Бүтээгч. “Бүх юм Түүгээр бий болсон. Бий болсон юмсаас Түүнгүйгээр бий болсон юмс нэг ч байхгүй” (Иохан 1:3). Тэрээр нүгэлгүй байсан ч аливаа зөвт байдлыг гүйцэлдүүлэхийн тулд багтисм хүртэж ад үзэгдсэн ч “сайныг үйлдэж явлаа” (Үйлс 10:38). Түүний сайн мэдээ бол энх амгалан болон сайн санааны захиас байлаа. Тэрээр хүн бүхнийг Өөрийнхөө үлгэр жишээг дагахыг хүсч байлаа. Тэрбээр Палестины замуудаар алхан өвчтэйг эдгээж, хараагүйг хардаг болгон, үхэгсдийг босгож явлаа. Бас мөнхийн үнэнүүд, мөнх бус байдлын өмнөх амьдралд бид оршин амьдарч байсан нь үнэн болохыг, дэлхий дээрх бидний амьдралын зорилго, ирэх амьдрал дахь Бурханы хөвгүүд, охидын өсөн хөгжих боломжуудын тухай заадаг байв.

Тэрбээр ариун ёслолыг Өөрийн агуу цагаатгагч золиослолын сануулагч болгон бий болгосон юм. Түүнийг баривчилж, хилс хэрэгт буруутган, хилэгнэсэн олны шаардлагыг биелүүлэхийн тулд Калварид загалмайд дүүжлэн цаазаар авах ял оноосон билээ. Тэрээр бүх хүн төрөлхтний нүглийг цагаатгахын төлөө амиа өгсөн юм. Дэлхий дээр амьдарч байсан, амьдарч байгаа болон амьдрах бүх хүнд Түүний агуу бэлэг зориулагдсан юм.

Бүх хүн төрөлхтний түүхэнд гол сүүрийг эзэлдэг Түүний амьдрал Бетлехемд эхлээгүй бас Калвари дээр дуусаагүйг бид хүндэтгэлтэйгээр гэрчилж байна. Тэр бол Эцэгийн Ууган Хүү, махан биеэр төрсөн Эцэгийн Төрсөн Ганц Хүү, дэлхийн Гэтэлгэгч мөн.

Тэрээр булшнаас босч ирэн, “нойрсогсдоос анхны үр жимс болсон юм” (1 Коринт 15:20). Амилсан Их Эзэн мөнх бус үйлчлэлийнхээ үед хайрладаг байсан хүмүүс дээрээ очжээ. Тэр бас эртний Америк дахь “өөр хонин сүрэг” (Иохан 10:16)-тэй үйлчилсэн юм. Өнөөгийн дэлхийд Тэрбээр Эцэгийнхээ хамт Иосеф Смит хөвгүүн дээр хүрч ирэн, өнө эртнээс амлагдсан “цагийн дүүрнийг” (Ефес 1:10) эхлүүлсэн билээ.

Бошиглогч Иосеф Амьд Христийн тухай “Түүний мэлхий галын дөл лүгээ адил байв; тэргүүнийх нь үс цэвэрхэн цас мэт цав цагаан байв; түүний төрх байдал нарны гэрлээс ч илүү хурцаар гялалзаж байлаа; мөн дуу хоолой нь агуу их ус хуйлрах мэт байв, бүр Иеховагийн дуу хоолой өгүүлэн;

Бибээр эхнийх мөн эцсийнх болой; Бибээр амьдардаг тэрээр болой, би бол алагдсан тэрбээр бөлгөө; бибээр Эцэгийн өмнө та нарын өмгөөлөгч билээ” (С ба Г 110:3–4) хэмээн бичжээ.

Бошиглогч бас Түүний тухай “Мөн эдүгээ түүний талаар өгөгдсөн олон гэрчлэлийн дараа, энэ бол түүний талаар бидний өгөх хамгийн сүүлчийн гэрчлэл юм: Тэр амьд бөлгөө!

Учир нь бид түүнийг бүр Бурханы баруун гар талд харсан билээ; түүнчлэн тэрээр Эцэгийн Төрсөн Ганц болой хэмээн гэрчлэх дуу хоолойг бид сонссон билээ.


Ийнхүү түүгээр, мөн түүгээр дамжин, мөн түүнээс дэлхийнүүд бүтээгдсэн мөн бүтээгддэг ажгуу, мөн тэдгээрийн оршин суугчид нь Бурханы төрсөн хөвгүүд хийгээд охид нь бөлгөө” (С ба Г 76:22–24) гэж тунхагласан юм.

“Элч нар болон эш үзүүлэгчдийн . . . суурин дээр босгогдсон бөгөөд Есүс Христ Өөрөө булангийн чулуу нь болох” (Ефес 2:20) Түүний санваар, Түүний Сүм дэлхий дээр сэргээгдсэнийг бид хариуцлагатайгаар, хүндэтгэлтэйгээр тунхаглаж байна.

Тэрбээр нэгэн өдөр дэлхий дээр эргэж ирэх болно гэдгийг бид гэрчилж байна. “Дараа нь ЭЗЭНий алдар илэрхийлэгдэж, бүх махан бие хамтдаа үзнэ” (Исаиа 40:5). Тэрээр Хаадын Хаан, Эздийн Эзэн болж захиран хаанчлах бөгөөд Түүний өмнө өвдөг бүхэн сөхөрч мөн хэл бүхэн хүлээн зөвшөөрөн Түүнийг шүтэн бишрэх болно. Бид бүгд өөрсдийн үйлс, зүрх сэтгэлийнхээ хүслээр шүүгдэхийн учир Бурханы өмнө зогсох болно.



Бид зохих ёсоор томилогдсон Түүний Төлөөлөгчдийн хувьд Есүс бол Христ, Бурханы үхэшгүй Хүү гэдгийг гэрчилж байна. Тэр бол өнөөдөр Эцэгийнхээ баруун гар талд байгаа аугаа Иммануэл Хаан мөн. Тэр бол дэлхийн гэрэл хийгээд амь амьдрал, итгэл найдвар болой. Түүний зам бол энэ дэлхийд аз жаргал хийгээд ирэх дэлхийд мөнх амьдрал өөд хөтөлдөг зам мөн. Юутай ч зүйрлэшгүй бэлэг болох тэнгэрлэг Хүүгийнх нь төлөө Бурханд талархал өргөө.

ТЭРГҮҮН ЗӨВЛӨЛ



2000 оны 1-р сарын 1

АРВАНХОЁРЫН ЧУУЛГА





Судрууд надад Есүс Христийн Цагаатгалын тухай юу заадаг вэ?

Судруудын үндсэн зорилго бол Есүс Христийн тухай гэрчилж, Түүнд ирж, Цагаатгалын адислалуудыг хүртэхэд бидэнд туслах явдал мөн. Бид судруудыг шимтэн судалснаар сургаал, түүх, бэлгэдлүүдээр дамжуулан Аврагчийн тухай мэдэх болно.

Есүс Христийн тухай ямар судрууд танд чухал байдаг вэ? Есүс Христийн тухай ямар бэлгэдлүүдийг та судруудаас олсон бэ? Цагаатгалыг илүү сайн ойлгоход ямар судрууд танд тусалсан бэ?

Таны зааж буй өсвөр үеийнхэн хэрхэн судруудаас Есүс Христийн талаар олж мэдэж байна вэ? Есүс Христийн тухай ямар бэлгэдлүүдийг олоход нь та тэдэнд тусалж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Судрууд болон Сүмийн бусад материалыг залбирч, судал. Та өсвөр үеийнхэнтэй юуны тухай хуваалцах хэрэгтэй гэж боддог вэ?

Эхлэл 22:1–14 (Абрахам хүү Исаакаа Бурханы Хүүгийн хийх золиослолтой адилтган тахилд өргөхийг хүссэн; Иаков 4:5 -ыг үзнэ үү)

2 Нифай 11:4; Мосе 6:63 (Бурханы бидэнд өгсөн бүх зүйл Түүний Хүүгийн тухай заадаг)

Мозая 13:33–35 (Бүх бошиглогч Есүс Христийг гэрчилдэг)

Боид К.Пакэр, “Бидний найдварын учир шалтгаан,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2014 оны 11-р сар, 6-8

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхэнд хэдэн минутын туршид, янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судар судлах, семинар, Сүмийн бусад хичээл эсвэл найз нартайгаа харилцдаг туршлага гэх мэт) өсвөр үеийнхэнд сурч байгаа зүйлсийнхээ хоорондын уялдаа холбоог ойлгоход тусал. Өдөр тутмын амьдрал сайн мэдээтэй хамааралтай болохыг олж харахад нь та хэрхэн тэдэнд тусалж чадах вэ? Доорх санаанууд танд тусалж болох юм:

- Өсвөр үеийнхэн өнгөрсөн долоо хоногт Ням гаргийн хичээлээр юу сурч мэдсэнийг нь шалга. Тэд хэрхэн сурч мэдсэн зүйлээ энэ долоо хоногт хэрэгжүүлсэн бэ?
- Есүс Христ болон Түүний Цагаатгалын тухай хамгийн сүүлд уншсан нэг судраа хуваалцахад тэднийг урь.

Хамтдаа суралц

Заахад туслах арга

“Анги нам гүм болохоос бүү ай. Асуултад хариулж, бодлоо илэрхийлэхийн тулд хүмүүст ихэвчлэн бодох хугацаа хэрэгтэй байдаг. Та асуулт асууж мөн сүнсэлг туршлага хуваалцсаны дараа эсвэл уг хүнд өөрийгөө илэрхийлэх нь хэцүү байгаа үед түр хүлээх хэрэгтэй (*Teaching, No Greater Call* [1999], 67).

Доорх үйл ажиллагаа бүр нь хэрхэн Есүс Христийг судруудаас олохыг сурахад нь өсвөр үеийнхэнд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

- Ангиараа ерөнхийлөгч Боид К.Пакэрын “Бидний найдварын учир шалтгаан” хэлсэн үгний эхний таван догол мөрийг унш. Судруудын Удирдамжаас “Есүс Христ” гэж эхэлсэн тодоор бичсэн сэдвийн гарчгуудыг хайж олоход ангийн гишүүдийг урь. Өөрсдөдөө сонирхолтой байгаа гарчгуудын дор жагсаасан цөөн хэдэн судрыг уншиж, Аврагч болон Түүний Цагаатгалын талаарх үүргүүдийн талаар мэдэж авсан зүйлүүдээ хуваалцахад тэднийг урь. Энэ үйл ажиллагааны нэг хэсэг болгон тэд бас ерөнхийлөгч Пакэрын хэлсэн үгэндээ дурдсан Есүс Христийн талаарх судруудыг судалж болно.

- Бүх өсвөр үеийнхнийг Есүс Христ болон Түүний Цагаатгалын тухай дуртай нэг судраа хуваалцахад урь. Ангийн гишүүдээр судрын эшлэлүүдийг самбар дээр бичүүлж, хамтад нь уншуул. Судрын эдгээр хэсэг яагаад тэдэнд чухал болохыг өсвөр үеийнхнээс асуу. Эдгээр эшлэлээр хэлхээ судар бий болгоход тэдэнд тусал (*Teaching, No Greater Call* [1999], 58-ыг үзнэ үү).

- Аврагч болон Түүний Цагаатгалын тухай судрууд дахь ямар нэг үйл явдал эсвэл түүхийг хамтдаа судал. Боломжтой бол энэ түүхтэй

холбоотой зургуудыг үзүүлээрэй (*Сайн мэдээний уран зургийн ном*-ыг үзнэ үү). Уг түүх эсвэл үйл явдал Аврагчийн үүрэг зорилгыг хэрхэн бэлгэдлээр харуулж байгааг олж мэдэхэд өсвөр үеийнхнийг урь. Есүс Христийн Цагаатгалын тухай бэлгэдлээр зааж байгаа судрын бусад түүхийг олох боломжийг өсвөр үеийнхэнд олго.

- *Сайн мэдээний уран зургийн ном*-ыг үзэж Цагаатгалын тухай заахад ашиглаж болох судрын түүхийн зургуудыг олоход өсвөр үеийнхнийг урь. Жишээ нь, Ноагийн хөвөгч авдрын түүх нь Цагаатгал нь хэрхэн нүглийн үерээс хамгаалагдахыг бэлгэдэн харуулдаг. Олсон зурагнуудтайгаа холбоотой судруудыг уншиж, (судрын эшлэлүүд номын эхэнд байгаа) Цагаатгалын тухай олж мэдсэн зүйлээ хуваалцахад тэднийг урамшуулан дэмж.

- Өсвөр үеийнхнийг Мосе 6:63-ыг уншиж, Есүс Христийн тухай гэрчилдэг, “тэнгэр дэх” эсвэл “газар дээрх” зүйлсийн жагсаалтыг гаргахад урь. Судруудын Удирдамжийг ашиглан, Есүс Христийг дээрх зүйлсийн заримтай нь харьцуулсан судруудыг олоход тэдэнд тусал (жишээ нь: Хиламан 5:12 -т Түүнийг хадтай зүйрлүүлсэн байгаа).

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Есүс Христ болон Түүний Цагаатгалын тухай хэрхэн судруудаас олж мэдэхийг тэд ойлгосон уу? Тэд ямар сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлагатай байна уу?

Үйлдэхэд урь

- Есүс Христийн тухай судруудаас хамгийн сүүлд олж мэдсэн нэг зүйлээ хуваалц.
- Хичээлийн үеэр төрсөн сэтгэгдлээ хуваалцахад өсвөр үеийнхнийг

урь. Есүс Христийн тухай мэдэхийн тулд хувиараа судар судлахдаа тэд юу хийж болох вэ? Дараагийн хичээлүүдээр сурах зүйлсээ хуваалцахад тэднийг урамшуулан дэмж.

Аврагчийн арга барилаар заах нь

Тэрээр Өөрийн үүрэг зорилгыг зааж, гэрчлэхдээ судруудыг ашигладаг байлаа. Тэр хүмүүст судруудыг өөрсөдтэйгөө харьцуулан бодохыг заадаг байв. Аврагч болон Түүний үүрэг зорилгыг илүү сайн ойлгоход нь өсвөр үеийнхэнд туслахын тулд та хэрхэн судруудыг ашиглаж болох вэ?

Сонгосон материалууд

“Teaching from the Scriptures,” Teaching, No Greater Call, (1999), 55–59

Судруудыг Холбох

Сайн мэдээний ихэнх зарчмууд нь судрын олон шүлэгт багтсан байдаг ба шүлэг бүр өөр өөрийн ойлголтыг өгдөг. Та нар аль нэг зарчмын талаар олон шүлгээс суралцах юм бол уг зарчмын талаар илүү бүрэн дүүрэн ойлголттой болно. Үүнийг хийх нэг арга нь ямар нэг сэдвийн талаар судрын шүлгүүдийн жагсаалт гарган тэр жагсаалтаа судар дээрээ бичих явдал юм. Сэдвээсээ шалтгаалан уг жагсаалт нь урт эсвэл хоёр гурван түлхүүр шүлгүүдээс бүрдсэн богино байж болно. Заримдаа судруудыг холбох гэж нэрлэгддэг энэ арга нь судруудаас суралцах үед мөн тэдгээрээс зааж байх үед маш тустай байдаг. Дараах аргаар судруудын шүлгүүдийг холбож болно:

Судрын шүлгийн хажуу дахь хоосон зайнд жагсаалтан дээрх дараагийн шүлгийн лавлахыг бичнэ. Сүүлийн шүлэг хүртэл ийн үргэлжлүүлнэ. Сүүлийн шүлгийн хажууд эхний шүлгийн лавлахыг бичнэ. Тэгээд жагсаалтын аль ч талаас эхлэн бүх шүлгүүдийг уншиж дуустал уг жагсаалтаа үргэлжлүүлж болно.

Та нар сэдвээ илүү бүрэн дүүрнээр ойлгохын тулд зарим жагсаалтаа тодорхой дараалалтай гаргах хэрэгтэй байж магад. Энэ дарааллын эхлэл хаана байгааг мэдэхийн тулд бусад шүлгүүдийн лавлахын дор дарааллын хамгийн эхний шүлгийг хаалтан дотор бичиж болно. Эсвэл зөвхөн эхний шүлгийн лавлахыг бусад бүх шүлгүүдийн хажууд, мөн дарааллын эхний шүлэг байгаа хуудас дээр бүтэн жагсаалтаа бичиж болно.



Есүс Христийн Цагаатгалын тухай итгэх итгэлээ бэхжүүлэхэд Мормоны Ном надад хэрхэн тусалж чадах вэ?

Мормоны Номын үндсэн зорилго бол Есүс бол Христ гэдгийг бүх хүмүүст итгүүлэх явдал мөн. Энэ ном бид “Түүнд ирэх ёстой, эс бөгөөс [бид] аврагдаж чадахгүй” (1 Нифай 13:40) гэдгийг заадаг. Есүс Христэд итгэх итгэлтэй, Түүний Цагаатгалын адислалуудыг хүлээн авсан итгэлтэй олон шавь нарын жишээ Мормоны Номонд байдаг. Мормоны Номын бошиглогчид “[бид] нүглээс ангижрахын тулд ямар сурвалжийг хайж болохыг мэдэж болохын тулд” (2 Нифай 25:26) хэмээн Аврагчийн тухай хүчтэй гэрчлэлийг хэлсэн билээ.

Мормоны Ном таныг Есүс Христэд хэрхэн ойртуулсан бэ? Мормоны Номон дахь ямар судрууд Аврагчийн тухай гэрчлэлийг тань бэхжүүлсэн бэ?

Мормоны Ном өөрийн чинь заадаг залуучуудын итгэлийг хэрхэн бэхжүүлсэн бэ? Тэд Мормоны Номыг ашигласнаар бие биеийнхээ Есүс Христэд итгэх итгэлийг хэрхэн бэхжүүлж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Та судруудыг ялангуяа Мормоны Номыг залбирч судалснаар Есүс Христэд итгэх итгэлээ бэхжүүлэхэд өсвөр үеийнхэнд хэрхэн тусалж чадна гэж боддог вэ?

Мормоны Номын гарчиг болон удиртгал

2 Нифай 25:26 (Нифайчууд хүүхдүүдийнхээ итгэлийг бэхжүүлэхийн тулд Христийн тухай номлож, бичдэг байлаа)

3 Нифай 27:13–14 (Аврагч Өөрийн бурханлаг үүрэг зорилгыг Нифайчуудад гэрчилсэн юм)

Нийл Л.Андэрсэн, “Мормоны Ном: Есүс Христэд итгэх итгэлээ бэхжүүлэх нь,” *Ensign* эсвэл *Лиахона* 2011 оны 10-р сар, 39–45

Видео бичлэг: “Мормоны Номын Удиртгал”

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхэнд хэдэн минутын туршид, янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судар судлах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа харилцдаг туршлага гэх мэт) өсвөр үеийнхэнд сурч байгаа зүйлсийнхээ хоорондын уялдаа холбоог ойлгоход тусал. Өдөр тутмын амьдрал маань сайн мэдээтэй хамааралтай болохыг олж харахад нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Доорх санаанууд танд тусалж болох юм:

- Есүс Христ болон Түүний Цагаатгалын тухай судалж байгаа зүйлсээ бататгах ямар туршлага тэдэнд байна вэ?
- Мормончууд Христэд итгэгчид мөн үү? хэмээн нэг найз нь асуужээ

гэж тэднээр төсөөлөн бодуул. Мормоны Номын судруудыг (энэ тоймд санал болгосон судруудыг) ашиглаж, энэ асуултанд хариулах даалгаврыг тэдэнд өг.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь Мормоны Ном Есүс Христэд итгэх тэдний итгэлийг хэрхэн бэхжүүлдгийг ойлгоход тэдэнд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

Заахад туслах арга

“Сүнсний өдөөлт ирсэн л бол хичээлийн төгсгөлийг хүлээлгүйгээр хэдийд ч хамаагүй гэрчлэлээ хэлж бай. Гэрчлэлээ хуваалцах боломжийг заадаг хүмүүстээ олго” (*Teaching, No Greater Call* [1999], 45).

- Есүс Христийн Цагаатгалын тухай гэрчлэлээ бэхжүүлэхэд Мормоны Ном надад хэрхэн тусалж чадах вэ? гэж самбар дээр бич. Ангийг жижиг бүлгүүд болгон хувааж, ахлагч Нийл Л.Андэрсэны “Мормоны Ном: Есүс Христэд итгэх бидний итгэлийг бэхжүүлдэг” өгүүллийн нэг хэсгийг уншихыг тэдэнд даалга. Самбар дээрх асуултын хариуг эрж олохыг тэднээс хүс. Даалгавар болгож өгсөн судрын хэсгээс олсон нэг эшлэлийн хамт хариултуудаа ангийнхандаа ярьж өгөхөд бүлэг бүрийг дэмж.
- “Мормоны Номын Удиртгал” видео бичлэгийг үзүүл. Аврагч болон Түүний Цагаатгалын тухай тэдний гэрчлэлд Мормоны Ном хэрхэн нөлөөлснийг харуулсан өөрсдийнхөө богинохон видео бүтээхэд хоёр хоёроороо ажиллахад өсвөр үеийнхнийг урь. Мормоны Ном гэж юу болохыг тэд хэрхэн тайлбарлаж болох вэ? Ямар шүлгүүд болон түүхүүдийг тэд хуваалцаж болох вэ? Энэ видео бичлэгийг бусадтай хуваалцах арга замуудын

тухай бодоход тэднийг урамшуулан дэмж.

- Бишопоос зөвшөөрөл авч Мормоны Номын тухай гэрчлэлтэй болж байгаа туршлагаа хуваалцах нэг шинэ хөрвөгчийг урь. Мормоны Номоос Есүс Христийн Цагаатгалын тухай дуртай судруудаа хуваалцахаар бэлтгэж ирэхийг түүнээс хүс. Мормоны Ном түүнийг Аврагчид хэрхэн ойртуулсан бэ? Аврагчийн үүрэг зорилгыг ойлгоход энэ нь түүнд хэрхэн тусалсан бэ? Есүс Христийн тухай Мормоны Номон дахь дуртай судруудын тухай болон хувийн гэрчлэлээ хуваалцахад ангийн гишүүдийг урь.
- Наманчилж, нүглийнхээ уучлалыг хүлээн авсан Мормоны Номон дахь хүмүүсийн (жишээ нь Бага Алма, Инос, Хаан Лемонай зэрэг) үлгэр жишээг ангиараа тунгаан бод. Мормоны Номон дахь тэдний зарим түүхийг унш. Эдгээр туршлагауд Цагаатгалын тухай бидэнд юу заадаг вэ?

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Мормоны Ном Цагаатгалд итгэх тэдний итгэлийг хэрхэн бэхжүүлдгийг тэд ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэвт илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

- Мормоны Номыг ашиглаж, Есүс Христэд итгэх итгэлээ бэхжүүлэхэд өсвөр үеийнхнийг урь. Есүс Христ болон Түүний Цагаатгалыг гэрчилсэн судруудыг Мормоны Номоос

олж дараагийн хичээлүүд дээр хуваалцах боломжийг тэдэнд олго.

- Мормоны Ном бол Есүс Христийн бас нэгэн гэрээ болох тухай өөрийн гэрчлэлийг хэл.

Аврагчийн арга барилаар заах нь

Есүс тухайн нөхцөл байдал бүрд зааж байгаа хүмүүстээ үлгэр дуурайл үзүүлж, халамжлан хүмүүжүүлэгч нь болдог байлаа. Тэр тэдэнд хэрхэн залбирах, заахыг болон Өөрийн амьдралын хэв маягаар тэднийг хайрлаж, тэдэнд хэрхэн үйлчлэхийг заадаг байлаа. Өөрийн тань үлгэр дуурайл заадаг өсвөр үеийнхэнд чинь хэрхэн сүнслэг нөлөө үзүүлж болох вэ? Мормоны Ном Есүс Христэд итгэх итгэлийг чинь хэрхэн бэхжүүлснийг мэдэхэд өсвөр үеийнхэнд туслахын тулд та хувийн ямар туршлагаа тэдэнтэй хуваалцаж болох вэ?

Сонгосон материалууд

Нийл Л.Андэрсэн “Мормоны Ном: Есүс Христэд итгэх итгэлээ бэхжүүлэх нь” Ensign эсвэл Лиахона 2011 оны 10-р сар, 39–45

Есүс Христийн тухай гэрчлэл

Мормоны Номон дахь Есүс Христийн тухай агуу сургаалуудыг Ариун Сүнсний тусламжтайгаар уншиж тунгаан бодох нь уг сургаалууд үнэн гэдэг гэрчлэлийг бий болгодог. Христийн тухай хүчирхэг сургаалууд: “Бурханы хүлцлийг мэдэх үү та?” (1 Нифай 11:16) хэмээн тэнгэр элч асуусан амьдралын модны тухай Нифайн үзэгдэл; “Ариун Мессиа, түүнд мөн түүгээр гэтэлгэл ирнэ; учир нь тэрээр ач ивээл хийгээд үнэнээр дүүрэн буюу” (2 Нифай 2:6) гэсэн Лихайн гэрчлэл; Тэр бол “их хаалганы сахиул . . . мөн тэрээр нэгээхэн ч зарцыг тэнд үл ажиллуулдаг” (2 Нифай 9:41) гэсэн Иаковын нэмэлт тайлбарыг би Мормоны Номоос шимтэн унших дуртай.

Тэгээд “Түүгээр хүмүүний аврал ирж болох тэр нэгээхэн ч нэр өгөгдөхгүй бас нэгээхэн ч өөр зам мөн нэгээхэн ч арга үгүй бөгөөд зөвхөн Төгс Хүчит Их Эзэн Христийн нэрээр мөн энэ нэр дээр буюу” (Мозая 3:17) хэмээн шавь байх шинж чанарын талаар заасан Хаан Бенжамины гуйвшгүй тунхаглалыг бид дагадаг билээ.

Итгэдэг зүйлсийнхээ төлөө амь насаа өгөхөд хүрсэн Абинадайн тухай бид ийн уншдаг:

“Гэвч амилуулалт буй, тиймийн тул, булшинд ялалт гэж үгүй, мөн үхлийн гашуун нь Христээр залгигдсан юм.

“Тэр бол дэлхийн гэрэл хийгээд амь амьдрал болой; тийм ээ, хэзээ ч харанхуйлагдахгүй төгсгөлгүй тэрхүү гэрэл;” (Мозая 16:8–9).

Цагаатгал, шударга ёс, амьдрал дахь нигүүлслийн тухай Алма дараах нэн чухал сургаалуудыг авчирсан юм: “Нигүүлслийн төлөвлөгөө нь цагаатгал хийгдэхгүйгээр улиран тохиогдох боломжгүй; тиймийн тул Бурхан нь төгс, шударга Бурхан, мөн түүнчлэн нигүүлсэнгүй Бурхан байж болохын тулд нигүүлслийн төлөвлөгөөг гүйцэлдүүлэхээр, шударга ёсны шаардлагыг хангахаар Бурхан өөрөө дэлхийн нүглийн төлөө цагаатгалыг нөхөн төлдөг” (Алма 42:15).

Мөн бид Лихайн хүүхдүүд дээр хүрч ирсэн Аврагчийн гайхамшигтай айлчлалын тухай уншдаг. Бид бас Түүний хайр, өрөвч нинжин сэтгэл, сургаалууд, Түүний өөрийнх нь гэрчлэлийг мэдэрдэг:

“Энэ бол та нарт миний өгсөн тэр сайн мэдээ би Эцэгийнхээ . . . тааллыг гүйцэлдүүлэхээр дэлхийд ирсэн билээ.

“Мөн би загалмай дээр өргөгдөж болохын тулд . . . би бүх хүмүүнийг өөртөө татаж болохын тулд, би хүмүүнээр өргөгдсөний адилаар хүмүүн миний өмнө зогсож, өөрсдийн үйлүүдээр тэд сайн эсвэл хилэнцэт байх эсэхээрээ шүүгдэхээр Эцэгээр өргөгдөхийн тулд Эцэг минь намайг илгээсэн бөлгөө (3 Нифай 27:13–14).

Эцэст нь Мормон, Моронай хоёрын “Та нар . . . өөрсдийн бүх нүглүүд мөн алдсуудаас наманчилж, мөн Есүс Христэд, тэрбээр Бурханы Хүү гэдэгт итгэх ёстойгоо мэдэгтүн, та нар” (Мормон 7:5) гэсэн сүүлчийн уриалга байдаг. “Тийм ээ, Христэд ирэгтүн, мөн түүгээр төгөлдөржигтүн, мөн бүх бурханлиг бусаас өөрсдөө татгалзагтүн; мөн хэрэв та нар бүх бурханлиг бусаас өөрсдөө татгалзаж, мөн Бурханыг өөрсдийн бүх хүч, оюун, мөн чадлаар хайрлах аваас, тэгвэл түүний ач ивээл та нарт хангалттайгаас түүний ач ивээлээр та нар Христээр төгс байж болно;” (Моронай 10:32).



Аврагчийн ач ивээлд найдах нь намайг илүү сайн багш болоход хэрхэн туслах вэ?

Бид сайн мэдээг заах үедээ заримдаа өөрсдийгөө энэ ажилд тэнцэхгүй гэж санадаг. Гэвч “сул дорой зүйлсийг хүчирхэг болгоход ... миний ач ивээл хангалттай” (Ифер 12:27) гэсэн Их Эзэний амлалтаас бид урам зориг авдаг билээ. Бид сул дорой байдлаа хүлээн зөвшөөрч, өөрсдийгөө даруусган, Есүс Христэд итгэх итгэлээ ашиглавал Тэрбээр Өөрийнх нь сайн мэдээг Түүний таалалд нийцэхээр зааж чадахуйц хүч чадлыг бидэнд өгөх болно.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Иеремиа 1:5–9; Мосе 6:31–34 (Бошиглогчид энэ ажилд өөрийгөө тэнцэхгүй гэж бодож болно, гэвч тэд Их Эзэнээс хүч чадал хүлээн авдаг)

1 Коринт 1:27–31; С ба Г 1:19–23
(Сул дорой бөгөөд энгийн хүмүүс сайн мэдээг тунхагладаг)

Иаков 4:7; Ифер 12:23–29 (Даруу хүмүүсийг хүч чадалтай болгоход Аврагчийн ач ивээл хангалттай)

Алма 17:9–11; 29:9 (Бид бусдыг Христэд авчрахад Их Эзэний мутарт зэмсэг болж чадна)

Дэвид А.Бэднар “Их Эзэний хүчээр,” *Ensign* эсвэл *Луахона*, 2004 оны 11-р сар, 76–78

“Үүнээс агуу дуудлага үгүй,” *Teaching, No Greater Call* (1999), 3–4

Дэвид М.Макконки, “Сайн мэдээнээс суралцах ба заах нь” *Ensign* эсвэл *Луахона*, 2010 оны 11-р сар, 13–15

Та сайн мэдээний талаарх асуултууддаа хэрхэн хариулт авсан бэ? Сурах ямар аргууд танд тусалсан бэ?

Сурах ямар аргуудыг өсвөр үеийнхэн мэддэг вэ? Өсвөр үеийнхнээс хэн нэгэн нь ангийнхандаа зааж болох тийм заах арга байна уу?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхэнд хэдэн минутын туршид, янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судар судлах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа харилцдаг туршилага гэх мэт) өсвөр үеийнхэнд сурч байгаа зүйлсийнхээ хоорондын уялдаа холбоог ойлгоход тусал. Өдөр тутмын амьдрал сайн мэдээтэй халмааралтай болохыг олж харахад нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Доорх санаанууд танд тусалж болох юм:

- Цагаатгалын тухай сурч мэдсэн болон сурсан зүйлийнхээ талаар ямар асуултууд байгааг хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс.
- *Teaching, No Greater Call* (3–4-р хуудас)-аас “Гишүүн бүр багш” нэртэй хэсгийг уншихыг тэднээс хүс. Сайн мэдээг заах үүргийнхээ тухай

бодлоо хуваалцахад өсвөр үеийнхнийг урь. Бусдад сайн мэдээг заах ямар боломжууд тэдэнд байдаг вэ?

Заах үүргээ биелүүлэхэд Их Эзэн бидэнд хэрхэн тусалдаг вэ?

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь илүү сайн багш болохын тулд Аврагчийн ач ивээлд найдахад өсвөр үеийнхэнд дэмжлэг үзүүлж чадна. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

Заахад туслах арга

“Хүн асуулт асуусан буюу санал бодлоо илэрхийлсэн үед түүнийг шоолох буюу шүүмжилж огт болохгүй, харин хайраар хийгээд эелдэг дөлгөөн байдлаар хамгийн сайнаараа хариулахыг хичээ. Хүмүүс өөрсдийнх нь санал зөвлөгөөг үнэлж байгааг мэдэрсэн үедээ туршлага, бодол, гэрчлэлээ илүү чөлөөтэй хуваалцах болно” (Teaching, No Greater Call [1999], 64).

- Хэцүү буюу дааж давшгүй мэт санагдсан ажил үүрэг хүлээн авсан тухай туршлагаа хуваалцахыг тэднээс хүс. Ирээдүйд тэдний хүлээж авах ямар үүрэг даалгавар дааж давшгүй мэт санагдаж болох вэ? Ахлагч Дэвид А.Беднарын хэлсэн Их Эзэний хүч чадлаар үгийн эхний 11 догол мөрийг ангиараа уншиж, хүнд даалгавар хүлээн авсан үед тэднийг хүчирхэгжүүлэх буюу урам өгч чадах ямар нэг зүйлийг сонссон буюу уншсан үед гараа өргөхийг тэднээс хүс. Сурч мэдсэн зүйлээ хуваалцахад тэднийг урь. Тэд сайн мэдээг бусдад заахдаа сурч мэдсэн зүйлээ хэрхэн ашиглаж чаддаг вэ? Хэцүү юм шиг санагдаж байсан даалгаврыг биелүүлэхэд Их Эзэнээс хүч чадал хүлээн авсан хувийн туршлагаа хуваалцаж болно.

- Хичээл эхлэхээс өмнө хөгжим тоглодог нэг хүнээс хөгжмийн зэмсгээ ангид авчрахыг хүс (эсвэл хөгжмийн ямар нэг зэмсгийн зургийг үзүүл). Хөгжмийн зэмсэг ном ёсоороо ажиллаж байхын тулд хөгжимчин юуг анхаарах ёстой тухай ярилцахыг суралцагчдаас хүс. Алма 17:9–11-ийг уншиж, хөгжим тоглож байгаа хүн Өөрийн сайн мэдээг заахад биднийг зэмсэг болгон ашиглаж байгаа Их Эзэнтэй хэрхэн адилхан

болохыг дүрслэхэд ангийн гишүүдийг урь. Мозаягийн хөвгүүд Их Эзэний мутарт үр өгөөжтэй зэмсэг байхын төлөө өөрсдийгөө бэлтгэхийн тулд юу хийсэн бэ? Өсвөр үеийнхэн заахдаа тэдний үлгэр жишээг хэрхэн дагаж болох вэ?

- Дэвид М.Макконкигийн “Сайн мэдээнээс суралцах ба заах нь” хэлсэн үгийг уншихыг тэднээс хүс. Сайн мэдээг заахад чухал, бас чухал биш гэж Макконки ахын хэлсэн зүйлсийн жагсаалтыг самбарт жагсаан бичихэд тэднийг дэмж. Макконки ахын ашигласан түүхүүд самбар дээр жагсаасан санаануудыг хэрхэн дүрсэлж байгаа тухай хуваалцахад тэднийг дэмж. Бусдад заахдаа Их Эзэнээс ирдэг хүч чадал дээр тулгуурлахын тулд энэ хэлсэн үгнээс сурч мэдсэн зүйлээ ашиглах арга замуудыг төлөвлөхөд өсвөр үеийнхнийг урь.

- Хичээл заах буюу үг хэлэх даалгаврыг бишопоос хүлээн авсан нэг найз чинь энэ үүргийг биелүүлэхэд өөрийгөө тэнцэхгүй гэж үзэн даалгаврыг хүлээн авах хүсэлгүй байгаагаа хэлжээ гэж төсөөлөн бодохыг өсвөр үеийнхнээс хүс. Тэд энэ найзаа хэрхэн дэмжиж болох вэ? Тэд түүнд туслахын тулд ямар судруудыг ашиглаж болох вэ? (Жишээ

нь, энэ тоймд зөвлөмж болгосон судруудыг үз.) Ийм нөхцөлд байгаа хэн нэгэнд туслахын тулд эдгээр судрыг ашиглан жүжигчилсэн тоглолт хийхэд тэднийг урь.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Илүү сайн багш болоход Аврагчийн ач ивээл хэрхэн тусалдгийг тэд ойлгосон уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэвт илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

- Өнөөдөр сурсан зүйл нь тэднийг юу хийхэд өдөөж байгааг өсвөр үеийнхнээс асуу. Тэрхүү өдөөлтийнхөө дагуу үйлдэхэд тэднийг урамшуулан дэмж. Суралцагчид

үүний дагуу үйлдэж байгаа эсэхэд хяналт тавих аргуудыг бодож ол.

- Заах үүрэгт чинь Их Эзэний өгч байгаа хүч чадал, тусламж дэмжлэгийг гэрчил.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч ганцаараа залбирахад зориулж цаг гаргах, мацаг барих болон Эцгээсээ удирдамж авах замаар Өөрийгөө заахад бэлтгэдэг байлаа. Та өсвөр үеийнхэнд заахаар бэлтгэхдээ Түүний үлгэр жишээг хэрхэн дагаж болох вэ?

Сонгосон материалууд

Дэвид А.Бэднар, “Их Эзэний хүчээр,” Ensign эсвэл Лиахона 2004 оны 11-р сар, 76–78

Ах эгч нар аа, зүрх сэтгэл маань дүүрч, толгой маань эргэн мөн өвдөг минь чичирч байна, мөн би та нартай хуваалцмаар байгаа өөрийн бодол сэтгэлээ илэрхийлж хэлэх хангалттай үгийг олж чадахгүй байна. Энэ Ариун өдөр та нарт хандан товчхон ярих үед Ариун Сүнс та бидэнтэй хамт байгаасай гэж би залбирч байна.

Ерөнхийлөгч Хинкли надад энэ үйлчлэх дуудлагыг өгснөөс хойшхи цагуудын туршид би Нифайгийн “бүх судрыг өөрсөдтэйгээ адилтга” гэсэн зэмлэлийг (1 Нифай 19:23) урьд урьдахаас илүү зорилготойгоор, шийдэмгийгээр сонсон дагасан юм. . . .

Мормоны Номонд өгүүлэгдэх Иаковын зааврын талаар би тунгаан бодсон:

“Иймийн тул, бид бошиглогчдыг судалж байв, мөн бидэнд олон илчлэлт болон бошиглолын суу билиг байв; мөн бид эдгээр олон нотолгоотой болсон учир найдлага олж, мөн итгэл маань гуйвшгүй болно, үүний хэрээр бид Есүсийн нэрээр зарлиглаж чадаад мөн модод, бас уулс, бас далайн давалгаа бидэнд дуулгавартай байв.


“Тэсэн хэдий ч, энэ нь түүний ач ивээл мөн хүмүүний үрсэд хандах түүний агуу их хүлцлээр бид эдгээр зүйлийг хийх хүчтэй гэдгийг бид мэдэж болохын тулд Их Эзэн Бурхан өөрсдийн маань сул доройг бидэнд үзүүлдэг болой (Иаков 4:6–7).

Ах эгч нар аа, миний сая уншсан шүлгэнд гарч байгаа ач ивээл гэдэг үгэнд онцгой анхаарал хандуулна уу. Библийн толь бичиг дээр бид *ач ивээл гэдэг үг нь* хүчирхэгжүүлэх буюу чадалтай болгох хүч гэсэн утгаар судруудад олонтоо хэрэглэгддэг болохыг мэдэж авдаг.

“Энэ үг нь туслах буюу хүч чадал өгөх бурханлиг арга хэрэгсэл гэсэн үндсэн утгатай бөгөөд энэхүү хүч чадал Есүс Христийн нигүүлсэл хийгээд хайраар өгөгддөг.

“ . . . Үүн лүгээ адил Их Эзэний ач ивээлээр хувь хүмүүс Есүс Христийн цагаатгал болон нүглийнхээ наманчлалд итгэх итгэлээр дамжуулан сайн үйлс бүтээхдээ хүч чадал, дэмжлэг тусламж авдаг. Эс бөгөөс тэд зөвхөн өөрийн хүч чармайлтаар энэхүү хүч чадал, дэмжлэг тусалцааг авах боломжгүй юм. Энэхүү ач ивээл бол хүч чадал өгөгч хүч бөгөөд эрэгтэй, эмэгтэйчүүд чадах бүхнээ хийсний эцэст мөнх амьтай болж өргөмжлөлд хүрэх боломжийг тэдэнд олгодог билээ” (х. 697)

Цагаатгалын боломж олгогч, хүч чадал өгөгч тал нь бид өөрсдийн мөнх бус чадвараа танин мэдэж, хэрэгжүүлж чадахгүй зүйлээ харж хийснээр төгөлдөржихөд маань тусалдаг. Би Аврагчийн Цагаатгалын чадвар олгох хүч чадал нь бодит хэмээн гэрчилж байна. Цагаатгалын хүч оруулах чадал байгаагүй бол өнөөдөр өглөө би та нарын өмнө зогсож чадахгүй байх байсан.



Би Цагаатгалын тухай бусдад заахдаа зүйрлэлүүдийг хэрхэн ашиглаж болох вэ?

Цагаатгалынх шиг биет бус, сүнслэг үзэл баримтлалыг ойлгоход нь бусдад туслахын тулд үүнийг ямар нэг бодитой, хүмүүст танил болсон зүйлтэй харьцуулах нь зүйтэй. Их Эзэн болон Түүний бошиглогчид зааж байгаа хүмүүстээ сүнслэг зарчмуудыг ойлгуулахын тулд хүмүүст танил зүйлс эсвэл туршлагаудыг олонтоо хэрэглэсэн байдаг. Бид эдгээр зүйрлэлийг судалснаар Цагаатгалыг өөрсдөө сайн ойлгож авах ба үүнийг бусдад илүү үр ашигтай зааж чадна.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Цагаатгалыг илүү сайн ойлгоход ямар зүйрлэлүүд эсвэл үзүүлэнт хичээлүүд тусалсан бэ?

Цагаатгалын тухай бусдад заах ямар боломж өсвөр үеийнхэнд байдаг вэ? Зүйрлэлүүдийг ашиглах нь илүү үр өгөөжтэй заахад нь тэдэнд хэрхэн тус болох вэ?

Исаиа 1:18 (Исаиа наманчлалын тухай заахын тулд цас, ноосыг зүйрлэл болгон ашигласан)

Матай 11:28–30 (Аврагч бидэнд өгдөг Өөрийн тусламжийг буулгатай зүйрлэжээ)

Лук 15:11–32 (Үрлэгэн хүүгийн тухай сургаалт зүйрлэл)

2 Нифай 1:15 (Лихай гэтэлгэлийг Бурханы хайрын мутарт тэврүүлэхтэй зүйрлэжээ)

Жэффри Р.Холланд, “Шударга ёс, хайр, нигүүлсэл

хамтдаа,” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 92–94

Д.Тодд Кристоффэрсон, “Гэтэлгэл,” *Ensign* эсвэл *Liahona*, 2013 оны 5-р сар, 109–112

Даллин Х.Өүкс, “Цагаатгал ба итгэл,” *Ensign*, 2010 оны 4-р сар, 30–34

“Зүйрлэлүүд ба үзүүлэнт хичээлүүд,” *Teaching, No Greater Call* (1999), 163–164

Видео бичлэг: “Зуучлагч” мөн *Мормоны Номын танилцуулга*-ыг үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхэнд хэдэн минутын туршид, янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судар судлах, семинар, Сүмийн бусад хичээл эсвэл найзуудтайгаа харилцдаг туршлага гэх мэт) өсвөр үеийнхэнд сурч байгаа зүйлсийнхээ хоорондын уялдаа холбоог ойлгоход тусал. Өдөр тутмын амьдрал сайн мэдээтэй хамааралтай болохыг олж харахад нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Доорх санаанууд танд тусалж болох юм:

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

- Цагаатгалыг ойлгоход багш, удирдагч, эцэг эхчүүд нь тэдэнд туслахын тулд юу хийснийг өсвөр үеийнхнээс асуу.
- *Teaching, No Greater Call* (163–164-р хуудас)-аас “Зүйрлэлүүд” хэсгийг

ангиараа хамт унш. Багш нар сайн мэдээний үнэнүүдийг заахад яагаад зүйрлэлүүдийг ашигладаг вэ? Сайн мэдээг илүү сайн ойлгоход тэдэнд тусалсан зүйрлэлүүдийн жишээг хуваалцахад өсвөр үеийнхнийг урь.

Хамтдаа суралц

Заахад туслах арга

“Ур чадвартай багш ‘Өнөөдөр би хичээл дээрээ юу хийх билээ?’, ‘Өнөөдөр би юу заах билээ?’ гэж боддоггүй, харин ‘Өнөөдөр хичээл дээр суралцагчид маань юу хийх билээ?’ ‘Би мэдэх ёстой зүйлсээ олж мэдэхэд нь суралцагчдаа хэрхэн туслах билээ?’ гэж өөрөөсөө асуудаг” (Виржини Х.Пеарс, *Teaching, No Greater Call* [1999], 61).

Доорх үйл ажиллагаа бүр нь Цагаатгалын тухай бусдад заахдаа зүйрлэлүүдийг ашиглаж сурахад нь өсвөр үеийнхэнд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- “Зуучлагч” видео бичлэгийг үзүүл. Ерөнхийлөгч Боид К.Пакэрын ашигласан янз бүрийн зүйрлэлүүдийг жагсаахад бие даан ажиллаж (зээлдүүлэгч, өртөн, өр гэх мэт), эдгээр зүйрлэлийн төлөөлж байгаа юмсыг бичихэд өсвөр үеийнхнийг урь. Суралцагчдыг хоёр хоёроор нь хувааж, ерөнхийлөгч Пакэрын зүйрлэлийг ашиглан Цагаатгалын тухай бие биедээ заахыг тэднээс хүс. Энэ зүйрлэл Цагаатгалыг илүү сайн ойлгоход өсвөр үеийнхэнд хэрхэн тусалдаг вэ?
- Цагаатгалын тухай заахад ашиглаж болох судрууд дахь зүйрлэлийн жишээнүүдийг (жишээ нь, энэ тоймд санал болгосон судрууд) бодож, хуваалцахыг тэднээс хүс. Тэд эдгээр зүйрлэлээс Цагаатгалын тухай юу мэдсэн бэ? _____ нь _____тай [той, тэй] адилхан юм гэж самбар дээр бич. Эхний хоосон зайг Цагаатгалтай холбоотой ямар нэг зарчмаар (*наманчлал, уучлал, эсвэл амилалт* гэх мэтээр), харин хоёр дахь хоосон зайг уг зарчмыг бусдад заахад ашиглаж болох тэдний мэдэх ямар нэг зүйлээр бөглөхийг тэднээс хүс. Энэхүү заах аргыг ашиглах

боломжийг өсвөр үеийнхэнд хэд хэдэн удаа олго.

- Ангийг хоёр бүлэг болгон хуваа. Ахлагч Жэффри Р.Холландын ярьсан, ах дүү хоёрын хавцлын хад руу авирсан тухай түүхийг уншиж, хэлэлцэхийг нэг бүлэгт даалга (“Шударга ёс, хайр, нигүүлсэл хамтдаа” хэлсэн үгээс). Нөгөө бүлгээс ахлагч Даллин Х.Өүксийн ярьсан, салхинд далийж ургасан модны тухай жишээг уншиж, хэлэлцэхийг хүс (“Цагаатгал ба итгэл” нийтлэлийг үзнэ үү). Судалсан зүйрлэлээсээ Цагаатгалын тухай ойлгож мэдсэн зүйлээ нөгөө бүлэгтээ заахыг бүлэг бүрээс хүс.
- Ахлагч Кристоффэрсоны “Гэтэлгэл” хэмээх хэлсэн үгнээс Жийн Валжийн, Сара хоёрын талаарх түүхүүдийг давтан уншихад өсвөр үеийнхнийг урь. Тэд эдгээр түүхээс Цагаатгалын талаар юу сурч авсан бэ? Тэд бусдад заахдаа эдгээрийг хэрхэн ашиглах вэ? Тэд Цагаатгалын талаар бусдад заахдаа үүнтэй адил ямар туршлагаудыг өөрсдийн амьдралаас жишээ татаж болох вэ?

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд Цагаатгалын тухай бусдад заахдаа зүйрлэлүүдийг хэрхэн ашиглахыг ойлгосон уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэвт илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

- Заах талаар өнөөдөр юу сурч мэдсэн тухайгаа бодохыг өсвөр үеийнхнээс хүс. Цагаатгалын тухай бусдад заахын тулд тэд юу хийхээр төлөвлөж байна вэ? Боломжтой бол хичээлийн үеэр бие биедээ заах боломжийг тэдэнд олго. Эсвэл бусад

цуглаан дээр болон гэр орондоо заах боломжийг тэдэнд зориулан төлөвлө.

- Өсвөр үеийнхэн Цагаатгалын тухай бусдад зааснаараа амьдралыг нь хэрхэн адисалдаг тухай гэрчлэлээ хэл.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч энгийн түүх, сургаалт зүйрлэл, амьдралын бодит жишээнүүдийг эргэн тойрноосоо олж хуваалцдаг байсан нь сайн мэдээний үнэнүүдийг илрүүлж олоход заадаг хүмүүст нь тусалдаг байжээ. Та Аврагчийн арга барилаар заахад нь өсвөр үеийнхэнд хэрхэн тусалж болох вэ? (Сайн мэдээг Аврагчийн арга барилаар заах нь, 4–5-ыг үзнэ үү.)

Сонгосон материалууд

Даллин Х.Өүкс, “The Atonement and Faith,” Ensign, 2010 оны 4-р сар, 33–34-өөс эш татав

Ноцтой зөрчлөө наманчлах замаар явах үед яагаад зовж шаналах шаардлагатай байдаг вэ? Бид наманчлалын үр дүнг зүгээр нэг нүглээс цэвэршүүлэх явдал гэж бодох хандлагатай байдаг бөгөөд энэ нь асуудалд хандах бүрэн дүүрэн итгэл үнэмшил биш юм. Нүгэл үйлддэг хүн салхинд амархан найгадаг модтой адил. Салхи, хуртай өдөр мод газар шүргэх шахам найгаж, навчис нь нүгэл мэт бохирдож, шавар шавхай болдог. Хэрэв бид зөвхөн навчсыг нь цэвэрлэхэд л анхаарах юм бол модыг найгуулж, навчсыг бохирдуулсан модны сул дорой байдал хэвээр үлдэх болно. Үүнтэй адил зөвхөн нүглээр бохирлогдсондоо харамсаж байгаа хүн дараагийн удаа илүү хүчтэй салхилах үед дахин нүгэл үйлдэх болно. Ахин дахин нүгэл үйлдэх сул дорой байдал нь модыг хүчирхэг болох хүртэл байсаар л байх болно.

Судруудад “харууссан зүрх, гэмшсэн сэтгэл” гэж нэрлүүлэх үр дүнг авчирдаг үйл явцыг хүн дайрч өнгөрөх үед Аврагч түүнийг нүглээс цэвэршүүлэх төдийгүй илүү их зүйлийг хийдэг. Тэрээр түүнд шинэ хүч чадал өгдөг.

Д.Тодд Кристоффэрсон, “Гэтэлгэл,” Ensign эсвэл 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 129–130-аас эш татав

Уран зохиолын нэгэн жишээ бодит биш ч гэсэн сэтгэлийг минь хөдөлгөж, надад үргэлж сүнслэг нөлөө үзүүлсээр байдаг. Энэ бол Виктор Гюогийн *Шоовдорлогдсон хүмүүс* сонгодог романы бишоп Бианвенюгийн үйлдэл юм. Уг түүхийн бараг эхэнд өлбөрч үхэх гэж байгаа эгчийнхээ хүүхдүүдийг хооллох гэж ганц талх хулгайлсныхаа төлөө 19 жил шоронд хоригдсоны эцэст

суллагдан, орон гэргүй болсон Жан Валжанд тэрхүү сайн бишоп Бианвеню хоол хүнс, хоноглох байр олгожээ. Зүрх сэтгэл нь хатуурч, хорслоор дүүрсэн Валжан бишоп Бианвенюгийн сайхан сэтгэлийн хариуд түүний мөнгөн эдлэлүүдийг хулгайлсан байна. Хожим нь Валжаныг цагдаа нар сэжиглэн саатуулахад тэрээр мөнгөн эдлэлүүдийг түүнд бэлэглэсэн гэж худал мэдүүлсэн ажээ. Цагдаа нар түүнийг бишоптой нүүрэлдүүлэхээр авчрахад, бишоп Бианвеню мөнгөн эдлэлүүдийг түүнд бэлэглэсэнээ хүлээн зөвшөөрсөнд Валжан нүд нь орой дээрээ гаран гайхсан гэдэг. Бишоп Бианвеню маш үнэмшилтэйгээр “Бас дээр нь! Би энэ лааны мөнгөн тавиуруудыг танд өгсөн шүү дээ. Бүгд нийлээд хоёр зуун франк болно. Та лааны тавиуруудыг яагаад тавагнуудын хамт авч яваагүй юм бэ?” гэжээ . . .

Бишоп түүн рүү хүрч ирэн, намуухан дуугаар:

Та эдгээр мөнгөн эдлэлийг шударга хүн болохын төлөө ашиглах болно гэж надад амласнаа бүү март, үүнийг хэзээ ч бүү март’ гэжээ.

Ийм амлалт өгснөө санаагүй Жан Валжан яах ч учраа олохгүй гайхан зогсож байлаа. Бишоп . . . дөлгөөхнөөр цааш үргэлжлүүлэн:

“Жан Валжан минь ээ, та одоо нүгэлтэн биш, харин сайн хүн боллоо. Сэтгэл зүрхийг тань би танд худалдан авч өглөө. Би таны зүрх сэтгэлийг харанхуй бодол санаа болон мөхлийн ирмэг дээрээс татан гаргаж ирлээ. Одоо би таныг Бурханд тушаалаа!’ гэжээ”.

Жан Валжан үнэхээр шударга, шинэ хүн болж, олон хүнд тусалсан юм. Тэрээр лааны хоёр мөнгөн тавиурыг Бурханд үйлчлэхийн төлөө сэтгэл зүрхээрээ гэтэлгэгдсэний сануулга болгон насан туршдаа нандигнан хадгалсан ажээ [Victor Hugo, *Les Misérables* (1992), 91–92-ыг үзнэ үү].

Дөрөвдүгээр сар: Урвалт ба сэргээлт

*“Бибээр сайн мэдээний бүрэн байдлаа өөрийн үйлчлэгч Иосефын гараар урагш илгээсэн”
(С ба Г 35:17).*

Урвалт ба сэргээлтийн үйл явдлуудаас сайн мэдээг сурч мөн заахдаа хэрэгжүүлж болох олон чухал зүйлсийг өсвөр үеийнхэн сурах боломжтой. Судалж байгаа зүйлсийнхээ талаар асууж лавлан, илүү ихийг сурахыг эрэлхийлж, сурч мэдсэн зүйлээ бусдад заахад нь өсвөр үеийнхнийг дэмжээрэй.

Энэ сард сонгох тоймууд:

Иосеф Смитийн жишээ нь сайн мэдээнээс суралцах талаар надад юу заадаг вэ?

Үнэн, худал хоёрын ялгааг би хэрхэн таньж мэдэх вэ?

Цэвэр сургаалыг заах нь яагаад чухал вэ?

Урвалт ба сэргээлтийн үйл явдлуудыг би өөрийнхөө амьдралтай хэрхэн адилтгаж болох вэ?

Урвалт ба сэргээлтийн тухай би бусдад хэрхэн тайлбарлах вэ?



Христийн амилсны баяр: Би Есүс Христийн амилалтын талаарх гэрчлэлээ хэрхэн хуваалцаж болох вэ?

Улаан өндөгний баярын ням гарагт бид бусад Христийн шашинтан хүмүүстэй нэгдэн, дэлхийн түүхэн дэх хамгийн чухал үйл явдал болох Христийн амилсны баярыг тэмдэглэдэг. Тэрээр “үхлийн хүлээсийг тасчиж, ингэснээр булш ялалт үгүй болж, мөн үхлийн шаналал нь сүр жавхланд найдах найдвараар уужруулагдсан билээ” (Алма 22:14). Түүний амилалт цагаатгагч золиослолынх нь төгсгөл байсан бөгөөд Амилалтаар дамжуулан Тэрээр бүх хүн төрөлхтний нүгэл хийгээд үхлийг ялсан юм. Бид Аврагчийн амилалтын талаарх гэрчлэлээ хуваалцсанаар бусдыг амар амгалан, итгэл найдвар мэдрэхэд тусалж чадна.

Ямар судар эсвэл хожмын үеийн бошиглогчдын сургаал Есүс Христийн амилалтын талаарх таны гэрчлэлийг хүчирхэгжүүлсэн бэ? Уг гэрчлэл таны амьдралд хэрхэн нөлөөлсөн бэ? Та хэзээ эдгээр судар эсвэл сургаалыг бусдын гэрчлэлийг хүчирхэгжүүлэхэд туслахаар ашигласан бэ?

Та хэзээ өсвөр үеийнхэн Аврагчийн талаар гэрчилж байгааг сонссон бэ? Та тэднийг бусадтай гэрчлэлээ хуваалцахад нь урамшуулан дэмжихийн тулд юу хийж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлд

Доорх материалуудыг залбирч судлаарай. Өсвөр үеийнхнийг Аврагчийн амилалтын талаарх гэрчлэлээ хуваалцахад юу урамшуулан дэмжинэ гэж та бодож байна вэ?

Лук 24; Иохан 20 (Есүс Христ амилсан)

3 Нифай 11:1–17 (Амилсан Аврагч нифайчуудад үзэгдэв)

С ба Г 76:22–24; Иосеф Смит—
Түүх 1:16–17 (Амилсан Аврагчийн
талаарх Иосеф Смитийн гэрчлэл)

Томас С.Монсон, “Тэр амилсан!”
Ensign эсвэл *Liahona*, 2010 оны 5-р
сар, 87–90

Д.Тодд Кристоффэрсон, “Есүс Христийн Амилалт,” *Ensign* эсвэл *Liahona*, 2014 оны 5-р сар

“Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл,” *Ensign*, 2000 оны 4-р сар, 2–3

Видео бичлэг: “Тэр амьд—Есүс Христ амьд учраас Улаан өндөгний баярыг тэмдэглэ”

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутад өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөл байдалд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, Сүмийн бусад хичээл эсвэл найзуудтайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Та нар тэдэнд өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм.

- Өсвөр үеийнхнийг өнгөрсөн долоо хоногийн хичээл дээр сурсан зүйлээ долоо хоногийн турш хэрхэн хэрэгжүүлснийг хуваалцахад урь.
- Өсвөр үеийнхнээс Есүс Христийн талаарх хэн нэгний гэрчлэлийг сонсоод хүчирхэгжсэн туршлагаа хуваалцахыг хүс.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь өсвөр үеийнхэнд Амилалтын талаарх гэрчлэлээ бусадтай хуваалцахад урамшуулан дэмжих болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу.

- Уг тоймд санал болгосон видео бичлэгүүдийг үзэж, өсвөр үеийнхнийг Аврагчийн талаарх сэтгэгдэл, мэдрэмжээ бусадтайгаа хуваалцахад урь. Өсвөр үеийнхнийг эдгээр видео бичлэгээс аль нэгийг нь гэр бүлийн гишүүд, найз нөхөд мөн бусад хүнтэй хуваалцахад урамшуулан дэмж. Дараагийн хичээл дээр эдгээр захиасыг хуваалцсанаар олж авсан туршлагаа мөн хүмүүс хэрхэн хүлээн авсныг хуваалцахад урь.
- Өсвөр үеийнхнийг Есүс Христийн Амилалтын талаарх гэрчлэлээ хүчирхэгжүүлэхэд нь бусдад туслахдаа ашиглах судруудыг (уг тоймд жагсаасан судрууд байж болно) олж, хуваалцахад урь. Өсвөр үеийнхнийг хичээл дээр ашигласан судруудаа дараа ашиглаж болохын тулд бичиж авахыг хүс.
- Өсвөр үеийнхнийг “Амьд Христ”-ийг эсвэл уг тоймд санал болгосон Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсээс аль нэгийг уншиж, Аврагчийн Амилалтын талаар хүчирхэг гэрчлэлийг өгүүлж буй хэсгийг эрж олоход урь. Тэднээс олсон хэсгээ нэг нэгэнтэйгээ хуваалцаж, эдгээр нь яагаад утга учиртай болохыг тайлбарлахыг хүс. Өсвөр үеийнхнийг Амилалтын талаар гэрчилдэг амьд бошиглогч, төлөөлөгчидтэй байх нь яагаад чухал гэж бодож байгаа талаар ярилцахад урь. Амилалтын талаарх өөрийн гэрчлэлийг хуваалцан мөн өсвөр үеийнхнийг хуваалцахад урь.
- Есүс Христийн Амилалт өсвөр үеийнхний амьдралд өөрчлөлт авчирсан гурав эсвэл түүнээс олон арга замыг бичих цаг өг. Тэднийг бичсэн зүйлээ хуваалцахад урь.

Заахад туслах арга

“Жижиг бүлгүүдээр ярилцах нь сонирхол нь буурч, анхаарал нь сарниж байгаа хүмүүсийг ярилцлагад амархан татан оруулдаг ач холбогдолтой” (*Teaching, No Greater Call* [1999], 72).

Тэдэнд ахлагч Д.Тодд Кристоффэрсоны “Есүс Христийн Амилалт” хэлсэн үгийг өгч, өөрсдийн жагсаалтад нэмж болох өөр зүйлсийг эрж олохыг хүс. Тэднийг Аврагчийн

Амилалтын талаар мэдэх хэрэгтэй хэн нэгний талаар бодоход урьж, тэднийг тухайн хүнд хэрхэн гэрчлэлээ хуваалцах талаар бодоход урамшуулан дэмж.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд Амилалтын талаарх гэрчлэлээ бусадтай хуваалцах сүнслэг өдөөлтийг мэдэрч байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхнээс өнөөдрийн сурсан зүйлээс юу хийх мэдрэмж төрж байгаа талаар асуу. Тэрхүү мэдрэмжийнхээ дагуу үйлдэхэд тэднийг урамшуулан дэмж. Тэднийг үүний дагуу үйлдэж байгаа эсэхэд хяналт тавих аргуудыг бодож ол.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн зорилгын талаар зааж мөн гэрчлэхдээ судруудыг ашигладаг байсан. Тэр хүмүүст судруудын тухай бодож, асуултандаа хариулт олоход тэдгээрийг ашиглах талаар заадаг байсан. Та өсвөр үеийнхэнд сударт байдаг хүчирхэг гэрчлэлүүдийг олоход нь хэрхэн туслах вэ?



Иосеф Смитийн жишээ сайн мэдээнээс суралцах талаар надад юу заадаг вэ?

Иосеф Смит сайн мэдээг сэргээх Их Эзэний зэмсэг болон үйлчлэхдээ сүнслэг мэдлэгийг эрэлхийлдэг байв. Тэрээр судруудын талаар тунгаан бодож, сүнслэг нөлөө бүхий асуултууд тавьж, сурч мэдсэн зүйлийнхээ дагуу үйлддэг байсан. Бид бошиглогчийн жишээг дагаснаар асуултууддаа хариулт авч мөн бидний амьдралыг удирдах сүнслэг удирдамжийг хүлээн авах болно.

Сайн мэдээнээс суралцахдаа, туулсан туршлагынхаа талаар бодоорой. Иосеф Смитийн үлгэр жишээ сайн мэдээнээс суралцагчийн хувьд таныг хэрхэн урамшуулдаг вэ?

Ангийн тань өсвөр үеийнхэн суралцахад ямар хандлагатай байдаг вэ? Иосеф Смитийн жишээ тэдэнд сайн мэдээнээс суралцахад хэрхэн түлхэц үзүүлж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Иосеф Смитийн амьдралаас суралц. Түүний үлгэр жишээ танд сайн мэдээнээс суралцах талаар юу зааж байна вэ? Та өсвөр үеийнхэнтэй юуг хуваалцаж болох вэ?

С ба Г 76:15–21 (Иосеф Смит судруудын тухай тунгаан бодсон)

Иосеф Смит—Түүх (Иосеф Смит судруудыг өөртэйгөө адилтган, сүнслэг нөлөө бүхий асуултууд тавьж, сурсан зүйлийнхээ дагуу үйлдсэн)

Иайро Маззагарди, “Сэргээлтийн ариун газар,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 39–41

Крэг К.Кристэнсэн, “Би өөрөө эдгээр зүйлийг олж мэднэ,” *Ensign* эсвэл *Liahona*, 2014 оны 11-р сар, 50–52

“Мөнхийн үнэнүүдийн тухай мэдлэгтэй болох нь,” *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 295–306

“Иосеф Смитийн анхны залбирал,” *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу*, 14

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн минутад өсвөр үеийнхний янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, Сүмийн бусад хичээл эсвэл найзуудтайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний хамаарлыг олж харахад нь өсвөр үеийнхэнд та нар хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм. Үүнд:

- Өөрсдийн судалж буй сургаалын тухай асуухад тэднийг урь.
- Өсвөр үеийнхэн бүрийг Иосеф Смитийн амьдралын тухай өөрийн

мэддэг нэг зүйлийг самбарт энгийнээр зурахад урь (эсвэл түүний амьдралын үйл явдлуудын тухай зургуудыг тавьж ярилц; *Сайн мэдээний уран зургийн цуглуулга*, 89–97-г үзнэ үү). Самбар дээр “Иосеф

Смитийн жишээ надад сайн мэдээнээс суралцах талаар юу заадаг вэ?” гэж бич. Өсвөр үеийнхнийг энэ асуултад хариулахыг хүс. Хичээлийн турш энэ асуултын талаар бодохыг тэднээс хүс.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь Иосеф Смитийн сайн мэдээний суралцагч байсан жишээнээс суралцахад өсвөр үеийнхэнд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго.

- Энэ долоо хоногийн туршид өсвөр үеийнхнээс хэн нэгийг Иосеф Смит—Түүх 1:5–17-г уншиж давтаад, Иосеф Смитийн асуултандаа хариулт авахын тулд хийж байсан зүйлийн талаар хуваалцахад бэлдэж ирэхэд урь. Ангиараа ахлагч Иайро Маззагардигийн хэлсэн “Сэргээлтийн ариун газар” хэмээх үгийг уншаад, түүний асуултынхаа хариултыг олохоор хэрхэн явж байгааг олж мэдэхийг хүс. Ахлагч Маззагардигийн туршлага Иосеф Смитийнхтэй хэр төстэй байна вэ? Сайн мэдээний талаар ямар ямар хэцүү асуулт өсвөр үеийнхэнд байдаг вэ? Өсвөр үеийнхэн асуух зүйл гарсан үедээ ахлагч Маззагардигийн “бошиглогч Иосеф Смитийн үлгэр жишээг дага” хэмээх уриалгыг хэрхэн хүлээн авч болох вэ?

- Ахлагч Крэг К.Кристэнсэний “Би өөрөө эдгээр зүйлийг олж мэднэ” хэлсэн үгэн дэх “Бурханаас гуйг” гарчигтай хэсгийг уншихад ангийн гишүүдийг урь. Ахлагч Кристэнсэний “Та нар Иосефийн туршлагаас өөрийн гэрчлэлийг олж, нэмэгдүүлэхэд хэрэглэж болох хэв загварыг харж байна уу?” гэсэн

асуултад хариулж болох хариултуудыг самбар дээр жагсаахад тэднийг урь. Иосеф Смит—Түүх 1:5–17-гоос энэ асуултын хариултуудыг хайхад тэднийг урамшуулан дэмж.

- Сайн мэдээнээс суралцахад бидэнд тусалдаг зарчмуудыг жагсаахад өсвөр үеийнхэнд тусал (даруу байх, тунгаах, судруудтай адилтгах, сүнсээр өдөөгдсөн асуулт тавих гэх мэт). Өсвөр үеийнхэн бүрд дараах шүлгүүдээс нэгийг оноо. Үүнд: Иосеф Смит—Түүх: 10-20, 21-26, 28-33, 34-47, 48-54, 68-75-р шүлгүүд. Эдгээр шүлгээс нэмэлт суралцах зарчмуудыг болон Иосеф Смит эдгээр зарчмыг хэрэгжүүлж байгаа жишээнүүдийг хайхыг өсвөр үеийнхнээс хүс. Өсвөр үеийнхэн сайн мэдээнээс суралцахаар чармайхдаа эдгээр зарчмыг хэрхэн хэрэгжүүлж болох вэ?

- “Иосеф Смитийн анхны залбирал” дууны үгийг хамтдаа уншаад (*Hymns*, дугаар 26), Иосеф Смитийн үнэнийг эрэлхийлэхдээ гаргаж байсан хандлагыг дүрсэлсэн үгсийг хайж ол. Тэдний сайн ойлгохгүй байгаа үгсийг тайлбарлаж өг. Өсвөр үеийнхэн үнэнийг эрэлхийлэхдээ Иосеф Смитийн жишээг хэрхэн

Сайн мэдээг судлах чадварууд

Зарчмуудыг хайх. Зарчим нь бидний үйл хөдлөлийг удирддаг үнэн юм. Зарим үед зарчмууд нь судруудад эсвэл бошиглогчийн үгсэд тодорхой илэрхийлэгддэг бол заримдаа эдгээр нь түүх, жишээгээр илэрхийлэгддэг. Энэ хэсгийн эхний үйл ажиллагаан дээр суралцах зарчмуудыг жагсаахыг өсвөр үеийнхнээс хүссэн байгаа. Тэднийг судраас хайх явцад дараах асуултууд тусалж болох юм. Үүнд: “Би судрын энэ хэсгээс ямар зарчим сурч байна вэ? Энэ нь миний бодож байснаас мөн өмнө сурснаас ялгаатай байна уу? Тэдгээр нь надад амьдралынхаа ямар нэг зүйлийг өөрчлөхөд сүнс-лэгээр нөлөөлж байна уу?” Хувиараа болон гэр бүлээрээ судруудаас суралцах үедээ зарчмуудыг хайж эрэлхийлэхэд тэднийг урамшуулан дэмж.

Аврагчийн арга барилаар заах нь

Тэрээр заахад бэлтгэхдээ ганцаараа залбирч, мацаг барьдаг байв. Тэр Тэнгэрлэг Эцэгийнхээ удирдамжийг эрэлхийлдэг байсан. Та Аврагчийн заах жишээг дагахын тулд юу хийж болох вэ?

дагаж болох вэ? Энэ үйл ажиллагааны нэгэн хэсэг болгон “Origin” видео бичлэг үзүүлэхийг бод.

- Ангийн суралцагчдыг хэдэн бүлэгт хувааж, бүлэг бүрд *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф*

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Иосеф Смитийн үлгэр жишээ сайн мэдээнээс суралцах талаар юу зааж байгааг тэд ойлгож байна уу? Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Иосеф Смитийн жишээнээс үндэслэн сайн мэдээнээс илүү сайн сурахад түлхэц үзүүлэх нэг зүйлийг бичихэд өсвөр үеийнхнийг урь. Бичсэн зүйлсээ бие биетэйгээ хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс.

Сонгосон материалууд

“Мөнхийн үнэнүүдийн тухай мэдлэгтэй болох нь” хэсгээс эш татав. Сүмийн Ерөнхийлөгчдийн Сургаалаас: Иосеф Смит (2007), 261–270

“Хүмүүс [үнэний] эсрэг ярьснаараа намайг биш, харин өөрсдийгөө хохироодог. . . . Аугаа чухал зүйлсийг ухаан муутай хүмүүс ядахдаа ганц удаа боловч бодож үзэлгүйгээр хайхрахгүй орхидог бол би үнэнийг, түүний үр дагаврыг бүх харилцан хамааралд нь авч үзэн, цээжиндээ чанга тэврэхийг хүсдэг. Бурханы илчилсэн бүхэнд би итгэдэг. Хүн хэт их итгэснийхээ улмаас зүхэгдэж байсныг би огт сонсож байгаагүй. Харин хүмүүс итгэлгүйгээсээ болж зүхэгддэг билээ.” [History of the Church, 6:477, 1844 оны 6-р сарын 16-д Иллинойн Наувуд Иосеф Смитийн уншсан лекцнээс Томас Буллок эш татжээ.]

“Бурхан хүмүүнд адислал буюу мэдлэгийг санал болгоход тэрээр үүнийг хүлээн авахаас татгалзвал тэрээр адислалаа алдах болно. Израилчууд өөрсдөд нь биш, харин Мосед хандан ярихын төлөө Бурханд залбирсан юм. Үүний улмаас Тэрээр тэднийг зуурдын зарлигуудын хуулиар зүхсэн билээ.” [History of the Church, 5:555; 1843 оны 8-р сарын 27-нд Иллинойн Наувуд Иосеф Смитийн уншсан лекцнээс Виллард Ричардс, Виллям Клэйтон нар эш татжээ.]

“Алдаа замхарлыг үнэн ялдгийг, гэрлийн өмнө харанхуй сөхрөн унадгийг хараад бибээр үргэлж сэтгэл хангалуун байдаг.” . . . [Letter from Joseph Smith to Oliver Cowdery, Sept. 24, 1834, Kirtland, Ohio, published in. Evening and Morning Star, Sept. 1834, p. 192.]

“Мэдлэг нь харанхуй бүдүүлэг, тодорхой бус байдал болон эргэлзээг үгүй хийдэг. Учир нь мэдлэг байгаа газар эдгээр зүйлс оршин тогтнож чадахгүй. . . . Мэдлэгт хүч байдаг. Бурхан агуу мэдлэгтэй бөгөөд хэрхэн бүх амьд оршихуйг захирахаа

мэддэг учраас бүх хүн төрөлхтөнөөс илүү хүчтэй юм. Түүнд бүхнийг захирах хүч чадал бий.” [History of the Church, 5:340; capitalization modernized; paragraph divisions altered; 1843 оны 8-р сарын 8-д Иллинойн Наувуд Иосеф Смитийн уншсан лекцнээс Виллард Ричардс, Виллям Клэйтон нар эш татжээ.]

“Бид Бурханаас холдох тусам чөтгөртэй улам ойртож, мэдлэгээ алддаг ба мэдлэггүйгээр бид аврагдаж чадахгүй. Бидний зүрх сэтгэл хорон муу санаагаар дүүрч, хилэнцийг үйлдэхэд суралцвал сайн сайхан зүйлийн төлөө эсвэл сайныг үйлдэх зай бидний зүрх сэтгэлд байхгүй болно. Бурхан сайн биш гэж үү? Тэгвэл та нар ч мөн сайн бай. Хэрэв тэр итгэлтэй бол, та нар ч мөн итгэлтэй бай. Итгэл дээрээ ариун журмыг, ариун журам дээрээ мэдлэгийг нэмж, сайн сайхан бүхнийг эрэлхийлэгтүн [2 Петр 1:5 - г үзнэ үү]” . . . [History of the Church, 4:588; 1842 оны 4-р сарын 10-д Иллинойн Наувуд Иосеф Смитийн уншсан лекцнээс Вилфорд Вүдрафф эш татжээ.]

Жорж А.Смит Тэргүүн Зөвлөлд үйлчилж байхдаа “Эрэгтэй, эмэгтэй хүн бүрийг мэдлэгийн оргилуур болох Их Эзэнээс мэдлэг олж авч болохын тулд Их Эзэний мэргэн ухааныг эрэлхийлэх хэрэгтэй гэж Иосеф Смит заасан билээ; мөн илчлэгдсэн сайн мэдээний амлалтууд нь явах ёстой энэ замаа үргэлжлүүлснээр бидэнд итгэлийг бий болгодог” хэмээн мэдэгджээ. . . [George A. Smith, Deseret News: Semi-Weekly, Nov. 29, 1870, p. 2.]

“Бидний өмнө санал болгосон бүхий л мэдлэгийг нэг дор олж авах нь мэргэн ухаан биш харин бид бага багаар олж авах хэрэгтэй; Дараа нь бид үүнийгээ ойлгох болно.” [History of the Church, 5:387; 1843 оны 5-р сарын 14-д Иллинойн . . . Иосеф Смитийн уншсан лекцнээс Вилфорд Вүдрафф эш татжээ.]

Сонгосон материалууд

“Бид шатан дээр гарахын тулд доороос нь эхлэх хэрэгтэй бөгөөд авирч гарах хүртлээ шат шатаар өгсдөг. Энэ нь яг сайн мэдээний зарчмуудтай адилба бид анхнаас нь эхлээд өргөмжлөлийн бүх зарчмуудад суралцах хүртлээ үргэлжлүүлэх хэрэгтэй. Гэхдээ та нарт хөшгийг нэвтрэн гарч, тэдгээрийг сурах хүртэл нэлээд хугацаа шаардагдана. Бид энэ дэлхий дээр бүх зүйлийг ойлгож чадахгүй; бид нас барсныхаа дараа ч өөрсдийн аврал ба өргөмжлөлөөсөө суралцах нь агуу ажил байх болно.” . . . [History of the Church, 6:306–7; 1844 оны 4-р сарын 7-нд Иллинойн Наувуд Иосеф Смитийн уншсан лекцнээс Вилфорд Вүдрафф, Виллард Ричардс, Томас Буллоок, Виллям Клэйтон нар эш татжээ.]

“Бурхан Арванхоёрт мэдүүлэх тэдгээр зүйлүүдээ Иосефт илчлээгүй бөгөөд ямар ч гэгээнтэн өөрийнхөө ойлгож чадах зүйлүүдийг аль болох хурдан мэдэх хэрэгтэй. Учир нь удахгүй бид хөршдөө Их Эзэнийг мэдэгтүн гэж хэлэх шаардлагагүй өдөр ирэх болно. Учир нь тэдний багаас том хүртэл нь тэд бүгд Намайг мэдэх болно гэж Эзэн тунхаглах өдөр гарцаагүй ирэх болно. [Иеремиа 31:34 -г үзнэ үү].” [History of the Church, 3:380; 1839 оны 6-р сарын 27-д Иллинойн Коммерст Иосеф Смитийн уншсан лекцнээс Виллард Ричардс эш татжээ.]



Би хэрхэн үнэн, худал хоёрын ялгааг таньж мэдэх вэ?

Их урвалтын үеэр сайн мэдээний олон үнэн өөрчлөгдөж эсвэл алдагдсан билээ. Эдгээр үнэн нь бидний үед бошиглогч Иосеф Смитээр дамжуулан сэргээгдсэн юм. Бурханы үгийг судалж, Ариун Сүнснийг сонссоноор бид сэргээгдсэн сайн мэдээний үнэнүүдийг дэлхийн заадаг худал хуурмагаас ялгаж чадна.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Үнэн ба худал хуурмаг хоёрын ялгааг хэрхэн таньж мэддэг болохыг ойлгохын тулд доорх материалуудыг ашигла. Энэ зарчмын дагуу амьдрах таны туршлага үүнийг үр дүнтэйгээр заахад танд тусална. Тэгээд энэ хичээлийн бусад үйл ажиллагаа нь өсвөр үеийнхнийг хичээлдээ идэвхитэй байлгах төлөвлөгөө гаргахад тань танд хэрхэн туслах талаар бод.

Та үнэн ба худал хоёрын ялгааг хэрхэн таньж мэддэг вэ? Үнэнийг худал хуурмагаас ялгах боломжтой байснаараа та амьдралдаа ямар адислалуудыг хүлээн авсан бэ?

Өсвөр үеийнхэнд тохиолддог ямар худал хуурмаг зүйлүүд байдаг вэ? Өөрсдийн хүлээж авсан мэдээллийн үнэн эсэхийг тодорхойлоход та тэднийг хэрхэн урамшуулан дэмжиж болох вэ? Үүнийг хэрхэн хийхийг мэдэх нь тэдэнд яагаад чухал вэ?

Иохан 8:31–32; Иосеф Смит—
Матай 1:37 (Бурханы үгийг судлах нь бидэнд үнэнийг ялгаж танихад тусалдаг)

Исаиа 5:20; Мосе 4:3–4 (Сатан хуурахыг оролддог)

Моронай 7:12–19 (Биднийг сайн зүйл хийж мөн Христэд итгэхийг ухуулдаг зүйлс нь Бурханаас ирдэг)

Моронай 10:5; С ба Г 46:7–8 (Ариун Сүнс үнэнийг гэрчилдэг)

Иосеф Смитийн Түүх 1:8–20 (Иосеф Смит үнэнийг мэдэхийн тулд залбирдаг)

Бойд К.Пакэр, “Миний мэддэг зүйлс,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2013 оны 5-р сар, 6–8

Нийл Л.Андэрсэн, “Иосеф Смит,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 11-р сар, 28–31

Маркос А.Айдукайтис, “Харин та мэргэн ухаанаар дутвал,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 5-р сар

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээл эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Та тэдэнд өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

- Тэд бусад хичээл, ангид Урвалт ба Сэргээлтийн тухай заалгасны дараа байгаа асуултуудынх нь талаар ярилц. Та хэрхэн тэдэнд хариултаа олоход тусалж чадах вэ?

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр өсвөр үеийнхэнд үнэн ба худал хоёрын хоорондох ялгааг хэрхэн олж мэдэхийг сурахад нь туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

Сайн мэдээг судлах чадварууд

Үнэн мөн хуурамч сургаалыг ялган таних нь Заримдаа бид шинэ мэдээллийг олж авсан үедээ, дараахын адил асуултуудад хариулснаар үүний үнэн эсэхийг тодорхойлж чадна: Энэ талаар сударт нэгээс олон удаа заадаг уу? Амьд бошиглогч, төлөөлөгчид үүний талаар заадаг уу? Энэ нь Сүмийн өнөө үеийн дадал болон зөвшөөрөгдсөн бодлоготой нийлж байна уу? Сүнс надад үүний үнэний талаар гэрчилж байна уу?

- Ангийн гишүүн бүрд Ерөнхийлөгч Боид К.Пакэрийн “Миний мэддэг зүйлс” хэлсэн үгийн төгсгөлийн есөн догол мөрийн хуулбарыг өг. Үнэн ба худал хоёрын ялгааг олж харахад тэдэнд туслах түлхүүр үгсийг хайхад өсвөр үеийнхнийг урь. Тэднээс олсон үгсээ самбар дээр бичин, яагаад эдгээр үгийг сонгосноо тайлбарлахыг хүс.

- Ангийн гишүүдийг хоёр бүлэг болгон хуваарилан, тус бүрд нь Ахлагч Нийл Л.Андэрсэний “Иосеф Смит” хэлсэн үгийн хуулбарыг өг. Нэг бүлгийг Сүмийн зарим гишүүнийг итгүүлсэн хуурамч захианы талаар уншихыг урь. Нөгөө бүлгийг, Ахлагч Рассэлл М. Нэлсоны зургийн талаарх түүхийг уншихад урь. Бүлэг бүрээс үнэн худлыг ялгах талаар өөрсдийн уншсан түүхээс сурсан зүйлээ хуваалцахыг хүс.

- Өсвөр үеийнхнээс Иосеф Смитийн Түүх 1:8–20-ийг уншаад үнэнийг худал хуурмагаас ялган танихын тулд Иосеф Смитийн хийсэн алхмуудыг жагсаан бичихийг хүс. Аливаа зүйлийг үнэн эсэхийг нь мэдэхийн тулд өсвөр үеийнхэн

Иосефийн жишээг хэрхэн дагаж болох вэ?

- Өсвөр үеийнхнийг Моронай 7:12-19-ыг уншиж, сайныг нүгэл хилэнцээс ялгахад тэдний ашиглаж болох шалгуурыг олохыг хүс. Өсвөр үеийнхэн бүрийг өөрт нь тулгараад байгаа сонголтуудын жагсаалтыг хийн, шийдвэр бүрийг гаргахдаа эдгээр шалгуурыг ашиглахад урь. Тэд хүсч байвал өөрсдийн жагсаалт дээрээс хуваалцахад тэднийг урь.

- Өсвөр үеийнхнийг сайн мэдээний талаарх гэрчлэлийг нь эргэлзээнд хүргэх ямар нэгэн мэдээллийг олж авсан нөхцөлд орлоо гэж төсөөлөхөд урь. Тийм нөхцөлд үнэн, худал хуурмаг хоёрыг ялгаж мэдэхийн тулд тэд юу хийж чадах вэ? Энэ асуултад хариулахад туслуулахын тулд Ахлагч Маркос А.Айдукайтисын “Харин та мэргэн ухаанаар дутвал” хэлсэн үгэндээ санал болгосон гурван алхмыг эсвэл энэ хичээл дэх судруудыг судлахад тэднийг урь. Тэднийг юу сурснаа хуваалцахыг хүс. Үнэн зөвийг худал хуурмагаас ялгаж чадсан туршлагаасаа хуваалцахад тэднийг урь.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд үнэн зөв болон алдааг хэрхэн ялган таних талаар ойлгож байна уу? Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Хичээлийн үед төрсөн сэтгэгдлээсээ хуваалцахад тэднийг урь. Тэд юуг хийхээр шийдсэн бэ? Тэднийг сурсан зүйлийнхээ дагуу амьдрахад нь та хэрхэн дэмжиж болох вэ?

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийнх нь зааж буй тэд бурууг үйлдэх үед бууж өгөөгүй. Тэрээр тэднийг үргэлжлүүлэн хайрлаж, тохинуулж байсан. Жишээ нь, Петр Түүнийг үгүйсгэсний дараа ч Аврагч түүнд үргэлжлүүлэн тохинуулж, Сүмийг удирдахуйц зохистой болоход нь тусалсан. Сайн мэдээг дагахдаа бэрхшээлтэй тулгарч байгаа тэдгээрт та ямар замаар тохинуулж болох вэ?

Сонгосон материалууд

Бойд К.Пакэр, “Миний мэддэг зүйлс,” Ensign эсвэл 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 5-аас эш татав

Судруудад сонголтыг “ёс суртахууны сонгох эрх” буюу бид сайн муугийн хооронд сонгох эрхтэй хэмээн тодорхойлдог. Чөтгөр биднийг сонгох эрхээ буруу ашиглаасай хэмээн эрэлхийлж, уруу татдаг.

Судрууд бидэнд “Миний өгсөн ёс суртахууны сонгох эрхийн дагуу хүн болгон ирээдүйд хамаарах сургаал хийгээд зарчимд үйлдэж болохын тулд, шүүлтийн өдөр хүн болгон нүглүүдийнхээ төлөө хариуцаж болохын тулд буюу” хэмээн заадаг.

Мөн Алма “Их Эзэн нүглийн хамгийн бага хэмжээгээр байлаа ч гэсэн хүлээн зөвшөөрч чаддаггүй” [Алма 45:16] хэмээн заасан. Үүнийг ойлгохын тулд бид нүглийг нүгэл үйлдэгчээс салгаж ойлгох ёстой.

Жишээ нь тэд Их Эзэний өмнө садар самуун үйлдэж байсан гэмт эмэгтэйтг авчрахад Тэрээр цөөхөн хэдэн үг хэлж, уг хэргийг хаасан. “Явж, мөн нүгэл дахин бүү үйлд” [Иохан 8:11] гэсэн нь Түүний тохинууллын мөн чанар байсан юм.

Хүлцэнгүй байдал нь ариун журам хэдий ч яг л бусад ариун журамтай адил, хэтрүүлсэн тохиолдолд энэ нь сул тал болон хувирна. Тиймээс бид “хүлцлийн урхинд” живэхгүй байж болохын тулд түүнээс болгоомжлох хэрэгтэй. Ёс суртахуунгүй үйлдлүүдийг хууль ёсны болгон хүлээн зөвшөөрөх иргэний хуулийг сулруулснаас үүссэн олон нийтийн хүлцэл нь Бурханы ариун явдлын

хуулийг зөрчсөнөөс үүсэх сүнслэг байдлын ноцтой үр дагавруудыг багасгадаггүй юм.

Бид бүгд, хүн бүр зөвийг буруугаас ялган таних боломж олгогч, удирдан чиглүүлэх нөлөө бүхий Христийн Гэрэлтэй төрсөн. Тэрхүү гэрлийг хэрхэн ашиглах, зөв шударга амьдрахад нөлөөлөх тэдгээр өдөөлтөд хэрхэн хариу үзүүлэх зэрэг нь энэхүү мөнх бус байдал дахь шалгуурын нэг хэсэг нь билээ.

“Учир нь болгоогтун, Христийн Сүнс хүн бүрт тэрбээр сайныг хилэнцээс ялган мэдэж болохын тулд өгөгдсөн байдаг, иймийн тул, би та нарт дүгнэх аргыг үзүүлье: учир нь Христэд итгүүлэхээр ятгахыг, мөн сайныг хийхийг урьдаг юм болгон нь, Христийн хүч болон бэлгээр илгээгдсэн байдаг, иймийн тул та нар энэ нь Бурханаас гэдгийг төгс мэдлэгээр мэдэж болно” [Моронай 7:16].

Хүн бүр сүнслэг удирдамж болон Ариун Сүнсний өдөөлтөд хариулахад бэлэн байх ёстой. Бидний оюунд цэвэр оюун билгийг илгээснээр бидэнд нөлөөлөх, зааварлах, заах, урьдчилан сэргийлэх арга зам Их Эзэнд байдаг билээ. Бурханы хүү, охин бүр өөрсдийн мэдвэл зохих зүйлсийг тэр дор нь мэдэж авч чадна. Сүнслэг нөлөө, илчлэлт хүлээн авч мөн түүний дагуу үйлдэж сур.

Уншсан, заасан, сурсан бүх зүйлээсээ миний санал болгох хамгийн үнэтэй хийгээд ариун нандин үнэн бол Есүс Христийн талаарх миний онцгой гэрчлэл юм. Тэр амьд. Тэр амьд гэдгийг би мэднэ. Би бол Түүний гэрч. Би Түүний гэрчилж чадна. Тэр бол бидний Аврагч, бидний Гэтэлгэгч. Би энэ талаар баттай байдаг. Мөн энэ тухай гэрчлэлээ би Есүс Христийн нэрээр үлдээж байна, амен.



Цэвэр сургаалыг заах нь яагаад чухал вэ?

Анхны Арванхоёр Төлөөлөгчийг нас барсны дараа хүмүүс өөрсдийн оюун ухаанд найдан судруудыг өөрсдийнхөөрөө орчуулж эхэлсэн байна. Үүний хор уршгаар буруу сургаал заагдаж, Сүм урвалтанд өртжээ. Бид сайн мэдээний багшийн хувьд бусдыг буруу зам руу хөтлөхгүйн тулд сэргээгдсэн сайн мэдээний цэвэр үнэнүүдийг заах үүрэгтэй байдаг. Бидний заадаг хүмүүс цэвэр сургаалыг ойлгосноор зүрх сэтгэл нь хөндөгдөж, тэд өөрсдийн зан чанар, ааш араншингаа өөрчилдөг (Бойд К.Пакер “Бүү эмээ”-г үзнэ үү *Ensign* ба *Лиакхона* 2004 оны 5-р сар, 79).

Багшийн хувьд та цэвэр сургаалыг заахын тулд юу хийдэг вэ? Цэвэр сургаалыг зааснаар ирэх хүч чадлыг та хэзээ мэдэрч байсан бэ?

Таны заадаг өсвөр үеийнхэн цэвэр сургаалын хүчийг таньж мэддэг үү? Тэдэнд цэвэр сургаалыг заах чадвартаа итгэлтэй байхад нь та хэрхэн тусалж чадах вэ?

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар ба материалуудыг судал. Эндээс та юуг өсвөр үеийнхэнтэй хуваалцахыг хүсч байна вэ?

Лук 24:32; Иосеф Смитийн Түүх 1:11–12 (Судруудаас заахад хүмүүсийн зүрх сэтгэлд хүрдэг)

2 Тимот 4:3–4 (Хуурамч сургаалууд заагдах болно хэмээн Паул бошиглон хэлдэг)

Мозая 18:19 (Судрууд болон бошиглогчдын үгс нь цэвэр сургаалын эх сурвалж юм)

Алма 4:19; 31:5 (Бурханы үг бол хүчтэй)

Моронай 10:5 (Ариун Сүнс үнэнийг гэрчилдэг)

Teaching, No Greater Call (1999), 52–53, 203–7

Д.Тодд Кристоффэрсон “Христийн сургаал” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2012 оны 5-р сар, 86–90

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутад өсвөр үеийнхний янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, Сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний хамаарлыг олж харахад нь та нар өсвөр үеийнхэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

- Хэн нэгэнд сайн мэдээний тухай зааж байхдаа Сүнснийг мэдэрсэн туршлагаасаа хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс.

- Ангид цэвэр устай нэг аяга бас бохир устай нэг аяга авчир. Ус нь хүмүүст бидний зааж буй сайн мэдээг төлөөлж байгаа гэдгийг хэл. Хэрэв цэвэр ус нь цэвэр сургаальг төлөөлж байгаа бол бохир ус нь юуг төлөөлж байна вэ? Сайн мэдээний

цэвэр сургаальг ямар зүйлүүд бохирдуулж болох вэ? (*Teaching, No Greater Call*, 52–53-г үзнэ үү). Цэвэр сургаальг заах нь чухал гэдгийг ойлгоход энэ туршлага өсвөр үеийнхэнд яаж тусалж байна вэ?

Хамтдаа суралц

Цэвэр сургаальг заах нь чухал болохыг өсвөр үеийнхэн ойлгоход дараах бүх үйл ажиллагаа тусалж чадна. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Дэлхийн арга замаар хүмүүсийн зан авирыг өөрчлөх гэж оролддог арга замуудыг жагсаан бичихийг өсвөр үеийнхнээс хүс. Тэгээд тэднээс Алма 4:19 ба 31:5-г уншаад, хүмүүст нөлөөлөх Их Эзэний арга замыг олохыг хүс. Тэднийг уншиж ойлгосон зүйлээ хуваалцсаны дараа цэвэр сургаальг заалгасан учраас зүрх сэтгэл нь өөрчлөгдсөн хүмүүсийн жишээг судраас олоход урь. Сурсан сайн мэдээний зарчмууд нь тэдний үйлдэлд нөлөөлсөн жишээнээсээ хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс.

- Худал хуурмаг сургаал заасан хүмүүсийн жишээг судраас олоход нь өсвөр үеийнхэнд тусал (жишээлбэл Шерим [Иаков 7-г үзнэ үү], Корихор [Алма 30-г үзнэ үү] эсвэл зорамчууд [Алма 31-г үзнэ үү]). Тэдний заасан зүйл хүмүүст хэрхэн нөлөөлсөн бэ? Их Эзэний үйлчлэгчид хариуд нь ямар сургаал заасан бэ? Үүнтэй төстэй ямар худал хуурмаг зүйлийг дэлхийд өнөө үед зааж байна вэ? Өсвөр үеийнхэн цэвэр

сургаалд хэрхэн хандаж мөн үүнийг зааж чадах вэ?

- Өсвөр үеийнхнийг 2 Тимот 3:2–4 ба 2 Нифай 9:28–29-г уншихад урь. Эдгээр судрууд нь өнөө үед хэрхэн биелэгдэж байгаа вэ? Хуурамч сургаальн ямар үр дагаврыг бид өнөөдөр хардаг вэ? (жишээ болгон 2 Тимот 3:1–5-г үзнэ үү). Сэргээгдсэн сайн мэдээний ямар зарчмууд эдгээр алдааг засахад тусалж чадах вэ?

- Ангийн тал суралцагчийг “Teaching, No Greater Call” номын Багш таны үүрэг хариуцлагууд (52-р хуудас), нөгөө бүлгийг “Сайн мэдээний багш нарт анхааруулах нь” (52–53-р хуудас)-г уншиж судлахыг хүс. Бүлэг бүрээс сурсан зүйлээ нөгөө бүлэгтээ үр дүнтэйгээр заах арга бодож олохыг хүс. Хүн нэг бүрийг танилцуулсан санаануудаас нэг нэгийг сонгон, яагаад энэ санаа нь цэвэр сургаальг заахад чухал болохыг тайлбарлахад урь.

Заахад туслах арга

“Бид сүмийн удирдагчдын хэлсэн зүйлсийг өөрсдийн дураар тайлбарлах ёсгүй. Бид судраас эш татахдаа тэдгээрийг нөхцөл байдалтай нь нийцүүлэн зааж байгаа эсэхээ магадлах хэрэгтэй байдаг” (*Teaching, No Greater Call* [1999], 53).

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээ хуваалцахыг хүс. Тэд цэвэр сургаал заахын чухлыг ойлгож байна уу? Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Заах боломжуудынхаа талаар бодохыг тэднээс хүс. Цэвэр сургаалыг заахын тулд хийх ёстойг тунгаан бодоход нь тэднийг дэмж.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн зорилгыг гэрчлэх мөн бусдад заахдаа судруудыг ашигладаг байсан. Тэрээр цэвэр сургаалын талаар зааж, үүнийг олонтоо онцлон тэмдэглэдэг байлаа. Цэвэр сургаалыг таньж мэдэн, бусдад заахдаа судруудыг ашиглахад нь та өсвөр үеийнхэнд хэрхэн тусалж чадах вэ?



Урвалт ба сэргээлтийн үйл явдлуудыг би өөрийнхөө амьдралтай хэрхэн адилтгаж болох вэ?

“Энэ нь бидэнд эрдэм болон тус байж болохын тулд бид бүх судрыг өөрсөдтэйгөө адилтгах” ёстой (1 Нифай 19:23). Судруудыг адилтгах гэдэг нь сударт өгүүлсэн үйл явдал ба нөхцөл байдлыг өөрсдийн амьдрал дахь үйл явдал, нөхцөл байдалтай харьцуулахыг хэлнэ. Урвалт ба сэргээлт нь олон жилийн өмнө тохиолдсон хэдий ч бид эдгээр үйл явдлаас суралцаж мөн өөрсдийн амьдралыг жишиж болно.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар ба материалуудыг залбиралтайгаар уншаарай. Юу өсвөр үеийнхнийг өөрсдийн амьдралаа урвалт ба сэргээлтийн үйл явдлуудтай адилтгахад туслах вэ?

1 Нифай 19:23–24 (Бид судруудыг өөрсөдтэйгөө адилтгах ёстой)

С ба Г 61:36 (Их Эзэн нэгд хэлснээ бүгдэд хэлдэг)

Иосеф Смитийн Түүх 1:5–20 (Иосеф Смит Иаковын 1:5-г өөртэйгөө адилтгасан)

“Урвалт”, *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 200–201

М.Рассэл Баллард “Өнгөрсөн үеэсээ суралцах нь” *Ensign* эсвэл *Луахона*, 2009 оны 5-р сар, 31–34

“Адилтгах,” *Teaching, No Greater Call* (1999), 170–71

Видео бичлэг: “Сэргээлт миний хувьд ямар утга учиртай билээ?”

Та судруудыг өөрийн амьдралтай адилтгаснаар хэрхэн адислагдсан бэ? Амьдралаа судруудтай адилтгахад танд ямар аргууд тусалсан бэ? Урвалт ба сэргээлтийн ямар үйл явдлууд нь таны амьдралд онцгой нөлөө үзүүлсэн бэ?

Судруудыг адилтгаж сурах нь өсвөр үеийнхнийг хэрхэн адислах вэ? Өсвөр үеийнхний амьдрал ба урвалт, сэргээлтийн тухай тэдний судалж байгаа зүйлсийн хооронд та ямар холбоог харж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутад өсвөр үеийнхний янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний хамаарлыг олж харахад нь та нар өсвөр үеийнхэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Залуу эмэгтэйчүүдийн ангид урвалт ба сэргээлтийн тухай саяхан сурсан зүйлээсээ залуу эрэгтэйчүүдтэй хуваалцах охидыг урь. Үүний дараа Аароны санваарын чуулга дээр урвалт ба сэргээлтийн тухай сурсан зүйлээсээ залуу эмэгтэйчүүдтэй хуваалцахыг залуу эрэгтэйчүүдээс хүс.

- Өсвөр үеийнхнийг 1 Нифай 19:23 -г уншаад, “бүх судрыг өөрсөдтэйгөө адилтгасан” гэж хэлсэн Нифайн үгс ямар утгатай болохыг ярилц (шаардлагатай бол энэхүү тоймын эхний догол мөрийг тэдэнтэй хуваалц). Сэргээлтийн үйл явдлуудыг өөрсдийнхөө амьдралтай холбох арга замуудыг олоход ангийн гишүүдийг урь.

Хамтдаа суралц

Дараах бүх үйл ажиллагаанууд нь өсвөр үеийнхэн өөрсдийнхөө амьдралыг урвалт ба сэргээлттэй хэрхэн адилтгаж болохыг ойлгоход нь тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Өсвөр үеийнхнийг Иосеф Смит—Түүх 1:5–10 -г уншаад, Иосеф Смитийг 14 настай байхад түүний амьдралд юу тохиолдож байсан тухай мэдэхийг хүс. Тэгээд тэднээс 11-20-г шүлгийг уншин, Иосеф уншсан судраа өөрийн туршлагатай адилтгах юу хийсэн бэ? гэдгийг олуул. Иосеф Смитийн жишээ өсвөр үеийнхэнд судраас илүү сайн суралцахад хэрхэн туслах вэ? Тэд өөрсдийн амьдралыг Иосеф Смитийн туршлагатай адилтгаж болох арга замуудыг бичих цагийг тэдэнд гаргаж өг. Ангийн нэг гишүүнээс бичсэн зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс.

- “Teaching, No Greater Call” номын 170–171-р хуудсан дахь *Адилтгах* гэсэн хэсгийг уншаад, өөрсдийгөө судартай адилтгаж болох арга замуудыг олоход урь. Өөрсдийн ойлгосон зүйлээ ангийнхантайгаа хуваалцахыг тэднээс хүс. *Teaching, No Greater Call* номын энэ хэсэгт эш татсан судруудаас нэгийг сонгон,

удирдамжийг нь амьдралдаа хэрэгжүүлэхийг урь. Эдгээр арга замыг ашиглан өсвөр үеийнхэн өөр ямар судруудыг өөрсөдтэйгөө адилтгаж болох вэ?

- Самбар дээр “Их урвалт” ба “Хувийн урвалт” гэсэн гарчгууд бич. “Итгэлдээ үнэнч байх нь” номын *Урвалт* гэсэн сэдвийг уншаад Их урвалт руу хөтөлсөн зүйлс эсвэл Их урвалтын үр дагавруудыг жагсаан бичихийг тэднээс хүс. Жагсаан бичсэн зүйлс нь тэднийг хувийн урвалт руу хэрхэн хөтөлж болохыг ярилцан өөрсдийгөө Их урвалттай адилтгахад нь тэдэнд тусал. Жишээлбэл Христийг нас барсны дараа төлөөлөгчдийг алсан хүмүүс, амьд бошиглогчдыг эсэргүүцдэг буюу шүүмжилдэг хүн бол хувийн урвалтанд орох аюулд байна гэсэн үг. Өөрсдийгөө хувийн урвалтанд оруулахаас хамгаалахын тулд өсвөр үеийнхэн юу хийж болох вэ?

- Найз нь “Би судар унших дургүй. Судар дээр эртний үед тохиолдсон

Заахад туслах арга

“Их олон материалаас заах нь чухал бишээ. Нэг дор дэндүү олон санаа заах нь суралцагчдыг будлиулах буюу ядраадаг учраас нэг юм уу хоёр гол зарчим дээр анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй” (*Teaching, No Greater Call* [1999], 99).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч хүмүүст судруудын талаар өөрсдөө бодож, асуулгынхаа хариултыг олоход судруудыг ашиглахыг заасан. Сорилт бэрхшээл тулгарсан үед судраас уншсан зүйлсээ амьдралд хэрэгжүүлж болохыг ойлгоход нь та өсвөр үеийнхэнд хэрхэн тусалж болох вэ?

зүйлсийг бичсэн байдаг шүү дээ. Өнөө үед миний амьдралд энэ ямар хамаатай юм бэ?" гэж хэлбэл тэд юуг гэж хариулах вэ? гэж тэднээс асуу. Ахлагч М.Рассэл Баллардын "Өмнөх

үеэсээ суралцах нь" хэлсэн үгийг өсвөр үеийнхэнд хуваан өгч уншуулаад тэндээс найздаа хэлэх хариултаа олохыг хүс.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд урвалт болон сэргээлтийн үйл явдлуудыг хэрхэн адилтгахаа ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан зүйлээсээ тэд юуг хийх урмыг авч байгаа тухай өсвөр үеийнхнээс асуу. Тэдний хийх зүйлийг эргэн шалгаарай.

Сонгосон материалууд

Teaching, No Greater Call номын “Likening” хэсгээс эш татав. (1999), 170–171

Бид “бидэнд эрдэм болон тус байж болохын тулд бүх судрыг өөрсөдтэйгээ адилтгах” хэрэгтэй. (1 Нифай 19:23) Судруудыг өөрсөдтэйгээ адилтгахын зорилго нь судрын түүхүүд нь өнөөгийн нөхцөл байдалтай хэрхэн адил төстэй байгаа хийгээд тэдгээрийн зааж байгаа зарчмууд нь бидний амьдралд ямар хамааралтайг мэдэх явдал юм. Тухайлбал: Үнэнийг хамгаалах талаар суралцаж байгаа хичээл дээр та зааж байгаа суралцагчдаа хаан Ноагийн шүүлтэнд орж байгаа Абинадагийн түүхтэй адилтгаж болно. (Мозая 11–17-г үзнэ үү.) Бид сүнслэг байдлаараа харалган байгаа талаар болон биднийг эдгээж, бидэнд сүнслэг гайхамшигтай харааг өгч чадах Аврагчийн хүчний талаар заахдаа, Христ сохор эрийг эдгээсэн түүхтэй адилтгаж болно (Иохан 9-г үзнэ үү).

Гэр бүлийнхэндээ эсвэл ангийн гишүүддээ уншсан зүйлээ тунгаан бодох боломж олгосноороо энэ аргыг үр дүнтэйгээр ашиглах болно. Жишээлбэл: Иосеф Смит Ариун ойн цоорхойд (Иосеф Смит—Түүх1:15–16-г үзнэ үү) байхдаа дайсны уруу таталтанд бууж өгөхийн даваан дээр авсан хариултын талаар заасныхаа дараа та нар суралцагчдаас тэднийг уруу таталттай тулгарсан үедээ хэрхэн даван туулснаа санаж, бичихийг хүсч болно. Та нар тэднийг сорилтын үедээ “Бурханыг дуудахад бүх [бидний] хүчээ шавхан дайчилж” (шүлэг 16) хичээх нь яагаад чухал байдаг талаар бодохыг урьж болно.

Судруудыг өөрсөдтэйгээ адилтгахад нь бусдад туслах өөр нэг арга бол өөрсдийгөө судар дээр гарч байгаа хүмүүсийн оронд орлуулахыг тэднээс хүсэх юм. Жишээлбэл: Хэн нэгэн Иохан 1:5–6 эшлэл дээр өөрийнхөө нэрийг орлуулж уншвал залбирлын талаар заасан энэ судар нь Иосеф Смитэд хэрэгжсэний нэгэн адил түүнд бас хэрэгжих болно.

“Харин та нарын хэн нэгэн нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гуйг. Тэгээд түүнд өгөгдөх болно. Харин тэр ямар ч эргэлзээгүйгээр итгэлээрээ гуйг.”

“Энэ цэдгийг бичсэн бошиглогч биднийг үүнээс юу сураасай хэмээн хүссэн бэ? Яагаад тэр эдгээр нарийн чухал зүйлүүдийг бичих болсон бэ?” хэмээн бид асууснаар судруудыг өөрсдийн амьдралтай олонтоо адилтгаж болно. Бид Еносын түүхийн талаар эдгээр асуултыг асуухад, бид залбирахдаа хэрэгжүүлж болох арга замуудыг мэдэж авч болно. Бид энэ түүхээс зарим үед залбирал нь ихээхэн хүч чармайлт шаарддаг ч Тэнгэрлэг Эцэг бидний залбиралд хариулдаг гэдгийг сурдаг. Мөн хүүхдүүд, эцэг эхийнхээ заасны дагуу амьдрахад олон жил шаардагдаж болох хэдий ч эцэг эх нь тэдэнд нөлөөлдөг гэдгийг бид сурдаг.

Бид судруудыг өөрсөдтэйгээ адилтгаж мөн бусдад ийн үйлдэхэд тусалснаар бид Бурханы үгийн хүчийг амьдралынхаа бүхий л зүйлүүд дээр харах боломжтой болдог.



Урвалт ба сэргээлтийн тухай би бусдад хэрхэн тайлбарлах вэ?

Бидний олонход сайн мэдээний үнэнийг бусадтай хуваалцах боломж тохиодог. Урвалт ба сэргээлт нь сэргээгдсэн сайн мэдээний амин чухал зарчим учраас эдгээр үнэнийг бусдад хэрхэн тайлбарлахаа мэддэг байх нь маш чухал байдаг. Бид хүмүүсийг гомдоох зүйл хэлж болохгүй ч сайн мэдээний сэргээлтийн онцлогийг илэрхийлэн гэрчлэх ёстой.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалуудыг залбирч уншаарай. Урвалт ба сэргээлтийн тухай бусдад тайлбарлаж сурахад нь тэдэнд юу туслах вэ?

Амос 8:11–12; Үйлс 3:20–21; 2 Тесалоник 2:1–3 (Урвалт ба сэргээлтийн тухай зөгнөн хэлсэн байдаг)

Ефес 2:20 (Сүм нь бошиглогч ба төлөөлөгчийн суурин дээр баригдсан юм)

Рассэл М.Нэлсон “Давалгаанд нэгдэгтүн” Ensign эсвэл Лиахона, 2013 оны 5-р сар, 45-48

Даллин Х.Өүкс “Цорын ганц үнэн болон Амьд Сүм” *New Era* 2011 оны 8-р сар, 3–5

“Гэрчлэлээ ойр ойрхон хуваалц” Миний сайн мэдээг номло (2004) 225-226

“Их урвалт”, “Есүс Христийн Сайн Мэдээ Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн нь” Миний сайн мэдээг номло (2004) 36-40

Урвалт ба сэргээлтийн талаар бусдад заасан туршлага танд байдаг уу? Бусад хүмүүс эдгээрийг заахдаа ямар үр дүнтэй аргуудыг хэрэглэж байхыг та харж байсан бэ?

Өсвөр үеийнхэн урвалт ба сэргээлтийн талаар юу мэддэг вэ? Одоо мөн ирээдүйд эдгээр үнэний тухай бусдад заах ямар боломжууд тэдэнд байдаг вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутад өсвөр үеийнхний янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний хамаарлыг олж харахад нь та нар өсвөр үеийнхэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Сүм болон тэдний итгэлийн талаар хүмүүс өөрсдөөс нь асууж байсан асуултуудаас хуваалцахыг урь. Тэд эдгээр асуултад хэрхэн хариулсан бэ?

- Өсвөр үеийнхнээс урвалт ба сэргээлтийн тухай сурсан туршлагаасаа хуваалцахад урь. Тэдэнд заасан хүн сэргээгдсэн сайн мэдээний эдгээр үнэнийг тэдэнд ойлгуулахын тулд юу хийсэн бэ?

Хамтдаа суралц

Дараах бүх үйл ажиллагаа нь урвалт ба сэргээлтийн талаар бусадтай хэрхэн ярилцахыг сурахад нь өсвөр үеийнхэнд тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Өсвөр үеийнхнээс Их урвалт ба сэргээлт болох болно хэмээн зөгнөн хэлсэн судруудаас хуваалцахыг хүс. Тэдэнд тусламж хэрэгтэй бол Сэдэвчилсэн удирдамж эсвэл энэхүү тоймд жагсаасан судруудыг санал болго. Эдгээр судар болон бусад материалыг ашиглан нэг нэгэндээ урвалт ба сэргээлт тухай тайлбарлан дадлага хийлгэ.

- Ахлагч Даллин Х.Өүксийн “Цорын ганц Үнэн болон Амьд Сүм” хэлсэн үгийн эхний зургаан догол мөрийг хамтдаа унш. Бид бусдыг гомдоолгүйгээр цорын ганц үнэн сүмийг хэрхэн гэрчилж болох вэ? гэж өсвөр үеийнхнээс асуу. Уг хэлсэн үгийн үлдсэн хэсгийг тэдэнд хувиарлан өгч уншуулаад, бусдын итгэлд хүндэтгэлтэй хандаж бас сэргээгдсэн сайн мэдээний хүчирхэг гэрчлэлийг хуваалцахдаа ахлагч Өүкс юу хийснийг олохыг хүс. Тэднийг хоёр хоёроор нь хувиарлаад сая сурсан зүйлээ ашиглан бие биедээ үнэн сүмийн тухай гэрчлэлээ хуваалцахад урь.

- “Миний сайн мэдээг номло” номын Гэрчлэлээ ойр ойрхон хуваалц хэсгийг уншихад тэднийг урь. Бид заах үедээ мөн гэрчлэлээ хуваалцах удирдамж өгөхдөө гэрчлэлээ

хуваалцах нь яагаад чухал байдаг тухай хамтдаа жагсаан бич. Сэргээлт тухай заахдаа гэрчлэлээ хуваалцах нь чухал болохыг харуулахын тулд шинэхэн хөрвөгчийг урьж авчран Иосеф Смитийн Анхны үзэгдлийн талаарх гэрчлэлийг хэрхэн олж авсан тухай хуваалцахад урь (бишопоос урьдчилан зөвшөөрөл авсан байна). Түүний хөрвөлтөнд бусад хүмүүсийн гэрчлэл хэрхэн нөлөөлсөн тухай түүнээс асуу. Та сэргээлт тухай гэрчлэлээ хуваалцан, өсвөр үеийнхнийг мөн гэрчлэлээ хуваалцахад урьж болно.

- “Teaching, No Greater Call” номын *Object Lessons* бүлгийг уншиж судлахыг өсвөр үеийнхнээс хүс. Бусдад урвалт ба сэргээлт тухай тайлбарлахад нь туслах үзүүлэнт хичээл бодож олоход урь. Жишээлбэл урвалтыг тайлбарлахдаа сүмийг “Бошиглогч ба төлөөлөгчид” хэмээн доод талд нь бичсэн дөрвөлжин зүйлсээр барьж үзүүл. Тэгээд сүм бошиглогч ба төлөөлөгчийн суурьгүйгээр оршин тогтнож чадахгүй гэдгийг харуул (Ефес 2:20-г үзнэ үү). Үзүүлэнт хичээлийн санаагаа нэг нэгэнтэйгээ хуваалцахад урь. Бусдад урвалт ба сэргээлт тухай заах ямар боломжууд тэдэнд гардаг вэ?

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Урвалт ба сэргээлт тухай бусдад хэрхэн тайлбарлахаа тэд ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Заахад туслах арга

“Хичээл дээр олон янзын сурах үйл ажиллагааг ашигласнаар суралцагчид сайн мэдээний зарчмуудыг илүү сайн ойлгож, удаан санах болно. Анхааралтайгаар сонгосон заах арга нь зарчмуудыг илүү тодорхой, сонирхолтой бас дурсамжтай болгодог” (*Teaching, No Greater Call* [1999], 89).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн заадаг хүмүүсээ гэрчлэхэд урьсан ба тэднийг гэрчлэлээ хэлэхэд Сүнс тэдний зүрх сэтгэлийг хөндсөн. Урвалт ба сэргээлтийн талаар гэрчлэлээ хуваалцаж сурахад нь та өсвөр үеийнхэнд хэрхэн туслах вэ?

Өсвөр үеийнхнийг үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан зүйлээсээ тэд юуг хийх урмыг авч байгаа талаар өсвөр үеийнхнээс асуу. Тэр мэдрэмжүүдийнхээ дагуу үйлдэхийг тэдэнд уриал. Тэдний хийх зүйлийг эргэн шалгах арга замыг бодохдоо Сүнсийг эрэлхийлээрэй.

Сонгосон материалууд

“Гэрчлэлээ ойр ойрхон хуваалц,” Миний сайн мэдээг номло (2004), 198–199

Гэрчлэл бол Ариун Сүнсээр өгөгддөг сүнслэг гэрчлэл бөгөөд баталгаа юм. Гэрчлэлээ хуваалцана гэдэг нь сайн мэдээнд итгэх итгэл, баталгаа, итгэлийн мэдрэмжийг энгийнээр тунхаглана гэсэн үг юм. Гэрчлэлээ байнга хуваалцаж байх нь Сүнсийг урих ба бусдад Сүнсийг мэдрэхэд нь туслах хамгийн хүчирхэг арга замуудын нэг юм. Гэрчлэлээ хуваалцсанаар та судраас заасан үнэнээ цаг үеэ олсон, хувийн гэрчлэлээрээ баяжуулж байгаа хэрэг юм. Амжилттай номлогч нь зааж, гэрчилж, Есүс Христэд итгэх итгэлийг бий болгох зүйлсийг хийхэд бусдыг урьж байдаг. Үүнд амьд, үнэн зарчмуудаас ирдэг амлалтууд өгөх нь багтдаг. Жишээлбэл: номлогч “Та Ариун өдрийг ариунаар сахивал та зүрх сэтгэлдээ амар амгаланг мэдрэх болно гэдгийг би мэдэж байна” гэж хэлж болно.

Өөрийн гэрчлэлээ хүчтэй байлгахын тулд та чин сэтгэлээсээ байх ёстой. Хүчирхэг гэрчлэл нь уран цэцэн үг эсвэл таны хоолойны өнгөнөөс биш харин таны зүрх сэтгэлийн итгэл үнэмшлээс шалтгаалдаг. Заах гэж байгаа сургаал, зарчмуудынхаа талаарх ойлголт, итгэл үнэмшлээ хүчирхэгжүүлэхийн тулд өдөр бүр хичээ. Зааж байгаа сургаал ба зарчмаа үнэн гэж батлахын тулд гэрчлэлээ байнга хуваалц. Аль болох олон удаа заа, тэгээд гэрчил мөн зааж байхдаа гэрчил.

Таны гэрчлэл “Есүс Христ бол Бурханы Хүү” эсвэл “Мормоны Ном үнэн гэдгийг би мэдсэн” гэх мэт энгийн байж болно. Та бас энэ мэдлэгийг хэрхэн олж авсан туршлагаа товчхон хуваалцаж болно. Хичээл бүр дээр гэрчлэлээ зөвхөн хичээл дуусах үед биш хичээлийн дундуур хэд хэдэн

удаа хуваалц. Таны хамтрагчийн заасан зүйлс Бурханаас гэдгийг гэрчил. Таны зааж байгаа зарчим нь үүнийг дагаснаар таны сонирхогчийн амьдралыг адислах болно гэдгийг гэрчил. Зарчмын дагуу амьдарснаар таны амьдрал хэрхэн адислагдсан талаар ярь.

Хүмүүс заримдаа таны юу зааж байгааг асууж болох ч чин сэтгэлийн, зүрх сэтгэлийн гэрчлэлийг асуух нь хэцүү байдаг. Та гэрчилж байхдаа таны зааж байгаа хүмүүс Ариун Сүнсний баталгааг мэдрээсэй хэмээн залбир. Та гэрчилж байхдаа сонирхогчдодоо таны гэрчлэлийг үнэн гэж батлах Ариун Сүнсийг мэдрэх орчинг бий болгоход тусал. Энэ нь таны тэдэнд өгөх амлалтуудыг хүлээн авахад тэднийг бэлтгэх болно.

Бригам Янг сэргээгдсэн сайн мэдээний талаар суралцаж байх эхний жилдээ Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд нэгдэн баптисм хүртээгүй юм. Тэрээр хөрвөлтийнхөө талаар хэлэхдээ: “Хэрэв энэ дэлхийн бүхий л авьяас, ур чадвар, мэргэн ухаан, ганган чамин байдал нь Мормоны Номтой хамт над руу илгээгдэж мөн дэлхийн хамгийн уран цэцнээр, дэлхийнхний эрдэм ба оюун ухаанаар үүнийг нотлохыг амлаж үүний үнэнийг тунхагласан бол тэдгээр нь надад замрахын тулд л бий болдог утаа мэт байх байсан. Гэвч би уран цэцэн үггүй, олон нийтийн өмнө илтгэх авьяасгүй нэгэн залуугийн “Би Мормоны Ном үнэн гэдгийг Ариун Сүнсээр мэддэг,” Иосеф Смит бол Бурханы бошиглогч” гэж хэлэхийг сонсоод Ариун Сүнс миний ойлголт, гэрэл, сүр жавхлан ба үхэшгүй мөнх байдлыг гэрэлтүүлсэн юм. Би тэдгээрээр хүрээлүүлж, тэдгээрээр дүүрсэн бөгөөд энэ хүний гэрчлэл үнэн гэдгийг би өөртөө мэдэж авсан” гэв. (*Journal of Discourses* 1:90).

БҮЛГИЙН ТОВЧ ТОЙМ

Тавдугаар сар: Бошиглогчид ба илчлэлт

“Бурханы илчилсэн бүгдэд, эдүгээ Түүний илчилж буй бүгдэд бид итгэдэг мөн Бурханы хаант улсад хамаарах олон агуу хийгээд чухал зүйлийг Тэрээр цаашид илчлэх болно гэдэгт бид итгэдэг” (Итгэлийн тунхаг 1:9).

Энэхүү бүлгийн тойм нь Их Эзэний илчлэлтүүдээс суралцахад мөн тэдгээрийг заах чадвараа хөгжүүлэхэд нь өсвөр үеийнхэнд туслах болно. Тэдгээр илчлэлт нь судрууд болон амьд бошиглогчдын хэлсэн үгсээр түүнчлэн Ариун Сүнсээр дамжуулан хувийн илчлэлтээр өсвөр үеийнхэнд ирдэг юм. Сурч байгаа зүйлсийнхээ талаар асууж лавлан, илүү ихийг сурахыг эрэлхийлж, сурч мэдсэн зүйлээ бусдад заахад нь өсвөр үеийнхнийг дэмжээрэй.

Энэ сард сонгох тоймууд:

Амьд бошиглогч, төлөөлөгчдөөс би юу сурч болох вэ?

Би судраас хэрхэн илүү үр дүнтэй суралцаж болох вэ?

Бишрэл хүндэтгэлтэй байх нь намайг илчлэлт хүлээн авахад хэрхэн туслах вэ?

Гэрчлэлээ хуваалцана гэдэг нь юу гэсэн үг вэ?

Сүнсний мэдрэмжийг дагах талаар ерөнхийлөгч Монсоноос би юу сурч болох вэ?



ТАВДУГААР САР: БОШИГЛОГЧИД БА ИЛЧЛЭЛТ

Би амьд бошиглогч, төлөөлөгчдөөс юу сурч болох вэ?

Амьд бошиглогч, төлөөлөгчид Сүмийг удирдахын тулд илчлэлт хүлээн авдаг бөгөөд тэдний зөвлөгөө биднийг төгс мэддэг ба бидэнд тохиолддог сорилтуудыг ойлгодог Их Эзэний хүслийг тусгасан байдаг. Бид амьд бошиглогч, төлөөлөгчдөөр удирдуулан, зургаан сар тутамд Ерөнхий чуулганы үеэр тэдний зөвлөгөөг хүлээн авахаар адислагдсан.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Та эдгээр материалыг судлах явцдаа амьд бошиглогчдын заасан зүйлүүдийн ач холбогдлын талаар өсвөр үеийнхнийг ойлгоход туслах үнэнүүдийг хай.

Бошиглогч, төлөөлөгчдийн заасан зүйлүүд бэрхшээлийг даван туулахад тань хэрхэн тусалсан бэ? Та зааж буй өсвөр үеийнхнээ хүчирхэгжүүлэх ямар туршлагаасаа хуваалцаж болох вэ?

Өсвөр үеийнхэн өнөөдөр ямар бэрхшээлүүдтэй тулгарч байна вэ? Бошиглогч, төлөөлөгчдийн заасан зүйлүүд эдгээр бэрхшээлтэй нүүр тулахад өсвөр үеийнхэнд хэрхэн тусалж болох вэ?

Мозая 8:16–18 (Үзмэрч бусдадаа агуу ашиг тус хүргэх болно)

С ба Г 1:38; 68:3–4 (Их Эзэний үйлчлэгч Сүнсээр ярихад тэдний хэлсэн үгс судар байх болно)

Хэнри Б.Айринг, “Хоёр эсвэл гурваараа хамтдаа цугларсан тэнд,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 3–6

Роналд А.Расбанд, “Би гайхширна,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2015 оны 11-р сар, 89–90

Гари И.Стивэнсон, “Тодорхой хийгээд эрхэм үнэнүүд,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2015 оны 11-р сар, 91–92

Дэйл Г.Рэнланд, “Бурханы мэлмийгээр харах нь,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2015 оны 11-р сар, 93–94

Саяхны Ерөнхий чуулган дээрх Тэргүүн Зөвлөл, Арванхоёрын чуулгын гишүүдийн хэлсэн үгс

“Бошиглогчид,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 57–58

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний хэдэн минутад өсвөр үеийнхний янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, Сүмийн бусад хичээл, эсвэл найз зүүдтайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний хамаарлыг олж харахад нь та нар өсвөр үеийнхэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм.

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

- Өсвөр үеийнхнийг сайн мэдээний талаар хэн нэгэн хүний асуусан саяхны тохиолдлоосоо хуваалцахад урь. Тэд хэрхэн хариулсан бэ?

- Өсвөр үеийнхнээс хамгийн сүүлийн Ерөнхий чуулганы сэтгэл догдлуулсан үгсийн талаар хуваалцахыг урь. Энэ нь тэдэнд яагаад чухал болохыг асуу.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь өсвөр үеийнхэнд тэдэнд ирдэг сорилтуудын хариултыг амьд бошиглогчдын үгсээр дамжуулан олоход туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс олон үйл ажиллагааг сонгоно уу.

Сайн мэдээг судлах ур чадвар

Ерөнхий чуулган болон бусад хурал цуглаан дээр хэлсэн үгсийг судлах тухайд. Энэ хичээлээр өсвөр үеийнхнийг Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг судлахад урих юм. Дараах санаанууд тэдэнд тусална. Тухайлбал: Аль нэг хэлсэн үгийн гол санааг өөрийнхөө үгээр товчлон ярихад тэднийг дэмж. Их Эзэн энэ үгнээс юуг сураасай гэж надаас хүсэж байгаа бол? Тэр надаар юу хийлгэхийг хүсэж байгаа вэ? Одоо миний амьдралд тохиолдож байгаа сорилтыг шийдвэрлэхэд надад туслах ямар нэг зүйл энэ хэлсэн үгэнд байгаа болов уу? гэж тэд өөрөөсөө асууж болно. Өсвөр үеийнхэнд сайн мэдээг болон Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг хувиараа болон гэр бүлээрээ судлах үеэр иймэрхүү асуулт ашиглаж болно гэдгийг сануул.

Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг “Хоёр эсвэл гурваараа хамтдаа цугларсан тэнд” хэлсэн үгэндээ Бурханы үгийг хүлээж авахад өөрсдийн зүрх сэтгэлийг бэлтгэхийн ач холбогдлыг тайлбарлахын тулд тариачны сургаалт зүйрлэлийг ашигласан. Өсвөр үеийнхнийг ерөнхийлөгч Айрингийн уг сургаалт зүйрлэлийг ярьж байгаа хэсгийг уншаад, сурсан зүйлээ харуулах зураг зурахад урь. Тэд хамгийн сүүлийн Ерөнхий чуулганаас зүрх сэтгэлдээ ямар “үрийг” суулгах ёстой вэ? Та зааж буй өсвөр үеийнхэнтэйгээ холбоотой гэж бодож байгаа үгийг ангид авчраад, тэднээс үүнийг уншин, үйлдэл болгож болох үнэний үрүүдийг олж мэдэхийг хүсэж болно.

- Өсвөр үеийнхэнд өнөөдөр тулгарч буй сорилтуудыг жагсаан бичихэд ангийнхандаа тусал. Эдгээр сорилтоос нэгийг сонгон авч, хамгийн сүүлийн Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсээс энэ сорилтыг даван туулахад нь туслах зөвлөмж хайхад хүн нэг бүрийг урь. Тэдэнд *Ensign* эсвэл *Лиакхона* сэтгүүлүүд дээрх хамгийн сүүлийн чуулганы “Сэдвийн индекс”-ээс ашиглахыг санал болго.

- Саяхны Ерөнхий чуулган дээр ерөнхийлөгч Томас С.Монсоны хэлсэн үгийг үзүүл. Өсвөр үеийнхнийг, ялангуяа тэдний насныханд чухал болох зөвлөгөө, зөвлөмжийг анхааралтай сонсож, зөвлөмжийг ашиглан 5 минутын хэлэх үг бэлдэхийг хүс. Тэдэнд ангидаа бие биенийхээ өмнө үг хэлэх дадлага хийх боломж олго.

- Таны зааж буй өсвөр үеийнхэнд чухал байж болох Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг ангиараа сонс эсвэл үз. Өсвөр үеийнхнээс мөнхийн үнэнийг ба судруудыг мөн үйлдэхэд урих урилгыг болон хэлсэн үгсэд амлагдсан адислалуудыг таньж мэдэхийг хүс. (Хугацаа бага байвал хэлсэн үгийн зарим нэг хэсгийг үзэж болно.)

- *Итгэлдээ үнэнч байх нь* номоос “Бошиглогчид” хэсгийг хамтдаа уншихыг ангийн гишүүдээс хүс. Уншиж байгаа хэсгээсээ бошиглогчдын үүрэг юу болохыг олж мэдээд, тэдгээр үүргийг самбар дээр бичихийг хүс. Өсвөр үеийнхэн бүрд ахлагч Роналд А.Расбандын “Би гайхширна,” ахлагч Гари И.Стивэнсоны Тодорхой хийгээд эрхэм үнэнүүд” болон ахлагч Дэйл

Г.Рэнландын “Бурханы мэлмийгээр харах нь” үгсээс нэгийг оноож өг. Өсвөр үеийнхнийг ахлагч Расбанд, Стивэнсон, Рэнланд нарын эдгээр үүргээ биелүүлж байгаа

жишээнүүдийг мөн бошиглогчдын өөр нэмэлт үүргүүдийг олж, хуваалцахад урь. Бошиглогчдыг өөрсдийнхөө үүргийг биелүүлэхэд өсвөр үеийнхэн хэрхэн адислагдсан бэ?

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Амьд бошиглогч, дагалдагчдаас юу сурч болохыг тэд ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхнийг хамгийн сүүлийн Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг сайн мэдээнээс суралцах ажлын нэг хэсэг болгож судлахад урь. Сурсан зүйлээ ангийнхантайгаа хуваалцахад тэднийг дэмж.

Дараагийн Ерөнхий чуулган дөхөх үед өсвөр үеийнхнийг өөрсдийн асуултуудыг жагсаан бичиж, үүндээ хариулт авахын тулд чуулган дээр хэлэх үгсийг залбиралтайгаар сонсоход урь.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч үхээд, амилахынхаа өмнөхөн шавь нартаа тэднийг “бүх үнэн уруу ... ирэх зүйлийг Тэр та нарт мэдүүл[эхээр]” хөтлөх Ариун Сүнсийг илгээхээ заасан (Иохан 16:13). Тэрхүү Ариун Сүнс өсвөр үеийнхэнд заах болон туслах хамгийн сайн арга замыг мэдэхэд танд туслах болно.

Сонгосон материалууд

Хэнри Б.Айринг, “Хоёр эсвэл гурваараа хамтдаа цугларсан тэнд,” Ensign эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 3–6-аас эш татав

Аврагч мөнх бус амьдрал дахь тохинууллынхаа үеэр үр болон тариачны тухай сургаалт зүйрлэлийг бидэнд өгсөн. Үр бол Бурханы үг, харин тариачин бол Их Эзэн юм. Үр ургах эсэх нь хөрсний байдлаас шалтгаалж байв. Түүний үгсийг та нар санаж байгаа байх.

“Түүнийг үрээ цацахад зарим үр нь замын хавиар унасанд шувууд ирээд идчихлээ.

Зарим нь чулуурхаг газар унаж, хөрс нь гүн биш тул тэр дороо соёолов.

Гэвч нар гарахад үндэсгүй учир тэд хорчийн хатжээ.

Зарим нь хогийн ургамлын дунд унав. Хогийн ургамал ургаж тэднийг барьчихаж.

Зарим нь сайн хөрсөнд унаж ургаад, ургацаа өгөхөд зарим нь зуу, зарим нь жар, зарим нь гуч дахин их болов.

Сонсох чихтэй нь сонсогтун гэв” (Матай 13:4–9).

Дахин хэлэхэд үр нь Бурханы үг, харин хөрс нь үрийг хүлээн авч буй хүний зүрх сэтгэл юм.

. . . Бид үр буюу Бурханы үгийг нэгэн үе зүрх сэтгэлдээ суулгасан. Зарим нь хүүхэд насандаа эцэг эх нь эрх мэдэлтэй хүмүүсээр баптисм хүртээлгэн, батлуулахад урих үед хүлээн авсан бол зарим нь Бурханаар дуудагдсан үйлчлэгчдээр заалгахдаа хүлээж авсан. Хүн бүр үр нь сайн гэдгийг болон зүрх сэтгэл нь тэлж байгааг мэдэрсэн

бөгөөд зүрх сэтгэл, оюун ухаанаа тэлж байгааг мэдрэхдээ баяр хөөр болж байсан.

Хүсэн хүлээсэн адислал маань удаж, итгэлийг маань устгахыг хүсэгчдийн ширүүн дайралтад өртөн, нүгэлд уруу татагдахад мөн зүрх сэтгэлийнхээ сүнслэг хэсгийг хөгжүүлэн, зөөлрүүлэхийн тулд гаргаж буй хүчин чармайлтыг маань сааруулдаг аминч үзэл гэх мэт сорилтод бидний итгэл соригдож байдаг.

Гэхдээ өмнөх баяр баяслаа алдсандаа гутарч байгаа хүн адислагдсан хүн байдаг. Зарим хүн итгэл нь гундаж байгааг олж хардаггүй. *Сатан ухаантай*. Тэр зовоохыг хүсэж байгаа хүмүүстээ тэдний мэдэрч байсан баяр баясал хүүхэд насных нь төөрөгдөл байсан гэж хэлдэг.

Өнөөдөр би та нарт ирэх өдрүүдэд зүрх сэтгэлээ зөөллөн, үр хүлээн авч, тордох онцгой боломж бидэнд олдох болно гэсэн захиасыг өгөх гэсэн юм. Үр бол Бурханы үг бөгөөд энэ чуулганыг сонсож, үзэж, унших хүн бүрийн дээр асгарах болно. Дуу хөгжим, хэлэх үгс болон гэрчлэлийг Бурханы үйлчлэгчид Ариун Сүнсний удирдамжийг тууштай эрэлхийлэн бэлдсэн. Тэд чуулганы өдөр ойртох тусам илүү удаан, илүү даруухан залбирч байсан билээ.

Түүнчлэн тэд та нарыг Бурханы сайн үгийг хүлээн авч ургуулан, үр жимсээ өгөх үржил шимтэй хөрсийг зүрх сэтгэлдээ бий болгохоор зөв сонголт хийхэд нөлөөлөх хүчтэй байхын төлөө залбирсан. Та нар Сүнстэй байж сонсвол зүрх сэтгэл тань зөөлрөн, итгэл тань хүчирхэгжиж, Их Эзэнийг хайрлах хайр тань нэмэгдсэн байхыг олж мэдэх болно.



ТАВДУГААР САР: БОШИГЛОГЧИД БА ИЛЧЛЭЛТ

Би судраас хэрхэн илүү үр дүнтэй суралцаж болох вэ?

“Христийн үгэн дээр найрлах” (2 Нифай 32:3) гэсэн сүнслэг тушаал нь судруудыг хайнга уншихаас хамаагүй илүү утга санааг агуулж байгаа юм. Бид тэдний заасан зүйлийг тунгаан бодож, эдгээр зүйлийг өөрсөдтэйгээ адилтган, хичээнгүйлэн хайх хэрэгтэй. Бид ойлгохын төлөө залбирч, Ариун Сүнсний өдөөлтийг дагах ёстой. Судруудыг гүн гүнзгий судлах нь биднийг итгэлтэй байхад тусалж, уруу таталтаас хамгаалан мөн Тэнгэрлэг Эцэгтээ ойр байхад тусалдаг.

Судрууд таны амьдралд хэрхэн нөлөөлсөн бэ?

Та судрыг илүү үр дүнтэй судлахын тулд юу хийсэн бэ?

Танай ангийн өсвөр үеийнхэн судруудын талаар сайн туршлагатай болж байна уу? Та тэднийг судраас илүү үр дүнтэй судлахад яаж тусалж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар, материалыг залбирч уншаарай. Өсвөр үеийнхнийг судраас илүү сайн суралцахад юу тусална гэж та үзэж байна вэ?

Исаиа 34:16; 1 Нифай 10:19; С ба Г 88:63, 118 (Бид хайвал олох болно)

1 Нифай 19:23 (Бид судруудыг өөрсөдтэйгээ адилтгах хэрэгтэй)

Дуулал 119:105; 2 Нифай 4:15–16; С ба Г 138:1–11; Иосеф Смит—Түүх 1:11–13 (Судруудыг тунгаан бодох нь илчлэлт авчирдаг)

2 Нифай 32:3 (Бид Христийн үгэн дээр найрлах ёстой)

С ба Г 138:1–11 (Бурханы үгийг судал)

Дэвин Ж.Дуррант, “Би зүрх сэтгэлдээ тэдгээрийг үргэлж тунгаадаг,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2015 оны 11-р сар, 112–115

Хэнри Б.Айринг, “Судраас суралцах нь сэдвээр хийсэн ярилцлага,” *Ensign*, 2005 оны 7-р сар, 22–26

Дэвид А.Бэднар, “Амьд усны эх булаг,” Залуучуудад зориулсан Сүмийн Боловсролын Сангийн галын дэргэдэх ярилцлага, 2007 оны 4-р сарын 4

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний хэдэн минутад өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, Сүмийн бусад хичээл эсвэл найзуудтайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний хамаарлыг олж харахад нь та нар тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болно:

- Энэ долоо хоногт хувиараа суралцаж байхдаа судраас сурсан зүйлээ хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс. Судар судлах тэдний төлөвлөгөө юу вэ? Судраас илүү үр дүнтэй судлах талаар тэд юу бодож байна вэ?

- Самбар дээр “Судруудад гүн умбах нь сүнслэг тэжээлд маш чухал ач холбогдолтой” (Квинтин Л.Күк,

“Та нар одоо тийн мэдэрч чадаж байна уу?” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2012 оны 11-р сар) гэж бич. Өсвөр үеийнхнээс судруудад өөрсдийгөө умбуулах гэдэг нь ямар утгатай болохыг асуу. Энэ нь судруудыг зүгээр уншихаас ямар ялгаатай вэ? Хичээлийн үеэр судар судлах талаар суралцах үедээ энэ тухай бодохыг нь дэмж.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаанууд нь өсвөр үеийнхэнд судраас илүү үр дүнтэй суралцахад туслах болно. Сүнслийн удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Судраас суралцахаа сайжруулах нэг арга зам бол хувиараа судраас судлахдаа долоо хоногийн турш анхаарлаа хандуулах нэг шүлгийг олох явдал юм (Дэвин Ж.Дуррантын “Миний сэтгэл тэдгээрийг үргэлж тунгаадаг” үгийг үзнэ үү.) Хичээл эхлэхээс долоо хоногийн өмнө ангийн хэд хэдэн гишүүнийг Дуррант ахын хэлсэн үгийг уншаад, нэг судрыг “тунгаажлахад” урь. Тэдэнд ангидаа туршлагаасаа хуваалцах цаг гаргаж өг. Самбар дээр “Бид судраас судлах үйл явцаа хэрхэн сайжруулж болох вэ?” гэж бичээд, өсвөр үеийнхнийг Дуррант ахын хэлсэн үгээс санал болгосон зүйлс болон хувиараа ба гэр бүлээрээ судлахдаа ашигладаг арга барилаасаа хуваалцахад урь.

- Самбар дээр *хайх, тунгаан бодох, залбирах* гэсэн үгсийг бич. Өсвөр үеийнхнийг энэхүү тоймд санал болгосон судраас аль нэгийг уншин, тэрхүү судраас сурсан зүйлээ ангийнхантайгаа хуваалцахыг урь. Судрын эшлэлээ тэдний заасан

зарчмуудыг харуулсан самбар дээрх үгсийн хажууд бичихийг хүс. Өсвөр үеийнхэн судраас үр дүнтэй суралцах бусад ямар зарчмын талаар бодож байна вэ? Тэд эдгээр зарчмыг харуулсан судрын өөр хэсгүүдийг мэдэх үү?

- Самбар дээр ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн “Судрыг суралцах нь сэдвээр хийсэн ярилцлага” нийтлэлээс зарим асуултыг бич. Энэхүү нийтлэл нь таны зааж буй өсвөр үеийнхэнд хамгийн их хамаатай юм. Тэднээс эдгээр асуултын хариултуудаа хуваалцахыг хүсээд, ерөнхийлөгч Айрингийн хариултуудыг унших хугацаа өг. Судраас илүү үр дүнтэй суралцахад туслах ерөнхийлөгч Айрингийн хариултуудаас тэд юу сурдаг вэ?

- Өсвөр үеийнхэнд ХҮГ-ийн хэвлэн гаргасан судруудыг сурахад туслах материалуудыг танилцуул (хуудасны зүүлт тайлбар, бүлгийн гарчиг, сэдэвчилсэн тайлбар гэх мэт). Сурахад туслах эдгээр материал нь тэдэнд судраас хэрхэн илүү

Заахад туслах арга

“Ангидаа та тэдний царайг, тэд таны царайг харж сууж болохуйцаар сандлуудаа байрлуул”.

үр дүнтэй суралцахаа ойлгоход тусалдаг. Бишопын зөвшөөрлөөр тойргийн гишүүдийг урьж авчран, тэд хэрхэн судраас илүү үр дүнтэй суралцсан тухай нь яриул.

- Өсвөр үеийнхнээс судраас өнөөдрийн сурсан зарчимтай холбоотой нэг бүлгийг сонгон уншихыг хүс. Эндээс сурсан зүйлээ хуваалцахыг тэднээс хүс.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд судраас хэрхэн илүү үр дүнтэй судлах тухай ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхнийг хувиараа судар суралцах төлөвлөгөөнийхөө талаар бодохыг урь. Өнөөдөр тэд төлөвлөгөөг нь сайжруулах юуг сурсан бэ?

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч бусдад зааж, гэрчлэхдээ судруудыг ашигладаг байсан. Тэрбээр хүмүүст судруудыг тунгаан бодож, асуултуудынхаа хариултыг олохын тулд тэдгээрийг ашиглахыг заасан. Өсвөр үеийнхэнд асуултынхаа хариултыг олохын тулд судруудаа ашиглахад нь та хэрхэн тусалж болох вэ?

Сонгосон материалууд

Хэнри Б.Айрингийн хэлсэн“ Судрыг суралцах нь сэдвээр хийсэн ярилцлага” үгээс эш татав. Лиахона 2005 оны 7-р сар, 8

Судрын уншлагаа илүү утга учиртай болгохын тулд та юу хийсэн бэ?

Ахлагч Айринг: Намайг Арванхоёр Төлөөлөгчийн Чуулганд ирэхэд Ахлагч Ричард Г.Скотт үнэтэй биш судрын цуглуулга худалдаж аваад шинэ дуудлагад маань хэрэг болох ойлголтууд хийгээд илчлэлтүүдийг тэмдэглэхийг надад санал болгосон юм. Би хэлснээр нь хийсэн. Гэхдээ би арай илүүт хийсэн.

Би Тэнгэрлэг Эцэгээс түүний Төлөөлөгчийн хувьд Тэр надаар юу хийлгэхийг хүсч байгааг асуусан. Би Түүний хариултуудаас юу мэдэрснээ бичиж авсан билээ. Би эдгээр хариултуудыг бичгийн машинаар бичээд, өнгөөр ялган судрынхаа нүүрэнд наав. Жишээ нь: эхнийх нь “Би Бурханы Хүү болох Христийг гэрчлэгч болох ёстой” гэж байсан. Тэгээд би судруудаа уншиж байхдаа Бурханы Хүү Христийг хэрхэн гэрчлэхийг надад зааж чадах санаануудыг эрж хайсан. Ямар нэгэн санааг олох болгондоо би үүнийгээ хөхөөр тэмдэглэдэг байв. Удалгүй би Их Эзэн надаар юу хийлгэхийг хүсч байгаа талаарх өөрийн гэсэн сэдэвчилсэн удирдамжтай болсон. Би үүнийг хийснээрээ маш их зүйлийг сурсан.

Юу хийх хэрэгтэйгээ мэдэхийн тулд судраас суралцсан нь бүх зүйлийг өөрчилдөг. Их Эзэн бидэнд зааж чадна. Бидний амьдралд үр хүүхдээ эсвэл хань ижлээ алдах хэцүү цаг үе тохиолдоход бид онцгой тусламж эрэн сударт хандах ёстой. Бид судруудаас хариултаа олно. Их Эзэн бидний бүх асуудал болон хэрэгцээг урьдчилан мэддэг юм шиг санагддаг бөгөөд хэрэв бид эрэлхийлэх л юм бол—бидэнд зориулагдсан тусламжийг Тэрээр сударт байрлуулсан байдаг.

Хожмын үеийн гэгээнтнүүд судар уншихаа хэрхэн нэн тэргүүнд тавих вэ?

Ахлагч Айринг: Судар унших цагийг завгүй хуваариасаа шахаж гаргахгүй байх цорын ганц арга нь судар унших тогтмол цагтай болох явдал юм. Өдрийн эхлэл болон төгсгөлийг өөрийнхөөрөө байлгаж болдог гэдгийг би мэдсэн бөгөөд эдгээр цагуудыг л ихэвчлэн хянаж чаддаг. Би хөвгүүн байхаасаа л өглөө болон орой судар унших дадалтай байсан юм. Энэ дадлынхаа ачаар 18 нас хүрэхээсээ өмнө Мормоны номыг олон удаа уншсан байсан.

Энэ дадлаа дагаагүй үед надад маш хэцүү байдаг. Та нар судраас тогтмол судлаад эхэлчихвэл уншаагүй үедээ үүнийгээ үгүйлдэг болно. Энэ нь заавал идэх ёстой хоолтой адил юм. Надад хоол хэрэгтэй байдаг шиг судрууд хэрэгтэй гэдгийг би мэднэ. Би хоолоо тогтмол иддэг шиг судраа тогтмол уншдаг.

Судар уншихад мацаг барих ба залбирах нь ямар үүрэгтэй вэ?

Ахлагч Айринг: Бидэнд юу хийхийг заахыг гуйж бид мацаг барих хэрэгтэй; бид яг хүүхэд шиг даруу мөн хүсэлтэй байх хэрэгтэй. Мацаг барина гэдэг нь үүнийг зөв хийхийг шаарддаг. Зүгээр л хэдэн хоол дараалан идэхгүй байснаар мацаг барьж байгаа гэсэн үг биш юм.

Үүний нэгэн адил бид мацаг барьж байхдаа даруу мөн хүсэлтэйгээр судраас унших хэрэгтэй. Бидэнд юу хийхийг заахыг хүсч судраас судалж байхдаа мацаг барих нь маш ихээр тусалдаг билээ.

Судраас уншихад Ариун Сүнсний үүрэг юу вэ?

Ахлагч Айринг: Биднийг уншиж байхад Ариун Сүнс Бурханы үгийг бидэнд баталдаг. Тэр баталгаа нь олон дахин давтагдсанаар, бидний итгэлийг хүчирхэгжүүлдэг. Тийн бид итгэлээрээ саад бэрхшээлүүдийг даван туулж, уруу таталтыг эсэргүүцэн зогсдог билээ.



ТАВДУГААР САР: БОШИГЛОГЧИД БА ИЛЧЛЭЛТ

Бишрэл хүндэтгэлтэй байх нь намайг илчлэлт хүлээн авахад хэрхэн туслах вэ?

Бид бишрэл хүндэтгэлтэй байхдаа Бурханд өөрсдийн хайраа харуулдаг ба бид хувийн илчлэлтээ хүлээн авах боломжтой болдог. Бишрэл хүндэтгэлтэй байх нь биднийг Сүнсний намуухан дуу хоолойг мэдрэхэд тусалдаг. Хэрвээ бид ариун нандин зүйлд бишрэл хүндэтгэлтэй хандвал Тэнгэрлэг Эцэг бидэнд итгэж, илүү олон үнэнийг нэмж илчлэх болно.

Бишрэл хүндэтгэлтэй байдал гэдэг нь таны хувьд юу гэсэн утгатай вэ? Бишрэл хүндэтгэлтэй байдал тань Сүнсийг мэдрэхэд танд хэрхэн тусалсан бэ? Ямар туршлагыг та өсвөр үеийнхэнтэй хуваалцаж болох вэ?

Танай ангийн өсвөр үеийнхэнд бишрэл хүндэтгэл ямар учир утгатай байдаг вэ? Тэдэнд бишрэл хүндэтгэл ба илчлэлтийн хоорондох уялдаа холбоог мэдэхэд та хэрхэн тусалж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар ба материалуудыг залбирч судал. Өсвөр үеийнхэнд бишрэн хүндэтгэх мэдрэмжийг бий болгоход юу тусалж болно гэж та үзэж байна вэ?

1 Хаадын дээд 19:12; 3 Нифай 11:1–7 (Их Эзэн намуун дуу хоолойгоор харьцдаг)

Дуулал 46:10 (“Тэмцэлдэхээ больж, намайг Бурхан гэдгийг мэд”)

С ба Г 63:64; 84:54–57 (Ариун нандин зүйлст бишрэл хүндэтгэлтэй ханд)

Бويد К.Пакэр “Бишрэл хүндэтгэл нь илчлэлтийг урьдаг” *Ensign*, 1991 оны 11-р сар, 23.

Паул Б.Фийпэр “Ариун нандин хэвээр нь хадгал” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2012 оны 5-р сар, 109–11

“Бишрэл хүндэтгэл” *Итгэлдээ үнэнч байх нь* (2003), 51

“Илчлэлт” *Итгэлдээ үнэнч байх нь* (2003), 109–113

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний хэдэн минутад өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, Сүмийн бусад хичээлүүд, эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний хамаарлыг олж харахад нь та нар тэдэнд яаж тусалж чадах вэ? Эдгээр санаанууд тусалж болно:

- Өсвөр үеийнхнээс бусад хичээлүүд дээр сурсан зүйлсийн талаарх аливаа асуултаа хуваалцахад урь.
- Самбар дээр “Бишрэл хүндэтгэл бол _____ юм.” гэж бич. Ангийн гишүүдээс самбар руу ирээд

бишрэл хүндэтгэлийн тодорхойлолтыг бичихийг хүс. Өсвөр үеийнхнийг эдгээр тодорхойлолтууд дээр

өнөөдрийн хичээл дээр бишрэл хүндэтгэлийн талаар сурсан зүйлээ нэмж бичихэд урь.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаанууд нь өсвөр үеийнхэнд бишрэл хүндэтгэл ба илчлэлтийн хоорондох холбоог ойлгоход туслах болно. Сүнсний удирдалжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Өсвөр үеийнхнээс “Бишрэл хүндэтгэл” гэсэн хэсгийг *Итгэлдээ үнэнч байх нь* товхимлоос эсвэл “Ариун нандин хэвээр нь хадгал” хэмээх Ахлагч Паул Пийпэрсийн ярианаас уншин “Бишрэл хүндэтгэлтэй байх нь илчлэлт хүлээн авахад надад хэрхэн тусалдаг вэ?” гэсэн асуултын хариултыг хайхыг хүс. Эндээс сурсан зүйлийнхээ талаар хуваалцахад тэднийг урь. Улам их бишрэл хүндэтгэлтэй болохын тулд тэд юу хийж болох вэ?

- Ангийнхныг жижиг бүлгүүдэд хуваан бүлэг бүрийг энэхүү тоймд санал болгосон нэг эсвэл хоёр судар хамтдаа судлахыг хүс. Бишрэл хүндэтгэл ба илчлэлтийн хоорондох

харьцааны талаар эдгээр судраас юу сурснаа тэднийг ярилцахыг урь. Сурсан зүйлээ бусадтайгаа хуваалцахыг бүлэг бүрээс хүс.

- Өсвөр үеийнхнийг ерөнхийлөгч Боид К.Пакэрын “Бишрэл хүндэтгэл нь илчлэлтийг урьдаг” хэлсэн үгнээс сүмийн цуглаан дээр илчлэлтийг урихын тулд бидний хийх ёстой зүйлсийг олж мэдэхийг хүс. Энэ талаар олж мэдсэн зүйлээ хуваалцаж ерөнхийлөгч Пакэрын өгсөн бусад нөхцөл байдал эсвэл ариун нандин зүйлсийг бишрэн хүндэтгэх талаарх зөвлөмжийг тайлбарласан арга замуудыг санал болгохыг тэднээс хүс (ариун сүм, судрууд гэх мэт).

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээ хуваалцахыг хүс. Бишрэл хүндэтгэл нь илчлэлттэй ямар уялдаа холбоотойг тэд сурсан уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Заахад туслах арга

“Бид сайн мэдээний сургаалыг судлахаар цуглахдаа бишрэл хүндэтгэлийн сүнсстэй байх ёстой. ... Хүндэтгэл бишрэлгүй байдал нь оюун ухаан мөн сүнсэнд ирэх илчлэлтийн нандин сувагт саад болдог. ... Бишрэл хүндэтгэл нь илчлэлтийг урьдаг” (Боид К.Пакэр *Teaching, No Greater Call* [1999], 82).

Аврагчийн арга барилаар заах нь

Бүхий л нөхцөл байдалд Аврагч шавь нартаа үлгэр жишээ бас агуу зөвлөгч нь болдог байлаа. Тэрээр ганцаар залбирч, мацаг барин заахад Өөрийгөө бэлтгэдэг байв. Бишрэл хүндэтгэл нь хувийн илчлэлтээ хүлээн авахад бэлтгэхэд танд хэрхэн тусалдгийг өсвөр үеийнхэнтэй хуваалц. Та тэднийг ариун зүйлсийг хүндэтгэдгээ харуулахад нь дэмж.

Үйлдэхэд урь

Илчлэлт хүлээн авахад бишрэл хүндэтгэлтэй байхын ач холбогдлын талаар өнөөдөр юу сурсныг өсвөр үеийнхнээс асуу. Хувийн илчлэлтээ илүү сайн хүлээн авахын тулд өөрсдийн биеэ авч явах байдал эсвэл эргэн тойрноо тэд хэрхэн өөрчилж болох вэ?

Сонгосон материалууд

Бонд К.Пакэрын “Бишрэл хүндэтгэл нь илчлэлтийг урьдаг” хэлсэн үгээс эш татав. Ensign, 1991 оны 11-р сар, 21–23

Бидний ариун ёслол болон бусад цуглаануудад гишүүд нь сүнсээр тэжээгдэн гэрчлэлүүд нь өсөн нэмэгдэж, сонирхогчид нь сүнслэг хөрвөлтөд хөтлөгдөх чухал өдөөлтийг мэдрэх үнэхээр хүндэтгэл бишрэлийн цуглаанууд байхад шинээр анхаарлаа хандуулах шаардлагатай байна. . . .

Бид ням гаргийн цуглаанд ирэхдээ хөгжим, хувцаслалт ба биеэ авч явах байдал зэрэг нь шүтэн бишрэхэд тохирсон байх ёстой. Цуглааны байруудын үүдний танхим нь хүмүүстэй мэндлэх ба бие биенээ сайн мэддэг хүмүүсийн хувьд яриа өрнүүлэх боломжтой газар юм. Гэсэн хэдий ч бид цуглааны байр руу орохдоо *бидний нэг бүр* хэн нэгнийг *сүнслэг байдлын хувьд* эмзэг байх үед нь улам таагүй болгох ямар нэгэн буруу зүйл хийх вий хэмээн болгоомжилж байх ёстой! . . .

Цуглааны байруудад биеэ хүндэтгэлгүйгээр авч явах нь зэмлэл биш юм аа гэхэд зохистой байдлын талаар сануулбал зохилтой зүйл юм. Удирдагчид хүндэтгэл бишрэл нь илчлэлтийг урьдаг гэдгийг заах хэрэгтэй. . . .

Хөгжим бол бидний шүтэн бишрэх үйлчлэлд асар чухал үүрэгтэй байдаг. Цуглаан дээр хөгжим сонгож, удирдаж, тоглон, дагаж дуулж байгаа тэдгээр хүмүүс нь үг хэлж байгаа хүнээс илүү бишрэл хүндэтгэлийн сүнсээр нөлөөлж чаддаг гэдэгт би итгэдэг. Бурхан тэднийг адислах болтугай.

Хөгжим нь илчлэлт ба гэрчлэлийн сүнсийг урьдаг шүтэн бишрэх уур амьсгалыг бий болгодог. . . .

Сүмийн дууллын эхлэл хөгжмийг намуухан тоглох хөгжимчин нь бидний мэдрэмжийг өөрчлөн

хаант улсын амар амгаланг заадаг дууллын үгсийг бидний оюун ухаанд хүлээн авахаар болгодог. Хэрэв бид Сэргээлтийн дуулуудыг анхааралтай сонсвол сайн мэдээ ба сургаалын зарчмуудыг зааж байдаг!

Цуглааны дуунуудыг дуулдаггүй удирдагч ба гишүүдийн тоо ихэсч байгааг би анзаарлаа. Магадгүй, тэд тэдгээр дуунуудыг мэддэггүй эсвэл дууллын ном хангалттай байхгүй байж болно. Бид Сионы дуунуудыг дуулах хэрэгтэй. Тэдгээр нь бидний хүндэтгэл бишрэлийн нэгээхэн чухал хэсэг юм. Бид сүмийн дуулалд мөн Сэргээлтийн магтан дуунуудыг ч тоомсорлохгүй байж болохгүй. Их Эзэн хэлэхдээ: “Учир нь зүрх сэтгэлийн дуунд сүнс минь баярлах авай; тийм ээ, зөв шударгыг үйлдэгчдийн дуу нь надад хандсан залбирал бөлгөө, мөн энэ нь тэдний тэргүүн дээр адислалаар хариулагдах болно” хэмээв. (С ба Г 25:12) Бидний ариун хөгжмийг биднээс холдох боломж бүү олго мөн үүнийг шашны бус дуу хөгжмөөр ч бүү орлуул. . . .

Бас нэг зүйл гэвэл: Бид залбиралдаа хүндэтгэл бишрэлийн үгсийг ашиглахгүй байна. Бид залбиралдаа *та (you)* болон *таны (yours)* гэсэн үгсийн оронд *Та (thee)* болон *Таны (thine)* гэсэн үгсийг хэрэглэдэг. Бид Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирахдаа хүндэтгэл бишрэлийн үгс, үг хэллэг хэрэглэдэг гэдгийг хүүхдүүддээ зааж, шинэ гишүүдэд эвтэйхэн хэлээрэй.

Бидний хэн маань ч хувийн сүнслэг байдалгүйгээр удахгүй тохиолдох зүйл байтугай өнөөгийн дэлхийд тэсвэрлэн үлдэж чадахгүй билээ. Хүндэтгэл бишрэлийн сүнс нь Сүмийн бүх байгууллагууд болон гишүүн бүрийн амьдралд ил байж чадах бөгөөд ийм байх хэрэгтэй юм.



ТАВДУГААР САР: БОШИГЛОГЧИД БА ИЛЧЛЭЛТ

Гэрчлэл хуваалцана гэдэг нь юу гэсэн үг вэ?

Гэрчлэл бол Ариун Сүнсээр өгөгддөг, сайн мэдээний үнэний сүнслэг гэрч юм. Бид гэрчлэл хуваалцах үедээ бусдад өөрсдийн мэддэг зүйлийнхээ үнэн гэдгийг Сүнсний хүчээр тунхагладаг. Гэрчлэлийн үндэс суурь нь Тэнгэрлэг Эцэг амьд, биднийг хайрладаг, Есүс Христ бол бидний Аврагч, Түүний сайн мэдээ бошиглогч Иосеф Смитээр сэргээгдсэн бөгөөд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол Аврагчийн үнэн сүм гэдэг мэдлэг юм.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалуудыг залбирч судлаарай. Өсвөр үеийнхэнд гэрчлэл хуваалцах гэдэг нь ямар утгатай болохыг ойлгоход нь юу тусалж болох вэ?

Матай 16:13–19; Мозая 3:17; Алма 5:45–48; 7:13; С ба Г 76:22–24 (Судрууд дахь гэрчлэлүүдийн жишээнүүд)

Алма 4:18–20 (Гэрчлэл хуваалцахаас ирдэг хүч)

Алма 11:39–41; 12:1; 15:12 (Зиезромд хүчтэй нөлөөлсөн Амюлекийн гэрчлэл)

Хэнри Б. Айринг, “Бурханы гэрчүүд” *Ensign*, 1996 оны 11-р сар, 30–33

Дийтр Ф. Угдорф, “Хувийн гэрчлэлийн хүч” *Ensign* эсвэл *Лиахона*, 2006 оны 11-р сар, 37–39

Даллин Х. Өүкс “Гэрчлэл” *Ensign* эсвэл *Лиахона*, 2008 оны 5-р сар, 26–29

“Гэрчлэлээ ойр ойрхон хуваалц,” *Миний сайн мэдээг номло* (2004), 225–226

“Гэрчлэлээр заах нь,” *Teaching, No Greater Call* (1999), 43–44

Видео бичлэгүүд: “Уран үггүй хүн,” “Томас С. Монсоны гэрчлэл”; *Сургаал ба Гэрээний болон сүмийн түүхийн үзүүлэнгүүд* (DVD)

Бусдын гэрчлэл танд хэрхэн нөлөөлсөн бэ?

Та албан ёсоор эсвэл энгийн ярианы хэлбэрээр хуваалцсанаар гэрчлэлээ хэрхэн хүчирхэгжүүлсэн бэ? Та ямар туршлагыг өсвөр үеийнхэнтэй хуваалцаж болох вэ?

Өсвөр үеийнхэн алба ёсоор эсвэл энгийн ярианы хэлбэрээр гэрчлэлээ хуваалцахыг нь та хэзээ харсан бэ? Та тэдэнд гэрчлэлээ хуваалцах ямар боломжуудыг олгож болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний хэдэн минутад өсвөр үеийнхний янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд, эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа

холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний хамаарлыг олж харахад нь та нар өсвөр үеийнхэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Тэдний гэрчлэлийг хүчирхэг-жүүлсэн саяхны тохиолдлоосоо хуваалцахад өсвөр үеийнхнийг урь.
- Найзыгаа мацгийн ням гарагт сүмд ирэхийг урьсан ба бишоп нь тойргийн гишүүдийг гэрчлэлээ хуваалцахад урьсан хэмээн төсөөлж

бодохыг өсвөр үеийнхнээс хүс. Хэрэв найз нь “Гэрчлэл хуваалцана гэдэг нь юу гэсэн үг вэ?” гэж асуу-вал тэд юу гэж хариулах байсан бэ? Шаардлагатай бол “Гэрчлэл гэж юу вэ?” гэсэн хэсгийг *Teaching, No Greater Call*-ын 43–44 хуудаснаас лавлаж харахыг хүс.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаанууд нь өсвөр үеийнхэнд гэрчлэлээ хуваалцах гэдэг нь юу гэсэн үг болохыг ойлгоход нь тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс олон үйл ажиллагааг сонгоно уу:

- Ерөнхийлөгч Дийтр Ф. Угдорфын “Хувийн гэрчлэлийн хүч” хэлсэн үгээс эш татсан “Гэрчлэл гэж юу вэ?” хэсгийг уншихыг тэднээс хүс. Уншсан зүйл дээрээ үндэслэн юу гэрчлэл болох, юу гэрчлэл биш болохыг жагсаан бичихийг өсвөр үеийнхнээс хүс. Тэдний итгэл ба гэрчлэлийг хүчирхэгжүүлсэн хэн нэгний гэрчлэлийг сонссон талаараа хуваалцахыг тэднээс хүс.
- Ахлагч Даллин Х. Өүксийн “Гэрчлэл” хэлсэн үгийн 2 дахь хэсгийг уншихдаа гэрчлэл болон мэдлэгийн бусад төрлүүдийн адил төстэй болон ялгаатай талуудыг олж мэдэхэд өсвөр үеийнхнийг урь. Сайн мэдээ үнэн гэдэг мэдлэгээ бататгахын тулд өсвөр үеийнхэн юу хийж болох вэ?
- Гэрчлэлээ хуваалцсан хүмүүсийн жишээг судруудаас олохыг тэднээс хүс (энэхүү тоймд санал болгосон хүмүүс гэх мэт). Олж мэдсэн зүйлээ

хуваалцах үед гэрчлэлээ хуваалцаж болох өөр өөр арга замуудын талаар (жишээ нь албан болон албан бус байдлаар) ярилцахад тэднийг дэмж. “Томас С. Монсоны гэрчлэл” видео бичлэгийг үзнэ үү. Гэрчлэлээ хуваалцах талаар ерөнхийлөгч Томас Монсоноос сурсан зүйлээ хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс.

- “Гэрчлэлээ ойр ойрхон хуваалц” хэсгийг уншихыг өсвөр үеийнхнээс хүсээд *Миний сайн мэдээг номло* гарын авлагын 225–226-р хуудсан дээр хавсаргасан хувиараа суралцах үйл ажиллагааг хийж дуусгахад тэднийг урь. Ангийнхантайгаа санаа бодлоо хуваалцахыг тэднээс хүс. Дараагийн удаа гэрчлэлээ хуваалцах үедээ тэд сурсан зүйлээ хэрхэн хэрэгжүүлж болох вэ (сүмийн цуглаан дээр эсвэл найзтайгаа ярилцахдаа)?
- “Уран үггүй хүн” видео бичлэгийг үзүүл. Бусдын энгийн мөртлөө

Заахад туслах арга

“Богино, оновчтой, шулуухан гэрчлэл хамгийн хүчтэй байх нь олонтоо” (*Teaching, No Greater Call* [1999], 43).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч өөрийн заасан хүмүүсээ бусдад гэрчлэлээ хуваалцахад урьсан бөгөөд тэд ийн хуваалцсанаар Сүнсийг зүрх сэтгэлдээ мэдэрсэн юм. Та өсвөр үеийнхэнд гэрчлэлээ хуваалцан мөн Сүнсийг мэдрэх ямар боломжуудыг өгч болох вэ?

чин сэтгэлийн гэрчлэлд сэтгэл нь догдолсон тохиолдлоосоо хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс. Чухам

ямар гэрчлэл тэдний зүрх сэтгэлийг догдлуулсан бэ?

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээ хуваалцахыг хүс. Гэрчлэл хэрхэн хуваалцахаа тэд мэдэж байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхнийг ирэх долоо хоногт албаны болон энгийн ярианы хэлээр гэрчлэлээ хуваалцах боломжийг эрэлхийлэхэд урь. Дараагийн хичээл дээр тэднийг энэ тухайгаа хуваалцахыг хүс.

Өдрийн тэмдэглэлдээ гэрчлэлээ бичихэд нь өсвөр үеийнхнийг дэмж.

Сонгосон материалууд

Дийтр Ф.Угдорфын “Хувийн гэрчлэлийн хүч” хэлсэн үгээс эш татав. *Ensign* эсвэл Лиахона 2006 оны 11-р сар, 37–39

Гэрчлэл гэдэг үгийн нэг тодорхойлолт бол “гэрч” гэсэн утгатай *testimonium* ба *testis* гэдэг Латин гаралтай эдгээр үгсээс үүссэн ба “аливаа зүйлийг үнэнийг гэрчлэн мэдүүлэх” гэсэн утгатай юм. (“*Testimony*,” <http://www.reference.com/browse/wiki/Testimony>; Merriam-Webster’s Collegiate Dictionary, 11th ed. [2003], “*testimony*,” 1291).

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдийн хувьд гэрчлэл гэдэг үг нь бид шашныхаа талаар ярихдаа хэрэглэдэг танил, дотно үг билээ. Энэ бол хүндэтгэлтэй бас дотно үг юм. Энэ үгэнд тодорхой, ариун нандин байдал хадгалагдаж байдаг. Бид гэрчлэлээ хуваалцахдаа логик, бодит баримтуудын цуглуулгаас илүүтэйгээр бидний зүрх сэтгэл, оюун ухааны мэдрэмжийн талаар дурддаг билээ. Энэ нь Сүнсний бэлэг бөгөөд тодорхой төсөөллүүд нь үнэн хэмээдэг Ариун Сүнснээс ирсэн гэрч юм.


Гэрчлэл бол Ариун Сүнснээс ирдэг үнэний баттай мэдлэг буюу баталгаа бөгөөд хожмын өдрүүд дэх Их Эзэний ажлын тэнгэрлэг байдал юм. Гэрчлэл бол “Есүс Христийн сайн мэдээний илчлэгдсэн үнэнүүдийн хувиршгүй, амьд, [ба] сэтгэл хөдөлгөсөн” *итгэл үнэмшил юм.* (Марион Г.Ромней “How to Gain a Testimony,” *New Era*, 1976 оны 5-р сар, 8; тодотгол нэмэгдсэн).

Бид гэрчлэлээ хуваалцахдаа сайн мэдээний захиасуудын туйлын үнэнийг тунхагладаг билээ. Үнэнийг харьцангуй хэмээн олонх нь ойлгодог цаг үед туйлын үнэний тухай тунхаг нь их түгээмэл

биш байдаг ба улс төрийн хувьд ч зөв зүйтэй эсвэл цагаа олсон байдаггүй. Хүн төрөлхтөнд мөнхийн үр дагавартай учраас юмсын “зүйлүүдийг байгаагаар нь” (Иаков 4:13) гэрчилдэг гэрчлэлүүд нь зоригтой, үнэн бас нэн чухал юм. Хэрэв бид нөхцөл байдалтайгаа уялдуулан өөрчилж бидний итгэл ба сайн мэдээний захиасыг тунхагладаг байсан бол Сатан татгалзахгүй байх байлаа. Сайн мэдээний үнэний баттай нотолгоо нь бидний амьдралд зангуу болдог бөгөөд Алтан Гадас лугаа адил хөдөлшгүй ба найдвартай байдаг. Хүн бүр ер бусын өвөрмөц байдаг учраас гэрчлэл нь маш хувийн шинжтэй бөгөөд хүн бүрийн хувьд бага зэрэг өөр байж болох ч Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний гэрчлэл нь дараах ойлгомжтой ба энгийн үнэнүүдийг үргэлж агуулж байдаг:

- Бурхан амьд. Тэр Тэнгэр дэх бидний хайртай Эцэг бөгөөд бид Түүний хүүхдүүд юм.
- Есүс Христ бол амьд Бурханы цорын ганц Хүү бөгөөд энэ дэлхийн Аврагч билээ.
- Иосеф Смит бол Бурханы бошиглогч бөгөөд Есүс Христийн сайн мэдээг хожмын үед сэргээсэн юм.
- Мормоны Ном бол Бурханы үг.
- Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли, түүний зөвлөхүүд мөн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд бол бошиглогчид, үзмэрчид, мөн энэ цаг үеийн илчлэгчид юм.

Бид Ариун Сүнсний хүч болон бэлгээр эдгээр үнэнүүдийн гүнзгий мэдлэгийг болон авралын төлөвлөгөөг олж авснаар “бүх зүйлийн үнэнийг мэдэх” мэдлэгт хүрч чадна. (Моронай 10:5)



Сүнсний мэдрэмжийг дагах талаар ерөнхийлөгч Монсоноос би юу сурч болох вэ?

Ерөнхийлөгч Томас С.Монсон хэлэхдээ: “Би Тэнгэр дэх Эцэгтэйгээ залбирч харилцаагүй өнгөрөөсөн нэгээхэн ч өдөр байхгүй. Би Тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцаагүй бол гарцаагүй төөрөлдөх байсан учраас энэхүү харилцаагаа эрхэмлэн дээдэлж хайрладаг билээ. Хэрэв та нар Тэнгэр дэх Эцэгтэйгээ ийм харилцаа холбоо тогтоогоогүй бол би та нарыг өмнөө зорилго тавин, ажиллаж эхлээсэй хэмээн хүсч байна. Ингэж чадваас энэ дэлхий дэх аялынхаа туршид сүнслэг байдлаа хадгалж үлдэхэд бидний хүн нэг бүрд зориулан амьдралын маань хэрэгцээ, шаардлагуудад туслах Түүний урам хийгээд удирдамжийг хүртэх эрхтэй байх болно. Ийм сүнслэг байдал, урам, удирдамж нь биднийг эрэлхийлсэн үед л харамгүйгээр өгөгддөг бэлэг юм. Эдгээр нь ямар их үнэ цэнэтэй зүйлс вэ! Тэнгэрлэг Эцэг маань надтай сүнслэг урмаар дамжин харилцах үед би үргэлж даруусгагдаж мөн талархалтай байдаг. Би үүнийг таньж мэдэхийг, үүнд итгэхийг мөн үүнийг дагахыг сурсаар байгаа билээ” (“Ариун газарт зогсох нь” *Ensign* эсвэл *Лиухона*, 2011 оны 11-р сар, 84).

Ариун Сүнсний өдөөлтийг дагасан нь таны амьдралыг хэрхэн адисалсан бэ? Үүнтэй холбогдуулан Ерөнхийлөгч Монсоны жишээнээс та хэрхэн сүнслэгээр урамшуулагдсан бэ?

Сүнслэг өдөөлтийг хэрхэн хүлээн авч мөн дагахыг таны зааж буй өсвөр үеийнхэн мэдэх үү? Ариун Сүнсний өдөөлтийг дагаж сурах нь өсвөр үеийнхэнд одоо болон ирээдүйд нь хэрхэн туслах вэ? Ерөнхийлөгч Монсоны жишээ нь тэднийг хэрхэн сүнслэгээр урамшуулж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар ба материалуудыг залбиралтайгаар уншаарай. Ариун Сүнсний өдөөлтийн дагуу үйлдэх талаар ерөнхийлөгч Монсоны үлгэр жишээнээс суралцахад өсвөр үеийнхэнд юу туслах вэ?

Сургаалт үгс 3:5–6 (Хэрвээ бид Их Эзэнд итгэвэл Тэрбээр бидний замыг заах болно)

1 Нифай 3:7 (Их Эзэн бидэнд зарлигласан зүйлээ гүйцэлдүүлэх замыг зэхдэг)

2 Нифай 32:1–5 (Ариун Сүнс бидний хийх ёстой зүйлсийг бидэнд үзүүлдэг)

С ба Г 8:2–3 (Ариун Сүнс бидний оюун ухаанд болон зүрх сэтгэлд ярьдаг)

Томас С. Монсон, “Адислалуудын тухай тунгаан бод,” *Ensign* эсвэл *Лиухона*, 2012 оны 11-р сар, 86–89

Томас С. Монсон, “Ариун газарт зогсох нь,” *Ensign* эсвэл *Лиухона*, 2011 оны 11-р сар, 82–86 (Германы Франкфуртын ариун сүмийг онцгойлон адислах ёслолын үйл ажиллагааг удирдсан талаарх түүх)

Томас С. Монсон “Табернеклын дурсамжууд,” *Ensign* эсвэл *Лиухона*, 2007 оны 5-р сар, 41–42 (Ерөнхий чуулган дээр үг хэлэхдээ тагтны

дэргэд суугаа охинд хандан ярихаар сүнслэгээр өдөөгдсөнөө мэдэрсэн тухай түүх)

Жэффри Р. Холланд, “Ерөнхийлөгч Томас С. Монсон: Эзэний мөрөөр,” *Ensign*, 2008 оны 6-р сар, 2–16 (“Найз

нөхөртөө болон Их Эзэнд үнэнч байх нь” гарчигтай хэсгийг үзнэ үү)

Видео бичлэгүүд: “Сүнсний өдөөлтүүдийг дагах нь”, “Сүнсний өдөөлтүүдийг үргэлж дага”

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутад өсвөр үеийнхний янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд, эсвэл найз нартайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний халмаарлыг олж харахад нь та нар өсвөр үеийнхэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Хүн бүрийг саяхан уншаад тэмдэглэсэн судраа олж ангийн-хантайгаа хуваалцахад урь. Тэдэнд сэтгэгдэл төрүүлсэн шүлгээсээ хуваалцахыг хүн бүрээс хүс.
- Энэхүү тоймын эхэнд дурдсан ерөнхийлөгч Томас С.Монсоны

мэдэгдлийг өсвөр үеийнхэнтэй хуваалц. Энэхүү мэдэгдлээс юу нь тэдний сэтгэлийг хөдөлгөсөн бэ? Ерөнхийлөгч Монсон Ариун Сүнсний өдөөлтийг хүлээн аваад түүний дагуу үйлдсэн тухай ямар түүхийг өсвөр үеийнхэн мэдэх вэ?

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь Ерөнхийлөгч Монсоны сүнслэг өдөөлтийг дагасан тухай жишээнээс суралцахад өсвөр үеийнхэнд тусална. Ариун Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Тэдний хүн нэг бүрд Ариун Сүнсний өдөөлтийг хүлээн авч, дагасан тухай ерөнхийлөгч Монсоны түүхийг оноож өг (энэхүү тоймд зөвлөмж болгосноос). Өсвөр үеийнхнээс энэхүү түүхийг уншаад үүнийгээ дүгнэн, сүнслэг өдөөлтийн дагуу үйлдэх талаар сурсан зүйлээ нэгтгэн дүгнэхийг хүс. Сүнсний өдөөлтийн дагуу үйлдсэнээр адислагдсан туршлагаасаа хуваалцахыг тэднээс хүс.

- Энэхүү тоймд заасан судруудыг уншин, судар тус бүр Сүнсний өдөөлтийг дагах талаар юу заагчийг товчхон дүгнэж бичихэд өсвөр үеийнхнийг урь. Энэхүү тоймд санал болгосон ерөнхийлөгч Монсоны тухай түүхүүдээс нэгийг эсвэл түүнээс илүүг хамтдаа унш. Тэдний уншдаг судруудыг жишээ болгосон ерөнхийлөгч Монсоны арга замуудыг сонсохыг өсвөр үеийнхнээс хүс.

Сайн мэдээг судлах ур чадвар

Хичээлийн дүгнэлт. Энэ хэсгийн эхний хоёр үйл ажиллагаагаар өсвөр үеийнхнийг чуулган дээр хэлсэн аль нэг үгээс эсвэл судрын аль нэг хэсгээс сурсан зүйлээ товч дүгнэн бичихэд урь. Өөрийн санаа бодлын талаар, тухайн хэлсэн үг буюу судрын хэсэгт заагдсан сургаалын тухай, болж байгаа үйл явдал, түүнд оролцсон хүмүүсийн тухай гэхчилэн бичихэд тэднийг дэмжсэнээр та тэдэнд тусалж чадна. “Их Эзэн энд юуг, яагаад онцгойлон анхаарахыг хичээсэн юм бол? Миний уншсан зүйлд яг надад хандсан ямар нэг зүйл байна уу? хэмээн тэд өөрөөсөө асууж болно.

Аврагчийн арга барилаар заах нь

Есүс Христ “Миний сургаал бол Минийх биш, харин Намайг Илгээгчийнх. Хэрэв хэн нэгэн нь Түүний хүслийг үйлдвэл тэр нь энэ сургаал Бурханаас ирсэн үү, эсвэл Би Өөрөөсөө ярьж байна уу гэдгийг мэднэ” (Иохан 7:16–17) гэж заасан. Таны дуулгавартай байдал таны зааж буй сургаалын үнэнийг мэдэхэд хэрхэн туслах вэ?

Сүнсний өдөөлтийг хүлээн авахуйц байхын тулд өсвөр үеийнхэн юу хийж болох вэ?

- Ерөнхийлөгч Монсоны тухай түүхүүдийг унших үедээ эсвэл энэхүү суралцах тоймд зөвлөмж болгосон видео бичлэгүүдийг үзээд дараах асуултуудыг тунгаан бодохыг өсвөр үеийнхнээс хүс: Зарим үед Ариун

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурч мэдсэн зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан зүйлийнхээ ачаар тэд юу хийх урмыг авч байгаа талаар өсвөр үеийнхнээс асуу. Тэр мэдрэмжүүдийнхээ дагуу үйлдэхийг тэдэнд уриал. Дагаж болох арга замуудын талаар залбиралтайгаар бодохдоо Сүнсийг эрэлхийлээрэй.

Сонгосон материалууд

Жэффри Р.Холланд “Ерөнхийлөгч Томас С.Монсон: Эзэний мөрөөр” нэмэлт материалаас эш татав. Лиахона 2008 оны 6-р сар, 2–16

Энэ түүх нь бидэнд Томас С.Монсоны онцгой зан чанаруудын нэг болох үнэнч байдлын тухайлбал Сүнсний дуу хоолойд үнэнч —байхыг сануулсан нэгэн явдлыг сануулдаг билээ. Залуу бишоп байхад нь нэг орой түүн рүү утасдаж тойргийнх нь нэг өндөр настай гишүүнийг эмчлэхээр Солт Лэйк хотын Ахмад дайчдын эмнэлэг рүү авч явсныг хэлжээ. Тэр хүнд адислал өгөхөөр эмнэлэг рүү очиж чадахсан болов уу? гэж утасдсан хүн асуув. Гадасны хуралд очихоор замд явж байгаагаа бишоп Монсон хэлээд, хурал дуусангуут эмнэлэг дээр яваад очъё гэжээ. Удирдлагын тэр хурал дээр түүний санаа нэг л түгшүүртэй, сэтгэл зовоод болж өгсөнгүй. Хурлыг даруй орхиж, эмнэлэг рүү шууд яв гэсэн өдөөлт мэдрэгдэж байлаа. Гэвч гадасны ерөнхийлөгчийг үг хэлж байхад гараад явна гэдэг эвгүй байлаа. Тэрээр гадасны ерөнхийлөгчийг ярьж дуусахыг хүлээгээд хаалтын залбирлын өмнө гарч явав. Нэг л мэдэхэд эмнэлэг дээр ирчихсэн коридороор гүйж байв. Нөгөөх хүний өрөөний гадна хүмүүс үймэлдэн гүйлдэж, нэг сувилагч бишоп Монсоныг зогсоон “Та бишоп Монсон уу?” гэж асуув. “Тийм ээ” хэмээн тэрээр түгшингүй хариулав. “Уучлаарай, “Өвчтөн амьсгал хураахынхаа дөнгөж өмнөхөн таны нэрийг хэлсэн шүү” гэж сувилагч хариулжээ.

Тэр шөнө залуу бишоп эмнэлгээс гарч явахдаа Их Эзэнээс ирсэн өдөөлтөөр үйлдэхдээ дахин хэзээ ч алдахгүй хэмээн өөртөө тангараглажээ. Энэ тангарагтаа ямарч хүн түүнээс илүү үнэнч байж чадахгүй бизээ. Чухамдаа, түүний амьдрал бол Сүнсний өдөөлтүүдэд итгэл бишрэлтэйгээр дуулгавартай хариулсан, удаа дараа тохиолдсон гайхамшиг юм.

Эмнэлэг дээр болсон тэр явдал олон жилийн дараа Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн болох хүртэл түүний санааны мухарт нь хадгалагдсаар байсан төдийгүй түүнийг нэг гадасны чуулганд очиход ер бусын нэг зүйл болжээ. Тэр долоо хоногийн сүүлчээр эхлээд түүнийг өөр гадсанд томилсон байсан боловч яагаад ч юм гэнэт томилолтыг өөрчлөх шаардлага гарсан байна. Тэр үед Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон (1899–1994), “Монсон ах аа, таныг Шривпорт Луйзана гадсанд очих ёстой юм шиг надад санагдаад байх юм” гэж хэлэхэд ахлагч Монсон тэр газрын тухайд ямар нэг онц гойд юм мэдэхгүй байлаа.

Ахлагч Монсон Шривпортод ирээд, 10 настай Кристал Метвин эдгэршгүй хавдраар өвчлөн зовон шаналж байгаа бөгөөд аль нэг Ерөнхий эрх мэдэлтнээс, ялангуяа—түүнээс адислал авахыг хүсч байгааг нь мэджээ. Чуулганы хуралдааны хуваарийг тэр үзээд, 130 км хол Кристалын гэрлүү явах цаг байхгүйг мэдэв. Гадасны чуулганы үеэр Кристалын төлөө нийтээрээ залбирахыг тэрээр гадасны ерөнхийлөгчөөс хүссэн аж. Тэднийд явж очих нь хүндрэлтэй байгааг Метвиний гэрийнхэн ойлгож, охиных нь хүсэл биелэгдэхийн төлөө залбирчээ. Ахлагч Монсон бямба гаргийн оройн удирдагчдын хурал дээр үг хэлэхээр бэлтгэж байтал, “Бодгальд минь өгүүлэх нэгэн дуу хоолойг би сонслоо. Захиас богинохон байсан боловч: ‘Хүүхдүүдийг над руу ирэхийг зөвшөөр. Тэднийг бүү хорь. Учир нь Бурханы хаанчлал тэдэн шиг хүмүүсийнх юм’ (Марк 10:14) гэсэн танил үгс байлаа. Метвинийх рүү очих асуудлыг маргааш өглөө нь гадасны ерөнхийлөгчийн тусламжтайгаар зохион байгуулжээ. Уг хэрэг явдалд оролцсон хүмүүсийн хувьд энэ нь хүндэтгэлтэй бөгөөд ариун туршлага болсон юм. Кристал хүссэн адислалаа хүлээн авснаас хойш ердөө дөрөвхөн хоногийн дараа Тэнгэрлэг Эцэгийнхээ гэрт буцаж очсон аж.

БҮЛГИЙН ТОВЧ ТОЙМ

Зургаадугаар сар: Санваар ба санваарын түлхүүрүүд

*“Бурханы хаант улсын түлхүүрүүд дэлхий дээр хүмүүнд итгэмжлэгдсэн болой”
(С ба Г 65:2).*

Энэ бүлгийн тоймууд нь өсвөр үеийнхэнд сайн мэдээнээс суралцахдаа болон сүмд үйлчлэхдээ санваарын үүрэг ба санваарын түлхүүрүүдийн талаар ойлгоход туслах болно. Өсвөр үеийнхнийг сурч байгаа зүйлсийнхээ талаар асууж лавлан, илүү ихийг сурахыг эрэлхийлж, сурч мэдсэн зүйлсээ бусдад заахад нь дэмжээрэй.

Энэ сард сонгох тоймууд:

Би сүм дэх зөвлөлүүдэд хэрхэн үр дүнтэй оролцож болох вэ?

Бурханы хаант улсыг байгуулахын төлөө эмэгтэйчүүд ба санваартнууд хэрхэн хамтран ажилладаг вэ?

Санваарын удирдагчдын зөвлөгөөг дагах нь яагаад чухал вэ?

Судар судлах ур чадваруудыг ашиглах нь санваарын тухай илүү ихийг мэдэхэд надад хэрхэн туслах вэ?

Би санваарын тухай бусдад заахдаа түүхүүдийг хэрхэн ашиглаж болох вэ?



Би сүм дэх зөвлөлүүдэд хэрхэн үр дүнтэй оролцож болох вэ?

Их Эзэний Сүм нь зөвлөлүүдээр дамжуулан удирдагддаг. Удирдагчид санваарын удирдлагаар дамжуулан хувь хүмүүс, гэр бүлүүд болон сүмийн сайн сайхны төлөө хамтран зөвлөлддөг. Сайн ажилладаг зөвлөл нь Бурханы хаант улсыг байгуулахын төлөө Ариун Сүнсээр удирдагдаж, нэгдмэл байхыг эрэлхийлдэг зөвлөлийн гишүүн бүрийг санал бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд урьдаг. Зөвлөлүүдэд түүний дотор ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлууд, бишопын өсвөр үеийнхний хорооны хурлууд болон гэр бүлийн зөвлөгөөнүүд дээр илчлэлт хэрхэн хүлээн авдгийг мэдэх нь эдгээр хурал, зөвлөгөөнүүдэд үр дүнтэй оролцоход бидэнд тусална.

Та зөвлөлийн хуралдаанд хэзээ оролцсон бэ? Их Эзэний ажилд зөвлөлүүдийн үүрэг хэчнээн чухал болохыг ойлгоход тань ямар туршлага тусалсан бэ?

Өсвөр үеийнхэн ямар зөвлөлүүдэд оролцдог вэ? (жишээ нь: ангийн болон чуулгуудын ерөнхийлөгчийн зөвлөлүүд, бишопын өсвөр үеийнхний хороо). Өсвөр үеийнхэн зөвлөлүүдийн зорилгыг хэр зэрэг сайн ойлгодог вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Сүм дэх үр ашигтай зөвлөлийн зарчмуудыг эхлээд өөрөө ойлгохын тулд доорх эх сурвалжуудыг ашигла. Дараа нь энэ тоймын үлдсэн хэсэг дэх үйл ажиллагаанууд өсвөр үеийнхнийг суралцах үйл хэрэгт идэвхтэй оролцуулах арга замуудыг төлөвлөхөд өөрт чинь хэрхэн тусалж болохыг авч үз. Зөвлөлүүдэд оролцох өөрийн тань туршлага үр өгөөжтэйгөөр заахад тань туслах болно.

Матай 18:20 (Их Эзэн Өөрийнх нь нэрээр цугларагчдын дунд байх болно)

Моронай 6:4–5 (Сүмийн гишүүд хүмүүсийг халамжлах асуудлыг хэлэлцэхээр олонтоо хамт цуглан зөвлөлддөг)

С ба Г 38:27 (Нэгдмэл байхыг бидэнд зарлигласан юм)

С ба Г 88:122 (Бүгдээрээ ярих болон сонсох боломжтой байгаа үед сэнхэрдэг)

Хэнри Б.Айринг “Санваарт суралцах нь” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2011 оны 5-р сар, 62–65

Дийтр Ф.Угдорф “Есүс Христийн сайн мэдээний үнэнүүд дээр үйлдэх нь” Дэлхий дахины удирдагчдын сургалт, 2012 оны 2-р сар

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний хамаарлыг олж харахад нь та нар тэдэнд яаж тусалж чадах вэ? Доорх санаанууд танд тусалж болно:

- Сайн мэдээний тухай ямар нэг зүйлийг үр өгөөжтэйгөөр сурч мэдсэн туршлагаа хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс. Тэд сүм, семинар, гэр бүлийн үдэш, хувиараа судар судалсан буюу өдөр тутмын амьдралынхаа туршлагаас жишээ авч болно.

- Ангиудын болон чуулгуудын ерөнхийлөгчийн зөвлөл, бишопын өсвөр үеийнхний хорооны хуралдаан зэрэг сүм дэх зөвлөлүүдийн хуралд оролцсон туршлагаа хуваалцахад өсвөр үеийнхнийг урь. Тэд хуралд бэлтгэхийн тулд юу хийсэн бэ? Уг хурал Их Эзэний ажлыг хийхэд хэрхэн тусалсан бэ?

Заахад туслах арга

“Хичээлийн өмнө асуултуудыг самбар дээр бичсэн байх нь хичээл эхлэхээс өмнө сэдвийн тухай бодоход суралцагсад туслах болно” (Teaching, No Greater Call [1999], 93).

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь сүм дэх үр ашигтай зөвлөлийн зарчмуудыг ойлгоход өсвөр үеийнхэнд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа хамгийн сайн тохирох нэг буюу түүнээс олон үйл ажиллагааг сонго. Энэ хэсгийн төгсгөл дэх зөвлөлийн загвар хуралдаанд оролцох цагийг өсвөр үеийнхэнд гаргаж өг.

- Энэ тоймд зөвлөмж болгосон судрын эшлэлүүдийг самбар дээр бич. Ангийн гишүүн бүрийг нэг судрын эшлэлийг судлахаар сонгож аван, Их Эзэн Өөрийн ажлыг хийхийн тулд яагаад зөвлөлүүдийг ашигладаг тухай бодохыг тэднээс хүс. Хэрэв хүн бусадтай зөвлөлдөхгүйгээр бүх шийдвэрийг ганцаараа гаргавал шийдвэрүүд нь яагаад үр нөлөө тааруухан байдаг вэ? Өсвөр үеийнхэн эдгээр зарчмыг гэр бүлтэйгээ харилцахдаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ?

- Ерөнхийлөгч Дийтр Ф. Угдорфын “Есүс Христийн сайн мэдээний үнэнүүд дээр үйлдэх нь” хэлсэн үгийг хэсгүүдэд хувааж, ангийн гишүүн бүрд нэг хэсгийг уншуулахаар өг. Зөвлөлд хэрхэн оролцох тухай уншсан хэсгээсээ хариулах нэг асуулт бичихийг тэднээс хүс. Асуултууд болон ярианы хэсгүүдийг хоорондоо сольж, ярилцахад тэднийг урь. Тэд гэр бүлийн зөвлөгөөн болон сүмийн зөвлөлүүдэд оролцохдоо хэрэгжүүлж болох юуг ерөнхийлөгч Угдорфоос сурсныг асуу.

- Амжилттай ажиллагч зөвлөлийн түлхүүр хэсгүүдийг ярилцан тэмдэглэж авахад өсвөр үеийнхнийг урь (жишээ нь, Сүнсний дагах, бие биенээ сонсох, үүрэг даалгавар өгөх, авах зэрэг). Зөвлөлийн хурал болон бусад үйл ажиллагаанууд дээр эдгээр зарчмуудыг хэрэгжүүлж буйг харсан туршлагаа хуваалцахад тэднийг урь.

- Өсвөр үеийнхнээс хэдэн хүнийг ерөнхийлөгч Хэнри Б. Айринг өсвөр насандаа пристүүдийн чуулгад хэрхэн үйлчилж байсан туршлагыг (“Санваарт суралцах нь” хэлсэн үгэнд), бусдыг нь тэрээр 20 жилийн дараа бишоп болсон үеийнх нь туршлагыг (мөн дээрх хэлсэн үгнээс) уншихад урь. Түүхийг бие биедээ дахин ярьж өгөхийг тэднээс хүс. Зөвлөлүүдийн тухай эдгээр түүхээс тэд юу сурсан бэ? Их Эзэний ажлыг үр өгөөжтэйгөөр хийх ямар арга замыг зөвлөлүүд санал болгосон бэ? Хамтаараа зөвлөлдөх ямар боломж өсвөр үеийнхэнд байдаг бэ?

Дараах үйл ажиллагаа нь зөвлөлд оролцох дасгал хийх боломжийг өсвөр үеийнхэнд олгох болно. Энэ үйл ажиллагаа тэдний ойлголтыг гүнзгийрүүлж, сурч мэдсэн зүйлээ амьдралдаа хэрэгжүүлэхэд тэднийг бэлтгэх болно.

- Дээрх үйл ажиллагаануудаас нэгийг нь хийсний дараа зөвлөлд хэрхэн оролцохыг жүжигчлэн тоглох замаар сурч мэдсэн зарчмуудаа амьдралд хэрэгжүүлэхэд өсвөр үеийнхнийг урь. Ангийн гишүүн бүрийг жүжигчилсэн тоглолтод оролцуулж, хүндэтгэл ба даруу байдлын ач холбогдлыг ойлгоход нь тойргийн гишүүдэд хэрхэн туслах вэ? гэх мэт хамтран зөвлөлдөх боломжтой сэдвийг сонгохыг тэднээс хүс.

Өсвөр үеийнхнийг өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Сүм дэх зөвлөлүүдэд хэрхэн үр ашигтай оролцохыг тэд ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан буюу дадлага хийсэн зүйлээ зөвлөлүүдийн хуралд оролцохдоо хэрхэн хэрэглэхийг ярихад өсвөр үеийнхнийг урь (дуудлага, гэр бүлийн зөвлөгөөн, семинартай холбоотой удирдлагын асуудал гэх мэт). Дараагийн хичээлийн эхэнд туршлагаа хуваалцахыг хэдэн суралцагсдаас хүс.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч заадаг хүмүүстээ асуулт асууж, санаа бодлоо хуваалцах боломжийг олгож, (Лук 10:25–37-г үзнэ үү), тэдний асуултуудад хариулан, яриаг нь сонсдог байлаа. Та өсвөр үеийнхнийг асуулт асууж, санаа бодлоо хуваалцахад хэрхэн урамшуулан дэмжиж чадах вэ?

Сонгосон материалууд

Хэнри Б.Айринг, “Санваарт суралцахуй” Ensign эсвэл Лиахона 2011 оны 5-р сар, 62–65

Намайг дикон байхад манайх Юта руу нүүж ирэв. Тэнд миний санваартаа өсч хөгжих өсөлтийг түргэгсэх гурван гайхалтай зүйлийг би олсон юм. Эхнийх нь: чуулгынхаа гишүүдтэй зөвлөлд хэрхэн хуралдахыг мэддэг ерөнхийлөгч; хоёр дахь нь бидний олонтоо сонссон—бие биеэ хайрлах агуу хайр руу удирдан хөтөлдөг Есүс Христэд итгэх агуу итгэл; гурав дахь нь бидний санваарын олон талт зорилго бол хүмүүний авралын төлөө хөдөлмөрлөх явдал мөн гэсэн хүн бүрийн итгэл үнэмшил байлаа.

Шилжиж ирсэн салбар маань тийм онцгой сайн салбар байгаагүй. Сүмийн аль ч нэгжид тохиолддог зүйлс тэр тойрогт мөн тохиолддог л байв.

Энэ гурван зүйл танай санваарын чуулгад байдаг ч та эдгээрийг анзаардаггүй байж мэднэ. Харин зарим ах нар өсч хөгжих хэрэггүй хэмээн бодоод эдгээр зүйлсийг та харахгүй өнгөрөөдөг байж болно. Харин одоо тэдгээр зүйлсийг тодорхой болгож та нарын анхаарлыг татахын төлөө Сүнс надад туслахын төлөө би залбирч байна. . . .

Би пристийн чуулгад анх орсон үедээ нэг дэх зүйлийн тухай олж мэдсэн юм. Пристийн чуулгын ерөнхийлөгч нь бишоп өөрөө байсан бөгөөд энэ нь та нарт өчүүхэн, гайхаад баймааргүй зүйл мэт санагдаж болох ч миний санваарын үйлчлэлийг эрс өөрчилж санваарын хүчийг надад мэдрүүлсэн билээ. Бишоп биднийг хэрхэн удирдаж байсан нь намайг өөрчлөгдөхөд нөлөөлсөн юм.

Тэр залуу пристүүд биднийг дэлхий дээрх хамгийн ухаалаг хүмүүс мэт ханддаг байв. Тэрээр бүх хүмүүсийг ярьж дуустал нь анхааралтай сонсдог байсан. Юу хийх хэрэгтэйгээ тэрээр шийдэхэд

бишопын гаргасан шийдвэрийг Сүнс бидний хэн хэнд маань баталж өгдөг юм шиг санагддаг байлаа.

“Ерөнхийлөгч нь чуулгынхаа гишүүдтэй зөвлөлдөхөөр хуралдах” гэсэн судрын үгс ямар утгатайг тэр үед л би ойлгосон. (Сургаал ба Гэрээ 107:87-г үзнэ үү.) Олон жилийн дараа би пристийн чуулгадаа бишоп болоход залуу прист байх үедээ сурч мэдсэн зүйлүүд маань надад болон манай чуулгад олон зүйлийг заасан юм.

Бишопоор үйлчлээд хорин жилийн дараа зөвлөлийн хурлын үр ашгийг зөвхөн цуглааны байранд төдийгүй ууланд аялж явахдаа харах боломж олдсон. Бямба гаргийн үйл ажиллагааны үеэр манай чуулгын нэг гишүүн ойд төөрчихөв. Тэрээр ганцаараа, дулаан хувцасгүй, хоол ундгүй, толгой хоргодох газаргүй байгааг бид мэдэж байсан. Бид түүнийг хайсан ч олж чадаагүй юм.

Пристийн чуулгын гишүүд бид хамтдаа залбирсны дараа би хүн бүрийг саналаа хэлэхийг хүсч байснаа санадаг. Би хүн бүрийн яриаг анхааралтай сонссон бөгөөд тэд нар ч гэсэн надтай адил зүйл хийсэн юм шиг надад санагдсан. Хэсэг хугацааны дараа бидэнд амар амгалангийн мэдрэмж төрөв. Төөрсөн чуулгын гишүүн маань хаа нэгтээ эсэн мэнд, аюулгүй байгаа гэсэн мэдрэмж надад төрөв.

Чуулга юу хийх ёстой, юу хийх ёсгүй нь надад тодорхой болсон юм. Түүнийг олсон хүмүүс ойд түүний байсан газрыг нь дүрслэн ярихад би тэр газрыг аюулгүй гэж мэдэрсэн маань зөв байсныг мэдэрч билээ. Гэвч миний харсан хамгийн том зүйл бол Есүс Христэд итгэх итгэлээр дамжуулан эв нэгдэлтэй санваарын зөвлөлийнхөн санваарын түлхүүртэй тэр хүнийг илчлэлт авахыг харах байлаа. Бид бүгд тэр орой санваарынхаа хүчээр өсч хөгжсөн.



Бурханы хаант улсыг байгуулахын төлөө эмэгтэйчүүд ба санваартнууд хэрхэн хамтран ажилладаг вэ?

Эмэгтэйчүүд Бурханы санваартнуудтай хамтран ажилласнаар үхэшгүй байдал ба мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрахад Тэнгэрлэг Эцэгтээ туслах чухал үүрэг гүйцэтгэж чадна. Санваартнууд болон эмэгтэйчүүд санваарын түлхүүрүүдийг эзэмшдэг хүмүүсийн удирдлага дор Бурханы хүүхдүүдийг адислахын тулд хамтран зөвлөлддөг. Тэд үүнийг тойрог, гадасны зөвлөлийн хурлууд, гэр бүлүүд болон бусад олон газарт хийж болно.

Бурханы хаант улсыг байгуулахын төлөө санваартнууд болон эмэгтэйчүүд хамтран ажиллаж байхыг та хэзээ харсан бэ? Ямар туршлагыг та өсвөр үеийнхэнтэй хуваалцаж болох вэ?

Их Эзэний ажилд эмэгтэйчүүд болон санваартнууд хэрхэн хамтран ажилладгийг мэдэх нь өсвөр үеийнхэнд яагаад чухал вэ? Залуу эрэгтэйчүүд болон залуу эмэгтэйчүүд хамтран ажиллах ямар боломжууд байдаг вэ? Тэд одоо бусдад үйлчлэх болон ирээдүйн үйлчлэлдээ бэлтгэхийн тулд юуг ойлгох хэрэгтэй вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Та заахаар бэлтгэхдээ дараах судар ба суралцах материалуудыг залбирч судлаарай. Өсвөр үеийнхэнд юу заавал тустай гэж та бодож байна вэ?

“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг” *Ensign* эсвэл *Лиакхона* 2010 оны 11-р сар, 129 (Нөхөр эхнэр хоёр гэр бүлээ анхаарч, халамжлах талаар эрх тэгш түншүүдийн хувиар хамтран ажиллах ёстой; догол мөр 6, 7-г үзнэ үү)

Рассэлл М.Нэлсон, “Эгч нараасаа гуйх гуйлт,” *Ensign*, эсвэл *Liahona*, 2015 оны 11-р сар, 95–98

Квинтин Л.Кук “ХҮГ эмэгтэйчүүд бахархмаар хүмүүс!” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2011 оны 5-р сар, 18–21

Видео бичлэг: “Тэнгэр элчүүдийн ажил” Удирдлагын сургалтын номын сан

Видео бичлэг: “Гэр орондоо бие биенээ дэмжих нь”

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд, эсвэл найз нартайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний хамаарлыг олж харахад нь та нар тэдэнд яаж тусалж чадах вэ? Дараах санаанууд танд тусалж болно:

- Сүм дээр эсвэл бие дааж судалсан нэг зүйлийнхээ үнэнийг дахин нотолсон туршлагаа хуваалцахад өсвөр үеийнхнийг урь.

- Хичээлийн нэрийг самбар дээр бич. Асуултын хариултыг бичихийг

ангийн гишүүн бүрээс хүс. Дараа нь хоёр хоёроороо ажиллаж хариултаа нэг өгүүлбэр болгон нэгтгэ. Нэгтгэсэн өгүүлбэрээ бусадтайгаа хуваалцахад тэднийг урь.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь Бурханы хаант улсыг байгуулахын төлөө эмэгтэйчүүд болон санваартнууд хэрхэн хамтран ажилладгийг ойлгоход өсвөр үеийнхэнд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс олон үйл ажиллагааг сонгоно уу:

- Өсвөр үеийнхнийг ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоний хэлсэн үгийн аравдугаар догол мөрөөс эхлэн уншихад урь. Тэд ерөнхийлөгч Кимбаллын бошиглол биелсэн талаарх ямар нотолгоог харж байсан бэ? Өсвөр үеийнхэн эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай, энэхүү бошиглолыг биелэхэд хэрхэн тусалж чадах вэ? Өсвөр үеийнхнийг ерөнхийлөгч Нэлсоний үгийг дуустал уншаад, эмэгтэйчүүд болон санваартнууд хэрхэн хамтдаа ажиллаж болох арга замуудыг олж мэдэхэд урамшуулан дэмж. Ангийн гишүүдийг өөрсдийн амьдрал дээрх эмэгтэйчүүдэд зориулан талархлын захиа бичих эсвэл олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан тэдгээрийг хуваалцахад урьж болох юм.

- Тойрогтоо дуудлагатай цөөн эгч болон санваартнуудыг сүмд хамтран ажилладаг туршлагынх нь тухай яриулахаар бишпоос зөвшөөрөл авч урь. Тэд бие биеийнхээ туршлага, мэдлэгээс хэрхэн ашиг тусыг олсон бэ? Өсвөр үеийнхнийг туршлагаасаа хуваалцахад урь.

- Ахлагч Квинтин Л.Күкийн “ХҮГ эмэгтэйчүүд бахархмаар хүмүүс!” хэлсэн үгийн “Сүм дэх эмэгтэйчүүдийн үүрэг” хэсгийг уншихад өсвөр үеийнхнийг урь. Сурч мэдсэн зүйлээ бие биетэйгээ хуваалцахыг тэднээс хүс. Сүм дэх эмэгтэйчүүд чухал үүрэг гүйцэтгэдэг тухай ойлгоход бусад туслахын тулд өсвөр үеийнхэн ахлагч Күкийн захиасыг хэрхэн ашиглаж болох вэ?

- Энэ тоймд санал болгосон видео бичлэгүүдийн аль нэгийг үзүүлж, санваартнууд эмэгтэйчүүдтэй хамтран ажиллах талаар сурч мэдсэн зүйлсээ хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс. Өсвөр үеийнхнийг эрэгтэй эмэгтэй хүмүүс гэр орондоо болон тойрогтоо Бурханы хаант улсыг байгуулахад оролцож байхыг харсан туршлагаасаа хуваалцахад урамшуул. Залуу эрэгтэйчүүд олон залуу эмэгтэйчүүд эдгээр видео бичлэгээс сурсан зүйлсээ сүмд хамтдаа үйлчлэхдээ хэрхэн тусгаж болох вэ?

- “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийн 6, 7-р догол мөрийг дор бүрнээ унших болон Бурханы мөнхийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд

Заахад туслах арга

“Та өөрөө сүнслэг байдлын хувьд бэлтгэгдсэн байх нь суралцах уур амьсгалд чухал ач холбогдолтой юм. Та өөрөө сүнслэг байдлын хувьд бэлтгэгдсэн байвал амар амгалан, хайр, хүндэтгэлийн уур амьсгалыг бүрдүүлж чадна. Заадаг хүмүүс чинь мөнхийн зүйлсийг тунгаан бодож, ярилцахад илүү итгэлтэй байх болно” (*Teaching, No Greater Call* [1999], 79).

эрэгтэй, эмэгтэй хүмүүс хамтран ажиллах арга замуудыг тодорхойлоход ангийн гишүүн бүрийг урь. Өсвөр үеийнхнээс олж мэдсэн зүйлийнхээ тухай хуваалцахыг хүс. Гэр бүлийн тунхаг дахь зарчмуудыг

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс сүмд хэрхэн хамтран ажилладгийг тэд ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан зүйлсээрээ юуг хийхээр сүнсээр өдөөгдсөнийг нь өсвөр үеийнхнээс асуу. Тэрхүү өдөөлтийнхөө дагуу ажиллахыг тэдэнд урамшуулан дэмж. Суралцагчдын ойлголтыг шалгаж болох арга замуудыг олохын тулд залбирч, Сүнсийг эрэлхийл.

дагадаг эхнэр, нөхрүүдийн жишээг тэд хэзээ харсан бэ? Гэр бүлийн тунхагт дүрсэлсэн гэр бүлийн харилцаанд өөрийгөө бэлтгэхийн тулд тэд одоо юу хийж болох вэ?

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн дагалдагчдыг Сүнс тэдний зүрх сэтгэлд хэрхэн нөлөөлсөн тохиолдлыг гэрчлэхийг урьдаг байлаа. Сайн мэдээ үнэнийг бие биедээ гэрчилж, заахад та өсвөр үеийнхнийг хэрхэн урамшуулан дэмжиж болох вэ?

Сонгосон материалууд

Квинтин Л.Кук “ХҮГ эмэгтэйчүүд бахархмаар хүмүүс!” хэсгээс эш татав. Ensign эсвэл Лиахона 2011 оны 5-р сар, 18–21

Сүүлийн гурван жилийн турш Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд санваарын болон туслах байгууллагын удирдагчидтай зөвлөлдөн Сүмийн шинэ гарын авлагууд дээр ажиллахдаа удирдамж, бурханлаг нөлөө, илчлэлтүүдийг эрэлхийлсэн юм. Энэхүү үйл явцад эгч нар туйлын чухал үүрэг гүйцэтгэж байгааг өндрөөр үнэлэх талархлын гүн мэдрэмж надад төрж билээ. Манай эгч нар гэр бүлтэй ч бай, ганц бие ч бай, гэр бүл болон Сүмд, асар их үүргийг үргэлж гүйцэтгэсээр ирсэн билээ. . . .

Хэдэн жилийн өмнө би Тонгад нэг гадасны чуулганд оролцож билээ. Ням гаргийн өглөө цуглааны байрны эхний гурван эгнээ 26-35 насны эрэгтэйчүүдээр дүүрсэн байв. Би тэднийг эрэгтэйчүүдийн найрал дуучид байна гэж бодсон. Гэвч чуулганы ажил хэргийг явуулах үед эдгээр 63 эрэгтэйн нэрийг дуудахад тэднийг Мелкизедек санваарт томилохоор нэр дэвшүүлж байгааг мэдэв. Би гайхахын сацуу бас баярлаж билээ.

Хуралдааны дараа би гадасны ерөнхийлөгч Матеакигаас ийм гайхамшиг хэрхэн тохиосныг асуув. Тэрээр гадасны зөвлөлийн хуралд идэвх султай гишүүдийг идэвхжүүлэх талаар ярилцсан тухайгаа ярих. Гадасных нь Халамжийн Нийгэмлэгийн ерөнхийлөгч Лиената Ва’энуку эгч үг хэлж болох уу гэж асуужээ. Тэр эгчийг үг хэлж байхад түүний санал болгож байгаа зүйл үнэн гэдгийг Сүнс ерөнхийлөгчид баталсан гэнэ. Тэр гадсанд номлолд үйлчлээгүй, 20-30 насны олон гайхамшигтай залуу эрэгтэйчүүд байгааг тэр хэллээ. Тэдний ихэнх нь номлолд үйлчлэхийг нь ихэд дэмжиж байсан бишоп болон санваарын бусад удирдагчдынхаа урмыг хугалсан гэдгээ мэддэг

бөгөөд одоо тэд сүмийн хоёрдугаар зэргийн гишүүд мэт өөрсдийгөө үздэг, мөн эдгээр залуу эрэгтэйчүүд бүрэн цагийн номлолд үйлчлэх наснаасаа хэтэрснийг тэрээр хэлжээ. Тэр бас тэднийг хайрладгаа болон тэдний төлөө санаа зовж байгаагаа хэлсэн аж. Авралын бүх ёслол тэдэнд боломжтой хэвээрээ байгаа бөгөөд, тэдний анхаарах зүйлс нь санваарын томилолт болон ариун сүмийн ёслолууд дээр төвлөрөх хэрэгтэй гэж хэлжээ. Мөн тэрээр эдгээр залуу эрэгтэйчүүдийн зарим нь ганц бие, ихэнх нь идэвхтэй—гайхалтай эмэгтэйчүүдтэй, зарим нь идэвх султай, зарим нь сүмийн гишүүн биш эмэгтэйчүүдтэй гэр бүл болсныг тэр дурджээ.

Гадасны зөвлөлийн хурлаар хэлэлцсэний дараа бишопууд цаг завьнхаа ихээхэн хэсгийг залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүдэд зарцуулж, харин санваартан ах нар болон Халамжийн Нийгэмлэгийн эгч нар дээрх эрэгтэйчүүд болон тэдний амьдралыг аврахад хичээл зүтгэл гаргахаар шийдсэн юм. Авралын энэхүү ажилд оролцсон хүмүүс тэднийг санваар, мөнхийн гэрлэлт, ариун сүмийн авралын ёслолуудад бэлтгэхэд нэн тэргүүнд анхаарч байлаа. Миний оролцсон чуулганд Мелкизедекийн санваарт томилогдсон 63 эрэгтэйн бараг ихэнх нь дараагийн хоёр жилдээ ариун сүмд хувийн хишгээ хүлээн авч, эхнэрүүд нь тэдэнтэй лацдан холбуулсан байлаа. Энэ явдал нь манай тойрог, гадсууд дахь авралын ажилд эгч нар шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдгийн, ялангуяа гэр бүлд болон Сүмийн зөвлөлд илчлэлт хүлээн авахад хэрхэн тус дөхөм үзүүлдгийн тодорхой жишээ юм. [Тонгагийн Ха’акамэ Гадас. Нукуалүфа Тонга Хакатэ гадасны ерөнхийлөгч Лэхонитэй Матеаки (Папуа Гвиней Порт Морэсби номлолын ерөнхийлөгчөөр дараа нь үйлчилсэн) ба гадасны Халамжийн Нийгэмлэгийн ерөнхийлөгч Лиената Ва’энуку нарын ярилцлагаас.]



Санваарын удирдагчдын зөвлөгөөг дагах нь яагаад чухал вэ?

Санваарын удирдагчид бусдыг удирдахаар дуудагдсан хүмүүстэй зөвлөхийн тулд Ариун Сүнснээс удирдамж хүлээн авдаг. Санваарын удирдагчдынхаа зөвлөгөөг сонсож, дагаж сурах нь биднийг сүнс болоод бие махбодод учрах аюулаас хамгаалж мөн бидэнд зөв сонголтууд хийхэд тусална.

Санваарын удирдагчдын зөвлөгөөг дагасан нь таныг хувийн амьдралд тань, дуудлагуудад тань, гэр бүлд тань хэрхэн адисалсан бэ?

Санваартнуудын зөвлөгөөг эрэлхийлэх ямар боломжууд өсвөр үеийнхэнд байдаг вэ? Санваарын удирдагчдын түүний дотор тойрог, гадасны удирдагчдын зөвлөгөөг дагахад та өсвөр үеийнхнийг хэрхэн урамшуулан дэмжиж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Санваарын удирдагчдын зөвлөгөөг дагах нь яагаад чухал болохыг өөрөө ойлгохын тулд дараах материалуудыг ашигла. Дараа нь энэ тоймын үлдсэн хэсэг дэх үйл ажиллагаанууд өсвөр үеийнхнийг суралцах үйл хэрэгт идэвхтэй оролцуулах арга замуудыг төлөвлөхөд өөрт чинь хэрхэн тусалж болохыг авч үз. Зөвлөгөөг дагах өөрийн тань туршилага үр өгөөжтэйгөөр заахад тань тусална.

Ефес 4:11–14 (Сүмийн удирдагчдаас ирдэг адислалууд)

С ба Г 1:38; С ба Г 21:4–5 (Их Эзэн үйлчлэгчдээрээ дамжуулан ярьдаг)

С ба Г 124:45–46 (Их Эзэний үйлчлэгчдийг анхааран сонс)

Даллин Х.Өүкс “Харилцааны хоёр шугам” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2010 оны 11-р, 83–86

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд суралцаж байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондын уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдрал дахь сайн мэдээний хамаарлыг олж харахад нь та тэдэнд яаж тусалж чадах вэ? Дараах санаанууд танд тусалж болно:

- Залуу эрэгтэйчүүдийг ангид байгаа залуу эмэгтэйчүүдэд Аароны санваарын чуулгуудад санваарын тухай сурсан зүйлээ заахад урь. Дараа нь санваарын тухай сурсан

зүйлээ заахад залуу эмэгтэйчүүдийг урь.

- Орон нутгийн санваарын удирдагчдаас (жишээ нь бишоп буюу гадасны ерөнхийлөгчөөс) саяхан

авсан зөвлөгөөнийхөө тухай хуваалцахад өсвөр үеийнхнийг урь. Энэ зөвлөгөөг дагаснаар тэд ямар адислал авсан бэ? Хичээлийн

үед сүнсээр өдөөгдсөнийхөө дагуу санваарын удирдагчдыг дагаснаас ирсэн адислалуудын тухай гэрчлэлээ хуваалц.

Заахад туслах арга

“Хичээлийн цагийн ихэнхийг уншлага уншиж өнгөрүүлэн, асуулт болгонд өөрөө хариулдаг багш, хичээлд оролцох суралцагчдын идэвхийг бууруулдаг” (*Teaching, No Greater Call* [1999], 64).

Аврагчийн арга барилгаар заах нь

Аврагч сургаал ба зарчмуудыг тайлбарлахын тулд түүх, сургаалт зүйрлэл, амьдралын бодит жишээнүүдийг олонтоо хуваалцдаг байлаа. Санваарын удирдагчдыг дагах тухай ямар түүхүүдийг та өсвөр үеийнхэнтэй хуваалцаж болох вэ?

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь санваартны удирдагчдын зөвлөгөөг дагахын ач холбогдлыг ойлгоход өсвөр үеийнхэнд тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа хамгийн сайн тохирох нэг буюу түүнээс олон үйл ажиллагааг сонго:

- Санваарын удирдагчийн зөвлөгөөг хүсч, түүнийг дагасан хүмүүсийн жишээг судруудаас олж, хуваалцахад ангийн гишүүдийг урь (жишээ нь: Хаадын дэд 5:1–14, Мозая 28:1–8, Алма 16:5–8). Зөвлөгөө авах талаар эдгээр жишээнээс сурч мэдсэн зүйлээ ярилцахад өсвөр үеийнхнийг урь. Эдгээр түүхэн дэх хүмүүс үйлчилдэг хүмүүсээ удирдах сүнсний удирдамжийг хэрхэн хүлээн авсан бэ? Гэрчлэлийг нь санваарын удирдагчдын сүнслэг нөлөө хэрхэн бэхжүүлсэн тухай туршлагаа хуваалцахад өсвөр үеийнхнийг урь.

- Ефес 4:11–14, Сургаал ба Гэрээ 1:38; 21:4–5; 124:45–46-г уншиж, дараах асуултанд хариулахад өсвөр үеийнхнийг урь: Санваарын удирдагчдын зөвлөгөөг дагах нь яагаад чухал вэ? Санваарын удирдагчийн

зөвлөгөөг дагаснаараа хэрхэн адислагдсан туршлагаа хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс.

- Ахлагч Даллин Х.Өүксийн “Харилцааны хоёр шугам” хэлсэн үгийг хувилан ангийн гишүүдэд тарааж өг. Ангийн хагасаас нь 1-р хэсгийн “Хувь хүний шугам”-ыг уншиж, ахлагч Өүксийн заасан зүйлийг дүрсэлсэн нэг зургийг бүгдээрээ нийлж зурахыг хүс. Ангийн нөгөө хагасаас нь “Санваарын шугам” 2-р хэсгийг уншиж, өмнөхтэй адил зураг зурахыг хүс. Хоёр бүлэг зурсан зургаа хоорондоо хуваалцсаны дараа “Хоёр шугамын хэрэгцээ” 3-р хэсгийг хамт уншихыг хүсч, хувийн болон санваарын удирдагчдаар дамжин ирдэг илчлэлтээр тэд өөрсдөө бас гэр бүл нь хэрхэн адислагдсаныг асуу.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлсийнхээ талаар хуваалцахыг хүс. Санваарын удирдагчдын зөвлөгөөг дагах нь яагаад чухал болохыг тэд ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Санваарын удирдагчдаас зөвлөгөө хүсэх тухай өсвөр үеийнхэн өнөөдөр юу сурч мэдсэн бэ? Хүлээн авсан зөвлөгөө болон зөвлөгөөг дагасны улмаас тэдэнд ирсэн адислалуудын тухай тэмдэглэлдээ бичихийг тэднээс хүс.



Судар судлах ур чадваруудыг ашиглах нь санваарын тухай илүү ихийг мэдэхэд надад хэрхэн туслах вэ?

Санваарын тухай сурч мэдэх хамгийн сайн аргуудын нэг бол судруудыг судлах явдал мөн. Судруудыг судлах нь тэдгээрийг зүгээр нэг уншаад өнгөрөх явдал биш. Бид санваарын тухай заадаг судруудыг ойлгохын тулд хүнд үгсийн тодорхойлолтыг унших, зүүлт тайлбар, суралцахад туслах бусад гарын авлагуудыг ашиглах зэрэг судар судлах ур чадварыг эзэмшиж, хэрэглэж сурах хэрэгтэй.

Ямар судрууд санваарын тухай ойлгоход тань тусалсан бэ? Судар судлах ямар ур чадвар судруудыг сайн ойлгоход тань тусалсан бэ?

Санваарын тухай өсвөр үеийнхэнд ямар асуултауд байдаг вэ? Санваарын тухай илүү ихийг мэдэхийн тулд судруудыг ашиглахад тэдэнд ямар ур чадварууд туслах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар ба суралцах материалуудыг залбирч судал. Заадаг өсвөр үеийнхэнтэйгээ юуг хуваалцах хэрэгтэй гэж та бодож байна вэ?

С ба Г 20:46–59 (Аароны санваарын үүргүүд)

Бойд К.Пакэр “Ахлагч бүрийн, мөн эгч бүрийн сайн мэдэх ёстой зүйл” *Ensign*, 1993 оны 2-р сар, 7–13

С ба Г 121:34–46 (Санваарын хүч нь зөв шударга байдлын зарчмуудаас хамааралтай байдаг)

“Судруудаас заах нь” *Teaching, No Greater Call* (1999), 54–59

С ба Г 84:33–44 (Санваарын тангараг ба гэрээ)

“Санваар” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 124–28

“Мелкизедек санваар,” Библийн лавлах

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний хамаарлыг олж харахад нь та тэдэнд яаж тусалж чадах вэ? Дараах санаанууд танд тусалж болно:

- Санваар ба санваарын түлхүүрүүдийн тухай асуух гэсэн бүх асуултаа асуухад өсвөр үеийнхнийг урь.
- Судрыг уншаад ойлгохгүй бол яадаг вэ? гэж өсвөр үеийнхнээс

асуу. Судар судлахад ямар материалууд тэдэнд тусалдаг вэ? Тэд судрын тухай ойлголтоо гүнзгийрүүлэхийн тулд өөр юу хийдэг вэ?

Заахад туслах арга

“Харцаараа суралцагчидтай харилцах нь тэднийг хичээлд идэвхтэй оролцуулах нэг арга зам мөн. Харцаараа суралцагчидтай харилцсанаар та сургалтын материал дээр биш, харин зааж байгаа хүмүүс дээрээ анхаарлаа төвлөрүүлдэг. Тайлбар яриа, асуултуудыг нь сонсох үед суралцагчидтай харцаараа харилцахад та тэдний ярьж байгаа зүйлийг сонирхож байгааг тэд мэдрэх болно” (Teaching, No Greater Call [1999], 71).

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь санваарын тухай илүү ихийг мэдэхийн тулд судар судлах ур чадварыг хэрхэн ашиглахыг ойлгоход өсвөр үеийнхэнд тусална. Ариун Сүнсний удирдалжийг даган ангийнханд чинь хамгийн сайн тохирох нэг буюу түүнээс олон үйл ажиллагааг сонгоорой:

- Сургаал ба Гэрээ 121:34–46-г уншиж, эзгэнэх, хянах, шилбүүрийн эсрэг өшиглөхөөр, сэнхрүүлээр зэрэг ойлгоход хүнд үгсийг олоход өсвөр үеийнхнийг урь. Эдгээр үгсийн тайлбарыг толь бичгээс харах буюу судрын шүлгүүдийг дахин уншихыг өсвөр үеийнхнээс хүс. Эдгээр үгсийг тайлбарласны дараа өсвөр үеийнхний ойлголт өмнөхөөсөө сайжирсан уу? Санваарын тухай өөр судруудыг сонгож, мэдэхгүй буюу ойлгоход хүнд үгсийг тайлбарлахад өсвөр үеийнхнийг урь (жишээ нь тэд *Итгэлдээ үнэнч байх нь* товхимлын “Санваар” хэсэгт эсвэл ерөнхийлөгч Бойд К.Пакэрын “Ахлагч бүр бас эгч бүр юуг сайн мэдэх ёстой вэ?” өгүүлэл дэх судруудыг судалж болно). Олж мэдсэн зүйлээ хуваалцахыг тэднээс хүс.
- Сургаал ба Гэрээ 20:46–59 эсвэл 84:33–44-аас судлах нэг, хоёр

шүлгийг ангийн гишүүн бүрд хуваарилж өг. Санваарын тухай өөр мэдээллийг олж үзэхийн тулд эдгээр шүлгийн зүүлт тайлбарыг ашиглахад тэднийг урь. Олж мэдсэн зүйлээ хуваалцахыг тэднээс хүс. Зүүлт тайлбарууд судруудыг илүү сайн ойлгоход тэдэнд хэрхэн тусалсан бэ?

- Саяхан хамаатны нэг хүн нь Мелкизедек санваар авсан тухай найздаа ярьж байна гэж төсөөлөн бодохыг өсвөр үеийнхнээс хүс. Тэд сүмийн тухай мэдэхгүй найздаа Мелкизедек санваарын тухай юу гэж тайлбарлах вэ? Хэрэв найз нь асуултууд асуувал тэд ямар судруудыг хуваалцах вэ? Библийн лавлахаас “Мелкизедек Санваар”-ын тайлбарыг уншиж, найзтайгаа ярилцах үед ямар судруудыг ашиглаж болохыг мэдэхийг өсвөр үеийнхнээс хүс.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлсийнхээ тухай хуваалцахыг хүс. Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Судар судлах ур чадварыг ашиглах нь санваарын тухай илүү ихийг мэдэхэд тэдэнд тусална гэдгийг тэд ойлгосон уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өнөөдөр санваар болон санваарын түлхүүрүүд мөн сайн мэдээний бусад сэдвүүдийг судлах үеэр эзэмшсэн ур чадвараа ашиглахад өсвөр үеийнхнийг урамшуулан дэмж. Дараа дараагийн хичээлүүд дээр сурч мэдсэн зүйлээ хуваалцахад тэднийг урь.

Сайн мэдээг судалснаар хүлээн авсан адислалуудынхаа тухай өсвөр үеийнхэнд ярь.

Аврагчийн арга барилгаар заах нь

Аврагч Өөрийн сайн мэдээг бусадтай хэрхэн хуваалцахыг шавь нартаа зааж, энэ ажлыг тэдэнд итгэмжлэн даатгаж, тэднийг бэлтгэсэн билээ. Санваарын тухай илүү ихийг мэдэж, сурч мэдсэн зүйлээ бусадтай хуваалцахыг хүсэхэд нь та өсвөр үеийнхэнд хэрхэн сүнслэгээр нөлөөлж чадах вэ?

Сонгосон материалууд

“Санваар” хэсгээс эш татав. Сайн мэдээний номын сан, LDS.org

Санваар

Санваар гэдэг нь Бурханы эрх мэдэл ба мөнхийн хүч юм. Бурхан санваараар дамжуулан газар, тэнгэрийг бүтээсэн бөгөөд тэдгээрийг санваараар удирддаг билээ. Тэрбээр энэ хүчээр дамжуулан Өөрийн хүүхдүүдийг гэтэлгэн, өргөмжилж, “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчирдаг” (Моисе 1:39). Бурхан санваарын эрх мэдлийг Сүмийн зохистой эрэгтэй гишүүдэд олгодог бөгөөд тэд Түүний хүүхдүүдийн авралын төлөө Түүний нэрээр үйлддэг бөлгөө. Сайн мэдээг номлох, авралын ёслолуудыг гүйцэтгэх, дэлхий дээрх Бурханы хаант улсыг удирдах эрх мэдэл санваартнуудад байдаг.

Сүмийн эрэгтэй гишүүд 12 нас хүрээд санваарын үйлчлэлээ эхэлдэг. Тэд Аароны санваартан болдог бөгөөд хожим нь тэдэнд олгох Мелкизедек санваартан байхад бэлтгэгдэх болно. Тэд амьдралынхаа өөр өөр үе шатуудад, өөр өөр үүрэг хариуцлага хүлээхэд өөрсдийгөө бэлдэх үедээ дикон, багш, эсвэл Аароны санваарын прист ба Мелкизедек санваарын дээд прист зэрэг өөр өөр албанд томилогдон үйлчилдэг.

Сүмийн эрэгтэй гишүүн санваартан болохын тулд эрх мэдэл бүхий санваартан нь санваарыг түүнд олгож, түүнийг санваарын албанд томилдог. (Еврей 5:4; С ба Г 42:11; Итгэлийн Тунхаг 1:5-ыг үзнэ үү)

Санваарын эрх мэдэл нь Сүмийн зөвхөн зохистой эрэгтэйчүүдэд олгогддог боловч санваарын адислалууд нь эрэгтэй, эмэгтэй мөн хүүхдүүд—бүгдэд боломжтой юм. Зөв шударга санваартан удирдагчдын нөлөө бид бүгдэд ач тустай бөгөөд бид

бүгд санваарын авралын ёслолуудыг хүлээн авах онцгой эрхтэй хүмүүс юм. . . .

Санваарын түлхүүрүүд

Санваарын түлхүүр атгагч тэдгээр нь Сүм дэх санваарын эрх мэдлийг хэрэгжүүлдэг. (С ба Г 65:2; 124:123-г үзнэ үү). Санваарын түлхүүр атгагч тэдгээр нь эрх мэдлийнхээ дагуу Сүмийг тэргүүлэх мөн чиглүүлэх эрх мэдэлтэй. Жишээлбэл: бишоп өөрийн тойргоо тэргүүлэх боломжтой болгодог түлхүүрүүдийг атгадаг. Цаашилбал тухайн тойргийн хүүхэд баптисм хүртэхээр бэлэн болох үед түүний баптисмыг гүйцэтгэх хүн бишопоос эрх мэдэл хүлээн авах ёстой.

Есүс Христ санваарын бүх түлхүүрүүдийг атгадаг. Тэрээр Өөрийн дагалдагчдаа Түүний Сүмийг удирдахын тулд шаардлагатай түлхүүрүүдийг өгдөг. Сүмийн Ерөнхийлөгч хамгийн ахмад дагалдагч нь Сүмийг бүхэлд нь удирдах эдгээр түлхүүрүүдийг (эсвэл өөр хүнд ашиглах эрх мэдэл олгож) ашиглаж болно. (С ба Г 43:1–4; 81:2; 132:7-г үзнэ үү).

Сүмийн Ерөнхийлөгч санваарын түлхүүрүүдийг санваарын бусад удирдагчдад хариуцсан нутаг дэвсгэртээ тэргүүлж болохын тулд олгодог. Санваарын түлхүүрүүд нь ариун сүмийн, номлолын, гадасны, ба дүүргийн ерөнхийлөгчдөд, бишопууд, салбарын мөн чуулганы ерөнхийлөгчдөд олгогддог. Эдгээр албан тушаалуудын нэгэнд үйлчилж байгаа хүн эдгээр түлхүүрүүдийг албан тушаалаасаа буух хүртэл атгадаг. Зөвлөхүүд түлхүүрүүд атгадаггүй боловч дуудлага болон даалгавраараа эрх мэдэл, үүрэг хариуцлага хүлээдэг.

Судрын эшлэлүүд: Иохан 15:16; Үйлс 8:14–20; Иаков 5:14–15; С ба Г 13; 20; 84; 107; Иосеф Смит—Түүх 1:68–73



Би санваарын тухай бусдад заахдаа түүхүүдийг хэрхэн ашиглаж болох вэ?

Түүхүүд нь бидний заах үйл явцыг баялаг агуулгатай болгож, зааж байгаа хүмүүсийн сонирхлыг татдагаас гадна биднийг чухал жишээнүүдээр хангаж, Есүс Христийн сургаалуудыг дагаснаас ирдэг адислалуудыг харуулдаг. Санваарын тухай заахад бидний ашиглаж болох олон түүх судрууд ба амьд бошиглогчдын үгс болон бидний өөрсдийн амьдралд байдаг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар, суралцах материалыг залбирч судлаарай. Санваарын тухай бусдад заахдаа түүхүүдийг хэрхэн ашиглахыг ойлгоход нь өсвөр үеийнхэнд юу тусалж болох вэ?

Лук 10:1 (Аврагч Далыг томилов)

Дэвид А.Бэднар “Тэнгэрийн хүчнүүд,” *Ensign* эсвэл *Liahona*, 2012 оны 5-р сар, 48–51

Үйлс 3:1–9 (Петр төрөлхийн хазгар хүнийг эдгээв)

Л.Том Пэрри, “Аароны санваар,” *Ensign* эсвэл *Liahona*, 2010 оны 11-р сар, 91–94

Үйлс 8:14–24 (Симон санваарыг мөнгөөр худалдаж авахыг хүсэв)

“Түүхүүд,” *Teaching, No Greater Call* (1999), 179–82

3 Нифай 18:1–9 (Есүс ариун ёслолыг гүйцэтгэв)

Дийтр Ф.Угдорф, “Чин үнэнч байх нь,” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 66–69

Видео бичлэгүүд: “Өөрсдийгөө ариусга,” “Дайны үед тохиосон гайхамшиг”

Санваарын тухай ямар туршлага таны гэрчлэлийг бэхжүүлсэн бэ? Судрын ямар түүхүүд болон амьд бошиглогчдын үгс санваарын хүчийг ойлгоход тань тусалсан бэ?

Өсвөр үеийнхэн санваарын талаар ямар туршлагатай вэ? Санваарын тухай ямар түүхүүд тэдний гэрчлэлийг бэхжүүлэхэд туслах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээл эсвэл найзуудтайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний хамаарлыг олж харахад нь та нар тэдэнд яаж тусалж чадах вэ? Дараах санаанууд танд тусалж болно:

- Хувиараа, гэр бүлээрээ, семинарт болон сүмийн бусад хичээл дээр судалж, мэдсэн зүйлээ амьдралд хэрхэн хэрэгжүүлж байгаа тухайгаа хуваалцахад өсвөр үеийнхнийг урь.

- Санваарын тухай гэрчлэлийг нь бэхжүүлсэн туршлагаасаа хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс. Та өөрийн туршлагыг хуваалцаж болно. Түүх хуваалцах нь яагаад санваарын тухай бусдад заах сайн арга зам болдгийг өсвөр үеийнхнээс асуу.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаанууд санваарын тухай бусдад заахдаа түүхүүдийг хэрхэн ашиглахыг ойлгоход нь өсвөр үеийнхэнд тусална. Ариун Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Ариун ёслолын цуглаан дээр санваарын талаар үг хэлэхийг тэднээс хүссэн хэмээн төсөөлөн бодохыг өсвөр үеийнхнээс хүс. Судраас санваарын тухай заадаг (өвчтэй хүнийг эдгээсэн буюу ёслолуудыг гүйцэтгэсэн гэх мэт) түүхийг олж, хэлэх үгэндээ ашиглахыг тэднээс хүс. Шаардлагатай бол тэд энэ тоймд санал болгосон судруудыг ашиглаж болно. Олсон судрын түүхээ ангийнхантайгаа хуваалцаж, уг түүх санваарын тухай юу зааж байгааг болон үүнийг хэлэх үгэндээ хэрхэн ашиглаж болохыг тайлбарлахад тэднийг урамшуулан дэмж.

- Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсээс санваарын тухай нэг түүх уншихыг ангийн гишүүн бүрд даалга (ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын хэлсэн Потемкиний тосгоны талаарх түүхийг “Чин үнэнч байх нь” үгээс, ахлагч Дэвид А.Бэднарын аавынх нь тухай түүхийг ахлагч Дэвид А.Бэднарын “Тэнгэрийн хүч” үгээс эсвэл ахлагч Л.Том Пэрригийн хэлсэн “Аароны санваар” үгээс Аароны санваарын зөвлөхийн гэрчлэл дэх түүхүүд гэх

мэт). Өсвөр үеийнхнийг уншсан түүхээ дүгнэж, уг түүх санваарын тухай юу зааж байгааг тайлбарлахыг хүс. Эдгээр түүхийг ашиглан санваарын тухай бусдад заах ямар боломж өсвөр үеийнхэнд байж болох вэ?

- Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсээс санваарын тухай нэг түүх уншихыг ангийн гишүүн бүрд даалга (Санваарын адислал хүлээн авсан Брадын тухай түүхийг ерөнхийлөгч Томас С.Монсоны “Хамгийн сайнаараа бай” хэлсэн үгээс, ахлагч Дэвид А.Бэднарын аавынх нь тухай түүхийг “Тэнгэрийн хүчнүүд” хэлсэн үгээс нь эсвэл Аароны санваарын зөвлөгчийн гэрчлэлийг ахлагч Л.Том Пэрригийн “Аароны санваар” хэлсэн үгээс олж болно). Тэднийг уншсан түүхээ дүгнэж уг түүх санваарын тухай юу зааж байгааг тайлбарлахыг хүс. Эдгээр түүхийг ашиглан санваарын тухай бусдад заах ямар боломж өсвөр үеийнхэнд байж болох вэ?

Заахад туслах арга

Зарчмуудыг олох нь.

Зарчим гэдэг нь бидний үйлдлийг удирдах мөнхийн үнэн юм. Зарчмууд нь заримдаа судрууд болон бошиглогчдын үгсэд шууд утгаараа байдаг бол зарим үед түүх эсвэл жишээн дээр далд утгаар хэлэгдсэн байдаг. Энэ хэсгийн эхний үйл ажиллагаанд өсвөр үеийнхнийг санваартай холбогдолтой зарчмуудыг дүрсэлсэн түүхийг олоход урьсан байгаа. Эдгээр зарчмыг таньж мэдэж сурахад нь туслахын тулд та тэднээс “Энэ зарчмыг ойлгоход туслах эдгээр судраас би юу сурах вэ? Энд Аврагчтай илүү адил болохыг надад заах ямар нэгэн зүйл байна уу?” гэх мэт асуултыг тавьж болно. Тэднийг хувиараа болон гэр бүлээрээ сайн мэдээг судлахдаа зарчмуудыг хайхад урамшуулан дэмж.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлийнхээ тухай хуваалцахыг хүс. Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Бусдад санваарын тухай заахдаа түүхүүдийг хэрхэн ашиглаж болохыг тэд ойлгож байна уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан зүйлсийнхээ дагуу юу хийхээр сүнсээр өдөөгдсөнийг нь өсвөр үеийнхнээс асуу. Тэрхүү өдөөлтийнхөө дагуу үйлдэхэд нь тэднийг урамшуулан дэмж. Суралцагчдын ойлголтыг шалгаж болох арга замуудыг олохын тулд залбирч, Сүнсийг эрэлхийл.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч зааж байгаа хүмүүстээ ойлгомжтой энгийн түүх, сургаалт зүйрлэл болон амьдралын бодит жишээнүүдийг хуваалцдаг байлаа. Та санваарын хүчийг ойлгоход нь тэдэнд туслахын тулд ямар түүхүүдийг өсвөр үеийнхэнтэй хуваалцаж болох вэ? Санваарын тухай бусдад заахад нь тэдэнд туслах ямар түүхүүдийг өсвөр үеийнхэн мэддэг вэ?

Сонгосон материалууд

Л.Том Пэрригийн “Аароны Санваар” хэлсэн үгээс эш татав. Ensign эсвэл Лиахона 2010 оны 11-р сар, 91–94

Аароны санваарын залуу эрэгтэйчүүд ээ, итгэлийн тань дагуу Их Эзэн та нарын амьдралыг адисална хэмээн амласан чухал гэрээ байдгийг би та нарт гэрчилж байна. Хэрвээ та нар Ариун Сүнсний сэрэмжлүүлгийн дуу хоолойд чих тавин Түүний зааврыг дагах юм бол тэнгэр элчүүдийн тохинууллаар адислагдах болно. Энэхүү адислал нь та нарын амьдралд мэргэн ухаан, мэдлэг, хүч болон алдар сууг нэмэх болно. Энэ бол Их Эзэний та нарт амласан адислал билээ.

Хэдэн сарын өмнө би нэгэн тойргийн мацгийн ариун ёслолд оролцсон юм. Тэгэхэд нэгэн Аароны санваарын зөвлөх гэрчлэлээ хуваалцав. Түүний гэрчлэл надад Аароны санваартан нь тэнгэр элчүүдийн тохинууллын түлхүүрүүдийг атгадаг талаар талархах сэтгэгдлийг шинээр төрүүлсэн юм.

Тэр зөвлөх тойргийнхоо Аароны санваартан залуучуудад өглөө нь тохиолдсон явдлаас хуваалцав. Түүнийг өглөө сүм рүү очиж явахад нь мацгийн өргөлийн дугтуй барьсан хоёр залуу дикон гишүүдийн гэрээр айлчилж байгааг ажигласан байна. Тэд ням гаргийнхаа хамгийн сайн хувцсаа өмсөн үүрэг даалгавраа хэрхэн нягт нямбай хийж байгааг нь хараад сэтгэл нь их хөдөлжээ. Дараа нь тэр зөвлөх нөгөө хоёр санваартан ахыг дагуулан хөгжлийн бэрхшээлтэй залуу эрэгтэйчүүдийн гэрээр айлчлан ариун ёслолыг түгээв. Энэ нь тэр хоёрын хувьд анхных байсан ба тэд санваарын үүрэг хариуцлагадаа хичнээн хүндэтгэлтэй мөн чин сэтгэлээсээ хандаж байгаа нь илт байв.

Дараа нь тэрээр зүрх сэтгэлийг нь маш их хөдөлгөсөн нэгэн туршлагыг товчхон хуваалцав. Учир нь нөгөө хоёр санваарын нэг нь Есүс

Христийн— жинхэнэ тохинуулал бүр тэнгэр элчийн тохинуулал гэж юу болохыг түүнд харуулсан ажээ. Тэр залуу санваартан ариун ёслолын усыг түгээн явсаар цугларсан хүмүүсийн дунд суугаа Дауны хам шинж өвчтэй нэгэн эрэгтэй хүн дээр ирэв. Тэр хүн усыг авч уух чадваргүй байсан юм. Залуу санваартан тэр даруй түүнд туслан зүүн гараа тэр хүний толгойн ард байрлуулан толгойг нь бага зэрэг гэдийлгээд баруун гараараа аягатай усыг аван эвтэйхэн, удаанаар түүний уруулд хүргэн усыг уулгасан юм. Тэрхэн мөчид өөрт нь үйлчилсэн тэр хүүд талархсан сэтгэл тэр хүний нүүрэнд—тодров. Тэгээд гайхамшигтэй залуу санваартан адислагдсан усаа цугласан бусад гишүүдэд түгээхээр цааш явсан юм.

Санваарын зөвлөх энэхүү нандин мөчид төрсөн мэдрэмжээ өөрийн гэрчлэлдээ хуваалцахдаа, би сэтгэл зүрхэндээ баяр хөөрийг мэдэрч, дотроо уйлсан бөгөөд Сүм дуулгавартай, хайраар дүүрэн Аароны санваартан залуу эрэгтэйчүүдийн гарт байгаа гэдгийг мэдсэн хэмээв.

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлэхдээ: “Өөрийгөө ёс суртхууны хувьд цэвэр ариун байлгаж, итгэлтэйгээр сүмийн цуглаануудад оролцдог тийм залуу эрэгтэйг надад өг. Өөрийнхөө санваарын үүргийг ойлгон ухамсарладаг, Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь хөтөлбөрийг хийж гүйцэтгэн скаутынхаа бүргэд тэмдгийг хүлээн авсан тийм эрэгтэйг надад өг. Семинарын анги төгссөн мөн Мормоны номын чин сэтгэлийн гэрчлэлтэй тийм залуу эрэгтэйг надад өг. Ийм л залуу эрэгтэйг надад өг, харин би танд номлолын талбарт болон амьдралынхаа туршид Их Эзэний өмнөөс гайхамшигийг үйлдэж чадах тийм залуу эрэгтэйг өгье” гэжээ. (“To the ‘Youth of the Noble Birthright (Язгууртан гаралтай өсвөр үеийнхэн) Ensign, 1986 оны 5-р сар, 45).

БҮЛГИЙН ТОВЧ ТОЙМ

Долоодугаар сар: Ёслолууд ба гэрээнүүд

“Ёслолуудад ... бурханлаг чанарын хүч илэрхийлэгддэг” (С ба Г 84:20).

Тэнгэр дэх Эцэг маань бидэнд зааж мөн биднийг Түүнтэй хамт амьдрахад бэлтгэхийн тулд сайн мэдээний ёслол ба гэрээнүүдийг ашигладаг. Энэ хэсэгт та ёслол ба гэрээнүүдийн талаар судлах үедээ сайн мэдээг судалж мөн заахад нь өсвөр үеийнхэнд туслах боломжтой байх болно. Сурч байгаа зүйлийнхээ тухай, илүү ихээр сурахыг эрэлхийлж мөн олж мэдсэн зүйлээ бусдад заах талаарх асуултуудыг асуухад нь тэднийг урамшуулан дэмж.

Энэ сард сонгох тоймууд

Би сайн мэдээний ёслолуудаас ямар сүнслэг үнэнүүдийг сурч болох вэ?

Би гэрээнүүдийн тухай ойлголтоо хэрхэн гүнзгийрүүлэх вэ?

Би Ариун ёслолыг өөрийнхөө хувьд хэрхэн илүү утга учиртай болгох вэ?

Би Аврагчийг үргэлж дурсан санах гэрээгээ хэрхэн сахих вэ?

Би Ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахад өөрийгөө хэрхэн бэлдэх вэ?



ДОЛООДУГААР САР: ЁСЛОЛУУД БА ГЭРЭЭНҮҮД

Би сайн мэдээний ёслолуудаас ямар сүнслэг үнэнүүдийг сурч болох вэ?

Ёслолууд нь ариун нандин бөгөөд санваарын эрх мэдлийн дор гүйцэтгэгддэг. Ёслолууд нь сайн мэдээний үнэнүүдийг бэлгэддэг бөгөөд эдгээр нь бидэнд Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөө ба Есүс Христийн Цагаатгалын тухай заадаг билээ. Ёслолууд нь бидэнд хэн болохыг маань заадаг. Мөн Их Эзэний өмнө хүлээх бидний үүргийг сануулдаг. Ёслолууд дахь бэлгэдлийн талаар судлах нь сайн мэдээг илүү бүрэн дүүрэн ойлгоход бидэнд тусалдаг бөгөөд Есүс Христэд итгэх бидний итгэлийг хүчирхэгжүүлдэг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судрууд болон материалуудыг залбирч судлаарай. Сайн мэдээний ёслолууд дахь бэлгэдлээс өсвөр үеийнхэн юу сурч чадах вэ?

Лук 22:19–20; 3 Нифай 18:1–11
(Ариун ёслол нь Аврагчийн бие ба цусыг төлөөлдөг)

Ром 6:3–6; С ба Г 76:51 (Баптисм нь Христийн үхэл ба амилалт мөн бидний сүнслэг дахин төрөлтийг бэлгэддэг)

С ба Г 84:19–22 (Бурханлаг хүч чадал нь санваарын ёслолуудаар дамжин илэрхийлэгддэг)

Бойд К.Пакэр “Ариун нандин ариун сүм” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 10-р сар, 29–35

Дэннис Б.Нэшвандэр, “Ёслолууд ба Гэрээнүүд,” *Ensign*, 2001 оны 8-р сар, 20–26

“Аврагч болон Түүний Цагаатгалыг дурсан санах нь” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 25–26

“Ёслолууд” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 99–100

“Зүйрлэлүүд ба үзүүлэнт хичээлүүд” *Teaching, No Greater Call* (1999), 163–64

Та өөрөө болон гэр бүлээрээ хүлээн авсан ёслолуудынхаа талаар бод (баптисм, ариун ёслол ба ариун сүмийн ёслолууд гэх мэт). Эдгээр ёслолоос та сайн мэдээний ямар үнэнүүдийг сурсан бэ?

Танай ангийн өсвөр үеийнхэн сайн мэдээний ёслолуудад талархдаг уу? Тэд баптисм ба ариун ёслолын бэлгэдлийг ойлгодог уу?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутын туршид өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн

мэдээний нөлөөг олж харахад нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Эдгээр санаанууд тусалж болох юм:

- Найздаа сургаалын үнэнийг тайлбарлаж байсан бол туршлагаасаа хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс.
- Тэд эсвэл гэр бүлийнх нь гишүүн нь саяхан ёслол хүртсэн бол туршлагаасаа хуваалцахад урь (баптисм, санваарын томилгоо эсвэл ариун сүмийн ёслолууд гэх мэт). Ёслолын юу нь тэдэнд онцгой сэтгэгдэл төрүүлсэн бэ?

Сайн мэдээг судлах ур чадварууд

Бэлгэдлүүдийг ойлгох нь. Судрууд дахь сургаалт үлгэр ба бэлгэдлүүдийг ойлгохын тулд өсвөр үеийнхэн бэлгэдлүүдийг таньж, бэлгэдлүүдийн хэсгийг таньж мэддэг мөн тэдгээрийг ойлгож чаддаг байх ёстой. Бэлгэдлийг таних нэг арга бол ижил, зүйрлэгдэнэ, мэт эсвэл адил зэрэг үгсийг олох явдал юм. Өсвөр үеийнхэн бэлгэдлүүдийн хэсгийг жагсаан бичиж болно (талх эсвэл ус гэх мэт). Бэлгэдлүүдийг ойлгохын тулд тэд Сүмийн бусад эх сурвалжуудыг (Сүмийн сэтгүүл, чуулган дээр хэлсэн үгс болон бусад судрууд гэх мэт) ашиглаж мөн сайн мэдээний зарчмыг ойлгоход бэлгэдэл хэрхэн тусалж байгааг тунгаан бодож болно. Тэднийг хувиараа судраас суралцахдаа сургаалт үлгэр ба бэлгэдэл гарах бүрд ийн хийж байхад урамшуулан дэмж.

Хамтдаа суралц

Дараах бүх үйл ажиллагаа нь сайн мэдээний ёслолууд дахь сүнсэлэг үнэнүүдийг олоход нь өсвөр үеийнхэнд тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Ангийг хоёр бүлэг болгон хуваарил. Нэг бүлэгт баптисм юу бэлгэддэг, нөгөө бүлэгт ариун ёслол юу бэлгэддэг болохыг судрууд болон бусад материалуудыг (энэхүү тоймд санал болгосон материалууд) ашиглан судлахыг даалга. Эдгээр ёслол нь тэдэнд Цагаатгалын тухай юу заадаг вэ? Бүлэг бүрээс сурсан зүйлээ бусадтайгаа хуваалцахыг хүс. Тэд *Сайн мэдээний уран зургийн цуглуулга*-ын 103–4 ба 107–8-р зургуудыг ашиглаж болно. Эдгээр ёслолын бэлгэдлийг ойлгох нь дараагийн удаа ёслолуудад оролцоход тэдний бодол санаа болон мэдрэмжинд хэрхэн нөлөөлөхийг өсвөр үеийнхнээс асуу.
- Өсвөр үеийнхнийг ахлагч Дэннис Б.Нэшвандэрын “Ёслолууд ба гэрээнүүд” хэлсэн үгийн “Бурханыг таньж мэдэх арга” гарчигтай хэсгийг уншаад “Сайн мэдээний ёслолууд Бурханы тухай бидэнд юу

заадаг вэ?” гэсэн асуултад хариулт олохыг урь. Тэднээс уншсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэднээс дараагийн удаа ёслолд гэрчилж, оролцоходоо энэхүү асуултыг өөрсдөөсөө асуун, тэдэнд төрсөн бодол, сэтгэгдлээ дараагийн хичээлд дээр хуваалцахын тулд бичиж тэмдэглэхийг урамшуулан дэмж.

- “Teaching, No Greater Call” номын *Зүйрлэлүүд ба үзүүлэлт хичээлүүд*-ийг ангиараа уншаад Их Эзэн яагаад бидэнд бэлгэдлээр дамжуулан заадаг шалтгааныг олохыг хүс. Их Эзэн бидэнд баптисмын ёслол болон ариун ёслолоор дамжуулан мөнхийн ямар үнэн ба зарчмуудыг заадаг вэ? Өсвөр үеийнхнийг энэхүү асуултын хариуг энэ тоймд жагсаасан судруудаас эсвэл *Итгэлдээ үнэнч байх нь* номын баптисм ба ариун ёслолын хэсгээс олоход урамшуулан дэмж.

Өнөөдөр сурч мэдсэн зүйлийнхээ тухай хуваалцахыг тэднээс хүс. Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Сайн мэдээний ёслолууд дахь сүнсэлэг үнэнүүдийг хэрхэн хайж олохоо тэд ойлгож мэдэж байна уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү хугацаа зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

- Удахгүй болох гэж байгаа баптисм ба Ариун Сүнсний бэлэг өгөх ёслолд оролцохыг өсвөр үеийнхэнд санал болго. Өнөөдөр сурсан зүйл нь баптисм ба ариун ёслолыг хүртэх

талаарх тэдний бодолд хэрхэн нөлөөлөх вэ?

- Сайн мэдээний ёслолуудын хүч чадлын тухай гэрчлэлээ хуваалц.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч бусдыг итгэлээр үйлдэж мөн Түүний заасан үнэний дагуу амьдрахыг уриалдаг. Өөрийг нь дагагч тэдэнд хүчирхэг туршлагуудаар дамжуулан сурах боломжийг Тэрээр өгсөн. Өсвөр үеийнхэн өөрсдийн оролцсон ёслолуудаасаа Цагаатгалын тухай суралцахад нь та хэрхэн тусалж чадах вэ?

Видео бичлэг: “Бидэнд сайн мэдээнээс суралцахад туслаач”

Сонгосон материалууд

Дэннис Б.Нэшвандер, “Ёслолууд ба гэрээнүүд” –ээс эш татав, Ensign, 2001 оны 8-р сар, 20–26

Бид ариун нандин ёслолуудад оролцсоноор Бурханы хаант улсын дэг жаяг хийгээд Түүний тухай их зүйлийг сурч авдаг. Жишээ нь, хэн нэгэн сайн мэдээний анхны ёслолуудын нэг болох баптисм хүртэхээс өмнө ариун сүмд орж, хамгийн ариун нандин ёслолуудыг гүйцэтгэдэг байсан бол хачин санагдана биз дээ. Бурханы хаант улсад дэг жаяг байдаг бөгөөд, үүний талаар суралцахад ч мөн дэг жаяг байдаг. . . .


Бид бүх зүйлийг нэгэн зэрэг хүлээж авдаггүй, гэхдээ уг мэдлэгийг хүлээн авахад зохистой, дуулгавартай байгаа үедээ бид ариун зүйлсийн талаарх мэдлэгийг аажим аажмаар, бага багаар хүлээн авдаг. Хаант улсын анхны ёслол болох баптисмаас эхлээд ариун сүмд гүйцэтгэгддэг хамгийн ариун нандин ёслолууд хүртэл бид санваарын баталгаа болон томилолт гэх мэт бусад ёслолуудаар дамжуулан өсч хөгждөг. Сайн мэдээний ариун нандин ёслолуудад оролцсоноор, хаант улсын талаарх бидний мэдлэгийг дэг жаягтай болгодог, тэгснээр Бурхан өөрийн мөн чанарыг бидэнд илчилдэг.

Ариун нандин ёслолууд болон Бурханы талаарх мэдлэг хоёр хоорондоо нягт уялдаа холбоотой. Тиймээс, бид Түүний томилсон ёслолуудад оролцсоноор Бурханы талаар ямар зүйлсийг сурч авдаг вэ? Жишээ болгон баптисмыг авч үзье. Усанд умбуулалтаар хийх баптисм нь нүглүүдийн ангижралын төлөө хийгддэг юм. Нүглээ бүрэн дүүрнээр, зүрх сэтгэлийнхээ бүх тэмүүлээр наманчилсан тэр нь баптисмыг хүлээн авдаг бөгөөд Бурханд зөвхөн өршөөх мөн тухайн нүглийн төлөөх гэмшлийн дарамтыг зайлуулах хүч

байдаг төдийгүй Тэрээр үүнийг үнэхээр хийдэг гэдгийг мэддэг. Энэ хүн өөрийнхөө туршлагаас Бурханы талаар болон Түүний сүр жавхлант хүч чадал хийгээд нинжин сэтгэлийн талаар ямар нэгэн зүйлийг мэдэж байдаг. Эдгээр зүйлийн зайлшгүйг мэдэж авах цорын ганц зам бол баптисмын ёслолд зохистойгоор оролцох явдал юм.

Баптисм нь Бурханы хаант улсад орох хаалгыг нээдэг ба энэ хаалгаар цэвэр ариун төдийгүй мөн Бурхан өршөөдөг гэдэг бат мэдлэгтэй хүн ордог. Сайн мэдээний бусад бүх ариун нандин ёслолын талаар бас адил авч үзэж болно. Дуулгавартай байхын хэрээр үхэл бидний үнэ цэнэтэй харилцааг төгсгөхгүй гэсэн итгэл үнэмшлийг хүчирхэгжүүлдэг ариун сүмийн ёслолуудад бид бэлтгэгддэг. Бид эдгээр зүйлийг заах ёслолуудад оролцсоноор энэ мэдлэгийг олж авдаг. Ийнхүү оролцоогүй тохиолдолд тэдгээрийг мэдэх боломжгүй билээ. Бошиглогч Иосеф Смит биднийг ариун нандин ёслолуудад оролцсоноороо чухал ариун үнэнийг мэдэж авахтай холбоотой дараах зүйлийг заасан юм: “Бусдын туршлагыг, эсвэл бусдад өгөгдсөн илэрхийлэлтийг *унших нь*, бидэнд *бидний* нөхцөл байдлын талаар болон Бурхантай харилцах бодит харилцааны талаар хэзээ ч бүрэн дүүрэн ойлголт өгч чадахгүй. Эдгээр зүйлийн талаарх мэдлэгийг Бурханы уг зорилгын тулд өгсөн ёслолуудыг хүлээн авснаар л мэдэж авах болно.” [*“Бошиглогч Иосеф Смитийн сургаал”* 324; emphasis in original.]

Ариун нандин ёслолууд нь Бурханы хаант улсын дэг жаягийг бага багаар илчлэх явцад бид тэдгээр ёслолыг хүлээн авснаараа Бурханы зан төлөв, шинж чанарын мэдлэг бидэнд илчлэгддэг юм. Гагцхүү энэ л арга замаар энэхүү мэдлэг олгогддог.



ДОЛООДУГААР САР: ЁСЛОЛУУД БА ГЭРЭЭНҮҮД

Би гэрээнүүдийн тухай ойлголтоо хэрхэн гүнзгийрүүлэх вэ?

Бид сайн мэдээний ёслолуудад оролцохдоо Тэнгэрлэг Эцэгтэйгээ гэрээ хийдэг. Биднийг гэрээнүүд хийхэд Бурхан тодорхой болзлуудыг тавьдаг. Бид эдгээр болзлыг дагах аваас Тэрээр биднийг адисална хэмээн амладаг. Бид гэрээнүүдийг илүү сайн ойлгох үедээ эдгээрийг хүндлэх мөн Тэнгэрлэг Эцэгийнхээ амласан адислалыг хүлээн авах боломжтой болдог.

Та хийсэн гэрээгээ хэрхэн ойлгож байсан бэ? Ямар судар ба материалууд танд тусалсан бэ?

Танай ангийн өсвөр үеийнхэн өөрсдийн хийсэн мөн ирээдүйд хийх гэрээгээ хэр сайн ойлгодог вэ? Тэд эдгээр гэрээний тухай судар ба бусад материалуудаас хэрхэн судлахаа мэдэх үү?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар ба материалуудыг залбирч судлан, өсвөр үеийнхэнд хийсэн мөн ирээдүйд хийх гэрээнүүдээ ойлгоход нь хэрхэн туслахаа тунгаан бод.

Мозая 18:8–10; С ба Г 20:37 (Баптисм хүртэхдээ хийдэг бидний гэрээнүүд)

С ба Г 20:77, 79 (Ариун ёслолын залбирлууд)

С ба Г 84:33–44 (Санваарын тангараг ба гэрээ)

Абрахам 2:8–11 (Абрахамын гэрээний нэг хэсэг болж Абрахамд өгсөн амлалтууд)

Рассэл М.Нэлсон “Гэрээнүүд” *Ensign* эсвэл *Лиакхона* 2011 оны 11-р сар, 86–89

“Гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээ” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 75

Миний сайн мэдээг номло (2004), 66–67, 91

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутын туршид, өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь та хэрхэн тэдэнд тусалж чадах вэ? Эдгээр санаанууд тусалж болох юм:

• Өсвөр үеийнхнийг гэртээ эсвэл найз нартайгаа сайн мэдээний аль

нэгэн сэдвээр ярилцсан саяхны туршлагаасаа хуваалцахыг урь.

- Хүмүүс гэрээнүүдийг хийж, сахиж мөн гэрээнүүдээ зөрчиж байгаа зургуудыг үзүүл (*Сайн мэдээний уран зургийн цуглуулга*-ыг үзнэ үү). Өсвөр үеийнхнийг гэрээ гэж юу болох, бид яагаад гэрээнүүд хийдэг

мөн гэрээгээ сахихад хүлээн авдаг адислалуудын тухай тайлбарлахад урь. Тэдэнд тусламж хэрэгтэй бол “Итгэлдээ үнэнч байх нь” номын *Гэрээ хэсгийг санал болго.*

Хамтдаа суралц

Сайн мэдээг судлах ур чадварууд

Жагсаалт гаргах. Энэ хичээл дээр өсвөр үеийнхнийг судруудыг судалж, сайн мэдээний гэрээнүүдтэй холбоотой амлалтуудыг жагсаан бичихэд урих болно. Жагсаалт гаргах нь өсвөр үеийнхэнд чухал санаануудыг олж танин, тэдгээрийг гүнзгий судлахад тусална. Хувиараа судраас судлах үедээ жагсаалт гаргахад нь тэднийг дэмж.

Видео бичлэг: “Бие биедээ заах нь”

Дараах бүх үйл ажиллагаа нь өсвөр үеийнхэнд гэрээнүүдийн талаарх ойлголтоо хэрхэн гүнзгийрүүлэх ёстойгоо сурахад тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Ангийн гишүүн бүрийг (хоёр хоёроороо эсвэл ганцаараа) гэрээг дүрсэлсэн судрын хэсгийг уншихад урь (энэхүү тоймд бичсэн судрууд гэх мэт). Тэднийг унших үед гэрээтэй холбоотой бидний өгдөг амлалтууд болон Бурханы өгдөг амлалтуудыг жагсаан бичихийг хүс. Өсвөр үеийнхэн бүрд гэрээний талаар сурсан зүйлээ бусдадаа заах боломж олго. Бурхан амлалтуудаа хэрхэн биелүүлдэг талаар тэд ямар туршлагаасаа хуваалцаж болох вэ?

- Өсвөр үеийнхнээс нэг гэрээг сонгоод, (баптисм, ариун ёслол эсвэл мөнхийн гэрлэлт гэх мэт) уг гэрээний талаар мэддэг зүйлээ хуваалцахад урь. Хуваалцсан зүйлээ самбар бичихэд тэднийг урь. Тэднийг уг гэрээнийхээ тухай судрууд (энэхүү тоймд санал болгосон зэрэг), *Итгэлдээ үнэнч байх нь* эсвэл *Миний сайн мэдээг номло* зэргээс судалж ойлголтоо гүнзгийрүүлэхэд урь.

- Энэхүү тоймд санал болгосон судрын хэсгүүдийн нэгийг ангиараа

уншаад, судруудад дүрсэлсэн амлалтуудыг жагсаан бичихийг өсвөр үеийнхнээс хүс. Ангийн гишүүн нэг бүрээс эдгээр амлалтаас нэгийг сонгон илүү гүнзгий судлахыг хүс. Тэд уг амлалтын талаар заасан судрын өөр өөр хэсгийг олж болно. Тэд мөн *Итгэлдээ үнэнч байх нь* ном эсвэл бусад эх сурвалжаас мэдээлэл хайж болно. Сурсан зүйлээ мөн энэ нь тэдний амьдралд хэрхэн нөлөөлөх талаар хуваалцахыг ангийнхнаас хүс.

- Бишопын зөвлөлийн гишүүн эсвэл бүрэн цагийн номлогчдыг ангид урьж, хүмүүсийг гэрээ хийхэд бэлтгэхэд нь туслахын тулд тэд юу хийдэг талаараа тайлбарлахыг урь. Гэрээнүүдийг ойлгоход хүмүүст номлогчид хэрхэн тусалдаг вэ? Хүмүүсийг гэрээнүүдээ сахихад номлогчид хэрхэн урамшуулан дэмждэг вэ? Өсвөр үеийнхнийг сонирхсон асуултаа асуухад нь дэмж.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд гэрээнүүдийн талаарх ойлголтоо хэрхэн гүнзгийрүүлэхээ ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сургаал дээр илүү хугацаа зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хувиараа суралцах үеэрээ ёслол ба гэрээнүүдийн талаар сурсан зүйлээ хуваалцахад бэлтгэж ирэхэд нь өсвөр үеийнхнийг дэмж.

Сайн мэдээг хичээнгүйлэн суралцсаны үр дүнд ирдэг адислалуудынхаа талаар гэрчлэлээ хуваалц.

Аврагчийн арга барилаар заах нь

Есүс бүхий л талаараа үлгэр жишээ ба багш байсан. Тэрээр өөрийн амьдралын хэв маягаар тэдэнд хэрхэн залбирах, хайрлах, үйлчлэхийг заасан. Та өөрийнхөө зааж буй өсвөр үеийнхэнд хэрхэн сайн үлгэр жишээ болохын тулд юу хийж болох вэ?

Сонгосон материалууд

“Гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээ”-ээс эш татав. Итгэлдээ үнэнч байх нь (2004), 98

Гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээ

Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөнд, эрэгтэй эмэгтэй хүмүүс бие биетэйгээ энэ амьдралд болон үүрд лацдан холбогдож чадна. Ариун сүмд лацдан холбогдож байгаа хүмүүс хэрэв гэрээнүүддээ үнэнч байх аваас тэдний харилцаа үүрд үргэлжлэх болно. Тэд юу ч, бүр үхэл ч тэднийг салгаж чадахгүй гэдгийг мэддэг.

Мөнхийн гэрлэлтийн гэрээ нь өргөмжлөлд чухал шаардлагатай юм. Иосеф Смитээр дамжуулан Их Эзэн илчлэхдээ: “Селестиел алдар сууд гурван тэнгэр буюу зэрэглэл буй; хамгийн дээдхийг нь олж авахын тулд хүн санваарын энэхүү ариун жаягт [гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээг хэлж буй] орох ёстой; мөн хэрэв тэрээр үүнийг хийхгүй аваас, тэрээр үүнийг олж авч чадах нь

үгүй. Тэрээр нөгөөд нь орж болно, гэвч тэр нь түүний хаант улсын төгсгөл болой; тэрээр өсөн нэмэгдэж үл чадна” гэжээ (С ба Г 131:1–4).

Хосууд лацдан холбох ёслолыг хүлээн авч, ариун сүмд ариун гэрээнүүдийг хийснийхээ дараа мөнхийн гэрлэлт болон өргөмжлөлийн адислалуудыг хүлээн авахын тулд цаашид итгэлтэй хэвээр байх ёстой. Их Эзэн хэлэхдээ:

“Хэрэв эр хүн миний хууль болох миний үгээр, мөн шинэ бөгөөд үүрдийн гэрээгээр нэг эхнэртэй гэрлэж, мөн энэ нь амлалтын Ариун Сүнсээр энэхүү хүч хийгээд энэхүү санваарын түлхүүрүүдийг миний томилсон, тослогдсон түүгээр тэдэн дээр лацдагдаж, мөн . . . хэрэв та нар миний гэрээг дагах аваас, . . . миний үйлчлэгч тэдэн дээр юуг ч тавилаа гэсэн бүх зүйлд энэ нь тэдэнд хийгдэх болно, мөн тэднийг дэлхийгээс гадна байхад бүрэн хүчтэй хэвээр байх болно” гэжээ (С ба Г 132:19).



Би хэрхэн ариун ёслолыг өөрийнхөө хувьд илүү утга учиртай болгох вэ?

Долоо хоног бүрийн ариун ёслолын үеэр бид амьдралаа дүгнэн цэгнэж, Аврагчийн Цагаатгалын тухай тунгаан мөн нүглээ наманчлахын тулд юу хийх ёстойгоо бодож үзэх ёстой. Ариун ёслолоос хүртэхийн тулд бид төгс төгөлдөр байх албагүй харин зүрх сэтгэлдээ наманчлалтай, даруу төлөв байх ёстой. Ариун ёслол нь сайн мэдээний дагуу амьдрахад өөрсдийгөө зориулах хүч чадал, боломжийн эх сурвалж болж чаддаг.

Та ариун ёслолыг илүү гүн гүнзгий утга учиртай болгохын тулд юу хийдэг вэ? Танд өсвөр үеийнхэнтэй хуваалцаж болох ариун ёслолтой холбоотой туршлагауд байгаа юу?

Өсвөр үеийнхэн ариун ёслолын ариун нандин чанарыг ойлгосноор ямар адислалууд авч болох вэ? Ариун ёслол эхлэхийн өмнө болон ариун ёслолын дундуур өсвөр үеийнхний анхаарлыг сарниулж болох ямар зүйлс байдаг вэ? Тэд эдгээр анхаарал сарниулах зүйлийг хэрхэн даван туулж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар, материалыг залбирч судал. Өсвөр үеийнхэнд ариун ёслолыг илүү гүн гүнзгий утга учиртай болгоход нь туслах ямар туршилагаас та тэдэнтэй хуваалцаж болох вэ?

Матай 26:26–28; 3 Нифай 18:1–13 (Аврагч ариун ёслолыг эхлүүлэв)

1 Коринт 11:23–29; 3 Нифай 9:20; С ба Г 20:37; 59:8–12 (Ариун ёслолоос зохистой хүртэхэд хэрхэн бэлтгэх вэ?)

Даллин Х.Өүкс “Ариун ёслолын цуглаан ба ариун ёслол,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2008 оны 11-р сар, 17–20

Шэрил А.Эсплин “Ариун ёслол бол бодгалийг шинэчлэгч,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 11-р сар, 12–14

“Ариун ёслол,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 147–149

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, Сүмийн бусад хичээл эсвэл найз нартайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь та хэрхэн тэдэнд тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Сайн мэдээний зарчмыг багш нь маш үр дүнтэй заасан талаар хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс.
- “Би _____ хийснээр ариун ёслолыг өөрийнхөө хувьд илүү

утга учиртай болгож чадна.” гэсэн өгүүлбэрийг өсвөр үеийнхнээс гүйцээн бичихийг хүс. Өөрсдийн хариултыг самбар дээр бичээд, хичээлийн туршид уг жагсаалтанд нэмж бичихэд тэднийг урь.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь ариун ёслолыг илүү гүн гүнзгий утга учиртай зүйл болгож сурахад өсвөр үеийнхэнд туслах юм. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго.

Сайн мэдээг судлах чадварууд

Судрууд дээрх үйл явдлыг төсөөлөн бодох нь. Энэ хэсгийн эхний үйл ажиллагаанд, хэрэв судруудын үйл явдлууд болсон газруудад байсан бол юу мэдэрч, юу хийх байсан талаар төсөөлөн бодоход өсвөр үеийнхнийг урина. Судруудын үйл явдлыг төсөөлөн бодох нь эдгээр түүхийг амьдралдаа хэрэгжүүлэхэд өсвөр үеийнхэнд тусалдаг. Тэднийг судраас судалж байхдаа үргэлж ийнхүү төсөөлөн боддог байхад урамшуулан дэмж.

- Мэддэг хэн нэгэн хүн нь тэдэнд тусгайлан зориулж ямар нэгэн зүйл хийсэн үеийн тухай бодоход өсвөр үеийнхнийг урь. Энэ нь тэдэнд ямар санагдсан бэ? Аврагч Цагаатгалыг бидний хүн нэг бүрийн төлөө гүйцэтгэснийг ойлгоход өсвөр үеийнхэнд туслахын тулд ахлагч Дэйл Г.Рэнландын “Би бүх хүмүүнийг өөртөө татаж болохын тулд” хэлсэн үгнээс “Яг одоо ямар зүг рүү” гэж эхэлж байгаа догол мөрийг хамтдаа уншихад урьж болно. Энэ хэлсэн үгэнд гарч буй эмэгтэй юуг мэдэж авсан бэ? Ариун ёслолыг илүү утга учиртай туршлага болгохын тулд өсвөр үеийнхэн юу хийж чадах вэ? Та ангийн гишүүн бүрд жижиг карт өгч болно. Тэгээд сүүлийн удаа ариун ёслолоос хүртэж байхдаа бодож байсан зүйлсээ жагсаан бичихийг ангийн гишүүдээс хүс. Тэд дараагийн удаа ариун ёслолоос хүртэхдээ Аврагч дээр анхаарлаа төвлөрүүлэхэд туслах, хүсэж байгаа зарим зүйлээ бас жагсаан бичиж болно.

- Ариун ёслол хүртээж буй Аврагчийн зургийг үзүүл (*Gospel Art Book*, 54-ийг үзнэ үү). Та нар

Матай 26:26–28-ыг уншиж байхдаа өсвөр үеийнхнээс зургийг харж, тэнд байсан бол ямар байх байсан талаар төсөөлөн бодохыг хүс. Ариун ёслол нь Аврагчийг хайрлах хайрыг болон Цагаатгалын талаарх гэрчлэлийг тань хүчирхэгжүүлсэн арга замыг хуваалц. Өсвөр үеийнхнээс гэрчлэлээ хуваалцахыг хүс. Өсвөр үеийнхнийг дараагийн удаа ариун ёслолоос хүртэхдээ өнөөдөр ярилцсан зүйлүүдээ тунгаан бодоход урамшуулан дэмж. Тэд ариун ёслолын үеэр Аврагчийн амьдралд тохиолдсон өөр ямар үйл явдлуудыг бодож болох вэ?

- Өсвөр үеийнхнийг ариун ёслолын дуртай дуулаас хуваалцаж (шаардлагатай бол тэд дууны номын ард байдаг гарчгийг харж болно), энэ нь тэдний хувьд яагаад чухал болохыг тайлбарлахад урь. Эдгээр дуулаас нэг юм уу түүнээс олныг дуулж, сонсож, эсвэл уншиж, дуулал бүрийн төгсгөлд байгаа судруудыг унш. Бид энэ дуулуудаас ариун ёслолын талаар юу мэдэж авч болох вэ? Дуулууд нь хэрхэн биднийг ариун ёслолд бэлтгэхэд тусалдаг вэ?

- Ангийн гишүүн бүрийг энэ тоймд санал болгосон судруудаас нэгийг сонгон уншиж, Их Эзэн биднээс ариун ёслолд бэлтгэхийн тулд юу хийгээсэй гэж хүсэж байгааг олж мэдэхэд урь. Олж мэдсэн зүйлээ хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс. Их Эзэн яагаад ийм арга замуудаар ариун ёслолд бэлдээсэй гэж биднээс хүсдэг вэ? Ариун ёслолыг илүү утга учиртай болгохын тулд хийдэг бусад зүйлээ хуваалцахад тэднийг урь. Дараа долоо хоногийн ариун ёслолоос хүртэхээр бэлтгэхдээ хийх ямар нэгэн зүйл сонгохыг өсвөр үеийнхнээс хүс.

- Өсвөр үеийнхнийг ахлагч Даллин Х.Өүксийн “Ариун ёслолын цуглаан ба ариун ёслол” хэлсэн үгийн II ба III хэсгийг эсвэл ШЭрил А.Эсплиний “Ариун ёслол бол бодгалийг шинэчлэгч” хэлсэн үгэн дэх залуу эмэгтэйчүүдийн удирдагчийн тухай

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Тэд ариун ёслолыг өөрсдийнхөө хувьд хэрхэн илүү утга учиртай болгохоо ойлгосон уу? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг хугацаа зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан зүйлээсээ юу хийх мэдрэмж төрж байгаа талаар өсвөр үеийнхнээс асуу. Тэр мэдрэмжийнхээ дагуу үйлдэхэд тэднийг уриал. Дагаж болох арга замуудын талаар залбирч, бодож үзэхдээ Сүнснийг эрэлхийлээрэй.

түүхийг уншихад урь. “Би хэрхэн ариун ёслолыг өөрийнхөө хувьд илүү гүн гүнзгий утга учиртай болгох вэ?” гэсэн асуултын хариултаудыг олохыг тэднээс хүс. Тэднээс хариултаудаа самбар дээр бичиж, уншсан хэсэг дэх зөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд хийхээр төлөвлөж байгаа зүйлээ хуваалцахыг хүс.

- Боломжтой бол ариун ёслолын ширээ рүү болон бэлтгэх өрөөнд ангиараа оч. Аароны санваартанг (багш эсвэл прист) эсвэл бишопыг хэрхэн ариун ёслолд бэлддэг талаар тайлбарлаж мөн энэхүү ёслолын ариун нандин чанарын талаарх гэрчлэлээ хуваалцахад урь. Ариун ёслолд илүү хүндэтгэл бишрэлтэй хандахын тулд тэд юу хийж болох талаар гэрчлэл, бодол саналаа хуваалцахад ангийн бусад гишүүнийг урь.

Аврагчийн арга барилаар заах нь

Есүс Христ заасан хүмүүстээ сайн мэдээний хичээлүүдийг өөрсдийн туршлагаас болон эргэн тойрон дахь орчноосоо олж авахад тусалдаг байсан. Тэрээр загасчлах, хүүхэд төрөх, мөн талбайд ажиллах талаар өгүүлдэг байсан. Өсвөр үеийнхэнд сайн мэдээний зарчмуудыг ойлгоход нь туслахын тулд та танил болсон түүхүүдийг хэрхэн ашиглаж болох вэ?

Сонгосон материалууд

Даллин Х.Өүкс, “Ариун ёслолын цуглаан ба ариун ёслол,” *Ensign* эсвэл 2008 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 21–24-өөс эш татав

I.

Ариун ёслол нь ариун ёслолын цуглааныг Сүмийн хамгийн ариун нандин, чухал цуглаан болгодог. Энэ бол гэр бүлээрээ хамтдаа оролцдог Хүндэтгэлийн өдрийн цорын ганц цуглаан мөн. Ариун ёслолоос гадна Их Эзэн Есүс Христийн Цагаатгал, сургаалуудад анхаарал төвлөрүүлэх асуудлыг ямагт төлөвлөж хэрэгжүүлдэг байх нь энэхүү цуглааны зорилго юм. . . .

II.

Сүмийн гишүүд ариун ёслолд өөрсдийгөө хэрхэн бэлтгэх хэрэгтэй вэ гэдгээс би эхэлье. . . .

Бид цуглаан эхлэхээс нэлээд өмнө суудлаа эзэлдэг. “Нам гүм энэ үед оршил хөгжмийг намуухан тоглодог. Энэ үе бол яриа хөөрөө өрнүүлэх юм уу, захиас дамжуулах цаг биш. Харин ариун ёслолын цуглаанд сүнслэг байдлын хувьд бэлтгэн залбиралтайгаар бясалган бодох цаг юм” [Расэлл М.Нэлсон, “Worshiping at Sacrament Meeting,” *Лиахона*, 2004 оны 8-р сар, 13; *Ensign*, 2004 оны 8-р сар, 27]

Аврагч амилсныхаа дараа нифайчууд дээр очсон үедээ тэднийг мал амьтны цус урсгаж, тахил өргөхөө зогсоох ёстойг заажээ. Үүний оронд “та нар харууссан зүрх, гэмшсэн сэтгэлийг надад өргөл болгон өргөх болно” (3 Нифай 9:20). Орчин үеийн илчлэлтэд давтагддаг энэхүү зарлиг ариун ёслолоос долоо хоног бүр хүртэхэд биднийг чиглүүлж, ариун ёслолд хэрхэн бэлтгэх ёстойг бидэнд хэлж өгдөг. “Ариун ёслолын цуглаанаас ирж болох сүнслэг мэдрэмжийн төлөө Сүмийн гишүүн бүр үүрэг хүлээдэг” гэж ахлагч Нэлсон

заажээ (*Лиахона*, 2004 оны 8-р сар, 14; *Ensign*, 2004 оны 8-р сар, 28).

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит авралын талаарх сургаалын бүтээлдээ бид дэлхийн гэтэлгэлийн төлөөх Аврагчийн үхэл, шаналлыг дурсан тэмдэглэж, ариун ёслолоос хүртдэг болохыг заажээ. Энэхүү ёслол бий болсноор бид Түүнд үйлчлэх, Түүнийг дуулгавартай дагах, Түүнийг үргэлж санах талаар байгуулсан гэрээнүүдээ шинэчлэх боломжтой болсон юм. . . . (*Doctrines of Salvation*, comp. Bruce R. McConkie, 3 vols. [1954–56], 2:341).

III.

Бидний хувцаслалт бидний зан төлөвийн хэмжүүр болоод зогсохгүй оролцож буй үйл ажиллагаандаа хэрхэн бэлтгэснийг дүгнэх хэмжүүр болдог байна. . . . Ариун ёслолын цуглаанд явах нь ариун сүмд орохтой адил юм. Бидний хувцаслалт өөрсдийнхөө оролцох ёслолын ач холбогдлыг хэрхэн ойлгож, хэрхэн хүндэтгэлтэй хандаж байгаагийн хэмжүүр болдог.

Ариун ёслолын цуглааны үед, ялангуяа ариун ёслолын үйлчлэлийн үед анхаарлаа зөвхөн шүтэн бишрэхэд төвлөрүүлж, бусад аливаа үйл ажиллагаанд, тэр тусмаа бусдын шүтэн бишрэхэд саад болох ёсгүй. Унтаж байгаа хүн бусдад саад болдоггүй шүү дээ. Ариун ёслолын цуглаан бол ном, сэтгүүл унших цаг биш. Залуучууд аа, ариун ёслол бол хоорондоо гар утсаараа ярих юм уу шивнэлдэх, өөр газар байгаа хүмүүст гар утсаараа мессеж явуулах цаг биш. Бид ариун ёслолоос хүртсэнээр Аврагчийг үргэлж санана хэмээн гэрээ хийдэг. Чухам ийм гэрээ хийдэг цуглаан дээр гэрээгээ илт зөрчиж байгаа хүмүүсийг харихад хэчнээн харамсалтай байдаг гээч.

Ариун ёслолын цуглааны хөгжим бол бидний шүтэн бишрэх үйл ажиллагааны амин сүнс юм. Зөв шударга хүмүүсийн дуулсан дуу Их Эзэнд

Сонгосон материалууд

хандсан залбирал болдгийг судруудад заадаг билээ (С ба Г 25:12-ыг үзнэ үү). “Зарим агуу номлол дууллуудыг дуулснаар номлогддогийг” (*Hymns*, ix) Тэргүүн Зөвлөл мэдэгдсэн байдаг. Ариун ёслолын цуглаанд оролцож байгаа хүн бүр шүтэн бишрэх дууллыг, ялангуяа ариун ёслолоос хүртэхэд биднийг бэлтгэдэг дууллыг дуулах нь хэчнээн сайхан байдаг билээ. Ялангуяа ариун ёслолын цуглааны бүх хөгжмийг төлөвлөхдөө энэ

хөгжим нь тоглож үзүүлэх биш, шүтэн бишрэх зорилготойг үргэлж санах ёстой.

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит: “Ариун ёслолын зорилго бол сайн мэдээг заах, итгэл бишрэлээ харуулахад биднийг уриалан дуудах, бидний Гэтэлгэгчийн үүрэг зорилгыг эргэцүүлэн бодож, сайн мэдээний авралын зарчмуудыг хэрэгжүүлэх явдал. . .” гэж сургасан (*Doctrines of Salvation*, 2:342).



ДОЛООДУГААР САР: ЁСЛОЛУУД БА ГЭРЭЭНҮҮД

Би Аврагчийг үргэлж дурсан санах гэрээгээ хэрхэн сахих вэ?

Бид ариун ёслолоос хүртэхдээ Аврагчийг үргэлж дурсан санана хэмээн амладаг. Энэ нь бид сонголт хийхдээ ямагт Түүний жишээ болон сургаалыг дагана гэсэн үг юм. Бид амьдралдаа Аврагчийг нэгдүгээрт тавьж мөн Түүнийг мэдэх болон Түүний хүслийг дагахыг эрэлхийлдэг. Бидэнд сорилт бэрхшээл тулгарахад бид тайвшрал ба эрч хүчийг авахын тулд Түүнд ханддаг. Тэнгэрлэг Эцэг биднийг энэхүү гэрээг сахих аваас үргэлж Ариун Сүнстэй байх болно хэмээн амласан.

Аврагчийг үргэлж санан дурсахын тулд та юу хийдэг вэ? Түүнийг санан дурсах нь таны амьдралыг хэрхэн адисалсан бэ?

Өсвөр үеийнхэн яагаад хийж байгаа бүх зүйлдээ Аврагчийг санан дурсах хэрэгтэй вэ? Энэ нь уруу таталтаас зайлсхийж, сорилт бэрхшээлтэй тулгарах үед тэдэнд хэрхэн тусалдаг вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Хичээлдээ бэлдэж байх үедээ эдгээр судар, материалыг залбирч судлаарай. Та өсвөр үеийнхэнтэй юуг хуваалцах хэрэгтэй гэж мэдэрч байна вэ?

Иохан 8:29 (Есүс Христ Эцэгээ үргэлж санан дурсаж мөн Түүнтэй адил байхыг эрэлхийлэх жишээг үзүүлсэн)

Иохан 14:26; 3 Нифай 11:32 (Ариун Сүнс бидэнд Аврагчийг санан дурсахад тусалж чадна)

Алма 37:36–37 (Бид бүх бодол санаа, үйлдлээ Их Эзэн рүү хандуулах ёстой)

Хиламан 12:1–5 (Хүмүүн нь Их Эзэнийг санахдаа удаан байдаг)

С ба Г 6:36 (Санах бодох бүрдээ Их Эзэн рүү харагтун)

С ба Г 20:77, 79 (Ариун ёслолын залбирлууд)

Гэррит В.Гонг, “Түүнийг үргэлж сана,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 95–98

Клаудио Р.М.Коста, “Тэд үргэлж Түүнийг санаж болохын тулд,” *Ensign* эсвэл *Liahona*, 2015 оны 11-р сар, 101–103

Д.Тодд Кристоффэрсон, “Түүнийг үргэлж санахын тулд,” *Ensign*, 2011 оны 4-р сар, 21–27

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хором өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, Сүмийн бусад хичээл эсвэл найзуудтайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний

нөлөөг олж харахад нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм.

- Сүмийн ангиудад сурсан ямар нэгэн зүйлийг нь сануулсан саяхны үйл явдлынхаа талаар хуваалцахад өсвөр үеийнхнийг урь.
- Ариун ёслол түгээж буй Аврагчийн зургийг байрлуул (*Сайн мэдээний уран зургийн цуглуулга*, 54-ийг

үзнэ үү). Өсвөр үеийнхнийг Сургаал ба Гэрээний 20:77, 79-д байгаа ариун ёслолын залбирлыг уншаад, ариун ёслолоос хүртэхдээ бидний хийдэг амлалтыг самбар дээр жагсаан бичихийг хүс. Өсвөр үеийнхэн Аврагчийг үргэлж санан дурсахын тулд юу хийдэг вэ?

Хамтдаа суралц

Өсвөр үеийнхэнд Аврагчийг үргэлж дурсан санахад дараах бүх үйл ажиллагаа тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу.

- Ангийн гишүүн нэг бүрийг энэхүү тоймд санал болгосон судруудын нэгийг уншаад, тэнд Аврагчийг үргэлж санан дурсах тухай юу зааж байгааг хуваалцахыг хүс. Түүнийг үргэлж дурсан санах нь яагаад чухал вэ? Түүнийг дурсан санах нь бидний өдөр тутмын амьдралд хэрхэн нөлөөлж чадах вэ (бидний гаргах шийдвэрт эсвэл бидэнд тулгарах сорилт бэрхшээлд)? Есүс Христийг дурсан санахыг хичээж байсан учраас адислагдсан туршлагаасаа хуваалцахад өсвөр үеийнхнийг урь.
- Өсвөр үеийнхнээс Хиламан 12:1–5-ыг уншаад, хүмүүс Их Эзэнийг амархан мартдаг шалтгаануудыг хуваалцахыг хүс. Бид Их Эзэнийг мартагч уруу таталтаас хэрхэн зайлсхийж чадах вэ? Аврагчийг өөрсдийн амьдралын нэг хэсэг болгохын тулд хийдэг зүйлсийнхээ талаар хуваалцахыг тэднээс хүс.
- “Би Аврагчийг хэрхэн үргэлж санах вэ?” гэж самбар дээр бич. Ангийн гишүүн бүрд самбар дээрх

асуултын хариуг олохын тулд Д.Тодд Кристоффэрсоны “Түүнийг үргэлж санахын тулд” өгүүллийг эсвэл ахлагч Гэррит В.Гонгийн “Түүнийг үргэлж сана” хэлсэн үгийг уншихыг даалга. Есүс Христийг санах арга замуудыг бидэнд заах санаа, түүхүүдийг эдгээр хэлсэн үгнээс хуваалцахыг тэднээс хүс. Тэд “Түүнийг үргэлж сана” гэсэн гэрээгээ илүү сайн биелүүлэхэд туслах юуг сурсан бэ?

- Өсвөр үеийнхнээс өөрсдийн мэдэх Аврагчийн талаар өгүүлсэн судрын түүхүүдийг хэдэн минут бодоод, дүгнэхийг хүс. (Та санаа өгөхийн тулд *Сайн мэдээний уран зургийн цуглуулгын* 30-61-р зургийг үзэхэд эсвэл ахлагч Клаудио Р.М.Костагийн “Тэд Түүнийг үргэлж санаж болохын тулд” хэлсэн үгийн эхний хэсгийг уншихад тэднийг урьж болно.) Эдгээр түүхийг санаж байх нь тэдний өдөр тутмын амьдралд хэрхэн туслах тухай бодоход тэднийг уриад, өөрийн бодол санааг хуваалцахыг хүс. Ахлагч

Сайн мэдээг судлах ур чадварууд

Христийн тухай сургаалыг хайх нь. Өсвөр үеийнхнийг судраас суралцах бүрдээ Есүс Христийн тухай сургаалыг хайхад урамшуулан дэмж. Тэд судрын ямар ч хэсгээс уншиж байхдаа “Энэ хэсгээс би Есүс Христ, Түүний зан төлөв, байдал, амьдрал эсвэл Цагаатгалын тухай юу сурч байна вэ?” хэмээн өөрсдөөсөө асууж болно.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагчийн тухай юу мэддэг болохоо хэсэгхэн зуур тунгаан бод. Тэрээр Өөрийн Эцэгийг үргэлж санан дурсдаг гэдгээ хэрхэн харуулдаг байсан бэ? Өсвөр үеийнхэн Аврагчийг үргэлж санан дурсахаас ирэх хүч чадлыг авч сурахад нь туслахын тулд та Түүний жишээг хэрхэн дагаж болох вэ?

Костагийн хэлсэн үгийг хувиран, өсвөр үеийнхэнд тарааж өгөөд, Аврагчийг санаж болох арга замын талаар гаргасан түүний жагсаалтыг уншихад тэднийг урь (үгийн төгсгөлд буй сумтай жагсаалтыг үзнэ үү). Гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн зүйл байвал хуваалцахыг мөн яагаад

уг зүйл тэдний хувьд утга учиртай байсныг тайлбарлахыг тэднээс хүс. Дараагийн удаа ариун ёслолоос хүртэхдээ Аврагчийн тухай бодоход өсвөр үеийнхэнд туслах зорилгоор уг хэлсэн үгийн хуулбарыг авч хадгалахыг тэдэнд санал болго.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд Аврагчийг үргэлж санан дурсах гэрээгээ хэрхэн сахих ёстойгоо ойлгож мэдсэн үү? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү хугацаа зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан зүйлээсээ өсвөр үеийнхэнд юу хийх мэдрэмж төрж байгаа талаар тэднээс асуу. Тэр мэдрэмжийнхээ дагуу үйлдэхэд тэднийг уриал. Дагаж болох арга замуудын талаар залбирч, бодож үзэхдээ Сүнсийг эрэлхийлээрэй.

Сонгосон материалууд

Д.Тодд Кристоффэрсон, "To Always Remember Him,"
Ensign, 2011 оны 4-р сар, 50, 55-аас эш татав

1828 оны 6-р сард Иосеф [Смит] Мормоны Номын эхний 116 хуудас гар бичмэлийг гэр бүлийн гишүүддээ үзүүлэхээр Пеннсилваний Хармонигаас Нью-Йоркийн Пальмира руу авч явахыг Мартин Харрист зөвшөөрчээ. Мартин амласан хугацаандаа эргэж ирсэнгүйд санаа зовсон Иосеф морин тэрэг хөлсөлж, Нью-Йоркийн Манчестер хотод байсан эцэг эхийнхээ гэр рүү яаран гарсан байна. Бошиглогч ирсэн даруйдаа Мартиныг ирүүлэхээр хүн явуулав. Мартин ирсэн ч, гар бичмэл нь алга болсон эсвэл хаана байгааг нь мэдэхгүй байна гэв.

“Ай халаг! Бурхан минь, Бурхан минь. . . . Бүх зүйл ингээд өнгөрдөг байж. Одоо би яана аа? Би нүгэл үйлдлээ. Би Түүнээс буруу юм гуйснаараа Бурханыг хилэгнүүлээ. . . . Бүхний Дээдийн тэнгэр элч намайг яаж баалах бол оо” гэж дуу алдсаныг ээж Люси Мак Смит нь тэмдэглэсэн байдаг.

Маргааш нь бошиглогч Хармонид эргэж ирэв. Тэнд ирээд тэрээр “Би түүний мутраас нигүүлслийг олохын тулд, түүний хүсэл тааллын эсрэг үйлдсэн бүхнийхээ төлөө уучлагдахын тулд Их Эзэний өмнө хүчтэй залбирлаар өөрийгөө даруусгав” гэж хэлжээ [*Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 83].

Бурханаас биш, хүнээс айсных нь төлөө Их Эзэн Иосефыг зэмлэсний дараа түүнд ийн хэлжээ.

“Чи бол Иосеф, мөн чи Их Эзэний ажлыг хийхээр сонгогдсон байсан болой, харин гэм буруугийн улмаас, хэрэв чи сонор сэрэмжгүй байх аваас, чи унах болно.

Гэвч санагтун, Бурхан нигүүлсэнгүй юм; тиймийн тул, миний чамд өгсөн зарлигийн эсрэг хийсэн зүйлээ наманчлагтун, мөн чи сонгогдсон хэвээр байгаа, мөн тэр ажилд дахин дуудагдсан бөлгөө” (С ба Г 3:9–10).

“Их Эзэн Урим ба Туммимыг ялтсуудын хамт түр хугацаагаар Иосефоос эргүүлэн авсан юм. Гэвч эдгээр зүйлийг түүнд удалгүй буцааж өгсөн билээ. ‘Тэнгэр элч надад Урим ба Туммимыг эргүүлж өгөхдөө’ ‘Бурхан миний итгэл бишрэл, даруу байдалд баярлан, залбирлаараа харамсан гэмшиж, хичээнгүй байсны төлөө намайг хайрласныг хэлж, баяртай байлаа. Би үүргээ сайн биелүүлэхийн төлөө . . . орчуулгын ажлаа дахин эхлэхийн төлөө залбирсан юм. Ингэснээрээ би үүргээ сайн биелүүлж . . . орчуулгын ажлаа дахин эхлэх боломжтой болсон юм’ хэмээн бошиглогч дурссан байдаг. Иосеф Их Эзэн өөрийг нь уучилсны төлөөх баярт мэдрэмжээр хүч чадал нь сэлбэгдэн, Түүний хүсэл тааллыг гүйцэлдүүлэх шийдвэр төгс байдлаар оногдсон ажилдаа ханцуй шамлан оржээ” [*Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит*84.]

Бурханд итгэл найдвар тавьж, хүмүүний хийж чадах зүйлээс айхгүй байх бошиглогчийн шийдвэр төгс байдал энэ туршлагын дараа улам бат бөх болсон ажээ. Тэр явдлаас хойш түүний амьдрал Христийн хүч болон нигүүлсэлд итгэж найдсанаар Түүнийг санана гэдэг нь чухам юу болохын гайхамшигт үлгэр жишээ болсон билээ. . . .

Товчоор хэлбэл, “түүнийг үргэлж санана” гэдэг нь бид айж амьдрах ёсгүй гэсэн үг юм. Сорилт бэрхшээл, урам хугаралт, уй гашуу бид бүгдэд янз бүрийн замаар ирэх болно, гэвч бидний бурханлиг Өмгөөлөгчийн улмаас бүх зүйл бидний сайн сайхны төлөө эцэст хамтдаа ажиллах болно гэдгийг бид мэднэ (С ба Г 90:24; 98:3-ыг үзнэ үү). . . .

Та бид бүгдээрээ Христийг амьдралынхаа төвд тавьснаар, Тэрээр Эцэгтэй нэг байдгийн адилаар бид Түүнтэй нэг болж чадна. Бид хийдэг бүх зүйлээ эргэн харж, цэгнэн, Аврагчийг амьдралынхаа гол төвд тавьж, хамгийн чухал зүйлсийг эн тэргүүнд анхаардаг болж, амьдралаа шинээр төлөвшүүлэхээс эхэлж болно.



ДОЛООДУГААР САР: ЁСЛОЛУУД БА ГЭРЭЭНҮҮД

Би хэрхэн ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахад өөрийгөө бэлдэх вэ?

Бид ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахаасаа өмнө ариун сүмд орохуйц зохистой амьдарч, хийсэн гэрээнүүдээ дагаж, ариун сүмийг амьдралынхаа нэгэн хэсэг болгон өөрсдийгөө бэлдэж болдог. Бид мөн судрууд болон бошиглогчдын үгсээс ариун сүмийн ёслолуудын талаар судалж чадна.

Хэрэв та ариун сүмийн ёслолуудаа хүлээн авсан бол үүний тулд өөрийгөө хэрхэн бэлтгэсэн бэ?

Өсвөр үеийнхэн ариун сүмийн талаар юу гэж боддог талаар ойлгоход тань тусалсан ямар зүйлийг та тэднээс сонсож эсвэл анзаарч харж байсан бэ? Ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахад бэлтгэхийн тулд тэд юу хийж байгаа вэ?

Анхааруулга: Тойрогтоо *Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн ариун сүмүүд* (09339) номтой болох талаар бишоптоо санал тавь. Энэ нь өсвөр үеийнхэнд ариун сүмд ороход бэлтгэхэд нь тусална.

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар, материалыг залбирч судал. Өсвөр үеийнхэнд ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахаар бэлтгэхэд нь юу тусална гэж та бодож байна вэ?

Дуулал 24:3–4; С ба Г 97:15–17 (Их Эзэний өргөөнд орохын тулд бид цэвэр байх ёстой)

Квинтин Л.Күк, “Өөрийгөө ариун сүмд байгаагаар хар,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 83–87

Квинтин Л.Күк, “Нямбай мөн Бристоль маягаар: Сайн, муу ямар ч үед ариун сүмд орох зохистой бай,” *Ensign* эсвэл *Liahona*, 2015 оны 11-р сар, 39–42

Рассэлл М.Нэлсон, “Ариун сүмийн адислалуудад бэлтгэ,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2010 оны 10-р сар, 40–51

Линда К.Бертон, “Хэзээ ч мэдэгдээгүй тийм маягаар бэлтгэсэн байв,” *Ensign* эсвэл *Liahona*, 2014 оны 11-р сар, 111–114

“Ариун сүмийг өөрсдийнхөө амьдралын нэг хэсэг болгох нь,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2010 оны 10-р сар, 76–78

“Тогтмол асуудаг асуултууд,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2010 оны 10-р сар, 79–80

“Тэргүүн Зөвлөлөөс өсвөр үеийнхэнд өгсөн захиас,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), ii–iii

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутын туршид, өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, Сүмийн бусад хичээл эсвэл найзуудтайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Эдгээр санаа тус болж болох юм.

- Бусад ангид эсвэл хувиараа суралцах үедээ ёслол, гэрээнүүдийн талаар сүүлийн үед олж авсан мэдлэгээсээ хуваалцахад өсвөр үеийнхнийг урь.

- Өсвөр үеийнхнийг “Залуучуудын бат бөх байдлын төлөө” номын

Тэргүүн Зөвлөлөөс залуучуудад өгсөн захиасыг уншихад урь. Тэднийг энэхүү захиасыг уншиж дууссаны дараа, яагаад энэ товхимлын нүүр хуудсанд ариун сүмийн зураг тавихаар сонгосныг асуу.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь ариун сүмийн ёслолуудад оролцоход өсвөр үеийнхнийг бэлтгэхэд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангиддаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго.

- Одооноос зохистой амьдрах нь өсвөр үеийнхний ариун сүмд ороход өөрийгөө бэлтгэх хамгийн чухал арга замын нэг юм. Квинтин Л.Күкийн “Нямбай мөн Бристоль маягаар: Сайн, муу ямар ч үед ариун сүмд орох зохистой бай” хэлсэн үгийн эхний гурван минутын бичлэгийг үзүүл. Ахлагч Квинтин Л.Күкийн харьцуулалт нь ариун сүмд орохуйц зохистой байхтай хэрхэн холбогдож байгаа талаар хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс. Өсвөр үеийнхнийг гурван бүлэгт хуваагаад, бүлэг бүрийг ахлагч Квинтин Л.Күкийн зохистой амьдрах талаар өгсөн гурван зарчмын нэгийг уншихад урь. Дараа нь сурсан зүйлээ ангийнхаа бусад гишүүнтэй хуваалцахыг бүлэг бүрээс хүс. Өсвөр үеийнхэнд ахлагч Күкийн санал болгосон зарчмуудын дагуу амьдрах зорилго тавих хугацаа гаргаж өг.

- “Always in Our Sights” видео бичлэгийг үзүүлж, ангийн гишүүн нэг бүрийг уг видео бичлэгтэй холбоотой судрын хэсгийг бодоход урь (гурамсан судрын сэдвийн жагсаалт эсвэл индексээс судрын

хэсгийг хэрхэн олохыг тэдэнд үзүүл). Өсвөр үеийнхнийг судрын хэсгээсээ хуваалцан, энэ нь тэднийг ариун сүм рүү явахад бэлтгэх талаар юу зааж байгааг тайлбарлахыг хүс. Өсвөр үеийнхэнд Квинтин Л.Күкийн “Өөрийгөө ариун сүмд байгаагаар хар” хэлсэн үгэнд санал болгосон шиг “өөрсдийгөө ариун сүмд байгаагаар харах” арга замуудын тухай бодоход тусал. Тэд олсон судруудаараа чимэглэсэн картууд хийж болох бөгөөд картуудаа толь юмуу ариун сүмийн адислал хүлээн авах зорилгыг нь сануулах, гэрийнхээ нүдэнд тусахуйц газар байрлуул. Өсвөр үеийнхэн ахлагч Күкийн хэлсэн үгнээс ямар амлалт, урилгыг олж чадах вэ?

- Ангиараа Дуулал 24:3–4-ийг уншиж, цэвэр гартай, ариун зүрхтэй байх гэдэг нь юу гэсэн үг болохыг өсвөр үеийнхнээс асуу. Сүнслэг байдлын хувьд ариун байх нь яагаад ариун сүмд орох шалгуур болдог вэ? (С ба Г 97:15-17-г үзнэ үү). Бишопын зөвлөлөөс нэг гишүүнийг ариун сүмийн эрхийн бичигтэй байхын тулд хувь хүний хийх ёстой зүйлсийн талаар үг хэлэхэд урь. Тэрээр

Сайн мэдээг судлах чадварууд

Судруудын удирдамжийг ашиглах нь. Энэ хэсгийн хамгийн эхний үйл ажиллагаа нь өсвөр үеийнхнийг Судруудын удирдамжийг ашиглан судрууд олоход урамшуулан дэмжих явдал юм (Teaching, No Greater Call, 57-р хуудсыг үзнэ үү). Тэд сайн мэдээнээс хувиараа суралцах үедээ Судруудын удирдамжийг болон бусад суралцах материалыг байнга ашигладаг байхын тулд тэдгээрийг хайж олж сурахад нь өсвөр үеийнхэнд туслаарай.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нарынхаа чадавхыг олж хардаг байв. Тэрээр тэдэнд итгэдэг байсан бөгөөд тэднийг бусдад үйлчилж, адислахад бэлтгэж байсан юм. Та ангийнхаа өсвөр үеийнхэнд ирээдүйн адислал, боломжуудад бэлтгэхэд нь туслахын тулд юу хийж чадах вэ?

өсвөр үеийнхэнд ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахад бэлтгэхийн тулд юу хий гэж зөвлөж болох вэ?. Өсвөр үеийнхнийг асуултууд тавихад урамшуулан дэмж.

- Өсвөр үеийнхэн бүрд ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоний “Ариун сүмийн адислалуудад бэлтгэ” хэлсэн үгийн нэг хэсгийг уншуулахаар оноож өг. Өөрт оногдсон хэсгээс ариун сүмд ороход бэлтгэх талаар сурсан зүйлээ хуваалцахад өсвөр үеийнхнийг урь. Ерөнхийлөгч Нэлсоний захиасаас өөр юу нь тэдэнд гүн сэтгэгдэл төрүүлсэн бэ?

- “Тогтмол асуудаг асуултууд” өгүүллээс ангийн тань өсвөр үеийнхэнд хамгийн их хамаатай гэж үзсэн асуултуудыг сонгож, уг асуултуудыг самбар дээр бич. Өгүүлэл дээрх

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Ариун сүмийн ёслолуудад хэрхэн бэлтгэхээ тэд ойлгосон уу? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлагатай юу?

хариултуудыг бичсэн нарийхан цааснуудыг бэлд. Өсвөр үеийнхнээр самбар дээрх асуултуудаас сонгуулж, бэлдсэн цааснуудаасаа хариултыг олуул. Олж мэдсэн зүйлээ хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс.

- Линда К.Бертон эгч “Хэзээ ч мэдэгдээгүй тийм маягаар бэлтгэсэн байв” хэлсэн үгэндээ биднийг ариун сүмд ороход “дусал дуслаар” бэлтгэхэд урамшуулан дэмжсэн. Ариун сүмийн ёслолуудад нэг дор биш, харин “дусал дуслаар” бэлтгэх нь яагаад илүү үр дүнтэй байдаг вэ? Ариун сүмд бэлтгэхэд тэдэнд туслах тогтмол хийх үйлдлүүдийг жагсаан бичихэд өсвөр үеийнхнийг урь. Тэд Бертон эгчийн хэлсэн үгээс санаа авч болно.

Үйлдэхэд урь

- Өнөөдөр сонсож, мэдэрсэн зүйлийнхээ талаар тунгаан бодоод, ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахад бэлтгэхийн тулд ямар нэг зүйл хийхээр сонгоход тэднийг урь.

- Ариун сүмийн ёслолууд чухал болох талаар гэрчлэлээ хуваалц.

Сонгосон материалууд

Рассэлл М.Нэлсон, “Ариун сүмийн адислалуудад бэлтгэ” хэлсэн үгнээс эш татав, Ensign эсвэл Лиана, 2010 оны 10-р сар, 41–51

Ариун сүм ариун учраас, үүнийг бузарлахгүй байхыг Их Эзэн хүсдэг. Энэхүү онцгой боломжийн төлөө маш сайн бэлтгэгдэх хүсэлтэй хэн ч гэсэн ариун сүмд орж болно. Бэлтгэлийн тухай ойлголт бусад хүч чармайлтаас илүү чухал зүйл юм. Би бага байхдаа их сургуульд ормоор байна гэж аав, ээж хоёртоо хэлдэг байснаа санадаг. Аав, ээж хоёр маань намайг их сургуульд орж болно гэхдээ шаргуу бэлдэж, их сургуулийн элсэлтийн бүх шаардлагыг хангасан үед л орж болно гэж билээ. Үүнтэй адил бид ариун сүмд орох шаардлагыг хангасан байх ёстой. Бид бие махбод, оюун санаа, сүнслэг байдлын хувьд бэлтгэдэг. Ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авахыг хүсч байгаа хүн бүрийн зохистой байдлыг хувь хүн тус бүрд нь тогтооно.

Санваарын эрх мэдлийн түлхүүрүүдийг эзэмшиж, үүрэг хариуцлага хүлээдэг хүмүүс ариун сүмийн бичиг олгох ярилцлагыг бидэнтэй хийн, бэлтгэлээ хангахад маань тусалдаг. Эдгээр удирдагчид бидний төлөө анхаарал тавьж, биднийг ариун сүмд ороход бэлэн байгаа эсэхийг тодорхойлдог. Тэд Их Эзэнийг хайрладаг бөгөөд “цэвэр ариун биш зүйл Түүний өргөөнд орохыг зөвшөөрөхгүй” байхад анхаардаг. [Сургаал ба Гэрээ 109:20.] Тийм учраас эдгээр ярилцлага хариуцлагын уур амьсгалд явагддаг.

Та ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авахад хэрхэн бэлтгэдэг вэ? Та бишопын зөвлөл, эцэг эх, гэр бүл, гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, багш эсвэл чуулгын зөвлөлтэйгээ зөвлөлдөж болно. Шаардлагууд нь энгийн юм. Товчхон хэлбэл хувь хүн Их Эзэний зарлигуудыг сахих шаардлагатай.

Учир нь ариун сүм бол Түүний өргөө шүү дээ. Их Эзэн жишгүүдийг тогтоосон юм. Бид ариун сүмд Түүний зочид болж ордог. . . .

Ариун сүмийн ёслол болон гэрээнүүд ариун нандин учраас ариун сүм дотор болдог зүйлсийн талаар ариун сүмээс гадуур ярихгүй байх чанд үүргийг бид хүлээдэг. Ариун юмст ариунаар хандах ёстой.

Суралцах энэхүү өргөөнд Их Эзэний арга замаар бидэнд заадаг. Түүний арга зам бол бидний арга зам биш. [Исаиа 55:8–9-ийг үзнэ үү.] Тэдний зааж байгаа арга барил бидний сайн мэдэх боловсролын байгууллагад ажилладаг тэдгээр хүмүүсийнхээ өөр байвал үүнд гайхах хэрэггүй. Ариун сүмийн ёслол болон гэрээнүүд нь Адам, Ева хоёрын үеэс сайн мэдээний салшгүй хэсэг байсаар ирсэн юм. Эрт дээр үеэс бэлгэдлүүдийг онцгой чухал үнэнүүдийг заахад ашигласаар ирсэн бөгөөд заах энэхүү арга нь өнөөдөр ч ариун сүмд хэрэглэгдсээр байна.

Тиймээс бид ариун сүмд заагддаг бэлгэдлүүд тус бүрийн төлөөлдөг бодит үнэнүүдийг тунгаан бодох шаардлагатай. [Жона. Витсөү, “Temple Worship”-г үзнэ үү, *Utah Genealogical and Historical Magazine*, 1921 оны 4-р сар, 62.] “Ариун сүмийн ёслолууд амьдралынхаа туршид үр өгөөжтэйгөөр тунгаан бодож, сурч мэдэх боломж олгодог бэлгэдлийн утга санаагаар дүүрэн юм.” [Ричард Г. Скотт, in *Conference Report*, 1999 оны 4-р сар, 33, эсвэл *Ensign*, 1999 оны 5-р сар, 27.] Ариун сүмд заагддаг сургаалууд нь гаргууд сайхан атлаа туйлын энгийн юм. Ариун сүмд заагддаг тэдгээр сургаалыг боловсрол багатай хүмүүс ойлгодог бөгөөд дээд боловсролтой хүмүүсийг ч гайхахад хүргэж болно.

Сонгосон материалууд

Ариун сүмд анх удаа явж байгаа гишүүдэд Судруудын Удирдамжаас ариун сүмтэй холбоотой “гослох, тос түрхэх,” “гэрээ,” “золиослол,” “Ариун сүм” зэрэг тайлбар хэсгүүдийг уншихыг би зөвлөж байна. Бас Египетээс гарсан нь, 26–29-р

бүлэг, Левит 8-р бүлгийг уншиж болно. Хуучин Гэрээ, Агуу Үнэт Сувд дахь Мосе болон Абрахамын номуудад ариун сүмийн ажил болон ёслолууд эрт дээр үеэс эхлэлтэй, урт удаан хугацаанд оршиж байгааг тэмдэглэсэн байдаг.

Наймдугаар сар: Гэрлэлт ба гэр бүл

Энэ бүлгийн тоймууд нь өсвөр үеийнхнийг гэр бүлийн нөхцөл байдалд суралцах ба заахын ач холбогдлыг ойлгоход нь тусална. Тэд Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд гэрлэлт ба гэр бүл чухал болох талаар тэдний сурсан мөнхийн үнэнүүдийг гэр бүлийнхэнтэйгээ болон бусадтай хуваалцахад бэлтгэх болно. Тэд түүнчлэн гэр бүлийнхээ түүх болон өөрийн гэр бүлийнхээ талаар илүү ихийг суралцах боломжтой байх болно.

Энэ сард сонгох тоймууд:

Өдрийн тэмдэглэл хөтлөх нь намайг болон гэр бүлийг минь хэрхэн адислах вэ?

Гэр бүлийнхээ түүхийг судлах нь яагаад чухал вэ?

Би гэр бүлийнхээ түүхийн ажлыг хэрхэн хийхийг бусдад хэрхэн заах вэ?

Гэрлэлт ба гэр бүлийн ач холбогдлын талаар би бусдад хэрхэн тайлбарлаж болох вэ?

Гэр орондоо суралцах болон заах ямар боломжууд байдаг вэ?



Өдрийн тэмдэглэл хөтлөх нь намайг болон гэр бүлийг маань хэрхэн адислах вэ?

Их Эзэн ба Түүний бошиглогчид тэмдэглэл хөтлөхийн ач холбогдлыг онцолсон байдаг. Өдрийн тэмдэглэл дээрээ бичиж тэмдэглэх нь Их Эзэний бидэнд өгсөн олон адислалуудыг амьдрал дээрээ тусгаж, таньж мэдэх боломжийг бидэнд олгодог. Бидний тэмдэглэлүүд нь гэр бүлийн маань ирээдүй үеийнхэнд сүнслэг өдөөлтийн эх сурвалж, хүч тэнхээ ч болж мэднэ.

Ямар тохиолдлууд танд өдрийн тэмдэглэл хөтлөх нь чухал болох талаар заасан бэ? Таны эсвэл аль нэгэн өвөг дээдсийн тань өдрийн тэмдэглэл дээр өсвөр үеийнхэнд сүнслэгээр нөлөөлөх ямар нэгэн тэмдэглэл байна уу?

Өдрийн тэмдэглэл хөтөлснөөр өсвөр үеийнхэн хэрхэн адислагдах вэ? Тэдэнд өдрийн тэмдэглэл хөтлөхгүй байх ямар шалтгаанууд байж болох вэ? Өсвөр үеийнхэнд тэмдэглэл хөтлөх сүнслэг шалтгаануудыг мэдэхэд нь та хэрхэн тусалж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судрууд болон материалуудыг залбирч судал. Таны зааж буй өсвөр үеийнхэнд юу сүнслэгээр нөлөөлөх вэ?

1 Нифай 1:1–3; Алма 37:8–9; Мосе 6:5, 45–46 (Тэмдэглэл хөтөлсөн талаарх судрууд дахь жишээнүүд)

1 Нифай 6:3–6 (Хувийн тэмдэглэлдээ юуг хамруулах)

3 Нифай 23:6–13 (Аврагч Нифайчуудыг цэдгээ гүйцэд хөтлөөгүйнх нь төлөө цээрлүүлдэг)

Хэнри Б.Аиринг “Өө, санацгаа, санацгаа” *Ensign* эсвэл *Лиакхона* 2007 он 11-р сар, 66–69

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутын туршид, өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь та нар тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Эдгээр санаанууд тусалж болох юм:

- Сайн мэдээний үнэнийг гэрчилсэн ямар туршлагауд саяхан тохиолдсоныг хуваалцахад өсвөр үеийнхнийг урь.
- Боломжтой бол хувийн тэмдэглэлээсээ эсвэл өвөг дээдсийнхээ

тэмдэглэлээс хуваалц (ангийн гишүүнийг эсвэл тойргийн гишүүнийг үүнийг хийхэд урь). Энэ туршлагыг тэмдэглэж авах нь яагаад чухал байсан бэ? Хэн нэгэн тэмдэглэл хөтөлснөөр бусад хүмүүс хэрхэн адислагддаг вэ?

Хамтдаа суралц

Сайн мэдээг судлах ур чадварууд

Тунгаан бодох нь. Энэхүү хичээлд өсвөр үеийнхэн өөрсдөдөө тохиолдож буй туршлагауудынхаа талаар тунгаан бодох болон түүнийгээ өдрийн тэмдэглэлдээ бичиж авахаар урамшуулагддаг. Тунгаан бодох гэдэг нь ямар нэг зүйлийг гүн гүнзгийгээр эргэцүүлэн бодох гэсэн утгатай. Өсвөр үеийнхнээс “Их Эзэн надад тохиолдож буй туршлагаудаас юу сураасай хэмээн надаас хүсч байна вэ?” гэх мэт асуултыг өөрсдөөсөө асуухад нь урь. Тунгаан бодох нь илчлэлтийг урьдаг. Өсвөр үеийнхнийг тунгаан бодохыг хувиараа сайн мэдээнээс суралцахдаа байнга хийдэг хэсэг болгоход урамшуулан дэмж.

Видео бичлэг: “Судраас үгсийг хайх нь”

Дараах үйл ажиллагаа бүр нь өсвөр үеийнхэнд өдрийн тэмдэглэл хөтлөхийн чухлыг ойлгоход туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Өсвөр үеийнхнийг ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн “Өө, санацгаа, санацгаа” (эсвэл энэхүү хэлсэн үг дээр үндэслэсэн видео бичлэгийг үзүүлнэ үү) хэлсэн үгийн эхний 8 догол мөрийг уншихад урин ерөнхийлөгч Айрингийн өдөр тутмын туршлагынхаа талаар бичсэнээс ирсэн адислалуудыг хайж олохыг хүс. Ерөнхийлөгч Айрингийн захиас бичгээс хувийн тэмдэглэл хөтлөх талаар тэд өөр юу сурсан бэ? Түүний хэлсэн үгийн сүүлчийн догол мөрийг хамтдаа уншаад Их Эзэний мутрыг амьдралдаа харсан эсвэл Түүний танд захиас илгээсэн юм шиг санагдсан саяхны туршлагаасаа хуваалц. Өсвөр үеийнхнийг ерөнхийлөгч Айрингийн санал болгосон асуултуудын хариултынхаа талаар тунгаан бодож, бодлоо бичиж тэмдэглэхэд урь.
- Өсвөр үеийнхнээс дараах судруудаас нэгийг уншихыг хүс: 1 Нифай 1:1–3; Алма 37:8–9; Мосе 6:5, 45–46. Судрууд дахь хүмүүс тэмдэглэл хөтөлсөн учраас ирсэн адислалуудын талаар бодон заримаас нь хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс. Хүмүүс яагаад өдрийн тэмдэглэл хөтөлдөггүй вэ? Өсвөр үеийнхэн өдрийн тэмдэглэл хөтлөхийн ач холбогдлын талаар мэдэж болох эдгээр судруудын хэсгүүдээс юу сурдаг вэ? Өсвөр үеийнхнийг өвөг дээдсийнхээ өдрийн тэмдэглэлийг (боломжтой бол) унших эсвэл эцэг эх, өвөө эмээгээсээ ярилцлага аваад

тэдний гэрчлэл, хөрвөлтийн түүх, утга учиртай амьдралын туршлага ба дуртай дурсамжаас нь бичиж авахад нь урамшуулан дэмж.

- Өсвөр үеийнхнээс хувийн тэмдэглэл дээрээ бичихийг хүссэн зүйлсийн жагсаалтыг гаргахыг хүс. Ангиараа 1 Нифай 6:3–6-г унш. Өсвөр үеийнхнээс Нифайн цэдэгтээ багтаахыг хүссэн зүйлийг хайж олоод жагсаалтандаа нэмж бич. Өсвөр үеийнхнийг өдрийн тэмдэглэл дээрээ бичих хэрэгтэй гэж мэдэрсэн зүйлээ тунгаан бодохыг урь. Өдрийн тэмдэглэл дээрээ хэдэн догол мөр бичих хугацаа тэдэнд өг.
- Өсвөр үеийнхнээс 3 Нифай 23:6–13-ыг уншихад урь. Энэ судар өдрийн тэмдэглэл хөтлөх бидний хүчин зүтгэлтэй хэр хамааралтай байх вэ? Өсвөр үеийнхнийг өдрийн тэмдэглэлдээ бичих хэрэгтэй гэж мэдэрсэн ямар нэгэн сүнслэг эсвэл утга учиртай туршлагын талаар бодохыг хүс. Бусад хүмүүст энэ туршлагынхаа талаар уншсанаар тэд хэрхэн адислагдаж болох вэ? Тэдэнд ангидаа эдгээр туршлагаудаа бичиж авах хугацаа өг.
- Өдрийн тэмдэглэл бичих эсвэл хувийн түүх хөтлөх талаар Ерөнхий эрх мэдэлтний хэлсэн үгс болон нийтлэлүүдээс нэгийг сонго. Өсвөр үеийнхнийг үүнээс хэсэгчлэн уншиж, дараа нь хэлсэн үгнээс сүнслэг урамшуулал эсвэл тус болохуйц гэж үзсэн нэг эсвэл хоёр

бодол санаагаа цаасан дээр бичихэд урь. Хүн бүрийг бичиж дуусахад тэднээс дэргэдээ суугаа хүнд цаасаа дамжуулахыг хүс. Тэднээс бие бие-нийхээ дамжуулж өгсөн цаасан дээр олж мэдсэн бодол санаагаа нэмж бичин дараагийн хүндээ дамжуулан

ангийн хүн бүртэй үзэл бодлоо хуваалцах хүртэл үргэлжлүүлэд тэднийг урь. Өсвөр үеийнхнээс уг цаасаа гэр рүүгээ авч яван тэмдэглэлээ хөтлөхдөө тэдгээрийг удирдамж болгон ашиглахад нь урамшуулан дэмж.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд өдрийн тэмдэглэл хөтөлснөөр ирэх адислалуудыг ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан зүйлээсээ өсвөр үеийнхэнд юу хийх мэдрэмж төрж байгаа талаар тэднээс асуу. Тэрхүү мэдрэмжүүдийнхээ дагуу үйлдэхэд тэднийг уриал. Суралцагчид үүний дагуу үйлдэж байгаа эсэхэд хяналт тавих аргуудыг бодож ол.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн заасан хүмүүсээс юм бодуулж, ямар нэгэн юм мэдрүүлсэн асуултуудыг асуудаг байв. Тэрээр тэднийг хайрладаг байсан учраас тэд Түүнтэй бодол санаа, хувийн асуудлаа илэн далангүй хуваалцдаг байсан. Өсвөр үеийнхэн санаа зоволтгүйгээр асуултуудад хариулах таатай уур амьсгалыг та хэрхэн бий болгож болох вэ?

Сонгосон материалууд

Хэнри Б.Айринг, “Өө санагтун, санагтун” –хэлсэн үгнээс эш татав, Ensign эсвэл Лиахона, 2007 оны 11-р сар, 66–69

Хүүхдүүдээ бага байхад нь тэдэнд юу тохиолдсон талаар хэдэн зүйлийг би бичиж эхэлсэн юм. Хэрхэн эхэлснээ та нартай хуваалцъя. Би гэртээ сүмээс нэлээд оройтож ирсэн юм. Тэр үед нар жаргасан байлаа. Намайг гэрийнхээ хаалга руу алхаж явах үед ойролцоо амьдардаг хадам аав маань намайг гайхшируулсан юм. Тэр хоолойнуудыг мөрлөж үүрсэн байсан ба ажлын хувцастайгаа маш хурдан алхаж байлаа. Тэр манай гэрийн ойролцоох голоос манай байшин руу ус татах системийг барьж байгааг би мэдэж байсан юм.

Тэр инээмсэглэн аяархан яриад, ажилдаа гарахаар харанхуйд намайг орхин яаран явсан юм. Би түүний бидний төлөө юу хийж байгаа зүйлийг нь бодон хэд алхаад хаалган дээр ирэнгүүт оюун бодолд маань минийх бус нэгэн дуу хоолой “Би энэ туршлагыг зөвхөн чиний төлөө өгөөгүй. Одоо бичээд ав” гэж хэлэхийг сонссон юм.

Би гэртээ очоод унтаж чадсангүй. Хэдийгээр би маш их ядарч байсан ч цаас аваад нөгөөх үгсийг бичлээ. Бичих зуураа оюун бодолдоо сонссон тэдгээр үгийн утгыг ойлгосон юм. Би гэр бүлийг маань адисалж буй Бурханы мутрыг хэрхэн олж харсан тухайгаа хүүхдүүддээ ирээдүйн нэг өдөр уншуулахаар бичиж үлдээх ёстой байжээ. Өвөө нь бидний төлөө хийж байсан зүйлсээ хийх шаардлагагүй байсан юм. Тэрээр өөр хүнээр хийлгэх ч юм уу эсвэл бүр хийхгүй ч байж болох байсан. Гэвч Есүс Христийн гэрээт дагалдагчдын адил арга замаар тэрээр бидэнд, өөрийнхөө гэр бүлд үйлчилж байсан юм. Энэ нь үнэн гэдгийг би мэдэж байсан. Тиймээс хэрэгтэй үед нь хүүхдүүддээ сануулахын тулд би бичин үлдээсэн билээ.

Олон жилийн турш би өдөр бүр хэдэн мөр нэмж бичдэг байлаа. Би хэчнээн их ядарсан байлаа ч, маргааш нь эрт босч ажилдаа явах байсан ч нэг ч өдрийг алгасаагүй. Би бичиж эхлэхээсээ өмнө дараах асуултыг тунгаан боддог байсан: “Би өнөөдөр биднийг, хүүхдүүдийг маань, гэр бүлийг маань адисалж буй Бурханы мутрыг харсан уу?” Үргэлжлүүлэн бичсээр байсан ба нэг зүйл тохиолдож эхлэв. Өнгөрсөн өдрийг эргэж харах бүрд Бурханы бидний хэн нэгнийх нь төлөө хийсэн зүйлийг завгүй үедээ анзаараагүй байсныгаа бид олж хардаг болсон юм. Энэ нь олонтоо тохиолдсон бөгөөд тохиолдох үед нь санахыг хичээснээрээ, бидний төлөө юу хийснийгээ надад харуулах боломж Бурханд олгосноо би ухаарсан.

Зүрх сэтгэл маань талархлаар бялхаж эхэлсэн юм. Гэрчлэл маань өссөн. Тэнгэрлэг Эцэг маань залбирлуудыг сонсч, мөн хариулдаг гэдгийг би илүү баттай мэдэж авсан билээ. Аврагч Есүс Христийн цагаатгалаар ирдэг зүрх сэтгэлийн зөөлөн байдал болон ариусалд би илүү талархлыг мэдэрсэн. Ариун Сүнс бидэнд бүхнийг тэр байтугай тухайн үед анзааралгүй буюу тоомжиргүй өнгөрүүлсэн зүйлсийг ч сануулах болно гэдэгт би илүү итгэлтэй болсон билээ. . . .

Бурханы өгөөмөр сэтгэлийг санаж, мэдэж авах замыг олоосой хэмээн би та нарт ухуулмаар байна. Ингэх нь бидний гэрчлэлийг өсгөх болно. Та нар өдрийн тэмдэглэл бичдэггүй байж болно. Бичиж хадгалсан зүйлсээ өөрсдийн хайртай болон үйлчилдэг хүмүүстэй хуваалцдаггүй байж болно. Гэвч Их Эзэний хийсэн зүйлсийг санаснаар тэд болон та нар өөрсдөө адислагдах болно. Бидний хааяа дуулдаг дараах дууг та нар санаж байгаа байх: “Адислал бүрээ тоол. Бурханы хийснийг ухааран та биширнэ”.



НАЙМДУГААР САР: ГЭРЛЭЛТ БА ГЭР БҮЛ

Гэр бүлийнхээ түүхийг судлах нь яагаад чухал вэ?

Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын төлөвлөгөө нь гэр бүлийн харилцааг мөнхөд үргэлжлэх боломжтой болгодог. Гэр бүлийн түүхийн ажлаар дамжуулан бид өвөг дээдсийнхээ талаар илүү ихийг сурч, сайн мэдээний ёслолууд хэрэгтэй байгаа тэдгээр хүмүүсийн нэрсийг олж тогтоон, бэлтгэж, ариун сүмүүдэд тэдний төлөө ёслолуудыг гүйцэтгэх боломжтой. Сүм биднийг гэр бүлийн түүхийн талаар судлах, нас барагсдын төлөө ариун сүмийн ажлыг гүйцэтгэхэд туслах олон эх сурвалжаар хангадаг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Гэр бүлийн түүхийн ажлын талаар илүү ихийг ойлгохын тулд доорх материалуудыг ашиглана уу. Энэхүү тоймын үйл ажиллагаануудыг багтаагаад, гэр бүлийн түүхийн ажлын талаарх таны туршилага үүнийг үр дүнтэй заахад тусална. Энэ тойм дахь үйл ажиллагаанууд өсвөр үеийнхнийг гэр бүлийн түүхийн ажилд оролцуулах арга замуудыг төлөвлөхөд тань хэрхэн тусалж болох талаар бодож үз. Өсвөр үеийнхэнд гэр бүлийнхээ түүхийг судлахын ач холбогдлыг ойлгоход юу туслах вэ?

Та гэр бүлийнхээ түүхийн талаар хэрхэн суралцсан бэ? Танд гэр бүлийн түүхийн ажлын талаарх гэрчлэлийг тань хүчирхэгжүүлсэн ямар туршлагауд байдаг вэ?

Та өсвөр үеийнхнийг гэр бүлийн түүхийн ажилд оролцоход нь хэрхэн урамшуулан дэмжиж болох вэ? Өвөг дээдсийнхээ талаар суралцаж, нас барсан гэр бүлийнхнийхээ төлөө ёслолуудыг гүйцэтгэхэд нь тэдэнд туслах ямар эх сурвалжууд танай бүс нутагт боломжтой байдаг вэ?

1 Коринт 15:29 (Эрт цагийн гишүүд үхэгсдийн төлөө баптисмыг гүйцэтгэсэн)

1 Петр 3:18–20; 4:6 (Сайн мэдээ сүнсний дэлхийд номлогдож байна)

Малахи 4:5–6; С ба Г 2:1–3 (Хүүхдүүдийн зүрх сэтгэл эцгүүд рүүгээ эргэх болно)

С ба Г 110:13–16 (Елиа лацдан холбох түлхүүрүүдийг дахин сэргээв)

С ба Г 128:16–18 (Нас барагсдын төлөөх ёслолууд нь үе удмуудын хооронд гинжин холбоосыг бий болгодог)

Ричард Г. Скотт, “Нас барагсдын авралаас ирдэг баяр баясгалан,” *Ensign* эсвэл 2012 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 113–116

Дэвид А. Бэднар, “Хүүхдүүдийнх нь зүрх сэтгэл эцгүүд уруугаа эргэх болно,” *Ensign* эсвэл 2011 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 28–31

Аллэн Ф. Пакэр, “Ном,” *Ensign* эсвэл 2014 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 114–117

“Гэр бүлийн түүхийн ажил болон угийн бичиг,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 68–72

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутын турш өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөл байдалд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээл эсвэл найзуудтайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Та тэдэнд өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь хэрхэн тусалж чадах вэ? Эдгээр санаа тусалж болох юм.

- Эцэг эх, ах дүү эсвэл гэр бүлийн бусад гишүүнээс саяхан суралцсан сайн мэдээний нэг зарчмын талаар хуваалцахад хэд хэдэн өсвөр үеийнхнийг урь.
- Өсвөр үеийнхнийг гэр бүлийн түүхийн ажлаа хийж байх үед тохиолдсон туршлагаадаасаа хуваалцахад урь. Түүнчлэн “Миний эмээтэй танилц” эсвэл “Гэр бүлийн түүх: Миний сурсан зүйл” бичлэгийг үзүүлж болно. Тэнгэрлэг Эцэг яагаад биднээс гэр бүлийн түүхийн ажлаа хийгээсэй гэж хүсдэг талаар ангиараа ярилц.

Хамтдаа суралц

Заахад туслах арга

“Суралцагчид чимээгүй болохоос бүү ай. Асуултад хариулж, бодлоо илэрхийлэхийн тулд хүмүүст ихэвчлэн бодох хугацаа хэрэгтэй байдаг. Та асуулт тавьж мөн сүнслэг туршилага хуваалцсаны дараа уг хүнд өөрийгөө илэрхийлэх нь хэцүү байгаа үед түр хүлээх хэрэгтэй (Teaching, No Greater Call [1999], 67).

Доорх үйл ажиллагаа бүр нь өсвөр үеийнхэнд гэр бүлийн түүхийн ажилд хэрхэн оролцохыг суралцахад тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу, түүнээс дээш үйл ажиллагааг сонго.

- Ангиараа Ахлагч Дэвид А.Бэднэрийн “Хүүхдүүдийнх нь зүрх сэтгэл эцгүүд уруугаа эргэх болно” хэлсэн үгээс “Өсвөр үеийнхэнд өгөх урилга”-ыг унш. Өсвөр үеийнхний гэр бүлийн түүхийн ажилд оролцохдоо хийж болох зүйлүүдийг олоход урь. Боломжтой бол өсвөр үеийнхэнд ёслол хэрэгтэй өвөг дээдсээ олоход FamilySearch.org-ыг хэрхэн ашиглахыг зааж өг. Тэднийг ариун сүм рүү явж, олсон өвөг дээдсийнхээ өмнөөс баптисм хүртэж, гишүүнээр батлуулахад урамшуулан дэмж. Бишопын зөвшөөрлөөр та тойргийн гэр бүлийн түүхийн зөвлөгчийг (эсвэл гэр бүлийн түүхийн ажилд туршилагатай хэн нэгнийг) энэ үйл ажиллагаанд туслахад урь.
- Өсвөр үеийнхнийг Ахлагч Ричард Г.Скоттын “Нас барагсдын авралаас ирдэг баяр баясгалан” хэлсэн үгээс “Ариун сүмд таны хийдэг ямар ч ажил” гэж эхэлсэн гурван догол мөрийг унш. Тэднийг гэр бүлийн түүхийн ажлыг хийх чухал шалтгаануудыг олж мөн хуваалцахад урь. Тэднээс уг хэлсэн үгийн сүүлийн хоёр догол мөрийг уншаад, өвөг дээдсээ хайж олохын тулд тэд юут “хойш тавьж” болох талаар ярилцахыг хүс.
- Өсвөр үеийнхний хагасыг нь Итгэлдээ үнэнч байх нь гарын авлагын “Гэр бүлийн түүхийн ажил болон угийн бичиг” бүлгээс “Нас барагсдыг аврах нь” хэсгийг (69-70-р хуудас) уншихад, үлдсэн хагасыг

нь “Тэр бүлийн түүхийн ажил дахь таны үүрэг хариуцлагууд” хэсгийг (70-72-р хуудас) уншихад урь. Суралцсан зүйлийнхээ тухай бусадтайгаа хуваалцахад тэднийг урь. Өсвөр үеийнхэнд удмын бичгээ хөтөлж эхлэхэд нь тусал. Тэднийг удмын бичгээ гэртээ үргэлжлүүлэн хөтлөхөд урамшуулан дэмж. Тэднийг эцэг эх болон гэр бүлийнхээ гишүүдээс тусламж хүсэхэд урь.

- Өсвөр үеийнхнийг жагсаасан судруудыг уншиж, “Бид яагаад гэр бүлийн түүхийн ажил хийдэг вэ?” гэсэн асуултын талаар тунгаан бодоход урь. Тэднээс санаа бодлоо хуваалцахыг хүс. Тэднийг гэр бүлийн түүхийн ажилд оролцож болох арга замуудыг жагсааж бичихэд урь. Тэднийг ирэх долоо хоногт уг жагсаалтаас юу хийхээ сонгоход урь. Тэднийг туршлагуудаа дараагийн хичээлүүд дээр хуваалцахад урамшуулан дэмж.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр юу сурснаа хуваалцахыг хүс. Тэд гэр бүлийнхээ түүхийн талаар суралцахын ач холбогдлыг ойлгож байна уу? Тэд ямар бодол эсвэл сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр нэмэлт асуултууд байна уу? Энэ сургаал дээр илүү их цаг зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан зүйлээс өсвөр үеийнхэнд юу хийх мэдрэмж төрж байгаа талаар тэднээс асуу. Тэрхүү мэдрэмжийнхээ дагуу үйлдэхэд тэднийг урамшуулан дэмж. Суралцагчид үүний дагуу үйлдэж байгаа эсэхэд хяналт тавих аргуудыг бодож ол.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нартаа итгэдэг байсан. Тэрээр тэднийг бэлтгэж, дараа нь тэдэнд заах, адислах мөн бусдад үйлчлэх чухал үүрэг хариуцлагуудыг өгсөн. Та өсвөр үеийнхнийг гэр бүлийнхээ түүхийг судлах үүрэг хариуцлагуудаа биелүүлэхэд мөн өвөг дээдсийнхээ төлөө ёслол хийлгэхэд нь хэрхэн бэлтгэж болох вэ?

Сонгосон материалууд

Ричард Г. Скотт, “Нас барагсдын авралаас ирдэг баяр баясгалан” – аас эш татав, Ensign эсвэл Лиахона, 2012 оны 11-р сар, 93–95

Ариун сүмд таны хийдэг ямар ч ажил таны цагийг дэмий гарздана гэж байхгүй, харин өвөг дээдсийнхээ хэн нэгний төлөө төлөөлөн гүйцэтгэх ёслол хийлгэснээр ариун сүмд өнгөрүүлсэн цаг тань улам ариун болж, агуу адислалуудыг хүлээн авах боломжийг танд олгоно. Тэргүүн Зөвлөл “Бидний хамгийн чухал үүрэг бол өөрсдийнхөө өвөг дээдсийг хайж олох явдал мөн” хэмээн тунхагласан билээ. [Тэргүүн Зөвлөлийн захидал, 2012 оны 2-р сарын 29; тодотгол нэмэгдсэн.]

Залуу хүмүүс та нар дайсны нөлөөг амьдралаасаа шахан зайлуулах найдвартай арга замыг мэдэхийг хүсч байна уу? Тэгвэл өвөг дээдсээ эрж олон, тэдний нэрийг ариун сүмийн төлөөлөн гүйцэтгэх ёслолуудад бэлтгэж, улмаар ариун сүмд очиж, тэдний төлөө баптисмын болон Ариун Сүнс хүлээн авах ёслолуудыг хийлгэхэд бие сэтгэлээ дайчлан ажиллагтун. Та нар нас ахих тусмаа,

бусад ёслолуудыг түүнчлэн хүлээн авахад оролцох боломжтой болно. Амьдралд тань нөлөөлөх дайсны муу нөлөөнөөс хамгаалах үүнээс илүү найдвартай хамгаалалтыг би мэдэхгүй.

Оросын Ростовын Номлолд ариун сүмийн ёслолууд хийлгэхээр 2000 нэрийг залуучуудад урилга болгон тараахдаа тэдний өөрсдийнх нь өвөг дээдсийн дор хаяж нэг нэрийг оруулж өгсөн байна. Энэ ажлыг гүйцэтгэсэн хүмүүсийг Украины Киевийн шинэ ариун сүм рүү урт удаан аялал хийхэд урьсан ажээ. Нэг залуу туршлагаа ийн хуваалцжээ: “Би компьютерийн тоглоом тоглож хамаг цагаа үрдэг байлаа. Ариун сүмд ёслол хийлгэх хүмүүсийн нэрийн индекс дээр ажиллаж эхэлснээс хойш компьютер дээр тоглох зав гардаггүй болсон. Би эхлээд, ‘Өө яаж үүнийг хийх юм бэ! Ёстой барахгүй юм байна!’ гэж бодсон шүү. Гэтэл төсөл дуусахад би компьютер тоглох сонирхолгүй болсон байлаа. . . . Гэр бүлийн түүхийн ажил бол дэлхий дээр бидний хийх ёстой ажил. Энэ ажил тэнгэрт үргэлжлэх болно.”



Би гэр бүлийнхээ түүхийн ажлыг хэрхэн хийхийг бусдад хэрхэн заах вэ?

Их Эзэн өнөө үед биднийг өвөг дээдсийнхээ талаар судлах, тэдний ёслолуудыг ариун сүмд гүйцэтгэх боломжтой болгохын тулд гайхалтай технологийг бэлтгэсэн билээ. Иймэрхүү арга замаар Тэрээр өнөөгийн өсвөр үеийнхнийг энэ чухал ажилд хувь нэмрээ оруулж болохын тулд эдгээр технологийг ашиглах чадвартай болгон бэлтгэсэн. Гэр бүлийнхээ түүхийг судлахын хажуугаар бид гэр бүлийн түүхийн эх сурвалжуудын талаар сайн мэддэггүй хүмүүст тусалж чадна. Энэ арга замаар бид тэдэнд энэхүү чухал ажлын талаар сүнсийг мэдрэх мөн нас барсан өвөг дээдэстээ аврал авчрахад нь тусалдаг.

Гэр бүлийн түүхийн талаар судлахад нь бусдад туслах ямар боломжууд танд байсан бэ? Хэн нэгэн хүн гэр бүлийн түүхийн ажлыг хэрхэн хийхийг танд заасан ямар туршлага байна вэ?

Гэр бүлийн түүхийн ажлыг хийхэд нь өсвөр үеийнхэн бусдад туслахдаа ашиглаж болох ямар ур чадвар болон боломж тэдэнд байгааг та олж мэдсэн бэ? Их Эзэн тэднийг энэ чухал ажилд бэлтгэсэн гэх ямар нотолгоог та олж харсан бэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах материалуудыг залбирч судал. Өсвөр үеийнхэн маань бусдыг гэр бүлийнхээ түүхийн талаар суралцахад нь туслах сүнслэгээр нөлөөлөх юуг та мэдэрч байна вэ?

С ба Г 128:16–18 (Нас барагсдын төлөөх ёслолууд нь үе удмуудын хооронд гагнагч холбоосыг бий болгодог)

С ба Г 138:46–48 (Өнөө үед ариун сүмүүдэд агуу ажил хийгдэх ёстой)

Рассэлл М.Нэлсон, “Хайраар хэл хэгдсэн ургууд,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 он 5-р сар, 91–94

Дэвид А.Бэднар, “Хүүхдүүдийн зүрх сэтгэл эргэх болно,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2011 он 11-р сар, 24–27

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутын туршид, өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээл эсвэл найзуудтайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь та нар тэдэнд яаж тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм.

- Өсвөр үеийнхнийг өмнөх хичээлдээр сурсан зүйлээ хэрэгжүүлсэн туршлагаасаа хуваалцахад урь.
- Өсвөр үеийнхнийг хэн нэгэнд технологи ашиглахад нь тусалсан туршлагаасаа хуваалцахад урь (компьютер, үүрэн телефон, эсвэл ижил тоног төхөөрөмж). Ахлагч Бэднарийн “Зөвхөн найзуудтайгаа харилцахын тулд биш, харин Их Эзэний ажлыг урагшлуулахын

тулд та нар гар утас болон компьютер дээр мессеж маш хурдан бичиж сурсан” хэмээх мэдэгдлийг хуваалц (“Хүүхдүүдийн зүрх сэтгэл эцгүүд рүүгээ эргэх болно,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2011 оны 11-р сар, 26). Өсвөр үеийнхэн технологи ашигладаг чадвараа гэр бүлийн түүхийн ажил хийхэд нь бусдад туслахын тулд хэрэглэж болох ямар арга замууд байж болох вэ?

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь гэр бүлийн түүхийн ажилд оролцоход нь бусдад хэрхэн тусалж болохоо мэдэхэд нь өсвөр үеийнхэнд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу.

Заахад туслах арга

“Ангид чимээгүй болоход бүү сандар. Асуултанд хариулахын тулд хүмүүс бодох хэрэгтэй байдаг. Та асуулт тавьж мөн сүнслэг туршлага хуваалцсаны дараа эсвэл уг хүнд өөрийгөө илэрхийлэх нь хэцүү байгаа үед түр хүлээх хэрэгтэй” (*Teaching, No Greater Call* [1999], 67).

- Ахлагч Дэвид А.Бэднарийн “Хүүхдүүдийн зүрх сэтгэл эцгүүд рүүгээ эргэх болно” хэмээх хэлсэн үгний “Өсвөр үеийнхэнд өгөх урилга” хэсгийг уншихад өсвөр үеийнхнийг урь. Өсвөр үеийнхнээс ахлагч Бэднарийн гэр бүлийн түүхийн ажилд бусдад туслахыг урьсан хэсгийг хайж олохыг хүс. Эдгээр урилгаас юу нь тэдэнд гүнзгий сэтгэгдэл төрүүлж байна вэ? Ахлагч Бэднарийн урилгуудаас өсвөр үеийнхний хариулж болох арга замуудыг жагсаан бичээд, ангиараа хийж болох ямар нэгэн зүйлийг жагсаалтаас сонгоход тэднийг урь.

- Өсвөр үеийнхнийг гэр бүлийн түүхийн ажлыг урьд өмнө нь огт хийж байгаагүй хэн нэгэнд тусалж байна хэмээн төсөөлөхөд урь. Ахлагч Рассэлл М.Нэлсоний хэлсэн “Хайраар хэлхэгдсэн ургууд” хэлсэн үгийн хэсгүүдийг өсвөр үеийнхний дунд хуваарилан өгч, гэр бүлийн түүхийн ажил хийхэд нь тусалж буй уг хүнтэй хуваалцаж болох зүйлсийг хайж олохыг хүс. Тэд ямар судруудаас хуваалцаж болох вэ? (Жишээлбэл: энэхүү тоймд тусгагдсан судруудын жагсаалтыг үзнэ үү.) Тэднийг олж мэдсэн зүйлээ хуваалцахыг мөн гэр бүлийн түүхээ судалж эхлэхэд нь тусалж болох хэн нэгний талаар бодохыг хүс.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Гэр бүлийн түүхийн ажлаа хийхэд нь бусдад хэрхэн туслахаа тэд ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сургаал дээр илүү хугацаа зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан зүйлийнхээ улмаас тэд юуг хийх урам авч байгаа талаар өсвөр үеийнхнээс асуу. Тэрхүү мэдрэмжийнхээ дагуу үйлдэхэд тэднийг урамшуулан дэмж. Суралцагчид үүний дагуу үйлдэж байгаа эсэхэд хяналт тавих аргуудыг бодож ол.

Аврагчийн арга барилаар заах нь

Бүхий л нөхцөл байдалд Аврагч бидний төгс жишээ ба бидний багш байсан. Тэрээр шавь нартаа тэдэнд заасан Өөрийн арга барилаар хэрхэн заахыг зааж сургасан. Таны үлгэр жишээ өсвөр үеийнхнийг бусдад заахад нь бэлтгэхэд хэрхэн тусалж болох вэ?

Сонгосон материалууд

Дэвид А.Бэднар, “Хүүхдүүдийн зүрх сэтгэл эргэх болно” хэлсэн үгнээс эш татав, *Ensign* эсвэл Лиахона, 2011 оны 11-р сар, 24–27

Одоо би, өнөө үед та нарын амьдрал дахь Елиагийн Сүнсний ач холбогдлын тухай онцлон ярьж байхдаа залуу эрэгтэй, эмэгтэйчүүд болон хүүхдүүдийг анхаарлаа хандуулахыг хүсэж байна. Би энэ тухай сүмийн бүхий л хүнд хандан ярьж байгаа ч ялангуяа та нарт илүү зориулж байна.

Та нарын ихэнх нь гэр бүлийн түүхийн ажлыг насанд хүрсэн хүмүүс л хийх ёстой гэж боддог байж магадгүй. Гэхдээ судруудад эсвэл сүмийн удирдагчдын заавруудад энэ чухал үйлчлэлийг зөвхөн насанд хүрэгчид хийх ёстой гэж заасан байхыг би үзээгүй. Та нар бол Бурханы охид хөвгүүд, гэрээний хүүхдүүд бөгөөд Түүний хаант улсыг байгуулах хүмүүс мөн. Гэр бүлийн авралын ажлыг хийх үүрэг хариуцлагаа биелүүлэхэд та заавал насанд хүрэхийг хүлээх шаардлагагүй.

Елиагийн Сүнсний эхлүүлсэн энэхүү ажлын талаар сурч мэдэн, үүнд хайртай болоход тань туслах олон нөөц боломжийг Их Эзэн өнөөдөр өгсөн. Жишээлбэл, FamilySearch вэб хуудас нь компьютер болон бусад төхөөрөмжүүд ашиглан гэр бүлийн түүхээ олж мэдэх, баримтжуулахад нь хүмүүст туслах зорилготой юм. Дэлхий даяарх сүмийн байруудад байрладаг гэр бүлийн түүхийн төвүүдээс эдгээр нөөц боломжийг ашиглах боломжтой.

Залуучууд мэдээлэл харилцааны технологитой ийм их ойр болсон өнөө үед FamilySearch болон бусад хэрэгслүүд гарч ирсэн нь тохиолдлын хэрэг биш ээ. Зөвхөн найз нартайгаа харилцахын тулд биш харин Их Эзэний ажлыг урагшлуулахын тулд та нар гар утас болон компьютер дээрээ мессеж маш хурдан бичиж сурсан. Өнөөгийн залуучуудын авьяас болон ур чадварыг авралын ажилд хувь нэмрээ оруулахад ашиглаж болно.

Елиагийн сүнсний талаар сурч, үүнийг мэд-рэхийг Сүмийн залуучуудаас би хүсч байна. Түүнчлэн тэд өвөг дээдсийнхээ тухай сурч мэдэн, тэднийг эрж хайн, нас барагсдынхаа өмнөөс баптисм хийлгэхэд *өөрсдийгөө* бэлдэхийг хүсч байна (С ба Г 124:28–36-г үзнэ үү). Мөн бусад хүмүүст гэр бүлийн түүхээ олж мэдэхэд нь туслахыг би та бүхэнд уриалж байна.

Та нар үүнийг хийх аваас та нарын зүрх сэтгэл эцгүүд рүүгээ эргэх болно. Абрахам, Исаак болон Иаков нартай хийсэн амлалтууд та нарын зүрх сэтгэлд суух болно. Таны патриархын адислал, түүн дээр мэдэгдсэн уг гарал тань тань эдгээр эцгүүдтэй тань холбож таны хувьд илүү утга учиртай болно. Та өвөг дээдсээ илүү хайрлаж тэдэнд илүү ихээр талархах болно. Аврагчийн тухай таны гэрчлэл илүү гүн гүнзгий, бат бөх болно. Та нар өсөн нэмэгдэж буй дайсны нөлөөнөөс хамгаалагдах болно гэдгийг би та нарт амлаж байна. Та энэхүү ариун нандин ажилд оролцож, үүнийг хийх хүсэлтэй болсноор залуу насандаа мөн амьдралынхаа турш хамгаалагдах болно.



Гэрлэлт ба гэр бүлийн ач холбогдлын талаар би бусдад хэрхэн тайлбарлаж болох вэ?

Ихэнх хүмүүст сайн мэдээний үнэнүүдийг бусадтай хуваалцах боломж гардаг. Өнөөдөр дэлхийд гэрлэлт ба гэр бүлийн талаар зөрчилдөөнтэй олон үзэл бодлууд байдаг учраас бид Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөн дэх гэрлэлт ба гэр бүлийн ач холбогдлын талаар хэрхэн тайлбарлахаа мэддэг байх нь чухал юм. Ингэхдээ бид бусад хүмүүс сайн мэдээний үнэнүүдийг ойлгож болохын тулд Ариун Сүнсний удирдамжаар өөрсдийн итгэл үнэмшлээ товчхон бөгөөд энгийнээр тайлбарлах хэрэгтэй.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Гэрлэлт ба гэр бүлийн ач холбогдлыг хэрхэн тайлбарлах талаар илүү ихийг ойлгож мэдэхийн тулд доорх материалуудыг ашигла. Бусдад сургаалыг тайлбарлаж байсан таны туршиллагууд үүнийг үр дүнтэй заахад тань тусална. Энэхүү тоймын үйл ажиллагаанууд өсвөр үеийнхнийг заахад суралцахад хэрхэн тусалж болох талаар бодож үз.

“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 11-р сар, 129

Нийл Л.Андэрсэн, “Сүнслэг шуурганууд,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 5-р сар, 32–36

Д.Тодд Кристоффэрсон “Гэрлэж, гэр бүлтэй болох шалтгаан” *Ensign* эсвэл *Лиахона*, 2015 оны 5-р сар, 35–39

“Гэрлэлт,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 74–78

“Мөнхийн гэрлэлт” болон “Ариун сүмүүд ба гэр бүлийн түүхийн ажил,” *Миний сайн мэдээг номло* (2004), 94–96

Та гэрлэлт ба гэр бүлийн талаарх итгэл үнэмшлээ бусад хүнд ойлгоход хэрхэн тусалж байсан бэ? Та Сүмийн гишүүн бус найзууддаа мөнхийн гэрлэлт зэрэг ойлголтыг ямар арга замаар тайлбарлаж байсан бэ?

Гэрлэлт ба гэр бүлийн талаарх өсвөр үеийнхний төсөөлөлд ямар туршиллага, үзэл санаа нөлөөлж байна вэ? Та гэрлэлт ба гэр бүлтэй холбоотой үнэнүүдийг бусдад тайлбарлахад нь өсвөр үеийнхнийг хэрхэн бэлтгэж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутын туршид, өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээл эсвэл найз нартайгаа хамт туулсан туршиллага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь та нар тэдэнд яаж тусалж чадах вэ? Эдгээр санаа тусалж болох юм:

- Өсвөр үеийнхнийг гэр бүлийнх нь гишүүн хэрхэн сайн мэдээний зарчмын жишээг тэдэнд харуулсныг хуваалцахад урь.

- Өөр хэлээр ярьдаг хэн нэгнийг (боломжтой бол, ангийн гишүүнийг) ангидаа ирэхийг мөн тэрхүү хэлээр ярихад урь. Тэдний мэдэхгүй хэлээр

ярихыг сонсох нь хэрхэн сүмийн гишүүн танил бус байж болох *мөнхийн гэрлэлт, лацдан холболт*, эсвэл *селестиеел хаант улс* зэрэг үгсийг хэрэглэн сайн мэдээний үнэнүүдийг бусдад тайлбарлахыг сонсож байгаатай адил болохыг тайлбарлахад өсвөр үеийнхнийг урь.

Заахад туслах арга

“Жижиг бүлгүүдээр ярилцах нь сонирхол нь буурч, анхаарал нь сарниж байгаа хүмүүсийг ярилцлагад амархан татан оруулдаг ач холбогдолтой” (*Teaching, No Greater Call* [1999], 72).

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь гэрлэлт ба гэр бүлийн ач холбогдлын талаар бусдад хэрхэн тайлбарлахыг сурахад нь өсвөр үеийнхэнд туслах юм. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

- Өсвөр үеийнхнээс ижил хүйстний гэрлэлтийн талаарх Сүмийн байр суурийг тайлбарлах шаардлага гарч байсан эсэхийг нь асуу. Тэд хэрхэн тайлбарласан бэ? Ахлагч Д.Тодд Кристоффэрсоны “Гэрлэж, гэр бүлтэй болох шалтгаан” эсвэл ахлагч Нийл Л.Андэрсэний “Сүнслэг шуурганууд” хэлсэн үгээс сонгосон догол мөрүүдийг уншихад тэднийг урь. Өсвөр үеийнхэн эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын гэрлэлтийн ач холбогдлын талаар юу олж мэдсэн бэ? Дараагийн удаа гэрлэлтийн талаарх өөрсдийн итгэдэг зүйлсийг хуваалцах боломж гарах үед юу хэлэхээ төлөвлөх эсвэл дүрд тоглон бэлдэхэд өсвөр үеийнхнийг урамшуулан дэмж.

- Гэрлэлт ба гэр бүлийн талаар өөр шашинтай хүмүүст байж болох “Би яагаад гэрлэж, хүүхэдтэй болох хэрэгтэй вэ?” эсвэл “Гэрлэлт яагаад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой вэ?” гэх мэт асуултаудыг бодож олоод, самбар дээр жагсаан бичихэд өсвөр үеийнхнийг урь. Өсвөр үеийнхнээс жагсаасан

асуултуудаас хэдийг сонгож, судраас хариултыг нь олохыг хүс (жишээ болгон Итгэлдээ үнэнч байх нь гарын авлагын “Гэрлэлт” ба “Гэр бүл” хэсгүүд мөн “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг” доторх судрын эшлэлүүдийг үзнэ үү). Өсвөр үеийнхнийг сонгосон асуултуудынхаа хариултыг *селестиеел гэрлэлт* эсвэл *лацдан холболт* зэрэг ойлгоход хэцүү байж болох үг, хэллэгүүдийг хэрэглэхгүйгээр нэг минутад багтаан хариулахад бэлтгэхэд урамшуулан дэмж. Тэдэнд хариултаа хуваалцах хугацаа өг.

- Өсвөр үеийнхнээр гэрлэлт ба гэр бүлийн ач холбогдлын тухай сонины мэдээ бичүүл. Энэ нь сургуулийн сонинд эсвэл блог дээр тавигдахаар богино хэмжээнийх байж болно. Өсвөр үеийнхнийг бэлтгэсэн зүйлээ ангийнхантайгаа хуваалцахад урь.

- Ангиараа хамтдаа Залуучуудын бат бөх байдлын төлөө номын “Гэр бүл” бүлгийг унш. Өсвөр үеийнхнийг гэр бүлийн тухай сурсан

сургаалын заримыг Хүүхдийн хэсгийн хүүхдүүдэд заахаар бэлдэхэд урь. Жишээлбэл, “Тэр бүл яагаад чухал вэ?” гэсэн асуултыг ашиглан тэд хүүхдүүдэд зааж болно. Энэхүү ойлголтыг энгийнээр, товчхон тайлбарлахад туслах тойм гаргахад тэднийг урь. Бишопын болон Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн зөвшөөрөлтэйгөөр өсвөр үеийнхнийг хичээл заахаар зохицуул. Тэднийг хичээлээ заасны дараа, сайн мэдээний энэ зарчмыг хэрхэн заасан тухай ярилцахыг хүс.

- Бишопын зөвшөөрлөөр бүрэн цагийн номлогчдыг гэрлэлт ба гэр

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд гэрлэлт ба гэр бүлийн ач холбогдлын талаар бусдад хэрхэн тайлбарлахаа ойлгосон уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан зүйлээс өсвөр үеийнхэнд юу хийх мэдрэмж төрж байгаа талаар тэднээс асуу. Тэр мэдрэмжүүдийнхээ дагуу үйлдэхэд тэднийг уриал. Суралцагчид үүний дагуу үйлдэж байгаа эсэхэд хяналт тавих аргуудыг бодож ол.

бүлийн сургаалыг бусдад хэрхэн тайлбарладаг тухайгаа ангийнхантай хуваалцуулахаар ангидаа урь. Ангийг хоёр бүлэгт хуваагаад, энэхүү тоймд санал болгосон материалуудыг (эсвэл тэд өөрсдөө олж болох материалаа) ашиглан нэг бүлгийг мөнхийн гэрлэлтийн талаар, нөгөө бүлгийг ариун сүм ба гэр бүлийн түүхийн талаар заахад бэлдэхийг хүс. Өсвөр үеийнхнийг сэдвээрээ энгийн, товчхон тайлбар бэлдсэний дараа судалсан сургаалаа нөгөө бүлгийнхээ нэг хүнд заахад урь.

Аврагчийн арга барилаар заах нь

Есүс Христ заасан хүмүүсээ итгэлээр үйлдэж, Өөрийн заасан үнэнүүдийн дагуу амьдрахад урьсан. Тэрээр Өөрийн бүх сургаалд дагалдагчдаа бүх зүрх сэтгэлээрээ сайн мэдээний дагуу амьдрахад нь туслахад анхаардаг байв. Та өсвөр үеийнхнийг сурч байгаа зүйлсээ итгэлээр үйлдэхэд хэрхэн урамшуулж болох вэ?

Сонгосон материалууд

“Ариун сүмийн гэрлэлт” (MormonNewsroom.org дээрх өгүүлэл) -ээс эш татав

Сүмийн гишүүд ариун сүмд хийгдсэн гэрлэлтүүд нь “лацдагдсан” буюу мөнхөд үргэлжлэхээр адислагдсан гэдэгт итгэдэг. Биднийг нас барсны дараа ч гэрлэлтийн холболт болон эцэг эх хүүхдүүдийн харилцаа хэвээр байж, хайр бүхий гэр бүлийн нэгдмэл байдал нь үргэлжилж чадна хэмээх энэхүү ойлголт нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдийн үндсэн итгэл юм.

Нэгэнт хосууд гэрлэн, ариун сүмд лацдан холбогдсон бол тэдний гэр бүлд төрсөн бүх хүүхэд төрөхдөө тэдэнтэй лацдан холбогдсон байдаг. Хэрвээ хосууд лацдан холбогдохоос өмнө хүүхдүүд нь төрсөн бол, тэр хүүхдүүд нь хожим эцэг эхтэйгээ ариун сүмд лацдан холбогдож болно. Мөн үрчлүүлсэн хүүхдүүд, үрчилж авсан эцэг эхтэйгээ лацдан холбогдох боломжтой байдаг.

Мөнхийн гэр бүлийн талаарх ойлголт нь судрууд болон орчин үеийн илэрхийлэлтээс ирдэг. Жишээлбэл, Шинэ Гэрээний Матай номын 16:19-д, Есүс Христ төлөөлөгч Петрт хандан: “Би чамд тэнгэрийн хаанчлалын түлхүүрийг өгнө. Чи газар дээр юуг холбоно, тэр нь тэнгэрт холбогдоно. Газар дээр юуг тайлна, тэр нь тэнгэрт тайлагдах болно” гэжээ. Сүм холбогдох гэдэг үгийг “лацдах” гэдэг үгтэй адилхан авч үздэг.

Лос Анжелес Таймс сонины 2000 нийтлэлд дурдагдсан судалгаагаар, “Салалтын энэ эрин зуунд, Мормончуудын ариун сүмийн гэрлэлтүүд нь төгсгөлгүй байхаар зориулагдсан” бөгөөд салалтын түвшин дөнгөж 6 хувьтай байдаг” гэж гарчээ. 1993 онд, *Демографи Сэтгүүлд* хэвлэгдсэн өөр нэгэн судалгаанд, сүмийнхээ аль нэг ариун сүмд гэрлэсэн Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд Америкчууд дундаас салах магадлал хамгийн багатай хүмүүс гэж дүгнэжээ.



Гэр орондоо суралцах болон заах ямар боломжууд байдаг вэ?

Гэр орон бол суралцах, заах, сайн мэдээний зарчмуудыг хэрэгжүүлэх хамгийн тохиромжтой газар юм. Хожмын үеийн бошиглогчид гэр бүлүүдийг гэр бүлийн залбирал, гэр бүлийн үдэш, сайн мэдээнээс суралцах болон заахыг мөн гэр бүлийг бүхэлд нь хамрах үйл ажиллагаануудыг нэн тэргүүнд тавихыг чухалчлан хүсдэг билээ.

Гэр орондоо сайн мэдээнээс суралцах, заах ямар туршлагаууд танд байдаг вэ? Та өсвөр үеийнхэнтэй ямар туршлагаа хуваалцаж болох вэ?

Гэр орондоо сайн мэдээнээс суралцахад нь өсвөр үеийнхнийг та хэрхэн урамшуулан дэмжиж болох вэ? Ямар амлагдсан адислалууд тэдэнд сүнслэгээр нөлөөлж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Өсвөр үеийнхнийг гэр орондоо сайн мэдээний үнэнүүдийг зааж мөн суралцахад нь бэлтгэхийн тулд доорх материалуудыг ашиглана уу. Таны хувийн туршлага өсвөр үеийнхэнд үр дүнтэй заахад тусална. Энэхүү тоймын үйл ажиллагаанууд нь өсвөр үеийнхнийг урамшуулах арга замуудыг төлөвлөхөд тань хэрхэн туслах талаар бод.

Мозая 4:14–15; С ба Г 68:25–28 (Эцэг эхчүүд хүүхдүүддээ сайн мэдээг заах үүрэгтэй)

М.Рассэлл Баллард, “Гэр бүлийн зөвлөл,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 49–52

Квинтин Л.Күк, “Эзэн бол миний гэрэл” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 50–54

Ахлагч Тэд Р.Каллистэр, “Эцэг эхчүүд: Хүүхдүүдийнхээ хамгийн чухал багш нар,” *Ensign* эсвэл 2014

оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 36–38

“Гэр бүлийн үдэш,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 72–74

“Гэр бүлийн залбирал,” *Итгэлдээ үнэнч байх нь*, 105

“Өдөр бүр судраас судлахын ач холбогдол,” *Итгэлдээ үнэнч байх нь*, 175–177

“Гэр ба Сүм” *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 1.4

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутын туршид, өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээл эсвэл найзуудтайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь та нар тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Эдгээр санаа тусалж болох юм.

- Өнгөрсөн долоо хоногийн хичээл дээр сурсан зүйлээ долоо хоногийн туршид хэрхэн хэрэгжүүлснийг хуваалцахад өсвөр үеийнхнийг урь.

- Өсвөр үеийнхнээс тэд өөрсдийгөө эцэг, эх хэмээн төсөөлөхийг хүс. Тэд хүүхдүүдийнхээ өмнө ямар үүрэг хариуцлага хүлээдэг вэ? Ангийн нэг гишүүнийг тэдгээрийг самбар

дээр жагсаан бичихийг хүсэн, өсвөр үеийнхнийг Мозая 4:14–15 ба Сургаал ба Гэрээ 68:25–28 зэргээс өөр нэмэлт хариуцлагуудыг хайж олоход урь. Эдгээр шүлэгт өгүүлснээр үүрэг хариуцлагуудаа биелүүлэхийн тулд эцэг эхчүүдэд ямар боломжууд байдаг вэ? Өсвөр үеийнхэн тэдэнд туслахын тулд юу хийж болох вэ?

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь өсвөр үеийнхэнд гэр орондоо сайн мэдээнээс суралцах ба заахад бэлтгэж, боломжуудыг хайхад туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго.

Сайн мэдээг судлах ур чадварууд

Судар судлах чадвар нь ихэнх хүнд төгөлдөр хуур тоглож, зураг зурдаг шиг аяндаа бий болдоггүй. Судруудыг үр дүнтэй судлахад суралцах нь ихэвчлэн ур чадваруудаа хөгжүүлэхийг шаарддаг. Энэхүү тоймд тусгагдсан сайн мэдээнээс суралцах ур чадварууд өсвөр үеийнхнийг сайн мэдээн ний хичээнгүй суралцагчид болоход тусална. Эдгээр ур чадварыг өсвөр үеийнхэнд онцгойлон зааж, тэд сайн мэдээнээс суралцах үедээ эдгээрийг ашигладаг байхад урамшуулан дэмж.

- Ангийн гишүүдийг ахлагч М.Рассэлл Баллардын “Гэр бүлийн зөвлөл” хэлсэн үгийг уншаад, хүүхдүүдийн хувьд гэр бүлдээ хэрэгжүүлж болох зөвлөгөөг олж мэдэн, тэмдэглэж авахад урь. Өсвөр үеийнхнийг онцгой санагдсан зүйлээ хуваалцахад урь. Ахлагч Баллард техник технологитой холбоотой ямар зөвлөгөө өгсөн бэ? Өсвөр үеийнхэн гэр бүлийн зөвлөлд эцэг эх, ах, эгч, дүүтээ хэрхэн дэмжиж болох вэ? Та гэр бүлийн зөвлөл ямар байдгийг харуулахын тулд гэр бүлийн зөвлөлийн талаар жүжигчилэн тоглоход өсвөр үеийнхнийг урьж болно.

- Өсвөр үеийнхнээс ахлагч Квинтин Л.Күкийн “Эзэн бол миний гэрэл” хэлсэн үгээс “Гэрт хэдэн цаг болж байна” гарчигтай хэсгийг уншихыг хүс. Өсвөр үеийнхэн уг түүхэн дэх Ваун Кимбалл ба түүний гэр бүлийн жишээнээс юу сурч болох вэ? Өсвөр үеийнхэн эцэг эхээсээ юу сурсан бэ? Тэд гэр орондоо

суралцаж, заахад нь хэрхэн тусалж болох вэ?

- Өсвөр үеийнхнийг Тэд Р.Каллистэр ахын эцэг эхээсээ сурсан сургамжийн тухай түүхийг уншихад урь (“Эцэг, эхчүүд:Хүүхдүүдийнхээ хамгийн чухал багш нар,” *Ensign* эсвэл 2014 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 36–38-ыг үзнэ үү). Өөрийнхөө түүхийг хуваалцаж, өсвөр үеийнхнийг эцэг эхээсээ суралцсан зүйлээ хуваалцахад урих талаар бодож үз. Яагаад эцэг эхчүүд “хүүхдүүдийнхээ хамгийн чухал багш” болдог вэ?

- “Тэнгэрийн удирдамжит хөтөлбөр” видео бичлэгийг үзүүлж, дэлхийн ямар аюулуудаас тэд хамгаалагдаж болох, мөн сайн мэдээнээс хамтдаа суралцдаг гэр бүл, хувь хүмүүст ямар хүч чадал ирдэг талаар хайж олохыг өсвөр үеийнхнээс хүс. Өсвөр үеийнхнийг *Итгэлдээ үнэнч байх нь* номон дахь “Гэр бүлийн үдэш” хэсгийг уншиж, өөрсдийн сонгосон сэдвээр гэр бүлийн үдшийн нэг хичээлийн

энгийн төлөвлөгөө бэлтгэхэд урь. Өсвөр үеийнхнийг бэлтгэсэн хичээлээ дараагийн хичээл дээр бие биедээ заахад урь.

- Ангиараа “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийн 7-р догол мөрийг унш. Өсвөр үеийнхнийг амжилттай гэр бүлүүдийн баримталдаг зарчмуудыг самбар дээр жагсаан бичихэд урь. Өсвөр үеийнхнээс гэр бүлээрээ хийх дуртай зугаатай үйл ажиллагааныхаа талаар хуваалцахыг хүс. Тэдгээр үйл ажиллагаанд оролцох үедээ сайн мэдээний ямар үнэнүүд эсвэл зарчмууд сурснаа хуваалцахад тэднийг урь. Жишээ нь, хамтдаа хоолоо бэлтгэх нь үйлчлэл ба хайрыг, хамтдаа спортоор хичээллэх нь тэвчээр ба шаргуу занг тэдэнд зааж болно. Өсвөр үеийнхнийг чөлөөт цагаараа гэр бүлтэйгээ хийх үйл ажиллагааг төлөвлөөд, эдгээр үйл ажиллагаа нь хэрхэн

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээ хуваалцахыг хүс. Гэртээ заах болон суралцахад хэрхэн бэлтгэж, боломжуудыг хэрхэн хайх талаар тэд ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Залбирах, судраас суралцах, гэр бүлийн үдэш хийх болон бусад чөлөөт үйл ажиллагаагаар дамжуулан гэр бүлтэйгээ сайн мэдээнээс суралцахад оролцсоноор ирдэг адислалуудаа хайж олоход ангийн гишүүдийг урь.

сайн мэдээтэй холбогддог талаар тэдэнтэй ярилцахад урамшуулан дэмж.

- Хүмүүс гэр бүлээрээ залбирах, судар судлах үедээ гэр бүлээ урамшуулан дэмжихэд ашиглаж болох санаануудыг өсвөр үеийнхнээр бодож олуул. Эдгээр үйл ажиллагаанаас гэр бүлүүдэд ирэх адислалудын талаар ярилц. Өсвөр үеийнхэн санаа авахаар *Итгэлдээ үнэнч байх нь* номны “Гэр бүлийн залбирал” болон “Өдөр бүр судраас судлахын ач холбогдол” хэсгүүдийг уншиж болно. Өсвөр үеийнхэн эцэг эхтэйгээ хэрхэн ярилцах, гэр бүлээрээ тогтмол залбирч мөн судраас судлахад тэднийг хэрхэн урамшуулан дэмжих талаар жүжигчилэн тогло. Өсвөр үеийнхнийг гэр бүлээрээ залбирах болон судраас судлах талаарх туршлагаасаа хуваалцахад урь.

Аврагчийн арга барилаар заах нь

Есүс Христ Өөрийн заасан хүмүүсийг итгэлээр үйлдэж, Түүний заасан үнэнүүдийн дагуу амьдрахад урьсан. Та хэрхэн өсвөр үеийнхнийг гэр бүлдээ одоо ба ирээдүйд сайн мэдээнээс суралцахад урамшуулан дэмжиж болох вэ?

Видео бичлэг: “Биднийг хөрвөлт рүү удирд”

Сонгосон материалууд

Тэд Р.Каллистер, “Эцэг эхчүүд: Хүүхдүүдийнхээ хамгийн чухал багш нар,” Ensign эсвэл 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 36-аас эш татав

Бэн Карсон “Би чинь бүх тавдугаар ангийнхан дотроо хамгийн муу сурагч байсан шүү дээ” гэж өөрийнхөө тухай хэлжээ. Нэг өдөр Бэнийг математикийн шалгалтад 30 бодлого бодоход ард нь сууж байсан сурагч алдааг нь засаж, шалгалтын ажлыг түүнд буцааж өгсөн гэнэ. Багш, хатагтай Виллиамсон сурагч бүрийг нэрээр нь дуудаж, авсан оноог нь хэлүүлж эхлэв. Эцэст нь Бэнийг ээлж болоход тэр ичсэндээ амандаа сулхан бувтнав. Хатагтай Виллиамсон түүнийг “9” гэж хэллээ гэж бодоод, 30 онооноос 9 оноо авсан нь Бэний хувьд том амжилт гэжээ. Тэгтэл Бэний ард сууж байсан сурагч “Ес биш ээ! . . . Тэр ганцыг ч . . . зөв бодоогүй” гэж хашгирав. Тэр үед би шалан доогуур ороод алга болчихмоор байсан хэмээн Бэн ярьж билээ.

Яг тэр үед Бэний ээж Соня өөрийн гэсэн асуудалтай тулгараад байв. Тэрээр өнөр бүлийн 24 хүүхдийн нэг байсан бөгөөд дөнгөж гуравдугаар ангийн боловсролтой, уншиж чаддаггүй байв. Тэр арван гуравтайдаа гэрлээд салсан бөгөөд хоёр хүүтэй, тэднийгээ Детройтын гэмт хэргийн үүр болсон ядуу дүүрэгт өсгөсөн ажээ. Гэсэн хэдий ч тэр эмэгтэй бие дааж амьдрах лут чадвартай байснаас гадна хэрэв тэд өөрсдөөсөө шалтгаалах бүхнийг хийх юм бол Бурхан түүнд болон хөвгүүдэд нь туслах болно гэдэгт бат итгэдэг байлаа.

Нэг л өдөр түүний болон хөвгүүдийнх нь амьдрал эрс өөрчлөгдсөн юм. Түүгээр гэр орноо цэвэрлүүлдэг, амжилттай яваа хүмүүс өөрсдийн гэсэн

номын сантай бөгөөд тэд ном их уншдаг болохыг тэр анзаарсан ажээ. Тэрээр ажлынхаа дараа гэртээ ирээд, Бэний дүүтэйгээ хамт үзэж байсан зурагтыг унтрааж, үндсэндээ дараах утгатай зүйлийг ярьсан байна. Хөвгүүд минь, та нар зурагт хэтэрхий их үзэж байна. Та хоёр одооноос эхлээд долоо хоногт гурван хөтөлбөр л үзэж болно. Чөлөөт цагаараа та хоёр номын санд очиж, долоо хоногт хоёр ном уншаад надад мэдэгдэж бай.

Хөвгүүд мэл гайхаж орхив. Сургуульд л ном уншихыг шаарддаг байсныг эс тооцвол би амьдралдаа ганц ч ном уншаагүй гэж Бэн хэлэв. Хөвгүүд эсэргүүцэж, дургүйцэн гомдоллож маргасан ч огт нэмэр болсонгүй. Тэгэхэд Бэн “Ээж биднээс юу хүсэж байгаагаа маш тодорхой хэллээ. Энэ дүрэм надад таалагдаагүй, гэвч ээж биднийг сайн хүмүүс болгохоор шийдсэн нь миний амьдралын зам мөрийг өөрчиллөө” гэж боджээ.

Тийнхүү энэ нь Бэний амьдралд үнэхээр агуу өөрчлөлт авчирсан аж. Тэр долоодугаар ангид орохдоо сурлагаараа ангидаа толгой цохидог болов. Тэр Иелийн Их Сургуульд тэтгэлгээр сурч, дараа нь Жонс Хопкинсийн анагаах ухааны сургуулийг төгсөж, 33-тайдаа уг сургуулийн Хүүхдийн мэдрэлийн мэс заслын тэнхимийн эрхлэгч, дэлхийд нэрд гарсан мэс засалч болсон юм. Тэр ийм амжилтад хэрхэн хүрсэн юм бол? Энэ нь амьдралдаа олон сайн сайхан зүйлээр дутагдсан сайхь эмэгтэй эх хүний дуудлагаа эрхэмлэн биелүүлснээс ихээхэн шалтгаалсан [Бэн Карсон, *Gifted Hands: The Ben Carson Story* (1990)-ийг үзнэ үү].

БҮЛГИЙН ТОВЧ ТОЙМ

Есдүгээр сар: Зарлигууд

*“Бурханы зарлигуудыг дагадаг тэдний адислагдсан мөн баярт байдлыг тунгаагаасай”
(Мозая 2:41).*

Энэ бүлгийн тоймууд нь Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудад дуулгавартай байх нь тэдний амьдралын баяр баясгалан болон ирэх дэлхийн мөнхийн амьдралын зүг хөгжин дэвшихэд хэрхэн нөлөөлдгийг ойлгоход өсвөр үеийнхэнд тусална. Энэхүү бүлгээр өсвөр үеийнхэн зарлигуудыг ойлгож мөн сахихад нь бусдыг хэрхэн дэмжиж болох талаар суралцах болно.

Энэ сард сонгох тоймууд:

Тэнгэрлэг Эцэгтэй илүү адил болохыг сурахад маань зарлигууд надад хэрхэн тусалдаг вэ?

Жишгүүдийг маань ойлгоход нь би бусдад хэрхэн туслах вэ?

Зарлигуудыг сахих нь сайн мэдээг сурах чадварт маань хэрхэн нөлөөлдөг вэ?

Би зарлигуудыг дагахад нь бусдыг хэрхэн дэмжиж чадах вэ?

Хэрвээ би зарлигуудыг дагавал Тэнгэрлэг Эцэг ямар адислалуудыг өгнө хэмээн амладаг вэ?



ЕСДҮГЭЭР САР: ЗАРЛИГУУД

Тэнгэрлэг Эцэгтэй илүү адил болохыг сурахад маань зарлигууд надад хэрхэн тусалдаг вэ?

Зарлигууд нь Тэнгэрлэг Эцэгтэй илүү адилхан болоход маань туслахын тулд биднийг хайрлах Түүнээс бидэнд өгөгдсөн зааварчилгаа юм. Зарлигуудаар дамжуулан Тэнгэрлэг Эцэг бидэнд Өөрийн хүслийг заадаг бөгөөд нэг нэгнээ хэрхэн хайрлаж мөн эгэл хүнээ хэрхэн ялан дийлэхийг бидэнд үзүүлдэг. Зарлигуудыг дуулгавартай дагах нь биднийг Бурханы дэргэд эргэж очин, мөнхийн амьдралыг хүртэхэд бэлтгэдэг. Бид үүнийг ойлгосноор зарлигуудыг ачаа дарамт гэж бодохгүй харин адислал хэмээн бодож эхэлдэг.

Амьдралын тань туршид зарлигуудын талаарх таны ойлголт хэрхэн өсч нэмэгдсэн бэ? Зарлигуудын дагуу амьдрахаар хичээх үед өөртөө ямар өөрчлөлтүүд гарч байгааг та ажигласан бэ?

Өсвөр үеийнхэн зарлигуудыг дагахаар хичээх явцад тэдэнд ямар бэрхшээлүүд тулгарч байна вэ? Бурханы зарлигуудын зорилгуудыг ойлгосноор тэд хэрхэн адислагдах вэ? Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудын талаар суралцах явцдаа тэд Түүний талаар юу сурч чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар ба материалуудыг залбирч судал. Бурханы зарлигуудын зорилгуудыг ойлгоход нь өсвөр үеийнхэнд юу туслах вэ?

Дэд Хууль 10:12–13; С ба Г 82:8–10 (Их Эзэний бидний төлөөх хүслийг ойлгоход зарлигууд нь бидэнд тусалдаг)

Матай 22:34–40 (Бидэнд бусдыг хайрлахыг зарлигласан)

Иохан 14:15; 1 Иохан 5:1–3 (Бид Бурханд хайртай учраас зарлигуудыг дагадаг)

С ба Г 88:22 (Селестиел алдар сууг хүлээн авахын тулд бид селестиел хуулиар амьдрах ёстой)

С ба Г 93:20 (Хэрвээ бид зарлигуудыг дагах аваас бид яваандаа Бурханы бүрэн дүүрэн байдлыг хүлээн авах болно)

Дийтр Ф.Угдорф “Намайг бүү мартаарай,” *Ensign* эсвэл *Лиахона* 2011 оны 11-р сар, 120–23

Д.Тодд Кристоффэрсон, “Би хайрладаг хүмүүсээ зэмлэдэг, сахилгажуулдаг юм,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2011 оны 5-р сар, 97–100

“Дуулгавартай байдал,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 85–86

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд, эсвэл

найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Саяхан сурсан нэг зүйлтэй нь холбоотой сүмийн дууллыг олохыг өсвөр үеийнхнээс хүс (дууллын номын арын хуудсуудад байгаа “Сэдэв” хэсгийг ашиглахыг тэдэнд санал болгож болох юм). Уг дууллаас нэг мөрийг хуваалцаж мөн энэ нь сайн мэдээний зарчмыг ойлгоход нь тэдэнд хэрхэн тусалдаг талаар тайлбарлахыг тэднээс хүсээрэй.
- Эгц хавцлын дээгүүр, уулын бэлийн дагуух хажуугаараа хашлагатай зам дээр явж буйгаар төсөөлөхийг өсвөр үеийнхнээс хүс. Ангийнхаа өөр нэг гишүүнтэй дараах асуултуудын талаар ярилцахыг тэднээс хүс: Их Эзэний зарлигууд нь энэ хашлагатай юугаараа адилхан бэ? Тэдгээр нь энэ замтай юугаараа адилхан бэ? Санал бодлоо ангийнхантайгаа хуваалцахад тэднийг урь.

Сайн мэдээг судлах ур чадварууд

Шүлгүүдийн хэлхээ холбоо. Энэхүү хэсгийн эхний үйл ажиллагаагаар өсвөр үеийнхнийг судрууд дээрээ шүлгүүдийг хэлхэх буюу ижил төстэй зарчим зааж байгаа судрын шүлгүүдийн лавлахыг шүлгийн хажуу зайд бичихийг хүсэх болно. Сайн мэдээг судлах энэхүү ур чадвар нь судрын янз бүрийн захиасын хоорондох хэлхээ холбоог олж харахад тэдэнд тусална. Сайн мэдээний бусад сэдвүүдийн талаарх ойлголтоо гүнзгийрүүлэхийн тулд судраас хувиараа суралцах үедээ энэ хэлбэрээр суралцахыг өсвөр үеийнхэнд уриал.

Видео бичлэг: “Асуултуудыг ярилцах нь”

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр Тэнгэрлэг Эцэгтэй илүү адил болоход маань зарлигууд бидэнд хэрхэн тусалдгийг өсвөр үеийнхэн ойлгоход туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Самбар дээр бидэнд зарлигууд яагаад өгөгдсөнийг тайлбарлах хэд хэдэн судрыг бич (энэ тоймд дурдагдсан мөн та нарын мэддэг өөр судруудыг оруулж болно). Уг судруудыг ангиараа хамтдаа уншин, Тэнгэрлэг Эцэг биднийг зарлигуудаас юу сураасай хэмээн хүсч байдаг талаар ярилц. Өсвөр үеийнхнийг эдгээр шүлгийг судар дээрээ тэмдэглэн мөн хажуу талын зайнд нь уг шүлэг юу зааж байгааг дүгнэн бичихэд урь. Судрууд дахь шүлгүүдийг хэрхэн хэлхэж холбохыг өсвөр үеийнхэнд үзүүл (*Teaching, No Greater Call*, 58 үзнэ үү).
- Самбар дээр “Бурхан бидэнд яагаад зарлигуудыг өгсөн бэ?” гэж бич. Өсвөр үеийнхнийг Сургаал ба Гэрээ 82:8–10-ыг уншин самбар дээрх асуултанд тохирох хариултаудыг хуваалцахыг хүс. Өсвөр үеийнхнээс яагаад Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудын зорилгуудыг мэдэх нь чухал гэж бодож байгааг нь асуу. Энэхүү ярилцлагын нэг хэсэг болгож энэ тоймын эхэнд байгаа догол мөрийг хуваалц эсвэл ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын “Намайг бүү мартаарай” хэлсэн үгнээс “Дөрөвдүгээрт, сайн мэдээний “яагаад” гэдгийг битгий мартаарай” гэдэг догол мөрийг уншиж өг.
- Ангийнхаа нэг хэсгээс ахлагч Д.Тодд Кристоффэрсоны “Би хайрладаг хүмүүсээ зэмлэдэг, сахилгажуулдаг юм,” хэлсэн үгний эхний догол мөрийг, нөгөө хэсгээс нь хоёрдугаар догол мөрийг уншихыг

хүс. “Бурхан бидэнд яагаад зарлигуудыг өгсөн бэ?” гэсэн асуултын хариултыг уг догол мөрүүдээс хайж олохыг тэднээс хүс. Тэдний олж мэдсэн зүйлсийг ярилц. Бурханд байдаг шинж чанаруудыг жагсаан бичихийг өсвөр үеийнхнээс хүс. Тэгээд тэднээс уг шинж чанаруудыг өөрсөддөө хөгжүүлэх мөн Тэнгэрлэг Эцэгтэй илүү адил болоход туслах зарлигуудыг бодож олохыг хүс.

- Самбар дээр Арван зарлиг мөн (Египетээс гарсан нь 20:3–17-г үзнэ

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Зарлигуудыг сахих нь Тэнгэрлэг Эцэгтэй илүү адилхан болоход бидэнд хэрхэн тусалдаг болохыг тэд ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр нэмэлт асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан зүйлийнхээ тухай тунгаан бодохыг өсвөр үеийнхнээс хүс. Энэ нь Бурханы зарлигуудын талаар бодох тэдний бодолд хэрхэн нөлөөлсөн бэ? Зарлигуудыг дуулгавартай дагах тэдний хандлагад энэ нь хэрхэн нөлөөлж болох вэ? Энэ нь тэдний хийх сонголтуудад хэрхэн нөлөөлж болох вэ? Өөрсдийн бодол сэтгэгдлээ өдрийн тэмдэглэлдээ бичихэд тэднийг дэмж.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн шавь нараас зарлигуудыг сахихыг хүсэхдээ үнэн хайрын үүднээс тийн үйлдсэн. Та өсвөр үеийнхэнд зарлигуудыг сахих талаар хайраар хэрхэн зааж болох вэ?

Сонгосон материалууд

Д.Тодд Кристоффэрсон, “Би хайрладаг хүмүүсээ зэмлэдэг, сахилгажуулдаг юм” хэлсэн үгээс эш татав, Ensign эсвэл Лиахона, 2011 оны 5-р сар, 97–100

Тэнгэрлэг Эцэг Бурхан маань биднээс өндөр жишгийг хүсэн хүлээдэг. Биднээс хүсэн хүлээдэг зүйлсийг нь Түүний Хүү Есүс Христ дараах үгсээр илэрхийлсэн юм: “Би эсвээс тэнгэрт буй Эцэг тань төгсийн адил та нарыг төгс байгаасай хэмээнэ би” (3Нифай 12:48). Бид “Селестиел алдар сууг тэсэн гарч,” (С ба Г 88:22) “Түүний дэргэд амьдрахын тулд” (Моисе 6:57) биднийг ариун болгох нь Түүний зорилго юм. Үүнд юу шаардлагатайг Тэр мэддэг учраас, бидэнд өөрчлөгдөх боломжийг олгодог зарлиг, гэрээнүүд, Ариун Сүнсний бэлэг, хамгийн чухал нь Өөрийн Хайртай Хүүгийн цагаатгал ба амилалтыг бидэнд өгсөн билээ.

Энэ бүхний цаадах Бурханы зорилго бол Түүний хүүхдүүд бид төгс баяр баясгаланг олж Түүнтэй хамт үүрд амьдран, адилхан болох явдал мөн. Хэдэн жилийн өмнө Ахлагч Даллин Х. Өүкс ийн тайлбарлажээ: “Эцсийн шүүлт бол бидний хийсэн сайн ба муу үйлсийг дэнслэн үнэлэлт дүгнэлт өгөх төдий зүйл биш. Энэ бол бидний үйл хэрэг, санаа бодлын маань эцсийн үр дүн, биднийг ямар хүмүүс болгосныг үнэлж дүгнэх явдал мөн. Хүмүүс зүгээр л урсгалаараа явах нь хангалттай биш юм. Сайн мэдээний зарлиг, ёслол болон гэрээнүүд нь тэнгэр дэх хадгаламжинд хураагдаж байдаг зүйлсийн жагсаалт биш. Есүс Христийн сайн мэдээ бол Тэнгэрлэг Эцэгийн хүсэн хүлээдэг хүмүүс хэн болохыг бидэнд харуулдаг төлөвлөгөө билээ.” [Даллин Х. Өүкс, “The Challenge to Become,” *Лиахона*, 2011 оны 1-р сар, 40; *Ensign*, 2000 оны 11-р сар, 32.]

Сонгосон материалууд

Роберт Д.Хэйлс, “Хэрвээ чи амьтай байхыг хүсвэл тушаалуудыг сахь” хэлсэн үгээс эш татав, *Ensign*, 1996 оны 5-р сар, 35–37

Зарим хүмүүс “Их Эзэн бидэнд яагаад тушаалуудыг өгсөн юм бэ?” гэж асууж болох юм. Сүнсний дэлхийд болсон зөвлөлд, Тэрээр, Түүний сүнсэн хүүхдүүд бид мөнх бус амьдралынхаа туршид дагах ёстой тушаалуудыг хүлээн авах болно хэмээн тогтоосон. Иехова, Тэнгэрлэг Эцэгийн анхны сүнсэн хүүхэд, “Бид доошоо явцгаах болно. . . мөн дээр нь [Бурханы бусад сүнсэн хүүхдүүд] оршин сууж болох дэлхийг бид хийх болно;

“Мөн Их Эзэн, тэдний Бурхан тэдэнд зарлиглах бүх зүйл юуг ч гэсэн тэд хийх нь үү гэдгийг харахын тулд үүгээр бид тэднийг нотлох болно; (Абрахам 3:25). “Мөн өөрсдийн анхны байдлыг хадгалдаг тэдэн дээр нэмэгдэх болно” хэмээн хэлжээ (Абрахам 3:24–26).

Эдгээр тушаалууд нь зуурдын амьдралд бидний бие махбод болон сүнслэг сайн сайхан мөн баяр баясгалангийн төлөө Бурхан Эцэгээс маань бидэнд хайраар өгөгдсөн зааварчилгаа юм. Зарлигууд нь мөнхийн өсөлт хөгжлийн талаарх

Бурханы хүсэл, бодлыг мэдэх боломжийг бидэнд олгодог. Мөн тэдгээр нь Түүний хүсэлд дуулгавартай байх бидний бэлэн байдлыг сорьдог.

Зарлиг тушаалууд нь ачаа дарамт болох эсвэл биднийг хязгаарлахын тулд өгөгдөөгүй юм. Их Эзэний өгсөн зарлиг тушаал бүр нь бидний хөгжил, дэвшил, өсөлтийн тулд өгөгдсөн билээ. Бошиглогч Иосеф Смит “Бурхан бидний баяр баясгаланг төлөвлөсөн. . . Өөрийнх нь төлөвлөсөн тэр баяр баясгаланг авчрах зорилготой биш л бол Тэр Өөрийн хүмүүстээ зарлиг болон ёслолуудыг хэзээ ч өгөхгүй” хэмээн хэлсэн (“Бошиглогч Иосеф Смитийн сургаал” Жозеф Фийлдинг Смит [1976], 256).

Их Эзэний тушаалуудад би хичнээн их хайртай гээч! Тэдгээр нь биднийг удирдаж, хамгаалж мөн Тэнгэрлэг Эцэгийн дэргэд буцаж очих боломжийг олгодог. Хэрвээ бид зарлигуудыг итгэлтэйгээр дагах аваас, бидэнд мөнхийн амьдралын адислалууд амлагдсан юм. Мөнхийн амьдрал ба “Бурханы бэлгүүдээс хамгийн агуу” (С ба Г 14:7) нь, Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хүү Есүс Христтэй мөнхөөс мөнхөд амьдрахаар өргөмжлөгдөнө гэсэн үг юм. Тэр биднийг Өөр дээрээ буцаж ирэхийг ихэд хүсч байдаг.



Жишгүүдийг маань ойлгоход нь би бусдад хэрхэн туслах вэ?

Бидний жишгүүдийн талаар бусад хүмүүс биднээс байнга асуух болно. Бид эдгээр асуултад хариулан мөн Бурханы зарлигуудыг дуулгавартай дагаснаар ирэх адислалуудын талаар гэрчлэхэд бэлэн байж чадна. Ийм байдлаар бид дэлхийн гэрэл нь байж чадна.

Таны жишгийн талаар бусад хүмүүс ямар асуултууд асууж байсан бэ? Тэдгээр жишгүүдийн дагуу яагаад амьдардгийг ойлгоход нь та тэдэнд хэрхэн тусалсан бэ?

Бусдад өөрсдийн жишгийн талаар тайлбарлах ямар нөхцөл байдалтай өсвөр үеийнхэн тулгардаг вэ? Энэ нь тэдэнд заримдаа яагаад хэцүү байж болох вэ? Ийм нөхцөл байдалд бэлтгэхэд нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар ба материалуудыг залбирч судал. Сүмийн жишгүүдийн талаарх асуултуудад хэрхэн хариулахыг ойлгоход нь өсвөр үеийнхэнд юу туслах вэ?

Ром 1:16; 2 Тимот 1:7–8; 2 Нифай 8:7 (Есүс Христийн сайн мэдээнээс бүү ич)

1 Тимот 4:12 (Итгэгч хүмүүсийн жишээ бай)

3 Нифай 11:29 (Зөрчилдөөний сүнс нь чөтгөрийнх болой)

С ба Г 11:21; 84:85; 100:5–8 (Их Эзэн, юу хэлэхээ мэдэхэд маань бидэнд туслах болно)

Томас С.Монсон “Бэлтгэл нь адислалыг авчирдаг” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 5-р сар, 64–67

“Дуулгавартай байдал,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 85-86

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд, эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Сайн мэдээний талаар сурч байгаа зүйлийг нь бататгасан саяхны туршлагаасаа хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс.
- Их Эзэний жишгүүд ба зарлиг тушаалуудын талаар найзууд, гэр бүлийн гишүүдийнх нь асуусан

асуултуудыг жагсаан бичихийг өсвөр үеийнхнээс хүс. Тэд өөрсдийн жишгүүдийн талаар хэрхэн тайлбарлаж өгсөн бэ? Тэдэнд арай өөрөөр хийсэн бол гэж хүсч байгаа зүйл байна уу?

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаанууд нь өөрсдийн жишгийг бусдад хэрхэн тайлбарлах талаар сурахад нь өсвөр үеийнхэнд тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу: Өөрсдийн жишгийг нэг нэгэндээ тайлбарлах дадлага хийх цагийг өсвөр үеийнхэнд гаргаж өг.

- Ангидаа *New Era* эсвэл *Лиакхона* сэтгүүлийн хэд хэдэн хувийг авчир. Өөрсдийнхөө жишгийг хамгаалж бусдад тайлбарлах шаардлагатай болсон хүмүүсийн түүхийг эдгээр сэтгүүлээс хайж олохыг өсвөр үеийнхнээс хүс. Эдгээр түүхээс сурсан зүйлсээ хуваалцахыг тэднээс хүс. (Та хичээлийн өмнөх долоо хоногт өөрийнхөө заадаг өсвөр үеийнхэнд тохирох өгүүлүүдийг Сүмийн сэтгүүлийн хэдэн дугаараас хайн олж болно.) Өсвөр үеийнхний амьдралд нь тохиолдож байсан, хуваалцахаар ижил төстэй туршлага байна уу? Өөрсдийн жишгийн талаар бусдад тайлбарлаж өгөхөд нь туслах ямар зүйлсийг эдгээр түүхээс тэд сурч авсан бэ?
- Ерөнхийлөгч Томас С.Монсоны “Бэлтгэл нь адислалыг авчирдаг” хэлсэн үгний хуулбарыг өсвөр үеийнхэнд өгөөрэй. Уг хэлсэн үгийг хурдан гүйлгэж уншин, түүний тайлбарласан Сүмийн жишгүүдийг (зохистой хувцаслах, шударга байдал болон Мэргэн ухааны үг гэх мэт) хайж олохыг ангийн гишүүдээс хүс. Өсвөр үеийнхэн бүрийг эдгээр жишгийн нэгийг сонгоод ерөнхийлөгч Монсоны энэ талаар юу хэлснийг уншин, уг жишгийг ерөнхийлөгч Монсон хэрхэн тайлбарласныг мөн өөрсдийнх нь дагах жишгийг бусад хүмүүс илүү сайнаар ойлгоход тусалж болох

зүйлсийг ангийнхантайгаа хуваалцахыг тэднээс хүс.

- Энэхүү тоймд дурдагдсан судруудын нэгийг уншихыг ангийн гишүүн бүрээс хүс. Бид өөрсдийн жишгийн талаар бусдад тайлбарлах үед бидний хандлага ямар байх ёстойг харуулсан үгсийг хайж олохыг өсвөр үеийнхнээс хүс. Өсвөр үеийнхэн бүрт *Залуучуудын бат бөх байдлын төлөө ном* байгаа эсэхийг магадал. Энэ номоос аль нэгэн жишгийг нь сонгон уншаад, мөн уг жишигтэй зөрчилдөх ямар нэг зүйл хийхийг найз нь хүсвэл хэрхэн хариулах талаар төлөвлөгөө гаргахыг тэднээс хүс. Өсвөр үеийнхэн яагаад Их Эзэний жишгүүдийн дагуу амьдрах сонголт хийдгийг ойлгоход нь найзууддаа хэрхэн тусалж болох вэ?
- “Дуулгавартай байдал” бүлгийн 2-р догол мөрийг *Итгэлдээ үнэнч байх нь* номоос уншихыг өсвөр үеийнхнээс хүс (85–86-р хуудас). Зарлиг тушаалууд нь дэндүү хязгаарладаг юм байна гэж ярьдаг найздаа хариулахдаа энэхүү догол мөрд байгаа мэдээллийг тэд хэрхэн ашиглаж болох вэ? Бурханы зарлиг тушаалуудын зорилгуудыг ойлгоход нь найздаа туслахын тулд ямар судрууд, жишээ болон хувийн туршлагаасаа тэд хуваалцаж болох вэ?

Заахад туслах арга

“Таны гол санаа тавих зүйл бол бусдад сайн мэдээнээс суралцахад нь туслах юм. Харин сэтгэл хөдөлгөм танилцуулга хийх нь таны зорилго биш. Үүнд суралцагчдын бие биедээ заах боломжууд багтдаг” (*Teaching, No Greater Call* [1999], 64).

Видео бичлэг: “Ангийн гишүүний асуултад хариулах нь”

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн дагалдагчдыг, тэдний сонирхлыг, тэдний тэмүүлэл болон хүслийг мэддэг байсан. Өөрийн зааж байгаа өсвөр үеийнхнээ та хэрхэн мэдэж болох вэ? Энэ нь таны заах арга барилд хэрхэн нөлөөлөх вэ?

Нэгээс илүү иймэрхүү үйл ажиллагаанд оролцсоных нь дараа, тэдэнд жишгүүдээ тайлбарлах дадлага хийх цаг гаргаж өгөөрэй. Жишээлбэл тэдэнд тулгарч болох нөхцөл байдлыг жүжигчлэн үзүүлж эсвэл тэд өөрсдөө Их Эзэний жишгүүдийн дагуу яагаад амьдрахаар шийдсэнээ ойлгоход нь найздаа туслах аргуудаа бичиж болох юм.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлийнхээ тухай хуваалцахыг хүс. Өөрсдийнх нь жишгийг ойлгоход нь бусдад хэрхэн туслахаа тэд мэдэж байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү хугацаа зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өөрсдийн жишгийг бусдад тайлбарлах нөхцөл байдлын тухай бодохыг өсвөр үеийнхнээс хүс. Өнөөдрийн хичээлээс авсан туршлага нь үүнийг үр дүнтэй хийхэд нь тэдэнд хэрхэн туслах вэ?

Сонгосон материалууд

Томас С.Монсон, “Бэлтгэл нь адислалыг авчирдаг”
хэлсэн үгээс эш татав, Ensign эсвэл Лиахона, 2010
оны 5-р сар, 64–67

Номлолд бэлддэгийн адил ариун сүмийн гэрлэлтэд бэлтгэж эхэл. Зөв зохистой болзоо энэхүү бэлтгэлийн нэг хэсэг юм. Болзоонд явахыг хүлээн зөвшөөрдөг ёс заншилтай оронд амьдардаг бол 16 нас хүртлээ болзоонд бүү яв. “Арван хэдэн настай хүүхдүүд бүгдээрээ болзоонд явах шаардлагатай биш, зарим нь үүнийг хүсэх ч үгүй биз. . . . Болзоонд явж эхлэхдээ хэсэг бүлгээрээ эсвэл өөр болзоонд яв. . . . Болзож буй хүмүүсээ эцэг эхтэйгээ заавал уулзуулж, [танилцуулж] бай.” Болзоонд явах нь гэрлэлтийн бэлтгэл учраас “зөвхөн өндөр жишигтэй хүмүүстэй болз.” [Залуучуудын бат бөх байдлын төлөө (товхимол, 2001), 24, 25.]

Уруу таталттай тулгарахгүй байх сайн орчин бүрдсэн газар оч.

Нэгэн ухаалаг эцэг хүүдээ хандан, “Хэрэв чи байх ёсгүй газар очсон гэдгээ мэдвэл шууд гараад яв!” гэж хэлжээ. Энэ бол бид бүгдэд сайн зөвлөгөө болох юм.

Их Эзэний үйлчлэгчид, бидэнд Тэнгэрлэг Эцэгээ болон өөрсдийгөө хүндэлдэг болохоо харуулахын тулд зөв зохистой хувцаслах хэрэгтэй гэж байнга зөвлөсөөр ирсэн. Таны хувцасласан байдал таны хэн бэ гэдгийг бусдад хэлж өгдөг бөгөөд та нарын болон бусад хүмүүсийн үйлдэлд нөлөө үзүүлдэг. Өөртөө болон таны эргэн тойронд байгаа хүмүүст хамгийн сайхан сэтгэгдэл төрүүлэхүйц байдлаар хувцасла. Биедээ шивээс хийж, биеэ цоолж, хэтэрхий чамин ганган хувцаслахаас зайлсхий.

Хүн бүрд сайн найз хэрэгтэй. Найз нөхөд тань та нарын бодол санаа, зан төлөвт их нөлөө үзүүлдэг. Мөн үүний адил чи ч бас тэдэнд нөлөөлдөг. Та нар эрхэмлэдэг зүйлсээ найз нартайгаа хуваалцах үед та нар бие биеэ хүчирхэгжүүлэн, дэмжиж чадна. Хүн бүртэй нинжин сэтгэл, хүндэтгэлээр харилцаж бай. Найзууд нь сүмийн үйл ажиллагаануудад урьснаар олон гишүүн бус хүмүүс сүмд ирсэн байдаг. . . .

Таны хэл яриа болон ярьдаг үгс тань таны зан төлөвийн талаар ихийг илэрхийлдэг. Эргэн тойрон дахь хүмүүсээ сэтгэл санаагаар дэмжиж, туслах үг хэллэгийг хэрэглэ. Гутаан доромжилсон, бүдүүлэг үг хэллэг, балмад хэл яриа, зохисгүй хошин үг хэл нь Их Эзэнийг гомдоодог. Бурхан болон Есүс Христийн нэрийг буруугаар бүү хэрэглэ. “Чи өөрийн Бурхан Эзэний нэрийг дэмий бүү дурд” хэмээн Их Эзэн хэлсэн байдаг. [Египетээс гарсан нь 20:7.]

Тэнгэрлэг Эцэг маань биднийг “ариун журамтай, сайхан эсвээс сайн гэгддэг буюу сайшаалтай” зүйлсийг эрэлхийлэхийг зөвлөсөн билээ. [Итгэлийн Тунхаг 1:13] Уншиж, сонсож, үзэж байгаа бүхэн чинь чамд нөлөөлөх болно.

Ялангуяа порнограф бүр ч аюултай, донтуулдаг зүйл юм. Порнографыг шохоорхон сонирхох нь хүчтэй зуршил болж, улмаар бүр илүү бузар зүйл болон бэлгийн харьцааны нүгэлд хөтөлдөг юм. Порнографас бүх хүч чадлаараа зайлсхий.

Тэнгэрлэг Эцэгийн жишигт нийцэхгүй зүйл гарч байгаа үед киног орхин гарах, телевизээ унтраах, эсвэл сувгаа солих зориг зүрхтэй бай. Товчоор хэлэхэд, хэрэв та нар тухайн кино, ном сэтгүүл, үзвэр үйлчилгээг зохистой эсэхэд эргэлзэж байгаа бол бүү үз, бүү унш, бүү оролц. . . .

Сонгосон материалууд

Хүчтэй үйлчилдэг мансууруулах бодис, жороор олгодог эмийг буруугаар ашиглах, согтууруулах ундаа, кофе, цай, тамхи зэрэг бүтээгдэхүүнийг хэрэглэх нь та нарын бие бялдар, оюун санаа, сүнсний сайн сайхныг сүйтгэх болно. Ямар ч төрлийн согтууруулах ундаа байлаа гэсэн та нарын сүнс болон биед хортой. Тамхи та нарыг боолчилж, уушгийг чинь муудуулж, амьдралыг чинь богиносгодог.

Дуу хөгжим биднийг Тэнгэрлэг Эцэгт ойртуулж чадна. Дуу хөгжмийг сурч боловсрохдоо, гэгээрэхдээ, сүнслэгээр нөлөөлөхдөө, эв нэгдэлтэй байхад ашиглаж болно. Гэхдээ энэ нь хурд, хэмнэл, эрч хүч болон үгнээсээ болоод бидний сүнслэг мэдрэмжийг бууруулдаг. Та нар оюун санаагаа зохисгүй дуу хөгжмөөр дүүргэж болохгүй.



Зарлигуудыг сахих нь сайн мэдээг сурах чадварт маань хэрхэн нөлөөлдөг вэ?

Сайн мэдээнээс суралцах нь Ариун Сүнсний удирдамжийг шаарддаг. Ариун Сүнс бидний ойлголтыг гэгээрүүлж мөн сайн мэдээний үнэнүүдийг гэрчилдэг. Түүний нөлөөг хүлээн авах зохистой байхын тулд бид зарлигуудад дуулгавартай байх ёстой. Бид сурсан зарчмаа дуулгавартай дагаснаар өөрсдийгөө Их Эзэнээс илүү их үнэнийг хүлээн авахад бэлтгэдэг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар ба материалуудыг залбирч судал. Зарлигуудыг сахих нь тэдний сайн мэдээнээс сурах чадварт хэрхэн нөлөөлдгийг ойлгоход нь өсвөр үеийнхэнд юу туслах вэ?

Даниел 1 (Даниел болон түүний хамтрагчид дуулгавартай байдлынхаа төлөө мэргэн ухаан болон ойлголтоор адислагдсан); мөн түүнчлэн “Бурхан тэдэнд мэдлэгийг өгсөн” видео бичлэгийг үз.

Иохан 7:17 (Хэрвээ бид Бурханы хүслийн дагуу үйлдэх аваас бид сургаалын талаар мэдэх болно)

2 Нифай 28:30; С ба Г 42:61; 50:24 (Хэрвээ бид Их Эзэнийг сонсох аваас бид илүү их гэрэл болон мэдлэгийг хүлээн авах болно)

С ба Г 76:5–10 (Их Эзэн Өөрт нь үйлчилдэг тэднийг хүндэтгэдэг)

Томас С.Монсон “Дуулгавартай байдал адислалыг авчирдаг” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 5-р сар, 64–67

Хэнри Б.Айринг “Амьд гэрчлэл” *Ensign* эсвэл *Лиахона*, 2011 оны 5-р сар, 125–28

Ричард Г.Скотт “Хувийн амьдралдаа илчлэлт, сүнсний удирдамжийг хэрхэн авах вэ?” *Ensign* эсвэл *Лиахона*, 2012 оны 5-р сар, 45–47

Зарлигуудыг сахих нь сайн мэдээнээс суралцагчийн хувьд танд хэрхэн тусалсан бэ? Ангийнхаа өсвөр үеийнхэнтэй хуваалцаж болох дуулгавартай байдлын талаарх ямар туршлага танд байгаа вэ?

Дуулгавартай байдал болон Сүнсний удирдамж хоёрын хоорондох холбоог таньж мэдэхэд нь та өсвөр үеийнхэнд хэрхэн тусалж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд, эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь та тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Бусад хичээлүүд дээрээ сурч байгаа зүйлсийнх нь талаар тэдэнд асуулт, санаа бодол байгаа эсэхийг нь асуу. Сурч мэдсэнийхээ үр дүнд олж авсан сэтгэгдэл, туршлагаасаа хуваалцахыг тэднээс хүс.

- Самбар дээр “Дуулгавартай байх нь сайн мэдээнээс суралцах чадварт

минь хэрхэн нөлөөлдөг вэ?” гэж бичээрэй. Энэ асуултын талаар тунгаан бодох цөөн хэдэн хормыг өсвөр үеийнхэнд өгөөд, дараа нь саналаа хуваалцахыг тэднээс хүс. Хичээлийн туршид энэ асуултын талаар тунгаан бодоход нь тэднийг дэмж.

Сайн мэдээг судлах ур чадварууд

Хичээлийн дүгнэлт. Энэхүү хэсгийн эхний үйл ажиллагаагаар өөрсдийн уншсан судрын түүхээ дүгнэн бичихийг өсвөр үеийнхнээс хүсэх болно. Өсвөр үеийнхнийг хувиараа судраас суралцах үедээ мөн тийн үйлдэж байхад дэмж. Тэд өөрсдийн сэтгэгдэл, заагдсан сургаал, тохиолдсон үйл явдал болон оролцсон хүмүүсийн талаар өдрийн тэмдэглэлдээ бичиж болно. Тэд өөрсдөөсөө “Их Эзэн юу харуулахыг хичээж байна вэ? Мөн яагаад? Эдгээр шүлгүүдэд надад хамаатай зүйл байна уу?” гэсэн асуултыг асууж болно.

Видео бичлэг: “Үзүүлэх материал ашиглах нь”

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр зарлигуудад дуулгавартай байх нь тэдний сайн мэдээнээс суралцах чадварт хэрхэн нөлөөлдөг болохыг өсвөр үеийнхнийг ойлгоход тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Ангийн гишүүдэд ерөнхийлөгч Томас С.Монсоны “Дуулгавартай байдал адислалуудыг авчирдаг” хэлсэн үгийн эхний 11 догол мөрийн хуулбарыг өгөөд энд өгүүлсэн зүйлийг цөөн хэдэн өгүүлбэрт дүгнэхэд тэднийг урь. Ангийн гишүүд бичсэн дүгнэлтээ нэг нэгэнтэйгээ хуваалцах үед та тэднийг яагаад энэ захиас чухал гэж тэд бодож байгаа тухай хуваалцахад нь тэднийг дэмж.

- Ангиараа Даниел 1-ийг уншиж эсвэл “Бурхан тэдэнд мэдлэгийг өгсөн” видео бичлэгийг үз. Даниел болон түүний найзууд дуулгавартай байдлаа хэрхэн харуулсан бэ? Тэд хэрхэн адислагдсан бэ? Даниелийнхтай ойролцоо ямар нөхцөл байдлууд өсвөр үеийнхэнд тулгардаг вэ? Мөн өөрсдийн дуулгавартай байдлын улмаас мэдлэг болон ойлголтоор адислагдсан өөр хүмүүсийн талаар судраас олж уншихыг өсвөр үеийнхнээс хүс (1 Нифай 4–т гардаг Нифай эсвэл Иосеф Смит —Түүх 1:11–17 дээрээс Иосеф Смитийн тухай гэх мэт). Өөрсдийн уншсан зүйлийн талаар

товч дүгнэлт бичээд, ангийнхандаа түүний сонгосон хүн дуулгавартай байдлынхаа улмаас мэдлэгээр хэрхэн адислагдсан болохыг зааж өгөхийг тэднээс хүс.

- Өсвөр үеийнхнийг дараах судрын шүлгүүдээс нэгийг нь сонгохыг хүс: Иохан 7:17; 2 Нифай 28:30; С ба Г 50:24. Сонгосон шүлгээ уншаад, энэ нь дуулгавартай байдал болон сайн мэдээнээс суралцах талаар юу зааж байгааг тунгаан бодохыг өсвөр үеийнхнээс хүс. Тэгээд ангийнхнаасаа өөр шүлэг сонгосон хэн нэгнийг олоод, бие биетэйгээ суралцсан зүйлсээ хуваалцахад урь.

- Өсвөр үеийнхэнд нэг эвдэрхий гар чийдэн өгөөд, асахгүй байгаагийн шалтгааныг олж мэдэхийн тулд шалгахыг тэднээс хүс. Ахлагч Ричард Г.Скоттын “Хувийн амьдралдаа илэрхийлэл болон удирдамжийг хэрхэн хүлээн авах вэ?” хэлсэн үгнээс дараах хэсгийг хуваалц: “Их Эзэнээс сүнслэг өдөөлтийг авч болохын тулд хувь хүн өөрийн оюун санаа, бие махбодоо цэвэр ариун

байлгаж мөн зорилгодоо цэвэр ариун байх ёстой. Их Эзэний зарлигуудыг дуулгавартай сахидаг хүн Түүний итгэлийг хүлээн авдаг. Тийм хүн Түүний сүнслэг өдөөлтөөр юу хийх ёстойгоо мэдэж авах бөгөөд мөн түүнийгээ хийх тэнгэрлэг хүч чадлыг хэрэгтэй үедээ хүлээн авдаг. Бидний дуулгавартай байдал нь сүнслэгээр өгөгдсөн зорилгоо биелүүлэхэд шаардагдах тэнгэрлэг хүч чадлыг хүлээн авах эрхийг бидэнд олгодог (47-р хуудас). Ахлагч Скоттын энэхүү мэдэгдэлд зааж байгаа зарчмыг, эвдэрхий гар чийдэн хэрхэн харуулж байна вэ? “Их Эзэний итгэлийг хүлээн авч” мөн Түүнээс илэрхийллийг хүлээн авахын тулд тэд юу хийх ёстойг тунгаан бодохыг

өсвөр үеийнхнээс хүс. Тэдний цөөн хэдээс нь бодол сэтгэгдлээ хуваалцахыг хүс.

- Өсвөр үеийнхнээс ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн “Амьд гэрчлэл” хэлсэн үгнээс “Иймээс итгэлийн үр та нарын зүрх сэтгэлд аль хэдийн суулагдсан...” гэдэг өгүүлбэрээр эхэлсэн догол мөрөөс “Мөнх амьдралын тухай Их Эзэний амлалт үнэн бодитойг” гэдгээр эхэлсэн догол мөрийг хүртэлх хэсгийг уншихыг хүс. Ерөнхийлөгч Айрингийн дуулгавартай байдал түүний гэрчлэлийг хэрхэн хүчирхэгжүүлсэн бэ? Ерөнхийлөгч Айрингийн жишээний дагуу ямар зүйлсийг өсвөр үеийнхэн хийж болох вэ?

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нартаа ойлгуулахын тулд энгийн түүх, сургаалт зүйрлэлүүд болон амьдралд тохиолддог жишээнүүдээс хуваалцдаг байсан. Зарлигуудад дуулгавартай байх нь тэдний сайн мэдээний ойлголтыг баяжуулахад туслах болно гэдгийг өсвөр үеийнхэнд харуулахын тулд судрууд, Сүмийн түүх эсвэл амьдралаасаа ямар түүхийг та хуваалцаж болох вэ?

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлийнхээ тухай хуваалцахыг хүс. Зарлигуудыг сахих нь сайн мэдээнээс сурах чадварт нь хэрхэн нөлөөлдөг болохыг тэд ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Зарлигуудыг сахих болон сайн мэдээнээс суралцах хоёрын хоорондох уялдаа холбооны талаар тэд өнөөдөр юу сурснаа дүгнэн хэлэхийг өсвөр үеийнхний цөөн хэдээс хүс. Ариун Сүнсээр заагдах чадвараа нэмэгдүүлэхийн тулд тэд юу хийх мөн юу хийхээ болих хэрэгтэй талаар бодохыг тэднээс хүс. Өөрсдийн бодол сэтгэгдлээ өдрийн тэмдэглэл дээрээ бичихэд тэднийг дэмж.

Сонгосон материалууд

Хэнри Б.Айринг, “Амьд гэрчлэл” хэлсэн үгнээс эш татав, Ensign эсвэл Лиахона, 2011 оны 5-р сар, 125–128-р хуудас

Иймээс итгэлийн үр та нарын зүрх сэтгэлд аль хэдийнэ суулгагдсан. Мөн Алмад амлагдсан итгэлийн өсөлтийг та нар зүрх сэтгэлээрээ мэдэрсэн биз ээ. Би үүнийг мэдэрсэн.

Гэвч итгэл чинь ургаж байгаа ургамал шиг гэжээгдэж байх ёстой, эс бөгөөс хатаж хорчийх болно. Итгэлээр өдөөгдсөн чин сэтгэлийн тогтмол залбирал бол шийдвэрлэх ач холбогдолтой амин чухал гэжээл мөн. Хүлээн авсан үнэндээ дуулгавартай байх нь гэрчлэлийг амьд байлгаж, улам бат бөх болгоно. Зарлигуудад дуулгавартай байх нь гэрчлэлийг тань өсгөн хөгжүүлж гэжээн тордох нэг чухал хэсэг мөн.

Аврагчийн дараах амлалтыг та нар санаж байгаа: “Хэрэв хэн нэгэн нь Түүний хүслийг үйлдэхийг хүсэж байвал, тэр нь энэ сургаал Бурханаас ирсэн үү, эсвэл Би өөрөөсөө ярьж байна уу гэдгийг мэднэ.” [Иохан 7:17.]

Энэ нь надад тохиолдсон бас та нарт ч тохиолдох болно. Миний багадаа заалгасан сайн мэдээний сургаалуудын нэг нь Бурханы бэлгүүдээс хамгийн агуу нь мөнх амьдрал гэсэн сургаал байлаа. [Сургаал ба Гэрээ 14:7-г үз.] Мөнх амьдралын нэг хэсэг нь гэр бүлүүд хайраар хамтдаа мөнхөд амьдрах явдал мөн гэдгийг би мэдсэн юм.

Эдгээр үнэнүүдийг би анх сонссон цагаас хойш эдгээр нь зүрх сэтгэлд минь гүн шингэж, сонголт бүрдээ гэр бүл дотроо зөрчил сөргөлдөөнөөс зайлсхийж, амар амгаланг тогтоохын төлөө үүрэг хүлээх ёстойг мэдэрдэг болсон билээ.

Бүх адислалуудаас хамгийн агуу нь болох мөнх амьдралыг би зөвхөн энэ амьдралын дараа олж

авч чадна. Гэвч энэ амьдралын сорилт бэрхшээлүүд дунд тэнгэр дэх гэр бүлээ ямархуу болохыг төсөөлөн харах боломж надад олдсон юм. Ариун сүмд хийгддэг лацдан холбох хүчний үнэн бодит байдлын талаарх миний гэрчлэл улам өсч, хүчирхэгжсээр байна.

Хоёр охиноо ариун сүмд өвөг дээдсийнхээ өмнөөс баптисм хүртэхийг хараад миний зүрх сэтгэл охиддоо мөн нэрс нь олдсон өвөг дээдэстэйгээ улам ойртон дотноссон юм. Гэр бүлийн гишүүдийн зүрх сэтгэл бие бие рүүгээ эргэх тухай Елиагийн амлалт бидэнд өгөгдсөн юм. [Малахи 4:5–6; Иосеф Смит—Түүх 1:38–39-г үз.] Тиймээс Алмагийн номонд бидэнд амласанчлан, итгэл нь миний хувьд тодорхой мэдлэг болсон юм.

Аврагч мөнх бус үйлчлэлийнхээ дараа сүнсний дэлхийд ирэх үед өвөг дээдсийнхээ мэдэрсэн тэрхүү баяр хөөрийг би бага зэрэг ч гэсэн мэдэрсэн юм. Уг үйл явдлыг Сургаал ба Гэрээнд ийн дүрсэлжээ:

“Мөн гэгээнтнүүд гэтэлгэлдээ баясан, мөн Бурханы Хүүг өөрсдийнхөө Гэтэлгэгч, мөн үхлээс хийгээд тамын гинжнээс Чөлөөлөгч хэмээн өвдөг сөгдөж мөн хүлээн зөвшөөрч байлаа.

“Тэдний төрх байдал гялалзан, мөн Их Эзэний оршихуйн хурц тод нь тэдэн дээр байлаа, мөн тэд түүний ариун нэрэнд магтуу дуулж байв.” [Сургаал ба Гэрээ 138:23–24.]

Мөнх амьдралын талаарх Их Эзэний амлалт үнэн бодитойг мэддэг гэрчлэлийнхээ дагуу үйлдсэнээр өвөг дээдсийнхээ баяр хөөрийг би мэдэрсэн юм. Энэ нь биелэх болно хэмээн Аврагч амлахад, үүний дагуу үйлдэхийг сонгосноор миний гэрчлэл хүчирхэгжсэн.



Би зарлигуудыг дагахад нь бусдыг хэрхэн дэмжиж чадах вэ?

Хожмын үеийн гэгээнтэн мөн сайн мэдээний багш нарын хувьд бид сайн мэдээний дагуу амьдрах жишээ болох ёстой. Бидний үлгэр жишээ зарлигуудыг дагахад бусдад сүнслэгээр нөлөөлж чадна. Аврагч Өөрийн дагалдагчдад, “Та нар бол дэлхийн гэрэл мөн” хэмээн хэлдэг (Матай 5:14). Сайн мэдээний дагуу амьдарснаар бидний мэдрэх амар амгалан болон баяр хөөр нь бидний үйл хөдлөл, үг яриа болон гэрчлэлийн хүчээр илэрдэг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалуудыг залбирч судлаарай. Тэдний жишээ болон гэрчлэл нь зарлигуудыг сахихад нь бусдыг дэмжих болно гэдгийг өсвөр үеийнхэнд ойлгуулахад юу туслах вэ?

Матай 5:14–16; 1 Тимот 4:12; Алма 17:11; 39:11 (Сайн үлгэр жишээ үзүүлэхийн ач холбогдол)

Алма 4:19 (Ариун гэрчлэлийн хүч)

Л. Том Пэрри “Төгс хайр айдсыг зайлуулдаг” *Ensign* эсвэл *Лиахона*, 2011 оны 11-р сар, 41–44

Анн М.Дибб “Босч зогс мөн гэрэлт” *Ensign* эсвэл *Лиахона*, 2012 оны 5-р сар, 117–19

“Заадаг зүйлийнхээ дагуу амьдар,” *Teaching, No Greater Call* (1999), 18–19

Зарлигуудыг дуулгавартай дагадаг бусдын жишээ танд хэрхэн нөлөөлж байсан бэ? Зарлигуудын дагуу амьдрах таны хичээл зүтгэл сайн мэдээний илүү үр нөлөөтэй багш болоход тань хэрхэн тусалсан бэ?

Бусдад үлгэр жишээ болох ямар боломжууд өсвөр үеийнхэнд байна вэ? Бусдыг зарлигуудыг дагахад дэмжих үедээ тэднийг эдгээр боломжоо ашиглахад нь туслахын тулд та юу хийж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд, эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь та нар тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

• Сүмийн хичээл болон цуглаанууд дээрээс тэд ямар зарлигуудын талаар олонтоо сонсож байгааг нь өсвөр үеийнхнээс асуу. Эдгээр

зарлигуудыг яагаад онцлон авч үзэж байна гэж тэд бодож байна вэ? Тэд юу сурч байна вэ? Тэдэнд ямар асуулт байна вэ?

- Зарлигуудыг дагахад нь дэмжихийг хүсч байгаа өөрсдийн мэдэх хэн нэгний талаар (нэрийг нь танилцуулахгүйгээр) бодохыг өсвөр үеийнхнээс хүс. Ангиараа хамтдаа хүмүүсийг сайн мэдээний дагуу

амьдрахад нь юу урамшуулдаг талаар ярилц. Өсвөр үеийнхний жишээ, туршлага болон гэрчлэлүүд нь тэдний хайртай хүмүүсийн зүрх сэтгэлийг хөндөхөд хэрхэн тусалж болох вэ?

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаанууд нь зарлигуудыг сахихад нь бусдыг хэрхэн дэмжиж болохыг ойлгоход өсвөр үеийнхэнд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Энэхүү тоймд байгаа үлгэр жишээний талаарх судруудаас өсвөр үеийнхэн бүрд хуваарилан өгч, өөр судрын шүлэг уншсан хэн нэгнийг олж, өөрсдийн сурсан зүйлсээ бие биетэйгээ хуваалцахыг тэднээс хүс. Өсвөр үеийнхэн оногдсон судар бүрийн талаар сонсож дуустал энэ үйл ажиллагааг үргэлжлүүл. Сайн мэдээг заахад үлгэр жишээ үзүүлэх нь яагаад чухал вэ? Албан болон албан бусаар тэдэнд байгаа заах боломжуудыг самбар дээр жагсаан бичихийг өсвөр үеийнхнээс хүс. Тэгээд *Teaching, No Greater Call* номын 19-р хуудсыг нээн, сайн мэдээнд дуулгавартай байхыг хичээдэг багш нарт ирдэг адислалуудын жагсаалтыг хамтдаа унш. Тэдний самбар дээр бичсэн заах боломжуудыг үр дүнтэй ашиглахад эдгээр адислал өсвөр үеийнхэнд хэрхэн туслах вэ?

- Ахлагч Л.Том Пэрригийн “Төгс хайр айдсыг зайлуулдаг” хэлсэн үгээс дараах хэсгийг хуваалц: “Бид Түүний жишээг дэлхийд үзүүлэхийн хэрээр бидний амьдрал сайн сайхан бөгөөд ариун журмын жишээ болох ёстой. Бидний хийдэг сайн үйлс нь Аврагч болон Түүний

сүмийн нэр хүндэд нөлөөлдөг. Сайн үйлс хийж, үнэнч шударга, нэр хүндтэй хүн байснаар та нарын амьдрал Христийн гэрлийг илтгэн харуулдаг.” Өсвөр үеийнхнээс хэн нэгний сайн үлгэр жишээ тэднийг сайн мэдээний дагуу амьдрахад нь урамшуулсан туршлагаудаа хуваалцахыг хүс эсвэл “Та нарын гэрэл тийнхүү гэрэлтэг” видео бичлэгийг үзүүл. Тэдний үлгэр жишээ бусдад ямар нөлөө үзүүлж байгааг тунгаан бодохыг тэднээс хүсээд, сайн үлгэр жишээ үзүүлснээрээ зарлигуудыг сахихад нь бусдыг урамшуулах хувийн зорилго тавихад нь тэднийг урамшуулан дэмж.

- Бурханы зарлигуудын нэгийг дагахад сонгосон үеийнхээ талаар хувийнхаа туршлагаас хуваалц. Хуваалцах үедээ *Teaching, No Greater Call* номын 180-р хуудас дахь “Хувийн туршлага” хэсгийн зааварчилгааг дага. Эдгээр зааварчилгааны талаар өсвөр үеийнхэнтэй ярилцаж, зарлигуудыг сахих талаар хувийн туршлагаасаа хуваалцах үедээ эдгээр зааварчилгааг дагахыг тэднээс хүс. Хувийн туршлага нь бусдад зарлигуудын талаар заах үр нөлөөтэй арга зам гэж яагаад бодож

Заахад туслах арга

“Суралцагчдын хэлэх зүйлсийг чин сэтгэлээсээ сонсож бай. Таны жишээ тэдэнд нэг нэгнийгээ сонсож сурахад туслах болно. Хэн нэгний хэлсэн зүйлийг та ойлгохгүй байвал “Би сайн ойлгосонгүй ээ. Дахиад тайлбарлаж өгөхгүй юу?” эсвэл “Хэлсэн зүйл дээрээ жишээ татаж болох уу?” гэх мэтээр асууж болно” (*Teaching, No Greater Call* [1999], 64).

байгаа талаар нь өсвөр үеийнхнээс асуу.

- Ангийнхнаас Алма 4:19 судрын утгыг дүгнэхийг хүс (тэдэнд тусламж хэрэгтэй бол 4-р бүлгийн оршлыг уншихыг санал болго). Өсвөр үеийнхнээс 19-р шүлгийг хамтдаа уншаад, “шударга гэрчлэлийг үзүүлэх” гэдэг нь ямар утгатай гэж бодож байгаа талаар мөн энэ нь сүмийн гишүүдийг зарлигуудыг дагахад нь хэрхэн урамшуулж болох талаар асуу. Өсвөр үеийнхэнд бусдын (эцэг эх, багш нар, удирдагчид эсвэл бусад өсвөр үеийнхэн гэх мэт) гэрчлэл нөлөөлж байсан уу? Судрууд дээр байдаг гэрчлэлийн жишээнүүдийн талаар бодохыг өсвөр үеийнхнээс хүс (жишээлбэл Матай 16:13–19; Мозая 3:17; Алма 5:45–48; 7:13; С ба Г 76:22–24). Тэдгээрийг хамтдаа уншаад, эдгээр гэрчлэлийг яагаад сүнслэгээр өдөөсөн гэж бодож байгаага

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлийнхээ тухай хуваалцахыг хүс. Зарлигуудыг сахихад нь бусдыг хэрхэн урамшуулан дэмжиж болохыг тэд ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Өсвөр үеийнхнийг үйлдэхэд урь

Өөрсдийн мэдэх хэн нэгнийг зарлигуудыг сахихад нь урамшуулан дэмжихийн тулд хийж чадах зүйлсийнхээ талаар бодоход өсвөр үеийнхнийг урь. Дараагийн хичээл дээр өөрсдийн туршлагаасаа хуваалцахыг тэднээс хүс.

хуваалцахад өсвөр үеийнхнийг урь. (Тэмдэглэл: Энэхүү үйл ажиллагаа нь өсвөр үеийнхэн бусдад сайн мэдээг заах үедээ гэрчлэлээ хэрхэн хуваалцахыг тэдэнд заах боломж юм. Энэ сэдвийн талаар илүү мэдээллийг *Teaching, No Greater Call*, номын “Гэрчлэлтэйгээр заах” гэсэн хэсгээс үзнэ үү 43–44.)

- “Үдэшлэгээс гарч яв” видео бичлэгийг үзүүл эсвэл өсвөр үеийнхнийг Анн М.Дибб эгчийн “Босч зогс мөн гэрэлт” (Самсон, Даниел, Жоанна эсвэл Карений түүх) хэлсэн үгэн дээрх түүхүүдээс нэгийг уншихад урь. Зарлигуудыг сахих эсвэл зөрчихөд бусдад нөлөөлдөг жишээн ний талаар сурсан зүйлсээ ярилцахыг тэднээс хүс. Өсвөр үеийнхэнд хэн нэгэнд дуулгавартай байхад нь нөлөөлсөн эсвэл хэн нэгэн тэдэнд дуулгавартай байхад нь нөлөөлсөн ямар туршлага байна вэ?

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч заадаг хүмүүсээ Өөрийнх нь заасан үнэний дагуу итгэлээр үйлдэж мөн амьдрахад урьдаг байсан. Сайн мэдээний дагуу амьдрах нь сайн мэдээг заах хүчирхэг арга зам гэдгийг өсвөр үеийнхнийг ойлгоход нь туслахын тулд та ямар боломжуудыг заахдаа ашиглаж болох вэ?

Сонгосон материалууд

Анн М.Дибб, “Босч зогс мөн гэрэлт” хэлсэн үгнээс эш татав, Ensign эсвэл Лиахона, 2012 оны 5-р сар, 117–119

Судрууд энэ тухай олон агуу жишээг дурдсан байдаг. Хуучин Гэрээний Шүүгчид номноос бид Самсоны тухай уншдаг. Самсон агуу их чадвартай төржээ. Учир нь тэнгэр элч ээжид нь “Тэрээр Израилыг, филистчүүдийн савраас аварч эхэлнэ” хэмээн амласан байв. [Шүүгчид 13:5] Гэвч Самсон өсч том болоод Бурханы удирдамжаас илүү дэлхийн уруу таталтуудад автагджээ. Зөв зүйлүүдийг сонгохоосоо илүүтэйгээр, “өөрт нь илүү таалагдсан” [Шүүгчид 14:3] сонголтуудыг тэрээр хийж эхэлжээ. Судрууд Самсоны аялал, үйл хэргүүд болон сонголтуудын талаар дурдахдаа “тэгээд тэр явав” [Шүүгчид 14:7] гэдэг үгсийг олонтоо хэрэглэжээ. Босч, урагш гэрэлтүүлэн, өөрийн агуу чадварыг ашиглахын оронд Самсон дэлхийн зүйлсэд автан Бурханы өгсөн хүчийг алдаж, залуугаараа харамсалтайгаар нас эцэслэсэн билээ.

Сударт байдаг Даниелийн түүх бол харин үүнээс огт өөр юм. Даниел Самсоны нэгэн адил, агуу их чадвартай төржээ. Даниелийн номын 6-р бүлгээс бид “Даниел ер бусын сүнсийг авсан тул сайд нар, аймгийн захирагчдаас тодорч байв” хэмээн уншдаг. [Даниел 6:3.] Даниел дэлхийн сорилтуудтай тулгарах үедээ дэлхийн дагадаг жишгийг дагалгүй, харин босч тэнгэр рүү харсан юм. Гучин хоног зөвхөн хаанд залбирах ёстой гэсэн хааныхаа тушаалыг дагалгүй Даниел “гэртээ ороод, (дээд давхрын өрөөндөө Иерусалимын зүг рүү харсан онгорхой цонхтой байлаа) урьд хийж байсан ёсоор өдөр бүр 3 удаа өвдөг сөгдөн Бурханыхаа өмнө залбиран, талархал өргөж байлаа.” [Даниел 6:10.]

Даниел айж эмээлгүйгээр, босч мөн урагш гэрэлтүүлж, Бурханы тушаалуудыг дагасан юм. Зөв

зүйлийн төлөө зогссоныхоо төлөө тэрээр арслангийн нүхэнд түгшүүртэй шөнийг өнгөрүүлсэн ч, дуулгавартай байдлынх нь төлөө Бурхан түүнийг хамгаалж, адисалсан билээ. Маргааш өглөө нь Дариус хаан Даниелийг арслангийн нүхнээс гаргаад, бүх хүмүүс Даниелийн Бурханаас айж, Даниелийн итгэлтэй байдлын жишээг дагах ёстой хэмээн тушаажээ. Үндэстнүүдийн жишиг гэж юу байх ёстойг болон дэлхийн уруу таталтанд автан жишгээ хэзээ ч бууруулахгүй байх жишээг Даниел бидэнд жинхэнэ утгаар нь харуулсан билээ.

Айж эмээлгүйгээр босч мөн урагш гэрэлтүүлэн, үе тэнгийнхэн дундаа жишгээ гэрэлтүүлэн яваа өнөөгийн өсвөр үеийнхний олон жишээнээс сонсохдоо би баяртай байдаг. Жоанна ахлах сургуульдаа сүмийн гурван гишүүний нэг нь мөн тойргийнхоо цорын ганц залуу эмэгтэй нь байсан билээ. Жоанна хэзээ ч бүдүүлэг муу үгс хэлэхгүй хэмээн өөртөө болон Их Эзэнд амласан байв. Нэг удаа тэрээр сургуулийнхаа нэг хүүтэй хамтран гэрийн даалгавар хийхээр болжээ. Мэдээж хэрэг, тэр хүү Жоаннагийн амласан шиг, бүдүүлэг үг хэлэхгүй гэж амлаагүй байв. Гэсэн ч Жоанна жишгээ баримталдаг байсан учраас түүнээс өөрийнх нь жишгийг хүндлэхийг хүсчээ. Жоанна энэ тухай уг хөвгүүнд олон удаа зөөлөн заримдаа хатуугаар сануулж байсан тул найз нь аяндаа арай боловсон үг хэрэглэдэг болсон байна. Найзынх нь өөрчлөгдсөнийг олон хүн анзаарсан бөгөөд хүүд нь сайн жишээ үзүүлсэнд нь, аав нь хүртэл Жоаннад талархжээ.

Саяхан Филиппин рүү ажлаар явахдаа би Карентэй танилцсан юм. Тэр зочид буудал, рестораны менежментээр бакалаврын зэргээ авахаар сурч байхдаа тохиолдсон нэгэн түүхийг надтай хуваалцсан юм. Багш нь бүх оюутнуудыг ресторанд

Сонгосон материалууд

үйлчилдэг янз бүрийн коктейлийг хэрхэн бэлтгэхийг сурч, энэ бүгдээс нь амсаж үзсэн байх хэрэгтэй хэмээн шаарджээ. Тэдгээр коктейлийн зарим нь спирт агуулж байсан тул үүнээс амсвал Их Эзэний зарлигийг зөрчинө гэдгийг Карен мэдэж байлаа. Ийм хэцүү байдалтай тулгарсан ч, Карен босч мөн урагш гэрэлтүүлэхээр зориглон тэдгээрээс уусангүй.



ЕСДҮГЭЭР САР: ЗАРЛИГУУД

Хэрвээ би зарлигуудыг дагавал Тэнгэрлэг Эцэг ямар адислалуудыг өгнө ХЭМЭЭН амладаг вэ?

Тэнгэрлэг Эцэгийн зарлиг бүр нь амлагдсан адислалыг дагуулдаг. Бид зарлигуудыг дуулгавартай дагаснаар аюулаас хамгаалагдан эрх чөлөө, хувийн хөгжил дэвшил, мөн бусад олон сүнслэг болон материаллаг адислал хүлээн авдаг. Эцэст нь бидний дуулгавартай байдал Тэнгэрлэг Эцэгийн дэргэдэх мөнх амьдрал руу хөтөлдөг. Эдгээр адислалыг таньж мэдэх нь биднийг болон бусдыг зарлигуудыг дагахад дэмжиж чадна.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Ямар судар болон хэлсэн үгс Бурханы дуулгавартай хүмүүст амласан адислалуудыг таньж мэдэхэд өсвөр үеийнхэнд туслах вэ?

Исаиа 58:6–11 (Мацаг барих хуулийг дагаснаар ирэх амлагдсан адислалууд)

Иеремиа 7:23–24; С ба Г 1:14–15; 58:29–33 (Дуулгаваргүй байдлын үр дагаврууд)

Малахи 3:10–12 (Аравны нэгийг төлснөөр ирэх амлагдсан адислалууд)

С ба Г 14:7; 82:10; 130:20–21 (Дуулгавартай байдлын адислалууд)

С ба Г 20:77, 79 (Ариун ёслолын залбирлууд)

С ба Г 59:9–20 (Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахиснаар ирэх амлагдсан адислалууд)

С ба Г 89:18–21 (Мэргэн ухааны үгсийг дагаснаар ирэх амлагдсан адислалууд)

Жэффри Р.Холланд, “Маргааш Эзэн та нарын дунд гайхамшигт зүйлсийг хийх болно,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 114–117

Вон Г.Кийч, “Бурханы зарлигуудыг сахидаг хүмүүс адислагдаж, аз жаргалтай байдаг,” *Ensign*, 2015 оны 11-р сар, 115–117 эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 110–112

Робэрт Д.Хэйлс, “Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь,” *Ensign* эсвэл *Liahona*, 2014 оны 5-р сар

“Дуулгавартай байдал,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 108–109

“Хүмүүст адислалуудыг амла,” *Миний Сайн Мэдээг Номло* (2004), 224

Сайн мэдээнд суралцагчийн мөн сайн мэдээний багшийн хувьд, амлагдсан адислалуудыг таньж мэдэх нь яагаад чухал вэ? Тэнгэрлэг Эцэгийн танд амласан адислалууд сайн мэдээний дагуу амьдрах хүсэлд тань ямар нөлөө үзүүлсэн бэ?

Өсвөр үеийнхэн бошиглогчдын болон судруудын үгсээс Бурханы амлалтыг ялган танихыг сурснаар хэрхэн адислагдах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутад өсвөр үеийнхний янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, Сүмийн бусад хичээл, эсвэл найзуудтайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний хамаарлыг олж харахад нь та нар өсвөр үеийнхэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Өнгөрсөн долоо хоногт зарлигуудыг дагахын ач холбогдлын талаар ойлгоход нь тусалсан туршлагаасаа хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс.
- Судрууд дахь зарлигууд ба амьд бошиглогчдын үгсийг, амлагдсан адислалууд эсвэл сэрэмжлүүлгүүд олонтоо дагалддаг болох; мөн өөрсдөө болон өөрсдийн заах тэдний төлөө тэдгээрийг ялгаж таних нь зарлигуудыг дагахад биднийг болон

бусдыг уриалах болно гэдгийг ойлгоход өсвөр үеийнхэнд туслаарай. “Тэргүүн Зөвлөлөөс залуучуудад өгсөн захиас” хэсгийг *Залуучуудын бат бөх байдлын төлөө* номоос уншсанаар уг амлагдсан адислалуудыг хэрхэн таньж мэдэхийг өсвөр үеийнхэнд харуул. Ямар нэгэн амлагдсан адислалыг сонсох бүрдээ гараа өргөхийг өсвөр үеийнхнээс хүс. Эдгээр амлалт нь өсвөр үеийнхэнд яагаад чухал вэ?

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаанууд нь өсвөр үеийнхэнд дуулгавартай байдлаас ирэх адислалуудыг таньж мэдэхэд тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Өсвөр үеийнхнийг “өөрийгөө тэнцэхгүй” байх гэж голж байгаа найзаа бодож олоход урь. Найз нь сайн мэдээний жишгүүдийг хэт өндөр мөн өөрийгөө хэзээ ч төгс төгөлдөрт хүрч чадахгүй гэж мэдэрч байж болно. Ахлагч Холланд “Маргааш Эзэн та нарын дунд гайхамшигт зүйлсийг хийх болно” хэлсэн үгэндээ найзтайгаа хуваалцаж болох ямар зөвлөгөөг өгсөн бэ? Ахлагч Холланд зарлигуудыг дагахын тулд бүх чадлаараа хичээж байгаа тэдэнд ямар ямар адислалыг амласан бэ? Ангийн гишүүдийг олж мэдсэн зүйлээ нэг нэгэнтэйгээ

хуваалцахад урь. Тэд мөн уг хэлсэн үгэн дэх зөвлөгөөг найзтайгаа хуваалцаж эсвэл олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дээр тавьж болно.

- Энэ тоймд санал болгосон видео бичлэгүүдээс нэгийг нь үзүүл. Өсвөр үеийнхнээс уг видео бичлэгээс дуулгавартай байснаар ирдэг адислалын тухай мэдэж сурсан зүйлээ нэг өгүүлбэрээр хэлэхийг хүс. Өсвөр үеийнхнийг өгүүлбэрээ ангийнхан-тайгаа хуваалцаад, видео бичлэг дээрх зарлигуудыг дуулгавартай дагахад урамшуулсан зүйлийг

Сайн мэдээг судлах чадварууд

Сэдэвчилсэн удирдамжийг ашиглах нь. Энэхүү бүлгийн эхний үйл ажиллагаагаар ямар нэг зарлигийн талаар судруудаас олохын тулд Сэдэвчилсэн удирдамжийг ашиглахад өсвөр үеийнхнийг урьдаг. Өсвөр үеийнхнийг хувиараа суралцах үед Сэдэвчилсэн удирдамжийг бие даан ашиглаж чаддаг болоход нь тэдэнд туслаарай. Цагаан толгойн үсгийн дарааллаар жагсаасан сэдэв дундаас хүссэн сэдвээ хайж, сэдэв болгоны дор байгаа холбогдох судруудыг хэрхэн олохыг тэдэнд үзүүл. Илүү бүрэн гүйцэд ойлголт авахын тулд холбогдох судруудыг олж, судлахад нь тэднийг урамшуул.

ярилцахад урь. Тэднийг видео бичлэгийг хуваалцаж болох хэн нэгний талаар бодоод, хуваалцах зорилго тавихад урь.

- Ангийн цөөн гишүүнээс биднийг аюулаас хамгаалдаг хаалт эсвэл хашлагыг самбар дээр зурахыг, харин үлдсэн гишүүнээс уг зураг юуг төлөөлж байгааг таахыг хүс. Эдгээр хаалт зарлигуудтай юугаараа адил вэ? Ангийн нэг гишүүнийг ахлагч Вон Г.Кийчийн “Бурханы зарлигуудыг сахидаг хүмүүс адислагдаж, аз жаргалтай байдаг” хэлсэн үгэн дэх хаалтын талаар өгүүлсэн түүхийг хуваалцахад бэлдэж ирэхийг хүс (эсвэл ахлагч Кийчийн энэ түүхийг өгүүлж буй видео бичлэгийг хэсгийг үзүүл). Өсвөр үеийнхнийг хоёр хоёроороо баг болж, хамтарч ажиллаад, зарлигууд биднийг хэрхэн аюулаас хамгаалдаг болохыг ойлгоход туслах өөр харьцуулалт гаргаж ирэхэд урь. Тэд зарлигуудыг сахиснаар хэрхэн адислагдаж, аюулаас хамгаалагдаж байсан бэ?

- Самбарын нэг талд нь “Зарлиг тушаалууд”, нөгөө талд нь “Амлагдсан адислалууд” гэж бич. Өсвөр үеийнхнээс Их Эзэн Өөрийнх нь зарлигийг дагадаг хүмүүст амласан адислалуудын тухай судрын шүлгүүдийг олохыг хүс. Жишээлбэл энэхүү тоймд дурдагдсан судруудыг

уншиж болох юм. Шаардлагатай бол аль нэгэн зарлигийн талаарх судруудыг олохын тулд Сэдэвчилсэн удирдамжийг хэрхэн ашиглахыг тэдэнд зааж өгнө үү. Тэднээс судалсан зарлигууд болон амлагдсан адислалуудаа самбар дээр бичихийг хүс. Эдгээр адислалын талаар уншихад зарлигуудын талаар ямар сэтгэгдэл төрж байна вэ?

- Өсвөр үеийнхнээс сүүлийн Ерөнхий чуулган дээр хэлсэн үг эсвэл *Залуучуудын бат бөх байдлын төлөө* номоос нэг бүлгийг сонгон уншаад, биднийг зарлигуудыг дагасан үед Их Эзэний үйлчлэгчийн амладаг адислалуудыг хайж олохыг хүс. Өсвөр үеийнхэн бүрд олж мэдсэн зүйлсээ хуваалцах боломж олго. Эдгээр амлагдсан адислалын нэгийг хүлээн авсан туршлагаасаа хуваалцахад тэднийг урамшуул.

- Ангиараа *Миний сайн мэдээг номло* номын “Хүмүүст адислалуудыг амла” хэсгийг унш (224–225-р хуудас). Өсвөр үеийнхнээс хэн нэгэнд заах хэрэгтэй байж болох нэг зарлигийн талаар бодон, “Хүмүүст адислалуудыг амла” хэсэг дэх зааврын дагуу уг зарлигийг ангийнхаа хэн нэгэнд зааж, дадлага хийхийг хүс. Хэдэн өсвөр үеийнхнийг туршлагаа хуваалцахад урь.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлийнхээ тухай хуваалцахыг хүс. Тэнгэрлэг Эцэгийн дуулгавартай нэгэнд өгнө хэмээн амласан адислалуудыг хэрхэн ялгаж танихыг тэд ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хувиараа сайн мэдээнээс суралцах үедээ амлагдсан адислалуудыг олж мэдэхийг өсвөр үеийнхнээс хүс. Дараагийн хичээл дээр олж мэдсэн зүйлээ хуваалцахад нь тэднийг дэмж.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч заасан бүх хүндээ, ямар ч үед үлгэр жишээ болж мөн багш нь байсан. Тэрээр тэдэнтэй хамт залбирснаар хэрхэн залбирахыг тэдэнд заасан. Тэднийг хайрлаж, үйлчилсний адил бусдыг хайрлаж, үйлчлэхийг Тэрээр тэдэнд заасан. Таны хайр мөн Бурханы зарлигуудыг дуулгавартай дагах жишээ таны зааж байгаа өсвөр үеийнхэнд хэрхэн нөлөөлж болох вэ?

Сонгосон материалууд

“Хүмүүст адислалуудыг амла,” Миний сайн мэдээг номло (2004), 197–198

Бодол санаа болон үйл хөдлөлүүдээ өөрчлөх ёс зүй хүмүүст хэрэгтэй байдаг. Амлагдсан адислалууд нь ихэнхдээ Бурханыг дуулгавартай дагахад хүчтэй өдөөлт болж өгдөг. Их Эзэн зарлигийг өгөхдөө уг зарлигийг сахиснаар ирэх адислалуудыг амладаг (С ба Г 130:20–21). Тодорхой зарлигийг дуулгавартай дагахад нь хүмүүсийг бэлтгэхдээ тэдэнд дараахыг заа:

- Зарлигуудыг дагаж амьдрах нь Бурхан болон Түүний Хүүг хайрлах хайрыг харуулдаг.
- Зарлигуудыг нь дагаснаар тэд Бурханд итгэх итгэлээ үзүүлдэг.
- Ингэснээр тэд Түүний амласан адислалуудыг хүлээн авах болно.

Зарлигийн талаар гэрчлэхдээ уг зарлигийн дагуу амьдарснаар хүлээн авсан адислалуудынхаа талаар ярь. Таны зааж буй хүмүүс ч мөн адил адислалуудыг хүлээн авч чадна гэдгийг тэдэнд амла.

Хүмүүсээс амлалтуудаа биелүүлэхээр хичээх үед, Тэнгэрлэг Эцэгийн тэдэнд өгсөн адислалуудын тухай ярихыг тэднээс хүс. Хэдийгээр амьдралд нь хүнд хэцүү үеүд тохиолдох боловч, тэд Түүний хүслийг дуулгавартай дагах үед, Түүний адислалууд үргэлжлэн ирэх болно гэдгийг тэдэнд амла.

БҮЛГИЙН ТОВЧ ТОЙМ

Аравдугаар сар: Христтэй илүү адил болох нь

“Би бол зам, үнэн, амь мөн хэмээн Есүс түүнд хэлсэн” (Иохан 14:6)

Энэхүү бүлгийн тоймууд нь Аврагчийн адилаар сайн мэдээг хэрхэн сурч мөн заахыг ойлгоход нь өсвөр үеийнхэнд туслах болно. Өсвөр үеийнхэн дуулгавартай болон даруу байдал гэх мэт Христийн зан чанаруудыг хөгжүүлэхээр эрэлхийлэх явцдаа сайн мэдээний илүү сайн суралцагчид болох болно. Есүс Христ бусдад хэрхэн заадаг байсныг сурснаар мөн Түүний жишээг дагахыг эрэлхийлснээр тэд илүү сайн багш нар болох болно.

Энэ сард сонгох тоймууд:

Аврагчтай илүү адил болоход нь бусдыг би хэрхэн урих вэ?

Би заах хүмүүстээ хайраа хэрхэн үзүүлэх вэ?

Аврагч сайн мэдээний үнэнүүдийг мэддэг зүйл болон туршлагуудтай хэрхэн харьцуулсан бэ?

Христтэй илүү адил болоход нь бусад хүмүүст туслахдаа би судруудыг хэрхэн ашиглах вэ?

Би заахдаа асуултуудыг хэрхэн үр дүнтэйгээр хэрэглэх вэ?

Би сайн мэдээнээс суралцах талаар Аврагчийн жишээнээс юу сурч болох вэ?



Би хэрхэн бусдыг Аврагчтай илүү адил болоход урих вэ?

Есүс Христ шавь нараа Өөрийг нь дагаж, Өөрийнх нь зарлигуудыг сахин, Өөртэй нь адил болоход урьсан. Сүмийн гишүүдийн хувьд бид Түүний жишээг дагах мөн бусдыг Түүний талаар суралцахад урих үүрэг хариуцлага хүлээдэг. Бид бүгд бусад хүнийг Христэд ирж, Түүгээр төгөлдөржихэд нь урих чадвараа дээшлүүлж чадна.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалыг залбирч, судал. Бусдыг Христэд ирэхэд хэрхэн урих талаар ойлгоход нь өсвөр үеийнхэнд юу туслах вэ?

Марк 10:17–22; Лук 10:25–37; (Есүс бусдыг сайн мэдээний зарчмын дагуу амьдрахад урьж байгаа жишээнүүд)

Матай 11:28–30; Моронай 10:32 (Христэд ирэх урилга)

Хэнри Б.Айринг “Христэд ир,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2008 оны 3-р сар, 49–52

Хэнри Б.Айринг “Сэрэмжлүүлгийн дуу хоолойгоо өргөцгөөе,” *Ensign*, 2009 оны 1-р сар, 4-9; *Лиахона*, 2009 оны 1-р сар, 2–7

“Би хэрхэн амлалт өгч, амлалтаа биелүүлэхэд нь хүмүүст туслах вэ?” *Миний сайн мэдээг номло* (2004), 221-230

Танд Христтэй илүү адил болоход бусдын ямар урилгууд тусалж байсан бэ? Та хэрхэн бусдыг Аврагчтай илүү адил болоход туслах өөрчлөлтүүдийг амьдралдаа гаргахад нь урьж байсан бэ?

Амьдралдаа өөрчлөлт гаргахад бусдыг урих ямар боломжууд өсвөр үеийнхэнд байдаг вэ? Та хэрхэн бусад Христтэй илүү адил болох урилгыг өгөх чадварыг олоход нь тэдэнд тусалж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээл эсвэл найз нартайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Та хэрхэн өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь тэдэнд тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Өсвөр үеийнхнийг сайн мэдээний зарчмын дагуу амьдрахаар уригдсан саяхан тохиолдсон туршлагаасаа хуваалцахад урь. Тэдэнд эдгээр урилга хэрхэн амьдралаа

сайжруулж мөн Аврагчтай илүү адил болоход нь тусалсан бэ?

- Аврагч бусдыг сайн мэдээний зарчмын дагуу амьдрахад урьж байгаа жишээг судруудаас уншихад

өсвөр үеийнхнийг урь (жишээлбэл, энэ тойм дахь судруудыг үзнэ үү). Бид бусдыг сайн мэдээний дагуу

амьдрахад урих талаар Аврагчийн жишээнээс юу сурч авч чадах вэ?

Хамтдаа суралц

Заахад туслах арга

“Хэрвээ бид суралцагчдад сайн нөлөө үзүүлэхийг хүсч байгаа бол заах дуртай байх хэрэгтэй ба өөрийн зааж байгаа хүн бүрийг хайрлах ёстой” (*Teaching, No Greater Call* [1999], 31).

Христэд ирэхэд бусдыг урьж мөн тийнхүү үйлдэхэд хэрхэн өөртөө итгэлтэй болохыг ойлгоход өсвөр үеийнхэнд дараах үйл ажиллагаа болгон туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Ангиараа; Миний сайн мэдээг номло номын 223-р хуудас дахь “*Шууд чиглэсэн асуулт асуух нь*” гарчигтай хэсгийг унш. Найз юм уу гэр бүлийнхээ гишүүнийг амьдралдаа эерэг өөрчлөлт гаргахад нь туслахын тулд асуултууд ашиглаж болох нөхцөл байдлын талаар бодоход өсвөр үеийнхнийг урь (хараах зуршлаа хаяхад нь найддаа туслах эсвэл гэр бүлийнхээ нэг гишүүнийг сүмд очиход урамшуулах гэх мэт жишээнүүд багтаж болно). Иймэрхүү нөхцөлд тэд ямар шулуун асуултуудыг асууж болох вэ? Тэд хэрхэн эдгээр асуултыг асууж болох вэ? Тэд эдгээрийг хэзээ асуух вэ? *Миний сайн мэдээг номло* номны 221-230-р хуудсан дахь “Амлалтуудыг хийж, биелүүлэхэд нь би хүмүүст хэрхэн туслах вэ?” бүлгийн бусад хэсгээс ярилцах талаар бодож үзээрэй.

- Өсвөр үеийнхнийг сайн мэдээний зарчмаар амьдрахад урьж болох хэн нэгний талаар бодоход урь. Ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн

“Сэрэмжлүүлгийн дуу хоолойгоо өргөцгөө” өгүүллийн “Хайр эхэнд нь ордог” хэсгийг уншихыг хүсвэл “Тохинууллын жишээнүүд” видео бичлэг үзээрэй. Тэднийг бодож байгаа хүнээ урихад нь туслах сурсан зарчмуудаа самбар дээр бичихэд урь. Тэд хэрхэн урих вэ? Тэд юу гэж хэлэх вэ?

- Энэ тоймд байгаа Христэд ирэх урилга бүхий судруудыг уншихад өсвөр үеийнхнийг урь. Эдгээр сударт Христэд ирэх тэдэнд ямар адислалууд амлагдсан байна вэ? Энэ тоймд санал болгосон видео бичлэгүүдээс нэгийг үзүүлж, видео бичлэг дэх хүмүүс нь хэрхэн найзууд болон гэр бүлийнхнийхээ энгийн урилгын ачаар адислагдсан талаар хуваалцахад өсвөр үеийнхнийг урь. Өсвөр үеийнхэн найзууд болон гэр бүлийн гишүүддээ ямар энгийн урилгыг өгч болох вэ? Урилгыг хүлээн авснаар хэрхэн тэдний найзууд болон гэр бүл нь адислагдах вэ?

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд хэрхэн Аврагчтай адил болоход нь бусдыг урих талаар ойлгож байна уу? Тэд ямар бодол сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлагатай байна уу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээс нь юу хийх мэдрэмж төрж байгаа талаар асуу. Тэднийг тэрхүү мэдрэмжийнхээ дагуу үйлдэхэд урамшуулан дэмж. Суралцагчид гүүний дагуу үйлдэж байгаа эсэхийг шалгах аргуудыг бодож ол.

Аврагчийн арга барилгаар заах нь

Есүс Христ нифайчуудад айлчлах үедээ өөрийг нь харж, мэдэрч, мэдэж болохын тулд Түүн рүү нэг нэгээрээ ирэхийг урьсан (3 Нифай 11:13–17-г үзнэ үү). Өсвөр үеийнхнийг Есүс Христийг хувиараа мэддэг болоход нь ямар арга замуудаар урьж болох вэ?

Сонгосон материалууд

Хэнри Б.Айринг, “Сэрэмжлүүлгийн дуу хоолойгоо өргөцгөөе” хэлсэн үгээс эш татав. Ensign, 2009 оны 1-р сар, 5–9 эсвэл Лиахона 2009 оны 1-р сар, 3–7

Хайр бол бүхнээс чухал зүйл

Хайр үргэлж бүхний түрүүнд байдаг. Нинжин сэтгэлийн ганц удаагийн үйлдэл хангалттай байх нь өдрийн од шиг ховор юм. Бидний мэдрэх ёстой хайрыг Их Эзэн дүрсэлсэн байдаг. Бидний урьдаг хүмүүс “Хайр бол тэвчээртэй,” “хайр бүгдийг даадаг, бүгдэд итгэдэг, бүгдэд найддаг, бүгдийг тэсвэрлэдэг” гэсэн үгсийг биднээс олж хардаг байх ёстой (1 Коринт 13:4, 7).

Би “хайр тэвчээртэй,” “хайр бүгдийг тэсвэрлэдэг” гэдэг нь юу гэсэн үг болохыг мэдэрсэн хүн. Нэг айл манай ойролцоох байшинд нүүж ирсэн юм. Тэдний байшин дөнгөж шинээр баригдсан байв. Би тэр үед орчныг тохижуулж, мод, бут сөөг тарьж, зүлэгжүүлэхэд гар бие оролцоход олон оройг зориулсан Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн бүлгийн нэгэн гишүүн байлаа. Биднийг ажлаа дуусгасан орой нөгөөх гэр бүлийн тэргүүн хажууд минь зогсож байсныг санаж байна. Тэрээр бидний хийсэн ажлыг ажиглан, ойрхон зогсож байснаа бидэнд хандан “Энэ бол Мормончууд та нараас бидэнд зориулан барьсан гурав дахь хашаа. Энэ хашаа хамгийн сайн нь гэж би бодож байна” гэв. Тэгээд тэр хүн өөрийнхөө сүмийн гишүүнчлэлээс хүлээн авдаг агуу сэтгэл ханамжийн талаар намуухан атлаа шийдэмгийгээр ярих. Түүнийг энд амьдарч байсан он жилүүдэд ийм яриа бидний хооронд олон удаа болдог байлаа.

Тэр хүнийг энд амьдарч байсан бүх хугацаанд түүнд болон гэр бүлийнхэнд нь үзүүлж байсан нинжин сэтгэлийн үйлдлүүд огтхон ч зогсоогүй юм. Юу гэвэл хөршүүд нь түүнийг үнэхээр хайрладаг байлаа. . . .

Хоёрдугаарт, бид бусад хүмүүсээр хийлгэхийг урьдаг тэр зүйлдээ бүр илүү үлгэр дуурайл үзүүлэх хэрэгтэй. “Хүмүүс та нарын сайн үйлсийг хараад Тэнгэр дэх Эцэгийг тань алдаршуулахын тулд та нарын гэрэл тэдний өмнө тийнхүү гэрэлтэг” гэсэн Аврагчийн энэхүү зарлиг ороо бусгаа энэ дэлхийд улам чухал болж байна (Матай 5:16).

Бидний үлгэр жишээний багаахан гэрэл бусдад бараг ажиглагдахааргүй өчүүхэн шүү дээ гэж бидний ихэнх нь боддог байж болох юм. Гэвч таньг бас гэр бүлийг тань бусад хүмүүс өөрийн тань боддогоос илүү ихээр ажиглан харж байдаг юм шүү дээ. Надад нэлээн дээр үед бусад сүмийн 300 орчим үйлчлэгч, удирдагч оролцсон цуглаанд оролцож, үг хэлэх завшаан тохиосон юм. Өмнөх цуглаануудад би ганцаараа очсоны нэгэн адил энэ удаа ч мөн л ганцаараа очив. Миний захиас Сүмийн гарал үүслийн тухай, залуу Иосеф Смитийн Анхны Үзэгдэл болон амьд бошиглогчдын тухай байлаа. Тэд яагаад миний захиасыг тийм ихээр анхаарч сонссоныг би асуусан юм. Хүн бүр үндсэндээ нэг л хариулт өгдөг байлаа. Тэд өөрсдийнхөө таньдаг Сүмийн гишүүн юм уу, гишүүн гэр бүлийн тухай ярина. “Тэд бол миний мэддэг хамгийн сайхан гэр бүл байсан шүү” гэж хэлэхийг би олон удаа сонссон. Сүмийн гишүүд гайхалтай арга замаар ажилласан олон нийтийн ямар нэг үйл ажиллагаа эсвэл байгалийн гамшигт үзүүлсэн тусламжийн талаар хүмүүс олонтоо ярьдаг байв. . . .

Сонгосон материалууд

Бидний улам сайн хийх ёстой гурав дахь зүйл бол гэрчлэлээр бусдыг урих явдал мөн. Хайр, үлгэр жишээ биднийг сонсох боломжийг хүмүүст олгоно. Харин бид амаа нээж, гэрчлэлээ хуваалцах ёстой. Үнэн, сонголт хоёр салшгүй холбоотой байдаг энгийн нэгэн баримт бидэнд тусалдаг. Тэнгэрлэг Эцэгийн маань бүх хүүхдүүд сүнслэг үнэнүүдийг гэрчлэхэд тэнцэхүйц байхын тулд хийх

ёстой зарим сонголт байдаг. Бид сүнслэг үнэнийг мэддэг учраас амьдралаа энэхүү үнэнд тохируулахаар сонголт хийх ёстой. Бид үнэний тухай гэрчлэлээ хайртай хүмүүс, найз нартайгаа хуваалцсанаар тэд энэхүү үнэнийг өөрсдөө мэдэхийн төлөө хийх сонголтуудыг нь тэдэнд харуулдаг.



АРАВДУГААР САР: ХРИСТТЭЙ ИЛҮҮ АДИЛ БОЛОХ НЬ

Би заах хүмүүстээ хайраа хэрхэн үзүүлэх вэ?

Есүс Христ Өөрийн заах хүмүүсийг хайрладаг байсан. Тэр тэдний төлөө залбирч мөн Өөрийн хайрыг илэрхийлэх боломжуудыг олдог байсан. Бид заах хүмүүсийнхээ төлөө залбирч, хувиа хичээлгүй тэдэнд үйлчилснээр тэднийг хайрлах хайраа хөгжүүлж чадна. Бидний заах хүмүүс чин сэтгэлийн хайрыг маань мэдрэх үед зүрх сэтгэл нь зөөлөрч, бидний зааж байгаа үнэнд илүү нээлттэй ханддаг.

Багш тань хайраа үзүүлсэн нь танд хэрхэн нөлөөлж байсан бэ? Та заах хүмүүсээ хэрхэн хайрладаг болсон бэ?

Өсвөр үеийнхэнд сүм дээр заах ямар боломж байдаг вэ? Тэдний хувьд заах өөр ямар цаг мөч байдаг вэ? Заах хүмүүсээ хайрлах нь өсвөр үеийнхэнд илүү сайн багш болоход нь хэрхэн туслах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалуудыг залбирч, судал. Өсвөр үеийнхэн заах хүмүүсээ хайрлахын чухлыг ойлгоход нь юу туслах вэ?

Иохан 13:34 (Есүс Христ биднийг хайрладаг шиг бид бусдыг хайрлах ёстой)

Мозая 28:1–3; Алма 17:21–39; 20:21–27 (Аммон өөрийн зааж байсан леменчүүдэд хайрыг үзүүлсэн нь)

Моронай 7:45–46 (Энэрэлгүйгээр бид юу ч биш)

Томас С. Монсон “Агуу багшийн жишээнүүд,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2007 оны 6 сар, 74–80

“Заах хүмүүсээ хайрла,” *Teaching, No Greater Call* (1999), 31–39

Видео бичлэг: “Заах хүмүүсээ хайрла” (татаж авах боломжгүй)

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Та өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Өсвөр үеийнхнийг хувиараа судраас суралцаж байхдаа саяхан уншсан нэг судрыг ангийн өөр нэг

гишүүнтэй хуваалцахад урь. Тэдэнд сурч байгаа зүйлсийнх нь талаар асуулт байна уу?

- Багш нь тэдэнд хайртайг хэрхэн мэдэх талаар өсвөр үеийнхнээс асуу. Багш хайраа үзүүлэх нь яагаад чухал вэ? Өсвөр үеийнхэн өөрсдийн заасан хэн нэгэнд хайраа үзүүлж

байсан уу? Иохан 13:34-ийг уншин, Аврагчийн зааж байсан хүмүүстээ хайраа үзүүлсэн арга замуудын талаар ярилц.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр заах хүмүүсээ Христийн адилаар хэрхэн хайрлахыг ойлгоход нь өсвөр үеийнхэнд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Өсвөр үеийнхнийг Моронай 7:45-ыг уншин, энэрэлт хүнийг дүрслэх үгсийг олж, эдгээр шинж чанаруудыг өөрийн үгээр тайлбарлахыг хүс (шаардлагатай бол мэдэхгүй үгсийнх нь тодорхойлолтыг олоход туслаарай). Өсвөр үеийнхэн бүрийг эдгээр үгсээс нэгийг сонгон, энэ нь заахтай хэрхэн холбогдож болох талаар тайлбарлахад урь. Тэднээс сүмд болон өөр бусад заах нөхцлүүдийн (гэртээ, сургууль дээр болон өдөр тутмын амьдралд) талаар бодохыг хүс. Тэднийг илүү сайн багш болоход нь туслах Моронай 7:45 дээр гарч байгаа зан чанаруудаас алийг нь хөгжүүлмээр байна вэ? Өсвөр үеийнхнээс цөөн хэдийг нь урьж, бодол санаагаа хуваалцахыг хүс.

- Ерөнхийлөгч Томас С. Монсоны “Агуу багшийн жишээнүүд” хэлсэн үгийн “Авахаасаа өгөх нь илүү ерөөлтэй” хэсгийг уншихыг эсвэл “Заах хүмүүсээ хайрла” видео бичлэгийг үзэхийг өсвөр үеийнхнээс хүс. Өсвөр үеийнхнээс асуу: Эдгээр жишээнд гарч байгаа багш нар заадаг хүмүүстээ хайраа үзүүлэхийн тулд юу хийсэн бэ? Өсвөр

үеийнхэнд заах ямар боломжууд байдаг вэ (сүмд болон бусад заах цаг мөч)? Өсвөр үеийнхнийг багшийн хувьд хайраа үзүүлж болох арга замуудыг төлөвлөхөд урь. Өсвөр үеийнхнээс цөөн хэдийг нь ангийнхантайгаа төлөвлөгөөгөө хуваалцахад урь.

- *Teaching, No Greater Call* номын 31-р хуудас дээрх ахлагч Даллас Н. Арчибалдын адилтгалын талаар хуваалц (та ярилцлаганд тус болох хоосон аяга болон савтай ус авчрах хэрэгтэй болох байх). Өсвөр үеийнхэн энэ адилтгалаас заах талаар юу сурч авсан бэ? Ангиа гурван бүлэг болгож хуваарилан, *Teaching, No Greater Call* номын “Заах хүмүүсээ хайрла” хэсгийн гурван бүлгийг нэг нэгээр нь бүлэг бүрд оноож өг. Оногдсон хэсгээс сурсан зүйлээ ангийнхаа бусад гишүүдэд заахад бүлэг бүрийг урь. Заахдаа уг зарчмыг харуулах түүх болон ярилцлага өрнүүлэх асуулт мөн хувийн гэрчлэлийг багтаахад тэднийг урамшуулан дэмж.

- Лемонайн сүргийг хамгаалж байгаа Аммоны зургийг үзүүлээд (*Сайн*

Заахад туслах арга

“Сайн мэдээний багшийн ажлын нэг хэсэг нь Тэнгэрлэг Эцэгийн тэдний төлөөх хайрыг ойлгож, мэдрэхэд нь суралцагчдад туслах явдал юм. Үүнийг зөвхөн үгээр илэрхийлснээр хийж чадахгүй. Энэ нь хүн бүрд биечлэн хүргэхийг шаарддаг” (*Teaching, No Greater Call* [1999], 35).

Аврагчийн арга барилаар заах нь

Есүс Христ Өөрийн заах хүмүүсийг хайрладаг байсан. Тэрээр тэдний төлөө залбирч, үргэлж тэдэнд үйлчилдэг байв. Та заадаг өсвөр үеийнхэндээ хайраа хэрхэн үзүүлж болох вэ?

мэдээний зургийн цуглуулга 78), энэ түүхийг ярьж өгөхийг ангийн нэг гишүүнээс хүс (Алма 17:21–39-ийг үзнэ үү). Өсвөр үеийнхний заримыг нь Мозая 28:1–3-ыг уншин, “Аммон болон түүний ах дүү нарт леменчүүдэд сайн мэдээг заах хүслийг юу төрүүлсэн бэ?” гэсэн асуултанд хариулт олохоор эрэлхийлэхийг

хүс. Өсвөр үеийнхний үлдсэн хэсгээр нь Алма 20:21–27-г уншин, “Аммоны хайр хаан Лемонайд ямар нөлөө үзүүлсэн бэ?” гэсэн асуултын хариултыг эрэлхийлэхийг хүс. Олж мэдсэн зүйлээ хуваалцаж, Аммоны жишээг даган хийж чадах тодорхой зүйлсийн талаар бодохыг тэднээс хүс.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд заах хүмүүстээ хайраа хэрхэн үзүүлэх талаар ойлгож мэдэж байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхнийг зааж байгаа хүмүүсийнхээ талаар бодоход урамшуул. Тэдгээр хүмүүсийг хайрлах хайраа үзүүлэхийн тулд хийх нэг зүйл сонгоход тэднийг урь.

Сонгосон материалууд

Томас С.Монсон, “Агуу багшийн жишээнүүд” хэлсэн үгээс эш татав. Ensign, 2007 оны 6-р сар, 106–112, эсвэл Лиахона, 2007 оны 6-р сар, 74–80

“Өгөх нь авахаас илүү адислагдсан байх болно”

Жаахан хөвгүүн байхдаа хүүхэд биднийг хайрлаж мөн сонсдог маш шаргуу, сүнслэгээр нөлөөлөгдсөн багшаар заалгах завшаан надад олдсон юм. Түүнийг Люси Гертч гэдэг байв. Ням гаргийн хичээл дээр Люси багш бидэнд дэлхийн Бүтээлт, Адамын уналт, Есүсийн цагаатгагч золиослолын талаар заадаг байсан сан. Тэрээр ангидаа Мосе, Иошуа, Петр, Томас, Паул, бүр Христ гэсэн хүндтэй зочдыг урин авчирдаг байсан юм. Хэдийгээр бид тэднийг хардаггүй байсан ч тэднийг хайрлаж, хүндэтгэж, дагаж сурсан.

Ангийн маань нэг хүүхдийн ээж нас барсан гэдгийг багш маань гунигтайгаар хэлсэн тэр нэг ням гаргийн өглөөний хичээл шиг зүрх сэтгэлд хүрсэн хичээл байгаагүй юм. Тэр өглөө Билли хичээлдээ ирээгүй бөгөөд яагаад ирээгүй болохыг нь бид мэдээгүй байв.

Хичээлийн сэдэв “Авахаасаа өгөх нь илүү ерөөлтэй” (Үйлс 20:35) байлаа. Хичээл дундаа орох үед багш маань номоо хаагаад бидний нүд, чих, зүрх сэтгэлийг Бурханы алдар суу руу чиглүүлсэн юм. Тэрээр “Манай ангийн үдэшлэгийн санд хэдэн доллар байгаа вэ?” гэж асуув.

“Дөрвөн доллар далан таван цент” гэсэн бардам хариулт нь Агуу хямралын тэр өдрийг дэврээв.

Дараа нь багш өмнөхөөсөө ч илүү найрсгаар: “Биллигийн гэр бүл санхүүгийн асуудалтай бас уй гашуу амсаж байгаа. Одоо ингээд гэр бүлийнхэнтэй нь уулзаж, та нарын хуримтлуулсан мөнгийг өгөх талаар юу гэж бодож байна вэ?” гэсэн санал гаргав.

Хэдэн бяцхан хүүхэд гурван гудамж алхан Биллигийн гэрт орж, түүнтэй бас ах эгч, аавтай нь мэндэлж байсныг би хэзээ ч мартдаггүй юм. Мэдээж, түүний ээж байхгүй байлаа. Хуримтлуулсан мөнгийг маань хийсэн цагаан дугтуй багшийн маань хүндэтгэн барьсан гараас уй гашууд автсан, гачигдалтай эцгийн гар дээр тавих тэр үед бид бүгдийн нүдэнд нулимс дүүрсэн байсныг би байнга дурсан санадаг.

Бид чимээгүйхэн тэднийхээс гарч, цуглааны байрны зүг буцаж алхацгаав. Мэдлэг ойлголтоо өсөн нэмэгдсэнийг хараад бид зүрх сэтгэлдээ урьд өмнө нь хэзээ ч мэдэрч байгаагүйгээр хөөрөн догдолж, баяр баясгалангаар бялхсан юм. Бурханы илчлэлтийг хүлээн авсан багш маань бурханлаг үнэний мөнхийн хичээлийг охид хөвгүүддээ заасан нь тэр байлаа. “Авахаасаа өгөх нь илүү ерөөлтэй.” Тэгэхээр одоо бүгдээрээ Еммау руу явж байсан шавь нарын үгийг жаахан өөрчлөөд үзье: “[Багш] судрыг бидэнд тайлбарлаж байхад нь зүрх маань [бидний дотор] . . . шатаж байсан бус уу?” (Лук 24:32).

Люси Гертч суралцагчдаа нэг бүрчлэн мэддэг байсан. Тэрээр ням гаргийн хичээлдээ ирээгүй эсвэл байнга хамрагдаж чаддаггүй хүүхдүүдийг андахгүй сайн мэддэг байсан ба тэдэн рүү утсаар ярьдаг байв. Бидний төлөө санаа тавьдгийг нь бид мэддэг байсан. Бидний хэн нь ч түүнийг, түүний заасан хичээлийг хэзээ ч мартаггүй.

Олон арван жилийн дараа Люсийг нас барахынх нь өмнөхөн би түүнтэй уулзаж билээ. Түүнийг бидний багш байсан тэрхүү олон жилийн өмнөх үйл явдлуудын талаар бид дурсан ярилцсан юм. Бид ангийнхаа хүүхэд нэг бүрийн тухай болон одоо юу хийж байгаа талаар ярилцаж билээ. Тэр амьдралынхаа турш хайр ба хүнлэг сайхан сэтгэлээр дүүрэн байсан.



Аврагч сайн мэдээний үнэнүүдийг мэддэг зүйл болон туршлагуудтай хэрхэн харьцуулсан бэ?

Есүс Христ бол Эзэн Багш юм. Тэр Өөрийн заах хүмүүст сайн мэдээний зарчмуудыг ойлгоход туслах энгийн түүх, сургаалт зүйрлэл болон амьдралын бодит жишээг хуваалцдаг байсан. Бид хувийн туршлага болон сайн мэдээний зарчмуудыг өөрсдийн эргэн тойрон дахь орчинтой харьцуулахдаа Аврагчийн адил заах түүхүүдийг ашиглаж болно.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар болон материалуудыг залбирч, судал. Өсвөр үеийнхэнтэй хуваалцах юуг та сүнслэгээр мэдэрч байна вэ?

Есүсийн сургаалт зүйрлэлүүдээс аль нь танд хамгийн мартагдашгүй байдаг вэ? Яагаад? Өөр ямар харьцуулалтууд сайн мэдээний зарчмуудыг ойлгоход тань тусалсан бэ?

Есүсийн сургаалт зүйрлэлүүдийн аль нь өсвөр үеийнхэнд утга учиртай байж болох вэ? Өөр ямар харьцуулалтууд сайн мэдээний зарчмуудыг ойлгоход нь тэдэнд тусалж болох вэ? Түүх болон харьцуулалтыг ашигладаг байсан Аврагчийн аргаас өсвөр үеийнхэн заах талаар юуг сурч авч болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Матай 20:1–15; 25:1–13, 14–30; Лук 8:4–15; 15:1–7, 8–10, 11–32; мөн “Үрэлгэн хүү” видео бичлэг (сургаалт зүйрлэлүүдийн жишээнүүд)

Матай 18:1–6 (Аврагч тэнгэрийн хаант улсын талаар заахдаа хүүхдийг авч үзсэн)

Матай 5:13–16; мөн “Уулан дээрх номлол: Ерөөлүүд” видео бичлэгийг үзнэ үү (Аврагч Өөрийн шавь нарыг давс болон лааны гэрэлтэй зүйрлэсэн)

Л. Том Пэрри, “Итгэлийн тунхагдах сургаал, зарчмууд” *Ensign* эсвэл *Лиахона*, 2013 оны 11-р сар

Жэффри Р. Холланд “Талбайд хөдөлмөрлөгчид” *Ensign* эсвэл *Лиахона*, 2012 оны 5-р сар, 31–33

Дэвид А. Бэднар “Та нар дахин төрөх ёстой” *Ensign* эсвэл *Лиахона*, 2007 оны 5-р сар, 19–22

“Харьцуулалт ба үзүүлэнтэй хичээлүүд,” *Teaching, No Greater Call* 163–64

“Түүхүүд,” *Teaching, No Greater Call* 179–82

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутад өсвөр үеийнхний янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох

уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний хамаарлыг олж харахад нь та нар өсвөр үеийнхэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Өөрсдийнх нь санаж байгаа гэр бүлийн үдшийн хичээл эсвэл өөр нэг хичээлийг мөн ариун ёслол дээр эсвэл чуулган дээр хэлсэн үгийг дүрслэхэд өсвөр үеийнхнийг уриад яагаад энэ нь дурсамжтай байдаг талаар ярилц.

- Өсвөр үеийнхнийг саяхан болсон ерөнхий чуулган дээр хэлсэн үгсээс санаж байгаа нэг түүхээ хуваалцахад урь. Тэд энэ түүхээс юу сурсан бэ? Үг хэлсэн хүн заахдаа яагаад энэ түүхийг сонгосон гэж тэд бодож байна вэ?

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь заах үедээ сургаалт зүйрлэлүүдийг болон өөр бусад харьцуулалтыг хэрхэн ашиглахыг ойлгоход нь өсвөр үеийнхэнд туслах юм. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс олон үйл ажиллагааг сонгоно уу:

- “Өргөст хэмх даршлах” болон “Хөрвүүлэгдэх нь” гэсэн хоёр гарчиг бүхий хүснэгт хийхэд өсвөр үеийнхнийг урь. Өсвөр үеийнхнийг ахлагч Дэвид А. Бэднарын “Та нар дахин төрөх ёстой” хэлсэн үгийг уншиж, түүний хөрвөлтийн үйл явцын талаар заахдаа хийсэн харьцуулалтыг олохыг хүс. Уг харьцуулалтыг дүрслэн ойлгоход нь туслахын тулд та зураг зурахад өсвөр үеийнхнийг урих талаар бодож үзээрэй. Сайн мэдээний үнэнийг заахдаа ашиглаж болох харьцуулалтын талаар өөрсдийн туршлагаас хуваалцах цагийг өсвөр үеийнхэнд гаргаж өгөөрэй.

- Өөрсдийн дуртай сургаалт зүйрлэлийн талаар бодож, түүнийгээ судраас олохыг өсвөр үеийнхнээс хүс. Хэрвээ тэдэнд санаа хэрэгтэй бол энэ тоймд санал болгосон сургаалт зүйрлэлүүдээс нэгийг хуваалцах талаар бодож үзээрэй. Сонгосон сургаалт зүйрлэлээ ангийнхандаа ярьж өгч, энэ нь тэдэнд яагаад утга учиртай болох талаар хуваалцахад

өсвөр үеийнхнийг урь. Сургаалт зүйрлэлүүд нь яагаад илүү үр дүнтэй заах арга байдаг вэ? (“Түүхүүд”, *Teaching, No Greater Call*, 179–82-ыг үзнэ үү) Сайн мэдээний нэгэн үнэний талаар заах өөрсдийн сургаалт зүйрлэлийг зохиох хугацааг өсвөр үеийнхэнд гаргаж өгөх талаар бодож үзээрэй. Эхлээд тэд сайн мэдээний ямар зарчмыг заахыг хүсэж байгаагаа шийдэх хэрэгтэй гэж тэдэнд санал болгон чиглүүлж болох юм. Тэгээд тэд өөрсдийн зааж байгаа хүмүүст танил нөхцөл байдлын талаар бодоод уг сайн мэдээний зарчмыг заах түүхийг зохиож болно.

- Гар утас юмуу гар утасны зургийг өсвөр үеийнхэнд үзүүлээд тэднээс гар утас ба сайн мэдээний зарчмыг хооронд нь харьцуулахыг хүс. Ахлагч Л. Том Пэрригийн “Итгэлийн тунхаг дахь сургаал, зарчмууд” хэлсэн үгийн “Санваарын зохион байгуулалт ба дэг жаяг” гарчгийн өмнөх таван догол мөрийг уншин, түүний хийсэн

Сайн мэдээг судлах ур чадварууд

Бэлгэ тэмдгүүдийг ойлгох нь. Судрууд дахь сургаалт зүйрлэлүүдийг болон бэлгэ тэмдгүүдийг ойлгохын тулд өсвөр үеийнхэн бэлгэ тэмдгүүдийг таньж мэдэн, тэдгээрийн хэсгүүдийг ялган таньж мөн хөрвүүлж чаддаг байх хэрэгтэй. Бэлгэ тэмдгүүдийг таньж мэдэх нэг арга зам нь *лугаа, адил, адилтгагдах, түүний адил* эсвэл *мэт гэх* зэрэг үгсийг эрж хайх явдал юм. Тэгээд өсвөр үеийнхэн бэлгэ тэмдгүүдийн хэсгүүдийн жагсаалтыг гаргаж чадна. Бэлгэ тэмдгүүдийг хөрвүүлэхийн тулд тэд сүмийн материалуудыг (сүмийн сэтгүүлүүд, чуулганаар хэлсэн үгс мөн өөр бусад судрууд гэх мэт) үзэж болох ба мөн уг шинж тэмдэг нь сайн мэдээний зарчмыг ойлгоход тэдэнд яаж тусалж байгааг бодож үзээрэй. Хувиараа сайн мэдээнээс суралцах үедээ сургаалт зүйрлэлтэй эсвэл бэлгэ тэмдэгтэй таарах юм бол үүний адил үйлдэхэд тэднийг урамшуул.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч заах хүмүүстээ сайн мэдээний хичээлүүдийг өөрсдийн туршлагаас мөн эргэн тойронтай орчноосоо олж авахад нь тусалдаг байсан. Бусдад сайн мэдээний үнэнийг заахдаа өөрсдийн туршлага болон танил зүйлсээ ашиглаж болохыг ойлгоход нь та өсвөр үеийнхэнд хэрхэн туслаж чадах вэ?

Видео бичлэг: “Сайн мэдээг Аврагчийн арга барилаар заах нь”

харьцуулалтын тухай ярилцахад тэднийг урь. Үгийнхээ төгсгөлд ахлагч Пэрри өсвөр үеийнхнийг Итгэлийн тунхаг дахь сургаалуудыг судлахад урьсан. Ангиараа түүний урилгыг уншаад өсвөр үеийнхэн бүрээс Итгэлийн тунхагийн нэг зарчим дахь сургаалыг судлан, ирэх долоо хоногт ангидаа тэрхүү сургаалаа харьцуулалт ашиглан, товчхон заахаар бэлдэж ирэхийг хүс.

- Энэхүү тоймд санал болгосон видео бичлэгүүдээс нэгийг үзүүлэх юмуу Аврагчийн сайн мэдээг адил төстэй зүйлтэй харьцуулсан жишээнүүдийг судраас уншихад өсвөр үеийнхнийг урь. Есүс яагаад энэ аргаар заасан бэ (“Comparisons and Object Lessons,” *Teaching, No Greater Call*, 163–64-ийг үзнэ үү)? Өдөр тутам хэрэглэдэг зүйлс болох саван, зоос, түлхүүр, чулуу эсвэл хоол гэх мэт хэд хэдэн зүйлсийг ангидаа авчир. Өсвөр үеийнхнийг ямар нэг зүйл сонгон, түүнийгээ ашиглаж, сайн мэдээний нэг зарчмыг

заахыг хүс. Хэрвээ өсвөр үеийнхэнд тусламж хэрэгтэй бол *Teaching, No Greater Call* номын 163–64-р хуудсыг ашиглаж болно.

- Матай 20:1–15-р шүлгүүдээс талбай дээр хөдөлмөрлөгчдийн сургаалт зүйрлэлийг уншихад өсвөр үеийнхнийг урь. Энэ сургаалт зүйрлэл тэдний амьдралд хамаарч болох хэд хэдэн хувилбарын талаар ярилцахыг тэднээс хүс. Ахлагч Жэффри Р. Холландын “Талбайд хөдөлмөрлөгчид” хэлсэн үгийг уншаад энэ сургаалт зүйрлэлийг ашиглан, түүний зааж байгаа сайн мэдээний үнэний талаар ярилц (өсвөр үеийнхэнд хамгийн тохиромжтой аль хэсэг дээр нь анхаарлаа төвлөрүүлэхийг та шийдэж болох юм). Судруудаас өөр нэг сургаалт зүйрлэлийг сонгон, энэ нь тэдэнд ямар хамаатай болох талаар ангийнхандаа ярихыг өсвөр үеийнхнээс хүс. Яагаад сургаалт зүйрлэлүүд нь сайн мэдээний зарчмуудыг бусад хүмүүс сурахад туслах үр дүнтэй арга болдог вэ?

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд сургаалт зүйрлэл болон бусад харьцуулалтыг заахдаа хэрхэн ашиглахаа ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Хэн нэгэнд сайн мэдээний үнэнийг заахдаа сургаалт зүйрлэл эсвэл харьцуулалтыг ашиглан заахад өсвөр үеийнхнийг урь. Энэхүү үнэнийг гэр бүлийн үдэш, ариун ёслолын яриан дээр эсвэл найздаа заах гэх мэт зааж болох нөхцөл байдлуудын талаар бодож үзэхийг тэднээс хүс.

Сонгосон материалууд

Дэвид А.Бэднар, “Та нар дахин төрөх ёстой” хэлсэн үгээс эш татав. Ensign эсвэл Лиахона, 2007 оны 5-р сар, 19–22

Давсны уусмалд даршилсан давстай өргөст хэмийн адил бид бүхэн Есүс Христийн сайн мэдээнд татагдаж орсноор дахин төрдөг. Бид хийсэн “гэрээнүүдээ . . . дагаж” мөн дээдлэн хүндэтгэж (С ба Г 42:13), “Христийн үгэн дээр найрлан” (2 Нифай 32:3), “зүрхнийхээ бүхий л эрч хүчээр Эцэгт хандан залбирч” (Моронай 7:48) мөн “бүхий л зүрх сэтгэл, хүчин чадал, оюун хийгээд чадлаараа [Бурханд] үйлчилснээр” (С ба Г 4:2):

“Мөн эдүгээ, та нарын хийсэн гэрээний учир та нар Христийн хүүхдүүд, түүний хөвгүүд, мөн түүний охид гэж нэрлэгдэх болно; учир нь болгоогтун, энэ өдөр тэрээр та нарыг оюун санаагаар тань төрүүлээ; учир нь та нарын зүрх сэтгэл түүний нэрэнд итгэх итгэлээр өөрчлөгдсөн хэмээн та нар хэллээ; тиймийн тул, та нар түүнээс төрсөн мөн түүний хөвгүүд мөн түүний охид болсон бөлгөө” (Мозая 5:7).

Энэ шүлэгт дүрсэлсэн сүнслэг дахин төрөлт нь ерөнхийдөө хурдан юм уу, бүгд нэгэн зэрэг тохиодоггүй; энэ нь нэг удаагийн үйл явдал бус харин үргэлжилсээр байдаг үйл явц юм. Шат шатаар мөн дүрэм дүрмээр, яваандаа, бараг мэдэгдэлгүйгээр, бидний үйл хөдлөл, бодол, үгс, болон үйлс маань Бурханы хүсэлтэй нэгдэн нэг болдог. Өөрчлөгдөх үйл явцын энэ үе шат нь цаг хугацаа, хатуужил болон тэсвэр тэвчээр шаарддаг.

Өргөст хэмх зөвхөн давсны уусмалд тууштай, тасралтгүй мөн бүрэн даршилснаар даршилсан өргөст хэмх болдог. Жорны гол орц бол давс гэдэг нь тодорхой юм. Давс нь сударт олон удаа гэрээ болон гэрээт хүмүүсийн хоёулангийнх нь тэмдэг

болон ашиглагдсан байдаг. Давс нь өргөст хэмхийг даршилсан өргөст хэмх болгон хувиргахад чухал байдагчлан гэрээнүүд нь бидний сүнслэг дахин төрөлтийн цөм юм.

Бид Христэд итгэх итгэлээ хөгжүүлэн, нүглээ наманчилж мөн санваарын эрх мэдэлтэй нэгнээр нүглүүдийн ангижралын тулд усанд умбуулалтаар баптисмыг хийлгэснээр дахин төрөх үйл явцыг эхэлдэг.

“Тиймд Эцэгийн алдраар Христ үхэгсдээс амилуулагдсаны адил, бид мөн шинэ амийн дотор явахын тулд үхэл уруу баптисм хүртсэнээр Түүнтэй хамт оршуулагдсан юм” (Ром 6:4).

Бид баптисмын уснаас гарч ирсний дараа бидний бодгаль Аврагчийн сайн мэдээний үнэн ба гэрэлд үргэлжлүүлэн умбан, ариусагдах шаардлагатай байдаг. Христийн сургаалд хайнга болоод хойрго хандаж, Түүний сэргээгдсэн Сүмд дутуу дулимаг оролцох нь бидэнд шинэ амьдралаар алхах боломжийг олгодог сүнслэг өөрчлөлтөд хүргэж чадахгүй. Харин гэрээнүүддээ үнэнч, амлалтандаа тууштай байж, мөн бодгалиа тэр чигээр нь Бурханд зориулах нь бид мөнхийн адислалуудыг хүлээн авах эсэхийг шийддэг.

“Та нарыг Израилын Ариун Нэгэн болох Христэд ирж, мөн түүний авралаас мөн түүний гэтэлгэлийн хүчнээс хүртээсэй хэмээнэ би. Тийм ээ, Түүнд ирэгтүн, мөн өөрийн бүхэл бодгалийг Түүнд өргөл болгон өгөгтүн, мөн мацаг барьж бас залбирахаа үргэлжлүүл, мөн эцсийг хүртэл тэвчигтүн; мөн Их Эзэн амьдардгийн адил та нар аврагдах болно” (Омнай 1:26).

Аврагчийн сайн мэдээнд бүрэн умбаж мөн ариусгагдах нь дахин төрөх үйл явцын хамгийн чухал алхмууд юм.

Сонгосон материалууд

Л. Том Пэрригийн “Итгэлийн тунхаг дахь сургаал ба зарчмууд” хэлсэн үгээс эш татав, Ensign эсвэл Лиахона, 2013 оны 11-р сар

Сайн мэдээг судалж мэдэх талаар онцолж хэлсэн багшийн маань хүчтэй үгс надад сүнслэг удирдамжийн эх сурвалж болсоор ирсэн юм. Судрууд биднийг үнэний жишиг рүү чиглүүлдэг бөгөөд үүгээр бид хүлээн авдаг мэдлэгээ үнэн эсвэл худал болохыг ялган таньдаг. Бүх үнэнүүдийн үндэс суурь, эх сурвалж болсон үнэн сургаал Бурханаас ирдэг билээ. Үнэн сургаалын номлол ба зарчмууд нь бидний Их Эзэн, Аврагчийн сайн мэдээнд оршдог. Худал бүхний эцэг болох Сатанаас худал сургаалууд ирдэг юм. Тэрээр илчлэгдсэн үнэнүүдийг мушгин гуйвуулах, өөрчлөх мөн хувиргахыг хүсдэг. Мөн бидний заримыг тэнгэрлэг гэртээ буцаж очих аянаасаа замаа алдан, төөрөхөд хүргэхийн тулд тэрээр биднийг хууран мэхлэх гэж оролддог.

Судрууд нь бидэнд хуурамч сургаалуудаас хэрхэн зайлсхийж болох талаар заадаг. Жишээлбэл: Тимотид Паулын бичсэн захидлаас бид

“Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд заахад, зэмлэхэд, залруулахад, зөвт байдал дотор чиглүүлэхэд тустай.”

“Энэ нь Бурханы хүн аливаа сайн үйлд бүрэн бэлтгэгдсэн байхын тулд юм” хэмээн уншдаг (2 Тимот 3:16–17).

Гар утсанд батарей хэрэгтэй байдагтай адил сүмд энэ сургаал хэрэгтэй. Гар утаснаас батарейг нь салгачихвал гар утас хэрэггүй зүйл болно. Тэгвэл үнэн сургаалыг заадаггүй сүм үүнтэй адил хэрэггүй юм. Ийм сүм биднийг Тэнгэрлэг Эцэгтээ болон мөнхийн гэртээ эргэж очиход маань удирдаж чадахгүй.



АРАВДУГААР САР: ХРИСТТЭЙ ИЛҮҮ АДИЛ БОЛОХ НЬ

Христтэй илүү адил болоход нь бусад хүмүүст туслахдаа би судруудыг хэрхэн ашиглах вэ?

Есүс Христ бол зааж сургахын төгс үлгэр жишээ юм. Тэр Өөрийн сайн мэдээг заахдаа судрууд ашигладаг байсан. Бид сайн мэдээг бусдад заахад судрууд болон амьд бошиглогчдын үгсийг орлох зүйл гэж байхгүй хэмээн хожмын үеийн бошиглогчид бидэнд заасан. Судраас заахын тулд бид өөрсдөө тэдгээрээс суралцах ёстой. Тэгснээр бид судруудын түүх, жишээнүүдээс хуваалцаж, заах хүмүүстээ судруудыг амьдралтайгаа харьцуулахад нь тусалж чадна.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар болон материалуудыг залбирч, судал. Заах үедээ судар ашиглахыг хүсэх урмыг өсвөр үеийнхэнд юу өгөх вэ?

Матай 12:1–8; 13:38–41 (Аврагчийн судруудтай адилтгаж байгаа жишээнүүд)

Лук 4:17–27 (Назар хотын хүмүүст заахдаа Есүс судар ашигласан нь)

3 Нифай 23:1–6 (Нифайчуудад заахдаа Есүс судар ашигласан нь)

“Судруудаас заах нь,” Жэффри Р. Холланд “Сүмд заах ба сурах нь,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2007 оны 6-р сар, 94–97

“Судруудаас заах нь” *Teaching, No Greater Call* 54–59

Сайн мэдээний нэг зарчмыг заахдаа та саяхан ямар судрууд ашигласан бэ? Судруудаас судлах нь илүү сайн багш болоход танд хэрхэн тусалдаг вэ? Та заах үедээ судруудыг хэрхэн ашигладаг вэ?

Судрын ямар түүх болон захиасууд өсвөр үеийнхэнд хамгийн их хамаатай, утга учиртай байж болох вэ? Өсвөр үеийнхний хувьд заахдаа судрууд ашиглах нь яагаад чухал вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Та өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Өсвөр үеийнхнээс дуртай судраасаа ангийнхантайгаа хуваалцахыг хүс. Энэ судар нь тэдэнд яагаад чухал вэ?
- Аврагч бусдад заахдаа судрууд ашиглаж байгаа жишээнүүдийг энэ тоймд санал болгосон болон өөрсдийн мэдэж болох бусад судруудаас уншихад өсвөр үеийнхнийг урь.

Дараахтай адил асуултуудыг өсвөр үеийнхэнтэй ярилц: Аврагч заахдаа яагаад судрууд ашигласан бэ? Судрууд ашигласан нь Түүний заасан хүмүүст хэрхэн нөлөөлсөн бэ?

Өсвөр үеийнхэнд заах ямар боломжууд байдаг вэ? Өсвөр үеийнхэн заахдаа судруудыг хэрхэн ашиглаж болох вэ?

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь Христтэй илүү адил болоход нь бусдад туслахын тулд судруудыг тэд хэрхэн ашиглаж болохыг ойлгоход нь өсвөр үеийнхэнд тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

Сайн мэдээг судлах ур чадварууд

Зүүлт тайлбаруудыг ашиглах. Энэ хэсгийн эхний үйл ажиллагаан дээр судруудын зүүлт тайлбар болон суралцах тусламжуудыг ашиглахад өсвөр үеийнхнийг урамшуулсан байгаа. Тэднийг Христийн зан чанарын талаар нэг шүлэг уншаад, уг шүлгийн зүүлт тайлбар бүрийг судлан, дараах асуулганд хариулахад тэднийг урь: Зүүлт тайлбар нь уг шүлгийг ойлгох ойлголтыг маань хэрхэн нэмэгдүүлж байна вэ? Судруудаас бие даан суралцахдаа зүүлт тайлбаруудыг байнга хэрэглэж байх талаар өсвөр үеийнхэнд урамшуулан хэл.

- Судрууд дахь суралцах тусламжуудыг (зүүлт тайлбар, бүлгийн товч, сэдэвчилсэн удирдамж, Библийн лавлах гэх мэт) багшийн хувьд хэрхэн ашигладгаа үзүүл (*Teaching, No Greater Call*, 56–57-г үзнэ үү). Бусад хичээлүүд дээр сурч байгаа Христийн зан чанаруудаас нэгнийг нь талаар гэр бүлийн үдшийн хичээлд заахаар бэлтгэхдээ судруудын суралцах тусламжуудыг ашиглахад өсвөр үеийнхнийг урь. Боломжтой бол тэдний цөөн хэдийг нь бэлтгэсэн зүйлээ ангийнхантайгаа хуваалцахад урь.

- Сайн самари хүн (Лук 10:25–37) эсвэл төөрсөн хонины сургаалт зүйрлэл (Лук 15:1–7) гэх мэт судрын аль нэг түүхийг ашиглан Христтэй адил нэг зан чанарын талаар жаахан хүүхдүүдэд заах гэж байгаагаар төсөөлөхийг өсвөр үеийнхнээс хүс. *Миний сайн мэдээг номло* номын 204–206-р хуудас дээрх удирдамжийг ашиглан уг түүхээ хэрхэн заах талаар төлөвлөгөө гаргахад тэднийг урь. Боломжтой бол тэдэнд заах дадлагын цаг гаргаж өгөн, уг түүхээ хүүхдүүдэд заах боломжийг зохицуулж өг.

- *Teaching, No Greater Call*, 54–55-р хуудсаас “Provide Context” болон “Share Biographical Information” хэсгүүдийг уншихыг өсвөр үеийнхнээс хүс. Ахмад Моронай болон эрх чөлөөний тугийн талаарх түүхээс хуваалцан, судрын талаар заах үедээ хам сэдвийг нь хэрхэн өгөхийг харуул. Жишээлбэл: Алма 46:1–11 дэх мэдээллийг эхэлж тэдэнд дүгнэн ярьж өгөөд, дараа нь 12–13-р шүлгийг уншиж болох юм. Өсвөр үеийнхнээс үндсэн мэдээллийг ойлгож байх нь судрын түүхийг ойлгоход тэдэнд хэрхэн тусалдаг талаар асуу. Өсвөр үеийнхнийг нэг судар сонгон, хам сэдэв болон намтрын талаарх мэдээллийг өгөн, бусдад заах дадлага хийхэд урь.

- Судруудаас тодорхой нэг зүйлийг хайхад бусдыг хэрхэн урихыг үзүүл. *Teaching, No Greater Call* номын 55-р хуудас дээрх жишээнүүдээс хэд хэдийг та ашиглаж болох юм. Христийн зан чанарын талаар нэг судар олж, энэ судраа унших явцад суралцагчид эрж хайж болох ямар нэгэн зүйлийг таньж олоход өсвөр үеийнхнийг урь. Тэдэнд “Эрж хайх” замаар судруудыг ангидаа заах боломж олгоорой.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд бусдыг Христэд ирэхэд нь туслах хичээл зүтгэлдээ судруудыг хэрхэн ашиглаж болохыг ойлгож мэдэж байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхнээс сайн мэдээнээс суралцах болон заахаа сайжруулахын тулд ангид сурсан зүйлээ хэрхэн ашиглахыг нь асуу. Бусдад заахдаа судар ашигласан туршилагаасаа хойшдын хичээлүүд дээр хуваалцахад тэднийг урь.

Аврагчийн арга барилаар заах нь

Тэрээр хүмүүст өөрсдөд нь зориулсан судруудын талаар бодож, тэндээс асуултынхаа хариултыг олохыг заасан. Та Аврагчийн адилаар заахад өсвөр үеийнхнийг хэрхэн урамшуулж болох вэ?

Сонгосон материалууд

“Судруудаас заах нь,” Teaching, No Greater Call номоос эш татав. (1999), 54–59

Хам сэдвийг олж тогтоох

Судрын хэсгийн нөхцөл байдал буюу үйл явдлыг хам сэдэв гэж нэрлэдэг. Суралцагчид хам сэдвийг мэдсэнээрээ тухайн судрын хэсэгт ямар үйл явдал болж байгаа эсвэл юуны тухай өгүүлж байгааг илүү сайн ойлгох болно.

Хам сэдвийг олж мэдэхийн тулд дараах асуултуудыг асуу:

- Хэн ярьж байна вэ?
- Тэр хүн хэнд хандан ярьж байна вэ?
- Тэр юуны тухай ярьж байна вэ?
- Тэр хэнд хариулж байна вэ?
- Тэр үүнийг яагаад хэлж байна вэ?

Жишээлбэл: Лук 15:11–32-г алдагдсан хүүгийн тухай Аврагчийн өгүүлсэн сургаалт зүйрлэл агуулагддаг. Бошиглогч Иосеф Смит энэ сургаалт зүйрлэлийн хам сэдвийг хайн олсноороо сургаалт зүйрлэлийг ойлгож авсан гэж хэлсэн байдаг:

“Надад судруудыг ойлгох түлхүүр байдаг. Би ийм хариулт авах болсон асуулт нь юу байсан эсвэл Есүс сургаалт зүйрлэлийг хэлэх болсон шалтгаан юу вэ? гэдгийг олж мэдэхийг хүссэн. . . . Есүсийг хүмүүст зааж байхад татвар хураагчид болон нүгэлтнүүд бүгд Түүнийг сонсохоор дэргэд нь очжээ; Тэгтэл фарисайчууд болон хуулийн багш нар дургүйцэн дүнгэнэлдэж, “Энэ хүн нүгэлтнүүдийг хүлээн аван, тэдэнтэй хамт хооллодог” гэв. Энэ бол алдагдсан хүүгийн сургаалт зүйрлэлийн учгийг тайлсан гол үг юм. Энэ нь эргэлзэнгүй,

алдаа эрэлхийлэн, ‘Агуу хүний дүр эсгэсэн энэ хүн хэрхэн татвар хураагчид болон нүгэлтнүүдтэй хамт хооллож яаж чадна вэ?’ хэмээн хэлж буй садукайчууд болон фарисайчуудын дургүйцэл болон асуултуудад өгсөн хариулт байлаа. (Бошиглогч Иосеф Смитийн сургаалаас, Иосеф Фийлдинг Смит [1976], 276–277).

Бошиглогч Иосефын онцлон хэлсэнчлэн алдагдсан хүүгийн сургаалт зүйрлэлийн хам сэдэв нь уг үлгэр эхлэхээс нэлээд хэдэн шүлгийн өмнө буюу Лук 15:1–2-оос эхэлдэг. Хам сэдвийг олох нэг арга нь судалж буй судрын хэсгийнхээ өмнөх ба дараагийн шүлгүүдийг унших явдал болно. . . .

Заримдаа судар өгөгдсөн цаг үеийн улс төр, нийгэм, эсвэл эдийн засгийн түүхийг суралцах нь бас тустай байж болно. Жишээлбэл: Сургаал ба Гэрээний 121 болон 122-р бүлгүүд дээрх Их Эзэний тайтгарал болон амлалтуудыг ойлгохын тулд тэр үед гэгээнтнүүдийн Миссурид амсаж байсан зовлон зүдгүүрүүд мөн Бошиглогч Иосеф Смит болон түүний хамтрагчдын Либерти шоронд тэвчиж байсан нөхцөл байдлуудын тухай мэдэх нь тустай. Паулын захиасуудын тухай ойлголтоо нэмэгдүүлэхийн тулд бид түүний аялсан газар нутаг болон түүний хандаж бичсэн Сүмийн салбаруудын нөхцөл байдлын тухай үндсэн мэдлэгээс тусламж авч болно. Ариун Библийн толь бичиг (The Bible Dictionary) нь үүний болоод Ариун Библи дэх судрын хэсгүүдийн бусад нөхцөл байдлын талаарх мэдээллийн онцгой эх сурвалж байж чадна.

Хам сэдвийг харгалзан үзэхдээ тухайн судрын хэсгийн тухай илүү сайн ойлголтыг өгдөг зорилгын үзэл санааг алдагдуулахгүй байх нь чухал. Түүх, улс төр, эдийн засаг эсвэл судар дахь хүмүүсийн хэл яриа зэрэг хам сэдвийг хичээлийн гол санаа болгон өөрчлөхөөс болгоомжил. . . .

Сонгосон материалууд

Хувийн намтрын мэдээлэл хуваалц

Бид судар дээрх хувь хүмүүсийн амьдралыг судалж байхдаа сайн мэдээний зарчмууд урт удаан хугацааны турш ажилладгийг байнга олж мэддэг. Жишээлбэл: Мормоны номон дахь Зиезромын бүрэн түүх нь хүн наманчилж, Их Эзэнд зөв шударгаар үйлчлэх замаа үргэлжлүүлж болдгийг үзүүлдэг. Та нар Судрын удирдамж дээрх цагаан толгойн үсгийн дарааллаар байгаа сэдвүүдийн

жагсаалтын “Зиезром”-ын тухай тайлбар шүлгүүдийг уншингаа Зиезромын сүмийг эсэргүүцсэн дайралт, түүний хөрвөлт болон эцэст нь номлогч мөн сайн мэдээний багшийн эрэлхэг үйлчлэлийнх нь тухай түүхийг олж мэдэж болно. Бусад удирдамж бүхий намтруудад Рут, Давид хаан, Самуел, Естер, Төлөөлөгч Паул, Ахмад Алма, Бенжамин хаан, залуу Алма, Кориантон, Мормон ба Моронай ордог.



АРАВДУГААР САР: ХРИСТТЭЙ ИЛҮҮ АДИЛ БОЛОХ НЬ

Би заахдаа асуултуудыг хэрхэн үр дүнтэйгээр хэрэглэх вэ?

Эзэн Багш Есүс Христ Өөрийнх нь заасан зарчмуудыг тунгаан бодож мөн хэрэгжүүлэхэд хүмүүсийг урамшуулахын тулд байнга асуулт асуудаг байсан. Түүний асуултууд нь бодох, дотоод сэтгэлийн гүнд орох мөн амлахад хүргэдэг байв. Бид зааж байгаа хүмүүстээ туслахын тулд сайн мэдээний талаар бодож, ярилцаж, хэрэгжүүлэхэд нь туслах асуултуудыг тэднээс асуух талаар суралцаж чадна.

Бусдыг сайн мэдээний талаар тунгаан бодож, тэдгээрийг хэрэгжүүлэхэд нь туслахын тулд асуултууд ашигладаг бүтээлч багш нарыг та харж байсан уу? Та заахдаа асуултуудыг хэрхэн ашигладаг вэ?

Өсвөр үеийнхэн илүү сайн багш болоход нь туслах асуултуудыг асуух талаар юу ойлгох хэрэгтэй вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар болон материалуудыг залбирч, судал. Таны зааж буй өсвөр үеийнхэнд юу сүнслэгээр нөлөөлөх вэ?

Матай 7:7–11 (Залбирлын зарчмыг хэрэгжүүлэхэд бидэнд туслах асуултуудыг Аврагч асуусан нь)

Матай 16:13–17 (Петрийг гэрчлэхэд урих асуултуудыг Аврагч асуусан нь)

Матай 16:24–26 (Гүнзгий бодол төрүүлэх асуултуудыг Аврагч асуусан нь)

Алма 5:14–30 (Алма нифайчуудад заахдаа асуултууд ашигласан нь)

Дийтр Ф. Угдорф “Нигүүлсэнгүй сэтгэлт хүмүүс нигүүлслийг олдог,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2012 оны 5-р сар, 70–76

“Асуулгаар заах нь,” *Teaching, No Greater Call*, 68–70

Видео бичлэг: “Юмсыг байгаагаар нь”

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Та өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

• Өнгөрсөн долоо хоногийн туршид Христийн адил зан чанарын талаар сурч байгаа нэг зүйлийнх нь

талаарх ойлголтыг гүнзгийрүүлсэн туршлагаасаа хуваалцахад өсвөр үеийнхнийг урь.

- Хичээл орохоос долоогоос дээш хоногийн өмнө багш нарынхаа асууж буй асуултуудыг бичиж авахыг өсвөр үеийнхнээс хүс (семинар, сургууль болон сүмийн хичээлүүдэд). Тэднээс багш нарынхаа

асуултууд ашигладаг өөр өөр арга замуудын талаар ангидаа ярилцахыг хүс. Тэд үр дүнтэй байсан юуг харсан бэ? Асуулт асуух нь яагаад заах чухал хэсэг болдог вэ?

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь бусдад зааж байхдаа асуултуудыг үр дүнтэйгээр хэрхэн ашиглаж болохыг ойлгоход нь өсвөр үеийнхэнд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Энэ тоймд жагсаасан судруудаас нэгийг уншин мөн эдгээр судрууд дахь Аврагчийн асуусан асуултуудыг олоход өсвөр үеийнхэн бүрийг урь. Тэр яагаад энэ асуултуудыг асуусан бэ? Аврагч тухайн нөхцөл байдлуудад асуулт асуугаагүй бол заах байдлууд нь ямар ялгаатай байх байсан бэ? Асуулт асуух нь яагаад бусдад заах үр дүнтэй арга зам болдог вэ? Бусдад зааж болох боломжуудын талаар бодоход өсвөр үеийнхнийг урь (гэр бүлийн багшийн хувьд, ариун ёслолын цуглаан дээр, гэр бүлийн үдшээр, энгийн үед гэх мэт). Эдгээр нөхцөлд асуулт асуух нь тэдний заах чадварыг хэрхэн дээшлүүлэх вэ?

- Ангиа хэд хэдэн бүлэг болгон хуваагаад, *Teaching, No Greater Call*, 68–69 номын “General Guidelines for Preparing Questions” гарчигтай хэсэг дэх асуултын төрлүүдээс нэгийг уншуулахаар бүлэгт бүрд оноо. Өөрсдийн сурсан асуултын төрлийн талаар заахад бэлтгэхийг мөн хэзээ энэ төрлийн асуултыг асуух нь зохимжтой талаар тайлбарлахыг бүлэг бүрээс хүс. Энэ төрлийн асуултын талаарх өөрсдийн

жишээнүүдээс бодож, хуваалцахыг тэднээс хүс. Бүлгүүд нь сурсан зүйлсээ тайлбарласны дараа *Миний сайн мэдээг номло* (131–39-р хуудас) ном дахь Христийн адил зан чанаруудаас нэгийг сонгон, уг зан чанарын талаар бусдад заахдаа асууж болох асуултуудыг бичиж авах цагийг бүлэг бүрд гаргаж өгөөрэй. Асуултуудаа самбар дээр бичихэд тэднийг урь.

- Өсвөр үеийнхнийг Алма 5:14–30-ийг уншиж, “Юмсыг байгаагаар нь” видео бичлэгийг үзэх эсвэл ерөнхийлөгч Дийтр Ф. Угдорфын “Нигүүлсэнгүй сэтгэлт хүмүүс нигүүлслийг олдог” сэдэвт хэлсэн үгийг тоймлон уншихад урь. Алма болон ахлагч Бэднар эсвэл ерөнхийлөгч Угдорфын заахдаа хэрэглэдэг зарим асуултуудын жагсаалтыг гаргахыг тэднээс хүс. Эдгээр асуултууд нь биднийг сурахад хэрхэн тусалдаг вэ? Дараагийн удаа яриа өгөхийг тэднээс хүсэх үед асуултууд ашиглаж болох арга замуудын талаар бодож үзэхэд өсвөр үеийнхнийг урь.

- *Teaching, No Greater Call* номын 70-р хуудас дахь “Creative Uses of Questions” хэсгийг эсвэл өөрийн

Заахад туслах арга

“Хариултыг нь судар болон хожмын үеийн бошиглогчдын сургаалуудаас олохыг суралцагчдаас шаардах асуултуудыг асуу” (*Teaching, No Greater Call* [1999], 62).

Видео бичлэг: “Шалгах асуултууд асуух нь”

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн заасан хүмүүст юм бодуулж, ямар нэгэн зүйл мэдрүүлэх асуултуудыг асуудаг байв. Тэрээр тэднийг хайрладаг байсан учраас тэд Түүнтэй бодол санаа, хувийн асуудлаа илэн далангүй хуваалцдаг байсан. Өсвөр үеийнхэн санаа зоволтгүйгээр асуултуудад хариулах таатай уур амьсгалыг та хэрхэн бий болгож болох вэ?

санах хэдэн аргуудыг өсвөр үеийнхэнд үзүүл (Христтэй илүү адил болох нь гэсэн энэ хичээлийн сэдвийн тухай асуулт ашиглах талаар бодож үзээрэй). Асуулт асуухын тулд таны юу хийснийг олж мэдэхийг өсвөр үеийнхнээс хүсээд,

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд заахдаа асуулт хэрхэн ашиглахаа ойлгож мэдэж байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү хугацаа зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйл дээрээ тулгуурлан тэдэнд юу хийх мэдрэмж төрж байгаа талаар асуу. Тэднийг тэрхүү мэдрэмжийнхээ дагуу үйлдэхэд урамшуулан дэмж. Суралцагчид үүний дагуу үйлдэж байгаа эсэхийг шалгах аргуудыг бодож ол.

Сонгосон материалууд

Дийтр Ф.Угдорфын “Нигүүлсэнгүй сэтгэлт хүмүүс нигүүлслийг олдог” хэлсэн үгээс эш татав. Ensign эсвэл Лиахона, 2012 оны 5-р сар, 78–81

Хайрт ах эгч нар минь ээ, миний асуух дараах асуултуудыг хувийн шалгалт гэж бодоорой:

Та нар хэн нэгний эсрэг агаа хорсол өвөрлөдөг үү?

Хэдийгээр хэлж байгаа тань үнэн байж болох магадлалтай ч гэсэн та нар хов жив ярьдаг уу?

Тэд ямар нэг буруу зүйл хийсэн учир бусдыг гадуурхаж, цааш түлхэж эсвэл ялладаг уу?

Та нар далдуур хэн нэгэнд атаархдаг уу?

Та хэн нэгэнд хор уршиг учруулахыг хүсдэг үү?

Хэрэв та нар эдгээр асуултуудын аль нэгэнд тийм гэж хариулсан бол өмнө хэлсэн: Үүнийгээ зогсоо!

гэсэн хоёр үгээс бүрдэх зааврыг хэрэгжүүлж болох юм. Буруутгалаар дүүрэн, нөхөрсөг бус дэлхийд хэн нэгнийг үзэн ядаж, үл хүндлэх шалтаг олоход амархан. Гэвч хэн нэгнийг үзэн ядахаасаа өмнө бидний Багш ба үлгэр жишээ Нэгэний: “Та нарын дундаас нүгэлгүй хүн нь эхлээд энэ эмэгтэй уруу чулуу шид” гэсэн үгсийг санацгаая. [Иохан 8:7.]

Ах эгч нар аа, чулуугаа доош хаяцгаая.

Эелдэг байцгаая.

Уучилцгаая.

Бие биетэйгээ тайван амгалан ярилцацгаая.

Бурханы хайр зүрх сэтгэлийг маань дүүргэг.

“Бүх хүнд . . . сайныг үйлдэцгээе.” [Галат 6:10.]

Аврагч “Өгөгтүн, тэгвэл чамд өгөгдөх болно. Тэгэхдээ шахагдсан, чигжсэн мөн бялхсан хэмжээтэйгээр. . . . Учир нь [өөрсдийнхөө] хэмжүүрийн жишгээр та нар хариуд нь хэмжигдэх болно” хэмээн амласан юм. [Лук 6:38.]

Энэ амлалт муу муухай зан авир гаргахын оронд үргэлж эелдэг, уучламтгай, энэрэнгүй байхыг хичээх хангалттай шалтаг биш гэж үү?

Есүс Христийн шавь нарын хувьд муут сайнаар хариулдаг байцгаая. [Матай 5:39–41-ийг үзнэ үү.] Өшөө хорслыг бүү эрэлхийл, биднийг дийлэх боломж уур хилэнд бүү өг.

“Өшөө авалт нь Минийх, би буцааж төлнө” гэж Эзэн айлдав.

“Хэрэв дайсан чинь өлссөн бол түүнийг хоолло. Хэрэв тэр цангасан бол түүнд уух юм өг. . . .

“Бузар муугаар бүү дийл, харин бузар муут сайнаар дийлэгтүн.” [Ром 12:19–21.]

Эцэстээ өршөөнгүй хүмүүс өршөөл энэрлийг хүлээн авна гэдгийг санагтун. [Матай 5:7-г үзнэ үү.]

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдийн хувьд биднийг хаана ч байсан гэсэн “бие биеэ хайрладаг” хүмүүс гэдгээр нь таних болтугай. [Иохан 13:35.]



АРАВДУГААР САР: ХРИСТТЭЙ ИЛҮҮ АДИЛ БОЛОХ НЬ

Би сайн мэдээнээс суралцах талаар Аврагчийн жишээнээс юу сурч болох вэ?

Бусад бүх зүйлийн адил сайн мэдээнээс сурах төгс жишээг Есүс Христ үзүүлдэг юм. Тэр Өөрийн Эцэгийг бүрэн дүүрнээр дагаж, дуулгавартай байсан учраас Түүний “бие болон мэргэн ухаан нь өссөөр байсан бөгөөд Бурханы болон олон түмний тааллыг олжээ” (Лук 2:52). Аврагч “ач ивээл дээр ач ивээлийг” (С ба Г 93:12) хүлээн авсны адил бид сайн мэдээнээс суралцах хичээл зүтгэлдээ Бурханаас гэрэл ба мэдлэгийг тэвчээртэйгээр эрэлхийлэх ёстой.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Дараах судар болон материалуудыг залбирч, судал. Таны зааж буй өсвөр үеийнхэнд юу сүнслэгээр нөлөөлөх вэ?

Лук 2:40–52 (Есүс Христ хүү өсч, хүчирхэг болж, мэргэн ухаанд боловсорсон)

Иохан 5:30 (Есүс Христ үргэлжид Эцэгийнхээ хүслийг эрэлхийлдэг байсан)

1 Коринт 2:14 (Төрөлх хүн Сүнсний зүйлсийг хүлээж авдаггүй)

С ба Г 1:26–28; 112:10 (Хэрвээ бид даруу мөн хүсэлтэй байх аваас Их Эзэн бидэнд заах болно)

С ба Г 93:11–20 (Аврагч хүлээн авсны адилаар бид ач ивээл дээр ач ивээлийг хүлээн авч чадна)

С ба Г 130:18–19 (Бид хичээл зүтгэл болон дуулгавартай байдлаараа дамжуулан мэдлэг мөн оюун билгийг эзэмшдэг)

Ричард Г. Скотт “Сүнслэг мэдлэгийг олж авах нь,” *Ensign*, 1993 оны 11-р сар, 86–88.

Роберт Р. Стоиер “Хүлээцтэйгээр заалгах нь,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2002 оны 5 сар, 31–32

Та Христийнхтэй адил ямар зан чанарууд нь сайн мэдээнээс суралцахад чухал гэж бодож байна вэ? Эдгээр зан чанаруудыг хөгжүүлэх нь сайн мэдээнээс суралцах болон заах хичээл зүтгэлд тань хэрхэн тусалсан бэ?

Өсвөр үеийнхэн Аврагчийн талаар, сайн мэдээний илүү сайн суралцагчид болоход нь туслах юуг ойлгох хэрэгтэй вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Та өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний

нөлөөг олж харахад нь тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Өсвөр үеийнхнийг хувиараа суралцахдаа Аврагчийн талаар сурч байгаа ямар нэг зүйлээ хуваалцахад урь. Түүнтэй илүү адил болохын тулд тэд юу хийж байна вэ?
- Есүс Христийн зан чанаруудыг самбар дээр жагсаан бичихийг өсвөр үеийнхнээс хүс (санаа авахын

тулд *Миний сайн мэдээг номло*143-р хуудсыг үзнэ үү). Эдгээр зан чанаруудаас аль нь бидэнд сайн мэдээний илүү сайн суралцагчид болоход тусална гэж өсвөр үеийнхэн бодож байна вэ? Хариултуудаа тайлбарлаж, Аврагчийн эдгээр зан чанарыг харуулсан арга замуудын жишээ хэлэхийг тэднээс хүс.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь Христийн адил зан чанаруудыг хөгжүүлснээр тэднийг сайн мэдээний илүү сайн суралцагчид байхад туслах болно гэдгийг ойлгоход нь өсвөр үеийнхэнд тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Ангиараа дараах судруудаас нэг буюу түүнээс олныг унш: Лук 2:40–52; Иохан 5:30; Сургаал ба Гэрээ 93:11–20. Эдгээр шүлгүүдээс Аврагчийн жишээ болгон үзүүлснээр сайн суралцагчид байх шинж чанаруудыг олоход өсвөр үеийнхнийг урь. Олж мэдсэн зүйлсээ болон өөрсдийн амьдралд хөгжүүлмээр байгаа сайн суралцагчийн өөр бусад шинж чанаруудын талаар хуваалцахыг тэднээс хүс.
- Судрын дараах эшлэлүүдийг самбар дээр бич: Иохан 5:30; С ба Г 1:26–28; 112:10; 130:18–19. Өсвөр үеийнхэн бүрийг эдгээр эшлэлүүдээс нэгийг сонгон уншин, судар дахь сайн суралцагчийн зан чанарыг олохыг хүс. Сайн мэдээг сурахад эдгээр зан чанар нь яагаад чухал вэ? Өсвөр үеийнхнийг эдгээр зан чанарыг судраас суралцахдаа хэрэгжүүлэх арга замуудыг төлөвлөхөд урь.

- Ахлагч Ричард Г. Скоттын “Сүнс-лэг мэдлэгийг олж авах нь” хэлсэн үгээс сүнс-лэг мэдлэгийг олж авах дөрвөн зарчмын нэгнийх нь талаар уншихад ангийн гишүүн бүрийг урь. Өсвөр үеийнхнээс ахлагч Скоттын захиасаас сурах талаар олж мэдсэн зүйлээ хуваалцахыг хүс. Аврагч эдгээр зарчмуудыг ямар арга замуудаар харуулсан бэ? Сайн мэдээнээс суралцахдаа эдгээр зарчмыг хэрэгжүүлж болох арга замуудыг хуваалцахад тэднийг урь.
- Өсвөр үеийнхнийг ахлагч Ричард Р. Стоиерын “Хүлээцтэйгээр заалгах нь” хэлсэн үгийг уншихад урь. Тэднээс ахлагч Стоиерын судрын жишээнээс өөрсдөд нь сонирхолтой санагдах жишээг сонгохыг хүс. Судруудаас түүх олж (хэлсэн үг дэх эшлэлүүдийг ашиглан), үүний талаар үргэлжлүүлэн уншиж мөн уншсан зүйлээ ангийн бусад гишүүдтэй хуваалцахад тэднийг урь. Тэд эдгээр түүхээс хялбархан

Сайн мэдээг судлах ур чадварууд

Есүс Христийн зан чанаруудыг эрэлхийлэх нь. Энэ хэсгийн эхний үйл ажиллагаа нь өсвөр үеийнхнийг Христийн зан чанаруудыг судруудаас хайхад урьдаг. Судраа унших бүрдээ үүнийг хийхэд өсвөр үеийнхнийг урамшуул. Дараах асуултуудыг тэд өөрсдөөсөө асууж болох юм: “Би Есүс Христийн талаар юу сурч байна вэ? “Түүнтэй илүү адил болохын тулд би амьдралдаа юуг өөрчлөх хэрэгтэй байна вэ?”

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч заадаг хүмүүс-
тээ хайртай байсан.
Тэрээр тэдний төлөө
залбирч, үргэлж тэдэнд
үйлчилдэг байв. Заах
өсвөр үеийнхнийхээ
төлөө залбирч, тэдэнд
үйлчлэх нь таны тэдний
төлөөх хайрыг мэдрэхэд
нь хэрхэн туслах вэ? Энэ
таны заах чанарт хэрхэн
нөлөөлөх вэ?

сурах талаар юу сурч авсан бэ? Тэд чадах вэ? Тэд өөрсдөө сайн мэдээ-
өөрсдийн амьдралаас үүнтэй адил нээс суралцахдаа эдгээр жишээг
ямар жишээнүүдийг хуваалцаж хэрхэн дагаж чадах вэ?

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд Христтэй илүү адил болох нь сайн мэдээний илүү сайн суралцагчид болоход хэрхэн туслахыг ойлгож мэдэж байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйл дээрээ тулгуурлан тэдэнд юу хийх мэдрэмж төрж байгааг асуу. Тэднийг тэрхүү мэдрэмжийнхээ дагуу үйлдэхэд урамшуулан дэмж. Суралцагчид үүний дагуу үйлдэж байгаа эсэхийг шалгах аргуудыг бодож ол.

Сонгосон материалууд

Ричард Ж. Скоттын “Сүнслэг мэдлэгийг олж авах нь,” хэлсэн үгээс эш татав. *Ensign*, 1993 оны 11-р сар, 86–88, эсвэл Лиахона, 1994 оны 1-р сар, 86–88

Даруу байдал нь сүнслэг мэдлэгийг танин мэдэхэд маш чухал билээ. Даруу байх гэдэг нь үг авдаг байх гэсэн үг юм. Даруу байдал нь та нарт Сүнсээр сургагдаж, судрууд зэрэг Их Эзэнээр урамшуулагдсан эх сурвалжуудаар заагдах боломж олгодог. Хувийн өсөлт хийгээд ойлголтын үр нь даруу байдлын үржил шимтэй хөрсөнд соёолж мөн ургаж цэцэглэдэг билээ. Үр жимс нь та нарыг энд болоод ирэх амьдралд удирдах сүнслэг мэдлэг юм.

Бардам хүн Сүнсний зүйлсийг мэдэж чадахгүй. Паул энэ үнэнийг зааж.

“Түүнчлэн Бурханыхыг Бурханы Сүнснээс өөр хэн ч мэддэггүй. . . .

“Харин төрөлх хүн Бурханы Сүнсний зүйлсийг хүлээж авдаггүй. Учир нь тийм хүнд эдгээр нь мунхаг явдал бөгөөд эдгээрийг ойлгож чадахгүй. Яагаад гэвэл эдгээр нь сүнслэгээр үзэгддэг” гэж хэлжээ (1 Коринт 2:11, 14).

Үнэ цэнэтэй мэдлэгийг олж авах мөн ашиглахад асар их хувийн хичээл зүтгэл шаардлагатай тул та нар амьдралын сэтгэл татам бүхнээс эцэс төгсгөлгүй турших боломжгүй. Тиймээс, та нар

чухал үнэнүүдээс суралцахад мөн хуваалцахад гол анхаарлаа хандуулах хэдэн чухал хэсгийг анхааралтай сонгох ёстой. Агуу үнэ цэнэтэй мэдлэгийг олж авахын тулд ер бусын хувийн хичээл чармайлт шаардагддагийг би мэднэ. Ялангуяа бидний хүсэл нь сүнслэг мэдлэгийг олж авах явдал тул энэ нь бодит үнэн юм. Ерөнхийлөгч Кимбалл хэлэхдээ:

“Ерөнхий боловсрол, сүнслэг мэдлэг хоёрын үнэт эрдэнэс нь нуугдмал байдаг. Тиймээс тэдгээрийг зохих ёсоор хайн судалж, олохыг эрмэлзээгүй тэднээс байнга нуугдмал байх болно. . . . Сүнслэг мэдлэг нь ганц асууснаар боломжтой болохгүй; бүр залбирлууд ч хангалттай биш. Энэ нь хэн нэгний амьдралаас цөхрөлтгүй оролдлого, бүхнээ зориулах хүслийг шаарддаг. . . . Мэдлэгийн бүх эрдэнэсээс хамгийн чухал нь Бурханы мэдлэг юм” гэжээ (*The Teachings of Spencer W. Kimball*, хуудас 389–390).

Бригам Янг Иосеф Смитийг анхааралтай сонсоноор үнэнийг сурч, үг, жишээ мөн Сүнсээр заагдсан бүгдийг ойлгохыг хичээж байлаа. Суралцсаны үр дүнд үе удмуудыг адисалсан билээ. Энэ нь Бригам Янгийг нэмэлт үнэнүүдийг сурч, Иосеф Смитээс биечлэн хүлээн авсан зүйлээсээ хамаагүй илүү ихийг хуваалцахад бэлтгэсэн юм. Түүний жишээг дага.

БҮЛГИЙН ТОВЧ ТОЙМ

Арваннэгдүгээр сар: Сүнслэг ба материаллаг байдлын хувьд бие даах нь

“Хүч тэдэнд буй, үүгээр тэд өөрсдийнхөө төлөө сонгогчид юм” (С ба Г 58:28).

Энэ бүлгийн тоймууд сүнслэг байдлын хувьд бие даахад шаардлагатай чадваруудыг хөгжүүлэхэд нь өсвөр үеийнхэнд тусална. Тэд мөн материаллаг байдлын хувьд бие даасан байх гэдэг нь юу гэсэн үг болох талаар мэдэж авна. Өдөр бүр тэдэнд тулгарах уруу таталтыг ялан дийлэхийн тулд тэд өөрсдийн гэсэн гэрчлэлтэй байх хэрэгтэй. Тэд үргэлж бусдын гэрчлэл дээр тулгуурлаад байж чадахгүй. Та тэдэнд хэрхэн сайн мэдээний талаарх асуултууддаа хариулт олж, үнэний талаар өөрийн гэсэн гэрчлэлтэй болохыг сурахад нь тусалж чадах юм. Тэд бие даасан байдалтай болох тусам тусламж хэрэгтэй хүмүүст үйлчилж, халамжлахдаа илүү бэлтгэлтэй байх болно.

Энэ сард сонгох хичээлийн тоймууд:

Би сүнслэг байдлын хувьд хэрхэн бие даах чадвартай болох вэ?

Би сайн мэдээний талаарх асуултуудынхаа хариултыг хэрхэн олж чадах вэ?

Би эргэлзээгээ хэрхэн итгэлээр давж чадах вэ?

Би өөрөө хэрхэн шийдвэр гаргаж сурах вэ?

Зорилго тавих нь бие даах чадвартай болоход маань надад хэрхэн туслах вэ?

Би санхүүгийн хувьд бие даасан байхад хэрхэн бэлтгэх вэ?

Би хэрхэн Бурханы гэрчлэгч болж зогсох вэ?



АРВАННЭГДҮГЭЭР САР: СҮНСЛЭГ БА МАТЕРИАЛЛАГ
БАЙДЛЫН ХУВЬД БИЕ ДААХ ЧАДВАР

Би сүнслэг байдлын хувьд хэрхэн бие даах чадвартай болох вэ?

Сүнслэг байдлын хувьд бие даах нь бидний мөнхийн сайн сайханд зайлшгүй чухал. Бид сүнслэг байдлын хувьд бие даах үед бидний гэрчлэл бусдын гэрчлэл дээр тулгуурладаггүй. Бид өдөр бүр залбирч, судраас суралцан, Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэн өөрсдийн сүнслэг туршлагыг эрэлхийлдэг. Бид тулгарсан хүнд асуудлуудаа шийдэхдээ Тэнгэрлэг Эцэгийн тусламжийг хүсэн Түүнд ханддаг. Түүнчлэн бид сүнслэг байдлын хэрэгцээ гарах үед нь бусдыг хүчирхэгжүүлж чаддаг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Та сүнслэг байдлын хувьд илүү бие даах чадвартай болохын тулд юу хийж байна вэ? Сүнслэг байдлын хувьд бие даах чадвартай байснаар та хэрхэн адислагдсан бэ?

Өсвөр үеийнхэн сүнслэг байдлын хувьд бие даах чадвартай болохын тулд юу хийж чадах вэ? Өсвөр үеийнхэн сүнслэг байдлын хувьд илүү бие даах чадвартай болсноор тэдэнд ямар ашиг тустай вэ?

Эдгээр судар болон бусад материалыг залбирч судална уу. Сүнслэг байдлын хувьд бие даах чадвартай болохын ач холбогдлыг ойлгоход өсвөр үеийнхэнд юу туслах вэ?

Матай 25:1–13 (Арван онгон охины сургаалт зүйрлэл)

Мормон 9:27 (Бид өөрсдийн авралыг гүйцээх хэрэгтэй)

Моронай 10:3–5 (Бид үнэнийг өөрсдөө мэдэж авч чадна)

С ба Г 58:26–28 (Бид туйлын зөв шударга байдлыг тохиолгохоор өөрсдөө сонгох ёстой)

С ба Г 130:18–19 (Хичээл зүтгэл, дуулгавартай байдал нь илүү мэдлэг, оюун билгийг хуримтлуулахад бидэнд тусалдаг)

Дийтр Ф.Угдорф, “Хувийн гэрчлэлийн хүч,” *Ensign* эсвэл *Лиахона* 2006 оны 11-р сар, 37–39

Жорг Клэбингат, “Бурханы сэнтий рүү дөхөж очихдоо өөртөө итгэлтэй байх нь,” *Ensign* эсвэл *Лиахона* 2014 оны 11-р сар, 34–37

Дэвид А.Бэднар, “Их Эзэнд хөрвүүлэгдэв,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2012 оны 11 сар, 106–9

“Мэргэн тэд нь” видео бичлэг; түүнчлэн *Doctrine and Covenants and Church History Visual Resource DVD*-г үзнэ үү.

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээл эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Та өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Өсвөр үеийнхнийг ням гаргийн хичээлд сурч байгаа зүйлээ мөн сайн мэдээнээс хувиараа суралцахдаа хэрэгжүүлсэн ямар нэг зүйлийн талаар хуваалцахад урь.
- Энэ хичээлийн эхэнд байгаа догол мөрийг уншихыг ангийн нэг

гишүүнээс хүсэн, бусад гишүүнийг “Сүнслэг байдлаар бие даах гэдэг нь юу гэсэн үг вэ?” гэсэн асуултын хариултыг олж сонсоход урамшуул. Уг асуултын хариултыг бичиж авах цөөн хэдэн хормыг ангийн гишүүдэд гаргаж өгөөд, хариултуудаа хуваалцах боломжийг тэдэнд олго.

Сайн мэдээг судлах чадварууд

Хичээлийн дүгнэлт.
Энэ хэсгийн эхний үйл ажиллагаа болгож, өсвөр үеийнхнийг Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээс юу уншсан талаар товч дүгнэлт бичихэд урина. Тэд уг хэлсэн үгийн захиасыг ойлгож байгаа эсэхийг бататгахад энэ нь тэдэнд туслах юм. Түүнчлэн тэднийг уг захиасыг амьдралдаа хэрэгжүүлэхэд урь; “Их Эзэн намайг энэ хэлсэн үгээс юу сураасай гэж хүсч байна вэ?” гэхчлэн асууснаар тэд үүнийг хийж чадна. Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээс суралцах бүрдээ ийнхүү үйлдэхэд өсвөр үеийнхнийг урамшуулан дэмж.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь өсвөр үеийнхэнд сүнслэг байдлын хувьд хэрхэн илүү бие даах чадвартай болоход суралцахад нь туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

- Бурханы сэнтий рүү дөхөж очихдоо өөртөө итгэлтэй байх нь хэмээх ахлагч Жорг Клэбингатын хэлсэн үгийн эхний догол мөрөөс асуултауд сонгон, өөрсдөө хариулахад өсвөр үеийнхнийг урь. Бүх өсвөр үеийнхнийг ахлагч Клэбингатын санал болгосон 6 зүйлээс нэгийг судлахад урьж, энэ нь сүнслэг байдлын хувьд илүү бие даах чадвартай болоход хэрхэн тусалж чадах талаар ангийнхандаа тайлбарлахыг тэднээс хүс.
- Бүх өсвөр үеийнхнийг энэ тоймд санал болгосон судруудаас нэгийг уншихад урь. Өсвөр үеийнхэнд судар унших цаг гаргаж өгснийхөө дараа тэднийг хоёр хоёроор нь хуваарилан, бие биенээсээ

дараахтай адил асуултууд асуухад урь: Чиний уншсан сударт юу гэж бичсэн байсан бэ? Чи эдгээр шүлгээс сүнслэг байдлын хувьд бие даах чадвартай болох тухай юу сурч авсан бэ? Уншсан зүйлдээ үндэслээд юу хийхээр сүнслэгээр өдөөгдөж байна вэ? Өсвөр үеийнхэнд ангийнхнаасаа асуулт асуух боломж олгоорой.

- Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын “Хувийн гэрчлэлийн хүч” хэлсэн үгэн дэх “Бид хэрхэн гэрчлэлтэй болдог вэ?” гарчигтай хэсгийг уншихыг өсвөр үеийнхнээс хүс. Бид өөрийн гэсэн гэрчлэлтэй байх нь яагаад чухал вэ? Өсвөр үеийнхнийг сайн мэдээний үнэний талаарх гэрчлэлээ хэрхэн олж авсан талаар

хуваалцахад урь. Та өөрийн гэсэн гэрчлэлтэй болоход ямар адислалууд ирсэн талаар гэрчлээрэй. Энэ ярилцлагын нэг хэсэг болгож, ерөнхийлөгч Томас С.Монсоны хэлсэн үгээс дараах хэсгийг хуваалцаж болох юм: “Биднийг буруу зүгт татах бүх хүчийг эсвэл буруу зам руу урин дуудах дуу хоолойнуудыг сөрөн, хүчтэй байж, гуйвалтгүй зогсохын тулд бид гэрчлэлтэй байх нь чухал юм. Та нар 12-той юм уу 112-той эсвэл эдгээрийн хоорондох настай ч бай, Есүс Христийн сайн мэдээ үнэн гэдгийг өөрсдөдөө мэдэж авч чадна” (“Ганцаар зогсох зоригтой бай,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2011 оны 11 сар, 62). Өсвөр үеийнхэн

сүнслэг байдлын хувьд бие даах чадвартай болохын тулд өөр ямар зүйлүүдийг хийж болох вэ?

- Өсвөр үеийнхнийг Матай 25:1–13-ыг уншихад эсвэл “Мэргэн тэд нь” видео бичлэгийг үзэхэд урь. Өсвөр үеийнхэн энэ сургаалт зүйрлэлээс сүнслэг байдлын хувьд бие даах чадвартай болох талаар юу сурч авсан бэ? Энэ ярилцлагын нэг хэсэг болгож, ахлагч Дэвид А.Бэднарын “Их Эзэнд хөрвүүлэгдэв” хэлсэн үгийн “Тэрчлэл, хөрвүүлэлт болон арван онгон охины сургаалт үлгэр” гарчигтай хэсгийг уншихад өсвөр үеийнхнийг урь. Өөрсдийн дэнлүүнд тос нэмэхийн тулд өсвөр үеийнхэн юу хийж чадах вэ?

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нартаа итгэж, тэднийг бэлтгээд, заах, адислах мөн бусдад үйлчлэх чухал үүргүүдийг тэдэнд оноосон. Та өсвөр үеийнхнийг сурсан зүйлээ бусдад заахад нь хэрхэн бэлтгэж чадах вэ?

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд сүнслэг байдлын хувьд хэрхэн бие даах чадвартай болох талаар ойлгосон уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхэнд өнөөдөр сурсан зүйлээсээ юу хийх мэдрэмж төрж байгаа талаар тэднээс асуу. Тэрхүү мэдрэмжийнхээ дагуу үйлдэхэд тэднийг урамшуулан дэмж. Суралцагчид үүний дагуу үйлдэж байгаа эсэхэд хяналт тавих аргуудыг бодож ол.

Сонгосон материалууд

Диймр Ф.Угдорф, "The Power of a Personal Testimony," Ensign эсвэл Liahona, 2006 оны 11-р сар, 38–39-өөс эш татав

Гэрчлэл бол хамгийн үнэ цэнтэй зүйл юм. Учир нь бид түүнийг оюун ухаан, зүй тогтлоор олж авч чадахгүй. Мөн дэлхийн эд зүйлсээр худалдаж авч чадахгүй. Өвөг дээдсээсээ ч өвлөн авч чадахгүй. Мөн тэд үүнийг бидэнд бэлэг болгон өгч чаддаггүй. Бид бусад хүний гэрчлэлд найдаж болохгүй. Бид өөрсдөө л бүх зүйлийг мэдэж авах хэрэгтэй. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли 'Хожмын үеийн гэгээнтэн бүр Есүс бол амьд, Бурханы амилсан Хүү гэдгийг ямар ч эргэлзээгүй, баттай мэдэж авах үүрэг хариуцлагатай' гэж хэлсэн ("Fear Not to Do Good," Ensign, 1983 оны 5-р сар, 80). . . .

Ариун Сүнс энэ гэрчлэлийг бидний сүнсэнд хэлж өгснөөр бид мэдэж авдаг. Бид ёс заншил, арьс өнгө, хэл, эдийн засгийн нөхцөл байдлаасаа үл хамааран тайван, эргэлзээгүй, үнэн, бат мэдлэгийг өөрсдийн гэрчлэлийн уг сурвалж болгон хүлээн авдаг. Сүнснээс ирдэг энэхүү шивнээ нь хүмүүний оюун ухаанаас илүүтэйгээр бидний гэрчлэлийн үнэн, бат суурь болж өгдөг юм.

Энэхүү гэрчлэлийн гол цөм нь Есүс Христэд итгэх итгэл, Түүний тухай мэдлэг, Түүний тэнгэрлэг номлол бөгөөд судруудад Тэр өөрийнхөө тухай "Би бол зам, үнэн амь мөн" (Иохан 14:6) гэж хэлсэн байдаг.

Тэгвэл бид Ариун Сүнсээр ирдэг хувийн гэрчлэлийг хэрхэн хүлээж авах вэ? Загварууд нь судруудад бичигдсэн.

Нэгдүгээрт: Итгэх хүсэлтэй бай. Мормоны Номонд биднийг урамшуулан, "Та нар бүр миний үгсийг туршин, сэрж мөн чадвараа сэргээх аваас, мөн итгэлийн жижиг хэсгийг ч гэсэн бодит болговол, . . . бүр та нарт итгэх хүслээс илүү нь байхгүй ч гэсэн" (Алма 32:27) гэсэн байдаг.

Зарим нь "Би итгэж чадахгүй. Би шүтлэгтэй хүн биш" гэж хэлж магадгүй. Хэрвээ бид итгэсэн мэт хоосон дүр үзүүлэх хүсэлгүй, харин үнэн, чин сэтгэлээсээ итгэх хүсэлтэй байвал Бурхан бидэнд тэнгэрлэгээр тусална гэж амласныг санах хэрэгтэй.

Хоёрдугаарт: Судраас суралц. Асуултууд тавь. Тэдгээрийг судал. Хариултуудыг судраас эрж хай. Дахиад Мормоны Номын бидэнд өгсөн бас нэгэн сайхан зөвлөгөө байдаг. Хэрэв та нар Бурханы үгийг хичээнгүйлэн судалснаар "зүрх сэтгэлд тань үр суулгагдаж болохын тулд зай тавьж өгвөөс," хэрэв та итгэлгүй байдлаар эсэргүүцэхгүй аваас сайн үр нь "та нарын цээжинд өсөж эхлэх болно." Сайн үр "[та нарын] бодгалийг тэлж," "ойлголтыг [тань] гэгээрүүлж эхлэх" (Алма 32:28) болно.

Гуравдугаарт: Бурханы хүслийн дагуу үйлд; зарлигуудыг сахь. Бид Бурханы хаант улс газар дэлхий дээр сэргээгдсэн тухай өөрсдөө олж мэдэж авахыг хүсвэл харилцан мэдээлэл солилцон, маргалдах нь хангалтгүй юм. Хайнга байдлаар суралцах нь ч бас хангалтгүй. Бид өөрсдөө үүнийг хийх ёстой. Энэ нь өөрсдөө судлаад, тэгээд Бурханы хүслийг дагана гэсэн үг юм.

Бид Христэд ирж, Түүний заасныг дагах хэрэгтэй. Аврагч бидэнд "Миний сургаал бол Минийх биш, харин Намайг Илгээгчийнх. Хэрэв хэн нэгэн Түүний хүслийг үйлдэхийг хүсэж байвал тэр нь энэ сургаал Бурханаас ирсэн үү, эсвэл Би Өөрөөсөө ярьж байна уу гэдгийг мэднэ" (Иохан 7:16) гэж заасан. Тэгээд тэр "Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь" (Иохан 14:15) гэж хэлжээ.

Дөрөвдүгээрт: Тунгаан бод, мацаг барь, залбир. Бид Ариун Сүнснээс мэдлэг хүлээн авахын тулд Тэнгэрлэг Эцэгээс үүнийг гуйх ёстой. Бид Бурхан бидэнд хайртай бөгөөд Ариун Сүнсний шивнээг танихад маань туслах болно гэдэгт итгэх ёстой.



АРВАННЭГДҮГЭЭР САР: СҮНСЛЭГ БА МАТЕРИАЛЛАГ
БАЙДЛЫН ХУВЬД БИЕ ДААХ ЧАДВАР

Би сайн мэдээний талаарх асуултуудынхаа хариултыг хэрхэн олох вэ?

Сүнслэг байдлын хувьд бие даах чадвартай болохын нэг хэсэг нь сайн мэдээний талаарх асуултууддаа хариулт авч сурах явдал юм. Бид өөрсдийн чин сэтгэлийн асуултад хариултыг хичээнгүйлэн эрэлхийлж, Аврагчийн өгсөн “Гуй, тэгвэл та нарт өгнө; хай, тэгвэл та нар олно; тогш, тэгвэл та нарт нээгдэнэ” (Матай 7:7) гэсэн амлалтад итгэх үед илчлэлт тохиодог. Бид залбирч, судрууд болон амьд бошиглогчдын үгсээс суралцан, Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийлэх үедээ сайн мэдээний талаарх асуултууддаа хариулт авч чадна.

Асуултууддаа хариулт эрэлхийлэх нь таныг сайн мэдээнээс суралцахад ямар үүрэг гүйцэтгэсэн бэ? Асуултууддаа ямар арга замаар хариулт олж авч байсан бэ?

Өсвөр үеийнхэн сайн мэдээний талаар ямар асуултууд тавьж байсан бэ? Та сайн мэдээний талаарх асуултуудын хариултыг эрэлхийлэхэд нь өсвөр үеийнхнийг хэрхэн урамшуулж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалыг залбирч, судал. Өсвөр үеийнхнийг Сайн мэдээний талаарх асуултуудын хариултыг эрэлхийлэхэд нь юу урамшуулах вэ?

1 Нифай 15:2–11 (Лемен, Лемүел хоёрт асуулт байсан ч Их Эзэнээс асуугагүй)

Алма 40:1–12; Ифер 2:18–23; Иосеф Смит—Түүх 1:10–18 (Асуултууддаа хариулт эрэлхийлж байгаа хүмүүсийн жишээ)

С ба Г 6:14–15 (Бид Их Эзэнээс асуух үед Сүнс бидний оюуныг гэгээрүүлдэг)

С ба Г 9:8–9 (Бидэнд асуулт байвал түүнийгээ оюундаа тунгаан бодоод энэ нь зөв эсэхийг Их Эзэнээс асуух ёстой)

Жэффри Р.Холланд, “Эзэн минь, би итгэж байна,” *Ensign* эсвэл 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган

Дийтр Ф.Угдорф, “Усан доторх тусгал,” Залуучуудад зориулсан СБС-ийн галын дэргэдэх ярилцлага, 2009 оны 11-р сарын 1; түүнчлэн уг хэлсэн үгийн видео бичлэгийг үзнэ үү

“Бодгалийн тухай асуултуудад Мормоны ном хариулдаг,” *Миний сайн мэдээг номло* (2004), 121–22

Жэймс Б.Мартино, “Түүн рүү эргэ, хариулт ирэх болно,” *Ensign* эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 47

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээл эсвэл найзуудтайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Та өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Өсвөр үеийнхнийг нэг газар байхдаа сурсан нэг зүйл нь (хувиараа судраас суралцах, гэр бүлийн үдэш, семинар гэхчлэн) өөр нэг газар байхад сурсан зүйлийг ойлгоход нь тэдэнд хэрхэн тусалж байсан талаар хуваалцахад урь.
- Өсвөр үеийнхнийг амьдрал эсвэл шашны талаар хүмүүсийн олонтоо асуудаг асуултуудын жагсаалт гаргахад урь (*Миний сайн мэдээг номло,*

117-р хуудсаас зарим жишээг үзнэ үү). Асуулт гарах үед юу хийгээсэй хэмээн Их Эзэн биднээс хүсдэг вэ? Суралцагчдыг хичээлийн туршид эдгээр асуултын талаар бодоход урамшуулаарай. Эдгээр асуултад хариулахын тулд ангидаа их цаг зарцуулах хэрэггүй, харин хариултаудыг бие даан эрэлхийлэхэд нь өсвөр үеийнхэнд туслах зарчмуудыг заахад анхаарлаа хандуулаарай.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь сайн мэдээний асуултууддаа хариулт хэрхэн олох талаар сурахад нь өсвөр үеийнхэнд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Ангийн гишүүдийг ахлагч Жэймс Б.Мартиногийн “Түүн рүү эргэ, хариулт ирэх болно” хэлсэн үгийг судлахад урь. Бид Мозаягийн хөвгүүд болон Лемен, Лемеүл хоёрын тухай түүний түүхээс асуултууддаа хариулт хүлээн авах тухай юуг сурч болох вэ? Та ангийн гишүүдийг уг хүмүүсийн гаргаж байсан авир, тэдний үйлдлүүдийн үр дагаврын ялгаануудыг жагсааж бичээд, энэ хоёр түүхийн ялгааг харьцуулж үзэхэд урьж болно. Та мөн ангийн гишүүдийг асуултууддаа хариулт хүлээн авсан туршлагаа хуваалцахад урьж болно.

- Дараах судруудыг уншихад өсвөр үеийнхнийг урь: Матай 7:7; С ба Г 6:14–15; 9:7–9. Асуулт тавьж, хариулт авах талаар эдгээр шүлгийн зааж байгаа зарчмуудыг хамтдаа жагсаан бич. Их Эзэн яагаад бидний хариултуудад тэр даруйд нь, бүрэн дүүрнээр үргэлж хариулдаггүй вэ? Сайн мэдээний талаар танд асуух зүйл байж, хариултыг нь хүлээн авч байсан тэр үеийнхээ тухай өсвөр үеийнхэнд ярьж өгөх талаар бодож үзээрэй. Тэднээс бас тиймэрхүү туршлага байвал хуваалцахыг хүс.

- Асуулт тавиад, илчлэлт хүлээн авсан тухай судрууд дахь

Заахад туслах арга

Ангийн нэг гишүүнтэй хэд хоногийн өмнөөс холбоо бариад, түүнийг уг хичээлийг бүхэлд нь эсвэл заримыг нь заахад урих талаар бодож үзээрэй. Заахад бэлтгэхдээ эдгээр сурах тоймыг ашиглахад өсвөр үеийнхнийг урамшуулан дэмж.

хүмүүсийн талаар бодохыг өсвөр үеийнхнээс хүс (шаардлагатай бол энэ тоймд санал болгосон судруудыг лавлаж үзэж болно). Судрууд дахь эдгээр хүний талаар уншиж, тэдний тавьсан асуултуудыг, асуултууддаа хэрхэн хариулт эрэлхийлснийг мөн тэдний хүлээн авсан хариултуудыг олж мэд. Тэднийг олж мэдсэн зүйлээ ангийнхантайгаа хуваалцахад урь. Тэд эдгээр туршлагаас асуух талаар өөр ямар зарчмуудыг сурч болох вэ? Өсвөр үеийнхэн асуултууддаа эдгээр зарчмыг хэрхэн хэрэгжүүлж болох вэ?

- Ангийн нэг гишүүнээс Марк 9:14–27 дахь түүхийг ярьж өгөхөд бэлдэж ирэхийг хүс эсвэл уг түүхийг ангиараа уншиж болно. Ангиа гурван бүлэг болгож хуваан ахлагч Жэффри Р.Холландын “Эзэн минь, би итгэж байна” хэлсэн үгэн дэх түүхээс ажигласан гурван зүйлийг нэг нэгээр нь уншуулахаар оноо. “Өөрсдөд нь эсвэл тэдний мэдэх хэн нэгэнд сайн мэдээний талаар асуулт, эргэлзээ байвал тэд ахлагч Холландын ажигласан зүйлсийг хэрхэн ашиглаж болох вэ?

- Дараах асуултуудыг самбар дээр бич: Их Эзэн яагаад биднийг асуулт тавьдаг хүмүүс байгаасай гэж хүсдэг вэ? Сайн мэдээний талаар асуух, сайн мэдээний үнэнд эргэлзэх хоёр нь хоорондоо ямар ялгаатай вэ? Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын “Усан доторх тусгал” хэлсэн үгийн “Энэ нь үнэн үү?” хэсгээс эдгээр асуултын хариултыг олоход өсвөр үеийнхнийг урь. Тэд ерөнхийлөгч Угдорфын хэлсэн үгийн энэ хэсгээс өөр юу сурсан бэ?

- “Миний сайн мэдээг номло” номын “Бодгалийн тухай асуултуудад Мормоны ном хариулдаг” (хуудас 121) хэсгийн эхний дөрвөн догол мөрийг ангиараа унш. Тэд өөрсдөө эсвэл тэдний мэдэх хэн нэгний тавьсан асуултыг уг асуултуудын жагсаалтаас сонгоход ангийн гишүүн бүрийг урь. Өсвөр үеийнхэнд сонгосон асуултынхаа талаарх Мормоны Номын захиасыг унших цаг гаргаж өгөөрэй. Тэднээс олж мэдсэн хариултуудаа хуваалцаж, бусдын иймэрхүү асуултад хариулахад нь туслахаар Мормоны Номыг хэрхэн ашиглаж болохыг тайлбарлахыг хүс.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн зааж байсан хүмүүсийг судрын талаар өөрсдөө тунгаан бодож, өөрсдөдөө байгаа асуултуудын хариултыг тэдгээрийг ашиглан олоход урамшуулдаг байсан. Таны заадаг өсвөр үеийнхэн сайн мэдээний талаарх асуултуудынхаа хариултыг олоход суралцсанаар хэрхэн адислагдах вэ?

Өсвөр үеийнхнийг дээрх үйл ажиллагаануудын нэгийг гүйцэтгээд, хичээлийн эхэнд бичсэн асуултуудыг давтахад урь. Эдгээр асуултын хариултыг эрэлхийлэх арга замуудыг төлөвлөх боломжийг тэдэнд өгөөрэй. Боломжтой бол судрууд, амьд бошиглогчдын үгс, Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимол болон Сүмийн бусад материалаас хариултаа хайж эхлэх боломжийг тэдэнд олго.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд Сайн мэдээний тухай асуултууддаа хэрхэн хариулт олох талаар ойлгож мэдэж байна уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхнийг хичээлийн үеэр төрсөн сэтгэгдлээ хуваалцахад урь. Тэд өөрсдөд нь байгаа сайн мэдээний талаарх асуултуудын хариултыг олохын тулд юу хийх вэ? Тэднийг олж мэдсэн зүйлээ дараагийн хичээлүүд дээр хуваалцахад урамшуул.

Сонгосон материалууд

Дийтр Ф.Угдорфийн “Усан доторх тусгал” залуучуудад зориулсан СБС-ийн галын дэргэдэх онцгой цугларалт дээр хэлсэн үгээс эш татав. 2009 оны 11-р сарын 1

Одоо дараагийн сэдэв бол Эргэлзээ ба асуултуудын талаар юу хэлэх тухай юм. Та нар сайн мэдээ үнэн гэдгийг яаж олж мэдсэн бэ? Сүмийн эсвэл түүний сургаалын талаар асуулттай байх нь зөв үү? Хайрт залуу найз нар минь, магадлан лавлах нь үнэн рүү хөтөлдөг тул бид асуулт асуумтгай хүмүүс. Ийм замаар л нэгэн залуу эрэгтэйд асуулт байснаас Сүмийн эхлэл тавигдсан. Үнэнийг хэлэхэд асуулт асуухгүйгээр яаж үнэнийг олж мэдэхийг би сайн мэдэхгүй байна. Та нар судруудаас ямар нэгэн асуултын хариулт болж ирээгүй илчлэлтийг олоход хэцүү. Асуулт урган гарахад Иосеф Смит хариултыг нь мэдэхгүй байсан тул Их Эзэнд хандсан. Үр дүн нь Сургаал ба Гэрээн дээрх гайхамшигтай илчлэлтүүд болон ирсэн билээ. Олон удаа жинхэнэ асуултаасаа хол давсан мэдлэгийг Иосеф хүлээн авч байв. Энэ нь зөвхөн бидний асуусан асуултад Их Эзэн хариултыг өгөөд зогсохгүй харин бүр илүү чухлаар тийм ээ, бидний асуух ёстой байсан асуултын хариултуудыг өгдөгт учир нь байгаа юм. Эдгээр асуултуудыг сонсоцгооё.

Сүмийн номлогчдын хүчин чармайлт нь шударга сонирхогчдын чин зүрхний асуултууд дээр суурилдаг. Магадлан лавлах нь гэрчлэлийг төрүүлэгч мөн. Зарим нь сайн мэдээтэй холбоотой асуултуудын талаар эрж хайж байгаагаасаа болоод ичиж эсвэл зохисгүй болсон мэт санагдсан ч тэд ингэж мэдрэх хэрэггүй юм. Асуулт асуух нь сул дорой байдал биш. Энэ нь өсөлтийн анхдагч мөн.

Бурхан бидэнд асуултуудынхаа хариултыг эрэлхийлж (Иаков 1:5–6-г үзнэ үү) мөн биднийг зөвхөн “Христэд итгэлтэй байж, чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр асуух”-ыг (Моронай 10:4) эрэлхийлэхийг зарлигласан. Хэрэв бид тэгэх аваас бүх зүйлсийн үнэн “Ариун Сүнсний хүчээр” (Моронай 10:5) бидэнд тунхаглагдах болно.

Асуулт асуухаас бүү ай. Сониуч бай, харин бүү эргэлз! Аль хэдийнээ хүлээн авсан итгэл ба гэрэлд байнга үнэнч бай. Бид мөнх бус байдалдаа төгс бусаар хардаг тул яг одоо бүх зүйлийг ойлгохгүй. Үнэндээ, хэрэв бүх зүйлс бидэнд ойлгогдож байгаа бол энэ нь бүгд мөнх бус хүний ой ухаанаар хийгдсэний баталгаа байх болно гэж би бодох хэрэгтэй. Бурханы хэлсэн үгсийг сана:

“Миний бодол санаанууд бол та нарын бодол санаа биш. . . .

“Тэнгэр нь газраас өндөр байдаг шиг, Миний зам та нарын замаас, Миний бодол та нарын бодлоос өндөр билээ” (Исаиа 55:8–9).

Тэгэхээр та нар мөнх бус амьдралын зорилгуудын нэг нь өөрсдийн бодол санаа ба арга замуудад Тэнгэрлэг Эцэгтэйгээ илүү адил болох явдал гэдгийг мэднэ. Энэ зорилгоос харахад асуултуудынхаа хариултыг хайх нь гэрчлэлийг гуйвуулахын оронд харин хүчирхэгжүүлж, биднийг Бурхантай ойртуулдаг. “Итгэл бол юмсын тухай төгс мэдлэгтэй байх нь бус” (Алма 32:21), харин та нар сайн мэдээний зарчмуудыг ямар ч нөхцөл байдалд өдөр бүр хэрэгжүүлэн итгэлээ хөгжүүлснээр сайн мэдээний амтат үр жимсийг амтлах бөгөөд энэ үр жимсээр үнэнийг нь мэдэх болно (Матай 7:16–20; Иохан 7:17; Алма 32:41–43-ыг үзнэ үү).



АРВАННЭГДҮГЭЭР САР: СҮНСЛЭГ БА МАТЕРИАЛЛАГ
БАЙДЛЫН ХУВЬД БИЕ ДААХ ЧАДВАР

Би хэрхэн эргэлзээгээ итгэлээр ялан дийлж чадах вэ?

Заримдаа Сүмийн гишүүдэд сайн мэдээний талаар асуултууд байдаг. Асуулт тавих нь ердийн зүйл ба бид үнэнийг итгэлтэйгээр эрэлхийлэх үедээ гэрчлэлээ хүчирхэгжүүлдэг. Гэхдээ биднийг итгэлгүйхэн асууж эхлэх үед Их Эзэний Сүнсэнд биднийг удирдах нь илүү хэцүү болдог. Бид хариулт эрэлхийлэх үедээ сайн мэдээний талаар аль хэдийн мэдэх зүйлсэд итгэлтэй байхаар, зарлигуудын дагуу амьдрахаар мөн өдөр тутам судраас суралцаж, залбирахаа үргэлжлүүлэхээр сонгох ёстой. Бид эдгээр зүйлийг хийх үед Тэнгэрлэг Эцэг гэрчлэлээ хүчирхэгжүүлэхэд маань бидэнд туслах болно.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Доорх эх сурвалжуудыг залбирч, судал. Та итгэлээ хүчирхэгжүүлж мөн хэцүү асуултуудад хэрхэн хандах талаар өсвөр үеийнхэнд заахад туслах ямар эх сурвалжуудыг ашиглаж болох вэ? Та тэдэнтэй юуг хуваалцахаар сүнслэгээр өдөөгдөж байна вэ?

Та итгэлээ хэрхэн хүчирхэгжүүлдэг вэ? Бидэнд хэцүү асуулт тулгарах үед хэрхэн хандах талаар хожмын үеийн бошиглогч, төлөөлөгч, удирдагчид юу гэж заасан бэ?

Сайн мэдээний талаарх ямар ямар хэцүү асуулт зарим өсвөр үеийнхэнд гардаг вэ? Тэднийг эдгээр асуултынхаа хариултыг итгэлтэйгээр эрэлхийлэхэд нь та хэрхэн тусалж чадах вэ?

Марк 5:35–36; 9:14–24; Иохан 20:26–29; С ба Г 6:36 (Бүү ай)

Хиламан 5:12 (Есүс Христ дээр сууриа тавь)

1 Нифай 15:24 (Судруудад тулгуурла)

Иохан 7:17; Иаков 2:17–18, 22;
3 Нифай 14:7–8; Ифер 12:6, 12
(Итгэлээр үйлд)

2 Нифай 2:11 (Бүх зүйлд сөрөг тал бий)

С ба Г 46:10–14 (Заримд нь мэдэх, заримд нь тэдний үгсэд итгэх нь өгөгддөг)

Вэрн П.Станфилл, “Тэрлийг сонго” *Ensign* эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 44

Нийл Л.Андэрсэн, “Иосеф Смит,” *Ensign* эсвэл 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 31–35

Рөүзмэри М.Виксом, “Итгэлээ сэргээх нь,” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 80–82

Л.Витни Клэйтон, “Итгэхийг сонго” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 20–22

Жэффри Р.Холланд, “Эзэн минь, би итгэж байна” *Ensign* эсвэл 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 108–111

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутад өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөл байдалд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, Сүмийн бусад хичээл, найзуудтайгаа эсвэл гэр бүлийнхэнтэйгээ хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хооронд уялдаа холбоо бий болгоход туслаарай. Та тэдэнд өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь хэрхэн тусалж чадах вэ? Доорх санаанууд тусалж болох юм:

- Сүмийн гишүүн бүр, залуу эрэгтэй, залуу эмэгтэй бүр сайн мэдээний талаар өөрийн гэсэн гэрчлэлтэй байх хэрэгтэй гэдгийг тайлбарла. Өсвөр үеийнхнийг өөрсдийн гэсэн гэрчлэлийг хөгжүүлэхийн ач холбогдлыг тэдэнд заасан туршлагаасаа хуваалцахад урь. Бид өөрийн гэсэн гэрчлэлээ хөгжүүлэх үедээ сүнслэг байдлын хувьд бие дааж чаддаг гэдгийг тайлбарла.

- Өсвөр үеийнхэнд тэдэнд танил ямар нэгэн зүйлийг ойрхноос авсан зургийг (маш ойрхноос зургийг нь авсан болохоор юу гэдэг нь мэдэгдэхгүй болсон зургийг) үзүүлэн,

тэднээр юу болохыг нь таалгах талаар бод. Тэгээд тэдэнд уг зүйлийг харуул. Биднийг зөв хандлагатай байх үед бидний ойлголт хэрхэн өөрчлөгддөг вэ? Энэ үзүүлэн өсвөр үеийнхэнд мөнхийн талаас нь ойлгох ойлголттой байхын ач холбогдлын талаар юу гэж зааж байгаа талаар тунгаан бодохыг тэднээс хүс. (Илүү санаа авахын тулд Рафаэл И.Пино, “Сайн мэдээний мөнхийн тухай ойлголт,” *Ensign* эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 107–109-ийг үзнэ үү). Өсвөр үеийнхэн хэцүү асуултуудтай тулгарах үед мөнхийн хандлагатай байх нь хэрхэн тусалж болох вэ?

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь хэцүү асуултуудынхаа хариултыг итгэлтэйгээр эрэлхийлэх талаар мэдэж авахад нь өсвөр үеийнхэнд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

- Ангийн нэг гишүүнээс Марк 9:14–27 дээрх түүхийг ярихад бэлдэж ирэхийг хүс эсвэл уг түүхийг ангиараа уншиж болно. Ангиа гурван бүлэг болгож хуваарилан, ахлагч Жэффри Р.Холландын хэлсэн “Эзэн минь, би итгэж байна” үгэн дэх түүхээс ажигласан гурван зүйлийг нэг нэгээр нь уншуулахаар оноо. Өсвөр үеийнхэн өөрсдөд нь эсвэл тэдний

мэдэх хэн нэгэнд сайн мэдээний талаар хэцүү асуулт, эргэлзээ гарах үед ахлагч Холландын ажигласан зүйлсийг хэрхэн ашиглаж болох вэ?

- Өсвөр үеийнхнийг ахлагч Нийл Л.Андэрсэний “Иосеф Смит” хэлсэн үгийн хүчилтөрөгчийн багийн талаарх адилтгалыг уншихад урь (эсвэл ахлагч Андэрсэний

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч заадаг хүмүүсээ хайрладаг байсан. Тэднийг хэцүү байдалтай тулгарахад нь Тэрээр хэзээ ч орхиогүй, харин үргэлжлүүлэн хайрлаж, тэдэнд тохинуулсаар байсан. Түүний үлгэр жишээг дагахын тулд та юу хийж чадах вэ?

уг үгийг хэлж байгаа видео бичлэгийн хэсгийг ойролцоогоор 10 дахь минутаас эхлэн үзүүл). Хувийн итгэлээ хүчирхэгжүүлэх нь хүчилтөрөгчийн багаа зүүхтэй юугаараа адил төстэй вэ? Ахлагч Андэрсэн “багаа зөв тааруулж өмссөн байх” талаар юу гэж хэлсэн бэ? Энэхүү хэлсэн үгээс хэцүү асуултуудыг шийдвэрлэх талаар өөр ямар нэмэлт зөвлөгөөг өсвөр үеийнхэн олж авч чадах вэ?

- Рөүзмэри М.Виксом “Итгэлээ сэргээх нь” хэлсэн үгэндээ эргэлзэж буй нэгэн залуу эхийн талаар өгүүлдэг. Энэ түүхийг ангийн гишүүдтэй хуваалц. Энэ түүх нь өсвөр үеийнхэнд хэцүү асуултууддаа хариулж чадахгүй байгаа үедээ юу хийх ёстой талаар юу гэж зааж байна вэ? Уг түүхэнд гарч буй залуу эхэд тусалсан хүмүүсээс ангийн гишүүд юуг сурч болох вэ?

- Ангийнхныг жижиг бүлгүүдэд хуваарилаад, бүлэг бүрд ахлагч Л.Витни Клэйтоны “Итгэхийг сонго” хэлсэн үгийн эсвэл ахлагч Вэрн П.Станфиллийн “Гэрлийг сонго”

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд сайн мэдээний талаарх хэцүү асуултууддаа хэрхэн итгэлтэй хандах талаар илүү сайн ойлгож байна уу? Тэд иймэрхүү асуултууд бүхий бусад хүнд хэрхэн туслах талаар илүү сайн ойлгож байна уу? Хэрвээ та ангийн аль нэг гишүүний талаар санаа зовж байгаа бол тэднийг өөрсдөд нь байгаа асуултуудынхаа талаар эцэг эхтэйгээ, өсвөр үеийнхний удирдагчтайгаа эсвэл бишоптой ярихыг хувь хүн тус бүрд санал болгож болно.

Үйлдэхэд урь

Та өсвөр үеийнхнийг идэвх султай гишүүнд юм уу эсвэл асуулт тавьж байгаа хэн нэгэнд хайраа илэрхийлсэн захиа бичихэд урамшуулж болно.

Та түүнчлэн тэднийг одоо өдөр тутам залбирч мөн судраас судалснаар гэрчлэлээ хүчирхэгжүүлэх шийдвэр гаргахад урамшуулж болно.

хэлсэн үгийн хуулбарыг тарааж өг. Бүлэг бүрээр уг хэлсэн үгийн нэг хэсгийг уншуулж, тэднийг өөрсдөд нь хамаатай эсвэл утга учиртай санагдсан хэсгүүдийг тодотгохыг хүс. Өсвөр үеийнхнийг суралцах үедээ Сүнснээс сурсан зүйлсийнхээ талаар хуваалцахад урь. Тэд Сэйлор Гатцлэрийн түүхийг эсвэл ахлагч Станфиллын дугуйн аялын түүхийг эргэлзээг даван гарч, итгэлээр урагш явах үйл явцтай хэрхэн уялдуулж ойлгож болох вэ?

- Ерөнхийлөгч Боид К.Пакэр “Гэрчлэлээ хуваалцсанаар гэрчлэл олж авдаг юм!” хэмээн заажээ. (“The Candle of the Lord,” *Ensign*, 1983 оны 1-р сар, 54). Гэрчлэлээ хуваалцах нь гэрчлэлээ хүчирхэгжүүлэхэд тэдэнд хэрхэн тусалдаг вэ? Иохан 7:17; Ифер 12:6, 12; Иаков 2:17-18, 22-ыг уншин, эдгээр судар нь итгэлээр үйлдэх талаар юу гэж заадаг талаар ярилц. Өөрсдөдөө байгаа итгэлд тулгуурлан үйлдэх нь Тэнгэрлэг Эцэгт бид илүү гэрэл, үнэнийг хүлээн авахад бэлэн байгааг хэрхэн харуулдаг вэ?

Сонгосон материалууд

Даллин Х.Өүксийн “Сайн, Илүү сайн, Хамгийн сайн” хэлсэн үгээс эш татав. *Ensign эсвэл* Лиахона, 2007 оны 11-р сар, 104–108

Ямар нэг зүйл нь зүгээр л *сайн* учир үүнийг хийх хангалттай шалтгаан биш гэдгийг хүлээн зөвшөөрөх бодит байдлаас бид эхлэх ёстой. Бидний хийж болох сайн зүйлсийн тоо тэдгээрийг хийх цагийн боломжоос хавьгүй их байдаг. Зарим зүйлс нь сайнаас илүү сайн байдаг бөгөөд бид амьдралдаа эдгээрт тэргүүн зэргийн анхаарал тавих шаардлагатай болдог.

Есүс энэ зарчмыг Мартагийн гэрт байхдаа заасан. Түүнийг “үйлчлэх ажилдаа түүртэж” байхад (Лук 10:40) түүний охин дүү Мариа “Эзэний хөлд суугаад үгийг нь сонсож байлаа” (шүлэг 39). Марта охин дүүгээ үйлчлэх ажилд ганцааранг нь орхисонд гомдоллоход Есүс Мартаг юу хийж байгаад нь магтаж сайшаасангүй (шүлэг 41) харин түүнд “үнэндээ ганцхан юм л хэрэгтэй билээ. Мариа өөрөөс нь зайлуулагдашгүй сайныгаа л сонгон авчээ” хэмээн заажээ (шүлэг 42). Мартагийн хувьд “их зүйлд санаа тавьж зовох” (шүлэг 41) нь магтууштай ч Багш Эзэнээс сайн мэдээг сурах нь илүү “хэрэгтэй” гэдгийг сурсан. Судрууд зарим зүйлс бусдаас илүү адислагдсан байдаг тухай бусад сургаалуудыг агуулдаг (Үйлс 20:35; Алма 32:14–15-ыг үзнэ үү). . . .

Янз бүрийн сонголтуудын талаар бодож байхдаа бид зарим зүйлсийн сайн байх нь хангалтгүй гэдгийг санах ёстой. Бусад сонголтууд нь илүү сайн байдаг ч нөгөө зарим нь хамгийн сайн нь байдаг. Хэдийгээр тодорхой сонголтууд нь илүү их зардалтай ч энэ нь бүх сонголтоос хамгийн агуу үнэ цэнэтэй учраас сонгох хамгийн шилдэг сонголт байж болно.

Зурагт үзэх, видео тоглоом тоглох, интернэтээр аялах эсвэл ном юм уу сэтгүүл унших зэрэг сонголтуудыг хийснээр бид цагаа хэрхэн ашиглаж байгаагаа бодоод үз. Мэдээж зохистой, эерэг зугаа цэнгээнтэй зүйл үзэх эсвэл сонирхолтой мэдээлэл олж авах нь сайн хэрэг. Гэвч иймэрхүү юм бүхэн нь амьдралынхаа тодорхой хэсгийг өгөхөөр үнэ цэнэтэй зүйл биш юм. Зарим нь илүү сайн ч нөгөө зарим нь хамгийн сайн нь байдаг. Их Эзэн бидэнд суралцахыг эрэлхийлэхийг хэлэхдээ, “мэргэн ухааны үгсийг *шилдэг* номнуудаас эрэлхийлэгтүн та нар” (С ба Г 88:118; тодотголууд нь нэмэгдсэн болно) гэсэн. . . .

Энд сайн, илүү сайн, хамгийн сайны зарим бусад төсөөллүүдийг үзүүлье:

Тэнгэр дэх Эцэгийнхээ үнэн Сүмд харьяалагдаж, Түүний бүх зарлигуудыг сахиж, мөн бүхий л үүргүүдээ гүйцэтгэх нь *сайн* хэрэг мөн. Гэвч үүнийг “хамгийн сайн” болгохын тулд хайраар мөн бардамналгүйгээр хийх ёстой. Бид агуу дуулал дээр “[өөрсдийн] сайнаа ахан дүүсийн нөхөрлөлөөр титэмлэе,” [“America the Beautiful,” *Дууллууд*, дугаар 338] хэмээн дуулдаг шиг бидний амьдралд нөлөөлж байгаа бүгдэд хайр болон халамжаа үзүүлэх ёстой.

Олон зуун мянган гэрийн болон айлчлагч багш нартаа би томилогдсон гэр бүлүүддээ зочлох нь *сайн*; сургаал болон зарчмыг заадаг богино айлчлалууд нь *илүү сайн*; харин бүхнээс *шилдэг* нь айлчлан очиж байгаа тэдгээр хүмүүсийн заримынх нь амьдралд өөрчлөлт оруулах явдал гэдгийг сануулмаар байна. Үүнтэй адил шаардлага бидний хийдэг олон цуглаанд мөрдөгдөж болно. Цуглаан хийх нь *сайн*, зарчим заавал *илүү сайн*, харин цуглааны үр дүнд амьдрал нь сайжирч байвал тэр *хамгийн сайн* болно.



АРВАННЭГДҮГЭЭР САР: СҮНСЛЭГ БА МАТЕРИАЛЛАГ
БАЙДЛЫН ХУВЬД БИЕ ДААХ ЧАДВАР

Би хэрхэн өөрөө шийдвэр гаргаж сурах вэ?

Бие даасан байхын нэг чухал хэсэг нь өөрсдийн төлөө хэрхэн шийдвэр гаргахыг сурах явдал юм. Тэнгэрлэг Эцэг биднийг удирдахад бэлэн байдаг ч Тэр бидэнд яг юу хийхийг үргэлж хэлж өгдөггүй. Тэр бидэнд сонгох эрхийг өгсөн ба биднийг мэдлэг, туршлага, итгэлээ ашиглан шийдвэрээ өөрсдөө гаргаасай хэмээн хүсдэг. Дараа нь бид гаргасан шийдвэрээ зөв эсэхийг бататгаж өгөхийг Түүнээс гуйж болно.

Та ямар ямар чухал шийдвэр гаргаж байсан бэ? Тэдгээр шийдвэрийг та хэрхэн гаргасан бэ? Их Эзэн танд хэрхэн тусалсан бэ?

Өсвөр үеийнхэн ямар ямар чухал шийдвэр гаргах хэрэгтэй байна вэ? Эдгээр шийдвэрийг гаргахад нь сайн мэдээний ямар зарчмууд туслах вэ?

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалыг залбирч судлаарай. Шийдвэр гаргахтай холбоотой сайн мэдээний зарчмуудаас суралцахад нь өсвөр үеийнхэнд юу туслах вэ?

Алма 37:37 (Их Эзэнтэй зөвлө)

С ба Г 9:7–9 (Биднийг оюун санаандаа шийдвэрээ тунгаан бодсоны дараа Тэнгэрлэг Эцэг биднийг удирддаг)

С ба Г 58:26–29 (Бид бүх зүйлд зарлигдуулах хэрэггүй, сайн зарчимд л санаа сэтгэлээ бүрэн зориулж байх хэрэгтэй)

Даллин Х.Өүкс, “Сайн, илүү сайн, хамгийн сайн,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2007 оны 11-р сар, 104–8

Робэрт Д.Хэйлс, “Аароны санваартнуудад: Арван жилийн туршид гаргах шийдвэрт бэлтгэх нь,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2007 оны 5-р сар, 48–51

Ричард Г.Скотт, “Залбирлын онцгой бэлгийг хэрэглэх нь,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2007 оны 5-р сар, 8–11

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Та өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

- Өсвөр үеийнхнийг сүнслэг болон дэлхийд саяхан тохиолдсон үйл явдлын талаар бодоход урь.

- Хамтдаа Сургаал ба Гэрээ 58:26–29-ийг унш. Их Эзэн “бүх зүйлд бидэнд зарлиглахыг” яагаад хүсдэггүй вэ? Өсвөр үеийнхнээс ирэх 10 жилийн туршид гаргаж болох чухал шийдвэрүүдээ самбар дээр жагсаан

бичихийг хүс. Энэ хичээлийн явцад сурах зүйлүүд нь эдгээр шийдвэрийг гаргахад тэдэнд хэрхэн тусалж болох талаар бодоход өсвөр үеийнхнийг урь.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь шийдвэр хэрхэн гаргахыг ойлгоход нь өсвөр үеийнхэнд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Өсвөр үеийнхнийг Сургаал ба Гэрээ 9:7–9 ба Алма 37:37-г уншин, эдгээр шүлэгт гардаг Их Эзэний зөвлөгөөг ирэх хэдэн жилийн турш чухал шийдвэр гаргахдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар тунгаан бодоход тэднийг урь. Эдгээр шийдвэрийн талаар “Их Эзэнтэй зөвлөлдөнө” гэдэг нь ямар утгатай вэ? “[Өөрийн] оюундаа тунгаан бодно” гэдэг нь ямар утгатай вэ? Тэднийг энэ талаарх санаа бодол болон шийдвэр гаргахын тулд Их Эзэнтэй зөвлөлдсөн туршлагаасаа хуваалцахад урь. Түүнчлэн туршлага болон гэрчлэлээ хуваалц.

- Ангийнхнаас ахлагч Роберт Д.Хэйлсийн ярьсан, сургалтад оролцоогүй нисгэгчийн тухай түүхийг уншиж байхдаа шийдвэр гаргах талаар сурсан зүйлийнхээ тухай бодохыг хүс (“Аароны санваартнуудад: Арван жилийн туршид гаргах шийдвэрт бэлтгэх нь”). Тэднээс олж мэдсэнээ хуваалцахыг хүс. Өсвөр үеийнхнийг ахлагч Хэйлсийн хэлсэн үгийн “Одоо цаг нь боллоо” гэж эхэлж байгаа догол мөрийг уншихад урин, ахлагч Хэйлс тэдэнд юу хий гэж зөвлөж байгааг болон тэдний одоо хийх сонголтууд хожмын

амьдрал дахь сонголтуудад нь хэрхэн нөлөөлөх талаар ангийнхантайгаа хуваалцахыг тэднээс хүс.

- Ахлагч Даллин Х.Өүксийн “Сайн, илүү сайн, хамгийн сайн” хэлсэн үгийн 1-р хэсгийг уншиж, энэ нь шийдвэр гаргах талаар тэдэнд юу зааж байгааг хуваалцахад өсвөр үеийнхнийг урь. Сайн, илүү сайн, хамгийн сайн гэдгийн хоорондох ялгааг гаргахдаа өсвөр үеийнхэн ямар шалгуур ашиглаж болох вэ? (ахлагч Өүксийн дараах өгүүллийг тэдэнд уншуулж болох юм: “Илүү сайн, хамгийн сайн зүйлс нь Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлийг хөгжүүлж, гэр бүлийг маань хүчирхэгжүүлдэг учраас бид илүү сайн, хамгийн сайн зүйлийг сонгохын тулд зарим сайн зүйлээ орхих хэрэгтэй болж болох юм.”) Самбар дээр *Сайн, Илүү сайн* болон *Хамгийн сайн* гэсэн гарчгууд бичээд, эдгээрт тохирох сонголтуудыг тэдгээр гарчгийн дор бичихэд өсвөр үеийнхнийг урь (хэрвээ тэдэнд жишээ хэрэгтэй бол ахлагч Өүксийн хэлсэн үгийн 4-р хэсгийг санал болго). Өсвөр үеийнхэн нь энэ үйл ажиллагаанаас сурсан зүйлээ шийдвэр гаргах үедээ хэрхэн хэрэгжүүлэх вэ?

Сайн мэдээг судлах чадварууд

Тунгаан бодох. Энэ хэсгийн эхний үйл ажиллагаа бол судрын шүлэг нь тэдний гаргах чухал шийдвэртэй ямар холбоотой болох талаар тунгаан бодоход өсвөр үеийнхнийг урина. Тунгаан бодох —өөрсдийн сонсон эсвэл уншсан зүйлийн талаар гүн гүнзгий бодох цаг гаргах нь Сүнсний удирдамжийг хүлээн авахад бидэнд тусалж чадна. Тунгаан бодох нэг сайн арга зам нь уншиж байгаа зүйлийнхээ талаар өөрсдөөсөө асуух явдал юм. Хувиараа судраас суралцахдаа тунгаан бодоход цаг зарцуулж байхад өсвөр үеийнхнийг урамшуул.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрөө залбиран, мацаг барьж, Тэнгэрлэг Эцэгийн тусламжийг эрэлхийлснээр Өөрийн зорилгыг биелүүлэхэд бэлдсэн юм. Та заахаар бэлдэж байхдаа Аврагчийн жишээг хэрхэн дагаж болох вэ?

- Ангийг хоёр бүлэг болгон хуваарил. Нэг бүлгийг ахлагч Ричард Г.Скоттын “Залбирлын онцгой бэлгийг хэрэглэх нь” хэлсэн үгийн “Та нар хэрхэн залбирах ёстой вэ?” хэсгийг, нөгөө бүлгийг “Залбирлууд хэрхэн хариулагддаг вэ?” хэсгийг уншихад урь. Өсвөр үеийнхнээс хэсгүүдийн гарчиг дахь асуултуудын хариултыг олж, мэдсэн зүйлээ өөрсдийн бүлгийнхэнтэйгээ ярилцахыг хүс. Тэгээд бүлэг бүрийг шийдвэр

гаргахдаа Их Эзэний удирдамжийг эрэлхийлэх талаар сурсан зүйлээ нөгөө бүлэгтээ заахад урь. Мөн тэд “Буруу замууд” видео бичлэгийг үзэж, энэ түүх Их Эзэн биднийг удирддаг талаар тэдний ойлголтод ямар мэдлэг нэмж байгаа талаар хуваалцахад урь. Тэднээс шийдвэр гаргахдаа энэ зөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд юу хийх талаар хуваалцахыг хүс.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд өөрсдийн шийдвэрийг хэрхэн гаргах талаар ойлгож байна уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхэнд өнөөдөр сурсан зүйлээсээ юу хийх мэдрэмж төрж байгаа талаар тэднээс асуу. Тэрхүү мэдрэмжийнхээ дагуу үйлдэхэд тэднийг урамшуулан дэмж. Суралцагчид үүний дагуу үйлдэж байгаа эсэхийг шалгах аргуудыг бодож ол.

Сонгосон материалууд

“Зорилгуудаа хэрхэн тавих вэ?” Миний сайн мэдээг номло (2004), 16

Зорилгууд бидний зүрх сэтгэлийн хүслийг болон бидний биелүүлж чадах зүйлсийн төсөөллийг илэрхийлдэг. Зорилго тавьж, төлөвлөснөөрөө найдварууд маань үйлдэл болдог. Зорилго тавьж мөн төлөвлөх нь итгэлийн үйлдэл юм. Залбирч, “бүх үндэстэнд зааж, тэдэнд Эцэг мөн Хүү, мөн Ариун Сүнсний нэрээр баптисм хүртээ” (Матай 28:19) хэмээн Аврагчийн тушаасантай нийцэхүйц зорилго тавь.

Үндсэн үзүүлэлт бүр дээр зорилго тавь. Түүнчлэн та хувийнхаа өсөлт хөгжилтийн төлөө зорилго тавьж болох юм. Зорилгодоо хүрэхийн тулд бусдын сонгох эрх чөлөөг хүндэтгэхийн сацуу чадлынхаа хэрээр бүх зүйлийг хий. Амжилтын хамгийн гол хэмжүүр бол дан ганц зорилгодоо хүрэх бус харин таны үзүүлсэн үйлчлэл болон бусад хүмүүсийн өсөлт хөгжилт юм. Зорилгууд нь Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийн дунд олон сайн зүйлсийг авчрахад танд туслах арга хэрэгсэл юм. Тэдгээрийг алдар хүнд олохын тулд ашиглах ёсгүй.

Сайн тунгаан бодсон зорилгууд нь та нарт тодорхой удирдамж зааврыг өгч, амьдралын өдрүүдийг тань хүмүүсийг Аврагчид итгэх итгэлээ хүчирхэгжүүлж, баптисм хүртэж, гишүүнээр батлуулж, сүмд бүрэн идэвхтэй байхад нь туслах үйл ажиллагаануудаар дүүрэн байлгах болно. Сорилттой зорилгууд нь идэвх зүтгэлтэй ажиллахад тань танд тусалж мөн бүх хүчээ шавхаж, өсөх замд таныг хөтлөх болно. Зорилго тавихдаа доорх зааварчилгааг дага:

- Сүнснийг дага.
- Үндсэн үзүүлэлтүүдэд анхаарлаа хандуул.

- Хүмүүст анхаарлаа хандуул. Хэдийгээр та тоонуудыг ашиглах боловч хүмүүсийн нэрсээр уг тоонуудаа дэмжих боломжтой бай.

- Тодорхой болоод үнэн бодитой бай. Гэхдээ өөрийнхөө хүрэх хэмжээнд тулгуурлан зорилго тавь.

- Долоо хоног тутам болон өдөр бүр зорилго тавь.

- Хэрэв гадаад хэл сурч байгаа бол гадаад хэл сурах зорилгоо багтаасан хувиараа болон хамтрагчтайгаа биелүүлэх зорилго тавь.

- Өдөр бүр, долоо хоног бүр, мөн зургаан долоо хоног бүр өсөлт хөгжилтөө хэмж. Зорилгоо биелүүлж чадахгүй болсон үедээ хүч чармайлтаа дүгнээд уг зорилгыг биелүүлэх арга замуудыг эрэлхийл. Хэрэв шаардлагатай бол өөрийн хүсэн хүлээж буй зүйлийг өөрчил.

Таны зорилгыг дээшлүүлж мөн итгэлийг тань нэмэгдүүлэхийн тулд номлолын ерөнхийлөгч тань үе үе гарамгай байдлын жишгүүдийг тогтоож болох юм. Дүүрэг, бүс болон номлолын жишгүүд нь өсч хөгжин, идэвхтэй ажиллаж мөн гүйцэтгэлийн өндөр түвшинд хүрэхэд тань танд туслах болно. Тэдгээр нь танд болон хамтрагчид тань тодорхой зорилгыг тулгах ноогдол мэтээр ашиглагдах ёсгүй.

“Хэрэв бид амьдралдаа зорилго тавьдаггүй, зорилгодоо хүрэхээр амьдрах арга барилуудыг хэрхэн гарамгай сайн эзэмшихийг суралцаагүй бол өндөр насалсан үедээ өөрсдийн амьдралыг эргэн харахад өөрт байсан бүхий л чадамжийнхаа зөвхөн багахан хэсгийг нь ашигласнаа харах болно гэдэгт би бүрэн итгэлтэй байна. Зорилго тавих зарчмыг гарамгай сайн эзэмшсэн хүн энэ амьдралдаа илүү агуу өөрчлөлтийг хийх чадвартай болдог” (Ахлагч М.Рассэлл Баллард, Солт Лэйк бүсийн залуучуудад хандан хэлсэн үг, 1981 оны 10-р сарын 18).



АРВАННЭГДҮГЭЭР САР: СҮНСЛЭГ БА МАТЕРИАЛЛАГ
БАЙДЛЫН ХУВЬД БИЕ ДААХ ЧАДВАР

Зорилго тавих нь бие даах чадвартай болоход минь хэрхэн туслах вэ?

Утга учиртай зорилго ба бодож гаргасан төлөвлөгөө нь Их Эзэний биднээр хийлгэх ажлыг гүйцэтгэхэд маань туслах болно. Амьдралдаа зорилго тавих нь бие дааж сурахын нэг чухал хэсэг юм. Энэ нь хүсч, мөрөөдөхөөс ч илүү ихийг багтаадаг. Ерөнхийлөгч Монсоны зааснаар: “Хүсэх нь үүнийг бие-лүүлэхгүй. Их Эзэн биднийг бодоосой гэж хүсдэг. Тэр биднийг үйлдээсэй хэмээн хүсдэг. Тэр биднийг хөдөлмөрлөөсэй хэмээн хүсдэг. Тэр бидний гэрчлэлийг хүсдэг. Тэр бидний зүтгэлийг хүсдэг” (“To the Rescue,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2001 оны 5 сар, 49). Бид зорилгодоо хүрэхийн тулд залбирч төлөвлөн, хичээнгүйгээр хөдөлмөрлөх үед Их Эзэн бидний хичээл зүтгэлийг баяжуулдаг ба чадавхдаа хүрэхэд маань бидэнд тусалдаг.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон бусад материалыг залбирч судал. Бие даах чадвартай болохын тулд зорилго тавих нь чухал талаар суралцахад өсвөр үеийнхэнд юу туслах вэ?

Хаадын дээд 18:21; Матай 6:24 (Бид хоёр эзэнд үйлчилж чадахгүй)

Филиппой 3:13–14 (Бид зорилгынхоо төлөө зүтгэж, түүнд хүрэхээр тэмүүлж чадна)

2 Нифай 32:9 (Бид хийх бүх зүйлдээ Их Эзэний удирдамжийг эрэлхийлэх ёстой)

Алма 34:32–33 (Энэ амьдрал бол Бурхангай уулзахаар бэлтгэх үе)

С ба Г 58:27–29 (Бид сайн үйлсэд оролцож байх хэрэгтэй)

Квинтин Л.Күк, “Ухаалаг сонголт хий,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 11-р сар, 46-49

“Хэрхэн зорилго тавих вэ,” *Миний сайн мэдээг номло* (2004), 146

Та амьдралдаа ямар зорилгууд тавьж байсан бэ? Та зорилгодоо хүрэхийн тулд юу хийж байсан бэ? Зорилгодоо хүрэх нь илүү бие даах чадвартай болоход тань хэрхэн тусалсан бэ?

Өсвөр үеийнхэн таны мэдэх ямар зорилгуудыг тавьсан байна вэ? Та тэднийг зөв зохистой зорилго тавихад нь хэрхэн урамшуулж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээл эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Та өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Өсвөр үеийнхнийг суралцаж байгаа сайн мэдээний үнэнийг бататгасан саяхны тохиолдсон туршлагаасаа хуваалцахад урь.
- Та өсвөр үеийнхэнтэй өөртөө тавьж байсан зорилгуудынхаа заримаас хуваалц. Үүндээ богино болон урт хугацааны зорилгуудын

аль алиныг нь багтаа. Эдгээр зорилгыг тавихаар хэрхэн шийдсэнээ, тэдгээрт хүрэхийн тулд юу хийсэнээ мөн хичээл зүтгэл амьдралыг тань хэрхэн адисалж байсан талаар тайлбарла. Өсвөр үеийнхнийг өөрсдийн иймэрхүү туршлагаас хуваалцахад урамшуулан дэмж.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь хувийн зорилгоо хэрхэн тавихыг сурснаар илүү бие даах чадвартай болоход нь өсвөр үеийнхэнд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго:

- Ангийн нэг хэсгээс ахлагч Квинтин Л.Күкийн өсвөр насны эрэгтэйтэй ярилцсан тухай түүхийг (“Ухаалаг сонголт хий” хэлсэн үгээс), мөн нөгөө хэсгээс ахлагч Л.Том Пэрригийн хүү нь өндөрт үсэрч сурах дадлага хийж байсан тухай түүхийг (“Raising the Bar” хэлсэн үгээс) уншихыг хүс. Оногдсон түүхээ ангийнхаа бусад гишүүнд товчхон ярьж өгч, зорилго тавих талаар сурсан зүйлээ тайлбарлахыг өсвөр үеийнхнээс хүс. Тэднээс өөрсдийн амьдралаас үүнтэй ижил төстэй жишээ хуваалцахыг хүс. Зорилго тавьж, түүнд хүрэхдээ илүү үр дүнтэй байхын тулд эдгээр түүхээс сурсан зүйлсээ хэрхэн хэрэгжүүлэх вэ?
- Өсвөр үеийнхнээс тэдний зарим зорилгын талаар, мөн зорилго тавих нь яагаад чухал болох талаар асуу. Тэднийг Миний сайн мэдээг номло номоос “Хэрхэн зорилго тавих вэ” (хуудас 146) хэсгийг уншин, зорилго чухал болох тухай шалтгаануудыг хайж, олж мэдсэн зүйлээ хуваалцахыг хүс. Бишопын зөвшөөрлөөр бүрэн цагийн номлогчдыг, эсвэл

саяхан номлолоосоо буусан номлогчийг урьж, номлолын ажилд зорилго тавихын чухлыг тайлбарлаж өгөхийг хүс. Одооноос зорилго тавьж сурах нь илүү сайн номлогчид болоход нь өсвөр үеийнхэнд хэрхэн туслах вэ? Амьдралын өөр бусад үед ч зорилго тавих нь чухал болох тухай өсвөр үеийнхэнтэй ярилцуулахаар тойргийн бусад гишүүнийг урих талаар бодож үзээрэй.

- Өсвөр үеийнхнийг зорилгуудаа жагсаан бичихэд урь. *Миний сайн мэдээг номло* номын 146-р хуудсан дахь зорилго тавихад зориулсан удирдамжийг өсвөр үеийнхэнтэй хамт лавлаж үзээрэй. Жагсаасан зорилгоо биелүүлэхэд нь эдгээр удирдамжийн аль нь өсвөр үеийнхэнд туслах вэ? Өөрсдийн зорилгоос нэгийг сонгон, уг зорилгоо биелүүлэхдээ эдгээр удирдамжийг хэрэгжүүлэх арга замуудыг бичихэд тэднийг урь. Хэдэн суралцагчаас бичсэн зүйлсээ хуваалцахыг хүс.
- Өсвөр үеийнхнийг Сургаал ба Гэрээ 58:27–29-ийг уншин, “сайн

Заахад туслах арга

“Жижиг бүлгүүдээр ярилцах нь сонирхол нь буурч, анхаарал нь сарниж байгаа хүмүүсийг ярилцлагад амархан татан оруулдаг ач холбогдолтой”.

Аврагчийн арга барилгаар заах нь

Аврагч заадаг хүмүүстээ хайртай байсан. Тэр тэдний сонирхол, найдвар, хүслийг мөн амьдралд нь юу тохиолдож байгааг мэддэг байсан. Та заадаг өсвөр үеийнхнийхээ хэрэгцээ, сонирхлыг ойлгохын тулд юу хийж чадах вэ? Энэ нь таны заах арга барилд хэрхэн нөлөөлөх вэ?

зарчимд санаа сэтгэлээ бүрэн зориулахад” болон “туйлын зөв шударга байдлыг тохиолгоход” туслах зорилгуудын жагсаалт гаргахад уриарай. Жагсаалтаа ангийн өөр гишүүнтэй хуваалцаж, эдгээр зорилгодоо хүрэхийн тулд одоо юу хийж байгаагаа, мөн юу хийж чадах талаараа тайлбарлахад нь тэднийг урамшуулан дэмж. Энэ тоймд санал болгосон нэмэлт судруудыг уншиж, эдгээр судраас зорилго тавих талаар олж авсан нэмэлт мэдлэгээ хуваалцахад тэднийг урь.

- “Ажил урагшилж байна” видео бичлэгийг үзүүлээд, зорилго тавьж, түүндээ хүрэх талаар уг видео

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд хувийн зорилгоо хэрхэн тавих талаар ойлгосон уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлагатай юу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхэнд өнөөдөр сурсан зүйлээсээ юу хийх мэдрэмж төрж байгаа талаар тэднээс асуу. Тэрхүү мэдрэмжийнхээ дагуу үйлдэхэд нь урамшуулан дэмж. Суралцагчид үүний дагуу үйлдэж байгаа эсэхэд хяналт тавих аргуудыг бодож ол.

бичлэгээс сурсан зүйлээ бичиж авах цөөн хэдэн хором гаргаж өгөөрэй. Тэднийг санал бодлоо ангийнхантайгаа хуваалцахад урь. Номлолд үйлчлэх нь Тайлерын сагс тоглох зорилгод саад болж байсан хэдий ч тэр яагаад энэ зорилгоо биелүүлэхийг сонгосон бэ? (Энэ ярилцлагын нэг хэсэг болгож, та Хаадын дээд 18:21 болон Матай 6:24-ийг уншихыг хүсч болох юм). Өсвөр үеийнхнээс сонирхдог нэг зүйлийнхээ талаар бодохыг хүс. Уг зүйл ба өөр нэг зохистой зорилго хоёрын аль нэгийг сонгох хэрэг тэдэнд гарч байсан уу? Тэд Тайлерын жишээнээс юу сурсан бэ?



АРВАННЭГДҮГЭЭР САР: СҮНСЛЭГ БА МАТЕРИАЛЛАГ
БАЙДЛЫН ХУВЬД БИЕ ДААХ ЧАДВАР

Би санхүүгийн хувьд бие даасан байхад хэрхэн бэлтгэх вэ?

Их Эзэн бидэнд боломжуудыг өгсөн бөгөөд Тэрээр биднээс эдгээрийг ашиглахдаа ухаалаг байгаасай гэж хүсдэг. Тэр биднийг өөрсдийгөө тэтгэж мөн бусдад үйлчилж чаддаг байхаар санхүүгийн хувьд бие даасан байгаасай хэмээн хүсдэг. Үүнийг хийхийн тулд бид аравны нэг болон өргөлүүдээ төлж, шаардлагагүй өрөөс зайлсхийн мөн төсөв гаргаж, өөрсдийн хэрэгцээнд тохируулан амьдрах ёстой.

Санхүүгийн хувьд бие даах хэрэгтэй гэсэн сүмийн удирдагчдын зөвлөгөөг дагаснаар амьдрал тань хэрхэн адислагдсан бэ? Бие даах байдал нь сэргээгдсэн сайн мэдээний чухал зарчим гэдэгт та яагаад итгэдэг вэ?

Өсвөр үеийнхэн өөрсдийгөө болон бусдыг тэтгэх талаар юу сурах хэрэгтэй вэ? Тэд санхүүгийн хувьд бие даах хэрэгтэй гэсэн зөвлөгөөг дагаснаараа тэд болон тэдний ирээдүйн гэр бүл хэрхэн адислагдах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Өсвөр үеийнхэнд санхүүгийн хувьд бие даах нь чухал гэдгийг ойлгож, өөрсдийгөө тэтгэн амьдрахад бэлтгэхэд нь ямар судар ба материалууд туслах вэ?

Малахи 3:10–11 (Аравны нэгийн адислалууд)

2 Нифай 9:30, 51; Иаков 2:13–14, 17–19; Алма 1:29–30; 4:6–8 (Бид бусдыг адислахдаа баялгийг ашиглах хэрэгтэй)

С ба Г 19:35 (Их Эзэн өрийг боолчлолтой харьцуулсан нь)

Робэрт Д.Хэйлс, “Сүнслэг ба материаллаг байдлын хувьд ухаалаг

тэтгэгч болох нь,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2009 оны 5-р сар, 7–10; түүнчлэн “Гэр бүлээ биеэ даан хангах нь” видео бичлэгийг үзнэ үү.

“Өр,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 146–47

“Аравны нэг ба өргөлүүд” *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 38–39

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Та өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Өсвөр үеийнхнийг хувиараа судраас суралцахдаа саяхан сурсан зүйлээсээ хуваалцахад урь.

- Өсвөр үеийнхнээс яаж хэрэглэж байгаагаасаа шалтгаалан тодорхой багаж хэрэгслүүд нь хэрхэн тустай, бас аюултай байж болох талаар

тайлбарлахыг хүс (хулганы хавх, алх, шүдэнз гэх мэт. Та үзүүлэн болгож эдгээр зүйлсээс нэгийг нь авчирч болох юм). Өсвөр үеийнхэнд мөнгө үзүүлж, мөнгө хэрэглэхийн

ээрэг болон сөрөг талыг тайлбарлахыг тэднээс хүс. Үүнийг бусдыг адисалж, Их Эзэний ажлыг урагшлуулахад хэрхэн ашиглаж болох вэ?

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь санхүүгийн хувьд бие даасан байхын чухлыг ойлгоход нь өсвөр үеийнхэнд туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

Сайн мэдээг судлах ур чадварууд

Сургаалыг хайх Энэ хэсэгт Их Эзэн мөнгөний талаар юу заадгийг олохоор судраас хайхад өсвөр үеийнхнийг урина. Тэднийг судруудыг уншиж байхдаа судруудын заах сургаалыг (эсвэл мөнхийн үнэнүүдийг) эрж хайхад урь. “Би сургаалын талаар юу сурч байна вэ? “Энэ нь миний бодож байснаас эсвэл өмнө нь сурснаас ялгаатай байна уу? Энэ нь намайг амьдралдаа ямар нэг өөрчлөлт гаргахад урамшуулж байна уу?” гэх мэт асуултуудыг өөрсдөөсөө асуухад нь тэднийг дэмж. Өсвөр үеийнхнийг хувиараа судраас суралцах үедээ иймэрхүү асуултуудыг өөрсдөдөө тавихад нь дэмж.

- Ахлагч Роберт Д.Хэйлсийн дараах үгсийг самбар дээр бич: “Хайрыг хамгийн их илэрхийлдэг гурван үг нь “Би чамд хайртай” бөгөөд хамгийн их халамж үзүүлдэг дөрвөн үг нь “Бид худалдаж авч дийлэхгүй” гэдэг үг юм.” Эхнэртээ даашинз худалдаж авч өгөхийг хүссэн ахлагч Хэйлсийн түүхийг уншихад өсвөр үеийнхнийг урь (“Сүнслэг ба материаллаг байдлын хувьд ухаалаг тэтгэгч болох нь” хэлсэн үг) эсвэл “ Гэр бүлээ бие даан хангах нь” видео бичлэгийг үзүүл. Ахлагч Хэйлс “бид худалдаж авч дийлэхгүй” гэдэг дөрвөн үгийг яагаад хамгийн их халамж үзүүлэх үгс гэж хэлж байгаагийн шалтгаануудын талаар бодож мөн хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс. Өөрсдийн боломжоос хэтрүүлэлгүй амьдарснаар ямар адислалууд ирдэг вэ? Өсвөр үеийнхэн Хэйлс эгчийн жишээг хэрхэн дагаж болох вэ? Боломжоосоо хэтэрсэн байдлаар амьдрахаар уруу татагдах үед Хэйлс эгчийн жишээ тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

- Самбар дээр хоёр янзын жагсаалт гаргахад өсвөр үеийнхнийг урь: нэгэнд нь дэлхийнхэн бидэнд мөнгөний талаар юу гэж хэлдгийг

бич, нөгөөд нь Их Эзэн бидэнд мөнгөний талаар юу гэж хэлдгийг бич. Энэ хичээлд өгөгдсөн судруудыг уншихдаа энэ жагсаалт дээр нэмж болох зүйлс олж мэдэхийг тэднээс хүс. Өсвөр үеийнхэн Их Эзэний мөнгөний талаар заасан зүйлсийг одооноос дагаж эхлэхийн тулд юу хийж чадахыг нь асуу. Самбар дээр санаануудаа бичихэд тэднийг урь. Уг жагсаалтаас энэ долоо хоногт дагаж эхлэхийг хүссэн нэг санааг өсвөр үеийнхнээр нэг бүрчлэн сонгуул. Хэрвээ тэд хүсвэл төлөвлөгөөнөөсөө хуваалцахад урь.

- Ангийн нэг гишүүнээс С ба Г 19:35-ыг уншихыг хүс. Их Эзэн яагаад өрийг боолчлолтой харьцуулж байна вэ? Өсвөр үеийнхнийг *Итгэлдээ үнэнч байх нь* номын “Өр” гэсэн хэсгийг уншихыг хүс. Ангийнхны нэг хэсгийг өрөөс зайлсхийж байх ёстой шалтгаанууд, нөгөө хэсгийг нь хэрхэн өрөнд орохгүй байж болох талаарх зөвлөгөөг олоход урь. Сурсан зүйлээ болон бид өрөнд орохгүй байх нь Их Эзэнд яагаад чухал гэж бодож байгаа талаар нэг нэгэндээ заахыг тэднээс хүс. Бид мөнгөө хэрхэн зохицуулж байгаа нь сүнслэг байдалд маань хэрхэн нөлөөлдөг вэ?

- Санхүүгээ хянах талаар Тэргүүн байгааг нь өсвөр үеийнхнээс асуу. Зөвлөлөөс юу хэлнэ гэж бодож Тэдний санааг самбар дээр бич.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Санхүүгийн хувьд бие даасан байхын чухлыг тэд бусдад тайлбарлаж чадахаар ойлгож авсан уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхэн өнөөдөр сурсан зүйлээсээ юу хийх мэдрэмж авч байгаа талаар тэднээс асуу. Тэрхүү мэдрэмжийнхээ дагуу үйлдэхэд тэднийг урамшуулан дэмж. Сулалцагчид үүний дагуу үйлдэж байгаа эсэхэд хяналт тавих аргуудыг бодож ол. Жишээлбэл: дараа долоо хоногийн хичээлийн эхэнд туршлагаасаа хуваалцахыг тэднээс хүсч болох юм.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн шавь нарыг өөрсдийн туршлагаар мөн эргэн тойрон дахь ертөнцөөсөө сайн мэдээний хичээлүүдийг олж нээхэд нь тусалсан. Та өсвөр үеийнхнийг санхүүгийн хувьд бие даасан байхын сүнслэг ач холбогдлыг мэдэхэд нь туслах өдөр тутмын ямар туршлага болон жишээнүүдийг хуваалцаж чадах вэ?

Сонгосон материалууд

Хэрэгцээтэй Бүх Зүйлсээ Бэлтгэ: Гэр бүлийн санхүү (*товхимол, 2007*)-ээс авсан зилэл

Тэргүүн Зөвлөлийн Захиас Бичгээс

Хүндэт ах эгч нар аа:

Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд маань хүнд хэцүү үед бэлтгэлтэй байхын тулд бага ч гэсэн мөнгө хуримтлуулж байх тухай зөвлөлөөс олон жилийн туршид зөвлөсөөр ирсэн билээ. Ингэж мөнгө хуримтлуулах нь бидний сайн сайхан, баталгаатай байдлыг маш ихээр нэмдэг. Гэр бүл бүхэн өөрийн хэрэгцээг чадлынхаа хэрээр хангах үүрэгтэй билээ.

Та дэлхийн хаана ч амьдардаг бай хамаагүй, өөрийнхөө санхүүгийн байдалд тохируулан хүнд хэцүү үе ирэхэд бэлтгэлтэй байхыг бид та нараас хүсэж байна. Бид та бүхнийг мөнгөө зөв зохистой зарцуулж, өр тавихаас зайлсхийхийн тулд аливаа зүйлсийг худалдан авахдаа хариуцлагатай хандахыг уриалж байна. Өр тавьсан бол аль болох түргэн буцаан төлж, энэ хүлээснээс өөрсдийгөө чөлөөл. Бага багаар мөнгө хуримтлуулсаар аажмаар өөрийн санхүүгийн нөөцийг бий болго.

Та бүхнийг хүнсний зүйлс болон ус нөөцөлж, мөнгө хадгалахдаа ухаалаг хандахыг хүсэж байна. Бүү хэтрүүл; энэ нь ухаалаг явдал биш, жишээлбэл хүнсний нөөцөө нэг дор бий болгох гэж өр тавих ёсгүй. Анхааралтай төлөвлө. Та тодорхой хугацааны дараа хүнсний болон санхүүгийн нөөцтэй болж чадна.

Хэрэв та өрөө төлж дуусган, санхүүгийн нөөцийг бага ч гэсэн бий болгосон бол та мөн таны гэр бүл илүү амьдралын баталгаатай болж, илүү гайхамшигтай амар тайвныг зүрх сэтгэлдээ мэдрэх

болно. Гэр бүлийнхээ санхүүг зохицуулахад хийж буй бүхий л зүйлд тань Их Эзэн таньг адислах болтугай.

Тэргүүн Зөвлөл

Гэр Бүлийн Санхүүгийн Үндсүүд

Аравны Нэг Болон Бусад Өргөлүүдээ Төл

Шударгаар аравны нэгээ төлж, мацгийн өргөлийг харамгүй өгснөөр гэр бүлийн санхүүгийн амжилттай эхлэл тавигдана. Итгэлтэйгээр аравны нэг болон өргөлүүдийг төлдөг хүмүүсийн дээр Их Эзэн тэнгэрийн цонхыг нээж, гайхамшигт адислуудыг асгахаа амласан билээ (Малахи 3:10-ыг үз).

Өрнөөс Зайлсхийх

Олдгоосоо бага мөнгө зарцуулах нь таны санхүүгийн баталгаатай байдалд чухал үүрэгтэй. Боловсрол, орон гэр худалдан авах болон бусад зайлшгүй шаардлагатай хэрэгцээг эс тооцвол өр тавихаас зайлсхий. Хэрэгцээтэй зүйлсээ худалдан авахын тулд мөнгө хуримтлуул. Хэрэв та өртэй бол аль болох түргэн төлж дуусга.

Төсөвлө

Бүх зардлуудаа бүртгэж бай. Сарын орлого болон зарлагаа бичиж тэмдэглэн тооцож бай. Шаардлагагүй зүйлд зарцуулдаг зардлаа хэрхэн бууруулах талаар нухацтай бод. Гэр бүлийн төсвийг бий болгохын тулд энэ мэдээллийг ашигла. Сүмийн өргөлд хэдийг өгөх, хэдийг цааш нь хадгалах болон хоол, байр, цахилгаан, унаа тээвэр, хувцас, даатгал гэх мэтийн зүйлүүдэд хэдий хэмжээний мөнгө зарцуулахаа төлөвлө. Төлөвлөснөө чанд баримтлан амьдар.

Сонгосон материалууд

Нөөц Бий Болго

Аажим аажмаар санхүүгийн нөөцийг бий болгож үүнийгээ зөвхөн зайлшгүй үед хэрэглэ. Хэрэв та бага мөнгө тогтмол хуримтлуулсаар байвал хэсэг хугацааны дараа хэр их цуглуулсныг хараад гайхах болно.

Гэр Бүлийн Гишүүддээ Заа

Санхүүгээ хэрхэн зохицуулах зарчмуудыг гэр бүлийн гишүүддээ заа. Төсөв зохиох болон гэр бүлийн санхүүгийн зорилго тавихдаа тэднийг оролцуулж бай. Шаргуу хөдөлмөр, арвигч хямгач байдал болон хуримтлалтай болох зарчмыг тэдэнд заа. Аль болох олон талын боловсрол эзэмшихийн чухлыг тэдэнд ойлгуул.



АРВАННЭГДҮГЭЭР САР: СҮНСЛЭГ БА МАТЕРИАЛЛАГ
БАЙДЛЫН ХУВЬД БИЕ ДААХ ЧАДВАР

Би хэрхэн Бурханы гэрчлэгч болж зогсох вэ?

Бид баптисм хүртэх үедээ “ямар ч цагт мөн бүх зүйлд мөн өөрийн байж болох хаана ч гэсэн Бурханы гэрчлэгч болж” (Мозая 18:9) зогсох гэрээнд ордог. Дэлхийн жишгүүд Бурханы зарлигуудаас хазайсаар байгаа тул бид итгэлээ байнга хамгаалах шаардлагатай болсоор байна. Ингэхдээ бид үнэнийг хамгаалахын тулд зоригтой мөн хайраар дүүрэн зогссон Аврагчийн үлгэр жишээг дагах ёстой. Хэрэв бид “Гэтэлгэгчийн хадан дээр” сууриа тавих юм бол эцсийн өдөр “хүчит салхи” “[биднийг] доош чирж дийлэх хүчгүй байх болно ... [бид] дээр нь босгогдсон ... хадны учир болой” (Хиламан 5:12).

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалыг залбирч судал. Өсвөр үеийнхнийг Бурханы гэрчлэгч болж зоригтой зогсоход нь юу урамшуулан дэмжих вэ?

1 Нифай 8:24–34 (Амьдралын модны тухай болон агуу, нүсэр барилгын талаарх Лихайн үзэгдэл)

Ром 1:16–17 (Сайн мэдээнээс битгий ич)

1 Тимот 4:12 (Итгэгч хүмүүсийн жишээ нь бай)

1 Петр 3:12–17 (Бидний итгэлийн талаар асуух хүмүүст хариулахад үргэлж бэлэн бай)

С ба Г 100:5–8 (Бурханы үгийг тунхагладаг хүмүүст өгөгдсөн амлалт)

1 Нифай 17:48–55; Мозая 13:1–9; 17:1–4; Моронай 1:1–3 (Хавчлага

дарамтыг үл тоон сайн мэдээнд үнэнч үлдсэн хүмүүсийн жишээ)

Томас С.Монсон, “Хүчтэй бөгөөд зоригтой бай,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 5-р сар, 66–69

Жэффри Р.Холланд, “Шавь байхын адислал ба төлөөс,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 5-р сар, 6-9

Нийл Л.Андэрсэн, “Сүнслэг шуурганууд,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2014 оны 5-р сар, 18-21

Видео бичлэг: “Бүдүүлэг үтгүй клуб”

Хэзээ танд итгэл үнэмшлээ хамгаалах шаардлага гарч байсан бэ? Ийм цаг мөчид бэлтгэлтэй байхад танд юу тусалсан бэ? Та өсвөр үеийнхэнтэй ямар туршлага хуваалцаж болох вэ?

Өсвөр үеийнхнийг Бурханы гэрчлэгч болж зогсохыг нь та хэзээ харсан бэ? Итгэл үнэмшил рүү нь дайрч болох ямар нөхцөл байдалтай тэд тулгарч болох вэ? Тэд хэрхэн бие биенээ хүчирхэгжүүлэн, дэмжиж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутад өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөл байдалд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээл эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Та нар тэдэнд өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Өсвөр үеийнхнээс ангиас гадуур саяхан тэдэнд тохиолдсон сурах болон заах туршлагаас хуваалцахыг хүс. Өмнөх долоо хоногуудад заагдсан зарчмууд тэдэнд хэрхэн тусалсан бэ?
- Ангид хоёр соронз авчирч, соронз хэрхэн бие биеэ татаж байгааг тайлбарла. Дараа нь нэг соронзыг эргүүлж тавиад хэрхэн бие биеэ түлхэж байгааг тайлбарла. Өсвөр

үеийнхнээс эдгээр соронзыг ерөнхийлөгч Томас С.Монсоны хэлсэн дараах үгсийг тайлбарлахад хэрхэн ашиглаж болохыг асуу: “Нэгэн үед сүмийн жишгүүд болон нийгмийн жишгүүдийн хооронд ялгаа бараг байдаггүй байлаа. Харин одоо том ангал бий болж, энэ нь улам томорсоор байна” (“Санваарын хүч,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2011 оны 5-р сар, 66).

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь өсвөр үеийнхнийг эсэргүүцэл, хавчлагыг үл тоон Бурханы гэрчлэгч болж зогсоход нь урамшуулан дэмжих болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Ангиараа 1 Нифай 8:24–34-ийг уншиж, өсвөр үеийнхнээс Лихайн уг үзэгдэл тэдний амьдралтай хэрхэн холбогдож байгааг асуу. Эсэргүүцэл эсвэл шүүмжлэлтэй тулгарах үедээ хэрхэн итгэлдээ үнэнч зогссон туршлагаа хуваалц. Өсвөр үеийнхнээс үүнтэй төстэй туршлага байвал хуваалцахыг хүс.
- Ангийн гишүүдийг хавчлага дарамтыг үл тоон, сайн мэдээнд үнэнч үлдсэн хувь хүмүүсийн түүхийг судраас хуваалцахад урь

(энэ тоймд байгаа судруудад зарим жишээ байгаа). Ангиараа эдгээр хүний түүхийг унш. Ангийн гишүүд эдгээр жишээнээс тэдний амьдралтай холбоотой юуг сурсан бэ? Уг ярилцлагын үеэр өсвөр үеийнхэн энэ тоймд санал болгосон бусад судрыг судалж байж болно.

- Ангийн гишүүдийг “Бүдүүлэг үггүй клуб” видео бичлэгийг үзэж, үүнээс Бурханы гэрчлэгч болж зогсоход нь тэднийг урамшуулж дэмжсэн үгсийг хайж олоход урь.

Заахад туслах арга

“Жижиг бүлгүүдээр ярилцах нь сонирхол нь буурч, анхаарал нь сарниж байгаа хүмүүсийг ярилцлагад амархан татан оруулдаг ач холбогдолтой” (*Teaching, No Greater Call* [1999], 72).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч заадаг хүмүүстээ хайртай байсан. Тэднийг зовж цөхрөхөд нь Тэрээр хэзээ ч орхиогүй, харин үргэлжлүүлэн хайрлаж, тэдэнд тохинуулсаар байлаа. Түүний үлгэр жишээг дагахын тулд та нар юу хийж болох вэ?

Тэд итгэл, жишгийг нь сорьсон ямар нөхцөл байдлуудтай тулгардаг вэ? Тэд итгэлээ хамгаалахын тулд юу хийж байна вэ? Тэд уг видео бичлэг дээрх жишээг хэрхэн дагах вэ?

- Ангийг гурав хуваагаад, бүлэг бүрд уг тоймд байгаа хэлсэн үгсээс нэгийг өг. Бүлэг бүрээс хэлсэн үгийг уншиж, хэн нэгийг сайн мэдээний үнэнийг хамгаалахад

зоригжуулахдаа хуваалцаж болох хүчирхэг өгүүлбэрүүдийг жагсаан бичихийг хүс. Бүлэг бүрд эдгээр өгүүлбэрийг бусадтай хэрхэн хуваалцаж болох талаар ангийн-хантайгаа хуваалцах боломж олго. Жишээлбэл, тэд зургаар эшлэл хийж, долоо хоногийн дундуур ангидаа ярилцсан зүйлсийнхээ сануулга болгон үүнийгээ ангийн бусад гишүүнтэй хуваалцаж болно.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд Бурханы гэрчлэгч болж зогсох сүнслэг удирдамжийг мэдэрч байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлагатай байна уу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхэн өнөөдөр сурсан зүйлээсээ юу хийх мэдрэмж авч байгаа талаар тэднээс асуу. Тэрхүү мэдрэмжийнхээ дагуу үйлдэхэд тэднийг урамшуулан дэмж. Тэднийг үүний дагуу үйлдэж байгаа эсэхэд хяналт тавих аргуудыг бодож ол.

БҮЛГИЙН ТОВЧ ТОЙМ

Арванхоёрдугаар сар: Хожмын өдрүүдэд Бурханы хаант улсыг байгуулах нь

“Бурханы хаант улс урагшилж, тэнгэрийн хаант улс ирэх болтугай” (С ба Г 65:6)

Ангийн тань өсвөр үеийнхэн Аврагчийн Хоёр дахь ирэлтэд дэлхийг бэлтгэхэд туслахын тулд энэ онцгой цаг үед дэлхий рүү илгээгдсэн билээ. Бурханы хаант улсыг байгуулж, Түүний сайн мэдээг хуваалцахдаа ашиглаасай хэмээн Их Эзэний хүсдэг онцгой бэлэг болон авьяас чадварууд тэдэнд бий. Энэ бүлгийн хичээлүүд нь тэднийг Сүм болон Бурханы хаант улсад удирдагч болон багш нар болохоор бэлтгэх үед эдгээр авьяас чадвараа хөгжүүлэхэд нь тэдэнд туслах болно.

Энэ сард сонгох хичээлийн тоймууд:

Христийн мэндэлсний баяр: Би Есүс Христ бол Бурханы Хүү хэмээх гэрчлэлээ хэрхэн хуваалцаж болох вэ?

Би Сүмд хэрхэн илүү үр дүнтэй үйлчилж сурах вэ?

Би хэрхэн илүү сайн удирдагч болж чадах вэ?

Би хэрхэн илүү сайн багш болж чадах вэ?

Бусадтай сайн мэдээг хуваалцах ямар үр дүнтэй арга замууд байдаг вэ?

Хоёр дахь ирэлтийн талаар заахад ашиглагддаг тэмдгүүдийг би хэрхэн ойлгох вэ?

Хоёр дахь ирэлтэд бэлтгэхэд надад туслах ямар зүйлсийг би судруудаас сурч чадах вэ?



АРВАНХОЁРДУГААР САР: ХОЖМЫН ӨДРҮҮДЭД
БУРХАНЫ ХААНТ УЛСЫГ БАЙГУУЛАХ НЬ

Христийн мэндэлсний баяр: Есүс Христ бол Бурханы Хүү хэмээх гэрчлэлээ би хэрхэн хуваалцаж чадах вэ?

Христийн мэндэлсний баяр бол Аврагчийн төрсөн өдрийг дурсан санаж, Түүний төгс амьдрал болон цагаатгагч золиослолын агуу бэлэгт талархах талархлаа шинэчлэх үе юм. Бид Түүний төрөлтийн талаарх судрын түүхүүдээс шавь байх загварыг олж хардаг. Эдгээрт Түүний ирэхийг зоригтойгоор бошиглосон лемен үндэстэн Самуелаас эхлээд Түүний төрөлтийн тэмдгийг тууштай хүлээсэн нифайчуудад Бурханы Хүү төрсөн тухай захиасыг хуваалцсан хоньчид мөн бошиглол биелснийг ялган таньж, иудейчүүдийн хааныг харахаар хол зам туулан ирсэн зурхайчид багтдаг. Бид эртний итгэлтэй гэгээнтнүүдийн адил Есүс Христийн талаарх гэрчлэл болон Түүний сэргээгдсэн сайн мэдээнээс олж авсан “үлэмж баярлуулах сайн мэдээг” бусадтай хуваалцах хүслийг мэдэрдэг юм (Лук 2:10).

Ямар судар болон хожмын үеийн бошиглогчдын сургаал Есүс Христийн бурханлаг байдлын талаарх таны гэрчлэлийг хүчирхэгжүүлсэн бэ? Энэхүү гэрчлэл таны амьдралд хэрхэн нөлөөлсөн бэ? Та бусдад гэрчлэлээ хүчирхэгжүүлэхэд нь туслахын тулд хэзээ эдгээр судар, сургаалыг ашигласан бэ?

Та өсвөр үеийнхний Аврагчийн талаар гэрчлэлээ хуваалцахыг хэзээ сонссон бэ? Бусадтай гэрчлэлээ хуваалцахад нь тэдэнд сүнслэгээр нөлөөлөхийн тулд та юу хийж чадах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Доорх эх сурвалжуудыг залбирч, судал. Аврагчийн талаар гэрчлэлээ хуваалцахад ямар зүйлс өсвөр үеийнхэнд сүнслэгээр нөлөөлнө гэж та бодож байна вэ?

Матай 2; Лук 2 (Есүс Христ мэндэллээ)

Хиламан 14 (Лемен үндэстэн Самуел Есүс Христийн төрөлтийг бошиглов)

3 Нифай 1:4-22 (Нифайчууд Христийн төрөлтийн тэмдгийг гэрчлэв)

Хэнри Б.Айринг, “Төгс бэлэг,” 2012 оны Христийн мэндэлсний баярын онцгой цугларалт

“Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл,” *Ensign*, 2000 оны 4-р сар, 2–3

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний хэдэн минутад өсвөр үеийнхний өөр өөр нөхцөл байдалд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, Сүмийн бусад хичээл болон найзуудтайгаа хийсэн зүйлс гэх мэт) зүйлсийг хооронд нь уялдаа холбоотой

болгоход туслаарай. Та тэдэнд өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаа тусалж болох юм.

Тухайлбал:

- Өсвөр үеийнхнийг өнгөрсөн долоо хоногийн хичээл дээр сурсан зүйлээ долоо хоногийн турш хэрхэн хэрэгжүүлсэн талаараа хуваалцахад урь.
- Аврагчийн төрөлтийг хэрхэн тэмдэглэдэг талаараа хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс. Ямар уламжлалууд тэдэнд Христтэй илүү ойр байхад тусалдаг вэ?

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр өсвөр үеийнхэнд Есүс Христийн талаар гэрчлэлээ хуваалцахад сүнслэгээр нөлөөлөхөд тусална. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонго.

- Энэ хичээлийн тоймд санал болгосон видео бичлэгүүдээс нэгийг үзүүлж, Аврагчийн талаарх санаа бодол, сэтгэгдлээ хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс. Аврагчийн бурханлаг байдлын талаар гэрчлэлээ хуваалцаж, өсвөр үеийнхнийг мөн гэрчлэлээ хуваалцахад урь. Эдгээр видео бичлэгийн нэгийг гэр бүлийн үдшээр эсвэл олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хуваалцахад өсвөр үеийнхнийг урамшуулан дэмж. Дараагийн хичээл дээр эдгээр захиасыг хуваалцсан туршлагаасаа ярихыг тэднээс хүс.
- Энэ хичээлийн тоймд санал болгосон судруудыг хамтдаа уншиж, Шинэ Гэрээ болон Мормоны Номон дээрх Аврагчийн төрөлтийн түүхүүдийг ангиараа ярилц. Эдгээр судар дээрх ямар зүйлс лемен үндэстэн Самуел болон хоньчдын нэгэн адил бусадтай гэрчлэлээ хуваалцахад өсвөр үеийнхэнд сүнслэгээр нөлөөлж байна вэ? Тэд өөр ямар ойлголт олж авсан бэ? Энэ Христийн мэндэлсний баяраар Есүс Христийн талаарх гэрчлэлээ хуваалцаж болох арга замуудыг тунгаан бодож, ярилцахад өсвөр үеийнхнийг урь.
- Христийн мэндэлсний баярын ариун дууллуудыг хамтдаа дуулж, тэдэнд сүнслэгээр нөлөөлж байгаа дууны захиасуудын талаар ярихад өсвөр үеийнхнийг урь. Эдгээр дуулалтай холбоотой ямар судруудыг тэд хуваалцаж болох вэ? Тохиромжтой бол та Христийн мэндэлсний баярын магтуу дууг ангийнхантайгаа хамт хүмүүст дуулж өгөх боломжийг эрэлхийлж болох юм.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд Есүс Христийн талаарх гэрчлэлээ бусадтай хуваалцахаар сүнслэгээр өдөөгдсөн үү? Тэдэнд ямар мэдрэмж эсвэл сэтгэгдэл төрсөн бэ? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлага байна уу?

Заахад туслах арга

Бид сайн мэдээг заах үедээ Ариун Сүнс бол жинхэнэ багш болохыг даруухнаар хүлээн зөвшөөрөх ёстой. Бидний хувьд өөрсдөөр минь дамжуулан зааж, гэрчилж, тайвшруулж мөн бусдад сүнслэгээр нөлөөлөх Ариун Сүнсний зэмсэг болон үйлчлэх нь нэр төрийн хэрэг юм.

Үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан зүйлс нь тэдэнд юу хийхэд сүнслэгээр өдөөсөн талаар өсвөр үеийнхнээс асуу. Тэднийг эдгээр мэдрэмжийнхээ дагуу үйлдэхэд урамшуулан дэмж. Үүний дагуу үйлдэж байгаа эсэхийг шалгах аргуудыг бодож ол.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн номлолоор зааж, гэрчлэхдээ судруудыг ашигладаг байлаа. Тэрээр хүмүүст өөрсдөд нь зориулсан судруудын талаар бодож, асуултынхаа хариултыг судруудаас олохыг заасан. Судруудахь хүчтэй гэрчлэлүүдийг таньж мэдэхэд нь та өсвөр үеийнхэнд хэрхэн тусалж болох вэ?



АРВАНХОЁРДУГААР САР: ХОЖМЫН ӨДРҮҮДЭД
БУРХАНЫ ХААНТ УЛСЫГ БАЙГУУЛАХ НЬ

Би сүмд хэрхэн илүү үр дүнтэй үйлчилж сурах вэ?

Их Эзэн биднийг үйлчлүүлэхээр дуудах үедээ итгэлтэйгээр үйлчлэх чадвартай болгодог. Бид үүрэг хариуцлага мэдэн, хичээнгүйгээр биелүүлэх үед Их Эзэн бидний хичээл зүтгэлийг хүчирхэгжүүлдэг. Бид сүмийн удирдагчдын зөвлөгөөг дагах үед дуудлагадаа үйлчлэхээр адислагддаг. Түүний хаант улсыг байгуулж мөн Түүний хүүхдүүдэд үйлчлэхээр бид ийн Түүнтэй хамтран ажилладаг.

Таныг дуудлагаа биелүүлэхээр хичээх үед Их Эзэн хэрхэн тусалдаг вэ? Та өсвөр үеийнхэнтэй ямар туршлага хуваалцаж болох вэ?

Таны заадаг өсвөр үеийнхнээс хэн хэн нь дуудлагад үйлчилж байна вэ? Одооноос эхлэн сүмд үр дүнтэй үйлчилж сурах нь тэдний хувьд яагаад чухал вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Бэлдэж байхдаа эдгээр судар болон материалуудыг залбирч, судлаарай. Та өсвөр үеийнхэнтэй юу хуваалцахаар өдөөгдсөн бэ?

Иеремиа 1:5–9; Мозая 2:11; Мосе 6:31–34 (Өөрсдийнхөө дуудлагыг биелүүлэхийн тулд Их Эзэнээс хүч чадлыг хүлээн авсан бошиглогчид)

Иохан 15:16; Итгэлийн тунхаг 1:5 (Илэрхийллээр дамжуулан үйлчлүүлэхээр Бурхан биднийг дууддаг)

Иаков 1:17–19; С ба Г 4; 107:99; 121:34–36 (Бид дуудлагаа

гүйцэтгэхийн тулд бүхий л хичээл зүтгэлээрээ ажиллах ёстой)

С ба Г 25 (Эмма Смит хүлээсэн үүргээ биелүүлэх талаар зөвлөгөө хүлээн авдаг)

Томас С. Монсон, “Аврагчийн үйлчлэх дуудлага,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2012 оны 8-р сар, 4–5

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Та өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Хамгийн сүүлд сайн мэдээг заасан туршлагаа хуваалцахыг тэднээс хүс. Тэд юу нь сайн болсон гэж бодож байна вэ? Тэд юуг сайжруулахыг хүсч байна вэ?

• Өсвөр үеийнхнээс сүмд хүлээн авч байсан ямар нэгэн дуудлагынхаа талаар ярихыг хүс. Тэд ямар үүрэг хүлээж байсан бэ? Уг дуудлагын юу

нь хэцүү, бэрхшээлтэй байсан бэ? Их Эзэн тэдэнд хэрхэн тусалсан бэ? Өөрийн туршлага болон гэрчлэлээ хуваалц.

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь сүмд хэрхэн үр дүнтэй үйлчлэхийг сурахад нь өсвөр үеийнхэнд туслах болно. Ариун Сүнсний удирдамжийг даган, ангийнханд тань тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

• Энэ хичээлд санал болгосон судруудын нэгийг уншин, дуудлагуудаа биелүүлэх талаар Их Эзэний заасан зарчмуудыг олохыг ангийн гишүүн бүрээс хүс. Тэднээс олж мэдсэн зүйлээ хуваалцахыг хүс. Эдгээр судрууд тэднийг юу хийхэд сүнслэгээр өдөөж байна вэ?

• Хэцүү даалгавар аваад Их Эзэнээс тусламж хүлээн авсан хэн нэгний тухай түүхийг судруудаас олж хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс (санаа авахын тулд энэ тоймд санал болгосон судруудыг үзнэ үү). Боломжтой бол тэдэнд *Сайн мэдээний зургийн цуглуулга дээрээс эдгээр түүхүүдтэй холбоотой зургуудыг олоход нь туслаарай.* Эдгээр түүхүүдийн юу нь тэдэнд сүнслэгээр нөлөөлж байна вэ? Тэд дуудлагаа биелүүлэх талаар энэ түүхүүдээс юу сурч байна вэ?

• Ерөнхийлөгч Томас С. Монсоны “Аврагчийн үйлчлэх дуудлага” хэлсэн үгээс сүмийн дуудлагадаа хэрхэн итгэлтэйгээр үйлчлэх талаар эшлэл үгийг эрэлхийлэн уншихад өсвөр үеийнхнийг урь. Ангийн гишүүдээс уншсан эшлэлээ болон ерөнхийлөгч Монсоны зөвлөгөөг яагаад тустай гэж бодсон талаараа

хуваалцахыг хүс. Тэд өөрсдийн сурсан зүйлсийг одоо болон ирээдүйд хүлээн авах дуудлагууддаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ?

• Самбар дээр *Зөвлөгөө ба Амлалтууд гэсэн хоёр гарчгийг бич.* Өсвөр үеийнхнийг Сургаал ба Гэрээ 25-аас Их Эзэний Эмма Смитэд дуудлагатай нь холбоотой өгсөн зөвлөгөө болон амлалтуудыг эрэлхийлж мөн олохыг урь. Тэднээс олж мэдсэн зүйлүүдээ самбар дээр бичихийг хүс. Энэхүү амлалт болон зөвлөгөө нь өсвөр үеийнхний хүлээж авах дуудлагуудад ямар хамаатай байж болох вэ? Дуудлага хүлээн авч байсан өсвөр үеийнхнээс уг дуудлагын адислалыг хүлээн авах үедээ авсан амлалт болон зөвлөгөөний талаар санаж байгаа зүйлээсээ хуваалцахыг хүс. Та мөн санаж байгаа зүйлээ хуваалцаж болно. Эдгээр амлалтууд нь хэрхэн биелэгдсэн байна вэ?

• Ангиараа Сургаал ба Гэрээ 107:99-ийг унш. Тэдэнд тойрог эсвэл гадаснаас тодорхой нэг дуудлагыг өгч байгаагаар төсөөлөн бодоход өсвөр үеийнхнийг урин, ямар дуудлагын талаар бодож байгааг нь тэднээс асуу (*Гарын Авлага 2: Сүмийг удирдах нь* номын 173–182-р

Сайн мэдээг судлах ур чадварууд

Зарчмуудыг олох нь. Энэ хэсгийн эхний үйл ажиллагаа нь өсвөр үеийнхнийг Бурханы хаант улсад үйлчлэх талаарх зарчмуудыг (эсвэл мөнхийн үнэнүүдийг) судраас хайж, эрэлхийлэхэд урьдаг. Тэднийг өөрсдөөсөө “Би энэ захиасаас ямар зарчим сурч авч байна вэ? Энэ нь миний бодож байснаас мөн өмнө сурснаас ялгаатай байна уу? Тэдгээр нь надад амьдралынхаа ямар нэг зүйлийг өөрчлөхөд сүнслэгээр нөлөөлж байна уу?” гэх мэт асуултуудыг асуухад нь урамшуул. Өсвөр үеийнхнийг өөрсдөө хувиараа судраас суралцах үедээ ийм асуултуудыг асуухад урамшуул.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийг нь дагасан тэдгээр хүмүүст итгэдэг байсан. Тэр тэднийг бэлтгэж, тэдэнд заах, адислах, бусдад үйлчлэх чухал үүрэг хариуцлагуудыг өгсөн. Та өсвөр үеийнхэнд бие биедээ заах ямар боломжуудыг олгож өгч чадах вэ?

хуудсаас “Дуудлагуудын жагсаалт” хэсгийг үз). Тэд уг дуудлагынх нь үүрэг юу болохыг олж мэдэхийн тулд юу хийх вэ? (Жишээлбэл: Тэд судруудаас, *Гарын Авлага 2-оос* үзэж эсвэл уг дуудлагад одоо үйлчилж байгаа хүнээс зөвлөгөө авч болно).

Өсвөр үеийнхнээс өөрсдийн бодсон дуудлагын талаар хичээлийн туршид болон ирэх долоо хоногт илүү ихийг суран, өөрсдийн сурсан зүйлээ дараагийн хичээл дээр хуваалцахыг хүс.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурч мэдсэн зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэд Сүмд хэрхэн үр нөлөөтэй үйлчлэх талаар ойлгож мэдэж байна уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйл дээрээ тулгуурлан юу хийхээр сүнслэгээр өдөөгдөж байгаа талаар асуу. Тэднийг эдгээр мэдрэмжүүдийнхээ дагуу үйлдэхэд уриал. Өгсөн даалгавраа шалгаж болох арга замуудын талаар залбирч бодож үзэхдээ Сүнсийг эрэлхийлээрэй.

Сонгосон материалууд

Хэнри Б.Айрингийн “Өөрийн дуудлагыг илүү сайнаар гүйцэтгэ” хэлсэн үгээс эш татав. Ensign эсвэл Лиахона, 2002 оны 11-р сар, 75–78

Та нарын мэдэх хэрэгтэй гурав дахь зүйл бий: Бурхан та нарыг дуудаж, удирдан чиглүүлдэг шигээ Тэрээр та нарыг өсгөх болно. Та нарт энэ өсөлт хэрэгтэй. Дуудлага тань гарцаагүй эсэргүүцлийг авчрах болно. Та нар Эзэний үйлчлэлд байна. Та нар Түүний төлөөлөгчид. Мөнхийн амьдрал та нараас хамаарна. Тэрээр сөрөг хүчтэй тулгарсан бөгөөд Түүний дуудсан олон мөн сөрөг хүчтэй тулгарна гэдгийг хэлсэн. Та нарын эсрэг цугласан хүчнүүд зөвхөн ажлыг тань саатуулахыг хичээгээд зогсохгүй мөн та нарыг сүнслэгээр унагахыг оролдох болно. Төлөөлөгч Паул үүнийг “Учир нь бидний тэмцэл бол махан бие ба цусны эсрэг биш, харин захирагчид, эрх мэдэл, энэхүү харанхуй ертөнцийн хүчнүүд” гэж дүрсэлсэн [Ефес 6:12].

Та нарт давж гаршгүй мэт санагдах үе байх болно. Та нарыг дайрах арга замуудын нэг нь өөрсдийгөө голох сэтгэлийг та нарт төрүүлэх явдал юм. Тийм ээ, та нар зөвхөн өөрсдийн хүчээр Бурханыг төлөөлөх дуудлагад хариулах нь хангалтгүй байх болно. Гэвч та нар бодит чадваруудаасаа илүү ихийг олох боломжтой ба та нар ганцаар ажиллахгүй.

Их Эзэн та нарын үйлчлэх хүмүүсийн өмнө юу хэлж, юу хийхийг тань зааж өгөх болно. Тэрээр та нарын ярьсан зүйлийн үнэнийг тэдэнд гэрчлэх Ариун Сүнсийг илгээх болно. Та нарын юу хэлж, юу хийх нь хүмүүст найдвар авчирч, удирдамж өгөх болно. Энэ нь бодит чадвар болоод ойлголтоос тань хавьгүй илүү давсныг та мэдэх болно. Энэ гайхамшиг нь бүхий л үеүдэд Их Эзэний Сүмийн таних тэмдэг байсаар байна. Энэ нь үүнийг өгөгдсөнийх нь төлөө авч эхэлж болох дуудлагын тань нэг хэсэг юм. . . .

Их Эзэн зөвхөн хичээл зүтгэлийн хүчийг тань өсгөөд зогсохгүй. Тэр Өөрөө та нартай хамт ажиллах болно. Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан хүнд хэцүү даалгаварт дуудагдсан дөрвөн номлогчид хандсан Түүний дуу хоолой Өөрийн хаант улс дахь Түүний дуудсан хүн бүрд “Мөн би өөрөө тэдэнтэй хамт явж мөн тэдний дунд байх болно; мөн бибээр Эцэгийн өмнө тэдний өмгөөлөгч болой, мөн тэднийг дийлэх юу ч үгүй байх болно” гэж урам зориг өгдөг [С ба Г 32:3].

Аврагч амилсан бөгөөд алдаршуулагдсан учраас Тэрээр мөч бүрд Өөрийн үйлчлэгч нэг бүртэй биечлэн хамт байж чадахгүй. Харин Тэрээр тэднийг болон тэдний нөхцөл байдлыг бүрэн төгс мэддэг бөгөөд Өөрийн хүчээр зуучлагч, өмгөөлөгч байх чадвартай. Тийм ч учраас Тэр та нарт: “Та нарыг хэн ч хүлээн авлаа гэсэн, тэнд би тэрчлэн байх болно, учир нь би та нарын нүүрний өмнө явах болно. Би та нарын баруун гар талд мөн та нарын зүүнтээ байх болно, мөн Миний Сүнс та нарын зүрх сэтгэлд, мөн Миний тэнгэр элчүүд та нарыг дэмжихийн тулд та нарын эргэн тойронд байх болно” хэмээн амласан [С ба Г 84:88]. . . .

Хүч чадал тань Их Эзэнээр олон дахин нэмэгдэх болно гэдэгт та нар бүрэн итгэлтэй байж болно. Тэрээр биднээс зөвхөн өөрийн бүхий л хичээл зүтгэл бүх зүрх сэтгэлээ өгөөсэй хэмээн хүсдэг. Үүнийг баяр хөөртэйгөөр мөн итгэлийн залбиралтайгаар хий. Эцэг ба Түүний Хайрт Хүү та нарыг хөтлөн удирдах Ариун Сүнсийг хамтрагч болгон илгээх болно. Та нарын хүчин чармайлт үйлчилж байгаа хүмүүсийн тань амьдралд улам үржигдэн өсөх болно. Одоо хүнд мэт санагдаж болох үйлчлэл ба золиослолоо хэсэг хугацааны дараа эргэн харахад золиослол тань адислал болж, Түүний төлөө үйлчилсэн тэдгээр хүмүүсийг болон та нарыг Бурханы гар өргөж буйг мэдэх болно.



АРВАНХОЁРДУГААР САР: ХОЖМЫН ӨДРҮҮДЭД
БУРХАНЫ ХААНТ УЛСЫГ БАЙГУУЛАХ НЬ

Би хэрхэн илүү сайн удирдагч болж чадах вэ?

Есүс Христ бол шударга удирдагчийн төгс төгөлдөр жишээ юм. Түүний Сүмийн удирдагчид өөрсдийн удирдах хүмүүсийг хайрлаж, тэдэнд үйлчилснээр Түүний жишээг дагадаг. Бид итгэлтэй шавь болохыг нэн түрүүнд хичээснээр бусдад гэрчлэлээ хөгжүүлж, Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христэд илүү ойр дотно болоход тусалж чадна.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Бэлдэж байхдаа эдгээр судар, материалыг залбирч, судлаарай. Та өсвөр үеийнхэнтэй юуг хуваалцахаар өдөөгдсөн бэ?

Египетээс гарсан нь 18:13–26 (Мосе Иетрогоос хэрхэн илүү үр дүнтэй удирдагч байх зөвлөгөөг авсан)

Матай 20:20–28; 23:11; С ба Г 50:26 (Христтэй адил удирдагчид өөрсдийн удирдах хүмүүст үйлчилдэг)

Иохан 13:4–15; 3 Нифай 18:16; 27:21, 27 (Есүс Христ бол удирдагчийн үлгэр жишээ юм)

Мозая 2:11–19 (Хаан Бенжамин хүмүүст үйлчилсэн нь)

С ба Г 121:34–46 (Шударга удирдлагын зарчмууд)

Стифэн В.Өвэн, “Агуу удирдагч агуу дагалдагч байдаг,” *Ensign* эсвэл 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 57–59

Томас С.Монсон, “Шударга байдлын жишээнүүд,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2008 оны 5-р сар, 65–68

Тэд Р.Каллистэр, “Залуу эрэгтэйд өгөгдсөн санваарын хүч,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2013 оны 5-р сар

“Есүс Христийн Сүмийн удирдлага,” *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 12–15

Христийн адил удирдагч болох өөрийн таньдаг хэн нэгний талаар бод. Тэр хүн удирдагчийн ямар шинж чанаруудыг эзэмшдэг вэ? Түүний удирдлага танд болон бусдад хэрхэн нөлөөлсөн бэ?

Өсвөр үеийнхэн яагаад хэрхэн удирдагч болох талаар суралцах хэрэгтэй вэ? Тэдэнд сүм, гэр орон, орон нутагтаа удирдах ямар боломжууд байгаа вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээл эсвэл найзуудтайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Та өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм.

- Өсвөр үеийнхнийг Сүмийн ангиудад сурсан ямар нэгэн зүйлийг сануулсан, саяхан тохиолдсон үйл явдлаасаа хуваалцахад урь.
- Аврагчийн зургийг харуулж (жишээлбэл: *Сайн мэдээний уран*

зургийн цуглуулга), самбар дээр *удирдагч* гэж бич. Есүс Христийг төгс төгөлдөр удирдагч гэж бодох үед тэдний оюун санаанд орж ирж байгаа өөр бусад үгийг самбар дээр бичихийг өсвөр үеийнхнээс хүс.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаанууд нь өсвөр үеийнхнийг илүү үр дүнтэй удирдагчид болж сурахад туслах юм. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу.

- Ангиараа Матай 20:20–28-ыг унш. Аврагч Бурханы хаант улсын удирдлагын талаар дагалдагчдадаа юу гэж заадаг вэ? Өсвөр үеийнхнийг дэлхийн удирдагчид ба Сүмийн удирдагчдыг харьцуулан, тэдний хоорондох ялгаатай болон адил төстэй зүйлүүдийг самбар дээр жагсаан бичихэд урь. Аливаа хүн хэрхэн бизнесийн эсвэл орон нутгийн удирдагч болдог вэ? Мөн хэрхэн Сүмийн удирдагч болдог вэ? Удирдагчийн ямар шинж чанарыг дэлхийнхэн үнэлдэг вэ? Мөн Сүмд ямар шинж чанарыг үнэлдэг вэ? Энэхүү ярилцлагын нэг хэсэг болгон Христтэй адил удирдагчийн зарчмуудыг заадаг судруудыг (энэ тоймд санал болгосон судар гэх мэт) уншихад өсвөр үеийнхнийг урь. Өсвөр үеийнхэнд эдгээр зарчмыг ойлгох нь яагаад чухал вэ? Тэд гэр бүл, Сүмийн үйлчлэл, орон нутагтаа эдгээрийг хэрхэн ашиглах вэ?
- *Гарын авлага 2-ын 3-р бүлэг* буюу “Есүс Христийн Сүмийн удирдлага” бүлгээс Аврагч жишээгээрээ харуулсан, зарчмуудыг зааж буй хэсгүүдийг сонгон ав (3.2.1, 3.3.3, 3.3.4, 3.3.5, 3.3.6 гэх мэт хэсгүүд). Ангийн гишүүн бүрээс эдгээр

хэсгийн нэгийг уншин, өөрийнх нь оногдсон хэсэгт заагдаж байгаа зарчмыг харуулсан түүхийг Аврагчийн амьдралаас бодож олохыг хүс (тэд санаа авч болохын тулд *Сайн мэдээний уран зургийн цуглуулгын 34–51-ийг* үзэж болно). Та мөн тэднээр Стифэн В.Өүвэний “Агуу удирдагч агуу дагалдагч байдаг” хэлсэн үгийг уншуулаад, Христтэй адил удирдах тухай гарч буй зарчим эсвэл түүхийг олуулж болно. Өсвөр үеийнхнээс гарын авлага, түүхээс юу мэдэж авсныг асуу. Тэд эдгээр зарчмын ямар жишээг амьдрал дээрээ харж байсан бэ?

- Ангиараа 3 Нифай 27:21, 27-г унш. Ерөнхийлөгч Томас С.Монсоны “Шударга байдлын жишээнүүд” гэсэн хэлсэн үгээс чихээ хөдөлгөж байсан тухай түүхийг (эсвэл түүний хэлсэн үгийн энэ хэсгийг видео бичлэгээр үзнэ үү) өсвөр үеийнхэнтэй хуваалцах үедээ эдгээр судрын захиасын талаар бодохыг тэднээс хүс. Энэ түүх нь өсвөр үеийнхэнд удирдлагын талаар юу зааж байна вэ? Тэднийг амьдарч байгаа байдлаараа бусдад ямар бодол төрүүлж байгаагаа тунгаан бодоход урь. Ангийн өөр нэгэн гишүүний

Сайн мэдээ судлах ур чадварууд

Зарчмуудыг олох нь. Зарчим гэдэг нь бидний үйл хөдлөлийг удирдаг мөнхийн үнэн юм. Зарим үед зарчмууд нь судруудад эсвэл бошиглогчийн үгсээр тодорхой илэрхийлэгддэг бол заримдаа эдгээр нь түүх, жишээгээр илэрхийлэгддэг. Та өсвөр үеийнхэнд Христийнхтэй адил удирдах зарчмуудын талаар заахдаа дараах “Би эдгээр судраас илүү сайн удирдагч болоход туслах юуг сурч байна вэ? Энэ хэсэгт Аврагчтай хэрхэн илүү адил болохыг надад зааж байгаа зүйл байна уу?” гэх мэт асуултыг тавьснаар эдгээр зарчмыг таньж мэдэн, суралцахад туслаарай. Судруудаас суралцах үедээ зарчмуудыг хайж эрэлхийлэхэд тэднийг урамшуул.

Видео бичлэг: “Зургуудыг ашиглах нь”

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагчийн тухай мэддэг зүйлсийнхээ талаар нэг хором бодоод үзээрэй.

Түүний заах, удирдах арга замын талаар та юу ажиглаж мэдсэн бэ? Тэр бусдад сурч, өсөж дэгжихэд нь хэрхэн тусалсан бэ? Та өсвөр үеийнхэнд сурч, өсөж дэгжихэд нь туслахдаа Түүний заах, удирдах жишээг хэрхэн дагаж болох вэ? Та тэднийг Христтэй адил удирдагчид болоход нь хэрхэн урамшуулж болох вэ?

жишээгээр адислагдаж байсан тохиолдлоосоо хуваалцахад тэднийг урамшуул. Тэд нэг нэгнээсээ удирдагчийн өөр ямар шинж чанаруудыг олж хардаг вэ?

- Ангийн нэг гишүүнээс үүргэвч үүрэхийг хүс. Үүргэвчийг хүнд болтол нь ном гэх мэт зүйлсээр дүүргэ. Энэ үүргэвч нь удирдагчийн дуудлагыг хэрхэн төлөөлж болохыг өсвөр үеийнхнээс асуу. Өсвөр үеийнхнийг Египетээс гарсан нь 18:13–26-г уншаад, илүү сайн удирдагч болох талаар Иетрогоос Мосегийн хүлээн авсан зөвлөгөөг эрэлхийлэхэд урь. Хэрвээ Мосе энэ зөвлөгөөг дагаагүй бол юу тохиолдох байсан бэ? Өсвөр үеийнхнээс гадасны өсвөр үеийнхний чуулганыг зохион байгуулах үүрэг оногдсон гэж төсөөлөн бодохыг хүс. Тэд

энэ нөхцөлд Иетрогийн зөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэх вэ? Тэдэнд өөрсдийн төсөөлж буйгаар өсвөр үеийнхний чуулганыг төлөвлөх цаг гаргаж өг. Тэд хэнээс тусламж хүсэх вэ? Тэд тухайн хүмүүсээс юу хийж өгөхийг хүсэх вэ?

- Ахлагч Тэд Р.Каллистэрийн “Залуу эрэгтэйд өгөгдсөн санваарын хүч” хэлсэн үгэнд заасан удирдлагын хэдэн зарчмаас хэсэг хэсгийг цаасан дээр бич. Ангийн гишүүн бүрд нэг нэг цаас өгөн, уг өгүүлээс оногдсон зарчмынхаа талаар мэдээлэл эрж хайхыг тэднээс хүс. Ахлагч Каллистэрээс удирдлагын талаар сурсан зүйлээ хуваалцахад ангийн гишүүдийг урь. Эдгээр зарчимтай холбоотой хувийн жишээнээсээ хуваалцахад тэднийг урамшуул.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд хэрхэн илүү сайн удирдагч болохыг ойлгож байна уу? Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өнөөдөр сурсан зүйл дээрээ тулгуурлан өсвөр үеийнхэн юу хийхээр сүнслэгээр өдөөгдөж байгаа талаар тэднээс асуу. Тэрхүү мэдрэмжүүдийнхээ дагуу үйлдэхэд тэднийг уриал. Суралцагчид үүний дагуу үйлдэж байгаа эсэхэд хяналт тавих аргуудыг бодож ол.

Сонгосон материалууд

Томас С.Монсоны “Шударга байдлын жишээнүүд” хэлсэн үгээс эш татав. *Ensign* эсвэл Лиахона, 2008 оны 5-р сар, 65–68

Та нарын олон нь Сүмийн дөрвөн Ерөнхийлөгчид зөвлөхөөр үйлчилсэн Ерөнхийлөгч Н.Элдон Таннэрыг санаж байгаа байх. Тэр аж үйлдвэрийн салбарт ажиллах хугацаандаа ч, Канадын засгийн газар үйлчилж байхдаа ч мөн хувийн амьдралдаа ч ямагт зөв шударгын гуйвшгүй үлгэр жишээг үзүүлсэн. Ерөнхийлөгч Таннэр бидэнд

“Сайн мэдээний сургаалуудын дагуу амьдрахаас илүү баяр хөөр, амжилтыг авчрах зүйл гэж үгүй. Үлгэр жишээ нь бай; Сайн сайхны нөлөө нь бай. . . .

“Бидний хүн тус бүр [Бурханы] нэрээр үйлдэх санваар болон хүч өгөгдсөн байх нь зохистой гэж үзсэн түүний сонгогдсон үйлчлэгчийн хувьд зарим ажилд урьдчилан томилогдсон. Та нарын удирдлага дор буй хувь хүмүүсийн амьдралд сайн эсвэл муу аль нэг байдлаар нөлөөлөх нөлөө тань ирээдүйн үр удамд нь ч нөлөөлсөөр байх болно гэдгийг ямагт сана” гэсэн сүнслэг зөвлөгөөг өгсөн. [“For They Loved the Praise of Men More Than the Praise of God,” *Ensign*, 1975 оны 11-р сар, 74.]

Ах нар минь, Бурханы санваар атгагчийн хувьд бид бусад хүмүүсийн дагах зөв шударгын үлгэр жишээ байхаар амьдрах нь бидний үүрэг мөн гэдгийг би давтан хэлье. Би ийм үлгэр жишээнүүдийг хамгийн сайнаар үзүүлж болохыг эргэцүүлэн бодох зуураа хэдэн жилийн өмнө гадасны чуулганд оролцож байхад болсон явдлыг бодсон юм. Нийтийн цуглааны үед нэгэн хүү гэр бүлтэйгээ гадасны төвийн урд талын эгнээнд сууж байхыг би ажигласан билээ. Би индэр дээр сууж

байв. Цуглаан үргэлжилж байх зуур намайг нэг хөлөө нөгөө дээрээ ачихад тэр хүү мөн адил хийж байхыг анзаарсан юм. Хэрэв би тэр хөдөлгөөнөө эсрэгээр нь хийж, нөгөө хөлөө ачихад тэр мөн л дуурайв. Намайг гараа өвөр дээрээ авахад тэр мөн л адил зүйлийг хийсэн. Намайг шанаагаа тулан суухад тэр мөн л дуурайсан билээ. Намайг юу л хийнэ, тэр миний хөдөлгөөн бүрийг дуурайж байв. Энэ нь намайг цугласан олонд хандан үг хэлэх цаг болох хүртэл үргэлжлэв. Би түүнийг сорихоор шийдсэн юм. Би түүн рүү эгцлэн хараад түүний анхаарлыг татсан гэдэгтээ итгэлтэй болсныхоо дараа чихээ хөдөлгөв. Тэр адил зүйл хийхийг дэмий л оролдож байсан, харин би түүнийг барьсан юм! Тэр зүгээр л чихээ хөдөлгөөд байж чадаагүй. Тэр дэргэдээ сууж байсан аав руугаа хараад ямар нэгэн зүйл шивнэлээ. Тэр чих рүүгээ заагаад дараа нь над руу заав. Аав нь миний чихээ хөдөлгөж байгааг харахаар над руу чиглэн харахад би юугаа ч үл хөдөлгөн, гараа зөрүүлэн сууж байлаа. Аав нь бага зэрэг ялагдсан байдалтай суух хүү рүүгээ эргэлзсэн байдалтай харав. Тэр эцэст нь над руу ичингүйрэн жуумалзаад мөрөө хавчсан юм.

Би тэр туршлагын тухай олон жилийн турш бодоод бид ялангуяа залуу байхдаа эцэг эхээ, удирдагчдаа мөн үе тэнгийнхнийгээ дуурайх хандлагатай байдгийг ойлгосон. Бошиглогч Бригам Янг хэлэхдээ: “Бид өөрсдийн хүүхдүүдэд харуулах хүсэлгүй аливаа зүйлсийг хэзээ ч өөрсдөдөө зөвшөөрөх ёсгүй. Тэднийг дуурайгаасай хэмээн хүсдэг үлгэр жишээг бид тэдэнд үзүүлэх ёстой” хэмээжээ. [*Deseret News*, 1871 оны 6-р сарын 21, 235.]



АРВАНХОЁРДУГААР САР: ХОЖМЫН ӨДРҮҮДЭД
БУРХАНЫ ХААНТ УЛСЫГ БАЙГУУЛАХ НЬ

Би хэрхэн илүү сайн багш болж чадах вэ?

Үр дүнтэй заах нь Их Эзэний хаант улсыг байгуулахын чухал хэсэг нь болдог бөгөөд бидэнд бусдад заах олон боломж гардаг. Бид бусдад заахаар албан ёсны дуудлага хүлээн аваагүй ч гэр бүлдээ мөн хөршийн болон найзын хувьд заах боломжууд гардаг. Бид өөрсдийн давуу болон сул талыг шударгаар дүгнэж, Их Эзэний тусламжийг даруухнаар эрэлхийлэн, мөн сайн мэдээг заахад зайлшгүй шаардлагатай чадвар, чадавхуудыг хөгжүүлэхийг хичээнгүйлэн эрэлхийлснээр илүү сайн багш нар болж чаддаг.

Та үр нөлөөтэй багш нараар хэрхэн адислагдаж байсан бэ? Та илүү сайн багш болохын тулд юу хийж байна вэ?

Та өсвөр үеийнхэнд заах ямар боломж олгосон бэ? Багш нарын хувьд тэдний давуу болон сул талууд нь юу вэ?

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон материалуудыг залбирч судал. Өсвөр үеийнхэнд хэрхэн илүү сайн багш нар болохоо ойлгоход нь юу туслах вэ?

Ифер 12:27 (Сул дорой зүйлүүдийг хүчирхэг болгоход Их Эзэн бидэнд туслах болно)

С ба Г 42:14 (Заахын тулд бид Сүнстэй байх ёстой)

С ба Г 88:78 (Хичээнгүйлэн заа)

Даллин Х. Өүкс, “Сайн мэдээг заах нь” *Ensign*, 1999 оны 11-р сар, 78–80

Дэвид М. Макконки, “Бурханы хүч ба эрх мэдлээр заах нь” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2013 оны 11-р сар

“Заах арга барилаа сайжруулах төлөвлөгөө гаргах нь” *Teaching, No Greater Call* (1999), 24–27

“Сайн Мэдээг заах нь” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 158–60.

“Аврагчийн арга барилаар заах нь” *Сайн мэдээг Аврагчийн арга барилаар заах нь* (2012), 4–5

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн минутад өсвөр үеийнхний янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд, эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний хамаарлыг олж харахад нь та өсвөр үеийнхэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

- Өсвөр үеийнхнээс хамгийн дуртай гэр бүлийн үдэш, эсвэл семинар, сүмийн хичээлийнхээ талаар товчхон ярьж өгөхийг хүс.

- Өсвөр үеийнхнийг сайн мэдээний дагуу амьдрахад сүнслэгээр нөлөөлж байсан хайртай багшийнхаа талаар бодоход урь. Юу энэ багшийг үр нөлөөтэй багш болгосон

бэ? Тэр багшид өсвөр үеийнхний дууриах ямар чанарууд байсан бэ? Өсвөр үеийнхнээс *Teaching, No Greater Call*, номын 26-р хуудас дээрх “Хамгийн чухал чанарууд” хэсгийг уншин, үр нөлөөтэй багш нарын өөр бусад чанаруудыг олохыг хүс. Сайн үр нөлөөтэй сайн мэдээний багш нар Бурханы хаант улсыг байгуулахад хэрхэн тусалдаг вэ?

Хамтдаа суралц

Дараах үйл ажиллагаа бүр нь өсвөр үеийнхэнд хэрхэн илүү сайн багш болохоор суралцахад нь тусалж чадах юм. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс олон үйл ажиллагааг сонгоно уу:

- Ангийнхныг гурван бүлэг болгож хуваан, бүлэг бүрээс дараах судруудын нэгийг уншихыг хүс: Ифер 12:27; С ба Г 42:14; С ба Г 88:78. Тэднээс дээрх судрууд нь илүү сайн багш болох талаар юу зааж байгааг тунгаан бодож мөн ярилцахыг хүс. Илүү сайн багш болох талаар нэмэлт мэдээллийг авахын тулд эдгээр шүлгүүдийн зүүлт тайлбаруудыг судруудаас олж уншихад тэднийг уриалаад мөн олж мэдсэн зүйлсээ хуваалцахыг хүс. “Итгэлдээ үнэнч байх нь” (158–60) номын “Сайн мэдээг заах нь” хэсгийг уншаад илүү хичээнгүй багш байх арга замуудын жагсаалтыг гаргахад өсвөр үеийнхнийг урь.

- Өсвөр үеийнхнээс ахлагч Даллин Х. Өүксийн “Сайн мэдээг заах” хэлсэн үгийн 3-р хэсгээс зургаан үндсэн заах зарчмыг олж, самбар дээр бичихийг хүс. Тэднээс өөрсдөө заах үед эдгээр зарчмуудыг хэр сайн хэрэгжүүлж байгаа талаараа

дүгнэлт хийхийг хүс. Эдгээрээс илүү сайн сурмаар байгаа эсвэл заах чадвараа дээшлүүлмээр байгаа нэг зарчмыг сонгоход тэднийг урь. Мөн ахлагч Өүксийн хэлсэн үгээс уг зарчмын талаар судалж, сурсан зүйлсээ хуваалцах, дараагийн удаа бусдад заахдаа тэд энэхүү зарчмыг хэрхэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа талаараа хуваалцахыг хүс.

- Ангиа хоёр бүлэг болгон хуваарил. *Teaching, No Greater Call* номын 24–25-р хуудас дахь “Өөрийн давуу болон сул талыг шинжлэн дүгнэх нь” хэсгийг нэг бүлгээр нь уншуулж, нөгөө бүлгээс нь 25–26-р хуудас дахь “Дээшлүүлэн сайжруулах төлөвлөгөө гаргах нь” хэсгийг уншихыг хүс. Бүлэг тус бүрдээ сурсан зүйлсийнхээ талаар ярилцаж, нөгөө бүлэгтэйгээ ярилцлагынхаа гол сэдвүүдийг хуваалцахыг тэднээс хүс. Зааж байхад нь тохиолдсон саяхны туршлагынхаа (жишээлбэл, гэр бүлийн үдэш, сүмийн ангид эсвэл гэрийн

Сайн мэдээг судлах үр чадварууд

Зүүлт тайлбаруудыг ашиглах. Энэ хэсгийн эхний үйл ажиллагаан дээр судруудын зүүлт тайлбаруудыг ашиглахад өсвөр үеийнхнийг урамшуулсан байгаа. Зүүлт тайлбарууд нь тэдний уншиж байгаа зүйлсийн талаарх ойлголтыг хэрхэн гүнзгийрүүлж байгааг олж мэдэхэд нь тусал. Судруудаас бие даан суралцахдаа зүүлт тайлбаруудыг байнга хэрэглэдэг байхад өсвөр үеийнхнийг урамшуул.

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн дагалдагчдад заан, адисалж мөн бусдад үйлчлэх чухал үүргүүдийг даалгасан. Өсвөр үеийнхэн өөрсдийн сурч байгаа зүйлсийг бусдад заах боломжуудыг ашигласнаар хэрхэн адислагдах вэ?

багшаар гэх мэт) талаар бодохыг өсвөр үеийнхнээс хүс. Өсвөр үеийнхэн бүрийг сайн мэдээний багшлалтаа сайжруулах төлөвлөгөө гарган, 25-р хуудас дээрх шиг хүснэгт бөглөхөд урь.

- Самбар дээр “Би хэрхэн илүү сайн багш болж чадах вэ?” гэж бич. Өсвөр үеийнхнийг Дэвид М. Макконкийн “Бурханы хүч ба эрх мэдлээр заах нь” хэлсэн үгийг эсвэл “Аврагчийн арга барилаар заах нь” сэдвийг *Аврагчийн арга барилаар сайн мэдээг заах нь* (4–5) номоос уншаад энэхүү асуултын хариултыг олоход урь. Тэднийг олсон хариултаа мөн сурсан зүйлсээ бусдад заахдаа

хэрэглэх тодорхой арга барилуудын талаар хуваалцахад урь.

- Өсвөр үеийнхнийг *Итгэлдээ үнэнч байх нь* номоос “Заах арга барилууд” хэсгийг уншаад тэндээс олсон заах аргуудыг самбар дээр жагсаан бичихэд урь. Өсвөр үеийнхэн эдгээр аргуудыг хэрэглэгдэж байсныг урьд нь хэзээ харсан бэ? Өсвөр үеийнхэн бүрийг Итгэлийн тунхагаас нэгийг сонгож, самбар дээрх аргуудаас нэгийг нь ашиглан бүлэг хүүхдүүдэд заахаар хэдэн минут зарцуулан бэлтгэхийг хүс. Тэднээс бэлдсэн зүйлээ хуваалцахыг хүс.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд хэрхэн илүү сайн багш болж чадахыг ойлгож байна уу? Тэдэнд өөр асуултууд байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхнийг хичээлийн үеэр төрсөн сэтгэгдлээ хуваалцахад урь. Багш нарын хувьд өсч дэгжихийн тулд тэд юу хийх вэ? Тэднийг туршилагуудаа дараагийн хичээлүүд дээр хуваалцахад урамшуул.

Сонгосон материалууд

Томас С.Монсон, “Examples of Righteousness,” Ensign эсвэл Liahona, 2008 оны 5-р сар, 66-аас эш татав

Ах нар минь, Бурханы санваар атгагчийн хувьд бид бусад хүний дагах зөв шударгын үлгэр жишээ байхаар амьдрах нь бидний үүрэг мөн гэдгийг би давтан хэлье. Би ийм үлгэр жишээнүүдийг хамгийн сайнаар үзүүлж болохыг эргэцүүлэн бодох зуураа хэдэн жилийн өмнө гадасны чуулганд оролцож байхад болсон явдлыг санав. Нийтийн цуглааны үед нэгэн хүү гэр бүлтэйгээ гадасны төвийн урд талын эгнээнд сууж байхыг би ажиглалаа. Би индэр дээр сууж байв. Цуглаан үргэлжилж байх зуур намайг нэг хөлөө нөгөө хөл дээрээ ачихад тэр хүү мөн адил хийж байхыг анзаарсан юм. Намайг тэр хөдөлгөөнөө эсрэгээр нь хийж, нөгөө хөлөө ачихад тэр мөн л дуурайв. Намайг гараа өвөр дээрээ авахад тэр мөн л адил зүйлийг хийсэн. Намайг шанаагаа тулан суухад тэр мөн л дуурайсан билээ. Намайг юу л хийнэ, тэр миний хөдөлгөөн бүрийг дуурайж байв. Энэ нь намайг цугласан олонд хандан үг хэлэх цаг болох хүртэл үргэлжлэв. Би түүнийг сорихоор шийдсэн юм. Би түүн рүү эгцлэн хараад, түүний

анхаарлыг татсан гэдэгтээ итгэлтэй болсныхоо дараа чихээ хөдөлгөв. Тэр адил зүйл хийхийг дэмий л оролдож байсан, харин би түүнийг барьсан юм! Тэр зүгээр нэг чихээ хөдөлгөөд байж чадаагүй. Тэр дэргэдээ сууж байсан аав руугаа хараад, ямар нэгэн зүйл шивнэлээ. Тэр чих рүүгээ заагаад, дараа нь над руу заав. Аав нь миний чихээ хөдөлгөж байгааг харахаар над руу чиглэн харахад би юугаа ч үл хөдөлгөн, гараа зөрүүлэн сууж байлаа. Аав нь бага зэрэг ялагдсан байдалтай суух хүү рүүгээ эргэлзсэн байдалтай харав. Тэр эцэст нь над руу ичингүйрэн жуумалзаад, мөрөө хавчсан юм.

Би тэр туршлагын тухай олон жилийн турш бодоод, бид ялангуяа залуу байхдаа эцэг эх, удирдагчдаа мөн үе тэнгийнхнийгээ дуурайх хандлагатай байдгийг ойлгосон. Бошиглогч Бригам Янг “Бид өөрсдийн хүүхдүүдэд харуулах хүсэлгүй аливаа зүйлсийг үйлдэхийг хэзээ ч өөрсдөдөө зөвшөөрөх ёсгүй. Бид тэднээс даган дуурайгаасай гэж хүсэж байгаа үйлдлээ өөрсдөө үлгэрлэн харуулах ёстой” хэмээн хэлжээ.



АРВАНХОЁРДУГААР САР: ХОЖМЫН ӨДРҮҮДЭД
БУРХАНЫ ХААНТ УЛСЫГ БАЙГУУЛАХ НЬ

Бусадтай сайн мэдээ хуваалцах ямар үр дүнтэй арга замууд байдаг вэ?

Сайн мэдээ хуваалцах нь хожмын үеийн гэгээнтэн бүрийн үүрэг юм. Бид сэргээгдсэн сайн мэдээний талаар бусдад ярьж өгөх боломжийн төлөө залбирч мөн эрэлхийлэх хэрэгтэй. “[Бидний] доторх найдварын талаар [биднээс] асуух хүн бүрд хариу өгөхөд ямагт бэлэн байж чадна” (1 Петр 3:15).

Танд бусадтай сайн мэдээг хуваалцах ямар боломж гарч байсан бэ? Та бусадтай сайн мэдээ хуваалцахын тулд юу хийж байсан бэ?

Өсвөр үеийнхэнд сайн мэдээ хуваалцах талаар ямар туршлага байна вэ? Өсвөр үеийнхэнд сайн мэдээ хуваалцах ямар боломж байна вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судрууд болон материалуудыг залбирч судал. Өсвөр үеийнхнийг сайн мэдээг хэрхэн хуваалцах талаар ойлгоход нь юу туслах вэ?

Матай 28:19–20 (Аврагч Өөрийн дагалдагчдад сайн мэдээг бүх үндэстнүүдэд заахыг зарлигласан)

Ром 1:16 (Есүс Христийн сайн мэдээ нээс Паул ичээгүй)

1 Тимот 4:12 (Итгэгч хүмүүсийн жишээ бай)

1 Петр 3:15 (Сайн мэдээний асуултуудад хариулахад бэлэн бай)

С ба Г 1:23 (Сул дорой бөгөөд энгийн хүмүүс сайн мэдээг тунхагладаг)

С ба Г 11:21 (Бурханы үгийг олж авахыг эрэлхийлснээр сайн мэдээг тунхаглахад бид бэлтгэх ёстой)

С ба Г 33:8–10 (Бид амаа нээх хэрэгтэй)

С ба Г 88:81 (Хөршөө сэрэмжлүүлэхийг бидэнд зарлиг болгосон)

С ба Г 100:5–8 (Ариун Сүнс бидний юу хэлэх ёстойг хэлж өгч мөн сайн мэдээний үнэний гэрч болох болно)

Нийл Л. Андэрсэн, “Энэ бол гайхамшиг,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2013 оны 5-р сар

Рассэл М. Нэлсон, “Итгэгчдийн үлгэр жишээ бай,” *Ensign* эсвэл *Лиакхона*, 2010 оны 11-р сар, 47–49

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд, эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Та өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний

нөлөөг олж харахад нь тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Өсвөр үеийнхнийг нэг найзынхаа үгс болон үйл хөдлөлөөс сайн мэдээний зарчим сурч мэдэж байсан үеийнхээ талаар хуваалцахад урь.
- Мөн тэднийг сайн мэдээ хуваалцсан дурсамжаасаа хуваалцахад урь

эсвэл та дурсамжаасаа хуваалцах талаар бодож үзээрэй. Тэд сайн мэдээг илүү үр дүнтэй хуваалцахад нь туслах эдгээр туршлагауудаас юу сурч байна вэ?

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр өсвөр үеийнхэнд сайн мэдээг хэрхэн үр дүнтэй хуваалцахыг сурахад нь туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангийнхандаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- “Бид яагаад сайн мэдээг хуваалцах хэрэгтэй вэ?” мөн “Бид сайн мэдээг хэрхэн хуваалцах хэрэгтэй вэ?” гэсэн хоёр асуултыг самбар дээр бич. Өсвөр үеийнхнийг хоёр бүлэг болгон хуваан, тэднээс эдгээр асуултуудад хариулт өгөх судруудыг олохыг хүс (энэхүү хичээлд санал болгосон судруудыг үзнэ үү; хэрэв шаардлагатай бол, уншиж байгаа судраа баттай сайн ойлгохын тулд нэгээс дээш удаа уншихыг өсвөр үеийнхэнд урамшуулан хэл). Тэднээс олж мэдсэн зүйлээ хуваалцаж мөн самбар дээрх асуултынхаа дор зохих хариултуудыг бичихийг хүс. Өсвөр үеийнхнээс сайн мэдээг хуваалцах өөрсдийн хичээл зүтгэлдээ хэрэгжүүлэх нэг зүйлийг самбар дээр бичсэн хариултуудаас сонгохыг хүс.
- Ахлагч Рассэл М. Нэлсоны “Итгэгчдийн үлгэр жишээ бай” хэмээх хэлсэн үгийн “Гишүүн номлогчид”. Тэднээс сайн мэдээг илүү үр дүнтэй хуваалцахад нь туслах зөвлөгөөг эрэлхийлэхийг хүс. Тэднээс олж мэдсэн зүйлсээ мөн

түүнийг хэрэгжүүлж болох тодорхой арга замын талаар хуваалцахыг хүс. Боломжтой бол ярилцсан зүйлсийн аль нэгээр дадлага хийх цагийг ангидаа гаргаж өгөөрэй.

- “Итгэл бишрэлээ хуваалцах нь” видео бичлэгийг үзүүлэн, хүмүүс сайн мэдээ хуваалцахдаа технологийг хэрхэн ашиглаж байгааг ажигласан арга замуудын талаар хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс. Тэд өөр ямар арга замуудын талаар юу бодож байна вэ? Найз нөхөдтэйгээ болон гэр бүлийн гишүүдтэйгээ сайн мэдээг хуваалцахдаа технологийг ашиглаж болох арга замуудыг төлөвлөх цагийг ангидаа гаргаж өгөөрэй.
- Ангийн гишүүдийг хоёр бүлэг болгон хуваарилан, бүлгүүдэд ахлагч Нийл Л. Андэрсэний “Энэ бол гайхамшиг” гэсэн хэлсэн үгийн хуулбарыг өг. Өсвөр үеийнхнээс “Хэрвээ та бүрэн цагийн номлогч биш бол” гэсэн хэсгээс эхлээд хэлсэн үгийг хамтдаа уншихыг хүс. Нэг бүлгээс сайн мэдээг үр дүнтэй

Заахад туслах арга

“Заримдаа хүмүүс бусад хүмүүсийн хэлж байгаа үгийг сонсохын оронд өөрийн хэлэх гэж байгаа зүйлийн талаар бодох магадлал их байдаг. Хариулах хариултаа бэлдэхийн оронд ярьж байгаа хүнд бүхий л анхаарлаа баттай төвлөрүүлээрэй” (*Teaching, No Greater Call* [1999], 67).

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч Өөрийн зааж байсан тэдэнд үлгэр жишээ үзүүлж, зөвлөх нь байсан. Таны жишээ өсвөр үеийнхнийг найз нөхөдтэйгээ болон гэр бүлийнхээ гишүүдтэй сайн мэдээг хуваалцахад нь хэрхэн урамшуулах вэ?

хуваалцахад маань бидэнд туслах ахлагч Андэрсэний өгсөн зөвлөгөөг, нөгөө бүлгээс мөн тийн үйлдэх тэдэнд өгөгдсөн амлалтуудыг эрж хайхыг хүс. Тэднээс олж мэдсэн

зүйлээ хуваалцахыг хүс. Өсвөр үеийнхэн ахлагч Андэрсэний зааж байгаа зүйлийг хэрэгжүүлэхийн тулд юу хийж чадна гэж та бодож байна вэ?

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Тэд сайн мэдээг хэрхэн хуваалцахыг ойлгож мэдэж байна уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их хугацаа зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхнийг хичээлдээ сурсан зүйлсээ ашиглан бусадтай сайн мэдээг хуваалцах боломжуудын төлөө залбирахад урь. Тэднийг дараагийн хичээлүүд дээр туршилагаасаа хуваалцахад урь.

Сонгосон материалууд

Рассэлл М.Нэлсоны “Итгэгчдийн үлгэр жишээ бай” хэлсэн үгээс эш татав. Ensign эсвэл Лиахона, 2010 оны 11-р сар, 51–53

Гишүүн бүр итгэгчдийн үлгэр дуурайл байж чадна. Ах нар аа, Есүс Христийг дагагчдын хувьд та нар нэг бүрчлэн Түүний сургаалуудын дагуу амьдарч чадна. Та нар “ариун зүрх мөн цэвэр гартай” байж чадна. Та нар “Бурханы дүр төрхийг өөрийн [төрх байдалд] шингээж” чадна [Алма 5:19]. Та нарын сайн үйлс бусдад илэрхий байх болно [Матай 5:16; Алма 7:24-ийг үзнэ үү]. Их Эзэний гэрэл та нарын нүднээс цацрах болно [Сургаал ба Гэрээ 88:11-ийг үзнэ үү]. Энэхүү цацарсан гэрэлтэйгээр асуултад хариулах бэлтгэлтэй бай. Төлөөлөгч Паул ийн “Харин та нарын доторх найдварын талаар асуух хүн бүрд хариу өгөхөд ямагт бэлэн бай” гэж зөвлөсөн [1 Петр 3:15].

Хариулт тань халуун дотно, баяр баясгалантай байг. Мөн хариулт тань тухайн хүнд хүндэтгэлтэй хандахуйц байг. Тэр мөн Бурханы хүүхэд бөгөөд Бурхан түүнийг мөнхийн амьдралд орох зохистой болж, нэгэн өдөр Түүнд эргэн ирэхийг хүсч байгаа гэдгийг санаарай. Түүний авралын болоод Христийн сургаалын талаарх ойлголтын үүдийг нээх тэр хүн нь та байж болох юм [2 Нифай 31:2, 21-ийг үзнэ үү].

Эхний хариултаа өгсний дараа, дараагийн алхмыг хийхэд бэлэн бай. Та нар найзыгаа сүмд ирэхийг урьж болно. Ихэнх найз нөхөд маань манай сүмд зочилж болно гэдгийг мэддэггүй. Түүний талаар илүү ихийг суралцахыг хүссэн хүмүүст Аврагч “Ир, та нар харна” гэсэн урилгыг илгээдэг [Иохан 1:39]. Ням гаргийн цуглаан эсвэл сүмийн үйл ажиллагаа эсвэл үйлчлэлд хамт оролцохыг урих нь буруу цуу яриануудыг сарниулж, зочдоод бидний дунд илүү таатай байх орчныг бүрдүүлэхэд туслах болно. . . .

Мормоны ном уншихыг найзаасаа хүсэж болно. Энэ нь уран зохиол эсвэл түүхийн ном биш гэдгийг тайлбарлаарай. Энэ бол Есүс Христийн бас нэгэн гэрээ. Үүний гол зорилго нь “өөрийгөө бүх үндэстнүүдэд үзүүлэх тэр Есүс бол Христ, Мөнхийн Бурхан хэмээн Иудей болон харийнханд итгүүлэх” явдал юм [Мормоны номын эхний хуудас]. Энэхүү номонд үнэнийг шударгаар эрэлхийлэгч хүмүүсийн зүрхэнд хүрч амьдралыг нь адислах хүч чадал бий. Найзыгаа энэ номыг залбирч, уншихад урь. . . .

Сургаалыг хуваалцах бас нэгэн арга нь найз нараа гэртээ урьж, бүрэн цагийн номлогчидтой уулзуулах явдал юм. Тэдгээр номлогчид сайн мэдээний сургаалыг заахаар дуудагдаж, бэлтгэгдсэн хүмүүс. Та нарын найз нөхөд гэрт тань тайвшралыг олж, та нарын байнгын дэмжлэгтэйгээр өөрсдийнхөө аврал ба өргөмжлөлд хүрэх аянаа эхлүүлж чадна. Их Эзэн “Та нар миний сонгосон хүмүүсийн цугларалтыг тохиолгон авчрахаар дуудагдсан билээ; учир нь миний сонгосон хүмүүс дуу хоолойг минь сонсож мөн зүрх сэтгэлээ хатууруулах нь үгүй” гэж хэлсэн [Сургаал ба Гэрээ 29:7].

Интернэт хөгжсөн энэ үед номлолын ажлыг хийх олон шинэ сонирхолтой аргууд гарч ирж байна. Та нар найз нөхөд, хөршүүддээ шинэ mormon.org вэб хаягаар орж үзэхийг санал болгож болно. Хэрэв та нар блог болон олон нийтийн сүлжээнд онлайнаар нэвтрэх боломжтой бол mormon.org хаяг руу орж болно. . . .

Есүс Христийн үлгэр жишээч дагалдагч бүр үр нөлөөтэй гишүүн номлогч болж чадна. Хайртай найз нөхөд ба хөршүүддээ сайн мэдээний сургаалын адислалуудыг авчрах ажилд гишүүд болон бүрэн цагийн номлогчид хамтдаа хөл нийлүүлэн, зэрэгцэн алхаж чадна. Тэдний ихэнх нь Израилын угсааныхан бөгөөд амлагдсаны дагуу цуглуулагдаж байгаа билээ. Энэ бол Их Эзэний Хоёр дахь ирэлтэд бэлтгэх бэлтгэлийн нэг хэсэг юм. Тэрээр бид бүгдийг итгэгчдийн үлгэр дуурайл болохыг хүсдэг.



АРВАНХОЁРДУГААР САР: ХОЖМЫН ӨДРҮҮДЭД
БУРХАНЫ ХААНТ УЛСЫГ БАЙГУУЛАХ НЬ

Би Хоёр дахь Ирэлтийн талаар заахад ашиглагддаг шинж тэмдгүүдийг хэрхэн ойлгож болох вэ?

Аврагч болон Түүний үйлчлэгчид Хоёр дахь Ирэлтийн талаар заахдаа тэмдгүүд болон сургаалт зүйрлэлийг олонтоо хэрэглэдэг байсан. Бид эдгээр тэмдгүүдийг хөрвүүлж сурах юм бол Хоёр дахь Ирэлт болохын өмнө тохиох үйл явдлуудын талаар ойлгох ойлголтоо гүнзгийрүүлж чадна.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судрууд болон материалаудыг залбирч, судал. Өсвөр үеийнхэн Хоёр дахь Ирэлттэй холбоотой бэлгэ тэмдгүүд болон сургаалт зүйрлэлүүдийг ойлгоход юу туслах вэ?

Судрууд дахь ямар сургаалт зүйрлэлүүд болон бэлгэ тэмдгүүд нь Хоёр дахь Ирэлтийг илүү сайн ойлгоход тань тусалсан бэ? Танд эргэж ирэхэд бэлтгэхэд тань Аврагчийн эдгээр харьцуулалтууд ямар урам, хүслийг төрүүлсэн бэ?

Хоёр дахь Ирэлтийн талаарх бэлгэ тэмдгүүд болон сургаалт зүйрлэлүүдийн аль нь таны заадаг өсвөр үеийнхний сонирхлыг татаж болох вэ? Та тэдний эргэн тойрон дахь дэлхийд эдгээр бошиглолууд хэрхэн биелэгдэж байгааг олж мэдэхэд нь тэдэнд хэрхэн тусалж болох вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Матай 13:24–30; С ба Г 86:1–7 (Буудай болон зэрлэг өвсний сургаалт зүйрлэл)

1 Тесалоник 5:2–8; 2 Петр 3:10–14; С ба Г 106:4–5; Иосеф Смит—Матай 1:46–48 (Хоёр дахь Ирэлт нь шөнийн харанхуй дахь хулгайч мэт ирэх болно)

Матай 25:1–13; С ба Г 45:56–57; 63:54 (Арван онгон охины сургаалт зүйрлэл)

С ба Г 45:34–39; Иосеф Смит—Матай 1:38–39 (Инжир модны сургаалт зүйрлэл)

Иосеф Смит—Матай 1:49–54 (Эзэн нь итгэлтэй болон хилэнцэт зарц дээрээ айлчилж байгааг Хоёр дахь Ирэлттэй харьцуулсан нь)

Даллин Х. Өүкс, “Хоёр дахь Ирэлтэд бэлтгэх нь,” *Ensign* ба *Лиакхона*, 2004 оны 5-р сар, 7–10

“Зүйрлэлүүд ба үзүүлэнгэй хичээлүүд,” *Teaching, No Greater Call* (1999), 163–64

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд, эсвэл найз нартайгаа хамт туулсан туршилага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Та өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний

нөлөөг олж харахад нь тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Сурч байгаа сайн мэдээний үнэнүүдийг жагсаан бичихийг тэднээс хүс. Дараа нь эдгээрийн хоорондох хамаарлуудын талаар ярилц.
- Өсвөр үеийнхнийг *Teaching, No Greater Call* номын 163-р хуудас дахь “Харьцуулалт ба үзүүлэн-тэй хичээлүүд” гарчигтай хэсгээс ерөнхийлөгч Бойд К. Пакэрын

харьцуулалтыг ашиглах талаар хэлсэн үгээс эш татан авсныг уншихад урь. Харьцуулалт нь (бэлгэ тэмдгүүд, сургаалт зүйрлэл гэх мэт) сайн мэдээний зарчмуудыг ойлгоход бидэнд хэрхэн тусалдаг вэ? Өсвөр үеийнхэн Хоёр дахь Ирэлтийн талаар бидэнд заадаг судрууд дахь ямар харьцуулалтыг мэдэх вэ?

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь өсвөр үеийнхэнд Хоёр дахь Ирэлтийн талаар заахад ашиглагддаг тэмдгүүдийг ойлгоход нь туслах болно. Ариун Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

- Өсвөр үеийнхнээс энэхүү тоймд санал болгосон арван онгон охины сургаалт зүйрлэлийг харуулдаг судруудыг уншихыг хүс (эсвэл “Мэргэн тэд нь” видео бичлэгийг үзүүлж болно). Цаасан дээр зураас татан хоёр багана гарган, багануудыг “Арван онгон охины сургаалт зүйрлэл” мөн “Хоёр дахь Ирэлт” гэж гарчиглан, хувь хувьдаа Аврагчийн хийсэн харьцуулалтын талаар бодохыг өсвөр үеийнхнээс хүс. Эхний багананд сургаалт зүйрлэлийн бүрэлдэхүүн болох ухаалаг охид, Хүргэн, тос гэх мэт бичин, хоёр дахь багананд эдгээр зүйлс нь Хоёр дахь Ирэлтийн хувьд юу төлөөлж байгааг бичихэд урь. Хэрвээ тэдэнд туслалцаа хэрэгтэй бол “Арван онгон охины сургаалт зүйрлэл” (*Ensign*, 2009 оны 3 сар, 48–49; ба *Лиакхона*, 2009 оны 3-р сар, 20–21) өгүүллийг хуваалц. Хамтдаа юу сурснаа болон энэ зүйрлэлт үлгэрийг судалсныхаа дараа юу хийхээр

сүнслэгээр нөлөөлөгдөж байгаа талаар нь ярилц.

- Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийг харанхуй шөнөөр ирэх хулгайчтай зүйрлэсэн гэх мэтчилэн энэ хичээлд санал болгосон судруудыг уншихыг өсвөр үеийнхэн бүрээс хүс. Тэднээс Хоёр дахь Ирэлтийн талаар сурсан зүйлээ ярилцахыг хүс. Хоёр дахь Ирэлт нь ямар хүмүүсийн хувьд хулгайч мэт ирэх вэ? Бид бэлтгэлтэй байхын тулд юу хийж болно гэж судруудад өгүүлж байна вэ? Хоёр дахь Ирэлттэй харьцуулах зүйлсийг өөрсдөө бодож олоод, харьцуулалтаа ангийнхантайгаа хуваалцахад урь.
- Ангиараа Иосеф Смит—Матай 1:49–54-ийг унш. Өсвөр үеийнхнээс хоёр зарцын хоорондох ялгааны талаар ярилцахыг хүс. Бидний өдрүүдэд зарим хүмүүс хилэнцэт зарцтай юугаараа адил байдаг вэ?

Сайн мэдээг судлах үр чадварууд

*Тэмдгүүдийг ойлгох нь. Судрууд дээрх сургаалт зүйрлэл болон бэлгэ тэмдгүүдийг ойлгохын тулд өсвөр үеийнхэн бэлгэ тэмдгүүдийг, тэмдгүүдийн хэсгүүдийг таньж мөн хөрвүүлж чаддаг байх хэрэгтэй. Бэлгэ тэмдгүүдийг таньж мэдэх нэг арга зам нь *лугаа, адил, адилтгагдах, түүний адил* ба *мэт, гэхчлэн үгсийг эрж хайх явдал юм.* Тэгээд өсвөр үеийнхэн бэлгэ тэмдгүүдийн хэсгүүдийн (тос, гэрэл, охин, Хүргэн гэх мэт) жагсаалтыг гаргаж чадна. Бэлгэ тэмдгүүдийг хөрвүүлэхийн тулд тэд сүмийн материалуудыг (Сүмийн сэтгүүлүүд, чуулган дээр хэлсэн үгс мөн өөр бусад судрууд гэх мэт) үзэж болох бөгөөд уг бэлгэ тэмдэг нь сайн мэдээний зарчмыг ойлгоход тэдэнд хэрхэн тусалж байгааг бодож үзээрэй. Хувиараа сайн мэдээнээс суралцах үедээ сургаалт зүйрлэл эсвэл бэлгэ тэмдэгтэй таарах юм бол үүний адил үйлдэхэд тэднийг урамшуул.*

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч шавь нартаа ойлгуулахын тулд энгийн түүхүүд, сургаалт зүйрлэлүүд болон амьдралд тохиолдсон жишээнүүдээс хуваалцдаг байсан. Тэрээр тэдэнд сайн мэдээний сургаалуудыг хувийн туршлага болон эргэн тойронд нь буй орчноос олж мэдэхэд нь тусалдаг байв. Өсвөр үеийнхэнд Хоёр дахь Ирэлтийн талаар ойлгоход нь туслахын тулд та сургаалт зүйрлэлүүд болон бэлгэ тэмдгүүдийг хэрхэн ашиглах вэ?

Зарц нарын үйлсийн үр дагаврууд нь юу байсан бэ? Өсвөр үеийнхнээс шүлгүүдийн зүүлт тайлбарт байгаа судруудын нэгийг сонгон уншихыг хүс. Тэднийг эдгээр нэмэлт судруудыг уншсанаар харьцуулах талаар илүү олж мэдсэн зүйлсээ хуваалцахад урь.

- Нэг найз нь Хоёр дахь Ирэлтийн өмнө тохиох үйл явдлуудын талаар санаа зовж байгаагаа илэрхийлж байгаа мэтээр төсөөлөн бодохыг өсвөр үеийнхнээс хүс. Тэр найзыгаа тайвшруулахын тулд тэд түүнд юу гэж хэлэх вэ? “Бүү санаа зов” видео бичлэгийг үзүүлж мөн найзтайгаа хуваалцаж болох нэмэлт зүйлүүдийг мөн судруудыг бичиж авахыг өсвөр үеийнхнээс хүс. Өсвөр үеийнхнийг сурсан зүйлсээ ашиглан Хоёр дахь Ирэлтийн талаар санаа зовж байгаа найзаа тайвшруулж байгаа дүр үзүүлэн жүжиглэхэд урь.

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурч мэдсэн зүйлийнхээ талаар хуваалцахыг хүс. Тэд ямар бодол, сэтгэгдэлтэй байна вэ? Хоёр дахь Ирэлтийн талаар сургаалт зүйрлэл болон бэлгэ тэмдгүүдийг тэд ойлгож мэдэж байна уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйл дээрээ тулгуурлан юу хийхээр сүнслэгээр өдөөгдөж байгааг нь асуу. Тэрхүү мэдрэмжийнхээ дагуу үйлдэхэд тэднийг урамшуулан дэмж. Өсвөр үеийнхэнд Хоёр дахь Ирэлтийн бэлгэ тэмдгүүдийн талаар бусдад заах ямар боломжууд байдаг вэ?

- Ахлагч Даллин Х. Өүксийн “Хоёр дахь Ирэлтэд бэлтгэх нь” хэлсэн үгийн 3-р хэсгийг ангийн нэг хэсгээр уншуулж, нөгөө хэсгээс 4-р хэсгийг уншихыг хүс. Тэднээс ахлагч Өүксийн ярьсан Хоёр дахь Ирэлтэй холбоотой бэлгэ тэмдгүүдийг олж, хуваалцахыг хүс. Эдгээр тэмдгүүд нь юу төлөөлж болох вэ? Ахлагч Өүксийн дараах асуултуудад хариулан, хариултуудаа бичих цагийг өсвөр үеийнхэнд өгөөрэй: “Тэр маргааш ирвэл яах вэ? . . . Бид өнөөдөр юу хийх вэ? Бид ямар зүйлд буруугаа хүлээх вэ? Бид ямар үйлдлүүдээ зогсоох вэ? Бид ямар зүйлийг хийж дуусгах вэ? Бид ямар өршөөлийг үзүүлэх вэ? Бид ямар гэрчлэлийг хуваалцах вэ? (Ensign эсвэл Лиакхона, 2004 оны 5-р сар, 9).



АРВАНХОЁРДУГААР САР: ХОЖМЫН ӨДРҮҮДЭД
БУРХАНЫ ХААНТ УЛСЫГ БАЙГУУЛАХ НЬ

Би Хоёр дахь Ирэлтэд бэлтгэхэд туслах ямар зүйлүүдийг судраас сурч чадах вэ?

Есүс Христ дэлхий дээр хүч чадал болон алдар суугаараа дахин ирэх болно гэж амласан юм. Хожмын үеийн гэгээнтний хувьд бидний хүлээдэг үүргүүдийн нэг нь Хоёр дахь Ирэлтэд өөрсдийгөө бэлтгэж мөн дэлхийнхэнд бэлэн байхад нь туслах явдал юм. Шударга хүмүүсийн хувьд Хоёр дахь Ирэлт нь энх амгалан болон ялалтын өдөр байх болно. Аврагч дахин яг хэзээ ирэхийг бид мэдэхгүй, гэхдээ бошиглолуудыг судлан мөн Түүний ирэлтийн тэмдгүүдийг ажиглах нь Хоёр дахь Ирэлтийн талаарх бидний гэрчлэлийг хүчирхэгжүүлж, Түүнийг ирэх үед бэлэн байхад маань туслах болно.

Сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлтгэ

Эдгээр судар болон бусад материалуудыг залбирч, судал. Та өсвөр үеийнхэнтэй юу хуваалцахаар өдөөгдсөн бэ?

Лук 21:34–36 (Их Эзэний өмнө зогсохдоо зохистой байхын тулд бид ямагт сэргэг байж мөн залбирч байх хэрэгтэй)

2 Петр 3:10–13 (Бид Аврагчийн Ирэлтийг хүлээж мөн бэлдэх ёстой)

1 Нифай 22:17 (Зөв шударгыг үйлдэгчид айхын хэрэггүй)

С ба Г 45:26–44; Иосеф Смит—Матай 1:21–36 (Хоёр дахь Ирэлтийн тэмдгүүд)

С ба Г 49:7; Иосеф Смит—Матай 1:40 (Их Эзэний ирэх цаг болон өдрийг мэдэх хүмүүн үгүй)

“Есүс Христийн Хоёр дахь Ирэлт,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 89–91

Танд Хоёр дахь Ирэлтийн талаарх ямар судрууд амар амгаланг авчирдаг вэ? Та Хоёр дахь Ирэлтэд бэлтгэн юу хийж байна вэ?

Өсвөр үеийнхэн судрууд дахь суралцах тусламжуудыг сайн ашиглаж мэдэх үү? Судруудаас суралцаж сурах нь тэднийг ямар арга замуудаар адислах вэ?

Заах болон суралцах бусад санаануудыг хавсралтаас үзнэ үү.

Уялдаа холбоог бий болго

Хичээл бүрийн эхний цөөн хэдэн хоромд өсвөр үеийнхэнд янз бүрийн нөхцөлд сурч байгаа (хувиараа судраас суралцах, семинар, сүмийн бусад хичээлүүд, эсвэл найз нартайгаа хамт туулсан туршлага гэх мэт) зүйлсийнх нь хоорондох уялдаа холбоог гаргахад туслаарай. Та өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний нөлөөг олж харахад нь тэдэнд хэрхэн тусалж чадах вэ? Дараах санаанууд тусалж болох юм:

- Өсвөр үеийнхнийг хувиараа судраас суралцахдаа эсвэл Сүмийн ангиуддаа сурч байгаа

сэдвүүдийнхээ талаар ярилцахад урь. Тэдэнд сурч байгаа зүйлсийнхээ талаар асуух асуулт байна уу?

- Аврагчийн мэндэлж байгаа болон Хоёр дахь Ирэлтийн сэдэвтэй зургуудыг үзүүл (*Сайн мэдээний зургийн цуглуулга*, 30, 66 үзнэ үү). Өсвөр үеийнхнээс “Есүс эгэлхнээр төрсөн” (*Сүмийн дуулал*, х. 20) дууг дуулж эсвэл үгийг нь уншин, Түүний дэлхий дээрх тохинуулал Хоёр дахь Ирэлтээс нь ямар ялгаатай байхыг харуулсан үгс, холбоо үгсийг зураг

тус бүрийн дор бичин жагсаалт гаргахыг хүс. Өсвөр үеийнхэнд Хоёр дахь Ирэлтийн талаар ямар асуултууд байгааг асуу. Тэдний асуултуудыг самбар дээр бичин мөн энэ хичээл дээр Хоёр дахь Ирэлтийн талаар судруудаас суралцах үедээ хариултуудыг эрэлхийлэхийг тэдэнд урамшуул.

Хамтдаа суралц

Доорх үйл ажиллагаа бүр нь өсвөр үеийнхэнд Хоёр дахь Ирэлтэд хэрхэн бэлтгэхийг ойлгоход нь туслах болно. Сүнсний удирдамжийг даган, ангидаа тохирох нэг юм уу түүнээс дээш үйл ажиллагааг сонгоно уу:

Сайн мэдээг судлах ур чадварууд

Сэдэвчилсэн удирдамжийг ашиглах нь. Энэ хэсгийн эхний үйл ажиллагаагаар өсвөр үеийнхнийг Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн талаарх судруудыг олохын тулд сэдэвчилсэн удирдамжийг ашиглахад урьсан. Сэдэвчилсэн удирдамжийн эшлэл бүрийн дор, сурч байгаа сэдвийнхээ талаар илүү ихийг суралцахад нь өсвөр үеийнхэнд туслахуйц үгс, үг хэллэгүүд байгаа. Мөн өсвөр үеийнхэн өөрсдийн сэдэвтэй холбоотой үгсийг бодож олоод, тэдгээрийг сэдэвчилсэн удирдамжаас харж болно. Сайн мэдээний ямар нэг тодорхой сэдвийн талаар суралцахыг хүсэх бүрдээ сэдэвчилсэн удирдамжийг ашиглаж байхад тэднийг урамшуул.

- Хоёр дахь Ирэлтийн талаарх дараах асуултуудыг самбар дээр бич: Юу тохиолдох вэ? Би бэлтгэхийн тулд юу хийж болох вэ? Би өөр юу сурч байна вэ? Судруудын удирдамжаас “Есүс Христийн хоёр дахь Ирэлт” гэсэн үгийг харж мөн хэд хэдэн унших судруудыг сонгон эдгээр асуултуудад хариулт олохыг өсвөр үеийнхнээс хүс. Тэднийг олж мэдсэн зүйлээсээ хуваалцахад урь.

- Өсвөр үеийнхнээс *Итгэлдээ үнэнч байх нь* номоос “Есүс Христийн Хоёр дахь Ирэлт” хэсгийг уншихыг хүс. Энэ хэсэгт санал болгосон судруудыг ашиглан, судрын хэлхээг хэрхэн гаргахыг өсвөр үеийнхэнд үзүүл. Тэд 90–91-р хуудас дээр жагсаагдсан бошиглогдсон үйл явдлууд болон тэмдэг бүрд судрын хэлхээ гаргаж болох юм. Жишээлбэл: “Газар дэлхий хийгээд тэнгэр дэх тэмдгүүд”-ийн талаар судрын хэлхээ үүсгэхийн тулд тэд Иоел 2:30–31 шүлгийг гарган, хажуу талын зайнд нь дараагийн судрын лавлах буюу Матай 24:29–30 гэж бичнэ.

Матай 24:29–30-ыг бичсэн хажуу талын зайнд тэд С ба Г 29:14–16 гэж бичин, цааш үргэлжлүүлнэ. Өсвөр үеийнхнийг уг сэдвийн талаар өөр судруудыг олж, уг хэлхээндээ нэмж бичихэд урамшуул. Өсвөр үеийнхнээс судрын хэлхээ гаргах нь яагаад хэрэгтэй гэж бодож байгаа талаар асуу. Тэд урьд өмнө нь мэдэж байгаагүй ямар тэмдгүүдийн талаар Хоёр дахь ирэлтийн тухай өгүүлэх судруудаас мэдэж авсан бэ? Тэд яагаад Хоёр дахь Ирэлтийн тэмдгүүдийн талаар мэдэх нь чухал гэж бодож байна вэ? (С ба Г 45:34–39-ийг үзнэ үү).

- Ангиараа Сургаал ба Гэрээ 45:44-ийг унш. Ангийнхандаа энэ шүлгийн зүүлт тайлбарыг унших нь илүү сайн ойлгоход нь хэрхэн тусалж болохыг харуул. Жишээлбэл: Зүүлт тайлбар 6 нь Марк 13:32–37 гэж байгаа бөгөөд энэ нь Хоёр дахь Ирэлтийн өдөр, цагийг хэн ч мэдэхгүй гэдгийг заадаг. Энэ нь бид яагаад анхааралтай байх ёстойг ойлгоход тусалж байна. Өсвөр

үеийнхэн бүрд энэхүү хичээлд эсвэл *Итгэлдээ үнэнч байх нь* номын 89–91-р хуудас дахь санал болгосон зүйлс гэх мэтчилэн Хоёр дахь ирэлтийн талаарх нийтлэлүүдийг оноож өг. Өсвөр үеийнхнээс уг шүлгүүдийг судлан, зүүлт тайлбар дахь

шүлгүүдийг уншсанаар олж авсан мэдлэгээ бичиж авахыг хүс. Тэдэнд өөрсдөө суралцан, сурсан зүйлсээ хуваалцах цаг гаргаж өг. Тэдний сурсан зүйлс Хоёр дахь Ирэлтэд илүү сайн бэлтгэлтэй байхад нь хэрхэн туслах вэ?

Өсвөр үеийнхнээс өнөөдөр сурсан зүйлээсээ хуваалцахыг хүс. Хоёр дахь Ирэлтийн талаар суралцахын тулд судруудыг хэрхэн судлахаа тэд ойлгож мэдэж байна уу? Тэдэнд өөр асуулт байна уу? Энэ сэдэв дээр илүү их цаг зарцуулах шаардлага байна уу?

Үйлдэхэд урь

Өсвөр үеийнхнийг хичээлийн үеэр төрсөн сэтгэгдлээ хуваалцахад урь. Хоёр дахь Ирэлтэд бэлтгэхийн тулд тэд юу хийх вэ? Тэд өнөөдөр хувиараа судраас суралцахдаа хэрэгжүүлэх ямар зүйл сурсан бэ?

Аврагчийн арга барилаар заах нь

Аврагч, Өөрийн заах тэднийг итгэлээр үйлдэж мөн Өөрийнх нь заасан үнэний дагуу амьдрахад урьдаг. Өөрийн бүх сургаалд Тэр дагалдагчдаа бүх зүрх сэтгэлээрээ сайн мэдээний дагуу амьдрахад нь туслахад анхаардаг байв. Өсвөр үеийнхнийг сурсан зүйлсийнхээ дагуу үйлдэхийг та хэрхэн урамшуулж байна вэ?

Сурах болон заах санаанууд

Аврагч Өөрийн номлолыг зааж, гэрчлэхдээ судруудыг ашигладаг байлаа. Тэрээр хүмүүст өөрсдөд нь зориулсан судруудын талаар тунгаан бодож, асуултынхаа хариултыг судруудаас олохыг заасан. Тэрээр өөрсдийнх нь туршлагаар болон эргэн тойронд нь байгаа зүйлсийг жишээ болгон авч, сайн мэдээний хичээлийг ойлгоход нь хүмүүст тусалдаг байсан. Тэднийг бусдад зааж мөн гэрчилснээр Түүний сургаалын гэрч болохыг Тэрээр хүсдэг байв. Ингэснээр сургаалын талаарх тэдний ойлголт улам гүнзгий болдог байв.

Аврагч өөрийн үлгэр жишээгээр харуулсан зарчмуудыг дагахад нь туслах суралцах үйл ажиллагаануудыг бэлтгэх нь өсвөр үеийнхний багш таны үүргийн чухал хэсэг юм. Бошиглогчдын үгсийг судлан, сурсан зарчмуудынхаа жишээнүүдийг ойлгож, сайн мэдээг бусадтай хуваалцахад нь өсвөр үеийнхэнд туслах болно гэж өөрийн бодсон заах бусад санаануудыг эсвэл энэхүү хавсралтад буй санаануудыг ашиглаарай. Та эдгээр санаануудыг аль ч хичээлийн сэдэвт тохируулан өөрчилж болно.

Үйл ажиллагаануудыг төлөвлөхдөө өсвөр үеийнхнийг сурсан зүйлсээ бусадтай хуваалцахад урамшуулан дэмжих нь хамгийн чухал зорилгуудын тань нэг юм гэдгийг санаарай. Тэд сургаалын үнэнийг илэрхийлэх үед тэдгээр үнэн нь Ариун сүнсний хүчээр тэдний зүрх сэтгэл, оюун санаанд нь батлагдаж байдаг. Сайн мэдээг бусадтай хуваалцсанаар өсвөр үеийнхэн нэг нэгнээ хүчирхэгжүүлдэг. Үе тэнгийнхнээсээ сайн мэдээний үнэнийг сонсох нь зарим үед удирдагч, багш нараасаа сонсохоос илүү хүчтэй байдаг.

Уялдаа холбоог бий болгох үйл ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаанууд нь:

- Өсвөр үеийнхэнд гэртээ, сүм дээр, семинар дээр сурч байгаа зүйлс болон өдөр тутмын амьдралдаа олж авч байгаа туршлагаудынхаа хооронд уялдаа холбоог бий болгоход тусална.

Өсвөр үеийнхэн эдгээр үйл ажиллагаанд нэг нэгээрээ, багаараа, ангиараа эсвэл чуулгаараа оролцож болно. Та өөрийн хичээл заадаг өсвөр үеийнхний хэрэгцээг анхаарч үзэх үед хамгийн шилдэг санаанууд танд ирэх болно гэдгийг санаарай.

Өсвөр үеийнхнийг гэртээ, сүм дээр болон бусад газарт сурч байгаа зүйлсийнхээ хооронд уялдаа холбоог бий болгоход тусал.

Үнэнүүдийн жагсаалт гаргах

Сурч байгаа сайн мэдээний үнэнүүдийг жагсаан бичихийг тэднээс хүс. Дараа нь эдгээр нь хоорондоо ямар хамааралтай болох талаар ярилц.

Үг эсвэл хэллэг бичих

Сүүлийн үед суралцсан ямар нэгэн зүйлээ нэг үг эсвэл хэллэгээр хуваалцахыг өсвөр үеийнхнээс хүс.

Судар хуваалцах

Хамгийн сүүлд судалсан судрынхаа талаар хуваалцаж, үүнээс юу сурснаа ярихыг тэднээс хүс.

Суралцах туршлагаа хуваалцах

Сайн мэдээний сургаалыг ач холбогдолтой байдлаар суралцсан талаарх туршлагаа хуваалцахыг тэднээс хүс.

Заах туршлагаа хуваалцах

Хамгийн сүүлд сайн мэдээг заасан туршлагаа хуваалцахыг тэднээс хүс. Заахдаа юу мэдэрсэн ба хичээл нь ямар байсан бэ? Тэд юуг сайжруулахыг хүсч байна вэ?

- Өсвөр үеийнхэнд ангидаа сурах сургаалыг танилцуулна.

Хэрэгжүүлсэн талаараа хуваалцах

Суралцаж буй зүйлсийнхээ дагуу хэрхэн амьдарч байгаа талаараа хуваалцахыг тэднээс хүс.

Асуулт асуух

Суралцаж байгаа сургаалынхаа талаар асуулт асуухыг тэднээс хүс.

Асуултууд хуваалцах

Сүмийн талаар эсвэл тэдний итгэдэг зүйлийн талаар хүмүүсийн асуусан асуултуудыг бусадтайгаа хуваалцаж, хэрхэн хариулсан тухайгаа ярихыг тэднээс хүс.

Өсвөр үеийнхний ангидаа үзэх сургаалыг танилцуулах

Судрууд дахь уг сургаалыг олох

Уг хичээлийн сургаалыг агуулсан судрын эшлэлийг олохыг тэднээс хүс.

Асуулт асуух

Сургаалын талаарх асуултад хариулахыг тэднээс хүс.

Дууллыг дуулах

Сургаалтай холбогдолтой дууллыг дуулахыг тэднээс хүс.

Хичээлийн гарчигт агуулагдаж байгаа асуултад хариулах

Хичээлийн гарчигт агуулагдаж байгаа асуултыг самбар дээр бичээд, уг асуултад хэрхэн хариулах талаар тунгаан бодохыг тэднээс хүс.

Дүр бүтээх

Хэн нэгэн тэднээс сургаалтай холбогдолтой асуулт асууж байгаа нөхцөл байдлыг жүжиглэн үзүүлэхийг тэднээс хүс. Тэд хэрхэн хариулах вэ?

Мэдэж байгаа зүйлээ тайлбарлах

Сургаалын талаар мэддэг зүйлсээ тайлбарлахыг ангийн гишүүдээс хүс.

Сургаалыг хэсгүүдэд хуваах

Сургаалыг хэдэн хэсэг болгон хувааж, хэсэг бүр ямар утгатай болохыг ангийн өөр гишүүдээр тайлбарлуул.

Зураг эсвэл бодит зүйлийг тайлбарлах

Энэ долоо хоногийн сургаалтай холбогдолтой зураг эсвэл ямар нэгэн зүйлийг харуулж, тэдгээрийг тайлбарлахыг тэднээс хүс.

Зураг зурах

Ярилцах гэж байгаа сургаалын тань талаар өсвөр үеийнхэн ямар ойлголттой байгааг харуулах зураг зурахыг тэднээс хүс.

Судрууд олж хуваалцах

Хичээлийн гарчигт агуулагдаж байгаа асуултад хариулахад туслах судар олохыг тэднээс хүс.

Мэдэж байгаа зүйлээ дүгнэх

Уг сургаалын талаар тэд юу мэдэж байгаа болон ямар туршлагатай гэдгээ цөөн үгээр эсвэл хэллэгээр дүгнэж хэлэхийг тэднээс хүс.

Нэрээ бичих шаардлагагүй судалгаа

Уг сургаалтай холбоотой мэдрэмж болон туршлагынх нь талаар асуусан богинохон, нэрээ бичих шаардлагагүй судалгааг тэдэнд тарааж өг.

Шалгалт

Тэд уг сургаалын талаар юу мэдэж байгааг мэдэхийн тулд богино шалгалт ав.

Үгсийн жагсаалт гаргах

Ярилцах гэж буй сургаалтай холбоотой үгсийн талаар бодохыг тэднээс хүс. Тэдэнд ямар үг эсвэл хэллэгийн талаар асуулт байна вэ?

Хамтдаа суралцахад зориулсан үйл ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаанууд тэдэнд тусална:

- Судрууд болон бошиглогчдын үгсийг **судалж**, тэдгээрийн утгыг эргэцүүлэн бодох.
- Уг сургаалын талаарх тэдний бодол санаа болон мэдрэмжүүдийг бусадтай **хуваалцуулах**.
- Ярилцаж буй сургаалынхаа талаар **жишээ үзэх**.

Өсвөр үеийнхэн эдгээр үйл ажиллагаанд нэг нэгээрээ, багаараа, ангиараа эсвэл чуулгаараа оролцож болно. Та өөрийн хичээл заадаг өсвөр үеийнхний хэрэгцээг анхаарч үзэх үед хамгийн шилдэг санаанууд танд ирэх болно гэдгийг санаарай.

Судрууд болон бошиглогчдын үгсийг судалж, тэдгээрийн утгыг эргэцүүлэн бодох

Асуултуудын хариултыг олох

Сургаалын талаар тэдэнд байгаа эсвэл таны тавьсан асуултуудын хариултыг олохыг тэднээс хүс. Олсон хариултынх нь талаар ярилц.

Үгс болон хэллэгүүдийг олох

Сургаалыг ойлгоход нь туслах үгс, хэллэгүүд болон жишээнүүдийг олохыг өсвөр үеийнхнээс хүс.

Цөөн үгээр дүгнэлт хийх

Судар болон бошиглогчийн хэлсэн үгсийг цөөн үгээр дүгнэн хэлэхийг тэднээс хүс.

Жагсаалт гаргах

Өсвөр үеийнхнийг судар болон бошиглогчдын үгсээс суралцсан сургаалын тухай түлхүүр санаануудыг олж, жагсаан бичихийг хүс. Тэднийг олсон зүйлээ хуваалцахад урь.

Шүлгүүдийг тохируулах

Тэдэнд хэдэн судрын эшлэл, судар бүрийн зааж байгаа зүйлийг дүгнэсэн товч агуулгыг өг. Судруудыг уншаад, товч агуулгатай нь тохируулахыг хүс.

Зурагтай нь тохируулах

Зурагнуудыг судрын үйл явдалтай тохируулахыг өсвөр үеийнхнээс хүс. Үйл явдал болон зурагнуудаас олж авсан бодлоо хуваалцахад урь.

Хоосон зайг бөглөх

Самбар дээр судрын агуулгыг бичихдээ зарим үгийг нь орхин бич. Тэрхүү агуулгыг гүйцээж бичихэд шаардлагатай үгс болон хэллэгүүдийг судруудаас хайж олохыг тэднээс хүс.

Жишээнүүдийг харьцуулах

Судруудаас хоёр болон түүнээс дээш түүх, үйл явдлыг уншин, тэдгээр нь сургаалын талаар юу зааж байгааг харьцуулахыг хүс.

Зураг зурах

Судрууд болон бошиглогчдын үгсээс уншсан зүйлсээ зурахыг тэднээс хүс.

Судар олох

Уг сургаалын талаар заадаг судрын үйл явдлыг олж, ямар утгатай болохыг тайлбарлахыг тэднээс хүс.

Холбогдолтой судруудыг холбох

Тухайн сургаалтай холбогдолтой судруудын жагсаалтыг гарган, тэдгээрийг уншиж, судар дээрээ тэмдэглэгээ хийхэд нь өсвөр үеийнхэнд тусал.

Дуулуудыг олж, дуулах

Сургаалтай холбогдолтой дууллыг олж, хамтдаа дуулахыг тэднээс хүс.

Зааж буй сургаалынхаа жишээнүүдийг харах

Бусадтай ярилцах

Уг сургаалтай холбогдолтой туршлагынх нь талаар бусадтай ярилцахыг өсвөр үеийнхнээс хүс.

Судрууд дахь жишээнүүдийг харах

Судрууд дахь уг сургаалын дагуу амьдарч байсан хүмүүсийн тухай уншиж эсвэл сонсохыг тэднээс хүс.

Бусад хожмын үеийн гэгээнтний жишээнүүдийг харах

Тус сургаалын дагуу амьдардаг бусад хожмын үеийн гэгээнтний тухай уншиж эсвэл сонсохыг өсвөр үеийнхнээс хүс.

Жишээнүүдээ хуваалцах

Та эхлээд сургаалын дагуу амьдардаг хүмүүсийн талаарх өөрийн жишээг хуваалцсаны дараа тэднээс жишээ хуваалцахыг хүс.

Түүхийн талаар ярилц

(Судрууд болон бошиглогчдын үгсээс) уг сургаалыг түүхэн жишээгээр нотолдог талаар тайлбарлахад тэднийг урь.

Оюун ухаандаа төсөөлөх

Сургаалын дагуу амьдардаг хэн нэгний талаар оюун ухаандаа төсөөлөн бодохыг тэднээс хүс.

Дүр бүтээх

Сургаалыг үзүүлсэн нөхцөл байдлуудыг төсөөлөн бодох юм уу дүр бүтээн үзүүлэхэд өсвөр үеийнхнийг урь.

Мэдээллийн хэрэгсэл, дүрс бичлэг үзэх

Сүмээс гаргасан мэдээллийн хэрэгсэл, дүрс бичлэгийг (DVD бичлэг, LDS.org сайт дахь видео бичлэг зэрэг) үзэхэд урь.

Мэргэжлийн хүний хэлсэн үгийг сонсох

Ангийн гишүүдтэй ярилцаж, тэдний асуултад хариулахаар зөвшөөрөгдсөн зочдыг урьж оролцуул.

Зочны яриаг сонсох

Уг сургаалын дагуу ярилцах зөвшөөрөгдсөн үг хэлэх хүнийг урь.

Уг сургаалын талаарх тэдний бодол санаа болон мэдрэмжүүдийг бусадтай хуваалцуул.

Хэлэх үгээ бэлдэх

Уг сургаалын талаар үг хэлэхээр бэлдэхийг өсвөр үеийнхнээс хүс.

Хичээл заах

Ангийн нэг гишүүнийг хичээлийн хэсгээс заахад урь.

Өөр ангид заах

Сургаалын талаар богино хичээл бэлдэж, өөр ангид заахыг (бишоп зөвшөөрсөн тохиолдолд) өсвөр үеийнхнээс хүс.

Хэн нэгэнд заах

Өөр хэн нэгэнд сургаалыг хэрхэн зааж болох тухай санаануудыг бодож олоход нь өсвөр үеийнхэнд тусал.

Сургаалыг гэрчлэх

Ангийн гишүүдийг уг сургаалын талаар гэрчлэлээ хуваалцахад урь.

Сургаалын талаар бичих

Ангийн гишүүдийг юу сурсан болон сургаалын талаарх өөрсдийн бодол санаа, мэдрэмжээ хуваалцахыг тэднээс хүс.

Утгыг нь тайлбарлах

Тэдний хувьд уг сургаал ямар утгатай болохыг өсвөр үеийнхнээс асуу.

Асуултуудын талаар ярилцах

Сургаалын утга учир, ач холбогдлын тухай асуултуудыг хэлэлцэхэд урь.

Асуултууд асуух

Сургаалын талаар бодож, үүнтэй холбогдолтой асуултууд асуухыг тэднээс хүс. Хамтдаа тэдгээр асуултад хариул.

Зураг эсвэл бодит зүйлийг тайлбарлах

Зураг эсвэл бодит зүйл нь уг сургаалыг хэрхэн харуулж байгааг тайлбарлахыг тэднээс хүс.

Зураг зурах

Тус сургаалыг тайлбарлах зураг, диаграм зурах эсвэл ханын сонин гаргахыг тэднээс хүс.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь эсвэл Хувийн хөгжил дэвшил номтой ажиллах үедээ олж авсан туршлагаа хуваалцах

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь эсвэл Хувийн хөгжил дэвшил номтой ажиллаж байхдаа сурсан уг сургаалтай холбогдолтой ямар нэгэн зүйлээ хуваалцах эсвэл энэ талаар хичээл заахыг тэднээс хүс.

Өсвөр үеийнхнийг үйлдэхэд урих үйл ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаанууд сайн мэдээ амьдралд нь хэрхэн хэрэгжиж байгааг харахад нь өсвөр үеийнхэнд тусална. Ерөнхийдөө, сурсан зүйлсээ хэрэгжүүлэх төлөвлөгөөг өөрсдөө гаргахад нь тэднийг урамшуулах хэрэгтэй. Эдгээр үйл ажиллагаанд тэдэнд энэхүү ойлголтыг өгөхөд тусална.

Өсвөр үеийнхэн эдгээр үйл ажиллагаанд нэг нэгээрээ, багаараа, ангиараа эсвэл чуулгаараа оролцож болно. Та өөрийн хичээл заадаг өсвөр үеийнхний хэрэгцээг анхаарч үзэх үед хамгийн шилдэг санаанууд танд ирэх болно гэдгийг санаарай.

Сургаалын дагуу амьдрах төлөвлөгөө гаргах

Юу хийхээ тунгаан бодох

Сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд юу хийх тухайгаа тунгаан бодохыг өсвөр үеийнхнээс хүс.

Юу хийхээ бичих

Сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд юу хийхээ бичихийг тэднээс хүс.

Ангийн гишүүдтэй зөвлөлдөх

Сургаалыг хэрхэн хэрэгжүүлэх талаар ангийнхаа гишүүдтэй зөвлөлдөхийг тэднээс хүс.

Мэдрэмж болон гэрчлэлээ хуваалцах

Сургаалын талаар мэдрэмж болон гэрчлэлээ хуваалцаж, энэ нь тэдний хувьд яагаад чухал болохыг тайлбарлахыг тэднээс хүс.

Заах тойм гаргах

Бусдад сургаалыг заах тойм гаргахыг тэднээс хүс.

Сургаалын чухал ач холбогдлын талаар ярилцах

Тэдний амьдралд сургаал ямар ач холбогдолтой талаар ярилцахыг тэднээс хүс.

Гэрчлэлээ бичих

Сургаалын талаар гэрчлэлээ бичихийг тэднээс хүс.

Бусадтай ярилцах

Бусадтай ярилцаж, сургаалын талаарх тэдний бодол санаа, туршлагын талаар олж мэдэхийг тэднээс хүс.

Жагсаалт гаргах

Сургаалыг амьдралдаа хэрэгжүүлснээр ирсэн адислалуудаа жагсаан бичихийг өсвөр үеийнхнээс хүс.

Сорилт бэрхшээл эсвэл асуудлыг даван туулах

Тэдэнд тохиолдсон сорилт бэрхшээл, асуудлуудыг хуваалцахад урь. Дараа нь тэдгээрийг даван туулахад тэдэнд сургаал болон судрууд хэрхэн тусалж болохыг хуваалц.

Хэрэгжүүлэх

Судар эсвэл бошиглогчдын үгсээс ямар нэгэн зарчмыг амьдралдаа хэрэгжүүлэхийг тэднээс хүс.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь эсвэл Хувийн хөгжил дэвшил номон дахь үйл ажиллагаануудыг хийх

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь эсвэл Хувийн хөгжил дэвшил номон дахь нэг үйл ажиллагааг хийхийг тэднээс хүс.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

